МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН
THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

НИЙТИЙН
номын сангуудын
тайлан 2022

Улаанбаатар

2023

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2022

(Тайлангийн эмхэтгэл)

УЛААНБААТАР ХОТ

2023 он

ННА 78
DDC 020
Н 615

Нийтийн номын сангуудын тайлан 2022

Эмхэтгэсэн: В.Түвшинтогтох /Арга зүйч/
Б.Гантулга /Арга зүйч/
Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

ISBN 978-9919-9751-4-2

ӨМНӨХ ҮГ

Номын сангуудыг арга зүйгээр удирдах аргын нэг нь тайлан, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах юм. Монгол Улсын Үндэсний номын сангаас сүүлийн 20 шахам жилийн хугацаанд аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын тайланг эмхэтгэж, уламжлалт хэвлэлээр болон цахимаар хэвлүүлж ирсэн. Энэ нь нийтийн номын сангуудыг бусад номын сангуудын үйл ажиллагаатай өөрийн үйл ажиллагаагаа харьцуулах, туршлага судлах, нэвтрүүлэхэд тус нэмэр болох, арга зүйгээр хангаж буйн нэг илрэл юм. Ингэснээр энэхүү эмхэтгэлийг хүлээдэг, ашигладаг номын санч, судлаачид ч бий болоод байна.

Тухайн жилийн онцлогоос хамаарч номын сангийн үйлчилгээ, тайлангууд онцлог бүхий гарах нь элбэг. 2022 оны тайлангийн эмхэтгэл өмнөх оныхоос ялгаатай хэд хэдэн зүйлийг цохон тэмдэглэвэл: ***1.*** дэлхий дахиныг хамарсан цар тахлын хөл хориог нээсэн жил байв. Үүнээс үүдэж номын сангуудын үйлчилгээний өсөлт ажиглагдаж байна. ***2.*** УИХ-ын дарга Г.Занданшатарын санаачлага, Соёлын сайдын "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийн хүрээнд номын сангуудад соёл олон нийтийн ажил, үйл ажиллагааны зардлыг шийдэж өгсөн нь номын сангуудын үйл ажиллагааны өсөлт, хүртээмжид чухал нөлөө үзүүлжээ. ***3.*** Цар тахлын улмаас номын сангууд мэргэжлийн сургалт, үйл ажиллагаанд хамрагдах боломж хомс байсны улмаас энэ онд гэхэд Монгол Улсын Үндэсний номын сангийн мэргэжилтнүүд 16 аймагт 20 удаа очиж ажиллан давхардсан тоогоор 700 гаруй номын санчийг сургалтад хамруулсан нь өмнөх жилүүдийнхээс даруй 4-5 дахин их байсан зэргийг дурдахад таатай байна.

Эмхэтгэлийн төгсгөлд аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн info@nationallibrary.mn хаягаар болон 70112397 утсаар ирүүлнэ үү.

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 08.

Аливаа орны Үндэсний номын сан тухайн орны бичиг соёлын өв, оюуны үнэт бүтээлийг хадгалан хамгаалж хойч үедээ үлдээх үүргээс гадна хэрэглэгчиддээ өөрийн орны болон дэлхийн бусад орны мэдлэг мэдээлэлтэй холбогч гүүр болон ажилладаг. Монгол улсын Үндэсний номын сан энэ хариуцлагатай үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд урт, богино хугацааны стратеги хөтөлбөрөөр дэвшүүлэн төрийн бодлогодоо тусгуулж, хамтран ажиллагсад, үйлчлүүлэгчиддээ ил тод таниулан орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шинэ төрлийн үйлчилгээ, хэрэглээг бий болгоход анхаарч ажиллаж ирлээ.

НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ: Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 10 зорилт, 41 арга хэмжээг 99,2%-тай биелүүлж ажилласан байна.

ХОЁР. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

- **Захиргаа, хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгжилт зохицуулалт**

Байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангиллын хувьд авч үзвэл улс соёлын төрийн үйлчилгээний албан хаагч 49, төрийн үйлчилгээний албан хаагч 12, нийт 61 орон тоотойгоор ажиллаж байна.

Монгол Улсын Үндэсний номын сангийн бүтэц орон тоотой уялдуулан Захирлын 2022 оны А/01 тоот тушаалаар:

- Захиргааны хэлтэс-31,
- Мэдээлэл, арга зүй, эрдэм шинжилгээний хэлтэс-13,
- Ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох хэлтэс-13,
- Сан хөмрөг, хадгаламжийн хэлтэс-16,
- Уншлага үйлчилгээний хэлтэс-14,
- Ашиглалтын өмнөх алба-26 нийт 112 орон тоотойгоор ажиллахаар батлагдсан.

Нийт албан хаагчдын 84 буюу 75%-ийг эмэгтэй, 28 буюу 25% эрэгтэйчүүд эзэлж байна.

Насны ангиллаар авч үзэхэд 18-24 насны 2, 25-34 насны 33, 35-44 насны 31, 45-54 насны 41, 55-аас дээш насны 4 албан хаагч хөдөлмөр эрхэлж байна.



Соёлын яамны Төрийн захиргааны удирдлагын газарт Салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд манай байгууллагад нэн шаардлагатай байгаа мэргэжилтний мэдээллийг гарган хүргүүлсэн.

Соёлын яамны Төрийн захиргааны удирдлагын газраас 2022 оны 4/1102 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг баримтлан хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн ажилтан, албан хаагчдын ирцийг бүртгэх зорилгоор хадгалагдаж байсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгах үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр байгууллагын дотоод хяналт, шалгалтын комиссын гишүүд, хүний нөөцийн ажилтан, сүлжээний инженер нарын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгууллаа. Мөн тус хуулийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу 2022 оны 04 дүгээр 29-ний өдрөөс эхлэн ажилтан, албан хаагчдын биеийн давхцахгүй өгөгдлийг ашиглах үйл ажиллагааг зогсоож, хурууны хээ уншигч төхөөрөмжийн техникийн мэдээлэл болон хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгасан. Цуглуулсан болон хадгалсан хурууны хээний мэдээллийг устгасан талаарх тайлан, мэдээг гаргаж tub1218@yahoo.com (Т.Уганбаяр СЯ-ны мэргэжилтэн) хаягаар цахимаар болон албан бичгээр СЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д өөрийн байгууллагын 112 албан хаагчийн мэдээллийг бүртгэсэн. ERP системийн бүртгэлд оруулсан нийт албан хаагчдын мэдээлэл, тайланг гарган албан бичгээр СЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.

➢ **Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт**

Хүний нөөцийн чиглэлээр:

Судалгаа –16,

Тайлан – 7,

Журам – 6 “Хөдөлмөрийн дотоод журам”, “Хяналтын төхөөрөмж байрлуулах, түүнийг ашиглах журам”, “Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам”, “Цалин хөлсний журам”, “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам”/ боловсруулсан байна.

Байгууллагын хүний нөөцийг дотоод болон гадаад эх үүсвэрээс бүрдүүлдэг. Дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх боломжгүй тохиолдолд сул чөлөөтэй ажлын байранд зар байршуулж, тухайн ажил, албан тушаалд шаардлага

хангахуйц ажил горилогчдыг хайж, хамгийн бага зардлаар, богино хугацаанд, хамгийн тохиромжтой ажилтныг сонгон шалгаруулж бүрдүүлэлтээ хийдэг.

Анкет ирүүлсэн ажил горилогчдоос сул чөлөөтэй байгаа ажлын байрны шаардлага хангахуйц ажил горилогчийг хандлага, харилцаа, туршлага, ур чадвар, мэдлэгийг харгалзан үнэлж, хэлтсийн дарга удирдлагын саналыг заавал авч шаардлагатай тохиолдолд Захиргааны зөвлөлийн хурлаар оруулан сонгон шалгаруулалтыг хийдэг.

2022 онд байгууллагын хэлтэс, албанд нийт шаардлагатай байгаа сул орон тоо бүхий нарийн мэргэшил, ур чадвар бүхий хэдий хэмжээний хүний нөөц шаардлагатай байгаа хэрэгцээг эхний улиралд тодорхойлж, Захиргааны зөвлөлөөр танилцуулсан.

2022 онд нийт 20 албан хаагчийг туршилтын хугацаатай ажилд томилж, шаардлага хангасан 18 албан хаагчийг үндсэн ажилтнаар томилон ажилласан байна.

- **Сургалт**

Монгол Улсын Үндэсний номын сангийн албан хаагчдын сургалт хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийт 28 сургалтад албан хаагчдыг хамруулсан. Үүнээс нийт албан хаагчдыг сургалтад хамруулан зохион байгуулсан сургалт-11, Оролцогчдын тоо давхардсан байдлаар-728, Соёлын яам, ТАЗ бусад байгууллагуудын сургалт-17, Оролцогчдын тоо давхардсан байдлаар-369 байсан.

Гадаадад: Эрдэм шинжилгээний болон бусад чиглэлээр албан хаагчдыг мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж 1 албан хаагч ЗГ-ын тэтгэлгээр Бүгд Найрамдах Унгар Улсын Өтвөш Лорандын Эрдмийн их сургуульд докторантурын сургалтад 1 албан хаагч ажлаас түр чөлөөлөгдөн хамрагдаж байна. Байгууллагын зүгээс тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулан, ажлын байрыг хэвээр хадгалж, нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлж байна.

БНСУ-ын Үндэсний номын сангаас Соёлын түншлэл хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй "Номын санчдад зориулсан боловсролын сургалт-2022" хөтөлбөрийн дагуу 2022.08-12 сарын хугацаанд 1 албан хаагчийг БНСУ-ын Үндэсний номын санд сургаж байна.

МУҮНС-ийн мэргэжилтнүүдийн төлөөлөл 30 албан хаагчийг орчин үеийн жишиг болох МУИС-ийн номын сан, Чингис хааны музейн тохижилт, үйл ажиллагаатай танилцуулсан.

Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ын хэрэгжилтийг ханган ажиллах (Хос бичигтэн байгууллага болох, монгол бичгийн хэрэглээний орчныг бүрдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах) зорилтын хүрээнд МУҮНС нь дотоод нөөц бололцоондоо тулгуурлан ажилтан, албан хаагчиддаа “Үндэсний бичгийн анхан шатны сургалт”-ын 30 цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 45 ажилтан сургалтыг амжилттай төгсч, суралцагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, батламж гардуулах үйл ажиллагааг зохион

байгуулсан. Мөн МҮОНРТ-ийн “Монгол бичиг-2025” нэвтрүүлгийн багтай хамтран байгууллагынхаа ажилтан, албан хаагчдад “Монгол бичгийн анхан шатны сургалт”-ыг зохион байгуулж байгаа үйл ажиллагааны талаар сурталчиллаа.

Дээрх зорилтын хүрээнд МУҮНС нь ажилтан, албан хаагчиддаа монгол бичгийн 18 цагийн зайн сургалтын хичээл, Эх хэлний өдрийг тохиолдуулан "Хос бичигтэн байгууллага" уриалгын хүрээнд албан хаагчиддаа компьютерт монгол бичгээр бичих чадварт суралцах 10 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Архивын Ерөнхий Газрын 2022 оны сургалтын захиалгад Архив бичиг хэргийн эрхлэгчийг 2 удаагийн Мэргэшүүлэх сургалтад бүртгүүлж, “Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх аргазүй”, "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй" сэдэвт мэргэшүүлэх 2 удаагийн сургалтад хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар сургалтад Захиргааны зөвлөлийн гишүүд тогтмол хамрагдаж, мөн холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан.

- “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих”,
- “Аз жаргалтай ажиллахын нууц”,
- “Орчин үеийн мегатрэндүүд”,
- “Коронавируст халдвар /Ковид19/ -ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”,

- “Манлайллын хэв маяг, хандлагаа тодорхойлох нь”,
- “Харилцан адилгүй үеийнхнийг үр дүнтэй манлайлах нь”,
- “Хүлээлтэд нийцсэн гүйцэтгэлийг тодорхойлж өгөх нь”,
- “Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь”,
- “Гүйцэтгэл сайжруулах көүчинг хийх нь”,
- “Төрийн байгууллагын бүтээмж”,
- “Чанарын менежментийн тогтолцоо”,
- “Эх орон энхийг сахиулагч”,
- “Цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга, онцлог зохицуулалт”,
- “Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил”,
- “Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх”,
- “Бүтээлчээр хурдан уншихуй”,
- “Монголчууд 20 дугаар зуунд”,
- “Төрийн албан хаагчийн ёс зүй”,
- “Монгол улсын үндэсний болон гадаад аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлууд”,
- “Монголын тусгаар тогтнолын үнэ цэн”,
- “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийн явц,
- “Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” зэрэг нийт 26 удаагийн сургалт.



Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн ажилтан, нягтлан бодогчдод зориулсан “ХНУМТ”, “ТАЦНС” системийн 5 удаагийн цахим цуврал сургалтад Хүний нөөцийн ажилтан, Ахлах нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч нар тус тус хамрагдсан.

“Төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн доод хэмжээ” ТАЗ-ийн ХНУМТ цахим системийн сургалтад Хүний нөөцийн ажилтан Д.Мөнхгэрэл, Ахлах нягтлан бодогч Э.Энхзул, Тооцооны нягтлан бодогч Ш.Бота нар хамрагдсан.

Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудал” цахим хэлэлцүүлэгт нийт 48 албан хаагч оролцсон.

МҮЭ-ийн холбооны Эмэгтэйчүүдийн хорооноос зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал” үндэсний чуулганд байгууллагын Үйлдвэрчний хорооны дарга Б.Цогжаргал оролцлоо.

Үйлдвэрчний эвлэлийн холбооноос зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл, хөдөлмөрийн гэрээ” сэдэвт сургалтад Захиргааны

хэлтсийн дарга Л.Гансүх, Хүний нөөцийн ажилтан Д.Мөнхгэрэл, байгууллагын Үйлдвэрчний хорооны дарга Б.Цогжаргал нар оролцлоо.

Монгол Улсын Үндэсний номын сангийн Хүний нөөцийн ажилтан, Үйлдвэрчний эвлэлийн дарга, Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран нийт албан хаагчдад "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгатай холбоотой онцлох зохицуулалт, шинээр орж ирсэн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтуудын талаарх мэдээллийг олгох ажлын байрны сургалтыг зохион байгуулсан ба нийт 66 албан хаагч хамрагдсан.

“Хувь хүний харилцаа хандлага” сэдвээр ажлын байрны сургалтыг Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, МУҮНС-ийн Залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран нийт ажилтан, албан хаагчдын дунд зохион байгууллаа. Тус сургалтад нийт 56 албан хаагч хамрагдсан.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийн Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг 3 дугаар сарын 24-ний өдрийн 16:00 цагт зохион байгуулж, нийт 96 ажилтан /өвчтэй-2, чөлөөтэй-2, томилолттой-1, цахимаар ажилласан-1/, 60 уншигч үйлчлүүлэгч /Эрдэм шинжилгээний уншлагын танхим-6, Их уншлагын танхим-50, цахим төлбөрт үйлчилгээний танхим-4/ тус тус хамрагдлаа.

Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран нийт ажилтан албан хаагчдын дунд “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нь” танхимын сургалтыг нийт албан хаагчдын дунд 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгууллаа.

Байгууллагын захиргаа, Ёс зүйн зөвлөлөөс нийт ажилтан, албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтыг Дотоод хэргийн их сургууль-Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн хошууч Г.Батжаргал удирдан явуулсан.

МУҮНС-ийн Залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран Голомт капитал ҮЦК ХХК-тай хамтран “Хөрөнгийн зах зээлийн анхан шатны сургалт”-ыг зохион байгууллаа.

Нийслэлийн онцгой байдлын газрын дэргэдэх ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ, АРГА ЗҮЙН ТӨВ-д 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр "Гамшгаас урьдчилан сэргийлэх" онол, дадлагын иж бүрэн сургалтад өмнө нь тус сургалтад хамрагдаагүй нийт 28 ажилтан, албан хаагчдыг хамруулаа.

Соёлын яамнаас зохион байгуулсан Байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг ашиглах, өгөгдөл мэдээлэл солилцох арга зүйн мэдлэгийг олгох танхимын сургалтад 5 албан хаагчийг хамруулсан.

Соёлын яамны СӨБХЗГ-аас зохион байгуулсан “Музейн аюулгүй байдлыг хангах нь” сургалтад музейн сан хөмрөгч, харуул хамгаалалтын ажилтан нийт 3 ажилтан хамрагдав.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд “Алсын хараа”-2050 “Шинэ сэргэлтийн бодлого” сургалтын эхний шатад онлайнаар байгууллагын захирал, ерөнхий номын санч 2 албан хаагч хамрагдсан. 2022 оны 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд дараагийн шатны танхимын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл, мэдээллийн газрын “Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд нэр дэвшүүлэх өвийг бүртгэх арга зүйн зөвлөгөө” сургалтыг 2022.09.22-ны өдөр Монгол Улсын Үндэсний номын сангийн сургалтын танхимд зохион байгуулж МУҮНС-гийн 10 албан хаагч, мөн Гандантэгчэнлин хийдийн 3 албан хаагчийг тус тус хамруулллаа.

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Боловсрол, соёлын хяналтын газраас “Дотоод хяналт шалгалтыг үйл ажиллагаандаа тогтмолжуулах нь” сэдэвт танхимын дадлага ажил бүхий сургалтыг 2022.09.29-ний өдөр Монгол Улсын Үндэсний номын сангийн сургалтын танхимд зохион байгуулж МУҮНС-гийн Дотоод хяналт, шалгалтын комиссын 5 албан хаагч, Захиргааны зөвлөлийн 2 гишүүн хамрагдлаа.

Хүний нөөцийн ажилтан, ХАБЭАжилтан хамтран Форум сургалтын төвөөс “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт”-ыг нийт албан хаагчдад 2022.09.13-ны өдөр зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлөөс 2022.06.13-24-ний өдрүүдэд зохион байгуулсан “И-Монгол академи”-аас төрийн албаны мэдээллийн технологийн ажилтнуудад зориулсан онлайн сургалтад 3 албан хаагчийг хамруулсан.

1 албан хаагч хувийн зардлаар Хүний нөөцийн ажилтан, оффис менежер, албан хэрэг хөтлөлт хосолсон чадамжийн гэрчилгээ олгох сургалтанд хамрагдаж төгссөн.

1 албан хаагч хувийн зардлаар Хөдөлмөрийн аюулгүй байдал-эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэж хугацаагүй лиценз олгох сургалтанд хамрагдаж байна.

- **Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах**

Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах сайжруулах ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд нэн шаардлагатай дараах журмуудыг боловсруулж, албан хаагчдын саналыг авч тусган үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан. Үүнд: “Хөдөлмөрийн дотоод журам”, “Хяналтын төхөөрөмж байрлуулах, түүнийг ашиглах журам”, “Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам”, “Цалин хөлсний журам”, “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам”.

2022 онд халамж үйлчилгээнд хамрагдсан нийт 14 албан хаагч байна. Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, тусламжаар нийт 2,800,000 төгрөгийг зарцуулсан байна.

Үндэсний бичиг үсгийн баяраар БШУЯ-ны "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" шагналаар 2 албан хаагч, Соёлын ажилтны өдрөөр 6 албан хаагчийг Соёлын яамны “Жуух бичиг”-ээр, “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 1 албан хаагчийг шагналд тодорхойлсон.

Улс тунхагласан өдрийг тохиолдуулан 1 албан хаагчийг Соёлын яамны “Жуух бичиг”-т тодорхойлж, шагнагдсан. Мөн "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар нийт 6 албан хаагчийг, "Алтан гадас одон"-гоор 2 албан хаагчийг шагнуулахаар тодорхойлсон.

2022 онд шагнал авсан-11 (МУСГЗ-1, БШУЯ-ны "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" шагналаар 2 албан хаагч, Соёлын яамны “Жуух бичиг”-ээр 7

албан хаагч, “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 1 албан хаагч, Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медалиар ... албан хаагч)

Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах хүрээнд урсгал засвар болон номын сангийн 3 дугаар давхрын 321 тоот өрөө, 303 тоот өрөө, 2 дугаар давхрын сургалтын танхимын үүдний хэсгийн дотор болон гадна талын тааз, хананы хэсэгт заслын ажил хийгдсэн ба нийт засвар үйлчилгээнд 15,304,115 төгрөгийг зарцуулсан.

Мөн 2,681,700 төгрөгийг хөдөлмөр хамгааллын чиглэлээрх ажил үйлчилгээнд зарцуулсан байна.

ЗГ-ын тэтгэлгээр Бүгд Найрамдах Унгар Улсын Өтвөш Лорандын Эрдмийн их сургуульд докторантурын сургалтад 1 албан хаагч ажлаас түр чөлөөлж ажлын байрыг хадгалан, нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлж байна.

Албан хаагчдыг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан зардлыг нь хариуцах, бие бялдраа чийрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд нийт ажилтан, албан хаагчдад 2022 оны 5 дугаар сарын 01-нээс эхлэн эрүүл мэндийн даатгалаар хийгдэх Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн насны багцуудад багтсан үзлэг, оношилгоо, шинжилгээ болон товлолт хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, эмнэлэг болон харьяалах хорооны мэдээлэл, шинжилгээ өгөхдөө анхаарах зүйлсийг дотоод сүлжээгээр танилцуулж, нийт 27 албан хаагч тус үзлэг, шинжилгээнд хамрагдсан. Мөн бие бялдраа чийрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн бялдаржуулах өрөөг тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийж, цайны завсарлагаар албан хаагчдад нээлттэй байлгаж байна.

- **Хэвлэл мэдээлэл, ил тод байдал**

- Монгол Улсын Үндэсний номын сан Nationallibrary.mn веб хуудас, цахим фэйсбүүк хуудсаар үйл явдлын мэдээ, мэдээлэл, номын үзэсгэлэн, номын нээлт арга хэмжээнүүдийн мэдээллийг цаг тухад бэлтгэн 150 гаруй мэдээллийг хүргэж түгээсэн.

Албан ёсны https://www.facebook.com/National.Library.of.Mongolia хуудас нь 2011 оноос эхлэн ажиллуулсан, 41666 дагагчтай хуудсаар нэгтгэснээр 126 нэр төрлийн мэдээллийг оруулсан.

Нийт хүртээмж, хандалтын тоо-590248
Нийт үзүүлсэн тоо-540120
Таалагдсан, сэтгэгдэл оруулсан болон хуваалцсан-29599

- Монгол Улсын Үндэсний номын сан https://www.youtube.com/@NationalLibraryofMongolia сувгаар нийт бичлэг контент, кино зэрэг нийт 6 бүтээлийг 367 хүнд үзүүлсэн.
- Сул орон тооны зарыг байгууллагын цахим хаяг, холбогдох мэдээллийн хэрэгсэл, вэбсайт зэргээр байршуулан түгээж хэвшсэн.

2022 онд Номын санч-мэдээллийн ажилтан, Маркетингийн менежер, Ном ариутгагч, Үйлчлэгч ажлын байр, албан тушаалд нээлттэй ажлын байрны зарыг байршуулж байгууллагын цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгслүүдээр түгээсэн.

Мөн сонгон шалгаруулалтад оролцож албан тушаалд томилогдсон албан хаагчдын товч мэдээллийг өөрсдийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр дотоод сүлжээгээр нийт албан хаагчдад ил тод танилцуулж хэвшсэн.

Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙР

Номын санч-Мэдээллийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авна.
Ажлын байранд тавигдах ерөнхий шаардлага:
Боловсрол: Бакалавр, магистр түүнээс дээш
Мэргэжил: Номын сан судлаач, ном зүйч, номын санч-мэдээллийн ажилтан

Ажлын цаг: Бүтэн цаг
Бүрдүүлэх материал:
• Ажилд орохыг хүссэн өргөдөл
• Дипломын хуулбар
• Төрийн албан хаагчийн анкет
• Өөрийн товч намтар
Холбоо барих: 11-311780

- **Жендерийн тэгш байдал**

Нийт албан хаагчдын 84 буюу 75%-ийг эмэгтэй, 28 буюу 25% эрэгтэйчүүд эзэлж байна.

Насны ангиллаар авч үзэхэд 18-24 насны 2, 25-34 насны 33, 35-44 насны 31, 45-54 насны 41, 55-аас дээш насны 4 албан хаагч хөдөлмөр эрхэлж байна.

Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар анхаарч ажлын байрны сул орон тооны зар мэдээнд хүйсийг онцлон дурдахгүй, аль нэг хүйсийг давуу гэж үзсэн агуулгыг тусгаагүй ба иргэнийг шинээр ажилд авахдаа тухайн хэлтэс албаны хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгохыг чухалчлан анхаарсан. Мөн сул орон тоо, мэргэжлийн сургалт, мэргэшүүлэх сургалтын тухай мэдээллийг нийт ажилтан, албан хаагчдад тухай бүр нээлттэй хүргэсэн.

Хөдөлмөрийн тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.4-т тус тус заасныг үндэслэн Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар анхаарч хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусгасан байх үүрэгтэй тул “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам”-ын төслийг боловсруулан хамт олны саналыг тусган, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулан үйл ажиллагаандаа тогтмол мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн Жендерийн үндэсний хорооноос 2022 онд зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудал” цахим хэлэлцүүлгийн мэдээллийг нийт албан хаагчдад хүргэж тус хэлэлцүүлэгт нийт 48 албан хаагч сайн дурын үндсэн дээр оролцсон.

СЯ-ны ТЗУГ-аас ирүүлсэн 2022 оны 4/2439 тоот албан бичгийн дагуу “Жендерийн өөрийн үнэлгээний асуулга” судалгааг удирдамжийн дагуу албан хаагчдын дунд зохион байгуулж, албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.

Арга зүйч В.Түвшинтогтох 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр "Соёлын салбар дахь жендерийн асуудал: Номын сангийн салбарт" сэдвээр илтгэл бичиж narantsatsral@ncge.mn хаягаар илгээсэн.

НҮБ-аас Монгол эрэгтэй, эмэгтэй хүн бүрийг Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг таслан зогсоох олон улсын “НЭГДЭЕ!” уриан доор нэгдэж, НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЖ, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход өөрсдийн үүрэг оролцоог ухамсарлан, гар бие, дуу хоолойгоо өргөн оролцохыг уриалсан Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй (ЖСХ) тэмцэх 16 хоногийн аян 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлүүлсэн байна. Энэхүү уриалга болон Соёлын яамны Төрийн Захиргааны Удирдлагын газраас 2022 оны 11

дүгээр сарын 25-ны өдрийн 4/3166 дугаар “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд нэгдэх тухай” албан бичгээр тус аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулж ажиллахыг чиглэл болгосны дагуу Захиргааны хэлтэс, байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороо зохион байгуулж ажиллалаа.

- Монгол Улсын Үндэсний номын сангийн нийт 41662 дагагчтай албан ёсны фэйсбүүк хуудас https://www.facebook.com/National.Library.of.Mongolia -аар 3 удаа аяны уриа, мэдээллийг олон нийтэд түгээсэн ба нийт 4650 хүн үзэж, таалагдсан болон хуваалцсан 198 хүн байна.

Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвтэй хамтран байгууллагын нийт ажилтнуудад “Сэтгэцийн эрүүл мэнд, ажлын байрны стресс” сэдэвт сургалтыг тус төвийн Эрдэм шинжилгээний ажилтан Г.Бадамцэцэг зохион байгуулан явуулсан ба нит 73 хүн хамрагдсан.

Гурав. Соёлын бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хүрээнд:

“Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.2.4; 1.3.5, 1.3.8; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2.1; 2.6.1.3; Соёлын яамны стратеги төлөлөгөөний 2.1 зорилтын хүрээнд Үндэсний номын сангийн стратегийн зорилт 4. Номын сангийн мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулж, олон улсын стандартын жишигт нийцүүлж, цахим үйлчилгээг бий болгох зорилт тавин ажиллалаа.

Номын сангийн мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулах.

Үндэсний номын сангийн Коха системийн 3.18 хувилбарыг шинэчлэлийг орон нутгийн болон бусад номын сангуудад нэвтрүүлэх боломжтой байхаар цахим номын сангийн нэгдсэн системийн зураглалыг ЦБМТСХ-ээс чиглэл авч хамтран ажлын даалгаварыг боловсруулсан ба гуравдагч талын /E-San, M+/ мэдээллийн системүүдтэй холбогддог, мэдээлэл дамжуулах боломжтой байх, мөн программ хангамжийн эх кодыг стандартын дагуу тайлбартай бичих, холбогдох баримт бичиг, эх код захиалагч талын өмч болох зэрэг шаардлагатай шаардлагуудыг тусгасан.

Тендерийн баримт бичгийг Багц-8-д тусгасан ба яамны СХОГ, Төрийн ХААГ-аас тендэрийг зарлан “АйСиТи групп” ХК шалгаран, 9 дүгээр сарын 08-ны өдөр СОЯ/202202037/8 гэрээ байгуулсан.

XIV.3.11 “Үндэсний номын сангийн өргөтгөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” тендерийн “Номын сангийн программ хөгжүүлэлтийн ажлын даалгавар Багц 8” ажлын хүрээнд “Ай СиТи групп” ХК-д Үндэсний номын сангийн ашиглаж буй системийн шинэчлэлийн ажлууд төлөвлөгөө гарган, өгөгдлийн сангийн мэдээлэл болон ажил гүйцэтгэх явцын шаардлагатай тодруулгыг өгч, СБХЗГ, ЦБМТХэлтэс-т мэдээлэл, чиглэл авч,

төлөвлөгөө гарган ажиллаж байна. ГЕН-ийн 3.9 дэх хэсэгт заасанаар 12 дугаар сарын 12-ны өдөр Коха программын 21.0 хувилбарыг хүлээлгэн өгнө.

Номын сангийн сан хөмрөгийг цахим хэлбэрт шилжүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

Цахим номыг дэвтэрчлэн унших програмын /Calibre, Flipping book/ туршилт хийгдэж, хөрвүүлэх заавар, цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөө, ажлын байранд тавигдах шаардлагыг бодовсруулан "Сан хөмрөгийг цахимд шилжүүлэх ажлын хэсэг" -ийг 8 ажилтны бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, сурган дадлагажуулсан.

- МЗЭ-ээс эрхлэн гаргадаг “Цог” сэтгүүлийн 328 дугаарын 74040 хуудсыг сканнердаж, JPEG зургийг засварлан, PDF хөрвүүлэн архивлах ажлыг амжилттай гүйцэтгэлээ.

- Монгол судлал, гар бичмэл номын, төвөд номын сан хөмрөгөөс 1280 нэрийн 40411 хуудас ном, гар бичмэл, диссертаци цахим хэлбэрт шилжүүлсэн.

- Төвөд номыг дижиталчлах ажлын хүрээнд 1340 багц судрын 433788 хуудас цахим хэлбэрт шилжүүлсэн.

Нийт: 35389 ш, 548239 хуудас.

Цахим сан хөмрөгийг 1,8%-иар нэмэгдсэн. Өссөн дүнгээр нийт сан хөмрөгийн эзлэх хувь 2,5%-д хүргэсэн.

Шинэ салбар номын сангийн интерьер дизайны зураг төсвийг хийлгэх төслийг хэрэгжүүллээ. 2022 оны 7-р сараас 4 үе шаттай хэрэгжиж, зургийг "Саясанаа" ХХК хийж гүйцэтгэж ажлын зураг, төсвийг номын санд хүлээлгэн өгсөн.

Энэ төслийн хүрээнд Голомт сан" Үндэсний номын сангийн хооронд байгуулсан төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний төсөл", "Голомт сан" "Саясанаа" ХХК-ийн хооронд байгуулсан зураг төслийн гэрээний төсөл", Ажлын даалгаврын төсөл, план төлөвлөлт, концепци төсөлд саналаа өгч, ажлын хэсгийн хуралдааныг 4 удаа хуралдаж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэгт, Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар "Үндэсний номын сангийн интерьер заслын төсвийн талаар" танилцуулга хийж, Барилга хөгжлийн төвд материалыг хүлээлгэн өгч, интерьерийн засвар хийх төсвийг батлуулаад байна.

Үндэсний номын санг шинэ барилга ашиглалтад орох бэлтгэл ажил, нүүлгэн шилжүүлэх цогц төлөвлөгөөг боловсруулах, зохион байгуулалтын ажил:

Барилгын гүйцэтгэлийн явц: Гүйцэтгэгч компанийн захирал асан "С"-тэй холбоотой компанийн өвлөгчийн асуудал шийдвэрлэгдээгүйгээс хэвийн үйл ажиллагаа алдагдаж, компани эрх зүйн чадамжгүй, санхүүгийн эх үүсвэргүй болсон. "Акми холдинг" ХХК-ны 2022 оны байдлаар гүйцэтгэл 93,2% Соёлын яамнаас 2022.09.26-ны өдрийн 3/2479 тоот албан бичгээр гэрээ цуцлах тухай мэдэгдлийг тус ХХК-ийн холбогдох хүмүүст хүргүүлж, хийж гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ болон үлдэгдэл ажлыг тооцож авах ажлын хэсгийг Соёлын сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/371 дүгээр тушаалаар байгуулан Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.

Нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын зохион байгуулалт:

СоЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022.02.21-ны өдрийн А/16 дугаар тушаалаар "Ажлын хэсэг байгуулах тухай" шийдвэр гарсан."Үндэсний номын санг шинэ барилга руу нүүлгэн шилжүүлэх цогц төлөвлөгөө"-г боловсруулсан.

“Нүүлгэн шилжүүлэлтийн үед баримтлах заавар”-ын төслийг боловсруулсан. СБХЗГ-ын дарга, ажлын хэсгийн дарга Д.Наранцэцэгт “Нүүлгэн шилжүүлэх ажлын цогц төлөвлөгөө”-г гарган танилцуулсан. ХХЕГ-тай уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө, шаардагдах төсвийг гарсан. 2022 оны 04-р сарын 11-ны өдөр Дэд сайдад, 2022 оны 04-р сарын 20-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хурлаар, 7 сард Соёлын Сайдад танилцуулсан.

Шинэ барилгын явц, бэлтгэл ажил, концепцтой холбоотой танилцуулга, уулзалт, ажлын хэсгийн хурлыг тухай бүр зохион байгуулж ажилласан.

- 2022.01.12, 03.13-нд ХХЕГ-ын удирдлагуудтай уулзаж, нүүлгэн шилжүүлэлтийн үед хэрэглэх, техник, тоног төхөөрөмжтэй танилцаж “Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн цогц төлөвлөгөө”-г боловсруулсан.
- 2022.02.11-нд Соёлын сайдын Хууль зүйн яаманд илгээх нүүлгэн шилжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах талаарх албан бичгийг төлөвлөн илгээж, зөвшөөрлийг авсан. Мөн нүүлгэн шилжүүлэх ажлын төсвийг /110 сая/ батлуулсан.
- 2022 оны 02-р сарын 16-ны өдөр Соёлын яамны дэд сайд М.Батбаяр, Соёл гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг болон яамны холбогдох мэргэжилтнүүд шинэ барилгын явцтай биечлэн танилцаж тодорхой үүрэг чиглэл өгч ажиллалаа.

- 2022 оны 03-р сарын 17-ны өдөр Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Бум-Очир, Соёлын дэд сайд М.Батбаяр, СБХЗГ-ын дарга Д.Наранцэцэг болон яамны холбогдох мэргэжилтнүүд шинэ барилгын явцтай биечлэн танилцлаа.

- Соёлын яамны СБХЗГ-ын дарга Наранцэцэг “ болон ажлын хэсэгт "Нүүлгэн шилжүүлэх ажлыг цогц төлөвлөгөө”-г хэлэлүүлж, “Нүүлгэн шилжүүлэлтийн үед баримтлах заавар зөвлөмж”-ийн төслийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулж танилцуулж санал авч, зааврыг захирлаар батлуулсан.

Соёлын сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/371 дүгээр тушаалаар байгуулагдсан Үндэсний номын сангийн шинэ барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын ажлын явц байдалтай танилцаж, гүйцэтгэсэн болон үлдэгдэл ажлын тоо хэмжээг нягталж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг 3 удаа хуралдаж, санал солилцсон.

Үндэсний номын санг шинэ барилга руу нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сан хөмрөгийн 380857 ширхэг ном, 35500 нэгж тогтмол хэвлэлийг баркоджуулан, нүүх болон үлдэхээр ялгаж, Коха системээр тооллогыг зохион байгуулсан.



- Монгол Улсын Үндэсний номын сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, үзэл баримтлалын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх:

- Монгол Улсын Үндэсний номын сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, үзэл баримтлалын төслийг боловсруулах Соёлын сайдын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/18 дугаар тушаал батлагдаж, Соёлын дэд сайд М.Батбаяраар ахлуулсан ажлын хэсэгт хэлтсийн дарга Г.Гүнжинлхам ажиллаж, Монгол Улсын Үндэсний номын сангийн үндсэн чиглэл, үзэл баримтлалын төслийг хэлэлцүүлж, холбогдох санал, судалгаа авч үзэл баримтлалын төсөл, зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх төслийг боловсруулж, дараах материалыг боловсруулсан. Үүнд.

- *Монгол улсын үндэсний номын сангийн үзэл баримтлал, үндсэн чиглэлийн төсөлд нэгжийн дарга нарын саналыг тусгасан байдал*
- *Монгол улсын үндэсний номын сангийн үйл ажиллагаанд хийсэн мандатын шинжилгээ, чиг үүргийн шинжилгээ*
- *Монгол улсын үндэсний номын сангийн үйл ажиллагааны шинэ үзэл баримтлалын өөрчлөлтүүд*
- *Монгол улсын үндэсний номын сангийн үзэл баримтлал, үндсэн чиглэлийн төсөлд соёлын сайдын саналыг тусгасан байдал*

2022 оны 04-р сарын 11-ны өдөр Дэд сайдад, 2022 оны 04-р сарын 20-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хурлаар, 5-сард Соёлын Сайдад 2 удаа танилцуулсан.

Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

2.1 **"Соёлын баримтат өвийг хадгалах, хамгаалах, судлах, олон нийтэд сурталчлах.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг; Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14.2; 20.6.3; 46.4; 31.2.4; 36;

- Гар бичмэл, барласан ном судраас 1280 нэрийн 40411 хуудас ном, гар бичмэл, диссертаци цахим хэлбэрт шилжүүлсэн.

Баримтат өв ном, судрын гэмтлийг сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор монгол бичгээр бичигдсэн 8 нэрийн гар бичмэл номын 910 нүүр буюу 455 хуудсыг сэргээн засварлан хайрцаг сав, хавтас хийн сан хөмрөгт хүлээлгэн өгч ажилласан. СӨҮТ-ийн үйл ажиллагаатай танилцан, Соёлын өвийн сэргээн засварлагч, доктор О.Ангарагсүрэнгээс тус тус цаасан өвийн сэргээн засварлах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч ажилласан.

- Соёлын баримтат өвийг сурталчлах цогц арга хэмжээний хүрээнд нийт 5 удаагийн бие даасан үзэсгэлэн, соёлын өвийн , сэдэвчилсэн 3 үзэсгэлэн зохион байгуулж, олон нийтэд тайлбарлан сурталчлав. Нийт 8 үзэсгэлэн. Соёлын өвийн үзэсгэлэнг https://exhibition.nationallibrary.mn/ веб хуудсаар, цахимаар үзэсгэлэнгийн танилцуулга мэдээ, ном судрын талаар хийсэн нэвтрүүлгийг Үндэсний номын сангийн youtube сувгаар сурталчилсан.

Үнэт ховор номын музейн байнгын үзэсгэлэнг танхимаар нийт 1978 хүнд /859 иргэн, 491-оюутан, 628-сурагч/ тайлбарлан үзүүлж, сурталчилсан ба "Үнэт ховор номын музейн журам", тасалбарын эхийг шинэчлэн бэлдэж хэвлүүлэв.
Соёлын өв, бичиг үсгийн дурсгалын үзэсгэлэнг https://exhibition.nationallibrary.mn/ веб хуудсаар, цахимаар үзэсгэлэнгийн танилцуулга мэдээ, ном судрын талаар хийсэн нэвтрүүлэгийг нийт 39 удаа бэлтгэн фэйсбүүк хуудас Үндэсний номын сангийн youtube сувгаар 511546 хүнд сурталчилсан ба цахимаар нийт 750,000 орчим хүнд сурталчилсан.

"Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойд зориулсан "Алтан цуглуулбар-999" номын үзэсгэлэн" нэртэй 13 минут 25 секундын нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн ба хэвлэл мэдээллийн байгууллага, телевизүүдэд гаргахаар албан бичгээр хүргүүлээд байна. Дараах холбоосоор үзэж сонирхуулж байна.

www.youtube.com/watch?v=05dIYd1Z6V0

- **"Үндэсний бичиг үсгийн баяр-2022" арга хэмжээ зохион байгуулах.**

Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Соёлын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Монгол хэлний тухай хуульд заасан 2025 оноос албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулахтай холбоотой хэрэглээг нэмэгдүүлэх, "Хос бичигтэн" болох санаачлагыг идэвхжүүлэх зорилгоор 19 дэх жилдээ зохион байгуулсан.

"Үндэсний бичиг үсгийн баяр – 2022" арга хэмжээг МУ-ын Ерөнхийллөгчийн дэргэдэх ХБҮЗ, МҮОНРТ, МУИС, Бичиг соёл боловсролын төв ТББ, Миний монгол бичиг ТББ-тай хамтран 2 үзэсгэлэн, 8 арга хэмжээг зохион байгуулсан.

Байгууллагын цахим хуудсанд зохион байгуулсан арга хэмжээний талаар 36 нийтлэл оруулж, 291818 хүнд хүрсэн байна.

Арга хэмжээнд нийт хамрагдсан хүний тоо-4500 гаруй.

Үндэсний бичиг үсгийн баярын нээлтийн ёслол Монгол Улсын Үндэсний номын сангийн гадна талбайд болж, Соёлын дэд сайд М.Батбаяр, Хэлний бодлогын үндэсний зөвлөл дарга С.Дулам, Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо, Соёлын яамны Соёл, гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг, ШУА-ийн ХЗХ-ийн захирал Ж.Бат-Ирээдүй, МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн эрхлэгч Б.Түвшинтөгс, МУБИС-ийн Монгол хэл шинжлэлийн тэнхимийн эрхлэгч Д.Соронзон болон эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн монгол хэл, бичгийн багш нар, мэргэжлийн ангийн оюутнууд, олон нийтийн төлөөлөл оролцлоо.

Зохион байгуулсан арга хэмжээ:

- “Монголчуудын хэрэглэж ирсэн бичгийн хэв, хэвлэлийн түүх” үзэсгэлэн
- "Үндэсний бичиг үсгийн баяр-2022" номын үзэсгэлэн
- “Монголчуудын эртний бичгийн сурвалж судалгаа” сэдвээр эрдэмтэдтэй уулзалт
- "Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа шинжилгээний ач холбогдол бүхий ном, судрыг нөхөн бүрдүүлэх журам"-ын төслийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг
- "Бүтээлч бичигтэн" үзэсгэлэн арга хэмжээ
- “Монгол бичгийн цахим бичвэр” улсын уралдаан
- "Үндэсний бичгийн сургамж ба хэрэглээ" судлаачидтай хийх уулзалт
- “Үндэсний бичигтэн монгол” шууд нэвтрүүлэг

2.2. Эрдэм шинижлгээ, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах.

Соёлын яамнаас олон улсын Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах өдрийг тохиолдуулан “Гэрэлт хөшөө, хад чулуун дээр хадгалагдсан соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” эрдэм шинжилгээ онол практикийн хурлыг Монгол Улсын Үндэсний номын сантай хамтран зохион байгууллаа. Хурлын сэдвийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр орших түүх, соёлын үл хөдлөх өвийг хамгаалах чиглэлээр эрдэмтэн судлаачдын хэрэгжүүлсэн олон талт судалгаа, ажлын үр дүнг танилцуулахаас гадна баримтат өвийн өмнө тулгамдсан асуудлыг хэлэлцэн гарц шийдлийн талаар оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, цөлжилт зэрэг байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан хүчин зүйлс, хөдөө хээр орших эртний бичгийн дурсгалын хадгалалт хамгаалалтын байдалд сөргөөр нөлөөлж байгаагийн сацуу аялагч, жуулчид хад чулууны толигор гадаргуу болон хөшөө чулуун дээрх эртний бичээс дээр тоо, үсэг давхарлан сийлэх, элдэв зураг зурах, чулуулгийг гэмтээх зохисгүй үйлдэл гаргаж үнэ цэнтэй байдлыг дордуулах явдал тасрахгүй байна.

Энэ удаагийн хуралд оролцогчид гэрэлт хөшөө, хад чулуун дээрх бичээсүүдийн тайлал, хамгаалалтын өнөөгийн байдал, сэргээн засварлах олон улсын туршлагын асуудлыг тодорхой хүрээнд сэдэвчлэн авч үзэн, шийдлийн хувилбарыг дэвшүүлж, байр сууриа илэрхийлсэн. Эдгээр асуудлаар зөвлөж, хэлэлцэх нь соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг зөв зүйтэй төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгохоос гадна цаашид энэ чиглэлийн хурал, уулзалт, зөвлөгөөн, симпозиумыг тогтмол зохион байгуулж байх тал дээр санал нэгдлээ.

ЮНЕСКО-ийн "Олон улсын хөшөө дурсгалын өдөр"-ийг тохиолдуулан Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран "Гэрэлт хөшөө, хад

чулуун дээр хадгалагдсан соёлын баримтат өвийн өнөөгийн байдал" ЭШХ зохион байгуулж, 76 уншигч, эрдэмтэн судлаач, оюутнууд оролцсон.

Хуралд музей, номын сан, архив, их, дээд сургууль, хүрээлэн, хууль сахиулах байгууллагын 80 гаруй төлөөлөгч оролцлоо.Ташрамд дурдахад баримтат өвийг хамгаалах хурлыг 2015 онд “Цаасанд мөнхөрсөн баримтат өв” сэдвийн хүрээнд зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2018 онд “Дүрс, дуу авианд шингэсэн баримтат өвийн өнөөгийн байдал”, 2019 онд “Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал”, 2020 онд “Чулуун болон модон соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” сэдвийн хүрээнд тус тус зохион байгуулсан юм.

ЮНЕСКО-ийн "Дэлхийн ном, зохиогчийн эрхийг хамгаалах өдөр"-ийн (World book and copyright day) хүрээнд номын санч, мэдээллийн ажилтнуудын дунд "Номын сан, мэдээллийн ажилтан мэдээллийн боловсрол олгогч болох нь" сэдэвт цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, бүх төрлийн номын сангийн төлөөлөл 70 гаруй номын санч, мэдээллийн ажилтан хамрагдлаа.

- Соёлын бүтээлч сарын хүрээнд "Mongolian Library Update-2022" Номын санч-Мэдээллийн ажилтнуудын үндэсний IX зөвлөгөөнийг Соёлын яам, Үндэсний номын сан Монголын номын сангуудын консорциумтай хамтран 2022.11.09-ний өдөр зохион байгуулж, танхимаар 120, цахимаар 183 Номын санч-мэдээллийн ажилтанууд идэвхтэй оролцож, зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжид тусгах саналыг нэгтгэн хүргүүлсэн.
- Соёлын яамнаас зохион байгуулж буй Соёлын бүтээлч сарын хүрээнд “Утга зохиол судлал, шүүмж, хамтын ажиллагаа, бодлого” форумыг МЗЭ, “Адмон” хэвлэлийн газар, “Номын соёлт ертөнц” ТББ-тай хамтран зохион байгуулсан ба нийт 100 гаруй хүн оролцож, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэн, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар болон Монголын утга зохиолын бодлогын баримт бичигт тусгах бодлогын зөвлөмж гаргасан.

Мэргэжил арга зүйн сургалт: 11 аймагт 13 удаа танхим болон цахимаар, орон нутагт очиж нийт 525 номын санчдад зохион байгуулсан. Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт сэдвийн хүрээнд 5 цуврал сургалт

онлайнаар зохион байгуулсан. Уг сургалтад давхардаагүй тоогоор 600 гаруй номын санч хамрагдсан.

Сургалтын сэдэв:

1. Цахим сан хөмрөгийн тухай ойлголт
2. Цахим сан хөмрөг бүрдүүлэх бодлого
3. Цахим сан хөмрөг бүрдүүлэх аргууд
4. Цахим сан хөмрөгийн хадгалалт
5. Цахим сан хөмрөгийн хэрэглээ

сургалтын хөтөлбөрийг мэргэжил арга зүйн хичээлийн хөтөлбөр, сургалтын санд оруулж, давтан сургалт явуулах боломж бүрдсэн.

Бусад сургалт: Нийслэлийн боловсролын газрын хүсэлтээр ЕБС-ийн номын санч нарын "Зөвлөлдөх баг"-ийг чадавхжуулах сургалт, Австрали Улсын ЭСЯ-ны дэмжлэгээр “Орон нутгийн номын санчдыг чадавхжуулах" сургалтыг Архангай, Дундговь, Сэлэнгэ аймгийн нийтийн номын санд зохион байгуулж, хамтран ажилласан.

2.3 Страгийн зорилт 1.1. Үндэсний соёлын өв, оюуны бүтээлийг баяжуулах, цуглуулах, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх. /Номын сангийн тухай хуулийн 9.2.2; 17.1 дэх заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, 53.2, 53,3 дахь хэсэг; Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 4.3/ 2.2.1 Бүтээгдэхүүн үйлчилгээний чанарт судалгаа хийж, уншигчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үндэсний соёлын өв, оюуны үнэт бүтээлээр сан хөмрөгийг баяжуулах.

МУҮНС-ийн 2012-2022 оны ном бүрдүүлэлтийн байдал, Коха программын татгалзал, уншигчдын судалгаанд дүн шинжилгээ хийж 2022 оны бүрдүүлэлтийн төлөвлөгөөг хийсэн. “Мөнхийн үсэг” ХХК, “Адмон” ХХК, “Номын коллектор” ХХК, “Монголын хэвлэн нийтлэгчдийн холбоо”, Хэл зохиолын хүрээлэнтэй байгуулсан “Ном худалдан авах гэрээ”-г үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Мөн Ном бүрдүүлэлт, каталогжуулалт, лавлагаа мэдээллийн үйл ажиллагааг Google Driver программын тусламжтайгаар хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах, тайланг нэгтгэх ажлыг хийж, номын санчдын ажлын гүйцэтгэлийг ил тод, дүгнэж, тайланг хагас, бүтэн жилээр нээлттэй хэлэлцүүлэн хэлтсийн ажлыг дүгнэж байна.

Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлтийг хийхдээ судалгаанд суурилж, ном хэвлэлийг бүрдүүлж байна. 2022 онд бүрдүүлэлтийн судалгааг 6 удаа хийж:

- 2021 оны нийт бүрдүүлэлт шинжлэх ухааны мэдлэгийн салбараар,
- 2021-2022 оны 1-р улирлын бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа
- 2022 оны бүрдүүлсэн номын хэлний байдлаар харьцуулсан судалгаа
- 2022 оны бүрдүүлсэн номын сан хөмрөгийн байдлаар харьцуулсан судалгаа
- 2022 оны бүрдүүлэлтийн төрөлд хийсэн судалгаа
- 2022 оны нийт бүрдүүлэлт шинжлэх ухааны мэдлэгийн салбараар хийж бүрдүүлэлтийг судалгаанд суурилан бүрдүүлж байна.

Уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн 378 нэрийн 1578 ширхэг 42.490.180 төгрөгний номыг шинээр худалдан авч, бэлэг хандивын журмаар 549 нэрийн 1666 ширхэг 36.560.250 төгрөгний ном, заавал авах хувиар 120 нэрийн 120 ширхэг 1.210.000 төгрөгний диссертаци CD, 26 нэрийн 143 ширхэг 2.348.938 төгрөгний ном, солилцоогоор 327 нэрийн 334 ширхэг 7.427.500 төгрөгний, нөхөн бүрдүүлэлтээр 30 нэрийн 43 ширхэг 846.300 төгрөгний Нийт 1430 нэрийн 3884 ширхэг 90.883.168 төгрөгний ном хэвлэлээр бүрдүүлсэн.

Бүрдүүлсэн 1430 нэрийн 3734 номыг ангилалын дагуу ангилж, данслан, Каталогт 5980 карт бичиж, 5241 карт байрлуулж, Редакц- 21166, Карт хуулах -3007, Индикатор -1430, Уншигч, номын санчдад 1863 удаа аман лавлагаа өгч ажилласан.



Архивын сан хөмрөгт 739 нэрийн 739 ширхэг 14.984.086 төгрөгний ном, Бэлтгэл фондод 324 нэрийн 324 ширхэг ном 6.994.340 төгрөгний ном хүлээн авч, Коха програмд архивын 10045 ширхэг номын мэдээллийг оруулсан. Бэлтгэл фондоос захирлын зөвшөөрлийн дагуу 9.438.577 төгрөгний 368 нэрийн 500 ш ном зарлагадаж, баримтыг бүртгэлийн номын санчид өгч, тэмдэглэгээ хийлгэсэн. Гадаад орнуудтай ном хэвлэл солилцох үйл ажиллагааг сайжруулахын тулд ОХУ-ын Үндэсний номын сан, Солонгосын үндэсний номын сан руу хамтын ажиллагааг өргөжүүлэх, Болгар, Эстони, Казакстан улс руу гадаад солилцоогоор хамтын ажиллагааг эхлүүлэх саналыг илгээж, шинээр ном солилцоог эхлүүлсэн. Мөн Солилцоогоор сан хөмрөгт бүрдүүлсэн номын судалгааг 2 удаа:

- 2022 оны гадаад солилцооны бүрдүүлэлт шинжлэх ухааны мэдлэгийн салбараар,
- 2022 оны эхний хагас жилд гадаадын номын сан эрдэм шинжилгээний байгууллагад илгээсэн номын судалгаа хийсэн.

Харилцаат номын санд 21 нэрийн 164 ширхэг 3.648.300 төгрөгний ном илгээж, 327 нэрийн 327 ширхэг 7.427.500 төгрөгийн ном, 22 нэрийн 77 ширхэг 255.750 төгрөгний сэтгүүлийг харилцаат номын сангаас хүлээн авсан байна.

Дорно дахины сан хөмрөгийн 37335 ном, Тогтмол хэвлэлийн сан хөмрөгийн 10260 нэгж 30769 ширхэг тогтмол хэвлэл, Монгол судлал гар бичмэлийн нийт 59561 ширхэг ном, судар, диссертаци, авторефератыг тоолж, дүнг гаргаж, илтгэх хуудас бичсэн. Ойрын сан хөмрөг, Монгол, Өрнө дахины сан хөмрөгийн форматын тооллогуудын илтгэх хуудсыг бичиж, 2022 оны 5-р сарын 17-ны өдрийн мэргэжлийн зөвлөлөөр оруулж хэлэлцүүлсэн.

2022 оны 03-р сарын 28, 31, 04-р сарын 12, 25-ны өдөр "Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа шинжилгээний ач холбогдол бүхий ном, судрыг нөхөн бүрдүүлэх журам"-ын төсөл дээр ажиллаж 5 удаа хуралдаж, Төрийн нарийн бичгийн даргад журмын танилцуулгыг танилцуулсан. "Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа шинжилгээний ач холбогдол бүхий ном, судрыг нөхөн бүрдүүлэх журам"-ын дагуу нөхөн бүрдүүлэх шаардлагатай /159 нэрийн 471 ширхэг 157.317.975 төгрөгний/ номын жагсаалтыг бэлтгэж Соёлын яаманд хүргүүлсэн.

- “Дэлхийн номын баяр”-аар Шинжлэх Ухааны Академитай хамтран шинэ ном хандивлах “Эрдэм номын чуулган” үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, заавал авах хувийг сурталчилж, 12 хүрээлэнгээс биечлэн очиж хандивын 372 ширхэг номыг хүлээн авч, батламжийг гардуулсан.

Ерөнхий сайдын ажлын албанаас хэвлүүлсэн “Алсын хараа-2050” номын нээлт болон их дээд сургууль, нийтийн номын сангуудад хандивлах үйл ажиллагааг хэлтсээрээ зохион байгуулж, номыг хуваарийн дагуу тарааж байна.

Номын нээлт:
Шинэ номын нээлтэнд 10 орчим удаа оролцлоо. Үүнд:
- МУ-ын ШУА-д нээлтээ хийсэн ‘’Амьдралыг тэтгэгч тогтолцооны нэвтэрхий толь’’ 3 боть номын нээлтэнд оролцсон.

“УИХ-аас гаргасан парламентийн эмхэтгэл” номын нээлтэнд оролцож 20 ширхэг ном хүлээн авсан.

- ШУАТАХ болсон эрдэмтэн Л.Балдангийн эрдмийн бүтээл номын нээлт
- МУИС-ийн “Криминологи” хуулийн номын нээлт.
- Музейн боловсролын ажилтны гарын авлага номын нээлт
- Юмжаагийн Цэдэнбалын 4 боть номын нээлт
- Улаанбаатарын их сургуулийн шинэ номын нээлт,
- "Хаан найргийн хатан Дулмаа" эрдэм шинжилгээний хурал номын нээлт,
- “Цэнгэг сарны улиан” шинэ номын нээлт
- “Олонд хайрлагдсан онцгой тавилан” номын нээлт

Лигдэн Хутагт хааны бүтээлгэсэн монгол шунхан барын Ганжуур Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй бөгөөд 1956-1958 оны үед Энэтхэгийн эрдэмтэн Ачаръяа Рагу Вира уг Ганжуурын эх судрыг гэрэл зурагт буулгасныг түүний хүү профессор Локеш Чандра 1979 онд анх удаа бүрэн цогцоор нь Энэтхэгт хэвлүүлсэн юм. Уг Ганжуурын 108 ботийг дахин хэвлэж, Монгол Улсын их дээд сургууль, номын сан, эрдэм шинжилгээний байгууллагууд, Бурхны шашны сүм хийдүүдэд хүлээлгэн өгөв.

Номын хандивын ажиллагаа:
Дараах 13 байгууллагуудад 529 нэрийн 635 ширхэг номын хандив өгсөн: Үүнд:
- Соёлын Яамны ТНБД Оюунбилэгийн Ховд аймгийн суманд хандивлах 30 ширхэг 630.100 төгрөгний ном, 1 нэрийн 10 ширхэг 65000 төгрөгний сэтгүүл нийт 695.100 төгрөгний номын жагсаалтыг гаргаж номыг Соёлын яамны мэргэжилтэн Д.Мөнхцэцэгт хүлээлгэж өгсөн.
- УИХ-ын гишүүн Адьшаагийн санаачлагаар Ховд аймгийн Дарви сумын номын санд 88 нэрийн 25 ширхэг номыг хандивласан.
- Хан-Уул дүүрэгт шинээр баригдсан эх нярайн төвд 58 нэрийн 68 ширхэг номыг бэлтгэн жагсаалт гарган хүлээлгэн өгөв.
- Хан-Уул дүүргийн хөгжлийн төвийн номын санд хандивлах 200 ширхэг номыг архив бэлтгэл фондтой хамтран гаргасан.
- “Гүүд Нэйборс” ОУТББаас зарласан “Миний ном” хандивын аянд нэгдэж 30 нэр төрлийн 151 ш номыг хандивласан.

- Дэлхийн яруу найргийн өдөрт- 2 нэрийн 4ш ном,
- Универсал Политехник коллежид 19 нэрийн 20 ш ном
- Үндэсний бичгийн сургамж ба хэрэглээ-судлаачидтай хийх уулзалтад 6 нэрийн 31ш
-Соёлын яам- 1 нэрийн 1ш ном,
- Соёл урлагийн ажилчдын өдрийн үйл ажиллагаанд.
- 10 нэрийн 10 ш ном
- ЗХ-ний хуурай замын командлалын газарт- 20 нэрийн 22 ш,
- СХД-ийн 103-р цэцэрлэгийн багачуудад- 9 нэрийн 9 ш.
- Завхан аймгийн Идэр сумын номын санд- 54 нэрийн 54 ш

Уншлага үйлчилгээ:

1. Төрөлжсөн 5 уншлагын танхимаар шинээр 3984 үнэмлэх нээж, уншигчийн үнэмлэх сунгалт 643, сэргээлт 141, 25699 уншигчид 54295 ном олгож, 474 гар бичмэл, солилцоогоор 682 номоор үйлчилгээ үзүүлсэн.
2. Захиргааны зөвлөлийн хурал 8, Номын сангийн мэргэжлийн зөвлөлийн хурал 13, Хэлтсийн хамт олны хурал 4, хуралдуулж тооллогын ажлын хэсэгт оролцсон номын санчдын үндсэн ажлын зохицуулалтыг тухай бүрт нь хийн ажиллуулж байна.

3. ҮҮХ-ийн 10 жилийн судалгаа, "СУ-3 судалгааны маягт", НУТ-ийн 2017-2021 оны судалгаа, 4 танхим 110 уншигчийн судалгаа, 2023 оны төсвийн төсөөлөл, бүтэц орон тооны судалгааг тус тус гаргасан.
4. "Номын хандив- буланг 2 байгуулах, 6 удаа шинэ номын нээлт, Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр "Соёл урлагийн ажилтны өдөр-2022", 78 удаа 4741 номоор сэдэвчилсэн болон шинэ сэтгүүл, номын үзэсгэлэн болон соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулсан.

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүд, шинэ номын, зохиолч уран бүтээлчдын ойд зориулсан номыны үзэсгэлэн 78 удаа 4741 ш номоор гаргаж, цахим болон танхимаар уншигч, сонирхогч, судлаачдад сурталчилсан. Үүнээс 2022 онд 70 наснаас дээш тэгш ой /5, 10 жилээр/ тохиож буй 27 зохиолчдын 600 ном, 12 тогтмол хэвлэлээр үзэсгэлэн гаргасан.

Зохиолчдын шинэ номын нээлт 6, зохиолч уншигчдын уулзалт 5, хуралт-лекцийг 4, уншлагыг дэмжих аян, номын сантай танилцах аяны хүрээнд орон нутаг, албан байгууллагын номын сангууд, шинэ болон бичил номы сан, номын буланд, гэр бүлд зориулсан сайн үйлсийн аяныг нийт 13 удаа зохион байгуулсан.

Нийт зохион байгуулсан арга хэмжээ - 28

Соёл олон нийтийн ажил:

- "Монголчуудын эртний бичгийн сурвалж судалгаа" сэдвээр эрдэмтэдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтад Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч, орчуулагч, судлаач Г.Аким "Хадны гурван бэхэн бичээсийн тухай", Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн "Чингис хаан судлалын хүрээлэн"-ийн захирал, доктор (Sc.D), профессор Б.Сумъяабаатар "Монгол бичгийн дэлхийд хосгүй хоёр дурсгал", судлаач, багш П.Батчулуун "Чингис хааны зарлигт "Хөх бичиг"-ийн тухай нэгэн баримт" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэн, 128 уншигч, судлаач, эрдэмтэд оролцов.

"Үндэсний ном, бичиг үсгийн баяр-2022" арга хэмжээ: СБХЗГ-тай хамтран удирдамж, төлөвлөгөө боловсруулах төсөлд ажиллан, нийт ажлын хэсгийн хурал, зохион байгуулалтын ажилд хамтарч ажиллав. МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн 158 дугаар зарлиг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн "5.1.17, Соёлын сайдын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/125 дугаар тушаал, тус тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний ном, бичгийн өдрүүд" арга хэмжээг Соёлын яам, ЗГХА, СУГ, Нийслэлийн ЗДТГ, НСУГ, ХТНС, УБХНТНС, Номын соёлт ертөнц ТББ зохион байгуулагчаар ажиллан УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор "Илүү их уншъя" уриатайгаар 5 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд, 9 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд 2 удаа зохион байгууллаа.

Үндэсний өв соёлын хүрээг хариуцан ШУА-ийн харьяа хүрээлэнгууд, Соёл урлаг судлалын хүрээлэн, Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэн, Соёлын яамны харьяа байгууллагууд, МЗЭ, Бичиг соёл төв, МЧСНЭ зэрэг 16 байгууллагыг зохион байгуулж ажилласан. Арга хэмжээний хүрээнд ховор номын үзэсгэлэн, номын худалдаа, 3 удаагийн хэлэлцүүлэг, хувь хүмүүсийн ном, судрыг уншиж, тодорхойлж өгөх, уншигчдын судалгаа авах болон Уран бичлэгийн үзүүлбэр, үйлчилгээ,"Номоо эмчилье", Зөөврийн номын үйлчилгээ зэрэг зохион байгуулсан 15 төрлийн арга хэмжээнд нийт 1800 гаруй хүнд хамрагдсан.

“Зохиолчдын фото зургийн үзэсгэлэн”-д зохиолчдын 56 зургаар, “Гар бичмэлийн үзэсгэлэн”-г 19 зохиолчийн 500 гаруй хуудас материалуудаар крилл болон хуучин монгол бичгээр гаргаж, нийт 800 орчим хүн үзэж сонирхсон.

Үндэсний номын сангаас эрхлэн гаргасан ном хэвлэл, судалгааны бүтээлийн үзэсгэлэн, худалдаагаар 26 нэрийн 135 номыг сурталчлан, 10 нэрийн 22 ширхэг 865,000 төгрөгийн орлого олсон.Үйл ажиллагааг МҮОНРТ болон ТВ5, Парламент телевиз, Эргэл.мн, Туг.мн мэдээллийн сайтад ярилцлага, мэдээллийг 16 удаа өгч, сурталчилсан. Мөн байгууллагын цахим

хуудсаар 18 нийтлэл, мэдээлэл, шууд
дамжуулалт /live/ хийж, 68933 хүнд хүрсэн гэсэн үзүүлэлттэй байна.

Номын баярыг хавар намар 2 удаа зохион байгуулж:

- "Зөөврийн номын сангийн үйлчилгээ"-г зохион байгуулж, 200 ширхэг номоор 120 гаруй уншигч, хэрэглэгч, хүүхэд багачуудад үйлчилгээ үзүүлэн, идэвхтэй уншсан гурван сурагч Б.Золзаяа, Б.Ариунзаяа, Т.Дөлгөөн нарыг шалгаруулж номын бэлэг гардуулсан.
- Хувиараа ном борлуулагч Б.Батбаяр, М.Пүрэвсүрэн нар 35 нэрийн 35 ширхэг номыг зөөврийн номын сангийн үйлчилгээнд зориулж хандивлав.
- "Зиндаа" сэтгүүлийн анхны дугаар 2016 онд гарснаас хойш эдүгээ 17 дахь дугаараа гаргасан бөгөөд "Зиндаа" сэтгүүлийн бүрэн дугаар болон өөрийн бичиж хэвлүүлсэн шинэ номынхоо дээжсээс Ерөнхий эрхлэгч Э.Адьяасүрэн Үндэсний номын сангийн сан хөмрөгт хандивлав.
- Ардын уран зохиолч, нэрт зохиолчидтой хийх уулзалтад Д.Цоодол, П.Бадарч, Б.Догмид нарын АУЗ болон "Болор цом"-ын эзэд, нэрт зохиолч яруу найрагчид оролцов.

Соёл, урлагийн ажилтны баярын өдрийг тохиолдуулан Соёлын яамны харьяа соёлын байгууллагууд "Соёлын орон зай" арга хэмжээний хүрээнд: Соёлын өвийн эх загвараас бүтээгдэхүүн бий болгож, сонирхсон хүмүүст барлах хэвээр хуулбарлан өгөх үйлчилгээ хүргэж, олон нийтэд сурталчилсан. Үүнд:

- Чингис хааны эш хөргийн хуулбар: Эх сурвалж: Тайванийн Үндэсний музей, Он цаг: XIII зуун
- Чингисийн чулууны бичгийн дардас: Эх сурвалж: ОХУ-ын Эрмитаж музей
Он цаг: 1225 он
-Гүюг хааны тамганы дардас: Эх сурвалж: Ватиканы нууц архив
Он цаг: 1246 он

Үндэсний номын сангийн цахим каталогийг сурталчилан хэрхэн ашиглах талаар болон Үндэсний номын сангийн сан хөмрөгт байгаа цахим номыг киндл төхөөрөмж ашиглан хэрхэн унших талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

Санал асуулга холбоос QR code-оор болон бичгийн хэлбэрээр 167 хүнээс судалгаа авсан.

Сан хөмрөгүүдэд хийгдсэн ажил: Уншлагын танхимаар **51792** ном хэвлэлийг уншуулж судлуулан **64045** ном хэвлэлийг шинээр ба буцаан байрлуулав.

- Уншлагын танхимаар **40819** ном, диссертаци, **10973** тогтмол хэвлэл нийт **51792 ном**
- **Ш**инээр ба буцаан байрлуулсан **64045 ном**
- Төлбөртэй уншлагын танхимаар **310** ном, **68** нэгж сонин, **38** нэгж **105** сэтгүүл Нийт **521** үйлчлэв.
- Шинээр **2393** ном, 8**0** диссертаци 1396 тогтмол хэвлэл Нийт **3869** хүлээн авч байрлуулав.
- Үзэсгэлэнд **4262** ном, **98** гар бичмэл, **6 с**онин, **47** нэгж **189** сэтгүүл Нийт **4602** үйлчлэв.
- Байгууллагын дотоод болон, байгууллага хоорондын солилцоонд **4573** ном, **1016** тогтмол хэвлэл /**168** нэгж **638** задгай сэтгүүл, **128** нэгж **82** задгай сонин/ Нийт **5589** үйлчилсэн.
- Тоон хэлбэрт **1280** нэрийн судар ном /39911 хуудас 79822 нүүр / оруулж, цахим хэлбэрээр уншуулсан.
- 455 хуудас 910 нүүр 8 гар бичмэлийг Сэргээн засварлуулав. /дэвтэрчилсэн болоод дэлгэмэл номыг А-4-өөр, сударчилсан номыг нэг хуудасны 2 талыг нэг нүүрээр/
- 8551 бар код бэлдэж, нааж эмхэлж цэгцэлсэн.
- **4755** хятад номын нүүр хавтасны зураг сканнердаж редакци хийж Коха програмд холбож, 2226 номонд редакци хийж бар кодыг хэвлэж наав.
- **8210** төвд ном судрыг ялган цэгцэлж, **569** номыг электрон каталогт оруулж**,** **2040** номыг дансанд бичиж**, 1676** карт бичиж хэвлэн гаргав.
- Уншигчдадтөвөд судар номын аман болон бичгийн лавлагааг нийт 1**5** хүнд **400** номоор өгч үйлчилсэн.
- **1604** боть Төвөд судартдонтор ялгагч хийж, баринтаглаж байрлуулав.
- Сан хөмрөгүүд **354** удаа Гэрэлтүүлэг, чийгшил, дулаан, ариун цэвэр, эрүүл ахуйн стандарт горимыг хангаж байгаа байдлын өдөр тутмын бүртгэлийг хөтлөж, шалган танилцаж ажиллав.
- **762007** ном хэвлэлд байрын шалгалт хийж, цэгцлэж янзлан байрлуулав.
- Гаднаас ирсэн зочид төлөөлөгч, хэвлэл мэдээллийн ажилтан, сургуулийн сурагчид мэргэжлийн сургуулийн оюутан нийлсэн **35** хүнд нийт 1**5** удаа сан хөмрөгүүдийг танилцуулж сурталчилсан.
- Сэлбэн засагчид **3856** сэтгүүл сонин, **32** албан бичиг, Нийт **3888** нэгжлэн хавтаслаж, **5680** ном сэлбэн засав. /6145 хуудас нааж сэлбэж, 1398 урагдаж элэгдсэн хуудсыг хувилж нөхсөн/
- Ариутгагч нар 272400 ном хэвлэлийг ариутган цэвэрлэхээс 283667 ном хэвлэлийг ариутган цэвэрлэж төлөвлөгөөг **104%** биелүүлэв.

Ганц хувь бүтээл, гар бичмэлийн эх хувийг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглуулах.

Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай уулзалт зохилон байгуулж, Соёлын өвийг хамгаалах хуулийн хэрэгжилт, судлаачдад бүрэн эхээр хуулбарлан өгөх талаар санал солилцон өгөгдсөн чиглэлийн дагу ажилласан.

Соёлын өвийг хамгаалах тухай 53.1, 2, 3 дахь заалтын дагуу Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах Ганц хувь бүтээл, гар бичмэлийн эх

хувийг судалгаа, шинжилгээний зориулалтаар байгууллага судлаачидтай хамтран ажиллаж үйлчлэв.
1. Уншигч Нямзайн Төрбатын хүсэлтээр 211/96 дансны дугаартай “Сайн ноён хан аймгийн өөлд Цорос хавсрагдсан хошууны Сандагдорж тайж нарын гэрийн бичмэл” эх бичвэрийн хэсэгчилсэн хуулбарыг хийж өгч хамтарч ажиллав. Нийт 4000 төгрөг. Бэлэн мөнгөний орлогын баримт 171792
2. Удирдлагын академийн хүсэлтээр Соёлын яамны 2022 оны 03 сарын 07 ний өдрийн 1/522 албан тоот, “Монгол Улсын төрийн албаны уламжлал, үнэт зүйлс /Түүхэн эх сурвалж/” эрдэм шинжилгээний төслийн хүрээнд судалгаа, шинжилгээ хийх ажилд нь 1. 2477/96 дансны дугаартай Хааны бичсэн сайдын сэтгэл цээрлүүлэх бичиг, 2487/96 дансны дугаартай Түшмэлийн засгийн чухлыг хураасан бичиг нэртэй 2 эх сурвалжийг бүрэн эхээр нь хуулбарлан авах ажил гүйцэтгэхэд Гэрээ байгуулан хамтран ажиллав.
3. Уншигч судлаач Ж. Баасанжавын хүсэлтээр Засагт хан аймаг, дайчин засаг Жалцангомбодорж тайжийн хошууны тайж нарын гэрийн үеийн бичмэлийн хэсгээс өөрийн элэнц өвөө Дамба, холонц өвөө Отгон, элэн өвөө Галба нарын нэр орсон хэсгийг хуулбарлан өгч хамтран ажиллав. 2022.05.24
4. Улаанбаатар Их сургуулийн багш Х. Номлосарангийн хүсэлтээр 1. 5264/96 дансны дугаартай “Гэтэлгэгч Ра Лозова”-ийн намтар оршивой гар бичмэл 4 нүүр, 2. 2787/96 дансны дугаартай “Холбоо найруулга” гар бичмэл номоос 3 нүүр нийт 7 нүүр хуулбарыг хийж хамтарч ажиллав.
5. Япон улсын Шоова эмэгтэйчүүдийн их сургуулийн докторантур Ц. Зүмбэрийн хүсэлтээр 1. 37/96 дансны дугаартай “Дундад олон улсын түүх”, 2. 1145/96 дансны дугаартай “Монголын хэмжээт засгийг... “ нэрт 2 эх сурвалжаас Монгол улсын орчин цагийн нэр томьёоны түүх сэдэвт судалгааны ажилд нь зориулж 4, 4 нүүр Нийт 8 нүүрийг цахим хаягаар нь илгээв.
5. Өндөр настан Я.Баатарын хүсэлтээр 8345/96 дансны дугаартай “Гэсэр хааны тууж” эх сурвалжаас 20 нүүр, 8540/96 дансны дугаартай “Гэсэр хааны тууж” өөр нэг хувилбар эх сурвалжаас тус тус 20, 20 нүүр нийт 40 нүүрийг цахимаар өгч хамтарч ажиллав.
6. Судлаач К. Уранчимэг, Г. Энхжин нарын хүсэлтээр 8345/96 дугаартай “ Гэсэр хааны тууж” гар бичмэлээс 11-22 нүүрээс хэсэгчилэн, 8540/ дугаартай “Гэсэр” тод үсгийн гар бичмэл номоос12-22, 23-34-р хуудсыг судалгааны зорилгоор хуулбарлан өгч хамтран ажиллав.
7. Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн 2022.11.18 ны 1/379 тоот албан тоот хүсэлтийн дагуу Түүхийн тэнхимийн багш, доктор Н. Баярцэцэгт Дорно дахины сан хөмрөгт хадгалагдаж буй 5020 дугаартай “Монгол үсгийн журмыг салгасан бичиг” (Манж-Хятад-Монгол үгийн толь бичиг)-ийн 2, 19-р тал, 4933 дугаартай “Манж арван хоёр тэргүүн үсэг” (Манж-хятад үгийн толь бичиг)-ийн 2, 66-р талыг уг эхээр нь хуулбарлан авч, “XVII-XX зууны эхэн үеийн Монголын боловсрол” хамтын бүтээлд нь оруулахад хамтарч ажиллав.

2.4. Соёлын баримтат өвийг хамгаалах, судлах талаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэх.

/Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.3; Номын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1/

Төвөд номыг дижиталчлах төсөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.Төслийн үйл ажиллагааг зохицуулагч Б. Сайнбилэг хариуцаж, бүхэлд нь хянах, каталог болон цахим датаг архивлан хадгалах, аюулгүй байдлыг хангах, захиралд үйл ажиллагаагаа танилцуулах, америк мэргэжилтнүүдтэй холбогдож

заавар зөвлөгөөг авах уламжлах хэрэгжүүлэх болон төслийн үйл ажиллагаагаа тайлагнадаг.

Азийн Өвийн Сан (Asian Legacy Library) буюу ACIP (Asian Classics Input Project) -ийн Америк удирдлага болох Жон Брэди, Эмма Льюс нар Монголд ирж 2018 онд байгуулсан гэрээг дахин хэлэлцсэн мөн АНУ-ын ЭСЯ, Монголын бусад байгууллагуудтай танилцаж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. 2018 оны "Харилцан Ойлголцлын санамж бичиг"-ийг "Хамтын ажиллагааны гэрээ" болгон агуулгыг боловсруулсан. Хамтын ажиллагааны гэрээний эцсийн найруулга хийгдсэн бөгөөд Соёлын яамны албаны хүмүүсээр хянагдаж байна.

Каталогт 33781 гарчиг ном оруулж, 1340 багц судрын 433788 хуудас цахим хэлбэрт, 1960 багц судрын зургийн боловсруулалтад орж бүрэн дууссан бөгөөд BDRC вебсайтад байршаад байна. Цахим хэлбэрт орсон судрууд шинэ баринтаг донтортойгоор фондод буцаан байрлуулсан. Каталогт орсон номын тоог 3,3%-иар нэмэгдүүлсэн.

Эрдэм шинжилгээ онол практикийн хуралд: Илтгэл хэлэлцүүлсэн:

1. “Гэрэлт хөшөө хад чулуун дээр хадгалагдсан соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” Эрдэм шинжилгээ-онол практикийн хуралд 2 илтгэл
2. "Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого- Номыны сангийн шинэчлэл" хэлэлцүүлэгт 2 илтгэл
3. "Mongolian Library Update-2022" Номын санчдын 9-р зөвлөгөөнд 6 илтгэл

Бусад:

- Соёлын баримтат өв хэмээх ойлголтыг олон улс ба үндэсний акт баримтуудад хэрхэн туссаныг тодруулах нь

-“Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны түүх, шашин соёл” сэдэвт Эрдэм шинжилгээний хуралд:

- Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй Далай Чойнхор вангийн хошуунд холбогдох сурвалжуудын тухай

- “Жамбалдоржийн Сэржээ 70 насны ойд”- зориулсан эрдэм шинжилгээний хуралд: Сэржээгийн зохиосон Монголчуудын номын өв 1, 2-р дэвтэр ба номын сан судлалын тухай сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн.

- Үндэсний бичиг үсгийн баяр 2022 арга хэмжээ: Улирал сэтгүүл. 2022.-№2

Ном бичиж хэвлүүлж эмхэтгэсэн эмхэтгэлд оруулсан талаар:

- Монгол Улсад орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулж “Монгол Улсын Үндэсний номын сангийн тогтмол хэвлэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй Монгол сонины санамж өгөх номзүй” УБ., 2021 он хэвлүүлэв. /2022./
- “Гэрэлт хөшөө хад чулуун дээр хадгалагдсан соёлын баримтат өвийн өнөөгийн байдал” Эрдэм шинжилгээ-онол практикийн хурлын эмхэтгэл. - УБ., 2022. -150х

Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Их Дээд сургууль, Албан байгууллагууд, уншигч судлаачдын хүсэлтийг шийдвэрлэж, хамтран ажилласан талаар

- МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнтэй хамтран ажиллаж “Зарлигаар тогтоосон Манж нарын тайх тавиглах хууль бичиг” 6 дэвтэр манж барын номыг хуулбарлахад хамтарч ажиллаж Хэвлэгдэн гарсан бүтээлээс нэг бүр 30000 төгрөгийн үнэ бүхий 50 ширхэг номыг номын санд гэрээний дагуу авав. /2022. 11.01/
- ХААИС-ийн Мал аж ахуй биотехнологийн сургуулийн хүсэлтээр түүхт 80 жилийн ойн хүрээнд тус салбарын эрдэмтдийн бүтээл, хэрэгжүүлсэн төсөл

хөтөлбөрүүдийн үр дүнг эмхэтгэн “ Манай эрдэмтэд- Шинжлэх ухааны ололт” бүтээлийг туурвиж гаргах ажилд нь холбогдох бүтээлийн жагсаалтыг гаргаж хамтарч ажиллав. 2022.04.14

- Дэлхийн яруу найргийн өдөрт зориулан "МОНГОЛ ХӨГЖИМТ АМАН ЗОХИОЛ БА ГҮР ДУУ, ЯРУУ НАЙРАГ" сэдэвт үзэсгэлэн, Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Л.Эрдэнэчимэгтэй хамтарч зохиолч, уншигчдын уулзалтыг зохион байгуулж ажиллав. 2022.04.21
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах зорилготой “Үндэсний бичиг үсгийн баяр-2022”-ын хүрээнд “МОНГОЛЧУУДЫН ЭРТНИЙ БИЧИГ СУРВАЛЖ СУДАЛГАА” эрдэмтэн судлаачидтай хийх уулзалт, ярилцлагыг 2022 оны 05-р сарын 02-ны өдрийн 11.40 цагт Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимд зохион байгуулж эрдэмтэн судлаачидтай хамтарч ажиллав. Уулзалт, ярилцлагад МУСГЗ, сэтгүүлч, орчуулагч, судлаач Г.Аким, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Б.Сумъяабаатар, Судлаач, багш П.Батчулуун нар уригдан оролцов.2022.05.02
- “Монголын хөгжмийн түүхээс” номын холбогдол бүхий сэдэв материалыг шүүж жагсаалтыг гаргаж хамтарч ажиллав. 2022.05.03
- Фантастик продакшн ХХК-ийн 2022 оны 06 сарын 16 ны 1/48 албан тоот хүсэлтийн дагуу Захирал Ичинхорлоогийн зөвшөөрлөөр Нэг ангитай уран сайхны кино хийх ажилд нь Сан хөмрөг хадгаламжийн хэлтсийн “Өрнө дахины сан хөмрөгт 3 цагийн хугацаатай кино зураг авхуулж хамтарч ажиллав. 2022.06.27
- Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх байгууллагын хүсэлтээр “Би Эл Би Эс” ХХК –ийн “Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар шийдвэрийг хүчингүй болгуулах” тухай шаардлага бүхий нэхэмжлэлээр Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчид холбогдуулан захиргааны хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах ажилтай нь холбоотой “Үндэсний шуудан сонин” 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн сонинг үзэх, онуудыг шүүх жагсаалтыг гаргахад хамтарч ажиллав. Үндэсний шуудан сонины 2009- 2022 оны бүх дугаарыг шүүв. 2022.05.04
- Сургалт, судалгаа, пиар, мониторингийн стратеги академийн 2022.05.17 ны №22 албан тоот хүсэлтээр С.Гомбожавын намтар, үйл ажиллагааны мэдээлэл цуглуулах ажилд нь жагсаалтыг гаргаж өгч хамтарч ажиллав. 2022.05.24
- Соёлын өвийн Үндэсний төвийн 2022 оны 05 сарын 11- ний өдрийн №01/176 тоот албан бичгийн дагуу Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8 дахь заалтыг үндэслэн соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж буй Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор “Түүх, соёлын хосгүй үнэт” дурсгалт зүйлийн зэрэглэлд батлагдсан хөдлөх дурсгалт зүйлийн цаасан суурьтай баримтад нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж, бүртгэлийн бүрдүүлэлтийг хангаж ажиллахад нь Засгийн газрын тогтоолоор Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд батлагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тус бүрийн бүртгэлийн

бүрдлийг бүрэн хангаж, цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэхэд хамтарч ажиллав. 2022.05.24

- Дундговь аймгийн Говь-Угтаал сумын түүхт 100 жилийн ойтой холбогдуулан хэвлүүлэх номонд орох холбогдох материалын жагсаалтыг гаргаж хамтарч ажиллав. 2022.05.26
- СУИС-ийн Соёлын сургуулийн магистр Н. Пагмадуламын хүсэлтээр Үндэсний номын сангийн захирлын үүрэг болгосны дагуу дипломын ажилдаа хавсаргах өргөмжлөл бичгийн ар өвөр нүүрийн хуулбар авахад нь хамтарч ажиллав. 2022.06.03
- Үндэсний номын сангийн ажилтан Ч. Гансүх, Б. Отгонтуяа, Ү. Доржоо нарын хүсэлтээр Захирал Ичинхорлоогийн зөвшөөрсөний дагуу Гар бичмэл монгол судлалын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 8641/96 дансны дугаартай Перл Бахын "Эх" хэмээх зохиол Ц.Цэрэндоржийн орчуулгаар хадгалагдаж байгаа хуулбарыг цахимаар өгч хамтарч ажиллав. 2022.06.06
- Улаанбаатар хот дахь Дорнод аймгийн Баян-Уул сумын нутгийн зөвлөл ТББ-ийн 2022 оны 06 сарын 20- ны өдрийн албан тоот хүсэлтээр ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Ага суурินд буриад түмний "Алтаргана" их наадамд Ж. Цэвээний хүндэтгэлийн Эрдэм шинжилгээний хуралд бүтээлийн үзэсгэлэн гаргах ажилд нь холбогдол бүхий 51 ном бүтээлийн жагсаалтыг гаргаж, нүүрийн зургийг сканнердаж хамтарч ажиллав. Үүнд: /Монгол бичгээр дэх гар бичмэл барын судар- 28, Кирилл монгол хэвлэмэл ном- 21, Тогтмол хэвлэл-2/
- Зэвсэгт хүчний 284-р ангийн 2022 оны 07 сарын 18 өдрийн А/394 тоот албан хүсэлтээр Захирал Ичинхорлоогийн зөвшөөрлөөр Зэвсэгт хүчний Байр зүйн албаны 90, Зэвсэгт хүчний 284 дүгээр анги үүсэн байгуулагдсаны 40 жилийн ойн сурталчлах өдөрлөгийг 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулах ажилд нь зориулж холбогдол бүхий номын бүртгэл жагсаалтыг гаргаж хамтран ажиллав. 1. MS 3949 John. F. Baddeley. Russia, Mongolia, China, New York, Vol-1. 1911. 2. MS 3684 John. F. Baddeley. Russia, Mongolia, China, New York, Vol-1. 1911. 2022.08.08

• СУИС-ийн Радио, телевиз, медиа урлагийн сургуулийн 2022.09.30 ны №01/176 тоот албан хүсэлтийн дагуу магистрантурт суралцаж байгаа Э. Солонгийн Номын сан судлалаар "Гадаадаас монголд эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтдийн бүтээлийн товчоо, номзүйд хийсэн ажиглалт"судалгааны ажилд нь холбогдох шинжлэх ухааны 169 бүтээлийн жагсаалтыг гаргаж хамтарч ажиллав. 2022.10.12

• Орхон аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 11 сарын 18- ний 88 тоот албан хүсэлтийн дагуу Монгол улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Орхон аймгийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний нэгдүгээр хавсралтын 2.4 дэх заалтыг хэрэгжүүлэх үүднээс "Номын сангийн тухай хууль"-ийн 7.6 дугаар зүйлийг удирдлага болгон Орхон аймгийн Нийтийн номын сантай хамтарч ажиллав. /Ном хэвлэл Сэлбэн засах Сэргээх ажлын хүрээнд/ 2022.11.22-23

• Зураач чөлөөт уран бүтээлч, нийтлэлч, аялагч, монголын эртний түүхийг судлагч, Ойрадын Хутаг Бэхи ба Чингис хааны үр, Төрийн Их Цагаан Тугийн эзэн сахигч, Цагаан туг овгийн Түдэвийн Энхбаатарын хүсэлтээр "Чингис хаанаас дээд үеийн өвөг дээдсийн монгол хувцас" "Монголын хөгжмийн түүхээс" номуудаас ишлэл авсан, мөн тухайн сэдэвтэй ном сэтгүүлийн жагсаалтыг хийж өгч хамтарч ажиллав. 2022.05.24, 2022.11.15

• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын газрын хүсэлтээр Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдаж Улс даяар мөрдөж эхэлсэний болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 30 жилийн ой 2022 тохиохтой холбогдуулж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын эрх зүйн түүхэн уламжлалыг нэгтгэн харуулсан “Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийн түүхэн товчоон” сэдэвт баримтат кинонд Үндэсний номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй эртний түүхийн болон түүхэнд холбогдох эрх зүйн баримт бичиг, бичмэл ном судар, 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийг бүрэн эхээр нь нийтэлсэн “Үнэн” сонин, Үндсэн хуулиудын төслийн хэлэлцүүлэг, батлах явц, олон нийтэд сурталчлахтай холбоотой сонин хэвлэлийн нийтлэл, ном товхимолын жагсаалтыг гаргаж өгч зураг бичлэг хийлгэж хамтран ажиллав.

Нийгэмд номын сангийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, соёлын боловсролын арга хэмжээний хүрээнд номын сангийн салбарыг сурталчлах зорилгоор Соёлын яамтай хамтран МҮОНРТ-тэй хамтран “Ном хож” нэвтрүүлгийг санаачлан эхний дугаарыг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр бэлтгэн хүргэж, Орчин цагийн номын сан байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Г.Гүнжинлхам “Ном хож” нэвтрүүлэгт оролцож 2-р байр эзэлсэн. “Ном хож” нэвтрүүлгийн асуултуудыг 21 аймгийн номын сангуудаас видео хэлбэрээр авч, найруулагчидтай хамтран ажиллав.

Нийслэлийн Боловсролын газрын хүсэлтээр Нийслэлийн ЕБС-ийн номын санч нарын зөвлөлдөх багийг чадавхжуулах сургалтанд “ЕБС-ийн номын сангийн СОНА Олон улсад” хичээлийг ЕБС-ийн 13 номын санчдад танилцуулсан.

“Парламентын номын сангийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт Г.Гүнжинлхам ажиллан “Парламентын номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, стандартын хэрэгжилт болон хүний нөөцийн байдал”-д үнэлгээ хийж, тайланг бичиж хүлээлгэн өгсөн.

“Дархан-уул аймгийн музейн, төв номын сангийн үзэл баримтлал боловсруулах арга зүйн сургалт “-нд Г.Гүнжинлхам “Номын сангийн үзэл баримтлал боловсруулах арга зүй, олон улсын туршлага” сэдвээр илтгэл тавьсан.

- Соёлын яамны “Дотоод аудитын шалгалт”, НМХЕГ-ын шалгалтанд хэлтсийн хийж буй ажлыг танилцуулж, шаардлагатай мэдээллийг бэлтгэж өгсөн.
Түвдийн төслийн удирдлагуудтай хийсэн 2 удаагийн уулзалтанд оролцож “Цахимын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах” талаар санал солилцсон.
- МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Соёлын яам харьяа байгууллагуудтай хамтран Баянгол цэцэрлэгт хүрээлэнд мод тарих үйл ажиллагаа
Гадаад хамтын ажиллагааны хүрээнд: БНТУ, БНХАУ, АНУ, Унгар, Япон, Улс гэсэн 5 орны холбогдох байгууллага, номын сангийн төлөөлөлтэй хамтран ажиллан нийт 7 арга хэмжээг хэрэгжүүлсэн.
1. “Nippon Foundation” сан Японы ЗГ-тай хамтран хэрэгжүүлдэг “Read Japan” төсөлд шалгаран 17 нэрийн номыг авсан.
2. Унгарын нэрт яруу найрагч Пэтөфи Шандорын дурсгалын самбарыг байрлуулан, Унгарын Үндэсний Номын сан, ШУА, Петофи уран зохиолын музейтэй хамтын ажиллагааны хүрээнд харилцан ойлголцолын санамж бичгийн төслийг боловсруулсан ба 100 боть ном хандиаар хүлээн авсан.
3.Оросын ҮНС-аас зохион байгуулсан “Номын сангийн үйл хэрэг Гурван тивд олон улсын онлайн хуралд илтгэл тавьж оролцсон.
4. Хятадын ҮНС, Катарын ҮНС-тай хамтран зохион байгуулсан “Best Practices and Challenges in sharing Digital Content” сэдэвт Торгоны Зам ОУ-н номын сангуудын холбооны 4-р чуулганд онлайнаар оролцсон.
6. Тайланд улсын Бангкок хотноо болсон IFLA-н Номхон далай, Зүүн өмнөд Азийн бүс нутгийн номын санчдын сургалт семинарт оролцсон.
7. Аргентины утга, уран зохиолыг ОУ-н тавцанд танин мэдүүлж, гадаад хэлнээ орчуулж хэвлэн нийтлэх ажлыг дэмжих "SUR Programa"-ийн танилцуулгыг Соёлын яаманд бэлтгэн өгсөн.

Ном солилцоо: Гадаад орны харилцаат номын санд солилцоогоор илгээсэн 21 нэрийн 164 ширхэг 3,648,300 төгрөгийн ном илгээж, хүлээн авсан гадаад ном, хэвлэл нь 327 нэрийн 334 ширхэг 7,427,500 төгрөгийн ном, 22 нэрийн 77 ширхэг 255,750 төгрөгийн сэтгүүл байна.

Төвөд номыг дижиталчлах төслийн хүрээнд: Төвөд номыг дижиталчлах төсөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.Төслийн үйл ажиллагааг зохицуулагч Б. Сайнбилэг хариуцаж, бүхэлд нь хянах, каталог болон цахим датаг архивлан хадгалах, аюулгүй байдлыг хангах, захиралд үйл ажиллагаагаа танилцуулах, америк мэргэжилтнүүдтэй холбогдож заавар зөвлөгөөг авах уламжлах хэрэгжүүлэх болон төслийн үйл ажиллагаагаа тайлагнадаг.



Азийн Өвийн Сан (Asian Legacy Library) буюу ACIP (Asian Classics Input Project) -ийн Америк удирдлага болох Жон Брэди, Эмма Льюс нар Монголд ирж 2018 онд байгуулсан гэрээг дахин хэлэлцсэн мөн АНУ-ын ЭСЯ, Монголын бусад байгууллагуудтай танилцаж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. 2018 оны "Харилцан Ойлголцлын санамж бичиг"-ийг "Хамтын ажиллагааны гэрээ" болгож агуулгыг боловсруулахад оролцсон. Хамтын ажиллагааны гэрээний эцсийн найруулга хийгдсэн бөгөөд Соёлын яамны албаны хүмүүсээр хянагдаж байгаа. Хараахан эцсийн шийдвэр гараагүй.
Каталогт 33781 гарчиг ном оруулж, 1340 багц судрын 433788 хуудас цахим хэлбэрт, 1960 багц судрын зургийн боловсруулалтад орж бүрэн дууссан бөгөөд BDRC вебсайтад байршаад байна. Цахим хэлбэрт орсон судрууд шинэ баринтаг

донтортойгоор фондод буцаан байрлуулсан. Каталогт орсон номын тоог 3,3%-иар нэмэгдүүлсэн.

Бусад, нэмэлт ажлуудаас:



ТЭРБУМ МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН НЭГДЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-д Үндэсний номын сангийн хамт олон нэгдэж, нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын талбайд 120 ширхэг хайлаас мод тарилаа.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТОДРУУЛГА

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

<u>1. Тайлагнагч байгууллага</u>

Энэхүү санхүүгийн тайлангаар Монгол улсын Үндэсний номын сангийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Санхүүгийн тайлагналын хугацаа нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2022 оны 11 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон.

<u>2. Толилуулгын суурь</u>

Санхүүгийн тайланг Улсын секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д “үндэслэн” эсвэл “түүний мэдэгдэхүйц шаардлагуудтай нийцэж байгаа” эсвэл “нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудтай нийцсэн” гэж тодорхойлж болно. Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг хэрэглэсэн болно.

Соёлын сайдын 2022.01.11-ны өдрийн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын барим бичгийг батлах тухай" А/02 тоот тушаал, Үндэсний номын сангийн 2021 оны 12 дугаар сарын А/41 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус мөрдөж ажилласан.

<u>3. Төсвийн үйл явц</u>

УНСББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх талаар хариуцлага хүлээсэн этгээд батлагдсан төсөв хэтрээгүй талаарх мэдэгдэл гаргадаг бөгөөд 2022 онд Үндэсний номын сан нь батлагдсан төсвийг хэтрүүлээгүй болно.

Тайлант хугацаанд Үндэсний номын сан Төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулан байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг

боловсруулан хэрэгжүүлсэн ба түүнд тусгагдсан 6 зорилт 20 арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр ханган хэрэгжүүлсэн.

Үр дүнгийн гэрээний дагуу 2022 оны 11 дүгээр сарын байдлаар Соёл урлаг хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээний санхүүжилт болох 1,677,956.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 3 арга хэмжээний нийт 1,510,208.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч төсвийн гүйцэтгэл 90 хувьтай гарсан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг "Төсвийн тухай" хуулийн 54.5 заалтад заасан бүрэлдэхүүнээр бэлтгэсэн тул төсвийн талаарх мэдээллийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хэсгээс тодруулж үзнэ үү.

4. Нягтлан бодох бүртгэлийн зарчим

4.1. Орлого хүлээн зөвшөөрөлт

2022 оны 11-р сарын 30-ний өдрөөр санхүүгийн үр дүнгийн тайланд 2,054,660.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэснийг дараах байдлаар тодруулж байна.

- Ерөнхий менежерийн гэрээний дагуу 2022 онд улсын төсвөөс урсгал санхүүжилтэд 1,677,956.4 мянган төгрөгийг хүлээн авч санхүүжилтийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- Байгууллагын үйл ажиллагаанаас 39,753.4 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- Нэмэлт төсвийн харилцах дансаар АСИП төслийн санхүүжилт 225,727.7 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 64,400.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор 46,823.0 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

4.2. Зардал хүлээн зөвшөөрөлт

2021 онд үйл ажиллагааны үр дүнгийн тайланд нийтдээ 2,822,177.1 мянган төгрөгийн зардлыг аккруэль сууриар хүлээн зөвшөөрч бүртгэсэн ба зардлын дэлгэрэнгүйг Хүснэгт 1-ээс харна уу.

Хүснэгт 1.

ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
I. ОРЛОГЫН ДҮН	1,679,111,629.00
Төсвөөс урсгал санхүүжилт	1,677,956,400.00
Даатгалын төлбөр	1,045,229.00
Нэр данс зөрүү	110,000.00
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,510,208,841.29
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,510,208,841.29
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,509,908,841.29
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,227,775,077.20
Үндсэн цалин	856,399,842.80

Нэмэгдэл	153,258,008.40
Унаа хоолны хөнгөлөлт	191,636,364.00
Урамшуулал	26,480,862.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	142,176,293.00
Тэтгэврийн даатгал	97,865,903.61
Тэтгэмжийн даатгал	11,513,626.99
ҮОМШӨвчний даатгал	9,093,301.79
Ажилгүйдлийн даатгал	2,154,859.89
Эрүүл мэндийн даатгал	21,548,600.72
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	50,815,648.97
Гэрэл, цахилгаан	25,560,649.03
Түлш, халаалт	17,616,511.94
Цэвэр, бохир ус	7,638,488.00
Хангамж бараа материалын зардал	64,491,176.12
Бичиг хэрэг	7,302,250.00
Тээвэр шатахуун	1,168,500.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,884,117.12
Ном, хэвлэл	32,716,020.00
Хог хаягдал зайлуулах, хортон шимэгчдийн устгал, ариутгал	2,246,250.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,174,039.00
Номативт зардал	528,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	528,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	732,500.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	732,500.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,482,735.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,759,671.00
Тээврийн хэрэгслийн татвар	171,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,335,464.00
Газрын төлбөр	1,860,000.00
Улсын мэдээллийн маягт хэв, бэлтгэх	4,356,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,907,411.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00
Бусад урсгал шилжүүлэг	300,000.00
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшуулал	300,000.00
Мөнгөн хөрөнгийн 2022-01-01 оны 11-р сарын 30-ний үлдэгдэл	168,902,787.71

5.Шилэн данс

Монгол улсын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж 2022 оны 11 сарын байдлаар шилэн дансны цахим хуудсанд 23 нэр төрлийн мэдээллийг 155 талбарт оруулсан.

Соёлын яамны Дотоод аудит-хяналт шинжилгээ үнэлгээний газраас улирал тутам хийсэн Дотоод аудитын дүнгээр тус байгууллагийн Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 98.2 хувьтай “Хангалттай” гэж дүгнэсэн.

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 08. Улаанбаатар хот

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөө, Нийслэлийг хөгжүүлэх 2022 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд тус номын снгаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2.6.2.1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн соёлын ордны номын сангийн фондын баяжилтыг жил бүр хийнэ.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар номын баяжилтын тендерийн ажил гүйцэтгэх гэрээг “Монсудар паблишн” ХХК-тай байгуулан захиалсан 1624 ширхэг 48,351,681 төгрөгийн номуудыг хүлээж авлаа. Үүнээс 374 ширхэг 8,759,596 төгрөгийн номыг нийслэлийн алслагдсан Багахангай, Багануур, Налайх дүүргийн соёлын ордны номын сангуудад хүлээлгэж өгсөн.

2.6.3.1. “Хотын соёл” цуврал контент бий болгож цахим аян хэрэгжүүлнэ.

“Хотын соёл” цуврал контентын хүрээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа хараааны бэрхшээлтэй иргэдэд соёлтой хандах чиглэлээр 2, “Хотын соёл - хотын гудамж, талбайн нэршил” сэдвээр 5, жендерийн тэгш байдал, эх оронч үзэл сэдвээр 2, нийтийн тээврээр соёлтой үйлчлүүлье сэдвээр 1, хоггүй цэвэрхэн хотын төлөө хамтдаа цувралаар 2, Хотын соёл нэршлээр цуврал 2, Номыг хэрхэн соёлтой унших вэ сэдвээр 1 нийт 15 удаагийн богино хэмжээний видео контент хийж уншигч олонд хүргэсэн байна.

Хотын соёл:. "Нийтийн тээврээр соёлтой үйлчлүүлье" Иргэдийн

4.1.1.3. Тоон гарын үсгийг нийслэлийн нутгын захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулна.

Тус номын сан нь 2022 оноос эхлэн албан бичгийн хэрэглээндээ тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлж нийслэлийн бүх байгууллагуудтай тоон гарын үсгээр баталгаажилт хийгдсэн албан бичгээр харилцаж эхэлсэн. Тайлант хугацаанд 110 гаруй албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн байна.

4.1.2.2. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

Тус номын сангийн төв хаалган дээр Монгол улсад хэрэгжиж буй MNS 5682:2006 стандартын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, ариун цэврийн өрөө, авто зогсоолын тэмдэглэгээ зэргийг тус тус хийсэн. Мөн Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 30 нэрийн цахим ном бүтээсэн. Тайлангийн хугацаанд "Технологийн төв"-ийн YOUTUBE суваг, Facebook групп дээр дүрс бичлэг, зурагтай 95 мэдээлэл оруулсан байна.

4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах хууль болон холбогдох бусад журмын дагуу төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган, 2021 оны жилийн эцсийн тайлан, Аудитын дүгнэлт, сар бүрийн ажил гүйлгээ зэргийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан.

4.2.2.1 Төрийн албан хаагчийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, авлига, хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог бууруулна.

Тус номын сангаас төрийн албан хаагчийг авлигын гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 110 дугаар бүхий номын тавиурыг байршуулан авлигын гэмт хэрэгтэй холбоотой мэдээ мэдээлэл бүхий номоор тогтмол баяжуулалт хийн ажиллаж байна.

4.2.3.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион явуулсан дараах сургалтуудад номын сангийн холбогдох албан хаагчдыг цаг тухай бүрт нь хамруулсан. Үүнд:

1. Авлигын эсрэг зөвлөгөөнд НБТҮТ-ийн эрхлэгч З.Төгсжаргал, ОНҮТ-ийн эрхлэгч О.Долгорсүрэн, ЧД дэх салбар номын сангийн эрхлэгч Н.Одхүү
2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтад Архив бичиг хэргийн ажилтан Б.Бадмаарагчаа
3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн талаарх сургалтад Программист О.Цог
4. Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь сургалтад Хүний нөөц, хуулийн зөвлөх М.Отгонбаяр
5. Нийслэлийн богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нь сэдэвт сургалтад Тооцооны нябо Н.Шинэгэрэл
6. Жендер ба хүний эрх сэдэвт сургалтад Захиргаа удирдлагын албаны дарга Ж.Золбоо
7. ННЗБ-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын сургалтад НБТҮТ-ийн эрхлэгч З.Төгсжаргал, ОНҮТ-ийн эрхлэгч О.Долгорсүрэн, ЧД дэх салбар номын сангийн эрхлэгч Н.Одхүү
8. Нийслэлийн нутгын захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн сан ublegal.ulaanbaatar.mn цахим хуудасны шинэчлэл хийгдэх сургалтад Хүний нөөц, хуулийн зөвлөх М.Отгонбаяр
9. Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, эдийн засаг сэдэвт сургалтад Ном ажиллагч М.Мөнхзаяа нар хамрагдсан байна.

Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг

Жил бүр нийт үндэсний бичиг үсгийн баярыг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ жил үндэсний бичиг үсгийн баярыг “Үндэсний бичиг үсэг- Монгол соёлын үнэт өв” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд тус номын сангаас дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

Үндэсний бичиг үсэг- Монгол соёлын үнэт өв

Эл баярын хүрээнд Батын Бадам зохиолчын зохиол бүтээлээс цувралаар “Хайрыг яаж зурах вэ?”, “Ялгаагүй ээ”, “Бэлэн амт хулгана”-ыг кириллээс монгол бичигт хөрвүүлэн танилцуулсан. Мөн “Монгол бичгийн үүсэл” видео бичлэгийг бэлтгэн байгууллагын фэйсбүүк пэйжид цахим хэлбэрээр байршуулсан.

Уулзалт, ярилцлага

Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Батын Лхагвасүрэнтэй “ Зохиолч-Уншигчдын” уулзалт ярилцлагыг зохион байгуулж, энэ үйл ажиллагаанд 45-р сургуулийн 7б, 7г ангийн 47 сурагчид, сургуулийн номын санч Халиунаа, монгол хэл-уран зохиолын багш нар оролцсон**.**

Бүтээлийн үзэсгэлэн

“Үндэсний бичиг үсгийн баяр 2022" хүрээнд Дүрслэх урлагийн академийн оюутан А.Намуунбайгаль "Миний дотор" уран бичлэгийн 40 бүтээлтэй үзэсгэлэнгээ тус номын санд 14 хоногийн хугацаанд дэлгэж, үндэсний бичиг соёлоо сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд хамтран ажилласан. Мөн Нийслэлийн

60-р сургуулийн сурагчдын 58 бүтээлээр “Уран бичлэгийн гайхамшиг” үзэсгэлэнг гаргасан байна.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

“Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв” сэдвийн хүрээнд “Монгол бичиг бидний бахархал, Монголчуудын бичиг үсгийн түүх” зэрэг монгол бичгийн гайхамшгийг харуулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн 4 удаа, 24 нэрийн 80 ширхэг номоор гаргасан.

Уралдаан, тэмцээн

Эх хэлээрээ сайхан бичье” сэдвийн хүрээнд уралдаан зарлаж, тус уралдаанд оролцсон хүүхдүүдийн бүтээлээр үзэсгэлэн гаргалаа.

Ярьдаг номын сангаас бичиг үсгийн баярт зориулан “Алтан хонх” уралдааныг амжилтай зохион байгууллаа. Уралдаанд 4-10-р ангийн 52 сурагч оролцож, дараах хүүхдүүд шалгарлаа. Үүнд:

- 1-р байрыг 7 а ангийн сурагч н.Батцоож,
- 2-р байрыг 8 б ангийн сурагч н.Содхүү
- 3-р байрыг 10 а ангийн сурагч н.Тэмүүжин нар тус тус байр эзэлсэн байна.

2.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг

Жил бүр уламжлал болон зохион байгууллагддаг номын баяр арга хэмжээ Улсын их хурлын дарга Г. Занданшатарын ивээл дор “ Илүү их уншъя” уриан дор зохион байгуулагдаж манай номын сангаас дараах ажлуудыг зохион явуулсан. Үүнд:

Номын баярын хүрээнд “Номын сантай автобус” зөөврийн уншлага үйлчилгээг Чингэлтэй дүүргийн 14, 17-р хороо, Хан-Уул дүүргийн 14-р хороо Өлзийт хороолол, Баянзүрх дүүргийн 27, 28-р хороо болон Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Төв талбай зэрэг газруудад зохион байгуулж номын сангийн үйлчилгээг хүүхдүүдэд хүргэж ажилласан.

Мөн номын баяр арга хэмжээний хүрээнд Төв талбай дээр болсон “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” арга хэмжээнд номын сангийн уншлага үйлчилгээг танилцуулж мэдээлэл хүргэхээс гадна Америкийн соёл мэдээллийн төвийн номын сангийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулсан.

Номын баярыг угтаж “Номын сангийн хайлтын систем буюу электрон каталог”-ыг хэрхэн зөв ашиглах вэ мэдээлэл зөвлөгөөг 16 дугаар сургуулийн н.Эрдэнэсүрэн багштай $7^{б}$ ангийн 27 сурагчдад, уншигчдад өгч ажилласан.

“Номын баяр- Таны дэргэд” өдөрлөгийг Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан дээр зохион явуулж уншигчдад карт нээх болон номын хайлт хийх, номын сангийн талаарх танилцуулга мэдээлэл зэргийг өгч ажилласан.

Мөн номын баяр арга хэмжээний үеэр БЗД-ий 21-р сургуулийн 5г ангийн сурагч Д. Баясгалан, БГД-ийн 56-р сургуулийн 7а ангийн сурагч Э.Уянга, СБД-ийн 11-р сургуулийн 11б ангийн сурагч Н.Цэрэнханд, ХУД-ийн 18-р сургуулийн 6а ангийн сурагч Б.Мишээл, СБД-ийн 31-р сургуулийн 10а ангийн сурагч М.Номиндарь, 45-р сургуулийн 4б ангийн сурагч С.Энххишиг нар “Тэргүүний уншигч- Д.Нацагдорж тэмдэг”-ээр, БГД-ийн 18-р хороонд оршин суугч Ц.Нямжанцангийн гэр бүл “Тэргүүний уншигч-гэр бүл”-ээр тус тус шалгарч шагнагдсан. Мөн Улсын их хурлын дарга Г. Занданшатарын нэрэмжит тэргүүний уншигч шагналаар Ахмад настан Ю.Мөнх-Амгалан шагнууллаа.

Ярьдаг номын сангаас номын баярын өдөрт зориулж "Номын далайд хамтдаа аялъя" уулзалт ярилцлагыг 2 удаа зохион явуулсан. Үүнд:

- МЗЭ-ийн шагналт, МУСГЗ зохиолч Базаржавын Нацагдорж
- МУИС-ийн НУС-ийн улс төр судлаачийн 2-р дамжааны оюутан Сайханцэцэг

Хараааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Ярьдаг номын сангаас "Илүү их уншъя" уриан дор зохион байгуулагдсан хавар, намрын "Үндэсний бичиг соёл,

номын өдрүүд -2022" 2 удаагийн арга хэмжээнд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль болон цахим номын сангийн үзэсгэлэн, туслагч технологийн үзэсгэлэнг танилцуулан оролцон ажилласан.

"Илүү их уншъя" уриан дор зохион байгуулагдсан "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд -2022" арга хэмжээг угтан зохиолч-уншигчийн уулзалтыг Хүүхдийн зохиолч, монголын зохиолчдын эвлэлийн мэргэжилтэн П.Наранбаатарыг урин “Бид эх орны ирээдүй” сэдвээр ярилцлаа. Уг уулзалтанд Ерөнхий Боловсролын 31-р сургуулийн Соёлмаа багштай 2д ангийн хамт олон оролцлоо.

2.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 158 дугаар зарлиг

Тус зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Ногоон хот – Иргэний оролцоо” хаврын мод тарих аяны хүрээнд батлагдсан хуваарийн дагуу байгууллага хамт олноороо Хан Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Айдсын аманд 60 ширхэг модны суулгац тарьж, усалгаа арчилгаа хийсэн.

2.4. Монгол улсын засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоол

Тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөхөд албан хаагчдын бэлтгэх үүднээс номын сангийн 36 албан хаагчийг хамруулсан Монгол бичгийн сургалтын хэл иргэншлийн сургуультай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 20-оос нэг сарын хугацаанд зохион явуулж бүх албан хаагчдад анхан шатны мэдлэг олгож сертификат гардуулсан.

2.5. Монгол улсын засгийн газрын 2022 оны “журам шинэчлэн батлах тухай” 1 дүгээр тогтоол

Коронавируст халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс халдварын эрсдэлийн шар түвшинд шилжих хүртэл тус номын сангийн үүний орох хэсэгт халуун хэмжигчтэй ариутгагч хаалгыг байрлуулж халдвар хамгааллыг сахих үүднээс уншигчдын гадуур хувцсыг тусгай зориулалтын 50х80

см хэмжээтэй даавуун уут оёж савлан мананцар үүсгэгчээр ариутгаж өлгүүрт өлгөж байсан. Мөн Байгууллагадаа нано кварцын гэрэлтэй, автомат мананцар үүсгэгч ариутгалын 10ш буу авч ариутгал халдваргүйжүүлэлт болон цэвэрлэгээг тогтмол хийж уншлага үйлчилгээнд гарсан ном товхимлыг ном ариутгагч шүүгээнд хийж ариутган дахин уншлагад гаргаж байсан.

2.6. Монгол улсын засгийн газрын 2021 оны “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол

Тус тогтоолын хүрээнд Номын сангийн 2022 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж төсөвт зардлыг хэмнэхэд чиглүүлж Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр настны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, Шаардлагагүй албан конторын тавилга болон бусад тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, Номын сангийн хэмжээнд сургалт семинар, хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаан, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд хэмнэлт гаргах, удирдлагын болон ажиллагсдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр ашигтай нь уялдуулан нарийн тооцож, ур чадвар, урамшуулалт цалинг хязгаараас хэтрүүлэхгүйгээр хавтгайруулан олгохгүй байх зэрэг арга хэмжээг авч ажиллахыг тасаг салбарын эрхлэгч, хүний нөөцийн мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч нарт үүрэг болгож ажилласан.

2.7. Монгол улсын засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 201 дүгээр тогтоол

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1448 жиргээ илгээгдэж, 465 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 47628, үүнээс гадна АСМТ 42848 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг өдөр бүр тогтмол түгээн ажиллаж байна.

2.8. Монгол улсын ерөнхий сайдын 2022 оны 06 албан даалгавар

“Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн явц, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох хэсгийг судлаж төлөвлөгөөнд тусгах талаар тасаг салбарын эрхлэгч болон албан хаагчдад таниулах, сурталчлах ажлыг байгууллагынхаа дотоод сүлжээгээр болон дотоод ажлын өдрөөр сургалтын цаг дээр танилцуулсан.

2.9. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамж

Тус захирамжийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах үүрэг бүхий “Шуурхай штаб”-ыг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч, биелэлтийг 7 хоног бүр танилцуулж ажиллахыг үүрэг болгосон. Тус ажлын хүрээнд манай

номын сан Баянзүрх дүүргийн 17 дугаар хороотой хамтран ажиллах хуваарийн дагуу шахмал түлшийг зохистой хэрэглэх талаар 500 ширхэг танилцуулга боршурыг хэвлэж хүргүүлсэн.

2.10. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай" А/480 дугаар захирамж

"Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг Д.Сүхбаатарын төв талбайд "Энх-тунх, Мөнх-тунх" уриан дор Нийслэлийн харъяа байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллалаа. Дээрх арга хэмжээнд номын сангийн үндсэн үйл ажиллагааг танилцуулахаас гадна номын сангийн хүүхдийн хөтөлбөрүүдийг сурталчилан танилцуулсан.

2.11. Нийслэлийн Засаг даргын 2015 оны "Автомашингүй өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай" А/472 тоот захирамж

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэс, Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан хэлтэсээс "АВТОМАШИНГҮЙ ӨДӨР-2022" нийтийг хамарсан урлаг, спортын олон талт арга хэмжээг 10 дахь жилдээ зохион байгуулсан. Тус өдөрлөгт манай номын сангаас хөтөлбөрийн дагуу зарим арга хэмжээг хариуцан ажилласан. Мөн номын сангийн хэмжээнд дараах ажлуудыг зохион явууллаа. Үүнд:

Төв болон салбар номын сангийн хүүхдийн уншлагын танхимын номын санчид "МИНИЙ МЭДЭХ ҮЛГЭР" сэдэвт танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг 10-15 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 33-р дунд

сургуулийн 9-р ангийн сурагч М.Нарансолонго 1-р байр, 48-р сургуулийн 11б ангийн сурагч У.Эгшиглэн 2-р байр, 48-р сургуулийн 11б ангийн сурагч М.Заяажаргал 3-р байрыг тус тус эзэлсэн.

Мөн хараны бэрхшээлтэй иргэдэд зориулсан ярьдаг номын сангаас "АВТОМАШИНГҮЙ ӨДӨР-2022" үйл ажиллагааны хүрээнд “Номын сандаа яаж хүрэх вэ” сэдэвт явган аяллыг Хараны бэрхшээлтэй 116-р сургуулийн ахлах ангийн сурагчид болон идэвхтэй уншигчдын дунд зохион байгууллаа. Энэ аялалын хүрээнд “Төв номын сан, Мөнгөн завьяа, Энх тайван найрамдлын ордон, Ард кино театр” зэрэг автобусны буудлаас яаж Улаанбаатар хотын нийтийн төв номын сан хүрэх, эргээд дээрх буудлууддаа яаж хүрэх зам маршрутыг танилцуулсан.

2.12. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/1049 дүгээр захирамж

Тус захирамжийн хүрээнд тайлант хугацаанд албан хаагчдаас ирсэн 18 өргөдөл, иргэнээс ирсэн нэг гомдлыг байгууллагын дотоод удирдлагын UB ERP нэгдсэн цахим системд бүртгэн хуулийн дагуу шийдвэрлэн 100 хувь барагдуулж ажилласан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 3 удаа гаргаж Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан.

2.13. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай”А/578 дугаар захирамж

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу биеийн давхцахгүй өгөгдөл гарын хурууны хээг устгах үйл ажиллагааг зохион байгуулж, төв болон салбар номын сангууд дээр цуглуулсан болон хадгалсан байсан мэдээллийг устгасан. Мөн тухайн ажлыг зохион байгуулсан тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.

2.14. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” А/789 дүгээр захирамж

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тус номын сангийн албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, нийслэлийн өмчид бүртгэлтэй суудлын автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлж өгөгдсөн хуваарийн дагуу хүлээлгэн өгсөн.

2.15. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “төлөвлөгөө батлах тухай” А/147 дугаар захирамж

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган

ажиллаж эхний хагас жилийн тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн бол жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна.

2.16. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдэл цалин шинэчлэн тогтоох тухай” Б/96 дугаар захирамж

Тус захирамжийн 2 дугаар хавсралт буюу Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга нарын үндсэн цалинг шинэчлэн тогтоосныг Нийслэлийн Засаг даргын тамгын газраас манай номын санд албан бичгээр ирүүлсэн. Үүний үндсэн дээр номын сангийн захирлын цалингийн шатлалын баталсан хавсралтын дагуу шинэчлэн хэрэгжилтийг ханган ажилласан.

2.17. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Ашиглагдаж байгаа бүх комьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжинд байнга хяналт тавьж ажиллаж байна.

2.18. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт

http://koha.pl.ub.gov.mn -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2021 оны 12 дугаар сарын 25-аас 2022 оны 06 дугаар сарын 10-нийг хүртэлх хугацаанд 67323 хэрэглэгч зочилж /visits/, 211093 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 87,1% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 12,9% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд Koha программ номын сангийн программын туршилтаар koha version: 21.05.04.000, 21.11.13.000 суулган нэмэлт өөрчлөлтүүд,шинэ дизайн оруулах кохагийн шинэ хувилбарыг суулган туршилт хийж байна. Төв болон салбар номын сангуудын номын санч нарын ном каталогжуулсан статистик мэдээг гаргаж өгсөн. RFID болон уламжлалт аргаар хослуулан Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн Нийтийн уншлагын танхим, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн Нийтийн уншлагын танхим, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангийн Нийтийн уншлагын танхим, Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангийн Хүүхдийн уншлагын танхимыг тоолсон.

<u>Интернэт сүлжээ</u>

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон.

Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 27.58 Mbps, дунджаар 38.78 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 56.01 Mbps, дунджаар 319.61 Kbps хүрсэн байна.



Утасгүй Интернэтийн сүлжээ

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 1.79 Mbps, дунджаар 5.37 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 50.80 Mbps, дунджаар 9.27 Mbps хүрсэн байна.



Тайлангийн хугацаанд суурин интернэтийг 11325 хэрэглэгч, утасгүй интернэтийг 8516 хэрэглэгч ашиглаж, нийт 19841 хэрэглэгчид интернэтийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Төв болон салбар номын сангуудын интернэт үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна.

Вэб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб http://www.pl.ub.gov.mn -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажилласан. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-аас 2022 оны 06 дугаар сарын 10-ний хүртэлх хугацаанд тайлан гаргахад 52307 хэрэглэгч зочилж /visits/, 346729 хуудасны мэдээллийг үзсэн байна. Нийт сайтийн хэрэглэгчдийн 76.7% нь шинээр орж, 23.3% нь хуучин хэрэглэгчид хэрэглэгчид зочилсон байна.

СТАТИСТИК

346729

Visit Today : 56
Visit Yesterday : 165
This Month : 757
This Year : 52307
Total Visit : 346729
Who's Online : 9

Тайлангийн хугацаанд сайтад зочилсон хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

Country	Users	% Users
1. Mongolia	62,571	92.69%
2. United States	936	1.39%
3. China	661	0.98%
4. South Korea	474	0.70%
5. Russia	448	0.66%
6. Japan	433	0.64%
7. Netherlands	260	0.39%
8. (not set)	205	0.30%
9. Germany	155	0.23%
10. Sweden	141	0.21%

Вэб хуудас шинэчлэх ажлын хүрээнд

Байгууллагын вэб сайтад шилэн данс, аудит дүгнэлт, санхүүгийн тайлан, төсөв, өргөдөл гэсэн дэд цэсүүд нэмэн мэдээ, мэдээлэл оруулж тогтворжуулан ажиллаж байна. Мөн вэб сайтад 48 мэдээ, мэдээлэл, нээлттэй ажлын байрны зар оруулсан байна.

2.19. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 18, шинээр болон эгүүлэн томилогдсон 16, шилжин ажилласан 12 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

2.20. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 183 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 180 бичиг ирсэн байна. 177 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хааж, 6 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 113 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 111, систем ашиглагдаггүй 2 байгууллагаруу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн зөрчилтэй 7 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 22 удаа танилцуулж ажилласан.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Уншлага үйлчилгээ

Номын сангийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт
1	Шинэ уншигч	15,800	17,405

2	Ирэгсэд	102,500	69,401
3	Ном олголт	260,500	141,184

Тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 2

Он		2021			2022		
№	Төлөв-лөгөө	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**
1	19,300	15,800	6527	41,3%	15,800	17,405	110%
2	119,700	102,500	21,352	20,8%	102,500	69,401	67,7%
3	299,250	260,500	43,112	16,5%	260,500	141,184	54,2%

Тайлбар

1. Тайлангийн хугацаанд Ковид-19 цар тахлын дэгдэлт нэмэгдэж улбар шар түвшинд шилжсэнтэй холбоотойгоор Нийслэлийн онцгой комиссын шийдвэрээр манай номын сан 2022.04.19-нийг хүртэл танхимын дүүргэлтийг 50%-иас ихгүй байлгасан.

2. Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд зарим албан хаагчид ажлаас чөлөөлөгдөх, шилжин ажиллах, жирэмсэний амралт авах зэрэгтэй холбогдуулан 6 удаагийн тооллого хийгдсэн.

3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тус номын сан гэрээр ном олгохдоо уншигч үйлчлүүлэгчдийн иргэний үнэмлэхийг авч үлдэн ном олгодог байсан. Ингэснээр иргэдээс гомдол ирсэн учир гэрээр ном олгохыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу 51 удаа 2523 ширхэг номоор Зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд:

- Бакула Ринбүүчи Бэтүб Данжай Чойнхорлин хийдэд 1 удаагийн 14 ширхэг номоор
- Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхтэй 1 удаа 30 номоор
- Багануур дүүргийн соёлын ордны номын сантай 1 удаагийн 21 ширхэг номоор
- ХУД-ийн 9-р хорооны “Аяут” өрхийн эрүүл мэндийн байгуулагатай 1 удаа 20 ширхэг боть номоор
- ХУД-ийн ЕБ-ын 114-р сургуулийн Д. Энхцэцэг багштай $9^{б}$ ангийн нийт 27 сурагч болон тус сургуулийн 22 албан хаагчдад уншигчийн карт шинээр нээж, 33 ширхэг боть номоор
- ХУД-ийн ЕБ-ын 60 дугаар сургуулийн номын сантай хамтран 243 хүүхэд, болон багш албан хаагчдад уншигчийн карт шинээр нээж, 57 ширхэг боть номоор
- Олон Улсын Улаанбаатар Их Сургуультай хамтран Уран зохиолын 12 ширхэг ном , Хүний хөгжлийн 7 ширхэг ном , Анагаах ухааны сувилахуйн 12 ширхэг ном , Солонгос хэлний 10 ширхэг нийт 41 ширхэг номоор 2 удаа

- Нийтийн уншлагын А танхимтай 3 нэрийн 39 ширхэг номоор
- Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн ХУТанхимтай 12 номоор
- Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль 1 удаа 20 ширхэг номоор
- Шинэ анагаах дээд сургуультай хамтарч 1 удаа, 15 ширхэг боть номоор
- Нийтийн уншлагын А танхим, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн хүүхдийн уншлагын танхимуудтай 8 нэрийн 59 ширхэг номоор
- Өргөө амаржих газрын номын сантай 16ш номоор
- Төв талбай дээр ном солилцоог явуулж 12ш номоор Хилийн цэргийн 0151-р ангийн номын санч Б. Сугармаатай 22 ш номоор
- Улаанбаатар хотын музейтэй зөөврийн номын сангийн үйлчилгээг 10 ширхэг номоор тус тус үзүүллээ.

3.4. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2022 оны жилийн байдлаар 38 нэрийн 228 ширхэг 6,071,000 төгрөгийн номыг худалдаагаар, 4 нэрийн 65 ширхэг брайль ном, 2616 нэрийн 3663 ширхэг 37,657,500 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 48 нэрийн 422 ширхэг 8,022,880 төгрөгийн номыг тендерээр тус тус бүрдүүлэн авч, нийт 773 нэрийн 2448 ш хэвлэмэл номонд техник ажиллагаа хийж, 773 нэрийн 2445ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2423ш RFID-ийн баркодон tag-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна. Дээрх бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүлсэн.

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, 2022 онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 16 нэр төрлийн 4,537,400 төгрөгийн тогтмол хэвлэл захиалсан байна.

Урагдаж гэмтсэн нийт 569ш ном хэвлэлийг сэлбэн зассан байна.

Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 389 нэгж, байгууллагын албан баримтуудыг 25 нэгж болгон тус тус хавтасласан байна.

3.5. Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааг амаар, цахимаар, утсаар, е mail-ээр нийт 4081 удаа лавлагаа өгсөн байна.

Номзүй



- Үндэсний ном зүйн нэгдсэн сан "Zotero" программд "Зууны мэдээ" сонины 2013, 2014, 2015, 2016, 2017, 2018, 2019, 2020 оны дугаараас 30677 мэдээллийг одоогийн байдлаар шивж оруулсан байна.
- 1955-1990 он хүртэлх "Улаанбаатарын мэдээ сонинг" скайнердаж дуусаад "Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд" оруулах ажлыг хийж байна.

- “Олон улсын эх дэлхийн өдөрт” 25 нэрийн номоор санамж өгөх номзүй хийж номын сангийн пэйж хуудсанд байршуулсан.
- “Хүнсний ногоо тарих –хөрс судлал” 54 нэрийн номоор санамж өгөх номзүй хийж номын сангийн пэйж хуудсанд байршуулсан.
- Халхын голын дайны холбогдолтой 93 нэрийн номоор санамж өгөх номзүй хийж номын сангийн пэйж хуудсанд байршуулсан. 17000 гаруй хүнд хүрч, 51 удаа шэйр хийсэн.
- Дэлхийн зөгийн өдрөөр “Зөгий, зөгийн балны талаар юу унших вэ” нэртэй санамж өгөх номзүй бэлтгэж номын сангийн каталогт оруулав.
- 5 дугаар сарын 13-нд Коха програмд “Гэр бүлийн боловсролд ” гэсэн 186 ширхэг номоор санамж өгөх ном зүйн жагсаалт гаргасан.

3.6. Мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөө

Хотын төв номын сангийн нийт номын санчдад мэргэжлийн сургалтыг 7 удаа зохион байгуулсан байна. Үүнд:

- “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан”-д мэдээлэл оруулах сургалтыг ОНҮТ-ийн ном зүйч О.Долгорсүрэн, номын санч Г.Шүрэнчимэг, Г.Ариунзаяа, Ө.Бадамсэд нарт
- Коха програмаас “Лист буюу номын жагсаалт үүсгэх” талаарх сургалт
- Коха програмын каталогийн ганцаарчилсан сургалтыг 2 удаа
- “Video maker” аппликейшн дээр ажиллах сургалт
- “CZUR” скайнер дээр ажиллах арга ажиллагааны талаарх сургалт
- Цахим каталогт ном каталогжуулах анхан шатны сургалт зэрэг болно.

Нийслэлийн алслагдсан Налайх дүүргийн Соёлын ордны номын санч Д.Нургүль, Г.Хорлоо, Багануур дүүргийн Соёлын ордны номын санч Г.Эрдэнэчимэг нарт номын техник ажиллагаа хийх, номыг нэгбүрчилсэн бүртгэлд данслах, Коха програмд ном каталогжуулах, данс баркод нэмэх, түүнийг хэвлэх талаар сургалт 6 удаа өгсөн.

3.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

2022 онд 908 ирцэд 1980 ном олгож үйлчилсний 405 номыг танхимаар, 1560 номыг гэрээр, 15 номыг солилцоогоор олгож үйлчилсэн байна. Хараaны бэрхшээлтэй 195 иргэдэд 226 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 107, утсаар 115, мессенжэрээр 4 удаа

МХҮХолбооны Ярьдаг номын студиэс ирсэн 220 нэрийн аудио номыг хүлээн авч уншлага үйлчилгээнд оруулсан. Дөрвөн төрлийн аудио номыг mp3 болгон youtube-с татаж уншлагад оруулсан. Хүүхдийн 2 төрлийн номыг брайль бичигт хөрвүүлж номын фондыг баяжуулсан байна. Мөн “Мэдээ, мэдээллийн тойм” группт 57 удаа аудио номын бичлэг, “Өдрийн сонин”-ы тойм 52 удаа тус тус оруулсан байна.

“Ном сонсож хөгжье” фэйсбүүк группт нийт 40 удаа мэдээ, мэдээллийг оруулсан.

Брайль болон дэйзи номын сэдэвчилсэн үзэсгэлэн нийт 10 удаа 108 ширхэг номоор:

- Дэлхийн номын өдөр
- Зохиолч Б.Нацагдоржийн уран бүтээл
- Зохиолч Б.Шүүдэрцэцэгийн уран бүтээл

- Ж.Золбаяр буюу Амайн уран бүтээл
- Зохиолч Б.Баярхүүгийн уран бүтээл
- Эх хэл бичиг – Соёлын дархла
- Товгор зурагт ном
- Цахим хүртээмжтэй номууд
- Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тоглоомын булан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрт

Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 30 нэрийн цахим ном бүтээсэн.

Тайлангийн хугацаанд “Технологийн төв”-ийн YOUTUBE суваг, Facebook групп дээр дүрс бичлэг, зурагтай 95 мэдээлэл оруулсан байна.

YouTube: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн суваг https://www.youtube.com/watch?v=syUksUaXi8w;- 15 мэдээ

Facebook групп: Онцлог хэрэгцээтэй иргэдийн нэгдсэн бүлэг групп – 15 мэдээ

Page: “Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний facebook хуудас -65 мэдээ

"Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан хэлбэрээр 45 уншигчдад 60 удаа зохион явуулсан.

Тайлангийн хугацаанд хийгдэх албан ёсны 30 удаагийн шинэчлэлт, Үйлчилгээнд ашиглагдаж буй компьютер, и-ном тоглуулагч, цахим брайль төхөөрөмж гэх техник хэрэгсэлүүдийн бүрэн ажиллагааг хариуцаж, 15 удаагийн хуваарьт засварыг хийсэн байна. Мөн “Windows” 10 үйлдлийн системийн шинэчлэгдсэн хувилбар болон хараагүй хүний дэлгэц уншигч “NVDA” програмын шинэ командуудыг орчуулж, хуучин програмын орчуулгыг шинэчлэх, Монгол хэлний ярьдаг програмын сан, бичвэрийн програмын санг нэмэгдүүлж, ярианы чанарыг сайжруулсан.

Компьютер, интернэт, дэлгэц уншигч програм хангамж цахим брайль төхөөрөмж, и-ном уншигч тоглуулагч тусгай хэрэгсэл гэх мэт техник хэрэгсэлийн зөвлөмжийг 250 удаа өгч, нийт 120 харааны бэрхшээлтэй иргэд хамрагдсан.

3.8. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

Тус номын санд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 45,7% буюу 32 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 1 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан. Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

Захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээн 6.7-д “Ажилтнуудыг 2 жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах…” гэж заасны дагуу 2019 онд байгууллагын 55 ажилтныг Хавдар судлалын үндэсний төвийн эмнэлэгт урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Дараагийн үзлэгийг энэ ондоо багтаан хамруулхаар төлөвлөн ажиллаж байна.

3.9. Зохион байгуулсан сургалтууд

- Америкийн Монгол Судлалын төв, МУБИС-ийн номын сантай хамтран зохион байгуулсан “Сэдвийн түлхүүр үг, нэрийн баталгаажуулсан бүртгэл” танхимын цуврал сургалт
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Соёлын яамнаас зохион байгуулсан "Соёлын боловсролын үндэсний сургагч багш" бэлтгэх сургалт
- СУИС-ийн багш, доктор, соёл судлаач Б.Мөнхбадрал “Соёлын дархлаа, үнэт зүйлс” лекц, ном зүйч Н.Одхүү “Каталогт номзүйн мэдээлэл (лист) бэлдэх”, каталогч З.Золжаргал “Кохад ном каталогжуулах” анхан шатны сургалтууд

- МҮЭХ-ны "Хөдөлмөр сургалт судалгааны төв" -өөс "ҮЭ-ийн үндсэн мэдлэг" олгох сургалт

<u>3.10. Үйл ажиллагааны ил тод байдал</u>

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **26** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах тухай” А/01 дүгээр тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

<u>3.11. Хүний нөөцийн ил тод байдал:</u>

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг тухай бүр байршуулан шинэчилсэн.

Тайлант хугацаанд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

2022 онд Улсын болон Нийслэлийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааны эрх шилжсэн төсөл арга хэмжээ байхгүй. Харин худалдан авах ажиллагааны захиалагчийн хяналт тавьж ажилласан 2 арга хэмжээ байна.

3.12. Улсын болон Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил

Нийслэлийн болон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 68,339,601 төгрөгийн номын бүрдүүлэлт хийгдэж, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн номыг номын данс бүртгэл, тайлан балансд тусгалаа. Үүнд:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 297 нэрийн 1605 ширхэг 48,351,681 төгрөгийн номын худалдан авсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт буюу МУ-ын Соёлын яамны санхүүжилтээр Харааны бэрхшээлтэй иргэдийн уншлагын танхимын номын фондын бүрдүүлэлтэд зориулж 23 нэрийн 6999 ширхэг 19,987,920 төгрөгийн хараaны бэрхшээлтэй уншигчдад зориулан хэвлэмэл тусгай форматад хөрвүүлсэн номыг худалдан авсан

Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Үүнд:

Д/д	Үйл ажиллагааны ерөнхий нэр	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Контент	15	2500
2	Уулзалт	51	617
3	Номын үзэсгэлэн	229	1753
4	Уралдаан	24	840
5	Тойм яриа	24	432
6	Чанга уншлага	38	1517
7	Сургалт	130	1204
8	Номын жим	67	1177
9	Америкийн соёл мэдээллийн төв Тоглоомын өдөр	559	2541

Эдгээрээс тоймлон үзвэл:

5.1.1. Контент

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд нийт 15 удаагийн богино хэмжээний видео контент хийж уншигч олонд хүргэсэн байна.

- Замын хөдөлгөөнд оролцож байгаа харааны бэрхшээлтэй иргэдэд соёлтой хандах чиглэлээр 2,
- “Хотын соёл - хотын гудамж, талбайн нэршил” сэдвээр 5,
- Жендерийн тэгш байдал, эх оронч үзэл сэдвээр 2,
- Нийтийн тээврээр соёлтой үйлчлүүлье сэдвээр 1,
- Хоггүй цэвэрхэн хотын төлөө хамтдаа цувралаар 2,
- Хотын соёл нэршлээр цуврал 2,
- Номыг хэрхэн соёлтой унших вэ сэдвээр 1

5.1.2. Уулзалт, лекц, ярилцлага

Дэлхийн ном болон зохиогчийн эрхийн өдрөөр Жангар хүүхдийн номын редакцын зохиолч, зураач Батбаярын Төрмөнхийг “ Зохиолч-Уншигчдын” уулзалт ярилцлагад урьж, 45-р сургуулийн 4б ангийн 25 сурагчид , 47-р сургуулийн 2г ангийн 32 сурагчид, ОНҮТасгийн номын санчид энэ арга хэмжээг хамтран зохион байгуулж явуулсан.

Дэлхийн Яруу найргийн өдрийг тохиолдуулан “Уншигч-Зохиолчдын Уулзалт”-ыг зохион байгуулав. Тус уулзалтын зочноор Монголын Зохиолчдийн Эвлэлийн Бодлого зохицуулалтын албаны дарга, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Намбарын Пүрэвийг урьж өөрийн биеэр хөтлөн, СБД-ийн 31-р сургуулийн 8-р ангийн 41 сурагчдыг урьж оролцуулав.

Дэлхийн номын баяр”-ын өдрийг угтан” НЕБ-ын 21-р сургуулийн 5г ангийн, номын сангийн идэвхтэн уншигч сурагч Дэлгэрбаярын Баясгалангийн бүтээлчээр баярлая, бага багаар суралцъя, бусаддаа туслая гэсэн уриатай “Бүтээлийн үзэсгэлэн”, уулзалтыг номын сан хамтран зохион байгуулсан.

Мөн Д.Нацагдоржийн шагналт зохиолч судлаач, яруу найрагч Ц.Буянзаяагийн “Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний хөгжлийн үе шатууд” лекц уулзалтыг зохион байгуулалцсан.

Д. Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч Надмидын Мандалыг урьж оролцуулсан.

МЗЭ-ийн болон Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, зохиолч, яруу найрагч Төрийн Баянсантай “ Зохиолч-уншигчдын уулзалтыг зохион байгуулж, арга хэмжээнд ЕБ-ын 45-р сургуулийн 11 дүгээр ангийн 40 гаруй сурагчид, монгол хэл-уран зохиолын багш, сургуулийн номын санчийн хамт оролцсон.

ХУД-ийн Зэвсэгт хүчний 326-р цэргийн ангитай хамтран ажиллаж буй ажлын хүрээнд МЗЭ-ийн шагналт, зохиолч, сэтгүүлч, яруу найрагч, бэлтгэл дэд хурандаа Г. Баатарнумтай “ ЗАЛУУ НАСНЫ ДУРСАМЖ УУЛЗАЛТ ” зохион байгуулсан.

Монголын хүүхдийн уран зохиолын нэрт төлөөлөгч, Д.Нацагдоржийн шагналт Д.Содномдоржийн охин Монголын Хүүхдийн Ордоны Монгол хэл-Уран зохиолын багш С.Цэцэгмаа урьж “Зохиолч-уншигчдын” уулзалт ярилцлагад Баянзүрх дүүргийн ЕБ-ын 85 дугаар сургуулийн 6, 7 дугаар ангийн сурагчид болон Н.Сувдаа багштай 2б анги, 30 сурагчид оролцов.

Зохиолч Луужир Жиймийтэй Налайх дүүргийн 103-р сургуулийн номын клубын 25 сурагчид

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангаас уламжлал болгон зохион явуулдаг "Зохиолч-Уншигчдын уулзалт ярилцлага"-ын зочноор МУСГЗ, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Шагдарсүрэнгийн Гүрбазар гуайг урьж оролцууллаа. Уг уулзалт ярилцлагад Монголын Үндэсний Их Сургууль -ийн Урлагийн сургуулийн С.Сарангэрэл багштай жүжиг, дуулаачийн ангийн 35 оюутан оролцлоо.

Хүүхдийн зохиолч О. Сундуй гуайтай “Зохиолч- Уншигчдын уулзалт ярилцлага” зохион байгууллаа. Уулзалтанд Ц. Амарсанаа багштай 31-р сургуулийн 2б ангийн 52 сурагч хамрагдсан байна.

Зочны ярилцлага

“Номын сангийн зочны ярилцлага” буланд нийт 25 зочин урьж оролцууллаа**.**

- “Том амжилт” ХХК-ний ерөнхий захирал Жаргалсайхан Шижир “ Комик нь хүүхдийн уран сэтгэмжийг илүү сайжруулж өгдөг”
- Зохиолч, яруу найрагч, орчуулагч Рэнцэнхандын Сайхан-Уул “ Хүний оюун ухаанаас амилдаг, хүний тархины мөрөөдөл сэтгэмжээр бүтдэг тийм яруу бүтээлийг ном хэмээх байх гэж ойлгодог”

- Хүүхдийн зохиолч П.Наранбаатар **“**Хорвоог танин мэдэх, өөрийгөө олж авах бие хүн болон төлөвшихөд ном асар их үүрэгтэй”
- Олон улсын шим судлаач С. Буянтогтох “Хүний амьдралд тулгарч буй бүх асуудлын хариулт номонд байдаг гэдэгт итгэдэг”
- МУСТА, жүжигчин, продюсер, Х.Баярмаа “ Богино хугацаанд хурдан уншсанаар илүү их зүйлийг ойлгох боломжтой”
- Дрийм тв “ Тавтай нойрсоорой” хүүхдийн нэвтрүүлгийн чиглүүлэгч хөтлөгч А. Найгалмаа “ Ном унших нь амралт болохоос гадна тархийг амрааж, стресс тайлдаг”

- Хэл шинжлэл ухааны магистер, хүүхдийн зохиолч, багш Т. Энхтуяа “Ном унших нь бие махбодод ч сэтгэл санаанд ч эерэгээр нөлөөлдөг”
- Монголын хүүхдийн уран бүтээлчдийн “Эвт үзэг” төвийн гүйцэтгэх захирал, хүүхдийн зохиолч Бат-Эрдэнийн Ганчимэг “ Тодорхой цагийг өөртөө заавал гаргаад, янз бүрийн ном уншаасай л гэж хэлье”

- Зохиолч, чөлөөт уран бүтээлч Хабааны Байыт “ Номын сэдэл анзаарч чадсан хүмүүнд бол хаа сайгүй байж л байдаг”
- Яруу найрагч Лхагвасүрэнгийн Хасар
- " Ач тусын үлгэрүүд" цуврал номын зохиолч Э.Эрдэнэцэцэг “ Ном бол гэрэл. Бүх зүйл эцэстээ гэрэл болдог.Гэрэл болохын төлөө л оршдог”
- Зохиолч Мээлс Пүрэвмаа “ Ном унших нь өөртэйгөө танилцах боломж юм”
- ‘’Чинсан хөгжлийн академи”-ийн ярих ур чадварын багш П. Одгэрэл “ Ном бол амьдралын тусгал, төсөөллийн өрөө”
- Монгол ТВ-ийн “Өнөө өглөө” хөтөлбөрийн хөтлөгч У.Эрхбаяр “ Ном унших нь аливаа зүйлд төвлөрч, сууж сурах, төсөөлөн бодох чадвар, үгийн баялаг нэмэгдүүлдэг”
- Зохиолч, ментор Т. Гүлдаурен “ Ухаантай хүн ярихаасаа илүү сонсдог, сонсохоосоо илүү боддог, бодохоосоо илүү уншдаг”
- “Нутгийн шийдэл” ТББ-ын захирал Цэдэвдамбын Оюунгэрэл “ Номгүй бол амьдрал хичнээн гунигтай, хоосон байх байсан бол”

5.1.3. Номын үзэсгэлэн танилцуулга

Номын үзэсгэлэн танилцуулгыг 229 удаа, 452 нэрийн,1745 ширхэг номоор **Сэдэвчилсэн номын үзэсгэлэн:** 47 удаа, 19 нэрийн, 1155 ширхэг боть номоор үзэсгэлэн гаргаж сан хөмрөгөө сурталчилсан.

- Дэлхийн яруу найргийн өдөрт 73 ш ном
- Бие хүний хөгжил 61 ш ном

- Инээдийн баяр 44 ном
- Дэлхийн номын өдөрт 25 ном
- Зохиогчийн эрхийг хамгаалах өдөрт 8 ном
- Дэлхийн тамхигүй өдөрт -13 ш ном
- Хүүхдийн зохиолч О.Сундуйн уулзалтанд зориулж 14 ном
- Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчийн уулзалтанд зохиолч Ш.Гүрбазарын 8 номоор
- Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан 18 ширхэг номоор
- " Гэгээн хайрын '' өдөрт 32 ширхэг номоор
- "Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-т 32 нэрийн 34 ширхэг номоор
- "Дэлхийн эмч нарын өдөр'' -т 1- нэрийн 14 ширхэг номоор
- '' Дэлхийн эрүүл мэндийн өдөр ''-т 1 нэрийн 24 ширхэг номоор
- ''Эх үрсийн баярын өдөр'' -т 28 ш номоор
- Зохиолч Л.Түдэв уран бүтээлийн 55 ширхэг номоор
- Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөрт 16 ном
- Цагаан сар 24 ном 4 үзүүлэн
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалаах өдөр 34 ном
- Наурызын баяр 20 ном
- О.Дашбаларын 15 ном, 1стикер
- ЕБС-ийн хүүхдүүдэд ЭЕШ-ын 26ш номоор
- Д.Содномдоржийн уран бүтээл 33ш, 2 стикер
- Олон улсын хүүхдийн номын өдрөөр 32ш номоор
- Олон улсын театрын өдөрт зориулсан үзэсгэлэн 15 ном,
- МЗЭ-ийн болон Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, зохиолч, яруу найрагч Төрийн Баянсан уран бүтээлээр сэдэвчилсэн номын үзэсгэлэн 10 номоор
- Үндсэн сан хөмрөгөөс 1удаа , 8 нэрийн ,10 ширхэг номоор
- Хүүхдийн уншлагын танхимаас 4 удаа, 4 нэр , 44 ширхэг номоор
- Америк мэдээллийн төвийн танхимаас "Эх Дэлхийн өдөр"-т зориулан 5 нэрийн 13 ширхэг шинэ номоор гаргаж сурталчилсан.

"Шинэ ном"-ын үзэсгэлэн: Уншлагын танхимуудын сан хөмрөгт ирсэн шинэ номыг сурталчлах 24 удаа, 236 нэрийн, 590 ширхэг номоор гаргалаа.

Цахим номын үзэсгэлэн:

- Үндсэн хуулийн тухай номоор үзэсгэлэн гаргаж 82 хүнд хүрсэн байна.
- Битүүний тухай зан заншил, номын танилцуулга гаргаж 149 хүнд хүрсэн.
- М.Цэнддоржийн 90 насны ойн намтар тухай үзэсгэлэн гаргаж 110 хүнд хүрсэн.
- О.Дашбалбарын 65 насны ойд зориулан намтар пост оруулан 112 хүнд хүрсэн байна.
- Дэлхийн яруу найргийн өдрөөр 7ш номоор үзэсгэлэн гаргаж 141 хүнд хүрсэн байна.

- “ Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдөрт “Үндэсний бичиг бидний бахархал” сэдэвт үзэсгэлэнг нийтийн уншлагын танхимаар 35 номоор гаргаж 83 хүн үзэж танилцсан байна.
- Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Шагжийн Ванчаарайгийн уран бүтээлийн үзэсгэлэн 20 номоор гаргаж page хуудсаар дамжуулан сурталчилсан нь 160 хүнд хүрсэн.
- “Агаарын бохирдол, угаарын хий, шахмал түлшний хэрэглээ, хэрэглэх” сэдэвт 12 цаасан мэдээлэл гаргаж, пэйж хуудсаар дамжуулан сурталчилсан нь 154 хүнд хүрсэн.
- Монгол үндэсний их баяр “Цагаан сарын баяр”-ыг тохиолдуулан уншигч та бүхэндээ Монгол түмний уламжлалт ёс заншил номоор үзэсгэлэнг 12ш ном, 6ш цаасан мэдээлэл гаргаж page хуудсаар дамжуулан сурталчилсан нь 240 хүнд хүрсэн.
- Монгол Улсын Төрийн Соёрхолт яруу найрагч Р.Чойномын уран бүтээлээс 10ш номоор үзэсгэлэн гаргаж page хуудсаар дамжуулан сурталчилсан нь 187 хүнд хүрсэн.
- Монголын болон гадаадын уран зохиолын ном, шүлгийн 21ш номоор үзэсгэлэн гаргаж пэйж хуудсаар дамжуулан сурталчилсан нь 236 хүнд хүрсэн.
- Монголын түүх судар, төрт ёсонд эерэг үүрэг гүйцэтгэж улмаар нэр хийгээд мөрөө үлдээсэн хатадын тухай 10ш номоор үзэсгэлэн гаргаж page хуудсаар дамжуулан сурталчилсан нь 192 хүнд хүрсэн.
- Монгол цэргийн өдөрт зориулан цэргийн дуу, шүлэг, цэргийн түүх, уламжлал, сэхээтний тухай 15ш номоор үзэсгэлэн гаргаж цахим хуудсаар дамжуулан сурталчилсан нь 251 хүнд хүрсэн.
- Мод тарих үндэсний өдөрт: мод тарих зөвлөмж, байгаль орчны танин мэдэхүйн холбогдолтой 36 нэр төрлийн номоор
- Орос ардын үлгэрээр аялцгаая 9ш номоор
- Дэлхийн хүүхдийн номын өдөрт 18ш номоор
- “Хүүхдийн уншвал зохих ном” 24 ширхэг номоор

5.1.4. Тойм яриа

Номын сангийн хэмжээнд тойм яриаг 27 удаа хийсэн байна.

- “БЭТҮВ” шашны сургуультай хамтран номын сангийн өдөрлөгийг Мэйкэрспэйс танхимын номын санч Б.Шүрэнбагана, Бүртгэл-Сан хөмрөгийн номын санч Д.Саруулбат, ХУТ-ын номын санч Д.Жаргалсайхан “ Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ?” номын тойм яриаг 35 шавь суралцагчдад мэдээлэл хийсэн.
- ЕБ-ийн “Номт наран” сургуулийн 38 сурагчдад Ж.Дашдондог зохиолчийн 11 номыг танилцуулж, тойм яриа хийсэн.
- “Номт наран” сургуулийн 3 бүлгийн 42 сурагчид О. Сундуй зохиолчийн намтар уран бүтээлийг танилцуулж, “Непко Кидс” хэвлэлийн газраас эрхлэн гаргасан 23 номоор

- Үндэсний бичиг үсгийн баярыг угтан “Номт наран” сургуулийн 2а ангийн 17 сурагчид Б.Бадам зохиолчийн кирилл болон монгол бичгээр бичигдсэн “Муурын нулимс”, “Чоно буруугүй”, “Хайрыг яаж зурах вэ” 3 номоор, Монголчуудын хэрэглэж байсан бичиг үсгийн үүсэл гарал түүхээс товч мэдээлэл танилцуулга хийв.
- **“**Номт наран” сургууль дээр Ю. Санжаагончиг “ Хэрэмний нулимс”, “ Мөөгөн хүү” **, “**Британика хүүхдийн танин мэдэхүйн цуврал, Гайхамшигт нүд , 100 баримт цуврал, Муур туулай 2-ын нэг өдөр, Хэн унтаагүй вэ?, Юуны чимээ вэ? , HERO комикс 1-6 цуврал, Д.Индра “Бүжинд тохиолдсон явдал” 1-4 цуврал номын тойм танилцуулга хийсэн.
- 47-р сургуулийн 2г ангийн 35 сурагчдад Н.Энхтайван зохиолчийн “Ногоон дэлхий” 12 цувралаас тойм танилцуулгыг хүргэв.
- Байгууллагын фэйсбүүк группэд: “Тэр хэн байв, тэр хэн бэ?” Жордан, Эйнштэйн, Диана,Мишель Обама цуврал, Монгол хүн цуврал: Д. Нацагдорж номыг бэлтгэн оруулсан.

5.1.5. *Чанга уншлага*

- Нийт **64** удаа, **1302** сурагч багачууд, уншигчдад чанга уншлага зохион байгуулсан
- “Номт наран” сургуулийн 3 бүлгийн 42 сурагчид О. Сундуй зохиолчийн “ Ялимгүй маргаан, Бөөвгөр Өөвгөр хоёр” богино өгүүллэгээр
- “Номт наран” сургуулийн 1а, 2а ангийн 35 сурагчдад О. Сундуй зохиолчийн “ Ялимгүй маргаан, Бөөвгөр Өөвгөр хоёр” өгүүллэгээр
- “Номт наран” 4г , 3в, 4а ангийн 43 сурагчдад Шинэ ном: Ю. Санжаагончиг “ Мөөгөн хүү” өгүүллэгээр
- ЕБ-ын “Номт наран” сургуулийн 2 бүлгийн 48 сурагчид Б.Бадам зохиолчийн “ Бэлэн амт хулгана” үлгэрээр
- ЕБ-ын “Номт наран” сургуулийн 5 бүлгийн 77 сурагчид Д. Нацагдоржийн “ Хуучин хүү” өгүүллэг, “Тэнэг чоно” монгол ардын үлгэрээр , “Гурван лам” дундад ардын сонгодог үлгэрээр
- 39-р сургуулийн Бэрцэцэг багштай 3г ангийн 29 сурагчдад О. Сундуй зохиолчийн “ Ялимгүй маргаан, Бөөвгөр Өөвгөр хоёр” өгүүллэгээр
- 47-р сургуулийн 2г ангийн 35 сурагчид Н.Энхтайван зохиолчийн “ Олзонд дуртай онгироо шаазгай” шүлгээр, Ач тусын үлгэр цувралын “ Өгөөмөр охин Өэлүн” номоор
- НЕБ-ын 39-р сургуулийн Даариймаа багштай 2в ангийн 36 сурагчдад Итал ардын үлгэр “ Шоргоолж буудайн үр” үлгэрээр
- 40-р цэцэрлэгийн Ганчулуун, Мөнхзул багштай “Бэлтгэл” бүлгийн 21 суралцагчдад Итал ардын үлгэр “ Шоргоолж буудайн үр”, “ Монголын олз” домог үлгэрээр чанга уншлага хийв.
- СБДүүрэг 6-р сургуулийн Болормаа багштай 3-р ангийн 50 сурагчдад зохиолч Ч.Лхамсүрэн “ Хэрэмний хүүхэд” зохиолоос

- “ Найтын Австрали Монгол” олон улсын дунд сургуулийн 1,2-р ангийн 30 сурагчдад “ Ойн бяцхан бэмби” үлгэрээр
- “ Найтын Австрали Монгол” олон улсын дунд сургуулийн 3,4-р ангийн 33 сурагчдад зохиолч О. Сундуй “Өөвгөр Бөөвгөр хоёр” сургамжит богино өгүүллэгээс
- НЕБ-ын 21-р сургуулийн 4и ангийн 43 сурагчид “Өнчин хусны дууль” сургамжит өгүүллэгээс
- Гёте сургуулийн 4б ангийн 25 сурагчид “Өнчин хусны дууль” сургамжит өгүүллэгээс
- СХДүүрэг 62-р сургуулийн 2д ангийн 35 сурагчид малайз ардын “ Маргааш маргааш” үлгэрээр

5.1.6. Номын жим

Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “ Номын жим” номын сантай танилцах аялалын хөтөлбөрийг зохион байгуулж **67** удаа **1177** хүн хамрагдлаа. Үүнд:

- “БЭТҮВ” шашны сургуулийн 41 багш, шавь суралцагчдыг хотын соёлыг төлөвшүүлэх , номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх “Номын жим” номын сантай танилцуулах аялалаар өөрийн номын сан болон МУҮНС-тай танилцах ажлыг зохион байгуулсан.
- 40-р цэцэрлэгийн Ганчулуун, Мөнхзул багштай “Бэлтгэл” бүлгийн 21 суралцагчид
- “Хил хамгаалах ерөнхий газар"-ын хөдөө орон нутгийн хилийн отрядад ажиллаж буй ажилтан албан хаагчдын төлөөлөл болох 16 албан хаагчид
- Олон улсын “Эм Ай Ю “–(MIU) Сургуулийн гадаад оюутны төлөөлөл, болон ахлах ангийн 28 сурагчид
- American Corner Make U space-с явуулдаг хөтөлбөр болох SIP /Student Internship program/-д шинээр элссэн 10 Intern хүүхдүүдэд номын сангийн үйл ажиллагаагаа танилцуулсан.
- СБД-ийн 6-р сургуулийн Мөнхчимэг багштай 6в ангийн 32 сурагчид
- СБДүүрэг 6-р сургуулийн Болормаа багштай 3-р ангийн 50 сурагчид
- СБДүүрэг 16-р сургуулийн Эрдэнэсүрэн багштай 7б ангийн 27 сурагчид
- БЗДүүрэг 21-р сургуулийн Б.Оюунгэрэл багштай 4и ангийн 43 сурагч
- НЕБ-ын 31 дүгээр сургуулийн Ж.Ганчимэг багштай 11Б ангийн 36 сурагчдад
- НЕБ-ын 31-р сургуулийн Ч.Болормаа багштай 4б ангийн 40 сурагчид
- НЕБ-ын 31 дүгээр сургуулийн Г. Лхагвасүрэн багштай 5а ангийн 34 сурагчид
- Нийслэлийн 31-р сургуулийн Г.Оюун-Эрдэнэ багштай 4г ангийн 45 сурагч
- СБДүүрэг 31-р сургуулийн эрүүл мэндийн клубын хүүхдүүдэд 15 хүүхэд
- 31-р дунд сургуулийн 2-р ангийн 43 сурагчдад номын сангаа танилцуулсан.
- НЕБ-ын 39-р сургуулийн Даариймаа багштай 2в ангийн 36 сурагчид

- НЕБ-ын 39-р сургуулийн 3г ангийн 35 сурагчид
- Орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан “Номын жим” аялалын хөтөлбөрийг Нийслэлийн 47-р сургуулийн Нансалмаа багштай 2г ангийн 34 сурагчдад, номын сангийн уншигчийн карт нээлгэж, номын сангийн үйл ажиллагаатай танилцуулсан.

- Нийслэлийн 60 дугаар сургуультай хамтран ажиллах 1 жилийн гэрээ байгуулж 234 хүүхэд болон багш ажилчдыг номын сангийн уншигчаар бүртгүүлж. 7б ангийн 25 сурагчид номын сантай танилцлаа.

- СХДүүрэг 62-р сургуулийн Отгонмэнд
  багштай 2д ангийн 35 сурагч, багш, эцэг эх, асран хамгаалагчийн хамт
- СХДүүрэг 62-р сургуулийн Б.Лхагвадэжид багштай 5е ангийн 47 сурагч, багш, асран хамгаалагчийн хамтаар хөтөлбөрт 49 хүн хамрагдаж, сурагчид номын сангийн уншигчаар бүртгүүлэн карт нээлгэсэн.

- СХД-ийн Ерөнхий Боловсролын 62-р сургуулийн Б.Багшмаа багштай 2е ангийн 37 сурагч

- БГД-ийн 73-р сургуулийн Пүрэвсүрэн багштай 4ж ангийн 36 сурагч
- БГД-ийн 73-р сургуулийн Энхтуул багштай 4ё ангийн 38 сурагч
- НЕБ-ын 79 дүгээр сургуулийн Ц.Тулгабаатар багштай 8а ангийн 37 сурагчдад хөтөлбөрт хамрагдаж карт нээлгэсэн.
- БЗД-ийн 20-р хорооны Гачуурт тосгоны 85-р сургуулийн 2а, 7б ангийн 21 сурагчид, 2 багш, 1 нийгмийн ажилтан
- Нийслэлийн Налайх дүүргийн 103-р сургуулийн номын клубын 25 сурагчид, номын санч, багш нар

- “Орчлон” олон улсын дунд сургуулийн Болормаа багштай 4е ангийн 28 сурагч, 5 багш, эцэг эх, асран хамгаалагчийн хамт
- “Найтын Австрали Монгол” олон улсын дунд сургуулийн 1-4-р ангийн 63 сурагч, багш, эцэг эх, асран хамгаалагчийн хамт
- “Гёте” олон улсын дунд сургуулийн Долгор багштай 4б ангийн 25 сурагч

- "Номын жим" аяллын хөтөлбөрт СХД-ийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 12 хүн хамрагдан номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа.

- 116-р сургуулийн 9-11-р ангийн 50 гаруй багш, сурагчид номын сангийн уншлага үйлчилгээ, үйл ажиллагаатай танилцлаа.

5.1.7. Америкийн соёл мэдээллийн төв

Байгаль орчны бохирдлоо багасгах, хог хаягдлаа ахин ашиглах эдийн засгийн үр нөлөөтэй "Дахин загварчлах" сургалтыг 17 удаа зохион байгуулж нийтдээ 154 хүн хамрагдлаа. Үүнд:

- Хуучин жинсэн материалаар цүнх оёх, төрөл бүрийн чимэглэл хийх сургалтыг 7 удаа загвар зохион бүтээгч багш И.Урангоо хариуцан явуулж 61 хүн хамрагдсан.
- Ашигласан ибаримтын цаас болон хаягдал сэтгүүлийг дахин сэргээж шинэ цаас гаргаж авах мөн таваг, хайрцаг хийх сургалтыг 5 удаа багш Оюун хариуцан явуулж 44 хүн хамрагдсан.
- Хаягдал цаасаар гоёл чимэглэл хийх, шил чимэглэх сургалтуудыг 3 удаа номын санч Б.Шүрэнбагана хариуцан явуулж 32 хүн хамрагдсан.
- Хаягдал цаасаар гоёл, чимэглэл хийх сургалтыг 2 удаа багш Хишгээ хариуцан 17 хүн тус тус хамрагдсан байна.

Тайлангийн хугацаанд Мейкюспэйс танхимын сургалт, хөтөлбөр болон үндсэн үйл ажиллагаануудыг цаг үеийн нөхцөл байдал, халдвар хамгааллын дэглэмтэй уялдуулан хөтөлбөрийн танхим, Мейкюспэйс танхимд болон онлайнаар хэлбэрээр зохион байгуулж ажиллалаа. Мөн сургалтуудыг шинээр шинэ багш нартай хамтарч амжилттай эхлүүлээд 5 төрлийн сургалт үйл ажиллагаа явагдаж байна. Сургалтын үйл ажиллагааг онлайнаар 1 удаа, танхимаар нийтдээ удаагийн сургалт, үйл ажиллагаанд 360 хүн хамрагдсан байна. Үүнд:

1. Young Coders
2. 2D Animation Course
3. Lego Mindstorms
4. Электроникийн үндэс ба Ардуйно
5. STEAM тоглоомын хөтөлбөр
6. Төгсөлтийн баярын арга хэмжээ
7. Оюутан дадлагажигч хөтөлбөр

Young Coders сургалтанд 8-12-р ангийн сурагчид хамрагдах боломжтой бөгөөд бүртгэлийг онлайнаар авч эссэ бичлэгээр нь сурагчдыг сонгон шалгаруулсны үндсэн дээр сургалтанд хамруулж байна. Тайлангийн хугацааны эхний улиралд 2 удаагийн элсэлт авч Бямба гариг бүрт явагдаж нийтдээ 8 удаагийн хичээлд 83 хүүхэд 7 удаа танхимаар, 1 удаа онлайнаар тус тус хамрагдсан. 5 сараас Мэйкюспэйс танхим шинэ бүтцээр хичээллэж эхэлсэн бөгөөд Young Coders хөтөлбөрт 15 сурагч хамрагдаж 7 хоногт 2 удаа танхимын хичээлд хамрагдаж байна. Сурагчид МАТЛАБ програм дээр код бичих, алгоримтын үндэс болон тооны машин хийх чадвартай болж байна. Мөн хувь хүний хөгжлийн хичээлүүдээр онол дадлага хосолбсон мэдлэгийг авч байна. Тус хичээлийг анги удирдсан багш Ц.Юүлжалсэнгээ хариуцан ажиллаж байна.



2D Animation сургалтын бүртгэлийг элсэлтийн зарыг хүртээмжтэй байх үүднээс онлайнаар авч нийт 4 удаагийн сургалтанд 90 хүүхэд хамрагдаж байна. 2D Анимэшн хийх сонирхол өсвөр үеийнхний маш их сонирхдог сургалт учраас төвийн санхүүжилтээр 6 зориулалтын дэлгэц худалдан авсан. Энэ хичээлээр анимэшний үндсэн төхөөрөмжүүд дээр ажиллах, үндсэн техникүүдийг сурах, дуу дүрс оруулах, сүүдэр, хөдөлгөөн үүсгэх зэрэг хичээлүүдийг “Мэжик Пен” сургалтын төвийн багш Е.Амармэнд болон бусад сайн дурын оюутнууд удирдан явуулж байна.

Lego Mindstorms програмчлах сургалт 15 удаа явагдаж 62 хүүхэд хамрагдсан. Тус сургалтаар хүүхдүүд танк, сумо, уралдааны машин болон роботуудыг угсарч, програм бичиж сурах мөн техник, технологийн мэдлэг авдаг. Мөн хийсэн роботуудаа хооронд нь уралдуулж мэдлэг чадвараа сорьсон байна. 12 хүүхэд амжилттай хамрагдсан сертификат гардуулсан.

Электроникийн үндэс ба Ардуйно хичээлийн зар болон бүртгэлийг мөн онлайнаар явуулж 10 хүүхэд шалгаруулж авсан. Хичээлийг ӨЗБЛА Сургуулийн электроникийн багш Д.Баярцэцэг удирдан явуулж сургачдад электроникийн суурь ойлголтыг туршилын хичээлээр бататган өгөхөөс гадна ардуно програмчилж сурах суурь хичээлүүдийг онол, дадлага хослуулан олгож 5 удаагийн сургалтанд 68 сурагч хамрагдсан. 7 хүүхэд амжилттай төгссөн сертификат авсан. Эхний улиралд явагдаад энэ сургалт ахин явагдахаа больсон.

Б.БААСТЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

❖ **Орон тоо, удирдлагын бүтэц**

Хүүхдийн төв номын сан /1 удирдах, 31 гүйцэтгэх/ 32 ажилтантай, 4 хэлтэстэй. Захирлын дэргэд

- Захиргааны зөвлөл
- Мэргэжил аргазүйн зөвлөл
- Эцэг эхийн зөвлөл
- Ёс зүйн хороо
- Өмч хамгааллын комисс
- Алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх комисс
- Баримт бичиг нягтлан шалгах комисс
- Гамшгаас урьдчилан сэргийлэх штаб ажилладаг.

ЗАХИРАЛ-1

Уншлага үйлчилгээний	Мэдээлэл технологи арга зүйн	Фонд хадгалалтын	Захиргаа аж ахуйн
Эрхлэгч 1 */Хэлтсийн эрхлэгч номын санчийн ажил үүргийг давхар хашдаг/* *Номын санч 11* *Бүртгэлийн номын санч 1*	***Эрхлэгч-1*** */Хэлтсийн эрхлэгч Ном зүйчийн ажил үүргийг давхар хашдаг/* *Арга зүйч-1* *Номзүйч-1* *Каталогич-2* *Инженер*	***Эрхлэгч -1*** */Хэлтсийн эрхлэгч Фондын номын санчийн ажил үүргийг давхар хашдаг/* *Сан хөмрөгч 2,* *Ном ангилагч 1* *Ном сэргээн засварлагч 1* *Ном бүрдүүлэгч 1*	***Эрхлэгч -1*** */Хэлтсийн эрхлэгч Ном бүрдүүлэгчийн ажил үүргийг давхар хашдаг/* *Нягтлан 1* *Бичиг хэрэг, архив 1* *Өлгүүр 2* *Үйлчлэгч 2* *Харуул 3* *Нярав 1 /Ном сэргээгчийн ажил*

❖ **Чиг үүрэг**

Төрөөс соёлын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжид үндэслэн хүүхэд, залуучуудад ном хэвлэл, хэвлэмэл бус материал, бусад мэдээллийн нөөцөөр номын сангийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн номын сан, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ЕБС-иудын номын сангуудыг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй.

1. Мэдээлэл технологи аргазүйн хэлтэс

Энэ хэлтэс нь байгууллагын үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, шинэчлэл хийх, хүүхдийн ном хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн номын санг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээнэ.

2. Фонд хадгаламжийн хэлтэс

Энэ хэлтэс нь сан хөмрөгийг шинэчлэх, баяжуулах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сан хөмрөгийн аюулгүйн ажиллагааг хангах, стандартын дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах үндсэн үүрэг хүлээнэ.

3. Уншлага үйлчилгээний хэлтэс

Энэ хэлтэс нь хүүхэд залуучуудад ном хэвлэл болон хэвлэмэл бус материал бусад цахим нөөцөөр чөлөөт сонголттой, төрөлжсөн 6 уншлагын танхимаар шуурхай соёлтой үйлчлэх, соёлын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

4. Захиргаа аж ахуйн хэлтэс

Энэ хэлтэс нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангах, үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, байгууллагын ил тод байдлыг ханган ажиллах, төсөв хөрөнгийг төлөвлөн, захиран зарцуулах, тайлагнах, хянах, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмын дагуу явуулах үүрэг хүлээнэ.

❖ **Тайлан төлөвлөлт**

Хүүхдийн төв номын сан жил бүр МУ-ын Соёлын сайдын хянаж баталсан Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Хэлтсүүдийн төлөвлөгөө, Өмч хамгаалах байнгын комиссын төлөвлөгөө, Дотоод хяналт үнэлгээний төлөвлөгөө гаргаж ажилладаг.
Соёлын яаманд 7 хоногийн тайлан, сарын мэдээ, улирлын мэдээ, хагас жилийн тайлан, жилийн гүйцэтгэлийн тайлан, Татварын тайлан Нийгмийн даатгалын тайлан, Сангийн яам,ТӨХ-нд тайланг хагас бүтэн жилээр, Архивын ерөнхий газарт архивын мэдээг хагас болон бүтэн жилээр, СУ маягтын дагуу статистик мэдээллийг НСУГ-т улирал тутамд, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг СУГ-т жил бүр тус тус тайлагнадаг .

2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсүүд Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан 4 зорилтын хүрээнд 29 төрлийн ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
Төлөвлөгөөт ажлаа 100% биелүүлж, 15 нэр төрлийн 236, нэмэлтээр 21, нийт 257 ажил арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

ХОЁР. ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

❖ **Захиргаа хүний нөөц төлөвлөлт хэрэгжилт**

Хүүхдийн төв номын сан батлагдсан орон тоонд төрийн үйл ажиллагааг
тасралтгүй хэвийн хангаж, Хөдөлмөрийн хууль болон Соёлын тухай хууль, ХТНС-гийн Дотоод журам, бусад холбогдох баримт бичгүүдэд суурилан уншигч хэрэглэгчдэд

тасралтгүй үйлчлэх зорилгоор ээлжийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Зуны улиралд 1 ээлжээр, өвлийн улиралд 2 ээлжээр ажилладаг.

- ХТНС-гийн нийт ажилтан давхардсан ажил үүргийг хавсран гүйцэтгэдэг.

Давхардлыг арилгах талаар Соёлын яаманд үндэслэлээ тайлбарлаж, албан бичгээр хандсан. Тэдгээр ажилтанд хавсран гүйцэтгэсэн ажил үүргийн 20-40% ийн нэмэгдэл олгодог.

- Үүрэг даалгаврын журнал хөтөлж, дээд газрын бичгүүдийн хариу болон

албан даалгаврыг ээнжүүлэх, шуурхай болгох арга хэмжээг авч ажилласан.

- Хөдөлмөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн

- Хөдөлмөрийн дотоод журам
- Хөдөлмөрийн гэрээ
- Албан хэрэг хөтлөлтийн журам,
- Архивын үйл ажиллагааны нийтлэг журам
- Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам
- Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэх, мөрдөн ажиллах журам
- Архивт баримт хүлээн авах журам
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт
- Ном солилцооны гэрээ
- Гэрээр ном олгох журам

боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

- Тушаалын (боловсон хүчин, үйл ажиллагааны) бүртгэл, явуулсан бичгийн

бүртгэл, ирсэн захирамжлалын баримт бичгийн бүртгэлүүдийг гарган албан бичгүүдийг нөхөж бүртгэлд орууллаа.

❖ **Хүний нөөц төлөвлөлт бүрдүүлэлт**

- Сул орон тоог олон нийтэд зарлаж, Хөдөлмөрийн хууль болон Дотоод

журмыг баримтлан сонгон шалгаруулалт хийж авдаг. Эхний 3 сар туршилтаар ажиллуулж, мэргэжилтнүүдийг дагалдуулж сургадаг.

Захиргааны албан хаагчдад магистр болон магистраас дээш цолтой боловсон хүчнийг ажиллуулж байна.

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан

“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу нийт албан хаагчдын хувийн хэргийг бүрдүүлэн баяжилт болон шинэчлэлт, хөдөлгөөнийг тухай бүр Хүний нөөцийн программ дээр шилжилт хөдөлгөөний болон бусад
өөрчлөлтүүдийн мэдээллийг цаг хугацаанд нь оруулж байна. бүрэн хийж байна.

❖ **Сургалт**

Ажилтнуудаа мэргэшүүлэх чадавхжуулахад анхаарч, ажлын байран дахь хөгжүүлэх сургалтзохион байгуулсан.

- “Хос бичигтэн байгууллага” үндэсний бичгийн сургалтад нийт 28 албан хаагчийг хамруулсан.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн сэдэвт сургалтанд ажилтан албан хаагчид бүрэн хамрагдсан.

Соёлын боловсролын Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтанд 2, Library update 2022 номын санч, мэдээллийн ажилтны 9 дүгээр зөвлөгөөнд 5, Соёлын байгууллагуудын нэгдсэн портал сайт нэвтрүүлэх сургалтанд 1, СУИС-ийн номын сангийн бакалаврын сургалтанд 1, СУИС-ийн Соёлын менежерийн сургалтанд 1, Алсын хараа 2050 сургалтанд 1, Нийгмийн даатгалын шимтгэлийн талаарх сургалт 1, Нягтлан бодох бүртгэлийн сургалт 1, Солонгос улсад Хөгжмийн продюссерын сургалтанд 1 ажилтан тус тус хамрагдсан. Пүрэв гариг бүрийн Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтанд тогтмол хамрагддаг.

❖ **Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах**

- Хүүхдийн төв номын сангийн ажилтан албан хаагчид ТҮ болон ТҮСУ

ангилал зэрэглэлээр цалинждаг.

Захирлын А/34 дугаар тушаал гаргаж, Нийтийн тээвэр, 2022 оны 10 дугаар сарын 01-нээс ажилчдын өдрийн хоолны нэмэгдэл 8,000 (найман мянга) төгрөг болгон нэмэгдүүлсэн.

- 1 ажилтанд 1 сарын цалинтай чөлөө 499.600₮ ,1 хүнд нүүрсний тусламж 98.000 ₮, олгосон.
- Өмнө нь, гэрэлтүүлэг муутай, хүйтэн, дотроо цайны газар байхгүйгээс

танхим орхиж гарах эсвэл танхимд хоол үнэртүүлэх, ажилтнууд өвдөх, мэс засалд орох хүндрэлтэй асуудлууд их байсан. Одоо, дотроо буфет ажиллуулж, ажилчдад хямд хоолоор үйлчилж байна.

- Ажилтнууд,уншигчдын тав тухыг хангах зорилгоор Буфеттай болсон
- Ариун цэврийн өрөөний стандартыг сайжруулсан.

Орох үүдний хэсэгт болон Дорно дахины танхим, өлгүүр, каталогийн хэсэгт нэгдсэн халаагуур /пар/ суурилуулж дулааныг нэмэгдүүлсэн.

- Үнэмлэх нээлт буюу бүртгэлийн номын санчийг өрөөтэй болгосон.

- Үйлчилгээний стандартад нийцэхүйц үндэсний хийц загвар бүхий ажлын хувцсаар жигдэлсэн.

- Гадаах орчин нөхцөл бохир, гэрэлтүүлэггүй байсан. Хотын захиргаанд удаа дараа хандсаны үр дүнд аркыг гэрэлтэй болгосон.

Гадаа камержилт байхгүйгээс орчны бохирдол их байдаг. Дотор камержуулалтгүйгээс уншигчдын болон ажилтнуудын утас, эд зүйлс алдагдах тохиолдол гардаг.

- **Хэвлэл мэдээлэл, ил тод байдал**

- Хүүхдийн төв номын сан 2022 оны 3 дугаар сард шинээр пэйж хуудас нээн идэвхжүүлэлт хийж, өөрийн пэйжээр LIVE дамжуулалт хийж, уншигчдад мэдээлэл түгээж байна. 2022 онд цахим орчинд нийт 1300 контент, 859 видео байршуулж, 6500 үзэлттэй 802835 хүнд хүргэсэн. ХТНС-д хэвлэл мэдээлэлтэй ажиллах төсөв байдаггүй тул Гэрээт байгууллага байхгүй.
- 2022 оны 3 дугаар сард Автор сэтгүүлчдийг хамруулсан Сэтгүүлч нийгмийн эмч арга хэмжээг зохион байгуулж, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд хүчээ нэгтгэж хариуцлагатай хандахыг уриалж ажилласан.
- Ийгл ТВ, ТВ 5, МҮОНТВ, Монголын радио, Масс ТВ, ergelt.mn. ubmedee.mn, Зууны мэдээ, С1 ТВ зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилласан.

- **Жендерийн тэгш байдал**

- Хүүхдийн төв номын сан эрэгтэй 4, эмэгтэй 28 ажилтантай. Номын санч мэргэжлээр сурч төгсч байгаа боловсон хүчин 100% эмэгтэй байдаг тул харуул хамгаалалт, инженерээс бусад ажлын байранд эмэгтэйчүүд ажилладаг.
- ХТНС-гаас “Соёлын салбар дахь Жендерийн асуудал” илтгэлийн уралдаанд оролцож, жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалахад номын сангаас зохион байгуулж буй соёлын ажлуудыг чиглүүлэх талаар санал дэвшүүлсэн.

ГУРАВ. СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

- *Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4-т заасны хүрээнд шинэ Хүүхдийн төв номын сангийн үзэл баримтлалыг боловсруулж, барилгын зургийн төсөлтэй танилцаж, санал оруулсан. Энэ хүрээнд “Хүүхдийн төв номын сангийн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, МҮНС-гийн Мэргэжлийн зөвлөл, Соёлын яамны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлээд байна.*

- **Соёл гэгээрэл, бүх нийтийн боловсрол**

- 2022 онд гэр бүлд чиглэсэн, уншигчдад чиглэсэн, номын санчдад зориулсан 15 нэр төрлийн 236 соёлын ажлыг зохион байгуулсан. Үүнд:

Танилцах аялал 86, сургалт 14, үзэсгэлэн 38, хэлэлцүүлэг 3, уралдаан 2, тэмцээн 8, парад 1,уншлагын үдэш 2, тэмдэглэлт өдрүүд 6, Зохиолч уншигчийн уулзалт 6, Боролдойн цаг 5, уншлагын цаг 28, уралдаан 2, АХА 8, уншлагын үдэш 2, номын парад 1, жүжигчилсэн

тоглолт 12, шилдэг уншигч шалгаруулах уралдаан 1, тэгш ойтой зохиолчдын намтар уран бүтээлийн сурталчилгаа 6

- Нэмэлтээр, Эрдэм шинжилгээний хурал 2, шинэ номын нээлт 3, өдөрлөг 3, тэмдэглэлт өдөр 4
- LIVE шууд дамжуулалтыг 30 удаа тус тус зохион байгуулсан.

- ЕБС-ийн номын санчдад 10 сургалт зохион байгуулж, нийслэл орон нутгийн 354 номын санчид хамрагдсан.
- Мэргэжил аргазүйн зөвлөгөөг 70 удаа өгсөн.

- Гэр бүлд чиглэсэн “Эртэч гэр бүл хөтөлбөр” ийг хэрэгжүүлсэн.
- Үлгэрийн баатруудыг амилуулж, тэднээр дамжуулж, дасгал бүжиг заадаг.
- Уншигч хүүхдүүдэд
    - Цирктэй аялал
    - Соёлын өвийн сургалтууд /морин хуурын домог, хархираа исгэрээ
    - Монголын нууц товчоо сургалт
    - Сампин зангидах сургалт
    - Алунгоо эхийн алтан сургаал
    - Эв эе, нөхөрлөлийн тухай
    - Цаасан урлал сургалт
    - Хуулийн мэдлэгтэй болцгооё уншлага /тогтмол/

- Шударга найз сургалт
- 12 жилийн магтаал сургалт
- Өвөөгийн сургаал лекц
- Ном ба англи хэл сургалт
- Герман хэлний сургалт
- 2 хэлний уншлага

❖ **Соёлын бүтээлч үйлдвэрлэл**

- Соёлын өвийн үзэсгэлэнг шинээр дэглэсэн. Хүүхдийн зурсан зургууд, Төрийн бэлгэдэл, Чингис хаан, Алунгоо хатан, язгуур урлаг, нүүдэлчин Монгол, Эрийн 3 наадам, бөө мөргөл, монгол ахуй, монгол гэр, хүүхдийн зохиолчдын эд хэрэглэл гар бичмэл зэрэг сэдэв агуулгаар баяжуулсан

- Соёлын өвийн үзэсгэлэнгийн үзмэрээс...

- Хүүхэд багачуудад өв соёлоо таниулах зорилгоор Өв соёлын богцтой болохоор зорьсон. Нүүдэлчин монголчууд наадамд зориулж богцондоо 12 жилийн картыг шинээр бэлтгэж, хэвлүүлсэн. Картанд 12 жилийн амьтдын магтаал, цаг, зүг чигийн бэлгэдлийг багтаасан.
- Мөн 12 жилийн хавчуурга, эсгий хэрэглэгдэхүүн, босоо стэндийг бүтээсэн.Соёлын өвийн үзэсгэлэнд байршуулж, ЕБС-ийн сурагчдад 12 жилийн магтаал, цаг болон зүг чигийн бэлгэдлийн сургалт хийхэд ашиглаж байна.



- ХТНС-гийн танилцуулгыг шинээр эх бэлтгэж хэвлүүлсэн

- “Номтой нөхөрлөе” уншсан номын тэмдэглэлийн дэвтэртэй болсон. Д.Нацагдоржийн тэмдэг олгох, тэргүүний уншигчийг шалгаруулах суурь болно.

- Үлгэрийн баатруудын баг өмсгөлтэй болсон. Танилцах аялал, номын баяр болон бусад соёлын ажлуудад тогтмол ашиглаж байна.

- Шинээр мэдээллийн 2 хэсэгтэй болсон. Угтах хэсэгт буйдан, ТВ дэлгэц байрлуулж хүүхдийн эрхийн мэдээ мэдээлэл, хялбаршуулсан хуулийн заалтуудыг тогтмол сурталчилж байна.

- 2 дугаар давхарт Үндэсний мэдээллийн хэсгийг шинээр тохижуулж, үндэсний өнгө төрхийг бүрдүүлсэн. Энэ хэсгийг уншигч хүүхдүүд болон хүүхдийн зохиолчтой хийх ярилцлага, LIVE мэдээлэл дамжуулалт, хэвлэл мэдээллийн байгууллагад ярилцлага мэдээлэл өгөх зэргээр ашигладаг.

- Явуулын соёлын ажилд зориулан Хуруун хүүхэлдэйн жүжигт зөөврийн мини театртай боллоо.

- Яруу үдэш” эко булантай болсон. Яруу найргийн үдэш зохион байгуулах зорилгоор байгуулсан.
- Өөдлөх айл үүднээсээ. Угтах хэсгийг тохижуулсан.

Соёлын өвийг хамгаалах

- 550 ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэлбэн засварласан.
- Соёлын өвийн үзэсгэлэнг шинээр дэглэж, бүртгэлжүүлсэн.

❖ **Цахим бодлогын хэрэгжилт**

- Цахим гарын үсгийг нэвтрүүлж ажиллаж байна.
- LIVE төхөөрөмжтэй болж, контент хийдэг болсон.

- Пэйж хуудсыг шинээр нээж идэвхжүүлэн соёлын үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлсэн ажил үйлчилгээг олон нийтэд тогтмол мэдээлж байна. Нийт 1300 контент, 859 видео, 6500 үзэлт, 802835 хандалт авсан байна.
- Утсан сувагчлалыг халж, 50мгв хурдтай, WIFI утасгүй интернет нэвтрүүлж, төхөөрөмжүүдийг шинэчилсэн.
- Цахим каталогт цахим сан хөмрөгийн веб хувилбартай ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг 1,2 хувьд хүргэсэн.
- Бага ангийн хүүхдийн цахим үгийн санд 27507 нүүр хуудсыг сканердаж Соёлын яаманд хүргүүлсэн.
- Соёлын яамны хэрэгжүүлж буй GLAM систем нэвтрүүлэхээр бэлтгэл хангаж байна.
- Цахим сургалтанд тогтмол хамрагддаг.
- Шилэн дансны мэдээллийг тогтмол тайлагнаж байна.

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТАЛААР

❖ **Төсвийн төлөвлөлт:**

Ангилал	2022 онд батлагдсан төсвийн хуваарь 2021.12.09 № 1/2739	2022 оны Тодотгосон төсвийн хуваарь 2022,03,03 №1/497	2022 оны Тодотгосон төсвийн хуваарь 2022,05,06 №1/1209	2022 12 дугаар сарын хуваарь
НИЙТ	356,386,94	359,437.1	360,657.6	30,464.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,386,94	359,437.1	360,657.6	30,464.7
УРСГАЛ ЗАРДАЛ	356,386,94	359,437.1	360,657.6	30,464.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,804.6	359,109.1	360,329.6	30,464.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	160,933.5	168,156.5	176,935.1	14,912.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,798.3	21,019.6	22,117.0	1,864.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,225.0	106,081.4	100,190.9	9,782.5
Хангамж, бараа материалын зардал	6,577.5	5,527.8	5,276.7	168.1
Нормативт зардал				
Эд хогшил, урсгал засварын зардал				
Бусдаар гїйцэтгїїлсэн ажил, їйлчилгээний тєлбєр, хураамж	49,070.3	58,155.7	55,641.8	3,737.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,031.8	55,602.1	53,144.2	3,737.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	840.5	840.5	0.0
Даатгалын їйлчилгээ	104.0	87.4	87.4	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	114.5	96.2	96.2	0.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	20.0	16.8	16.8	0.0
Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,800.0	1,512.7	1,456.7	0.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200.0	168.1	168.1	0.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх				
Бараа їйлчилгээний бусад зардал				
УРСГАЛ ШИЛЖЇЇЛЭГ	328.0	328.0	328.0	0.0
Бусад урсгал шилжїїлэг				
Бусад Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал				
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328.0	328.0	328.0	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	365,132.6	359,437.1	360,657.6	30,464.7
Улсын төсвөөс санхүүжих	365,132.6	359,437.1	360,657.6	30,464.7
Улсын төсвөөс санхүүжих				
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
Төсвийн байгууллага	1	1	1	1
АЖИЛЛАГСДЫН ТОО	32	32	32	32
Удирдах ажилтан	1	1	1	1
Гүйцэтгэх ажилтан	24	24	24	24
Үйлчлэх ажилтан	7	7	7	7
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	32	32	32
Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	23	23	23	23
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	9	9

❖ Төсвийн зарцуулалт:

Д/д	Төсвийн байгууллага/ эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Хэмнэлт/ хэтрэлт	
		жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/		дүн	Тайлбар
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,386,94	312,256,20	356,386,94		
	УРСГАЛ ЗАРДАЛ	356,386,94	312,256,20	356,386,94		
1	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,12,45	299.235.21	351,12,45		
1.1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	176,935.1	176,935.1	176,935.1		
1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,117.0	22,117.0	22,117.0		
1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,190.9	100,190.9	100,190.9		
1.4	Хангамж, бараа материалын зардал	5,276.7	5,276.7	5,276.7		
1.5	Нормативт зардал					
1.6	Эд хогшил, урсгал засварын зардал					
1.7	Томилолт, зочны зардал					

1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,641.8	55,641.8	55,641.8		
1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	168.1	168.1	168.1		
	ТАТААС					
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328.0	328.0	328.0		
	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	328.0	328.0	328.0		
	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	328.0	328.0	328.0		
	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг					
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-	
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ					
	ИХ ЗАСВАР					
	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ					
	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ					
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	360,657.6	360,657.6	360,657.6		
	Улсын төсвөөс санхүүжих	360,657.6	360,657.6	360,657.6		

❖ **Худалдан авалт:**

2022 онд Улсын төсвөөр хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээ, тендер байхгүй. Үйл ажиллагааны зардалтай холбоотой бичиг хэрэг болон хангамжын материалыг шууд худалдан авалтаар гүйцэтгэж байна.

❖ **Шилэн дансны хэрэгжилт:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цаг тухай бүрд нь https://shilendans.gov.mn/ сайтад бүртгэж байна. Мөн Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас улирал бүр шалгалт хийгдэж, зөвлөмжийн дагуу энэ оны 3-р улирлын байдлаар 19 нэр төрлийн мэдээллийг 99 талбарт бүрэн мэдээлсэн.

❖ Хүүхдийн төв номын сангийн 2022 оны 01-09 сарын шилэн дансны мэдээллийг нягтлан шалгаж дутуу мэдээллүүдийг оруулж ажилласан. Үүнд:

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Захирлын тушаалуудыг PDF файл үүсгэн оруулсан.

АРХАНГАЙ АЙМГИЙН С.ЖАМЬЯНГАРАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго: Аймгийн нийт иргэдийг мэдээллээр хангах соёлын үнэт өв болох ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн төв бий болгох, мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэх, ном хэвлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.

1.2. Номын сангийн ерөнхий мэдээлэл: Аймгийн нийтийн номын сан 1945 онд, Хүүхдийн номын ордон 1987 онд байгуулагдсан. 648 м2 талбайтай хүүхдийн номын ордны шинэ барилга 2013 онд, 348 м2 талбайтай нийтийн номын сангийн шинэ барилга 2017 онд тус тус ашиглалтанд орсон. Орон тооны нийт 10 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан:

- Захирлын өрөө
- VIP өрөө
- Үндсэн фонд
- Тогтмол хэвлэлийн фонд
- Лавлагаа номзүйн фонд
- Нийтийн уншлагын танхим 1
- Нийтийн уншлагын танхим 2
- Зөөврийн номын санчийн өрөө
- Цайны өрөө
- Жижүүрийн өрөө

Хүүхдийн номын ордон:

- Хүүхдийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхимын фонд
- Гадаад номын фонд
- “Их мэдэх” танхим
- Монгол бичиг, Англи номын фонд
- Эко танхим
- Нягтлан бодогчийн өрөө
- Архивын өрөө

Цахим хаяг: “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудас
library_ar@yahoo.com_и - мэйл хаяг

Цагийн хуваарь: Даваа - Баасан гаригт 9:00 - 13:00, 14:00-18:00 цаг, /13:00 – 14:00 цайны цаг/

Байгуулагын утас: 70333248, 70332353

Номын сангийн захирал: О.Мөнхтуяа

ХОЁР. САН ХӨМРӨГ

2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал: Уншигчдын эрэлт хэрэгцээг үндэслэн татгалзлалын дэвтэр хөтөлж тухайн жилийн батлагдсан төсвөөс сан хөмрөгийн баяжилтаа хийж ирсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар 15,279,000 төгрөгийн 1625 ширхэг ном, 1,024,200 төгрөгийн 10 нэр төрлийн сонин сэтгүүл, 8,254,900 төгрөгийн 611 ширхэг, 79 нэр төрлийн хандивын номоор сан хөмрөгийн баяжилт хийллээ.

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт: Номын сангийн чухал зүйлийн нэг бол сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт байдаг. Иймучраас 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа урагдаж, гэмтсэн 1300 ширхэг номыг сэлбэн засаж уншлагад гаргахад бэлэн болгосон.

2. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт ном, хэвлэл болон тавиурын тоосыг арчиж цэвэрлэсэн.

3. Номын сангийн фондын өрөөнүүдийн дулаан, чийгшилд өдөр бүр хяналт тавьж ажилладаг.

4. Байгууллагын өрөө тасалгаануудад улирал бүр их цэвэрлэгээ, ариутгал хийлгэсэн.

5. Шинээр ирсэн 2236 номонд техник ажиллагаа хийж ШУ – ны салбараар тавиурт байрлууллаа.

6. 2022 онд улирал бүр 10 нэр төрлийн сонин, сэтгүүл захиалж уншигчдад хүргэсэн ба үдэж хавтаслан, хаягжуулж сонин сэтгүүлийн нэг бүрчилсэн бүртгэлд дансалж, тогтмол хэвлэлийн фондод шилжүүллээ.

7. Нийтийн уншлагийн танхимын фонд – 2 болон үндсэн сан хөмрөгийн бүх тавиурын хаяг ялгагчийг шинэчилсэн.

8. Хүүхдийн номын ордны 2500 номыг шинэчилсэн дансанд бүртгэсэн.

9. 2022 оны жилийн эцсийн байдлаар Архангайн үнэн, Архангайн толь сонины 1991 - 2021 оны дугааруудыг үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд оруулах бэлтгэл ажил хийгдсэн. Мөн 1959 - 1990 оны 2244 дугаарын 9104 нүүрийг нэгдсэн цахим сангийн программд оруулаад байна. Архангайн амьдрал сонины 2018 - 2020 оны 4 нэгж 25 дугаарын 210 нийтлэлийг түүвэрлэн оруулж, орон нутгийн картын санд баяжилт хийлээ.

10. Фондын номын санчийн ажлыг хүлээлцэх тооллогын хүрээнд орос, англи, монгол хэл, бичиг дээр хэвлэгдсэн 46000 гаруй ном, 1900 гаруй тогтмол хэвлэлийг нэг бүрчлэн тоолж, тооцоог бодож, дутсан болон урагдаж гэмтсэн номнуудыг номын санд нэн шаардлагатай шинэ номоор орлуулан төлүүлж данс бүртгэлд тусгалаа.

2.3. Каталог зохион байгуулалт: Үүлэн технологид суурилсан электрон каталогийн коха програмыг үйлчилгээндээ нэвтрүүлж байгаа бөгөөд хүүхдийн уншлагын танхимын фонд, нийтийн уншлагын танхимын фонд, тогтмол хэвлэлийн фонд, үндсэн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монгол хэл дээр хэвлэгдсэн нийт 16989 нэр төрлийн 57749 ширхэг номын мэдээллийг бүрэн шивж оруулсан ба ном бүрийн бар кодыг наасан. 2023 онд Орос болон англи хэл дээр хэвлэгдсэн номыг коха программд шивж оруулах ажлыг төлөвлөөд байна.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ.

2022 онд Нийтийн номын сан нь төрөлжсөн 12 танхимаар иргэд, уншигчдад үйлчилгээ үзүүллээ. Уншлагын танхимаар, гэрээр, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр нийт 2000 уншигч шинээр бүртгэж, давхардсан тоогоор 25000 ирэгсдэд 52797 ширхэг ном,

7203 ширхэг сонин, сэтгүүлээр үйлчилсэн.

3.1. Уншлага үйлчилгээ: Уншлага үйлчилгээг дараах байдлаар тус тус хүргэсэн байна.

1. Нийтийн уншлагын танхим: 327 уншигч шинээр бүртгэж, 9454 иргэсдэд 16973 ширхэг ном, 7203 ширхэг сонин, сэтгүүл танхимаар болон гэрээр олгосон.

2. Үндсэн фонд: 248 уншигч шинээр бүртгэж 4139 иргэсдэд 12800 ширхэг ном гэрээр олгосон.

3. Хүүхдийн уншлагын танхим: 1150 уншигч шинээр бүртгэж 11407 иргэсдэд 22000 ширхэг ном танхимаар болон гэрээр олгосон.

4. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: Уншигчдад номын сангийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг гэрээний дагуу аймгийн Ахмадын хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, “Булган” МСҮТ, АТГ, Онцгой байдлын газар, Прокурорын газар, Татварын хэлтэс зэрэг 10 байгууллагын 275 уншигч шинээр бүртгэж 1024 ном олгосон. Зөөврийн номын сангийн үйлчилгээний тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж Үндэсний номын санд тайлагнадаг.

3.2. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ: Эрдэнэбулган сумын 5 багийн 205 насанд хүрэгч, 121 хүүхэд, нийт 326 иргэд, уншигчдад 2000 орчим номоор нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

3.3. “Их мэдэх” танхим: “Их мэдэх” танхим 2022 оны жилийн эцсийн байдлаар цэцэрлэгийн 3 - 5 насны 325 хүүхэд, 3 – р ангийн 320 сурагч, эцэг эхчүүдэд үйлчилж нийт 850 орчим ном олгосон. Мөн хүүхдийн номын ордон, нийтийн номын сангаар аялуулж үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.

3.4. “Эко” уншлагын танхим: Уншигчдад байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалах сэдэл төрүүлэх зорилгоор “Эко” танхимыг ажиллуулдаг. 2022 оны байдлаар 745 иргэд, уншигч үйлчлүүлсэн. Мөн “Миний Архангай” сэдвийн хүрээнд хийсэн сурагч, эцэг эхчүүдийн бүтээлээр уг танхимд үзэсгэлэн гаргалаа.

3.5. Ангийн уншлага: Эрдэнэбулган сумын I, II, III, IV сургуулийн бага, дунд бүлгүүд ангийн уншлага тогтмол хийдэг. 2022 онд давхардсан тоогоор 1472 ирэгсдэд 5708 номоор үйлчилгээ үзүүлж үлгэр, өгүүллэг уншиж өгч, ном унших ач тусын талаар мэдээлэл хийсэн.

3.6. “Боролдой” үлгэрийн цаг: “Боролдой” үлгэрийн цаг үйлчилгээг хүүхдийн уншлагын танхимаар үйлчлүүлсэн уншигчдад зориулж их мэдэх танхимд явуулдаг. 2022 онд 18 удаа үлгэрийн цаг үйлчилгээг цэцэрлэгийн насны 589 хүүхэд багачуудад хүргэсэн байна.

3.7. Номын үзэсгэлэн: Нийтийн номын сан нь 2022 онд 39 удаа шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг зохион байгуулж иргэд уншигчдад ШУ – ны салбарын 2775 номыг сурталчлан таниуллаа.

3.8. Лавлагаа, мэдээлэл: "Хүмүүн бичиг", Архангайн амьдрал, Монголын үнэн, Зууны мэдээ, Архангай үнэн, Өдрийн сонин, Төрийн мэдээлэл, Боловсрол судлал, Архангайн боловсрол, Утга зохиол урлаг, Өнөөдөр сонин, Улирал ба зохиолч, Бөх сонин зэрэг тогтмол хэвлэлээс 156 уншигч 187 лавлагаа, мэдээлэл авлаа.

3.9. Цахим үйлчилгээ: "Архангай – Нийтийн номын сан" пэйж хуудсанд 165 уншигч хандаж и-мэйл хаяг, фэйсбүүкээр дамжуулан ном, тогтмол хэвлэлийн бүтээгдэхүүнээс шүүлгэж лавлагаа мэдээлэл авлаа.

3.10. Мэргэжил, арга зүйн ажил: Их тамир, Чулуут, Өлзийт, Хашаат, Өгий – нуур, Батцэнгэл сумдын Соёлын төвийн номын санчдад 8 удаа цахимаар болон утсаар мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн. Сумын Соёлын төвүүдийн номын санчдын группээр мэдээлэл солилцож хамтран ажилладаг.

ДӨРӨВ. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

4.1. "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр" - ийг тохиолдуулан 2022 оны 3 дугаар сарын 8 – нд аймгийн Нийтийн номын сан, "Архангайн толь" сонины редакци, "Тамир" телевиз хамтран "Ээждээ захидал бичээрэй" уралдааныг 18 дахь жилдээ зохион байгууллаа. Ээжийгээ хайрлах үрс бүхний чин сэтгэлийн халуун дулаан үгсийг захидлаар дамжуулан хүргэх, хүүхэд залуусын дунд захидлын соёлыг түгээн дэлгэрүүлэх, эх хэлний

найруулга зүйн чадварыг дээшлүүлэх зорилгын хүрээнд энэ жил сурагч, насанд хүрэгч гэсэн 2 ангиллаар цахим болон танхимаар зохион байгууллаа. Ангилал тус бүрээс шагналт 4 байр, онцлох нэг захидал шалгаруулсан. Эрдэнэбулган, Чулуут, Эрдэнэмандал, Тариат, Өлзийт, Өгийнуур зэрэг сумдаас нийт 132 оролцогч оролцож, нийт 230 гаруй иргэд, уншигчид хамрагдлаа. Уралдааны шагналын санг "Дэлхийн соён, гэрэл, гэгээ дэлгэрүүлэх дэлхий холбоо" - ны тэргүүн П.Төмөрцэцэг ивээн тэтгэсэн ба шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг шууд лайв хийж шалгарсан захидлуудыг уншуулж олон нийтэд хүргэв.

4.2. Монгол улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 101 жилийн ой, "Монгол цэргийн өдөр" - ийг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сан, "Тамир" телевиз хамтран 2022 оны 3 сарын 18 – нд "Аавдаа захидал бичээрэй" уралдааныг насанд хүрэгч, сурагч гэсэн хоёр ангиллаар зохион байгууллаа. Уралдааны шагналын санг спорт хувцас үйлдвэрлэлийн "АР ДИ БИ ТИ ЭРДЭНЭ" ХХК ивээн тэтгэж хамтран оролцлоо. Захидлын уралдаанд Эрдэнэбулган, Хайрхан, Хангай, Чулуут, Цэнхэр, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Булган, Тариат, Өлзийт, Өгийнуур зэрэг сумдаас нийт 153 оролцогч оролцож. 300 орчим иргэд, уншигч хамрагдсан.

4.3. МУ - ын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу Архангай аймагт "Үндэсний бичиг үсгийн баяр - 2022" арга хэмжээг 2022 оны 5 сарын 7 - нд зохион байгууллаа. "Түргэн уншлага", "Зөв сайхан бичигтэн" уралдааныг дунд, ахлах анги, насанд хүрэгч гэсэн насны 3 ангиллаар, "Уран бичлэг" - ийн уралдааныг сурагч, насанд хүрэгч гэсэн 2 ангиллаар танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд 280 оролцогч оролцож, 600 орчим уншигч хамрагдлаа.

4.4. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”: Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх өдрүүдийн тухай хуульд жил бүрийн 5, 9 сарын 3 дах долоо хоногийн амралтын өдрөөр “Үндэсний бичиг соёл, номын өдөр” – ийг тэмдэглэн өнгөрүүлэхээр баталсан билээ. Нийтийн номын сан нь уг арга хэмжээг 2022 оны 5 дугаар сарын 19 – 22 – ны өдрүүдэд “Илүү их уншъя” уриан дор 31 дэх жилдээ тэмдэглэн өнгөрүүлсэн ба 2838 орчим иргэд, уншигч оролцсон байна. Уг арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Г.Дэмид жанжны талбайд 2022 оны 5 сарын 21 – нд “Үндэсний бичиг соёл номын өдрүүд - 2022” арга хэмжээний нээлт, “Зохиолч уншигчдын уулзалт”, “Хан тамирын ай” номын нээлт, “Номтой гудамж” өртөө, Номын үзэсгэлэн, Номын худалдаа, “Маск парад” - ын уралдааныг зохион байгууллаа.

-Улаанбаатар хотоос ирсэн 12 зохиолч, яруу найрагч аймгийн иргэдтэй уулзаж “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгууллаа.

- Аймгийн албан байгууллагуудын дунд “Маск парад” дүр хувиргалтын уралдааныг зохион байгуулж 9 байгууллагын 108 албан хаагч оролцож 800 гаруй хүүхэд багачууд, иргэд үзэж сонирхлоо.

- Нийтийн номын сан, гэр гандан, ЕБС – иудын номын сангаас сурагчдын гар урлал, монгол бичиг, уран зураг, үзүүлэн бүхий бүтээлүүдээр Номтой гудамж өртөөг зохион байгуулж байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчиллаа.
- Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн зохион байгуулж номын худалдаа гаргасан.

- Нээлтийн үеэр номын сангийн байнгын идэвхтэн уншигч 7 сурагчийг Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэг, үнэмлэхээр шагналаа.

- Архангай аймгаас гаралтай сүүлийн 400 жилд төрсөн 370 гаруй зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг нэгтгэсэн “Хан тамирын ай” шинэхэн номын нээлт болж номыг бүтээхэд туслалцаа үзүүлсэн хүмүүст талархал гардууллаа.

- 2022 оны 5 сарын 22 – нд Архангай аймгийн харъяат МУ соёлын гавъяат зүтгэлтэн, сэтгүүлч, яруу найрагч Гочоогийн Жамцын “Бүтээлийн дээжис” 8 боть номын нээлтийг зохион байгууллаа. 8 боть номын нээлтийн үйл ажиллагаанд УБ хотоос уригдан ирсэн зохиолч яруу найрагчид өөрсдийн яруу найргаас хүргэж, ХДТ – ын хамт олон уран бүтээлээрээ мэндчилж хүндэтгэл үзүүллээ. Мөн Г.Жамцын фото зургууд, гар бичмэл, шагнал урамшуулал, баярын бичиг, диплом, бүтээл, ном зэргээр үзэсгэлэнг гаргаж ирсэн зочид төлөөлөгчдөд танилцуулсан.

- “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтын уралдааныг аймгийн хүүхдийн цэцэрлэгийн ахлах бүлгийн сурагчдын дунд 2022 оны 5 сарын 20 – нд зохион байгууллаа.

Нийт 11 цэцэрлэг баг бүрдүүлэн 110 оролцогч оролцож шагналт 3 байр шалгаруулсан ба 500 орчим багш сурагч, эцэг эхчүүд хамрагдсан.

- Аймгийн ЕБС – ийн 1 – 5 – р ангийн сурагчдын дунд “Уран уншлагын уралдаан” – ыг 2022 оны 5 сарын 19 - нд зохион байгуулав. 215 оролцогч өөрсдийн сонгосон шүлэг, өгүүллэгийг уншиж өрсөлдсөн ба шагналт 3 байр шалгаруулла. Нийт 389 иргэд үзэж сонирхсон.

- 2022 оны 5 сарын 19 – нд ЕБС – ийн 6 – 9 – р ангийн сурагчдын дунд захидалын уралдааныг зохион байгуулж, 45 захидал ирснээс шагналт 3 байр шалгаруууллаа. Сурагчид хамгийн унших дуртай номоо сонгож ном, гол баатар, зохиолч эсвэл хэн нэгэн дүрд зориулж захидал илгээжээ.

- Хүүхдийн зохиолч, яруу найрагч Цэрэнжавын Уламбаярын мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан түүний зохиол бүтээлээс сонгон дүрийн тоглолт бэлтгэн тавих уралдааныг ЕБС - ийн 10 – 12 – р ангийн сурагчдын дунд 5 сарын 19 – нд зохион байгуулсан бөгөөд 150 оролцогч хамрагдаж шагналт 1 байр, онцлох 1 байр тус тус шалгаруууллаа.

4.5. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу 6 сарын 1 - нд Г.Дэмид жанжны талбайд “Ээжтэйгээ хамт уншъя” арга хэмжээг зохион байгуулсан ба танин мэдэхүйн АХА тэмцээн, Гэр өрөг, Баян Монгол наадгай, Монгол ардын аман тоглоомын нэг Зүйр цэцэн үгийг хэн сайн мэдэх вэ уралдаануудыг явууллаа. Мөн ятга хөгжмийн хамтлаг мэндчилгээ дэвшүүлж 194 хүүхэд оролцлоо.

4.6. МУИС - ийн номын сангаас Монголын нийт номын санчдын дунд зарласан “Монголын нууц товчоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдааны 1 -р шатны шалгаруулалтыг Нийтийн номын сангаас ЕБС – ийн болон 18 сумын соёлын төвийн номын санчдын дунд зохион байгуулсан бөгөөд нийт 16 эссэ ирснээс 1 - р шатны шалгаруулалтанд Лаборатори 1 - р сургуулийн номын санч Мөнхтуяагийн эссэ шалгарч 2 - р шатны шалгаруулалтад МУИС – ийн номын санд хүргүүллээ.

4.7. Соёлын ажилтны баярын өдрийг тохиолдуулан Зая цогцолборт “Цэцэрлэг сити” уриатай соёлын орон зай бүрдүүлж номын сангийн үйл ажиллагааг сурталчлан танилцуулж уншигчдын дунд “Хамтдаа уншъя”, “Хамтдаа бичье” уралдаануудыг зохион байгуулж 124 иргэд, уншигч оролцсон байна. Байгууллагын асраар зочилж сэдэвчилсэн номын үзэсгэлэн, уран бичлэгийн үзүүлбэр, байгууллагын үйл ажиллагаа, уралдаан тэмцээн зэргийг 300 гаруй иргэд, уншигч үзэж сонирхлоо.

4.8. “Үндэсний бичиг үсгийн баяр – 2022” /намрын номын баяр/

“Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх өдрүүдийн тухай хууль”- ийн 5.1.17 дугаар зүйлд жил бүрийн 5, 9 дүгээр сарын 3 дах долоо хоногийн амралтын өдрүүдэд “Үндэсний бичиг соёл, номын өдөр” – ийг тэмдэглэн өнгөрүүлэхээр баталсан. Нийтийн номын сан нь уг арга хэмжээг 2022 оны 9 дугаар сарын 16 – 19 – ний өдрүүдэд “Илүү их уншъя” уриан дор 31 дэх жилдээ тэмдэглэн өнгөрүүлсэн ба 2540 иргэд, уншигч оролцсон байна. Уг арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд – 2022” арга хэмжээний нээлт, “Зохиолч уншигчдын уулзалт”, “Номтой гудамж” өртөө, номын сэдэвчилсэн үзэсгэлэн, номын худалдаа, “Номын сайн нөхөр шалгаруулах” уралдаан, “Хэрвээ би зохиолч байсан бол...” эх зохиох уралдаан, “Уншсан номын тухай” эргэцүүлэл, “Эрдмийн хөтөч” багш нарын

дундах тэмцээн, “Сургааль шиг амьдралгүй яахав” номын нээлт зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

-“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд – 2022” арга хэмжээний нээлт 2022 оны 9 сарын 16 – нд ГБХЗХГ – т болж нээлтийн үеэр аймгийн төвийн ЕБС – ийн сурагчдаас тэргүүний уншигч шалгаруулах журмыг хангасан 7 идэвхтэн уншигчийг шалгаруулж “Тэргүүний уншигч Д.Нацагдорж” тэмдэг, үнэмлэхээр шагналаа.

- МУ – ын гавъяат багш, хөгжмийн зохиолч С.Батболд, Хүүхдийн зохиолч П.Наранбаатар нар 2022 оны 9 сарын 16 – нд хүрэлцэн ирж илтгэл, лекц тавьж уран бүтээлээ хүргэж “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгууллаа. Тус арга хэмжээнд аймгийн СӨБ, ЕБС, Соёлын төвүүдийн дуу хөгжмийн багш, бүлгийн болон туслах 50 багш, 120 хүүхэд оролцлоо.

- Номын баярын нээлтийн үеэр 10 байгууллага номтой гудамж өртөө зохион байгуулж иргэд, уншигчдын дунд оюуныг сорьсон тоглоом, уралдаан явуулж, байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилсан. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор 1000 орчим уншигч, иргэд хамрагдлаа.

- Номын баярын арга хэмжээний нээлтийн үеэр Нийтийн номын сангийн сан хөмрөгт хадгалагддаг Уйгаржин Монгол бичиг дээрх 35 номоор уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх зорилгоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргалаа.

- “Хэрвээ би зохиолч байсан бол...” эх зохиох уралдааныг 9 сарын 18 – нд аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 6 – 9 – р ангийн сурагчдын дунд зохион байгуулж 45 материал ирснээс шагналт 3 байр шалгаруууллаа.
- “Уншсан номын тухай” эргэцүүлэл видео бичлэгийн уралдааныг 9 сарын 18 – нд ЕБС - ийн 10 – 12 – р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Сурагчид өөрсдийн сонгосон ном, зохиолын талаар төрсөн сэтгэгдэл, эргэцүүлэл бүхий видео бэлтгэн ирүүлсэн. Нийт 10 гаруй бичлэг ирснээс шагналт 1 байрыг шалгаруууллаа.
- “Эрдмийн хөтөч” тэмцээнийг аймгийн нийт багш нарын дунд зохион байгууллаа. 9 сургуулийн багш нар баг бүрдүүлж оролцож Миний Архангай, Танин мэдэхүй, Ёс заншил, Үндэсний бичиг, Монголын нууц товчоо гэсэн 5 үеийн 25 асуултанд хариулж эрдэм мэдлэгээ сорьлоо. Тал бүрийн мэдлэгийг шаардсан, туршлага солилцсон оюунлаг тэмцээн гэдгээрээ онцлогтой ба 45 багш хамрагдаж шагналт 3 байр шалгаруулсан.

- Чөлөөт уран бүтээлч, яруу найрагч Д.Түвшинцэцэгийн “Сургааль шиг амьдралгүй яахав” шүлгийн түүвэр шинэ номын нээлтийг зохион байгууллаа. 70 иргэд, уншигч оролцсон.

- “Үндэсний бичиг, соёл номын өдрүүд – 2022” арга хэмжээний үеэр Монголын нууц товчоог бүрэн эхээр нь үндэсний бичгээр бичсэн сурагчийн бүтээл, Монголын уран зохиолын гурван оргилын нэг болох “Гэсэр” туужийг кирилээс монгол бичигт хөрвүүлэн торгон дээр бичсэн багш, сурагчийн бүтээл, уран бичлэг зэргээр үзэсгэлэн гаргасан байна.

4.9. Соёлын яамнаас Номын сайн нөхөр шалгаруулах уралдааныг зохион байгуулсан ба журмын дагуу нийтийн номын сан нь 2022 оны 9 сарын 10 – ны дотор аймагтаа шалгаруулалт зохион байгуулж Шилдэг уншигч - Насанд хүрэгчээр Ахмад уншигч Н.Данинов, Лаборатори 1 – р сургуулийн МХУЗ – ын багш Ц.Цэрэнбалжид, Шилдэг уншигч – сурагчаар Лаборатори 1 – р сургуулийн 10а ангийн сурагч Б. Батцэцэг, Шилдэг номоор Эрдэнэбулган сумын 5 – р сургуулийн МХУЗ – ын багш Д.Долгорсүрэнгийн “Монгол бичгийн сорилго – 2”, 5 – р сургуулийн МХУЗ – ын багш О.Баасангийн “Үндэсний бичгийн онол дадлагын дэвтэр” зэргийг шалгаруулж Соёлын яам руу журмын дагуу материал бүрдүүлэн хүргүүллээ..

Мөн номын баярын хүрээнд шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, номын худалдаа зохион байгуулсан.

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд – 2022" арга хэмжээний хаалт, шагнал гардуулах арга хэмжээ 2022 оны 9 сарын 19 – нд номын сангийн байранд зохион байгуулагдлаа.

Соёлын олон талт шинэ арга хэмжээнүүдийг санаачлан зохион байгуулж өргөн хүрээг хамарсан бөгөөд үүнээс "Номтой гудамж" өртөө, "Эрдмийн хөтөч" багш нарын дундах тэмцээн нь уншигч, оролцогчдын сонирхлыг татсан онцлог арга хэмжээ боллоо.

4.10. Соёлын яамнаас 11 дүгээр сарыг жил бүр "Соёлын бүтээлч сар" – ын аян болгон зарладаг. Иймээс энэ аяны хүрээнд 4 чиглэлээр 6 СОНА зохион байгуулж 1367 иргэд, уншигч оролцсон байна.

Нийтийн номын сангаас "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

4.11. I долоо хоног " Үндэсний нэгдмэл үнэт зүйл" чиглэлийн хүрээнд "Book challenge" номын хандивын аяныг өрнүүлж 29 уншигч оролцож 120 орчим ном цугларсан.

4.12. Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн шагналт сурагчдын ном уншихыг уриалсан уриалга бичлэгийг пэйж хуудсаараа дамжуулан 2441 хүнд хүргэж 9 сурагч оролцлоо.

4.13. II долоо хоног "Бүх нийтийн соёлын боловсрол" чиглэлийн хүрээнд 2022.11.11 – нд "Монголчуудын угийн бичгийн академи" - тай хамтран "УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЦГӨӨЕ" I шатны сургалтыг зохион байгууллаа. 19 байгууллагын 70 гаруй албан хаагч хамрагдаж батламж гардан авлаа. Сургалтыг зохион байгуулахад аймгийн ЗДТГ, Соёл урлагийн газар, Насан туршийн боловсролын төв, ГБХЗХГ дэмжлэг үзүүлж Монголчуудын угийн бичгийн академийн ерөнхийлөгч, доктор Ш.Бэндэръяа, Монголчуудын угийн бичгийн академийн тэргүүлэх гишүүн, ардын судлаач, билэг зүйч, соёлын гавъяат зүтгэлтэн С.Дамбий нар хөтөлбөрийн дагуу удирдан явууллаа.

Сургалтын үеэр өөрсдийн хөтөлсөн угийн бичгээ танилцуулсан 2 иргэнийг шагнаж урамшууллаа. Хамрагдсан нийт албан хаагчид угийн зураглалаа гаргасан ба угийн бичиг хэрхэн хөтлөх, угийн бичиг хөтлөхийн үр дүн, ашиг тус, угийн бичиг хөтлөөгүйгээс үүдэн гарах хор уршиг, ургийн баяр хэрхэн хийх, ураг удам, овог нэрийн учир зэрэг олон хэрэгцээт мэдээллээр хангагдлаа.

4.14. III долоо хоног “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” чиглэлийн хүрээнд аймгийн ХБИ – ийн дунд “Хамтдаа уншъя” арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 34 иргэн хамрагдаж өөрсдийн хийсэн гар урлалаараа үзэсгэлэн гаргаж, танин мэдэхүйн АХА тэмцээнд оролцож мэдлэг оюунаа сорьсон. АХА тэмцээн шагналт 3 байртай ба азтан шалгаруулж, урлагийн тоглолт үзүүлж, нээлттэй микрофон аялуулж, дуулж баясан нэгэн өдрийг хамт өнгөрүүллээ. Шинэ болон Монголын түүхийн номоор номын үзэсгэлэн гаргалаа.

4.15. IV долоо хоног “Соёлын аялал жуулчлал” чиглэлийн хүрээнд амгийн МСҮТ – тэй хамтран суралцагчдын дунд “Номын ертөнц – гайхамшиг” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж шагналт 2 байр шалгаруууллаа. Тэмцээнд 5 оюутаны бүрэлдэхүүнтэй 5 баг оролцож миний Архангай, үндэсний бичиг соёл, танин мэдэхүй, ёс заншил, Монголын нууц товчоо гэсэн 5 үеийн 25 асуултад хариулж оюун мэдлэгээ сорин өрсөлдлөө. Номын сангийн үйл ажиллагааг сурталчлан танилцуулж, байнгын уншигч 2 оюутанд номон бэлэг гардуулсан бөгөөд нийт 100 орчим оюутан хамрагдсан.

4.16. Соёлын бүтээлч сар аяны IV долоо хоног Соёлын аялал жуулчлал чиглэлийн хүрээнд ЭБ – сумын 1 – р сургуулийн 3 – р ангийн 5 бүлгийн багш, сурагч, эцэг эхчүүдийн дунд “ОЮУНЛАГ ГЭР БҮЛ” арга хэмжээг зохион байгууллаа. Энэ арга хэмжээний хүрээнд сурагчид эцэг эхийн хамт 2 удаа номын сангаар үйлчлүүлж Архангай аймгийн зохиолчдын бүтээл болох Миний Архангай номноос уншиж, номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, музейгээр аяллаа. Уншлагын хугацаанд сурагч, эцэг эхчүүд Монгол үндэсний дээлтэй уншлага хийж, номын агуулгын хүрээнд гэр бүлээрээ бүтээл хийсэн. Давхардсан тоогоор 1200 иргэд уншигч оролцлоо. Миний Архангай танин мэдэхүйн номыг сурталчлан таниулж хүүхэд багачууд, эцэг эхчүүдэд нутаг орны түүх, түүхэн газар нутаг, түүхэн хүмүүсийн талаар мэдээлэл хүргэж, АХА тэмцээнийг сурагч, насанд хүрэгч гэсэн 2 төрлөөр явууллаа. Оюунлаг гэр бүл арга хэмжээний нээлтийн үеэр сурагч, эцэг эхчүүдийн хийсэн бүтээлийн үзэсгэлэн, 5 ангийн урлагийн мэндчилгээр хүргэлээ.

Миний Архангай сэдэвт бүтээлийн төрөлд шагналт 4 байр, АХА тэмцээнд 3 байр, 1 идэвхтэн анги хамт олон шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагнал, номон бэлэг гардуулсан. Оюунлаг гэр бүл арга хэмжээний шагналын санг ивээн тэтгэж, номын сангийн үйл ажиллагааг дэмжин ажилласан Ар Арвис компаний захиралд талархал, дурсгалын зүйл гардууллаа.

4.17. Нийтийн номын сангаас санаачлан “Номын цаг нэвтрүүлэг” - ийг Тамир телевизтэй хамтран зохион байгуулдаг ба 2022 онд 2 дугаар хийж үзэгчдэд хүргэлээ.

ТАВ. ТЕХНОЛОГИ

5.1. Электрон каталоги: Үүлэн технологид суурилсан коха програмд 16989 нэр төрлийн 57749 ширхэг номын мэдээллийг оруулсан нь нийт сан хөмрөгийн 90% болно.

5.2. Цахим мэдээлэл:

“Архангай - Нийтийн номын сан” пэйж хуудсанд үндсэн үйл ажиллагаа, СОНА – ын талаарх мэдээллийг тогтмол байршуулдаг. 2022 онд 147 удаагийн давтамжтай мэдээлэл байршуулж цахим орчинд давхардсан тоогоор 200,000 гаруй хүнд хүргэсэн байна. Мөн “Номын сангийн тухай хууль”, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга зэргийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор хоолойн бичлэг, шторк, мэдээлэл, лайв, видео бичлэг бэлтгэн цахим орчинд нийтэлж, уншигчдад сурталчлан танилцуулж, мэдээлэл хүргэлээ.

“Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудасны сүүлийн 7 хоногийн хандалт.

5.3. Байгууллагын аюулгүй байдал:

24 цагийн харуул хамгаалалт, галын дохиолол, гадна ба дотор хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч бүхий дохиолол, гадна талбайн гэрэлтүүлэг зэргийг хийж аюулгүй байдлыг хангасан.

Нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимд соронзон долгионоор мэдрэгч дохиолол бүхий хамгаалалтын төхөөрөмж байрлуулж чөлөөт сонголтоор ном олгодог ба алдагдахаас сэргийлдэг.

ЗУРГАА. ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ:

2022 онд орон нутгийн төсвөөс 85.553.2 мянган төгрөг, улсын төсвөөс 193.066.9 мянган төгрөгөөр тус тус тайлант хугацаанд батлагдсан төсвийн дагуу бүрэн санхүүжиж өр авлагагүй ажилласан.

ДОЛОО. СУРГАЛТ, СЕМИНАР

- 2022.02.23 - АТГ - аас зохион байгуулсан цахим сургалт
- 2022.02.24 - Аймгийн ЗДТГ, Соёл урлагийн газараас хамтран зохион байгуулсан “Соёлын салбарын удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөн”
- 2022.03.03, 04 – нд МУ - ын Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Сан хөмрөгийн тухай ойлголт”, “Цахим сан хөмрөг бүрдүүлэх бодлого” сэдэвт 9 цагийн сургалт
- 2022.03.24 Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь” 2 цагийн сургалт, мөн СУИС - ийн багш Т.Хайдавын зохион байгуулсан мэргэжлийн сургалт
- ГБХЗХГ - аас зохион байгуулсан “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад олон талт хамтын ажиллагаа” зөвлөгөөн
- “Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн чуулган”
- Аймгийн Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Төрийн албаны ёс зүй”, “Олон нийтийн санхүүгийн боловсрол” сэдэвт сургалт
- 2022.07.28 – 29 Үндэсний номын сан, Австралийн элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан “Номын санчдын туршлага солилцох сургалт”

- 2022.10.07 философич С.Молорэрдэнийн номын танилцуулга, уулзалт

➢ 2022.09.13 “Төрийн албан хаагчдын шударга зарчимч байдал ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага” сургалт

НАЙМ. БУСАД АЖИЛ:

1. Өдөр бүр хлораминтай усаар чийгтэй цэвэрлэгээ хийж, ажлын байрны ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин ажиллаж байна.

2. Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэж, ажилтан, албан хаагч, уншигчдад тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлж ажиллаж байна.

3. Улирал бүр хүүхдийн номын ордон, нийтийн номын санд их цэвэрлэгээ хийдэг.

4. 2022.03.24 - ний 16:00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээлэх дуут дохио дуугарч Нийтийн номын сан, Хүүхдийн номын ордонд үйлчилгээ авч байсан 32 уншигч, 8 ажилтныг эхний дуут дохиогоор “Нуугд – Суу - Хүлээ” зарчмын дагуу тухайн өрөө, тасалгаанд аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалах арга хэмжээг авахуулж, ширээн доогуур орох, даацын хана дагах, булан тохойд зогсоох зэрэг арга хэмжээ авсан. Хоёр дахь дохио дуугарсны дараа барилга, объектыг орхин гарахдаа гарын доорх эд зүйл ашиглан толгойгоо хамгаалж Нийтийн номын сангийн урд талбайд гарсан. Энэ үеэр уншигч, ажилтан, албан хаагчдад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний талаар зааварчилгаа өгсөн.

5. 2022.05.20 - ны өдөр Соёл урлагийн салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан спортын арга хэмжээнд хамт олноороо хамрагдаж дардасны төрөлд 3 - р байр эзэлсэн.

6. 2022.04.27 Аймгийн СУГ – ын хамт олон номын сангийн үйл ажиллагаатай танилцаж цаашид хамтран ажиллах тухай санал солилцлоо.

7. Бүх нийтийн их цэвэрлэгээг хамт олноороо хийж гүйцэтгэлээ.

8. Соёл урлагийн ажилтны баярын өдрийг тохиолдуулан "Цэцэрлэг сити" соёлын орон зай арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Заяа цогцолборын урд талбайг цэвэрлэлээ.

9. 2022.10.08 - буюй Үндэсний мод тарих өдрийн хүрээнд байгууллагын хайс болон "Минжүүр баатар" - ын талбайд гүйлс мод тарьлаа.

10. УБ хотод зохион байгуулагдсан “Монголын номын санчдын спортын 13 – р их наадам”-д 2022 оны 10 дугаар сарын 28 – 30 – нд хамт олноороо оролцсон.

11. Аймгийн ИТХ – ын нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо 2022.11.22 – нд хуралдлаа. Энэ үеэр номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилтийн талаар танилцуулга хийлээ.

12. Монгол бахархалын өдрийг тохиолдуулан их эзэн Чингис хааны эш хөргийг байгууллагадаа хүндэтгэн заллаа.

13. “Хаан бичиг” номын дэлгүүрээс сар шинийн баярыг тохиолдуулан 21 аймгийн насанд хүрэгчдийн дунд зохион байгуулсан монгол бичгийн уралдаанд 3 ажилтан цахимаар оролцож, номын санч Г.Минжинсор 1 - р байранд шалгарсан.

---oOo---

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН Б. АХТАНЫ НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. ЭРХЭМ ЗОРИЛГО:

Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй төв ”** болох.

1.2. НОМЫН САНГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Тус номын сан 1949 онд байгуулагдсан. 2014 онд шинэ байранд орж, нэг ээлжинд 180 хүнийг хүлээн авч ном уншуулах чадвартай 5 уншлагын танхимтай. Насанд хүрэгчдийн танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын 1-р танхим /1-3 анги, бяцхан уншигчдын/, Хүүхдийн уншлагын 2-р танхим /4-7 анги/, болон оройн номын сангийн танхимтай. Танхимууд бүгд чөлөөт сонголттой. Нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03-р сарын 09-ний өдрийн 37 тоот тогтоолоор аймгийн нийтийн номын санг зохиолч, яруу найрагч Б.Ахтаны нэрэмжит болгов. Өлгий сумын бүх ЕБС-ийн болон Цэцэрлэгүүдийн захиралуудаар гэрээ байгуулж, 5 хоногийн график гарган, сурагчид болон хүүхэд багачуудыг номын санд бүрэн хамруулж байна.

Цахим хаяг: Б.Ахтаны нэрэмжит Баян-Өлгий аймгийн төв номын сан
Өвлийн цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт, Өглөө 8:00-12:00, үдээс хойш 13:00-17:00 цаг, орой 17:00-21:00
Зуны цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт, Өглөө 9:00-12:00, Орой 13:00-18:00 цаг
Бямба гаригт: Өглөө 10:00-13:00
Байгууллагын утасны дугаар: 70422504, 95425353
Номын сангийн захирал Д.Алтынгүл

1. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

1.1. Номын сангийн хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал.

2022 оны байдлаар 496ш номыг 9448000 төгрөгөөр худалдаагаар, 323ш номыг 3338400 төгрөгөөр бэлэг хандиваар, фондын бүрдүүлэлт хийгдэж, электрон каталогт оруулан, 819ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлд авч, уншлагын танхимуудад хүлээлгэн өгч

уншлаганд шилжүүллэв. 2022 онд номын сангийн хэмжээнд 16 төрлийн 730 000 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.

Англи улсад ажиллаж амьдарч буй Монголчуудын санаачилга дэмжлэгээр хэрэгжүүлж буй "Аймаг бүрд 1000 ном" аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн хүүхэд багачуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд зориулсан 600 гаруй номыг “Дагшин Алтай” ТББ-ын төлөөлөл аймгийн төв номын санд хүлээлгэж өглөө.

Монголын казах сурагчдын "Алтайн бүргэд" холбооноос хандивлаж буй Англи, Монгол, Казах хэлний сурагчдын гарын авлага, роман бүхий 2000 номын эхний 540ш ном, Хавшийн Исламын нэрэмжит хүүхдийн 2-р танхимд Х.Исламын хүүхдүүд, үр сад 150ш ном, Австралийн элчин сайдын яамны төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Х.Өрнөх, Монголын Үндэсний номын сангийн мэргэжилтэн М.Даваасүрэн, Анагаах Ухааны төв номын сангийн захирал Д.Баярцэнгэлээр ахлуулсан ажлын хэсэг хүүхдийн номын сангийн хөмрөгийг баяжуулах зорилгоор боловсрол, шинжлэх ухаан, танин мэдэхүй, утга зохиолын нэн хэрэгцээтэй монгол, англи ном хандивлав.

1.2. Сэлбэн засалт:

Элэгдэж хуучирсан 220ш ном, 15ш сонин сэлбэн зассан. Үүнд: Хүүхдийн 1-р танхимаас 50, хүүхдийн 2-р танхим 72, ГНОТанхимаас 58, уншлагын танхимаас 40 ном сэлбэн засав. Үндсэн фондын бүх номыг тоос шороог арчиж, монгол, казак уран зохиолын, байгалын шинжлэх ухаан, нийгэм, түүхийн болон улс төрийн номнуудыг үсэг дараалал, зохиогчийн тэмдэг болон ангилалаар ангилж байршуулсан .

2. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

2022 онд **10908** уншигчдад шинээр карт нээж, **27805** иргэсдэд нийт **58840** ном олгон уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг хανган үйлчилэв.

Танхимууд Үзүүлэлт	Уншлагын танхим	ГНОТ	ХТ-1	ХТ-2	Зөөврөөр	Цахима ар	Нийт
Уншигч	1800	1900	2433	2475	1800	410	**10908**
Байнгын уншигч	2100	2200	3900	3550	2100	890	**14740**
Ирэгсэд	4265	5500	5800	7790	2950	1500	**27805**
Ном олголт	11800	11945	13500	14840	3100	1650	**56835**

Өлгий сумын 1, 2, 4, 5, 8, 19 дүгээр хүүхдийн цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлэг, Дарын цэцэрлэгийн дунд ангийн бяцхан уншигчид номын сангийн бяцхан уншигчдын танхимтай танилцаад, ярьдаг ном /даналық әліппесі/, хөдөлгөөнт ном үзэж, бяцхан уншигчдын танхимын номын санчийн уншиж өгсөн үлгэрээс өөрсдийн мэдэж авсан мэдлэгээ хуваалцаж, дасгал хөдөлгөөн хийв.

2.1. ЦАХИМ -ВИДЕО БИЧЛЭГ

Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн Үндсэн фонд болон чөлөөт уншлагын танхимд байгаа номуудаас энэхүү сэдэвтэй “Монголын үзэсгэлэнт эмэгтэйчүүд”, “Үндэсний бичиг соёлын өдөр”, “Дэлхийн номын өдөр”, “Тэнгэрлэг эрчүүд”, “ Монголын түүх –Монголын бахархал”, “Тусгаар тогтонол -97жил” Ойн баярыг тохиолдуулан уншигчдад онлайн хэлбэрээр видио бичлэг сурталчилав. Онлайн хэлбэрээр гаргасан, уг видео бичлэгийг 260 гаруй уншигч лайк дарж , 900 гаруй уншигч үзсэн байна.

Хүүхдийн 1,2-р танхимаас бага ангийн сурагчдад Сохор найз цуварлын ном, Монгол ардын шилдэг үлгэрүүд, Цүнхтэй инээд, Хөгжөөнтэй туужууд, Нацагдоржийн бүрэн зохиол болон үлгэрийн номуудаар чанга уншлага хийж, үлгэрийн шинэ номын үзэсгэлэнг цахим болон танхимаар гаргаж, зохиолчийн булан, үлгэрийн цаг булангуудыг тогтмол ажиллуулж сурталчилан ажиллав.

Элсэлтийн Ерөнхий шалгалтын вакуумжуулсан сургалтын үеэр сурагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу 5-р сарын 15 наас эхэлж номын сангийн цагийн хувиард өөрчлөлт оруулж, 2 уншлагын танхимыг оройн 10 цаг хүртэл ажиллуулан, ЭЕШ-ийн холбогдолтой номын үзэсгэлэн, номыг хэрхэн ашиглах талаар сурагчдад зөвлөгөө өгч ажиллав. Иймд Өлгий сумын болон Алтанцөгц, Толбо, Цэнгэл, Ногооннуур, Булган, Сагсай сумуудаас нийт 125 гаруй сурагчид өдрийн болон оройн номын санд ЭЕШ-ийн холбогдолтой 398 ш номыг ашиглаж, шалгалтанд орох бэлтгэлээ хангаан суусан.

2.2. Гадны номын сан “Зуны уншлага”

Хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг үр бүтээлтэй зөв боловсон өнгөрүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, соёл урлагийн салбарт байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор **“Зуны уншлага”** **“Номын аялалд**

гарцгаая” сэдэвт 3 сарын аян зарлаж, номын сангийн гадна талбайд гадны номын санг өглөөний 08 цагаас оройн 10 цаг хүртэл байнга ажиллуулсан.

“НОМЫН АЯЛАЛД ГАРЦГААЯ” уриан дор зохион байгуулагдаж буй “ЗУНЫ УНШЛАГА”-ын хөтөлбөрийн хүрээнд номын сангийн хамт олон 2022 оны 07 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд “Зост” хүүхдийн зусланд мөн Цагааннуур сумын өдөрлөгт номын үзэсгэлэн гаргаж ажиллав. Тус үйл ажиллагааны үеэр “Зост” хүүхдийн зусланд амралтаа өнгөрөөж буй хүүхэд багачуудад шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, хүүхдүүдийн дунд уншсан номын тухай мэтгэлцээн явуулж, “Сэтгэ, бод” сэдэвт хөгжөөнт тэмцээн болон “Зугаатай зун” сэдэвт АХА танин мэдэхүйн тэмцээнүүд зохион явуулав.

Төрийн албан хаагчдын дунд ном унших хөдөлгөөн өрнүүлэх, үндэсний бичиг соёлыг сурталчлах, номоор дамжуулан танин мэдэхүйг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Баян-Өлгий аймгийн Прокурорын Газрын ажилтан албан хаагчид болон аймгийн төв номын сангийн нийт 32 ажилтан албан хаагч нарын хамтарсан “НОМ ОЮУНЫ ТОЛЬ” сэдэвт өдөрлөг зохион явууллаа.

2.3. Номын клуб, ном сонирхогчдын уулзалт

Номын сангийн дэргэдэх 27 сурагчдын бүрэлдэхүүнтэй “Уншигчын клуб”-ыг шинээр байгуулж , уншигчдын булан гарган, номын санд карт нээлгэж, зорилгоо тодорхойлон цаашдаа хийх үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг, уулзалтыг 2 удаа зохион байгуулав.

2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлсэн үйлчилгээ

Соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд “Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан уран бичлэгийн сургалтыг”-ыг зохион байгуулав. Уг сургалтыг Б.Баастын нэрэмжит Лабортари 2 дугаар сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Н.Ариунзаяа хүүхдүүдийн өөрсдийн нэрийг нь бичүүлэн, гарын бэлэг өгч урамшуулав. Хүүхдүүд их идэвхтэй оролцож, мөн зурагтай номуудыг их сонирхон баярлаж байлаа.

Хүүхдийн баярыг тохиолдуулан Өлгий сумын 13 –р багийн байнгын асаргаанд байгаа Манарбек овогтой Тилекберген, Темирбек овогтой Арайлым , Дарьбазар овогтой Сүхбаатар нарт Засаг даргын нэрэмжит гарын бэлгийг Номын сангаас төлөөлөн гардуулж , мөнгөн тусламж үзүүлж хүүхдүүдэд сэтгэлийн урам хайрлах зорилготой ажиллаа.

2.5 Зөөврийн номын сангаар үйлчилгээ үзүүлсэн байдал.

Номын сангийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа алслагдсан, тусгай байгууламжид байгаа иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг Өлгий сумын ТГ, Цагдаагийн Газар, ШШГА, Прокурор, Шүүх, ОБГ, Татварын Хэлтэс, ХЦ 0285-р анги , ХЦ 0226-р анги, Цэргийн 165-р анги, Гэрэлт Хөгжлийн Тэмүүлэл ТББ, УЦУОШТөв, ХГХЗХГ, Нийгмийн датгал зэрэг 12 байгууллага болон алслагдсан хөдөө сум багуудын ард иргэд, хүүхдийн зусланд нийт 35 байгууллагад зөөврийн номын сангаар 2950 уншигч болон ирэгсэдэд 3100 ном уншуулж үйлчилэв.

2.6. Номын санд хэрэгжүүлжсэн төсөл хөтөлбөрүүд

УИХ-ын гишүүн Х.Баделханы дэмжлэгээр 40 сая төгрөгний “Бяцхан уншигчдын танхим”-тай болов. Тус танхим нь сургуулийн өмнөх боловсролын насны бяцхан уншигчдын нурууны түвшинд тохирсон номын тавиур, сандал ширээ, хүүхдүүдийн оюуны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх сонсдог ном болон электрон ном, дэлгэц, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон юм.

Аймгийн Орон нутаг хөгжлийн сангаас хөрөнгө оруулалтаар номын сангийн бүх өрөө танхимуудын 38 300000 төгрөгний цонхны их засвар хийгдэж, уншигчдын ая тухтай байдлыг хангасан орчин бүрдүүлсэн.

Швейцарын хөгжлийн агентлагт алслагдсан хөдөө сум, багийн ард иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, нийтийн уншлагыг дэмжих,

зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Уншаад урагшлья” сэдэвт төсөл оруулж, уг төслийг Швейцарын хөгжлийн агентлаг дэмжиж номын санд 49500000 төгрөгний зөөврийн номын сан ажиллуулахад зориулагдсан Toyota Alphard Vellfaire маркийн машин бэлэглэж, хөрөнгө оруулалт хийж дэмжлэг үзүүлэв.

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 3-р сарын 09-ний өдрийн 37 тоот тогтоолоор аймгийн нийтийн номын санг нэрт зохиолч, урлагийн гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Бабийн Ахтаны нэрэмжит болгосон.

Номын санд Б.Ахтаны хүүхдүүд А.Айман, А.Олимпиад нар зохиолчийн хэрэглэж байсан дээл, бичгийн ширээ, гар бичмэл, эмээл мөн зохиолчийн номуудыг номын сангийн музейн буланд хүлээлгэж өгсөн.

Хүүхдийн 2-р танхимыг МУ-ын ШУ-ны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, зохиолч, сэтгүүлч Хапышийн Исламын нэрэмжит болгож, тус танхимын нээлт болов. Х.Ислам гуайн үр хүүхдүүд энэхүү 2-р танхимд гэрэлтүүлэг, танхимын шалыг

паркетлах, цонхны хөшигнүүдийг солих, хаягжуулах зэрэг тохижуулах ажил болон зохиолчын өөрийн хэрэглэж байсан монгол, казак, орос 150ш ном, номын тавиур, самбар хийлгэж өгч, туслалцаа үзүүлэв.

2.7. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Номын сангийн сангаас зохион байгуулах СОНА-ын жилийн төлөвлөгөөг боловсруулан ажилласанаар 2022 онд давхардсан тоогоор нийт 61 удаа СОНА зохион байгуулагдаж, 25 төрлийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 972 ном дэлгэгдэж, 4306 ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан.

№	Зохион байгуулагдсан соёл олон нийтийн ажлын нэр	Оролцсон хүний тоо	Зохион байгуулсан газар	Зориулалт
1	Зохиолч, философич С.Молор-Эрдэнэтэй "Уншигч-зохиолчид"-ын уулзалт	30	Уншлагын танхимд	
2	Монгол-Япон хүний нөөцийн хөгжлийн төвөөс уншигчид болон хүүхэд багачуудад Японы соёлын танилцуулга, Япон орны уламжлал хувцасны онцлогийн талаар танилцуулга	25	Уншлагын танхимд	**"Японы соёлын өдөрлөг"**

3	“Настан буурал ээж минь” зургийн уралдаан	11	Уншлагын танхимд	**Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр**
4	Үндэсний өв, урлаг соёл “Жигит султаны-2022”, “Наурыз бике” уралдаан	110	ХДТ-д	**“Наурыз” –ын баяраар**
5	МУСГЗ, зохиолч, яруу найрагч Р.Шынай, Яруу найрагч Рысбек нартай “Зохиолч-уншигчидтай уулзалт”	45	Уншлагын танхимд	**Дэлхийн номын баяр**
6	“Түргэн хэллэгийн” уншлагын уралдаан /Ж.Аргынбайн нэрэжит 4-р ЕБС –ийн 6-7 дүгээр ангийн сурагчдын дунд/	33	Уншлагын танхим	**Үндэсний бичиг үсгийн баяр**
7	“Сайхан бичигтэн” уралдаан /аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд/	300	Номын санд	
8	“Тэргүүний уншигч” уралдаан /ЕБС-ийн 9-12 ангийн сурагчид болон насанд хүрэгчдийн дунд/	30	ГНОТанхимд	
9	Бүтээлийн үзэсгэлэнг Өлгий сумын ЕБС-ийн дунд зохион байгуулж “Бүтээлч багш”-1,”Бүтээлч сургууль”-1 тус тус шалгаруулав	15	Номын сангийн гадна тайлбайд	
10	“Ертөнцийн гурвыг хэн сайн цээжлэх вэ?” сэдэвт уралдаанд Б.Баастын нэрэмжит Лаборатори 2-р сургуулийн 6-7 ангийн сурагчдын дунд	30	Уншлагын танхимд	
11	Казахын ард түмний суут хүмүүн, их соён гэгээрүүлэгч, яруу найрагч Абай Хунанбаевын **“Өлең-сөздің патшасы, сөз сарасы”** сэдэвт уран уншлагын уралдаан	40	Уншлагын танхимд	**Наурызын баяр**
12	“Номын өргөний ид шид” сэдэвт лекц	48	Номын санд	**“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” /хавар, намар/**
13	“Үлгэрээс үлгэрлэе” цэцэрлэгийн багш нарын дунд онлайн уралдаан	20	Цахим орчинд	
14	“Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн багачуудын дунд /2 удаа/	530	Цахим орчинд	
15	“Бийрээ нийлье, ургаа уудалья” үндэсний бичиг, угийн бичгийн сургалт	40	Уншлагын танхимд	
16	Номын клуб, ном сонирхогчдын уулзалт	27	Уншлагын танхимд	
17	Зохиолч сэтгүүлч Н.Ербахыт, Зохиолч, яруу найрагч А.Баймурат нартай Зохиолч-уншигчдын уулзалт	35		

18	Зохиолын баатаруудын дүрийн тоглолт, үлгэрийн баатаруудын парад /2 удаа/	450	Төв талбайд	
19	Номын флошмоб /2 удаа/	20	Төв талбайд	
20	Зохиолч, яруу найрагч Б.Баастын уран бүтээлээс "Уран уншлага" уралдаан	29	Уншлагын танхимд	
21	Гар зургийн уралдаан	30	Төв талбайд	
22	Яруу найрагч, сэтгүүлч К.Алаштай Зохиолч-уншигчдын уулзалт	56	Уншлагын танимд	
23	"Номын аялалд гарцгаая" зуны уншлагын аян	45	"Зост" хүүхдийн зусланд	**Зуны уншлага**
24	"Номын сайн нөхөр" уралдаан	255	Цахим болон танхим	
25	Хүүхдийн 1,2-р танхимаас бага ангийн сурагчдад Сохор найз цуварлын ном, Монгол ардын шилдэг үлгэрүүд, Цүнхтэй инээд, Хөгжөөнтэй туужууд, Нацагдоржийн бүрэн зохиол болон үлгэрийн номуудаар чанга уншлага	250	Хүүхдийн 1,2 танхимд	
26	"Соёлын өртөөчилсэн аялал" сэдэвт номын сангийн танилцуулга, аялалыг /Прокурор газар, Цагдаагийн газар, Ус Цаг Уур Орчин Шинжилгээний Төв, Онцгой байдал, Өлгий сумын ЗДТГ, Цэргийн 165-р анги, Алтай сумын Улаанхад ЕБС-ийн сурагчидад, Зайд ЕБС-ийн дунд ангийн сурагчдын дунд /	320	Номын санд	**"СОЁЛЫН БҮТЭЭЛ САР-2022"**
27	Албан байгууллагуудын албан хаагчдын дунд үндэсний бичгээр "Сайхан бичигтэн" уралдаан	25	ГНОТанхимд	
28	Зохиолч Ж.Лондоны "Тектік сарын" номын мэтгэлцээн / 4-р ЕБС-ийн 9 "А" ангийн сурагчдын дунд/	32	Уншлагын танхимд	
29	Монгол Улсын Аж Үйлдвэрийн Гавьяат Зүтгэлтэн, яруу найрагч Таукейн Халифатай уншигчдын уулзалт	60	Уншлагын танхимд	
30	Аймгийн Улсын бүртгэлийн эцэг, эхийн зөвлөлтэй хамтарч ажилтан албан хаагчдын хүүхдүүдийн дунд "Уран уншлага", "Гар зургийн" уралдаан	26	Уншлагын танхимд	

31	“Үлгэрч анги” уралдаан /Өлгий сумын цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд /	255	Цэцэрлэгт	
32	Монголын Зохиолчдын Эвлэлийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Баймергений Зархумын нэрэмжит уран бүтээлийн “**Уран уншлагын уралдаан**” /Монгол, Казах хэл дээр /	120	Уншлагын танхимд	
33	Орон нутгийн зохиолчдын болон хувь хүний номын нээлт /19 удаа/	525	Уншлагын танхимд	
	Нийт	**4271**		

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

Номын үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын тоо	Зориулалт
Ховор ном	20	“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” /хавар, намар/
Хүүхдийн ном	40	
Бабалар сөзи	120	
Сонин сэтгүүл	15	
Хамгийн том ба жижиг ном	14	
Шинэ ном	70	
Орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн	55	
Үндэсний бичгийн сурагчид болон багш нарын бүтээлийн үзэсгэлэн	45	
Хуучин номын үзэсгэлэн худалдаа	120	
Тэргүүний уншигч хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн	47	
Зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн	10	
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа	6	
Номын макет/ Жангар, Улаан малгат, Ахтаны түүвэр зохиол/	4	
Тэнгэрлэг эрчүүд	38	Цэргийн баяр
Их зохиолч Абайн Хунанбаев	32	Их зохиолч Абайн Хунанбаев “Уран уншлага” уралдаан
Шинэ номын цахим үзэсгэлэн	59	Дэлхийн номын өдөр, хүүхдийн баяр
Эх сайхан монгол хэл	35	

Багшнарын болон сурагчдын бүтээлийн үзэсгэлэн	58	Бичиг үсгийн баяр
Хууль зүйн ном	25	Хууль сурталчлах өдөр
Орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн	120	Зохиолч-уншигчдын уулзалт, Уран уншлага, номын нээлт
Доктор, профессор, түүхч Х.Исламын уран бүтээлээс	25	Доктор, профессор, түүхч Х.Исламын танхимын нээлт
Монголын түүх Монгол бахархал	39	Монгол бахархалын өдөр
Нийт	**972**	

Зохиолч Философич С.Молор-Эрдэнэ аймгийн төв номын сангийн ахлах ангийн сурагчдын дунд номын танилцуулга хийж, уулзалт болон мэтгэлцээн зохион байгуулав. Уулзалтанд нийт 30 гаруй ахлах ангийн сурагчид хамрагдав.

Монгол-Япон хүний нөөцийн хөгжлийн төвөөс уншигчид болон хүүхэд багачуудад зориулсан “Япон соёлын өдөрлөг” амжилттай зохион явагдаж, уг арга хэмжээний хүрээнд Япон соёлын танилцуулга, Япон орны уламжлал хувцасны онцлогийн талаар танилцуулга хийгдэж, хүүхэд багачуудад “Мэари болон шулмын цэцэг”, “Аавын хийж өгсөн хоол дэлхийд хамгийн амттай нь” кинонуудыг үзүүллээ.

Номын сангаас Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөр явуулсан “Настан буурал эмээ минь” сэдэвт гар зургийн уралдааныг Өлгий сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохиол байгуулж, уг уралдаанд 40 гаруй сурагчид оролцсоноор дараах 4 байрыг шагнан урамшуулав.

1-р байр Ш.Өркенбек 3-р ЕБС-ийн 12-р анги

2-р байр С.Тулпар 3-р ЕБС-ийн 11-р анги

3-р байр М.Еркебулан 4-р ЕБС-ийн 10-р анги
Тусгай байр К.Аллаберген Улаанхус сумын 12-р анги

“ЖИГИТ СУЛТАНЫ-2022”, “НАУРЫЗ БИКЕ-2022”

“Наурыз” –ын баяраар Үндэсний өв, урлаг соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Аймгийн Засаг Даргын Тамгын газар, Аймгийн Соёл, Урлагийн газар, Аймгийн төв номын сангаас хамтран зохион явуулсан “Жигит султаны-2022”, “Наурыз бике” уралдаануудыг амжилттай зохион байгуулж шилдгүүдээ шалгарууллаа.

Дэлхийн номын өдөр

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас 1995 онд 4 дүгээр сарын 23-ныг “Дэлхийн номын өдөр” болгон зарласан билээ. Энэ өдөр дэлхийн 100 гаруй оронд зохиолч, хэвлэн нийтлэгчдэд хүндэтгэл үзүүлэх, ном уншихын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулдаг.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан номын сангаас Зохиолч уншигчдын уулзалт, Номзүйн гарын авлага, Шинэ номын үзэсгэлэн, Дэлхийн уран зохиолын номын үзэсгэлэн, Ховор номын үзэсгэлэн, Ном солилцоо зохион байгууллаа.

МУСГЗ, зохиолч, яруу найрагч Р.Шынай, яруу найрагч Рысбек нар уншигчидтай уулзалт хийж, улзалтын үеэр зохиолчдын номын үзэсгэлэн, ном зүйн гарын авлагуудыг гаргаж сурталчилсан ба Зохиолч, сэтгүүлч Н.Ербахыт шинэ номын дээжээсээ аймгийн төв номын сангийн сан хөмрөгт хандивлав. Зохиолч, уншигчдын уулзалтад МЗЭ Баян-Өлгий аймаг дахь салбарын тэргүүн Б.Зархум, аймгийн зохиолч яруу найрагчид, сэтгүүлчид, ном соёлоо дээдлэгч уншигчид оролцлоо. Мөн уулзалтын төгсгөлд хамгийн сонирхолтой, болон чухал асуулт асуусан уншигчдад зохиолчид өөрсдийн гарын зурсан номоо бэлэглэлээ.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2022”

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 105 тоот зарлигийг хэрэгжүүлэх, Монголчуудын оюуны соёлын давтагдашгүй өв үндэсний монгол бичгийг нийтэд эзэмшүүлэх, хэрэглэх оршин нөхцөлийг бий болгох үндэсний хэл бичиг, ёс заншил, уламжлал, өвийг судлаж, сурталчилах зорилгоор **“Үндэсний бичиг үсгийн баяр-2022”-**ийг тэмдэглэн өнгөрүүлж дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

1. “Түргэн хэллэгийн” уншлагын уралдаан

“Түргэн хэллэгийн” уншлагын уралдааныг Өлгий сумын Ж.Аргынбайн нэрэжит 4-р ЕБС –ийн 6-7 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 50 хүүхэд оролцож эхний байр эзэлсэн 3 байрыг шагнан урамшуулав.

2. “САЙХАН БИЧИГТЭН” УРАЛДААН

“Сайхан бичигтэн” уралдааныг Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан ба аймагийн төвийн болон хөдөө орон нутгаас 200 гаруй хүүхэд, насанд хүрэгчид оролцов.

3. БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН:

Бүтээлийн үзэсгэлэнг Өлгий сумын ерөнхий боловсролын сургуулиудын зохион дунд байгуулж "Бүтээлч багш"-1,"Бүтээлч сургууль"-1 тус тус шалгаруулан идэвхтэй оролцсон ЕБС сурагчид болон багш нарыг шагнан урамшуулан ажиллаа.

4. **"ЕРТӨНЦИЙН ГУРВЫГ ХЭН САЙН ЦЭЭЖЛЭХ ВЭ?"** сэдэвт уралдаанд Б.Баастын нэрэмжит Лаборатори 2-р сургуулийн 6-7 ангийн 30 гаруй сурагчид оролцов. Эхний 4 байрыг шагнан урамшуулав.

НОМЫН НЭЭЛТ

Зохиолч,түүхч О.Хавсатарын казак хэлээр хэвлэгдсэн "Жадик омогийн уугийн бичиг", "Цойлогсод", Зохиолч Зейнелхабдылын Хатпагийн 7 төрлийн шинэ ном, Яруу найрагч Н.Ербахытын "Көп күткен көктем еди", Яруу найрагч М.Сояны "Бал балды таудын балдыры", Яруу найрагч А.Енбекийн "Бес –богда", Зохиолч

К.Баделханы “Туган жер”, Яруу найрагч А.Бодаубай “Ховда койнауы”, “Жыр арнаймын елиме”, Төр нийгмийн зүтгэлтэн, гавьяат ажилтан Ш.Жүкейн “Толбо нуурын тулалдаан” “Шангишбай партизан”, Зохиолч, яруу найрагч Ж.Жанатын “Рахман нур”, Зохиолч, яруу найрагч Б.Маратын “Атанмен ойна”, “Жырахта”, “Санырау шежиреси”, Зохиолч, яруу найрагч, орчуулагч Х.Байытын “Монгол өлен”, Х.Ержаны “Өмир өткелдери”, Ш.Хумарын “Акикат пен Өсиет”, Б.Ерболат “Махаббат жыры” нэртэй номнуудын нээлтийг хийж, орон нутгийн зохиолч, яруу найрагчдад “Онцлох батламж” гардуулан ажиллаа.

Дэлхийн номын баярыг тохиолдуулан Зохиолч, яруу найрагч Жекейн Қабдырашын "АУЫЛДА ТУЫП ӨСКЕНМІН" нэрт номын нээлт амжилттай зохион байгуулагдав.

Монгол Улсын Аж Үйлдвэрийн Гавьяат ажилтан, төр нийгмийн зүтгэлтэн Ш.Жүкейн "Шанкишбай партизан", "Толбо нуурын тулалдаан" нэртэй шинэ номуудын нээлт болов.

УРАН УНШЛАГА

Казахын ард түмний суут хүмүүн, их соён гэгээрүүлэгч, яруу найрагч Абай Хунанбаевын **“Өлең-сөздің патшасы, сөз сарасы”** сэдэвт уран уншлагын уралдааныг 2 үе шаттайгаар явуулав. Уг уралдаанд нийт 40 гаруй сурагч оролцов. Үүнд:

1-р шат 9-13 нас
1-р байр Б.Ахтоты, Улаанхус сумын 2р сургуулийн 5-р ангийн сурагч .
2-р байр С.Инжу, Цэнгэл сумын Руханият сургуулийн 4-ангийн сурагч.
3-р байр С.Амин,Толбо сумын 7-р ангийн сурагч.
4-р Тусгай байр 3-сургуулийн 4-р ангийн сурагч Е.Ерханат нар тус тус байр эзлэв.

2-р шат 14-18 нас
1-р байр М.Арай, Бастама сургуулийн 10-р ангийн сурагч
2-р байр М. Нурдана, Алтай сумын 8-р ангийн сурагч
3-р байр Х. Нуралем, Алтай сумын 8-р ангийн сурагч
Тусгай байр Сагсай сумын 11-р ангийн сурагч К. Ахбөпе нар тус тус шалгарсан
Тус уралдааны шүүгчээр ажилласан Монгол улсын гавьяат багш Е.Дөрветхан
Түүх судлаач, М.Хурманханы нэрэмжит ХДТ-ын ажилтан А.Еженхан
6-р БДС-ийн казах хэл, уран зохиолын багш Т. Дауирбек .

Өлгий сумын ЕБС-ын дунд ангийн сурагчдын дунд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Бөхийн Баастын уран бүтээлийн **“Уран уншлага”-**ын уралдааныг зохион явууллаа.
Энэхүү арга хэмжээнд нийт оролцсон сурагчдаас:
4-р сургуулийн 7 “а” ангийн сурагч С.Аружан 1-р байр

3-р сургуулийн 9 “а” ангийн сурагч М.Елик 2-р байр
4-р сургуулийн 7 “в” ангийн сурагч Е.Инкар 3-р байр
4-р сургуулийн 7 “а” ангийн сурагч А.Айдана нар тусгай байр эзэллээ.

Монголын Зохиолчдын Эвлэлийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Баймергений Зархумын нэрэмжит уран бүтээлийн “УРАН УНШЛАГЫН УРАЛДААН” монгол, казах хэл дээр зохион явууллаа. Тус уралдаанд аймгийн болон сумуудаас нийт 76 оролцогч авьяас билэг, оюун ухаан, ур чадвараа гарган амжилттай оролцож шилдгүүдээ шалгарууллаа.Үүнд:
1-р байр. Болдбаатарын Болор-Эрдэнэ Буянт сумын ЕБС-ийн 11”А” ангийн сурагч,
2-р байр. Өнерханы Баглан Баяннуур сумын 1-р ЕБС-ийн 9”Г” ангийн сурагч,
3-р байр. Мырзабекийн Наурызбай Ногооннуур сумын ЕБС-ийн 12-р ангийн сурагч,
3-р байр. Салдатбекийн Нурали Дэлүүн сумын ЕБС-ийн 8 “А” ангийн сурагч,
Тусгай байр. Мухарапын Арай Бастама сургуулийн 11 “Б” ангийн сурагч,
Тусгай байр. Бегарысын Инкар Булган сумын ЕБС-ийн 9-р ангийн сурагч нар тус тус шалгарлаа.

Хууль сурталчлах өдөрлөг

М.Икейн нэрэмжит Өлгий хотын төв талбайд “Хууль сурталчлах өдөрлөг” зохион байгуулагдаж номын сангаас “Хууль зүйн булан”-ийн 250 гаруй номуудаар үзэсгэлэн гаргаж ажиллаа.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2022”

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050”, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлийгийг хэрэгжүүлэх зорилгоор **“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022”** арга хэмжээг аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2022 оны 5-р сарын 12 -22 өдрүүд болон 09-р сарын 16-18 өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэв. Номын баярын 2 удаагийн арга хэмжээнд нийт **4900** гаруй хүүхэд багачууд, ард иргэд хамрагдсан.

1. **Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд**

1.1. Төв орон нутгийн хэвлэлээр сурталчилгаа

Баян-Өлгий аймгийн Дербес ТВ –д **“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022”-**ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай хэвлэлийн бага хурал хийж сурталчилав.

1.2. **“Номын өргөний ид шид”** номын сангийн танилцуулга лекц

“Номын өргөний ид шид” сэдэвт лекц зохион байгуулж мөн номын сангаас уншигчдад үзүүлэх боломжуудыг хүргэх үүднээс уншигчдад номын сангийн үйл ажиллагааг танилцуулав. Уг арга хэмжээнд ЕБС-ийн 4-р сургуулийн 8”а” ангийн сурагчид анги АУБ Ж.Аршагүл эцэг, эх, асран хамгаалагчид мөн номын санчид, сургуулийн номын санчид оролцож “Номын ач тус “ сэдэвт лекц, уншигч асран хамгаалагачдын дунд асуулт хариулт тэмцээн зохион явуулав. Идэвхтэй оролцсон эцэг эхчүүд болон сурагчдад шагнал гардуулан хүндэтгэл үзүүлэв.

1.3. **“Соёлын өртөөчилсөн аялал”** танилцах аялал

Сурагчдыг номтой нөхөрлүүлэх ном унших дадалтай болгох зорилгоор аймгийн төв номын сангийн үйл ажиллагаатай танилцах аялал хийлээ. Энэхүү аялалд 5-р ЕБС-ийн 7 “в” ангийн сурагчид, Билге-Тегин ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, Сагсай сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд явуулав.

1.4. “Үлгэрээс үлгэрлэе” онлайн уралдаан

Өлгий сумын СӨБ-ийн багш нарын дунд зарласан **“Үлгэрээс үлгэрлэе”** онлайн уралдаанд нийт 27 цэцэрлэгийн багш нар үлгэр ярих, үлгэрийг уран тод хүүхдүүдэд сонирхолтой болгон чанга уншиж өгч идэвхтэй оролцлоо. Үүнд:

1-р байр Оюунлаг алхам цэцэрлэгийн багш Гүлжазира
2-р байр 12-р цэцэрлэгийн багш Т.Хуралай
3-р байр 14-р цэцэрлэгийн багш Х.Тамара
Тусгай байр 17-р цэцэрлэгийн багш Х.Март
Тусгай байр 7-р цэцэрлэгийн багш Нуршаш тус тус шалгарсан.

1.5. “Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт

Хүүхдийн хэл ярианы чадварыг үлгэрээр дамжуулан хөгжүүлэх, үлгэрийн баатаруудын дүрд хувирч жүжигчлэн тоглох чадвартай болгох, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд багачуудын ном эрдэмийг дэлгэрүүлэх зорилгоор Өлгий сумын цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд **“Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт** уралдаанд зохион байгуулсанаар уралдаанд 27 цэцэрлэгийн 270 хүүхдүүд болон Өлгий сумын ЕБС –ийн бага ангийн нийт 185 сурагчид идэвхтэй оролцов. Үүнд:

Гранпри О.Анаргүл багштай 18-р цэцэрлэгийн бэлтгэл бүлэг
1-р байр Гүлжазира багштай 1-р цэцэрлэг бэлтгэл бүлэг
1-р байр Лазат багштай 11-р цэцэрлэг бэлтгэл бүлэг
2-р байр К.Күнбаги багштай 5-р цэцэрлэг бэлтгэл бүлэг
3-р байр Х.Алмагүл багштай 8-р цэцэрлэг бэлтгэл бүлэг
Тусгай байр Г.Мейраш багштай 19-р цэцэрлэг бэлтгэл бүлэг
Тусгай байр Б.Ермеш багштай 21-р цэцэрлэг бэлтгэл бүлэг

1.6. “Бийрээ нийлье, ургаа уудалья” үндэсний бичиг, угийн бичгийн сургалт зохион байгуулах

“Бийрээ нийлье, ургаа уудалья” үндэсний бичиг, угийн бичгийн сургалтанд ургын омог бичсэн 40 гаруй зохиолч, судлаачид оролцож, өөрсдийн бодол санаагаа солилцов. Цаашид нийт ургын омгийн нэвтэрхий толь бичих дүгнэлтэд хүрэв.

2. Үзүүлэн таниулах ажлын хүрээнд хийсэн ажлын талаар

2.1. Шинэ болон сэдэвчилсэн үзэсгэлэн

Төв номын сангаас Шинэ номын үзэсгэлэн, Хүүхдийн номын үзэсгэлэн, Сонин сэтгүүлийн үзэсгэлэн, “Бабалар сөзи” номын үзэсгэлэн, Ховор хуучин номын үзэсгэлэн, Хамгийн том, хамгийн жижиг номын үзэсгэлэн, Орон нутгийн хэвлэлийн үйлдвэр, хэвлэлийн газар, зохиолчдын хэвлэгдсэн номын үзэсгэлэн, Сумдын соёлын төвийн номын сан, сургуулийн номын сангуудын номын болон сурагчдын бүтээлийн үзэсгэлэн нийт 19 төрлийн үзэсгэлэнгүүд дэлгэгдэв.

2.2. Тэргүүний уншигч хүүхдийн бүтээл, зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн

Номын сангаас Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөр явуулсан “Настан буурал эмээ минь” сэдэвт гар зургийн уралдаан, Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан явуулсан “Сайхан бичигтэн” уралдаанаас эхний байр эзэлсэн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, номын тэмдэглэлийн үзсэгэлэн, орон нутгийн зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэнүүдийг тус тус гаргаж сурталчилав.

3. Уншлагыг дэмжих ажлын хүрээнд хийгдэх ажлын мэдээлэл

3.1. Тэргүүний уншигч сурагч, гэр бүл, байгууллагын шалгаруулалт

Номын сангаас байнга ном уншдаг уншигчдыг Номын баяраар шагнан урамшуулах уламжлал ёсоор номын сайн нөхөр, хамгийн их ном уншсан тэргүүний уншигч нарт “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн -сурагч”, “Тэргүүний уншигч –Гэр бүл”, “Тэргүүний уншигч-Байгууллага”, “Тэргүүний уншигч-Анги хамт олон”, -ны шалгаруулав.

“Тэргүүний уншигч –Гэр бүл” – Ж.Бауыржаны гэр бүл, Сансызбайн Машейн

“Тэргүүний уншигч-Байгууллага- Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар

“Тэргүүний уншигч-Анги хамт олон”- 4- БДС-ийн Аршагүл багштай анги хамт олон

“Тэргүүний ахмад уншигч” –Бибол Дакей

Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэнээр

1. 4-р БДС-ийн 4 “а” ангийн сурагч Амантайн Айни
2. 4-р БДС-ийн 4-р ангийн сурагч Бахытжаны Айсара
3. 5-р БДС-ийн 8-р ангийн сурагч Солдатханы Аружан
4. 3-р БДС-ийн 12 “б” ангийн сурагч Ержаны Жанболат
5. Дарын сургуулийн 11 “б” ангийн сурагч Адилбек Ахерке
6. 3-р БДС-ийн 12 “в” ангийн сурагч Алданыш Фестиваль
7. Сагсай сумын БДС-ийн Т.Серикжан
8. Сагсай сумын БДС-ийн Х.Меруерт
9. Сагсай сумын БДС-ийн К.Балгынбек

3.2. Зохиолч-уншигчдын уулзалт, ярилцлага

Баян-Өлгий аймгийн Зохиолч сэтгүүлч Н.Ербахыт, зохиолч, яруу найрагч А.Баймурат нартай Зохиолч-уншигчдын уулзалт, ярилцлагыг 4-р ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд болон яруу найрагч, сэтгүүлч, ном соёлоо дээдлэгч уншигчид оролцов. Уулзалтын үеэр зохиолчид шинэ номын дээжээсээ аймгийн төв номын сангийн сан хөмрөгт хандивлав. Мөн уулзалтын төгсгөлд хамгийн сонирхолтой, болон чухал асуулт асуусан уншигчдад зохиолчид өөрсдийн гарын зурсан номоо бэлэглэв.

3.3. Зохиолын баатаруудын дүрийн тоглолт, үлгэрийн баатаруудын парад

Өлгий сумын цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан **“Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт** уралдаанд оролцсон 27 цэцэрлэгийн 270 хүүхэд багачуудын болон ЕБС-ийн бага ангийн сурагчдын үлгэрийн баатаруудын дүрийн тоглолтын парадыг аймгийн төв талбайд амжилттай зохион байгууллаа.

3.4. Номын флошмоб

Номын сангийн дэргэдэх Өлгий сумын ЕБС-ийн дунд ангийн 20 сурагчдын бүрэлдүүхэнтэй “Номын флошмоб” клубын сурагчид номын нээлтийн баярын өдрөөр 5 төрлийн бүжигийг нэгтгэн бүжиглэн идэвхтэй оролцлоо.

4. Номын худалдаа

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн худалдаа, Арвин ХХК, Алтай Акдемийн өөрсдийн гаргасан ном, оюуныг хөгжүүлэх тоглоомын худалдаа, Емпати сургуулийн өөрсдийн гаргасан ном, товхимол, танилцуулга, хуучин номын худалдаа, хувь ном цуглуулагчдын номын худалдаа г.м номын худалдаа номын байрын 2 удаагийн арга хэмжээнд зохион байгуулагдав.

5. Судалгаа

Ном, хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалгаа, Уншигчдын сэтгэл ханамжийн судалгааг 2 удаагийн нийт 150 оролцогчдоос авч үүнээс 80 сурагч, 70 насанд хүрэгчдийн саналыг дэмжиж ажиллахаар төлөвлөв.

6. **Талбайн зохион байгуулалт**

Талбайн дэд хэсэгт тайз байрлуулж, баруун талд номын үзэсгэлэн, номын худалдаа, хүүхдийн тоглоомын худалдаа, зүүн талд цэцэрлэгийн хүүхдүүдийн үлгэрийн баатаруудын дүрийн тоглолтын парадыг явуулахаар, дунд хэсэгт нь номын баярыг сонирхогчдыг байрлуулахаар зохион байгуулан ажиллав.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2022”-ийн нээлтийн үйл ажиллагаа

Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор “Илүү их уншъя” уриан дор зохион байгуулагдах 31 дэх удаагийн “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2022”-ийг 05-р сарын 20 ны 10.00 цагт аймгийн төв талбайд эхэлж өргөн хүрээтэй тэмдэглэн өнгөрүүллээ.

Энэхүү арга хэмжээнд дараах ажлууд зохион байгуулагдав.

- Сумдын соёлын төвийн номын сангуудын болон аймгийн ЕБС-ийн бүтээлийн үзэсгэлэн
- Ном бэлэглэх, хандивлах арга хэмжээ
- Тэргүүний уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэлийн үзэсгэлэн
- Өлгийн зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн гаргах
- Зохиолын баатаруудын дүрийн тоглолт, үлгэрийн баатаруудын парад /Цэцэрлэгийн ахлах ангийн хүүхдүүд/
- Тэргүүний уншигч сурагч, гэр бүл, байгууллагыг алдаршуулах
- Номын флашмоб /бүжиг/
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн худалдаа
- Ховор хуучин номын үзэсгэлэн
- Хуучин номын худалдаа
- Уншигчдын сэтгэл ханамжийн судалгаа, ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалга

ХУРЛЫН ДАРГЫН ИВЭЭЛ ДОР
31 дэх

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ИВЭЭЛ ДОР
31 дэх

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ИВЭЭЛ ДОР
31 дэх
НОМЫН БАЯР

НОМЫН БАЯР

АҚТАН
БАБИҰЛЫ
Б.АҚТАН
ЖАҢҒАР

“СОЁЛЫН БҮТЭЭЛ САР-2022”

Зорилго: Монгол Улсын урт хугацааны бодлого 2050 болон Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт “Соёлын бүтээлч сар-2022” аяны хэрэгжилтийг хангаж, соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлүүлэх, урлагийн бүтээл, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархалыг сэргээх, бэхжүүлэх юм.
Бүх нийтийн соёлын боловсрол: 1 дэх долоо хоногт Номын сангаас “Үндэсний бичиг соёл” –ыг сурталчлах өдөрлөг

1 дэх долоо хоногт аймгийн Төв номын сангаас 11-р сарын 01,02 -ны өдөрүүдэд "Соёлын өртөөчилсэн аялал" сэдэвт номын сангийн танилцуулга,

аялалыг Цагдаагийн газрын 30 албан хаагчид болон Ус Цаг Уур Орчин Шинжилгээний Төвийн 16 албан хаагч нийт 46 албан хаагчдад номын сангийн үйл ажиллагааг танилцуулах, шинэ номын үзэсгэлэн гаргах, "Ном уншихын ач тус" сэдэвт зөвлөмж, лекц унших, үнэгүй карт нээх, чөлөөт сэдэвээр АХА тэмцээн явуулах г.м үйл ажиллагаануудыг амжилттай зохион байгуулав.

Бүх нийтийн соёлын боловсрол: 2 дахь долоо хоногт Номын сангаас “Үндэсний бичиг соёл” –ыг сурталчлах ажлын хүрээнд

2 дахь долоо хоног буюу бүх нийтийн соёлын боловсролоор аймгийн Төв номын сангаас 11-р сарын 07-ны өдөр Өлгий сумын албан байгууллагуудын албан хаагчдын дунд үндэсний бичгээр “Сайхан бичигтэн” уралдаан явуулав. Энэхүү үйл ажиллагаанд нийт 20 гаруй насанд хүрэгчид оролцож эхний 5 байр эзлүүлж шагнан урамшуулав.

1-р байр – Г. Батцэцэг / ГИХГ-ын ахлах мэргэжилтэн /
2-р байр – Х.Нургүл /5-р ЕБС-ийн багш/
3-р байр – Т.Назкеш /5-р ЕБС-ийн багш/
Тусгай байр-Б. Саруул /2-р ЕБС-ийн номын санч/
Тусгай байр- Н. Серикгүл /Бастама ЕБС-ийн багш

2022 оны 11-р сарын 09-ны өдөр Баян-Өлгий аймгийн Б. Ахтаны нэрэмжит Төв номын санд "Соёлын Бүтээлч Сар" аяны хүрээнд Өлгий сумын Ж.Аргынбайн нэрэмжит Ерөнхий Боловсролын 4 дүгээр сургуулийн 9"А" ангийн хамт олонтой хамтран номын хэлэлцүүлэг зохион явуулав

Тус үйл ажиллагааны зорилго нь “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын хугацаанд ЕБ-ын сургуулийн суралцагчдыг номтой нөхөрлүүлэх, хөгжүүлэн дэмжих,бүтээлч сэтгэлгээний аргад суралцуулахад оршино.
Мөн дараах зорилтуудын биелэлтийг хангаан ажиллав.

Үүнд:
-Зохиолч Ж.Лондоны “Тектік сарын” номыг ангиараа унших.
-Зохиолын дагуу зурсан зургаар үзэсгэлэн гаргах.
-Зохиолын дагуу номын тэмдэглэлийн дэвтэрт тэмдэглэл хийх
-5 багт хуваагдаж “21-зууны манлайлагчид” тэмцээнд оролцов.

Аймаг орон нутгийн зохиолчид ба тэдний зохиолуудыг уншигчдад таниулах, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд зорилгоор Монгол Улсын Аж Үйлдвэрийн Гавьяат Зүтгэлтэн, яруу найрагч Таукейн Халифатай уншигчдын уулзалт зохион байгууллаа. Зохиолч, уншигчдын уулзалтад МЗЭ Баян-Өлгий аймаг дахь салбарын тэргүүн Б.Зархум, аймгийн зохиолч яруу найрагчид, сэтгүүлчид, ном соёлоо дээдлэгч 60 гаруй уншигчид болон ЕБС-ийн ахлах ангийн сурагчид оролцож, орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн гаргаж, сурагчдын дунд зохиолчын яруу найрагаас "Уран уншлага" зохион байгуулав.

Зохиолч, уншигчдын уулзалтын үеэр МУАҮГЗ, зохиолч Таукейн Халифа шинэ номын дээжээсээ аймгийн төв номын сангийн сан хөмрөгт хандивлан, хүүхэд залуучуудад өөрийн бичсэн номын тухай товч тайлбарлан, сурагчдын асуултанд хариулж, чөлөөт ярилцлага өрнүүлэв.

Соёлын үйлдвэрлэл: 3 дахь долоо хоногт Номын сангаас “Үндэсний бичиг соёл” –ыг сурталчлах ажлын хүрээнд 11-р сарын 14 нд Алтай сумын Улаанхад багийн ЕБС-ийн захриал, багш нар болон нийт 16 сурагчид номын сангаар зочилон номын сангийн уншлагын танхимуудаар танилцаж, үлгэрийн ном уншиж, сонирхон цаашид хамтарч ажиллахаар гэрээ байгуулан ажиллаа. Мөн тус багийн сургуулийн номын сангийн баяжилт болгож, хүүхдүүдэд зориулсан үлгэрийн номууд бэлэглэв.

Бага насны хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх, хүүхэд бүрийн хэл яриаг хөгжүүлэхэд нөлөөлөх зорилгоор “Оюунлаг алхам” цэцэрлэгийн бага, дунд, бэлтгэл бүлгийн хүүхдүүд номын сангийн “Бяцхан уншигчдын” танхимын , зурагтай ном, ярьдаг ном, үзгээр уншдаг номуудыг сонирхуулж, үлгэр болон хүүхэлдэй үзэж бүжиглэн хөгжилтэй өнгөрүүлэв. Энэхүү үйл ажиллагаанд цэцэрлэгийн багш нар болон нийт 30 гаруй бяцхан уншигчид хамрагдав.

Аймгийн Улсын бүртгэлийн эцэг, эхийн зөвлөлөөс хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг дэмжих зорилгоор албан хаагчдын хүүхдүүдийн дунд ЗУРАГ ЗУРАХ, УРАН УНШЛАГЫН уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.
Тэмцээн маш сонирхолтой өрсөлдөөнтэй болж өндөрлөлөө. НАМАР сэдвээр зураг зурах, чөлөөт сэдэвт уран уншлагын тэмцээний байр эзэлсэн байдлыг танилцуулвал:

Зургийн уралдаан
Гран при - Рысбай овогтой Нурсултан
1-р байр арман овогтой Аружан
2-р байр ашухан овогтой Айбике
3-р байр имашхан овогтой Жаннур

Уран уншлага
1-р байр рахман овогтой Мустафа
2-р байр мейрамбек овогтой Али
3-р байр сьез овогтой Бегим
3-р байр ансаган овогтой Ергалым нар тус тус эзэллээ

МУУГЗ, зохиолч, яруу найрагч, Б.Ахтаны ном, сонин сэтгүүлд гарсан уран бүтээлүүд, гар бичмэл, өөрийн хэрэглэж байсан дээл, эмээл, ширээ г.м эд зүйлсийн үзэсгэлэнг аймгийн ХДТ-ын "Бүргэд" найраглалаас хийсэн жүжиг үзэгчидэд гаргаж сурталчилсан. Энэхүү үзэсгэлэнг 400 гаруй ард иргэд үзэж сонирхов.

5. **СУРГАЛТ, АРГА ЗҮЙ**

4.1. СУРГАЛТ

Австралийн Элчин Сайдын Яам, Монгол Улсын Үндэсний номын сангийн хамтарсан ажлын хэсэг 2022 оны 02 сарын 15-16 өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Төв номын санд ажиллав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Австралийн ЭСЯ-ны Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Х.Өрнөх, Судалгааны ажилтан Д.Сумъяажав, Австралийн Засгийн Газрын тэтгэлгийн төгсөгч, Үндэсний номын сангийн мэргэжилтэн М.Даваасүрэн, Анагаах Ухааны Төв номын сангийн Захирал, программист Д.Баярцэнгэл нар ажиллаж номын санчдыг чадавхжуулах, туршлага хуваалцах сургалт зохион байгуулж, техникийн туслалцаа үзүүлэн, хүүхдийн номын фондыг шинжлэх ухаан, танин мэдэхүй, утга зохиолын шилдэг бүтээлүүдээр баяжууллаа.

Номын сангийн тухай хуулийн сурталчилгаа, хэлэлцүүлэг

Номын сангийн хуулийг сумдын соёлын төвийн номын санч, сургуулийн номын санч нарт цахимаар, төвийн номын сангийн номын санчдад аймгийн МХГ-ын улсын байцаагч А.Айжантай хамтарч “Номын сангийн тухай хуулийн хэрэгжилт, эрх зүйн орчин” сэдэвт 2 цагийн сургалтыг зохион байгууллаа.

2.8. “Бяцхан үүрсээ болзошгүй эрсдэлээс хамгаалья” аян

“Бяцхан үүрсээ болзошгүй эрсдэлээс хамгаалья” 45 хоногийн аяны хүрээнд хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын Эцэг эхийн зөвлөлийн дарга А.Рина номын сангийн ажилчин албан хаагчдын дунд “Бяцхан үүрсээ болзошгүй эрсдэлээс хамгаалья” сэдэвт сургалт зохион байгуулав.

Номын санчдын Цахим сургалт

Сумдын Соёлын төвийн болон сургуулийн номын санчдын дунд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” сэдэвт сургалтыг цахим орчинд зохион байгуулж нийт 21 номын санчид оролцож, номын сангаас зохион байгуулах СОНА, Номын сангийн хуулийн тухай хэлэлцүүлэгт идэвхтэй оролцлоо.

Соёлын сайд С.Номин тэргүүлсэн ажлын хэсгийн СУГ-д зохион байгуулсан “Соёлын салбарын сэргэлтийн бодлого” сэдэвт сургалтанд хамрагдав.

Соёлын сайд С.Номин тэргүүлсэн ажлын хэсэг аймагт ажиллах үеэрээ иргэдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах ном, хэвлэлийн үйлчилгээг өргөжүүлж, хос хэлээр ном хэвлэлийг хэвлүүлэх асуудлаар номын сангийн удирдлагуудтай уулзаж, номын сангаас гаргаж байгаа соёлын бүтээлч үйлдвэрийн үзэсгэлэнтэй танилцав.

Баян-Өлгий аймгийн СУГ-ын “Соёлын байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт” сэдэвт сургалтанд оролцож, Соёлын байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт туршлага солилцов.

Соёлын яамнаас 4 удаагийн чадавхжуулсан сургалтанд оролцлоо. Үүнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлан
- Төрийн албан хаагчийн ёс зүй
- Авилгалын эсрэг
- Статистик мэдээ боловсруулах арга зүй, тоон мэдээллийн хэрэглээ ач холбогдол зэрэг цахим сургалтанд хамрагдав. ҮНС-ийн арга зүйч В.Түвшинтогтохын зохион байгуулсан “Нэмэлт үйлчилгээний журам” хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо солилцов.
- ҮНС болон бүх аймагуудын арга зүйчдийн нэгдсэн груп болон номын сангийн асуудал шийдэл гурапд нэгдэн байнга холбоотой байж, бүх мэдээ мэдээллийг авч санал солилцож, холбоотой ажиллаж байна.

Гадаад, дотоодын номын сангуудын туршлага

Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн Магсарын Баянзулын нэрэмжит Ховд аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судаллаа. Мөн Ховд Аймгийн Соёлын Өвийн Хүрээлэн болон Музей үзэж сонирхов. Энэхүү уулзалтанд номын сангаас нийт 8 номын санч оролцов.

Номын сангийн захиралаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гадаад орнуудын номын сангуудын үйл ажиллагаатай танилцах, номын сангуудаас туршлага судлах, номын фонд баяжуулах зорилгоор Казакстан Улсын Алматы хотын Үндэсний номын сан болон Ш.Уалиханы нэрэмжит түүх, эрдэм шинжилгээний хүрээлэн, Өскемен хотын Пушкины нэрэмжит төв номын сан, Оралхан Бөкейн нэрэмжит хотын төв номын санд туршалага солилцож, сургалт семинарт оролцов.

Швейцарын хөгжлийн агентлагийн дарга хатагтай Стефани Бурри номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахаар боллоо.

4.2. АРГА ЗҮЙ

- Өгөгдсөн арга зүйн бүртгэлийг цахимаар хөтөлж хөдөө сумдын соёлын төвийн болон сургуулийн, Өлгий сумын сургуулийн нийт 38 номын санчдад 69 удаа арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаа. Улаанхус, Сагсай сумын Соёлын төвийн номын сан, аймгийн төвийн 2,3 сургуулийн номын сангуудаар биечлэн очиж, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, ном зүй, картын сан, зөөврийн номын сангийн үйлчилгээний талаар зөвлөлгөө өгч ажиллав.

- Соёлын төвийн номын сангуудын товч түүх, номын сангийн гадна болон танхимуудыг харуулсан зураг, жилийн төлөвлөгөө, тайлан, номын санчын анкет, ажил байрны тодорхойлолтоос бүрдсэн хавтасуудыг авч ажиллаж байна.
- Соёлын төвийн номын санчдын сумын номын санчдын ажлыг дүгнэх аргачлалын дагуу үйл ажиллагааг дүгнэж, аймгийн ЗДТГ-д хүргүүлэн, эхний байр эзэлсэн номын санчдыг "Өргөмжлөл" болон номоор шагнан урамшуулсан.
- Байгууллагын номын санчдын болон ажилчдын ажлыг дүгнэх аргачлал боловсруулан, хагас жилийн ажлыг дүгнэн, номын сангийн захиргаанд танилцуулан ажиллав.

6. ЛАВЛАГАА, НОМ ЗҮЙН АЖИЛ

- Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны мессенжер, бичгээр, утсаар, амаар нийт 415 лавлагааг 1650 уншигч хэрэглэгчдэд өгсөн байна.
- Шинээр бүрдүүлсэн 1154 ном хэвлэлийг LIB-4U программын цахим каталогт бүртгэн нийт 240 ширхэг карт шинээр бичиж, холбогдох каталогуудад байрлуулсан.
- Электрон каталогийн хайлтын компьютерийг ажиллахад бэлтгэх, каталогийн шоголуудыг цэгцлэх ажлыг өдөр бүр хийж гүйцэтгэв.
- Каталогийн лавлагааг уншигчдад өгч номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, каталог ашиглах, захиалгын хуудас бичих, номоо хэрхэн хайх, номоо хэрхэн сонгох талаар мэдээлэл өгч, зарим номын шифрийг тодруулах,олдохгүй байгаа зохиолуудыг электрон каталогоос хайлт хийж өгч байсан.
- "Төрийн мэдээлэл", "Хууль зүйн мэдээ" сэтгүүлийг тогтмол авч лавлагааны фондоо баяжуулан ажиллаж байна.
- Ном зүйн картын санд шинээр "Зуны мэдээ" сониноос "Соёл гэгээрэл" сэдэвт 150ш, "Хууль зүйн" сэдэвт 50ш картын санг ном зүйн бичилтийн дагуу бичиж, каталогийн шүгээнд байрлуулав.



- Хүүхэд залуучуудад зориулсан хуулийн булангийн ном зүйн жагсаалт, шинэ номын ном зүйн жагсаалт, МУ-ын ардын зохиолч, соёлын гавьяат зүтгэлтэн

Султаниягийн Магауия, МЗЭ-ийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Б.Зархум, Зохиолч, сэтгүүлч Н.Ербахыт, Яруу найрагч З.Рысбек, Т.Халифа нарын санамж өгөх ном зүйн бүртгэл зэрэг 6 төрлийн номзүйн жагсаалтыг тус тус гаргаж уншигчдад сурталчилж байна.

7. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

- Lib-4U праграммын PC VERION энгийн хувилварыг ашиглан дотоод сүлжээндээ холбогдон WiFi утасгүй интернетийг ашиглан үйлчилж байна.
- Сумдын соёлын төвийн номын сангуудын цахим програмын нэгдсэн тайлангийн мэдээ, нэгдсэн каталогийн мэдээ, Monbiblio цахим программд оруулсан нэгдсэн тайлан, нэгдсэн каталогийн мэдээ, мэдээллийн сангийн нөөцийг бэлдэж цаг хугацаанд нь Соёлын яамд хүргүүлэн ажилласан. Мөн Бугат, Баяннуур, Булган сумын компьютеруудыг форматлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Номын сангийн бүх уншлагын танхимууд болон каридорд ном алдах эрсдэлээс хамгаалах зорилгоор камержуулалт, хянах дэлгэцийг тогтмол ажиллуулж байна. Камерийн бичлэг хийх төхөөрөмжүүд 7 хоногийн бичлэг хадлагдан ажиллаж байна. Үүдэнд байрлуулсан соронзон хаалга нь хэвийн ажиллаж байна.

- Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор Б.Ахтаны нэрэмжит Fase хуудасыг тогтмол ажиллуулж, номын сангийн үйл ажиллагааны талаар нийт 89 удаа мэдээ, мэдээлэл тавьж сурталчилсан.
- “Дербес” TV, “Саян” TV, ОНОНРадиотой хамтран гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор 51 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд сурталчилсан.

8. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ ОНОВЧТОЙ ХИЙХ

7.1. ДОТООД ХЯНАЛТ

1. Дотоод хяналтын жилийн төлөвлөгөө боловсруулан хагас, бүтэн жилийн тайланг МХГ-д хүргүүлэн ажиллаа.
2. Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр дунд эрсдэлтэй гарсантай холбоотой тусгай төлөвлөгөө гаргаж, 6 төрлийн дутагдалаас 4 үзүүлэлтийг бүрэн арилгаж ажилласанаар **“Дунд**” эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан



3. Хагас бүтэн жилээр удирдамжийн дагуу ажилтан албан хаагчдын ажлыг шалган алдаа дутагдалыг хамт олны хурлаар танилцуулан арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаа.
4. Аймгийн МХГ-ын улсын байцаагчийн зохион байгуулсан “Соёлын байгууллагуудын дотоод хяналт сэдэвт сургалтанд хамрагдаж, “Номын

сангийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналтын үндсэн чиглэлүүд сэдэвт итгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцов.

7.2. БАЙГУУЛЛАГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулан аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсийн даргад хянуулж ажиллав.
- Номын сангийн 2022 оны үйл ажиллагааны мэдээ, ажиллагсадын судалгааны мэдээ, тоног төхөөрөмжийн мэдээг хагас, бүтэн жилийн тайлангуудыг цаасан болон цахим хэлбэрээр цаг тухайд нь хүргүүлэн ажиллаа.
- Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтийн үзүүлэлтээр 98.9 оноо авч "А" үнэлгээгээр үнэлэгдэв.
- Аймгийн ЗД-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас, бүтэн жилийн биелэлт
- Соёлын сайдын аймгийн ЗД-тай хийсэн гэрээний хагас, бүтэн жилийн биелэлт
- Номын сангийн 2022 оны үйл ажиллагааны мэдээг /4 улиралаар/
- Үндэсний хөтөлбөрүүд, Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр, "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022" хаврын болон намрын төлөвлөгөө тайлангууд, "Соёлын бүтээлч сар"-ын мэдээг 4 хоногоор тус-тус хүргүүлэн ажиллав.
- Номын сангаас 7 хоног болгон зохион байгуулсан СОНА болон захиргааны тайланг 7 хоногийн 4 дэх өдөрт СУГ-д хугцаанд нь хүргүүлэн ажилласан.
- Аймагт хяналтад авч буй хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.
- Байгууллагад ирсэн нийт 48 төрлийн албан тоотын хариу өгч, зарим хариутай бичгийг судлан тушаал, удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллав.
- Номын сан нь 2022 оны ажлын үзүүлэлтээр аймгийн **"Оны шилдэг төрийн байгууллага"**-аар шалгарч "Гэрчилгээ", цом, гадаад аялах эрхээр шагнагдав.

8. ТӨСӨВ. САНХҮҮГИЙН АСУУДАЛ

- Шилэн дансны хуулийн заалтуудыг мөрдөж санхүүгийн тайлан, мэдээ, балансыг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгсөн. 2022 оны батлагдсан

төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, байгууллага нь ямарч өр, авлагагүй гарсан нь ололттой тал байсан.
- Шилэн дансыг сар бүр цахимаар шивэлт хийн хэвлэж гарган, харагдах байдлаар мэдээллийн самбарт байршуулсан.

9. БУСАД АЖИЛ

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ

Номын сан нь тус аймгийн уншигчдын онцлог, уншигч номыг санчдын хүсэлт мөн аливаа зохиолч уншигчдын дугуй ширээний уулзалт, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, шинэ номын нээлтийн үйл ажиллагаа зэрэг ажлуудад тулгуурлан нийт 6 төрлийн соёлын бүтээлч үйлдвэрлэлээ гарган ажиллаж байна. Үүнд: Номын сангийн хаягтай, логотой, эшлэл үгтэй, шинэ номын зурагтай тэмдэглэлийн дэвтэр, блокнот, уншсан номын тэмдэглэл, номын хавчуур, А4-ийн хэмжээтэй цаг тооны бичиг /календарь/ монгол, казах хэлээр, түлхүүрийн оосор, гарын бугуйвч нарыг тогтмол гаргаж ажиллаж байна.

- Аймгийн ЗД-ын 2022 оны 03 дугаар сарын 04 ний өдрийн А/144 дугаар захирамжийн “Цэвэр орчин-хоггүй –Өлгий” аян байгууллагын гадна талын цэвэрлэгээ, хувират газард цэвэрлэгээ хийж ажиллав. :

- Аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зөв хэв маягыг төлөвшүүлэх зорилгоор “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ МОНГОЛ” аянд идэвхтэй оролцож, өглөө бүр ажлын байранд дасгал хийж хэвшсэн.

Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” аяны хүрээнд хамт олоноор 70 ширхэг мод тарих арга хэмжээнд идэвхтэй оролцов.

Номын санд ажиллаж байгаал тэтгэвэрт гарсан ахмадуудад "Олон Улсын Ахмадын баяр"-ын өдрийн халуун мэндийг хүргэж , гарын бэлэг өгч баярлуулав.

БҮТЭЭЛЧ АЖИЛ

Номын баярыг тохиолдуулан Зохиолч Б.Ахтаны номын макетийн материалыг фото студиод хийлгэж номын санчид хамтарч өрсдөө том номын макет болгож гаргасан, шинээр 13ш цэцэг тарьж, шинэ номын нээлтийн үйл ажиллагаанд хэрэглэх ширээний бүтээлэг, бүх танхимуудын сандалын бүтээлэгийг өөрсдөө оёж энэ жилийн бүтээлч ажилд хувь нэмэр оруулсан.

ДҮГНЭЛТ

Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн 2022 онд хийсэн бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийхэд:

Номын сангаас зохион байгуулагдсан "Дэлхийн номын өдөр", "Бичиг үсгийн баяр", "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022" хавар, намрын арга хэмжээнүүд, "Номын сайн нөхөр", "Зуны уншлага", "Соёлын бүтээлч сар", Зохиолч-уншигчдын уулзалт, "Уран уншлага" "Номын мэтгэлцээн", "Соёлын өөртөөчилсэн аялал", ЕБС-ийн бага ангийн сурагчид, Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд "Үлгэрийн баатарын дүрийн тоглолт", "Үлгэрч анги" г.м бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх соёлын олон талт үйл ажиллагааг танхим болон цахим орчинд зохион байгуулж, Өлгий сумын ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийг номын санд хамруулах 5 өдрийн график гаргаж ажилласанаар номын сангийн уншигчдын тоо жилээс жилд нэмэгдэж, ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 05 Номгон

1.Номын сангийн үйлчилгээ

1.1. Лавлагаа арга зүйн ажил

Лавлагаа арга зүйн танхим, Баянхонгор фонднoос бусад уншлагын танхимуудад шаардлагатай номуудыг түр шилжүүлгээр өгч, лавлагаа ном зүйн үйлчилгээг 1845 уншигчдэд үзүүлсэн. Үүнээс электрон каталогоос ном хайх заавар зөвлөгөөг 1632 уншигчдад, амаар 79 уншигчдад, бичгээр 61 уншигчдад, утсаар 73 уншигчдад лавлагаа өгсөн. Уншигчдаас хэрэгцээтэй байгаа номуудыг татгалзлаар бүртгэн, шинэ ном худалдан авах захиалгад нийт 22 номыг бүртгүүлж, 16 номыг худалдан авав.

Орон нутгийн картын сан: Яруу найрагч С.Мөнхтогтох, Б.Баярсайхан нарын уран бүтээлээр орон нутгийн картын сан хийсэн. Орон нутгийн зохиолчдын 60 гаруй ном, зохиол бүтээлийг цахимаар сурталчилсан.

Ном зүйн ажил: "Ардын аман зохиол" сэдвээр ном зүйн бүртгэл гаргаж, сурталчлав. Мөн тогтмол хэвлэлийн "Өнөөгийн Баянхонгор" сонины 2021-2022 оны дугааруудаар ном зүйн бүртгэл, "Дэлхийн номын өдөр"-ийг угтан сэдэвчилсэн, санамж өгөх ном зүй тус тус гаргасан.

Тогтмол хэвлэлийн Zotero программд "Өнөөгийн Баянхонгор" сонины 2008-2022 оны нийт 10155 мэдээллийг шивж, Үндэсний номын сангийн тогтмол хэвлэлийн үндэсний нэгдсэн мэдээллийн санд илгээсэн. Үндэсний тогтмол хэвлэлийн орон нутгийн цахим санг бий болгоход 1990 оны "Лениний зам", "Шинэ зам" сонины 1991-1998 он хүртэл 2017 нүүрийг тогтмол хэвлэлийн сан бий болгож МҮНС-д тайланд файлыг дахин илгээж ажиллалаа.

Арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд: Ерөнхий боловсролын Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, 5 дугаар сургууль, Баян-Ойт, "Гэгээн сумади, Соого Сейкео, Политехникийн коллежийн номын санд, байгууллагуудаас "Жаргалтай амьдрал" төв, Шүүхийн номын санд, сумдаас Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Заг, Жаргалант, Гурванбулаг, Баянбулаг суманд тус тус арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Шинээр ашиглалтад орсон "Гэгээн сумади" цогцолбор сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Уншигчдад зориулан гаргасан гарын авлага: Нийт танхимуудаас уншигчдад зориулан /нэр дурьдах/ зэрэг 17 төрлийн гарын авлагыг гаргаж уншигчдад сурталчилан, ашиглуулан ажиллаж байна.

1.2. Сан хөмрөгийн үйлчилгээ: Фондоос ном, хэвлэлийг уншлагын танхимууд, гэрээр ном олгох тасгаар олгож, буцаан авч байрлуулан, шинэ номын мэдээг улирал тутамд ирсэн шинэ номуудаар нэгтгэн, номын зураг, номзүйн бичилтийг хийж, товч анатацитайгаар 4 удаа гаргаж, уншигчдад суртчилан ажиллалаа.

***Фонд баяжилт**:* Тайлангийн хугацаанд хандиваар 110 нэр төрлийн 120 ширхэг 2.752.400 төгрөгний номоор, худалдаагаар 653 нэр төрлийн 872 ширхэг 15.457.800 төгрөгний номоор, нийт 763 нэр төрлийн 992 ширхэг 18.210.200 төгрөгний номоор сан хөмрөгийг баяжуулж, стандртын дагуу техник ажиллагааг хийн, уншлаганд гарган, өдөр тутмын хэвлэл "Зууны мэдээ", "Өдрийн сонин", "Хүмүүн бичиг", "Утга зохиол урлаг", "Өнөөгийн Баянхонгор" сониныг 476,700 төгрөгөөр захиалан авч, нийт 81 уншигчдад үйлчиллээ. Хэвлэлүүдийг сар, улирлаар нэгж болгон үдэж сонин сэтгүүлийн дансанд бүртгэж, сан хөмрөгт байрлуулан, урагдаж гэмтсэн 174 ширхэг номыг сэргээн засварлан, бүртгэл хөтлөв.

Сан хөмрөгийн эргэлтийн судалгааг улирал бүр гаргаж, үр дүнг тооцоход 7934 ном буюу фондын номын 16,4 хувийг уншигчид ашигласан байна. Уран зохиол, аман зохиол, гүн ухааны номууд эрэлт хэрэгцээ ихтэй байлаа.

Номын сан хоорондын ном солилцоо: Ном солилцооны гэрээг 8 сумын болон сургуулийн номын сантай байгуулж, 257 номоор 1028 уншигчдад ном олгож үйлчилжээ.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Политехникийн коллеж, 339 дүгээр цэргийн ангийн номын сангуудад 13 удаа 231 номоор 422 хүнд үйлчилжээ.

Номын үзэсгэлэн: Шинэ номын үзэсгэлэнг 15 удаа 512 номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 23 удаа 1087 номоор, цахимаар 1 удаа 60 гаруй номоор тус тус үзэсгэлэн гаргаж, уншигчдад сурталчилсан.

1.3. Уншлага үйлчилгээ: Төлөвлөгөөнд шинээр 2000 уншигчдад үйлчлэхээс 2108 уншигчдад, 13000 ирцэд үйлчлэхээс 6497 ирцэд, 27500 ном олгохоос 15.614 ном олгож үйлчилсэн. “Номын сан Баянхонгор” facebook цахим хуудсанд уншигч хүүхэд багачуудад зориулан үлгэр домог, танин мэдэхүйн мэдээлэл 139 удаа, соёл олон нийтийн ажил 83 удаа, “Цахим уншлага” пэйж хуудсанд зохиол, өгүүллэг, тууж 60 удаа тус тус нийтэлжээ. Нийтлэлийн хүртээмж 2584, нийтлэлтэй харьцах 1500, хуудас шинээр таалагдсан тоо 221, шинээр дагаж нэгдсэн 150 хэрэглэгч байна.

1.4. Уншигч, номын санч нарт зориулсан сургалт, уулзалт:

Монгол Улсын Үндэсний номын сантай хамтран аймгийн төвийн болон орон нутгийн номын санч нарт “Номын сангийн үндсэн ойлголт” сэдэвт сургалтыг 9 дүгээр сарын 12-нд зохион явууллаа. Сургалтыг Үндэсний номын сангийн ерөнхий номын санч Т.Баярлах, ном зүйч Б.Цогжаргал, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын соёл хариуцсан мэргэжилтэн Б.Одгэрэл нар удирдан явуулж, нийт 34 номын санч хамрагдав.

“Хил хязгааргүй номын сан” төслийн хүрээнд номын сангийн менежментийн системийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 06-нд зохион байгуулж, танхимаар 31 номын санч, цахимаар 14 номын санч тус тус хамрагдлаа. Сургалтыг Австралын Элчин сайдын яамны хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Х.Өрнөх, Монголын номын сангуудын холбооны гүйцэтгэх захирал М.Даваасүрэн, Анагаах ухааны төв номын сангийн захирал, Монголын номын сангуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүн З.Баярцэнгэл, С.Гантулга нар удирдан явууллаа. Төслийн хүрээнд манай номын санд 1,955,300 төгрөгийн үнэ бүхий хүүхэд, танин мэдэхүйн чиглэлийн ном зохиолыг гардуулж өгсөн.

Зохиолчдын хэвлэн гаргасан ном, зохиол бүтээлийг иргэдэд сурталчлах зорилготойгоор зохиолч уншигчдын уулзалтыг тогтмол зохион байгуулж ирсэн. Үүнд: Философич С.Молор-Эрдэнийн шинэ номын танилцуулга болон лекц, Баянхонгор аймгийн Заг сумын харъяат, МЗЭ-ийн шагналт, "Хүрэн морь" яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт, сэтгүүлч, яруу найрагч Лхагвасүрэнгийн Батцэнгэлийн "НУЛИМСТАЙ БУРХАН", түүний редакторласан "ТӨРД ЗҮТГЭСЭН ЭРХМҮҮД" шинэ номын нээлт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гишүүн, сэтгүүлч, “Цагаан бороо” номын зохиолч Б.Наминчимэдтэй хийсэн уулзалт, зохиолч П.Баярсайханы “Тодхон зүгт” номын нээлт, Х.Дэмбэрэлийн “Говь хангайн цэнхэр орон” номын нээлт тус тус зохион байгуулагдаж 260 гаруй иргэд оролцлооо.

Хүүхдийн төв номын сангаас цахимаар зохион явуулсан “Номын сангийн тухай хууль”-ийг танилцуулах, сурталчлах сургалтад аймаг, орон нутгийн номын санчид, мэргэжилтүүд оролцсон.

1.5. Албан хаагчдын хамрагдсан сургалт:

Архивын тасгаас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэл”, “ERP системийн ашиглалт, хяналт, тоон гарын үсэг” сэдэвт сургалтад захирал Б.Түвшинчимэг, архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал нар оролцлоо.

“Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт соёлын салбарын удирдах ажилтны нэгдсэн хэлэлцүүлэг Улаанбаатар хотод 6 сарын 07-09-нд зохион байгуулагдаж, захирал Б.Түвшинчимэг оролцов. Хэлэлцүүлгийн хүрээнд орон нутгийн соёл, урлагийн байгууллагууд стратеги төлөвлөгөөндөө шинэ сэргэлтийн бодлогыг тусгах, санал солилцох, нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж ажиллахад соёлын байгууллагын ажилтан бүрийн оролцоо чухлыг онцоллоо.

Мөн “Насан туршийн боловсролын төв”-тэй хамтран 15 цагийн 5 багц сургалтууд, E-Mongolia академаас зохион байгуулсан “ERP системийн ашиглалт”, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Жендерийн мэдрэмжтэй төрийн алба” сургалт, “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын зөвлөгөөн”, аймгийн Төрийн архиваас зохион байгуулсан “Баримт бичгийн стандарт” сургалт, Архивын ерөнхий газар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран цахимаар зохион байгуулсан “Монгол бичгийн хэвлэмэл хуудасны стандарт, хөтөлбөрийн хэрэгжилтийг танилцуулах” сэдэвт сургалт, Соёлын яам, Авлигатай тэмцэх газраас хамтран цахимаар зохион байгуулсан Авлигын эсрэг хуулийн талаарх сургалт, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс зохион байгуулсан “Хяналт шинжилгээ үнэлгээний цахим систем”-ийн сургалт, аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулсан “Намайг алгас” аяны талаарх сургалт, төрийн албан хаагчдад цахимаар зохион явуулдаг “7:4:10” сургалт гэх мэт 20 орчим сургалтуудад ажилтнууд дангаараа болон хамт олноороо оролцож, мэдээлэл авч, мэдлэгээ дээшлүүлдэг.

Дугуйлан: Нийтийн номын сангийн дэргэдэх “Оюунлаг тархи” клубээс Цагаан сарын уламжлалт баярыг тохиолдуулан үндэсний хувцас, өв соёлоо сурталчлах, номд хайртай оюунлаг ард иргэдээ дэмжих, номын соёлыг ёс заншилтай хослуулан түгээн дэлгэрүүлэх, үндэс угсаагаа бахархан судлах зорилготой “Номтой цагаан сар” фото зургийн уралдааныг санаачлан зохион байгуулав. Уралдаанд Номундалай, Номгон, Эрдэм, Сооғо Сейкео сургуулийн нйит 22 оролцогч оролцсоноос цахим орчинд хамгийн их хандалт авсан эхний 3 сурагчийг шалгаруулан шагнаж урамшуулсан.

“Оюунлаг тархи” клубээс “Өглөөний номтой уулзалт” үйл ажиллагааг 6, 7 дугаар сард нийт 6 удаа Оготнотой булаг дээр өглөөний эрт зохион байгууллаа. Уулзалтад 7-12 дугаар ангийн сурагчид сайн дураараа, номын найз нөхдүүд нийлэн оролцож, номын танилцуулга, хэлэлцүүлэг өрнүүлж, танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн, спорт аяга өрөх тэмцээн зохион байгуулж, дуу хөгжим, яруу найраг, чөлөөт ярилцлага өрнүүлэн, өглөөг үр бүтээлтэй өнгөрүүсэн.

1.5.Соёл олон нийтийн ажил:

1.Цагаан сарын уламжлалт баярыг тохиолдуулан үндэсний хувцас, өв соёлоо сурталчлах, ёс заншлаа судлах зорилготой “Монгол ёс заншил” танин мэдэхүйн тэмцээнийг албан хаагчдын дунд 2 дугаар сарын 18-ны өдөр зохион явууллаа. Оролцогчид 2 багт хуваагдаж, баг тус бүр үндэсний хэв маяг илтгэсэн ширээ засаж, монгол хувцасаар гоёж оролцсон. Морь уралдах, алаг мэлхий өрөх, авах, хэлц үгийн тайлбар, ертөнцийн гурав, оньсого таалцах, шагай шүүрэх зэрэг 8 төрлийн тэмцээн зохион явуулж Я.Гэрэлтуяа ахлагчтай баг тэргүүлж бооцооны мөнгөн шагнал болох 50.000 төгрөгөөр шагнуулсан.

2. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Ээждээ бичих захидал” уралдааныг 6-9, 10-12 дугаар ангийн сурагчдын дунд 2 насны ангиллаар 8 дахь жилдээ зохион явууллаа. Уралдаанд 58 сурагч захидал ирүүлсэнээс удирдамжийн дагуу 6-9 дүгээр анги, 10-12 дугаар ангийн насны ангиллаар тус бүр эхний 3, нийт 6 байрыг шалгаруулан, шагнаж урамшуулсан. .

Шагналыг “Гэгээ” гоо сайханы дэлгүүр, “Начин байкери”, “Шижир учиг” урлангийн хамт олноос гоо сайхны бүтээгдэхүүн, баярын бялуу, дээлийн өнгө зэрэг нийт 960,000 төгрөгийн үнэ бүхий зүйлүүдээр ивээн тэтгэж, хамтран ажилласан.

3. Монгол цэргийн түүхт 101 жилийн ойд зориулан “Аавдаа хэлэх чин сэтгэлийн үг” захидлын уралдааныг 9 дэх жилдээ зохион явууллаа. Нийт 169 захидал ирсэнээс ангилал тус бүрээс эхний 3 байрыг буюу нийт 9 захидал шалгарав. Дунд насны ангилалд тэргүүн байрыг Б.Адьяасүрэн, ахлах насны ангилалд тэргүүн байрыг А.Жадамба, насанд хүрэгчдийн ангилалд тэргүүн байрыг Г.Батдэлгэр нар тус тус эзэллээ. Уралдааныг аймгийн Даамны холбооны нарийн бичгийн дарга Ц.Даваасүрэн, “Шижир учиг” урлангийн хамт олон ивээн тэтгэж, хамтран ажиллав.

4. Дэлхийн усны өдрийг угтан, “Газрын доорх ус” уриан дор “Ус үнэт баялаг” сэдвээр 10-12 дугаар ангийн сурагчдын дунд эсээ, илтгэлийн уралдааныг зохион явууллаа. Уралдаанд аймаг, сумдаас нийт 53 эсээ ирснээс шилдэг 13 эсээг шалгаруулан уралдааны 2 дахь шат буюу илтгэлийг хэлэлцүүлэн эцсийн дүнг гаргасан. Уралдааны тэргүүн байрт Номгон ахлах сургуулийн 12 дугаар ангийн сурагч А.Жадамба, дэд байрт Эрдэм ахлах сургуулийн 12 дугаар ангийн сурагч Г.Түмэн-Уянга, гутгаар байрт Номгон ахлах сургуулийн 12 дугаар ангийн сурагч Б.Алтангэрэл, тусгай байрт Эрдэм ахлах сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Б.Өсөхжаргал, Э.Хонгорзул нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал, гарын бэлгээр шагнууллаа. Шагналын санг Чандмань-Баянхонгор ХК 340,000 төгрөгөөр ивээн тэтгэж, нийт 369.500 төгрөг зарцуулсан.

5. Олон Улсын хүүхдийн номын баярыг тохиолдуулан Дани Улсын хүүхдийн зохиолч Х.К.Андерсены мэндэлсэний 217 жилийн ойд зориулан түүний зохиолоос сэдэвлэсэн гар зургийн уралдааныг 5-7 дугаар ангийн сурагчдын дунд явуулж, нийт 95 бүтээл ирсэн. Уралдааны тэргүүн байрт Соого Сейкео сургуулийн 5Б ангийн сурагч Ц.Биндэрьяа, дэд байрт Баян-Ойт цогцолбор сургуулийн 5Б ангийн сурагч Э.Тэмүүлэн, гутгаар байрт Алгоритм сургуулийн 7Б ангийн сурагч М.Урангоо, тусгай байрт Гэгээн сумади сургуулийн 5А ангийн сурагч Б.Дүүрэнжаргал, Баян-Ойт цогцолбор сургуулийн 5Б ангийн сурагч Э.Мөнхсарнай нар тус тус шалгарч, шагналаа гардан авлаа.

6. Аймгийн Зохиолчдын холбоотой хамтран **“Дэлхийн яруу найргийн өдөр”-** ийг 03 дугаар сарын 28-нд 9 дэх жилдээ тэмдэглэн өнгөрүүлж, энэ хүрээнд аймгийн Зохиолчдын анхдугаар чуулган, “50 номын хожил” танин мэдэхүйн тэмцээн, номын үзэсгэлэн гаргаж сурталчлах ажлыг тус тус зохион байгууллаа. Чуулганд Монголын Зохиолчдын эвлэлийн орон нутаг хариуцсан мэргэжилтэн В.Сэлэнгэ, Хос шарга дууны шүлгийг бичсэн Бөмбөгөр сумын уугуул яруу найрагч Д.Агваан, Соёлын гавьяат зүтгэлтэн, Сүхбаатар аймгийн Утга зохиолын салбар нэгдлийн тэргүүн, яруу найрагч С.Амартайван нар урилгаар ирж, нийт 70 гаруй хүн оролцов.

Тус чуулганаар, Зохиолчдын холбооны дүрэм журмаа хэлэлцэн баталж, цаашдын ажиллах чиг хандлагаа тодорхойлох, Төрийн шагналт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит шагналыг бий болгохоор тус тус шийдвэрлэж, аймгийн удирдлагуудад уламжлав.

Мөн тус өдрөөр хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн **“50 номын хожил”** уралдааныг явуулж, идэвхтэй оролцсон Политехникийн коллежийн оюутан Б.Ууганбаяр, М.Гунаажав, Гэгээн сумади сургуулийн сурагч Х.Сумьяабазар, Б.Цэвээнэз, Соого сейкео сургуулийн сурагч Ч.Лувсанвандан, Эрдэм ахлах сургуулийн сурагч Б.Өсөхжаргал нарт Талархал, номын дээжээс гардуулж шагнаж урамшуулсан. Энэ үеэр дэлхийн яруу найргийн сонгомол зохиол, хүүхдийн дэлхийн шилдэг зохиол, ардын уран зохиолч Тангадын Галсангийн “Монгол хүмүүний зүрхний бичээс” шүлгийн ишлэл, Зохиолчдын холбоонд шинээр элссэн гишүүдийн номууд зэрэг 60 гаруй номоор үзэсгэлэн гаргаж сурталчлав.

Үйл ажиллагааг ТВ-10 телевизээр дамжуулан олон нийтэд хүргэж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.638.400 төгрөгөөр санхүүжүүллээ.

7. Гэр бүлийн бүх гишүүдэд ном унших арга ухааныг хүргэх, ном унших соёлыг түгээх, номтой нөхөрлүүлэх, томчуудаар дамжуулан хүүхэд багачуудад номын ертөнцөөр аялах боломжийг сурталчлан таниулах, үлгэр дууриалал болгох зорилгоор аймгийн төвийн төрийн албан хаагчдыг хамруулсан **“Номтой зочин” подкастыг** зохион байгууллаа. Байгууллагын дэргэдэх “Оюунлаг тархи” номын клубын гишүүд тус бүр нэг ном сонгон авч судлан, тухайн номыг нэр бүхий албан хаагчдад уншуулах зорилгоор албан өрөөнд нь зочлон, 10 хоногийн хугацаанд номын тэмдэглэл хөтлөх даалгаврыг өгч ажиллаа. Энэхүү подкастад Номундалай цогцолбор сургуулийн захирал Ц.Алтангэрэл, Номгон ахлах сургуулийн захирал Сарангэрэл, Эрдэм ахлах сургуулийн захирал Ц.Загдсүм, Баян-Ойт цогцолбор сургуулийн захирал Л.Аюурзана, Төгс-Алгоритм сургуулийн захирал Г.Отгончимэг, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Энхжаргал, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Даваасүрэн, Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Оюунсайхан, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Нямдулам, “Номт” номын дэлгүүрийг үүсгэн байгуулагч Энхчимэг, Соого Сейкео сургуулийн багш С.Мөнхтогтох, Соёл, урлагийн газрын дарга Ц.Азбаясгалан, “Үүрэгтэй залуус” ТББ-ийн чиглүүлэгч Ичинноров, Infinity Pearl сурагчдын холбооны тэргүүн Г.Түмэн-Уянга, Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эх баригч Х.Болортуяа, Түүх, угсаатан зүйн музейн мэргэжилтэн Бадмаа нарын 16 хүн хамрагдсан.

8.“Дэлхийн номын өдөр”-ийг тэмдэглэх ажлын хүрээнд 04 дүгээр сарын 12-нд хүүхдийн зохиолч, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Хүнбишийн Дэмбэрэлийн “Цагаан богд“ тууж, “Аралдаа багтдаггүй амбан шар”, “Хөгнө сунаж мал өсдөг”, “Торомны уралдаан”, “Хазаарын чимээ” зэрэг өгүүллэгийн номуудаа уншигч түмэндээ өргөн барьж шинэ номын нээлтээ хийлээ. Тус өдөрлөгт яруу найрагчид, сурагчид, номын санчид, оюутнууд, Баян-Ойт цэцэрлэгийн Б.Нарангэрэл багштай бэлтгэл бүлгийн хүүхдүүд, Хөгжимт драмын театрын уран бүтээлчид, Оюунлаг тархи клубийн сурагчид, ТВ-10 телевизийн ажилтнууд нийт 60 гаруй хүн оролцлоо. Х.Дэмбэрэлийн намтар уран бүтээл, тууж, богино өгүүллэгийг байгууллагын Facebook-ээр сурталчилсан. Энэ үеэр номын үзэсгэлэнг 130 гаруй номоор, дэлхийн хамгийн том, жижиг номнууд, дэлхийн шилдэг 10 зохиолыг цувралаар гаргаж гарын авлага болгон хэвлэсэн.

9. МЗЭ-ийн гишүүн, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт, яруу найрагч А.Батжаргалын санаачилгаар **“Найргийн чансаа-3**” яруу найргийн наадмыг аймгийн Зохиолчдын холбоо, Хүүхдийн Тэмүжин театртай хамтран 4 дүгээр сарын 29-нд зохион байгууллаа. Уран бүтээлийн чанар чансааг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлж амжилтыг ахиулах зорилготой уг наадамд 30 яруу найрагч оролцсон. Наадмын 2 дугаар шатанд шалгарсан 13 шүлгийг Хүүхдийн Тэмүжин театрын залуу уран бүтээлч Соёлын тэргүүний ажилтан Ж.Алтанчимэг, жүжигчин Б.Нямхүү, Б.Золзаяа, З.Энгүүн-Эрдэнэ нар уншиж сонордуулав. Шүүгчээр Тэмүжин театрын ерөнхий найруулагч, Соёлын тэргүүний ажилтан Д.Долгорсүрэн, Нийтийн номын сангийн ном зүйч Б.Должин, МЗЭ-ийн шагналт яруу найрагч, аймгийн Зохиолчдын холбооны тэргүүн Б.Жавзандулам, Зохиолчдын холбооны нарийн бичгийн дарга, ардын боловсролын тэргүүний ажилтан Х.Тунгалаг, Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч А.Батжаргал нар ажилласан. Наадмын тэргүүн байрт “Нутагтаа очно” шүлгээр Оюунтөгс, дэд байрт “Азарган чоны улианд хийморийн салхит талаасаа адуугаа хурааж ирэхээр мордсон аавдаа” шүлгээр С.Мөнхтогтох, гутгаар байрт “Гэгээн тэнгэр ээж минь” шүлгээр залуу яруу найрагч С.Ууганбаяр нар шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав. “Шижир учиг”

оёдлын цех, Ц.Сарангэрэл захиралтай “Ивээлт наран” хүнсний дэлгүүр тус тус ивээн тэтгэлээ.

10. Үндэсний бичиг, соёл, түүх, уламжлалаа хойч үедээ өвлүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 5-р сарын эхний 7 хоногт тэмдэглэдэг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтаж монгол бичгийн “Тэргүүний уншигч” шалгаруулах 15 дугаар улсын уралдааны эхний шатыг аймаг орон нутагтаа зохион байгуулж, 2 насны ангиллаар манлайлан оролцсон 10 сурагчийг шалгаруулж, улсын уралдаанд оролцуулсан. Тус уралдааны 8-9 дүгээр ангийн төрөлд Номундалай лаборатори сургуулийн 8е ангийн сурагч Ц.Оюунтүлхүүр тэргүүн байрыг, мөн тус ангийн сурагч С.Дэлгэрдалай тусгай байрыг эзэлсэн амжилттайгаар оролцоод ирсэн. Манай аймгийн хүүхдүүдийг нэгэн жигд сайн уншлагатай, чанартай оролцож байгааг шүүгч нар онцоллоо.

11. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд зохиогдсон ажлуудыг нэг **“Босоо бичгийн гайхамшиг”** хичээнгүй бичиг, уран бичлэгийн уралдааныг Хэлний бодлогын салбар зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсролын төвтай хамтран явуулав. Уралдаанд аймаг, сумдаас 442 оролцогч оролцож, шагналын санд 600,000 төгрөг зарцуулсан.

Хичээнгүй бичгийн 7-9 дүгээр ангийн төрөлд тэргүүн байрт Баянцагаан сум 8Б ангийн сурагч В.Баярцэцэг, дэд байрт Номундалай сургууль 9Е ангийн сурагч Н.Номин-Эрдэнэ, гутгаар байрт Номундалай сургуулийн 8Г ангийн сурагч Э.Анужин, тусгай байрт Баянцагаан сумын 9А ангийн сурагч Н.Алдармаа, Номундалай сургуулийн 8Г ангийн сурагч Б.Энэрэл нар тус тус шалгарлаа.

Хичээнгүй бичгийн 10-12 дугаар ангийн төрөлд тэргүүн байрт Номгон ахлах сургуулийн 12-4 ангийн сурагч Б.Ариунзаяа, дэд байрт Баянцагаан сумын 11Б ангийн сурагч Т.Цэнд, гутгаар байрт Номундалай сургуулийн 12Д ангийн сурагч Б.Одмаа, тусгай байрт Номундалай сургуулийн 10В ангийн сурагч Э.Батзул, Номгон сургуулийн 11В ангийн сурагч Я.Ерөөлтбямба нар тус тус шалгарлаа.

Уран бичгийн төрөлд тэргүүн байрт Төгс-Алгоритм сургуулийн 10Б ангийн сурагч Г.Болорчимэг, дэд байрт Төгс-Алгоритм сургуулийн 10А ангийн сурагч О.Номин-Эрдэнэ, гутгаар байрт Номундалай сургуулийн 11Г ангийн сурагч Б.Жавзанпагма, тусгай байрт Номундалай сургуулийн 11Г ангийн сурагч Б.Буяндэлгэр, Өлзийт сумын сургуулийн 9Б ангийн сурагч А.Одонтуяа нар тус тус шалгарлаа.

12. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” буюу номын баярын үйл ажиллагааг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор **“Илүү их уншъя”** уриатайгаар иргэд, хүүхэд багачуудад чиглэсэн олон талт ажлуудыг 5 дугаар сарын 23-30 –ны өдрүүдэд зохион байгууллаа.

Нээлтийн арга хэмжээг Баганат талбайд зохион байгуулж УИХ-ын дарга Г.Занданшатар, Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай, аймгийн Засаг даргын орлогч Б.Батсуурь, бусад хамтран ажилласан байгууллагын төлөөлөл оролцож, цугласан хүүхэд багачууд, ард иргэдэд мэндчилгээ дэвшүүллээ. Энэ үеэр манай байгууллагын зүгээс явуулын номын сангийн үйлчилгээ, номын үзэсгэлэн, уншигчдын бүтээлийн үзэсгэлэн, IQ хөгжүүлэх тоглоомын үйлчилгээ үзүүллээ. Мөн аймгийн Түүх угсаатны зүйн музейгээс “Хонгор нутгийн өв соёл” үзэсгэлэн, ерөнхий боловсролын сургуулиудаас хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн, аймгийн Зохиолчдын холбооноос зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа, номын дэлгүүрүүдийн хямдралтай номын худалдаа, Худалдааны үндэсний их сургуулийн оюутнуудаас хэрэгцээт номоо үнэ төлбөргүй авах боломжийг уншигчдад олгох зэрэг ажлууд зохион байгуулж, хамтран ажиллав. Ойролцоогоор 800 орчим хүн оролцов.

13. Номын баярын хүрээнд зохион байгуулагдсан гол ажлуудын нэг **“Үлгэрээс үлгэрлэе”** буюу цэцэрлэгүүдэд очиж хүүхдүүдэд үлгэр уншиж өгөх өртөөчилсөн аялал байлаа. Байгууллагын дэргэдэх “Оюунлаг тархи” номын клубын

сурагчид, Хүүхдийн Тэмүжин театрын драмын багш Золзаяа нартай хамтран "Үлгэрээс үлгэрлэе" чанга уншлага, үлгэр уншиж өгөх ажлыг 7 удаа явуулж, 7 цэцэрлэгийн нийт 700 гаруй хүүхдүүд хамрагдсан.

14. Номын баярын хүрээнд **"Соёлын өртөөчилсөн аялал"-ыг** 2 удаа зохион байгуулав. Энэхүү үйл ажиллагаа нь соёлын салбарын 4 байгууллага болох Нийтийн номын сан, Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театр, Түүх угсаатны зүй-Байгалийн музейн үйл ажиллагааг хүүхэд багачуудад танилцуулах, сурталчлах зорилготой. Тус аялалд Алгоритм, Номундалай, Номгон сургуулийн 80 гаруй хүүхдүүд оролцлоо.

15. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 4-7 дугаар ангийн сурагчдын дунд Дани улсын зохиолч Х.К.Андерсений зохиол бүтээлээр **"Үлгэрийн баатрууд амилсан нь**" сэдэвт уншсан номын тэмдэглэл бичих уралдааныг зохион байгуулав. Уралдаанд 45 сурагч бүтээлээ ирүүлсэнээс, тэргүүн байрт Эрдэм ахлах сургуулийн 5г ангийн сурагч Б.Тэлмүүн, дэд байрт Эрдэм ахлах сургуулийн 6в ангийн сурагч Анударь, гутгаар байрт Эрдэм ахлах сургуулийн 6в ангийн сурагч Мишээл, тусгай байрт Эрдэм ахлах сургуулийн 6в ангийн сурагч Өнөрчимэг, Эрдэм ахлах сургуулийн 5г ангийн сурагч Гал-Эрдэнэ нар тус тус ээзлж Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Шагналын санг "Нийгмийн түншлэлийн сүлжээ" ТББ 160,000 төгрөгөөр ивээн тэтгэж, хамтран ажилласан.

16. **"Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх** нь" уулзалт, цэнгүүнийг аймгийн Ахмадын холбоотой хамтран зохион байгууллаа. Энэ үеэр 40 хүний дунд танин мэдэхүйн АХА тэмцээн, азын сугалаа явуулж, ялагчаар ахмад настан Б.Дорж шалгарлаа. Урилгаар Ахмадын ордны дарга С.Лочинлхам, Номгон 1 дүгээр багийн ахмадын зөвлөлийн дарга А.Гарьд, МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Д.Дашдамба нар оролцож "Мэндлэх хүндлэх ёс" сэдвээр мэдээлэл сурталчилгаа хийсэн. Нийт үйл ажиллагаанд 300 гаруй хүн оролцов.

17. Номд дуртай хүүхэд залуусыг нэгтгэх, хөгжүүлэх, сонирхол нэгт найз нөхөдтэй болгох, зуны амралтыг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой **"Өглөөний номтой уулзалт"** үйл ажиллагааг 8-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 42 сурагч хамрагдлаа. "Номтой уулзалт" аялалыг 6 дугаар сарын 21, 28, 7 дугаар сарын 05, 08-ны өдрүүдэд 4 удаа "Огтонотой булаг"-т зохион байгуулсан. Уулзалтад ирсэн хүүхэд бүр өөрсдийн уншиж судалсан номоо авчран бусад хүүхдүүдэд танилцуулах, номын тухай яриа, бяцхан хэлэлцүүлэг өрнүүлэх, танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн, спорт аяга өрөх тэмцээнд оролцох, шүлэг яруу найраг, хөгжим тоглох гэх мэтээр сонирхолтой, зугаатай өнгөрүүлсэн.

18. Баянхонгор аймгийн Баацагаан сумын харьяат, төрийн шагналт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит **"Хүрэн морь-2022"** яруу найргийн наадмыг аймгийн Зохиолчдын холбоо, Монголын Зохиолчдын эвлэлтэй хамтран 32 дахь жилдээ зохион байгууллаа. Наадамд Баянхонгор аймгийн 9 сум, Төв, Говь-Алтай, Ховд, Увс, Сүхбаатар, Завхан аймаг болон Улаанбаатар хотоос яруу найрагчид оролцож, бүтээлээ ирүүлснээс 2 дугаар шатанд 43 яруу найрагч тэнцсэн. Энэ удаагийн яруу найргийн наадмын шүүгчээр МЗЭ-ийн гүйцэтгэх захирал О.Энхжавхлан, утга зохиол шүүмжлэгч, судлаач Х.Чойдогжамц, аймгийн Зохиолчдын холбооны тэргүүн Б.Жавзандулам, утга зохиолч шүүмжлэгч, судлаач, Эрдэнэмандал ахлах сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Н.Энхбат, Соёл урлагийн газрын дарга Ц.Азбаясгалан нар ажиллаж, онооны нэгтгэлийг номын санч О.Наранцэцэг, Зохиолчдын холбооны нарийн бичгийн дарга Х.Тунгалаг нар, хөтлөгчөөр ахмад уран бүтээлч Д.Оюунсүрэн, яруу найрагч П.Баярсайхан нар тус тус ажиллалаа.

Найргийн наадам 4 үе шаттай явагдсан бөгөөд 2-р шатанд тэнцсэн 43 яруу найрагчаас 36 яруу найрагч шүлгээ уншиж, 3-р шатанд 18, 4-р шатанд 8 яруу найрагч тус тус шалгарлаа.

Дөрөвдүгээр шатанд шалгарсан 8 яруу найрагчаас **тэргүүн** байр буюу “Хүрэн морь-2022” цомын эзнээр Баянхонгор аймгийн Баянбулаг сумын харьяат, залуу яруу найрагч Дагдангийн Тунгалаг “Санаад л байна даа” шүлгээрээ, дэд байрт МЗЭ-ийн шагналт, зураач, яруу найрагч Мягмарын Амархүү “Том хашаа ба эрээн хорвоо” шүлгээрээ, гутгаар байрт Ховд аймгийн Мянгад сумын харьяат залуу яруу найрагч Цогоогийн Отгонбаатар “Үхэл ирж намайг авахад” шүлгээрээ, дөтгөөр байрт Эрдэнэцогт сумын харьяат залуу яруу найрагч Хадбаатарын Дамбажав “Өвгөн дэнлүү” шүлгээрээ, тусгай байрт Баянхонгор аймгийн Жаргалант сумын харьяат, ахмад яруу найрагч Долживын Жавхлан “Ижий аавыгаа санаад бичсэн шүлэг” шүлгээрээ, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын харьяат Доцоогийн Жаргалсайхан “Миний диваажин миний эх орон” шүлгээрээ, Баянхонгор аймгийн Заг сумын харьяат яруу найрагч Лхагвасүрэнгийн Батцэнгэл, Говь-Алтай аймгийн Чандмань сумын харьяат, яруу найрагч Ганхуягийн Сүхбаатар “Гүйж яваа морь” шүлгээрээ, Төв аймгийн Баянхангай сумын харъяат яруу найрагч Төөмөөгийн Батсуурь “Үзэгний өчил” шүлгээрээ тус тус байр эзэллээ.
Наадмын “Хүрэн морь” сийлбэр цом, шагналын санд 3.000.000 төгрөг зарцуулсан. “Тод од сод” ХХК, Өлзийт палас, “Молор эрдэнэ” бичиг хэргийн дэлгүүр, Буянт Богд супермаркет, Өгөөмөр-1 хүнсний дэлгүүр тус тус ивээн тэтгэж, хамтран ажилласан.

19. “Аймаг байгуулагдсаны 81 жил, Ардын хувьсгалын 101 жилийн ойн баяр наадам”-аар Мазаалай паркад зохион байгуулж буй арга хэмжээг хариуцан ажиллаж 2 өдрийн турш наадамчин олон, ард иргэд, хүүхэд багачуудад шинэ номын үзэсгэлэн, IQ хөгжүүлэх тоглоомын үйлчилгээ, монгол ёс заншилтай холбоотой уралдаан тэмцээнийг зохион байгуулж, говийн бүс, хангайн бүсийн урлагийн тоглолтоор үйлчилсэн. АХА тэмцээнд нийт 180 орчим хүн, шагай шүүрэх уралдаанд 48 хүн, спорт аяга өрөх тэмцээнд 45 хүүхэд, нийт 273 хүн, урлагийн тоглолт бусад үйл ажиллагаануудад 450 орчим хүмүүс хамрагдсан.

20. **“Номын баяр-Орон нутагт”** үйл ажиллагааг 9 дүгээр сарын 14-22 –ны өдрүүдэд говийн 8 сумыг хамруулан зохион байгууллаа. Номын баярын хүрээнд Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Баянговь, Баянлиг, Жинст, Богд сумын Соёлын төвтэй хамтран сумдын ард иргэд, хүүхэд багачуудад номын үзэсгэлэн толилуулж, “Номын хавчуурга” урлах уралдаан, АХА, “Алтан хонх”, “50 номын хожил” танин мэдэхүйн уралдаануудыг зохион байгуулж, нийт 2500 гаруй хүн хамрагджээ. Шагналын сан, үйл ажиллагааны зардалд нийт 5,000,000 төгрөг зарцуулсан.

21. Хүүхэд багачууд, өсвөр үеийнхнийг шүлэг, яруу найргаар дамжуулан монгол хэлний гайхамшигт ертөнц, үгийн баялаг сантай танилцуулж, санаа бодлоо уран яруу хэлээр илэрхийлж сурах, бүтээн туурвих шинэ үеийн яруу найрагчдыг дэмжих зорилготой “**Өсвөрийн яруу найрагч бид”** яруу найргийн уралдааныг 6-12 дугаар анги, коллежийн оюутнуудын дунд зохион байгууллаа. Тус уралдаанд 22 залуу яруу найрагч оролцсноос ангилал тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж, шагнаж урамшуулсан.

Дунд ангийн төрөлд: Тэргүүн байрын шилжин явах цомын эзнээр 5 дугаар сургуулийн 6Б ангийн сурагч Н.Эрхсаран, дэд байрт Баянцагаан сумын 8А ангийн сурагч Б.Ганбямба, гутгаар байр Номундалай цогцолбор сургуулийн 8Г ангийн сурагч М.Цэлмүүн нар тус тус шалгарлаа.

Ахлах ангийн төрөлд: Тэргүүн байрын шилжин явах цомын эзнээр Политеиникийн коллежийн ардын хөгжмийн 3 дугаар курсын оюутан С.Чинболд, дэд байрт Номгон ахлах сургуулийн 11/4/ ангийн сурагч Д.Даваасүрэн, гутгаар байрт Номгон ахлах сургуулийн 12/3/ ангийн сурагч Я.Ерөөлтбямба нар шалгарлаа. Шагналд 144000 төгрөг зарцуулсан.

22. Соёлын яамнаас санаачлан хэрэгжүүлж буй **“Соёлын бүтээлч сар”** аяныг 11 дүгээр сарын турш зохион байгууллаа. Аяны нээлтийг Хөгжимт драмын

театрт зохион байгуулж, шинэ болон ховор ном, орон нутгийн зохиолчдын нийт 155 номоор үзэсгэлэн гаргаж, 70 гаруй иргэд үзэж сонирхов. Байгууллагын Фейсбүүкээр Хонгор нутгийн яруу найрагчдын 60 гаруй зохиол, бүтээлийг сурталчилсан.

Аяны хүрээнд хэрэгжүүлсэн эхний ажил болох **“Урилгатай уншлага**” буюу ном уншлагыг дэмжих, эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, Номундалай, Соого сейко, Эрдэнэмандал, Баян-Ойт цогцолбор сургуулиуд идэвхтэй оролцож, 457 уншигчдад карт нээж 2249 ирцээр, 4240 ном олгож үйлчилжээ.

23. “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд **АХА, Алтан хонх** танин мэдэхүйн уралдаан, спорт аяга өрөх тэмцээнийг Номундалай, Соого сейкео, Эрдэнэмандал, Гэгээн сумади сургуулиуд, Политехник коллеж, Зэвсэгт хүчний 339-р анги, иргэдийн дунд 12 удаа зохион явуулж, нийт 415 хүн оролцлоо. Идэвхтэй оролцсон хүмүүсийг Өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.

24. “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд хүүхдүүдийн дунд зарлагдсан **“Номын хавчуурга урлах**” уралдаанд Номундалай, Номгон, Баян-Ойт, Соого сейкео, Гэгээн сумади, Тавдугаар сургуулиуд, Политехникийн коллежийн нийт 352 сурагчдын 641 бүтээл ирсэнийг ангилал тус бүрээр эхний 3 байр, нийт 9 хүүхэд, хамгийн олон хүүхдүүдийг хамруулж, идэвхтэй оролцсон шилдэг номын санчаар Номундалай сургуулийн номын санч Г.Туяацэцэг, Баян-Ойт сургуулийн номын санч Ж.Дуламсүрэн нар шалгарлаа. Уралдааны шагналын санд нийт 198.000 төгрөг зарцуулсан.

25. “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд үндэсний бичиг үсгээ түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, өвлүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор аймгийн төвийн төрийн байгууллагын дунд “**Хос бичигтэн”** уралдааныг зохион байгуулав. Тус уралдаанд Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Баян-Ойт, Соого сейкео, 5-р арван жилийн сургуулийн 25 багш ажилчдын нийт 25 бүтээл (кирилл болон монгол бичгээр хослуулан бичсэн бүтээл) ирснээс: Тэргүүн байрт Баян-Ойт сургуулийн бага боловсролын багш Б.Арсай, дэд байрт 5-р сургуулийн бага боловсролын багш Б.Цолмонтуяа, гутгаар байрт Эрдэнэмандал сургуулийн түүх нийгмийн багш С.Мөнхзул, тусгай байрт 5-р сургуулийн сургалтын менежер Э.Наранчимэг нар шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

26. Зохиолч яруу найрагчдын “**Яруусахуйн-Амирлал”** яруу найргийн цэнгүүнийг “Соёлын бүтээлч сар” хаалтын үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулав.Тус цэнгүүнд Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүн, Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит болон Утга зохиолын төлөө шагналт яруу найрагч Д.Жавхлан, Монголын Урчуудын эвлэлийн салбарын тэргүүн МУСТА зураач, яруу найрагч Г.Цэрэндорж, МУСТА, ахмад яруу найрагч Б.Байгальмаа нарын урын сангийн бүтээлээр үзэсгэлэнг гаргаж, иргэдэд сурталчлав. Тус үйл ажиллагаанд 50 гаруй хүн оролцлоо.

Дээрх **26 төрлийн соёл олон** нийтийн ажлыг зохион байгуулж, 6672 хүн хамрагджээ. Олон нийтийн ажлын үйл ажиллагааны зардалд байгууллагын төсөв, номын баярын зардлаас 10,900,850 төгрөгийг, ивээн тэтгэлгээр 5,188,400 төгрөгийг тус тус зарцуулжээ.

2.Мэдээллийн үйлчилгээ: Байгууллагын 15 компьютерын дотоод сүлжээ, LIB4U программын хэвийн ажиллагааг хангаж, вирустсэн компьютерийг форматалж, цахим үйлчилгээ явуулан, facebook хуудсыг соёл олон нийтийн ажил, сургалт, бусад мэдээ мэдээллээр тухай бүр баяжуулж, иргэдэд мэдээлж ажиллаа.

Байгууллагын үйл ажиллагаа, соёл олон нийтийн ажлын урилга, хөтөлбөр, өргөмжлөл, талархал, сурталчилгаа зэрэг хэвлэлийн үйлчилгээг хийж ажиллав.

Орон нутгийн номын сангийн цахим программын ашиглалтыг сайжруулан, хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

3.Удирдлагын ажил: Төрөөс баримтлах соёлын бодлого Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, номын

сангийн стандарт, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу гаргасан албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэн ажиллаж байна.

Байгууллагын хамт олны хурал 12 удаа, өмч хамгаалах байнгын зөвлөл 2 удаа, баримт нягтлан шалгах комиссын хурал 3 удаа тус тус хуралдав.

Нийт ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн энэ оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталж, шинэчлэгдсэн Хөдөлмөрийн хуультай нийцүүлэн ажилтан тус бүрээр хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулав.

Төрийн албаны ажил үйлчилгээг тасралтгүй, хэвийн явуулж, байгууллагад ажилд орсон, ажлаас гарсан ажилчдыг хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд тушаал шийдвэрийг гаргаж ажилласан. Үүнд, нягтлан бодогч Д.Баатархуягаас М.Мөнхбатад, нийтийн уншлагын таниимын омын санч О.Наранцэцэгээс Ц.Болорчимэгт, хүүхдийн уншлагын танхимын номын санч Ц.Сарантуяагаас Я.Гэрэлтуяад, харуулын ажилтан Б.Даваацэрэнгээс Ж.Оргилболдод, хүүхдийн танхимын номын санчаар түр ажиллаж байгаа Я.Гэрэлтуяагаас Б.Янжмаад, сан хөмрөгч Я.Гэрэлтуяагаас Б.Бүжидмаад тус тус ажил хүлээлцүүлэв.

Нийт ажилтнууд Улсын бүртгэлийн газраас тоон гарын үсэг авав.

<u>Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд</u> анхаарч, байгууллагын захиргаанаас ахмадуудад сар шинийн баярыг угтаж нийт 180,000 төгрөг, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан ажилчдын хүүхдүүдийг хүлээн авч баярлуулахад 550,000 төгрөг, ном зүйч Б.Должин, захирал Б.Түвшинчимэг, сүлжээний ажилтан М.Дондовжамц нарт эмчилгээний зардалд нийт 150,000 төгрөг, номын санч Ц.Болорчимэт хүүхдээ эмчлүүлэхэд 45,000 төгрөг, архив бичиг хэргийн ажилтан О.Байгалд архивын сургалтын 60,000 төгрөг, нягтлан бодогч Д.Баатархуяг, номын санч О.Наранцэцэг, харуул Б.Даваацэрэн нарыг ажлаас гарахад хүндэтгэл үзүүлж (мөнгөн аяга өгөхөд) 180,000 төгрөг, нийт 1,165,000 төгрөгийг зарцуулсан.

Шагнал урамшуулал:

Ажил хөдөлмөрөө төр, орон нутагтаа өндөрөөр үнэлүүлж, Монгол Улсын Засгийн газрын шагнал "Хөдөлмөрийн хүндэт" тэмдгээр ном зүйч Б.Должин, сан хөмрөгч Я.Гэрэлтуяа нар, Баянхонгор сумын "Хөдөлмөрийн аварга" ажилтнаар номын санч О.Наранцэцэг, Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар ном зүйч Б.Должин, сан хөмрөгч Я.Гэрэлтуяа нар, Соёлын яамны "Жуух" бичгээр архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал, үйлчлэгч А.Уранчимэг нар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дээд шагнал "Соёрхол" одонгоор гэрээр ном олгох тасгийн номын санч Б.Бүжидмаа, аймгийн Засаг даргын "Жуух" бичгээр харуул хамгаалалтын ажилтан Б.Даваацэрэн нар, Баянхонгор аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн медалиар нийт ажилтнууд тус тус шагнагдсан.

4. Албан хэрэг хөтлөлтийн ажил: Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг шинэчлэгдсэн хууль, холбогдох журам, баримт бичигийн MNS 5140:2021 стандартын дагуу хөтлөн явуулж, хууль, журмуудыг ажилтнуудад дотоод сүлжээгээр тарааж, сурталчлан таниулж, мөн сургалт явуулсан.

Ирсэн бичиг 112, үүнээс хариутай бичиг 70, явсан бичиг 81, ирсэн захирамж, тогтоол 7, тушаал 42, түр олгосон баримт 2 байна. i-office программыг үйл ажиллагаандаа ашиглаж, байгууллага хооронд харилцаж байна. Иргэд болон ажилчдаас нийт 10 өргөдөл ирсэнийг бүртгэн, хугацаанд нь шийдвэрлүүлж, өргөдөл, гомдлын мэдээг улирал тутамд Соёл, урлагийн газарт мэдээллэж байна. Иргэдээс санал гомдол ирээгүй.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн хэрэгжилт, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт бусад тайлан хэрэгжилтийг нэгтгэж Соёл, урлагийн газарт цаасаар болон файлаар хүргэв.

Соёл урлагийн СУ мэдээг шинэ маягтаар гаргаж Соёл урлагийн газарт хүргэж, бусад ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэлээ.

Тамга, тэмдэг, албан хэвлэмэл хуудасны тооллого: Байгууллагад хэрэглэгддэг 7 төрлийн тэмдэг, мөн 7 төрлийн хэвлэмэл хуудсыг захирлын тушаалаар томилогдсон комиссын дарга, гишүүд нүдээр үзэн тоолов. Тэмдэг, хэвлэмэл хуудасны ямар нэг зөрчилгүй, тооллогыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, Архивыг тасагт тайлан хүргэв.

Архивын ажил: Ажилчдаас ирүүлсэн санал болон өмнөх оны хөтлөх хэргийн жагсаалт, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үндэслэн 2022 оны хөтлөх хэрэгт 150 нэгж баримтыг тусган жагсаалтыг боловсруулж, Төрийн архивын тасагт хугацаанд нь хүргэв.

Нийт ажилтнуудаас 2021 оны баримтыг бүртгэлээр авч, байнга 52, түр 70 жил 4, түр 10 жил хадгалах 63 баримтын бүртгэл гаргав. Номын санч О.Наранцэцэг, Ц.Сарантуяа, нягтлан бодогч Д.Баатархуяг нар өөрсдийн баримтаа эмхлэн цэгцэлж, үдэж өгсөн.

“Төрийн болон байгууллагын архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, архивын 2021 оны баримтуудыг хамгаалалтын хайрцагт хийж, тавиурт байрлуулав.

Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын үндсэн санд 2019 оны байнга хадгалах 575 хуудас бүхий 57 нэгж баримтыг цаасаар болон цахим хувиар дансны хамт шилжүүлэв. Баримтыг сканердаж, мастер болон ашиглалтын хувь үүсгэн, баримтын нүүр, ашиглалтын хуудас, дотоод товьёг, баталгааны хуудас бичиж, үдэж хавтаслав. Баримт шилжүүлэхэд картон 57 ширхэг, бичгийн цаас 2 боодол, утас зүү, DVD 2 ширхэг, принтерийн хор 1 ширхэг тус тус хэрэглэгдсэн. Төрийн архивын AMS программд баримтын өгөгдлүүдийг хүний нэр, газар зүйн нэр, байгууллагын нэрээр шивж оруулав. Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын 1 хувийг DVD-д хуулж, байгууллагад хадгалж байна.

Тусгай төрлийн баримт бүрдүүлэлт: Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны гэрэл зургаар цомог бэлтгэн, зааврын дагуу эмхлэн цэгцэлж, Төрийн архивын санд хугацаанд нь хүлээлгэн өгч, хадгалуулав. Цомогт 37 ширхэг гэрэл зураг орсон. Зургийг угаалгах, зурган файл бэлтгэн өгөхөд DVD болон хайрцаг тус тус 2 ширхэг, картон, бичгийн цаас, принтерийн хор, цавуу хэрэглэгдсэн.

5. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын хүрээнд: Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын жилийн төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Covid-19 эсрэг анхааруулга, санамжийг коридор, танхимууд, мэдээллийн самбарт байршуулсан.

ХАБЭА-н журам, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн гаргалаа.

Аюулгүй ажиллагааны зааврууд гаргаж, ажилтнууд тус бүрээр гарын үсэг зуруулан, захирлаар батлуулсан.

Номын санч, харуулын ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийв.

Шавьж устгал, ариутгалыг Акос компаниар 1 удаа хийлгэж, төлбөрт 60,000 төгрөг зарцуулсан.

6.Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Гамшгаас хамгаалах орон тооны бус зөвлөлийн ажилтнууд төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж, хөл хорио цар тахлын үед байгууллагад 3 удаагийн ариутгал халдваргүйтлыг хийлгэн ажилласан.

7.Авлигатай тэмцэх ажлын хүрээнд: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг оны эхэнд гарган, удирдлагаар батлуулан, хэрэгжилтийг бүтэн жилээр гаргаж хэвшсэн. Авлигын эсрэг хууль, Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгаар тус бүр гарын авлага бэлтгэн 54 уншигчид танхимаар сурталчилсан.

Мөн байгууллагын Фейсбүүк хуудсанд авлигын эсрэг мэдээлэл, постор, хуулиудыг оруулан, аймгийн группүүдэд шэйр хийн түгээж байршуулсан. Төсвийн мэдээллийн самбарт төсвийн хуваарь гүйцэтгэлийн мэдээг тогтмол солиход байнга хяналт тавин ажиллаж байна.

8.Залуучуудын зөвлөлийн ажил:

9.Санхүү, бүртгэлийн ажил: Нийт батлагдсан төсөв 185,418,700 төгрөг, үүнээс үндсэн цалин 97,137,000 төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 12,142,000 төгрөг, урсгал зардал 17,708,700 төгрөг, ном хэвлэл худалдан авахад 14,136,000 төгрөг, номын баярын арга хэмжээний зардалд 10,000,000 төгрөг, 11 сарын байдлаарх дансны эцсийн үлдэгдэл 34,295,000 төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 7,160,000 төгрөг байна.

Соёлын яамнаас номын баяр арга хэмжээний зардалд **10.000.000** төгрөг, шинэ ном хэвлэл худалдан авахад **9.750.000** төгрөг, бусад үйл ажиллагааны зардалд **5.000.000** төгрөг тус тус нэмэгдэж орж ирсэнийг төсвийн хуулийг баримтлан зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэр, Соёлын яам, Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан журам, шийдвэрийг хэрэгжүүлэн, санхүү бүртгэлийн тайланг цаг тухайд нь гаргаж, шилэн данс, төсвийн мэдээллийн самбараар дамжуулж иргэд, уншигчдад санхүүгийн ил тод байдлыг мэдээлж ажилласан.

Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулан, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтын маягтын дагуу 13 нэр төрлийн баримтыг шинэчлэн хөтөлж ажилласан.

Байгууллагын хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогыг захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн дарга, гишүүд хугацаанд нь чанартай явуулсан. Албан хаагч, ажилтны эд хөрөнгийн картаар нэг бүрчлэн тоолж, өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж ашиглах боломжгүй бараа материалыг эд хөрөнгийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэв.

10. Цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын ажил: Үйлчлэгч, харуул, жолоочийн албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийг биелүүлэн, өрөө танхимууд, коридорын цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ. Ээлж хүлээлцэхдээ рабортын дэвтэрт тухайн ээлж гараатай өдөр болж өнгөрсөн үйл явцыг тодорхой тэмдэглэн, эд хөрөнгийг бүртгэн бичиж, өрөө тасгуудын лац ломбыг шалган хүлээн авч, хүлээлгэн өглөө.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болон Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд хамт олноороо Шинэ суурьшлийн бүсийн зам дагуух ногоон зурвас газарт байгууллагын хариуцсан талбайд 65 нүхэнд 100 ширхэг мод тарьж, усалгаа хийсэн. Ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, хаягжуулалт хийв. Долоо хоногт 1 удаа усалгаа хийж байна.

Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны А/58 дугаартай “Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд байгууллагын хамт олноор Есөнбулаг 9 дүгээр багт Цэргийн ангийн баруун талын нийтийн эзэмшлийн талбайд их цэвэрлэгээ хийсэн. Хог хаягдлыг цэвэрлэн 10 шуудайд хийж хогийн машинд ачуулсан. Хог цэвэрлэсэн тухай тайланг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт хүргэсэн.

Цахилгаан, сантехникийн жижиг гэмтлүүдийг засаж, сэлбэн ажиллав.

Жолоочийн ажлын байрны тодорхойлолт, “Ажлын хэрэгцээний автомашин ашиглах, хэрэглэх” журмыг мөрдөж, байгууллагын пургон автомашиныг техникийн үзлэг оношлогоонд цаг хугацаанд нь оруулж, шаардлагатай засварыг хийсэн.

11. Шинэ бүтээлч ажил:

Орхон аймгийн номын сангийн ном зүйч Ч.Эрдэнэсувд, Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн номын санч О.Наранцэцэг нар хамтран зохиолч Б.Номинчимэдийн “ЦАГААН БОРОО” түүхэн романы тухай номын цахим хэлэлцүүлгийг цахим орчинд зохион байгууллаа.

Орон нутгийн номын сангуудын сан хөмрөгт тооллого хийх ажлын хүрээнд энэ оны 10, 11 дүгээр сард Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Заг, Жаргалант, Гурванбулаг, Баянбулаг сумдад тус тус номын бүртгэл тооллогыг явууллаа. Тооллогыг БСШУСайдын А/500 дугаар тушаалаар батлагдсан “Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журам”-ын дагуу зохион байгуулахадданс, бүртгэл зөрүүтэй, ангилал буруу оруулсан гэх мэт зөрчлүүд байгааг илрүүлж, сум тус бүрд тооллогын акт үйлдэж, номын санчдад заавар зөвлөгөө өгөв. /зураг/

12. Төлөвлөгөөнөөс бусад цаг үеийн ажил:

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Илүүдэд жингүй-Эртэч Монгол” идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжих аянд хамт олноор нэгдэж Биеийн тамир, спортын газартай хамтран дасгал хөдөлгөөнөөр хичээллэж, аймаг орон нутгаас зохион байгуулсан “Хог бишээ мөнгө” аян, мод тарих өдөр, их цэвэрлэгээний өдөр зэрэг ажлуудад хамт олноороо тасралтгүй оролцож ирсэн.

Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачлагыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилготойгоор аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс “Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба-II” 3 сарын аяныг зарласан. Тус аяны “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлье, шинэчлэлийг шилдгээсээ суралцъя” төрийн албан хаагчдын шинэ санал, санаачлагыг дэмжих зорилтын хүрээнд “Тэргүүний уншигч” Нацагдорж тэмдэгтэн, номын сангийн идэвхтэн уншигч, зорилтот бүлгийн иргэн Ц.Мөнхцэцэгт цүнх, ном, хичээлийн хэрэглэл, 2 ээлжийн хувцас олгож, үсчин, гоо сайхны үйлчилгээнд хамруулж нийт 403.500 төгрөгийн тусламж үзүүллээ.

Дүгнэлт:

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж үзэхэд нийт 75 ажил төлөвлөсөнөөс 72 ажил арга хэмжээ бүрэн биелэгдсэн, Соёлын сайдтай байгуулсан гэрээний хүрээнд Соёл, урлагийн газрын даргатай хамтран ажиллах төлөвлөгөөнд 9 ажил үйлчилгээ орсоноос 6 ажил 100 хувийн гүйцэтгэлтэй 2 ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт гүйцэтгэл 93.7 хувьтай гэж үзэж байна.

Ололтой зүйлүүд:

- Соёл танин мэдэхүй, соён гэгээрлийн ажлуудад хамрагдаж, оролцож буй иргэдийн тоо өмнөх онуудаас өссөн.
- Номын сангийн LIB4U программыг орон нутгуудад нэвтрүүлсэнээр сум орон нутгийн номын сангуудад номын тооллого хийх ажил түргэн шуурхай болж, номын дүн, мэдээ, уншигчийн тоо, ном олголтын мэдээ тайлан үнэн зөв гарах давуу

талтайгаас гадна өөрийн номын байхгүй ном хэвлэлээ бусад номын сангаас хайн олж, хоорондоо солилцон ашиглах боломжтой болсон.

❖ "Номын баяр-Орон нутагт" арга хэмжээг зохион байгуулсанаар номын баярын утга учир, ном уншихын ач холбогдлыг хөдөө орон нутгийн хүүхэд багачууд ард иргэд мэдэж, орон нутгийн хэмжээнд цаашид өөрсдөө зохион байгуулах үр дүнтэй ажил болсон

❖ Номын сангийн сан хөмрөг өмнөх онуудад баяжигдаж байгаагүйгээр баяжигдаж, дутагдалтай хүрэлцэхгүй байсан ном хэвлэлүүдээ нэмэн авч, орон нутгийн номын сангуудад ном солилцоогоор ном явуулах нөөц боломж бүрдсэн.

Дутуу биелэгдсэн ажлууд болон цаашид анхаарах ажлууд:

❖ Номын тооллого хийх ажил 17 сумд хийхээс 9 сумд хийгдсэн
❖ "Номын баяр-Орон нутагт" үйл ажиллагаа 50 хувийн гүйцэтгэлтэй
❖ Уншигчийн төлөвлөгөө, ирцээр уншигчийн гүйцэтгэл 87.9 хувь, ном олголтын гүйцэтгэл 59.8 хувьтай байна.

БУЛГАН АЙМГИЙН С.УДВАЛЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. АЛСЫН ХАРАА	**ЭРХЭМ ЗОРИЛГО**
Чанартай үйлчилгээ	Мэдээллийг түгээе
Чадварлаг хамт олон	Мэдлэгийг цогцлооё

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Үндэсний соёлын үнэт өв ном хэвлэлийг хадгалж хамгаалах, сурталчилан таниулах, ард иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэл, соёл олон түмний ажлаар дамжуулан соён гэгээрүүлэх, бүтээлч уншлагыг дэмжин үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчин	
Давуу тал ➢ Шинэ барилгын зураг төсөв хийгдсэн ➢ Мэргэжлийн удирдлагатай ➢ Байршил сайтай ➢ Соёл олон нийтийн ажлын зохион байгуулалт сайн ➢ Ном хэвлэл 100% цахим каталогт орсон ➢ Уншигчийн бүртгэл, ном олгох үйлчилгээ 90% цахим болсон ➢ Бүх албан хэрэгцээнд ашиглаж байгаа компьютерууд вирусын хамгаалалт, нэмэлт hard суулгаж багтаамж, хурдын сайжруулсан	Сул тал ➢ Дохиолол хамгааллын системгүй ➢ Агааржуулалт, ариун цэврийн өрөө дотор ОО байхгүй ➢ Сантехник, цахилгааны монтаж муу ➢ Заал танхимын багтаамж хүрэлцээ бага ➢ Цахим сан хөмрөг бага
Гадаад орчин	
Боломж ➢ Соёлын яамтай болсон ➢ Төсөл хөтөлбөрт хамрагдах ➢ Номын сангууд болон төр бус байгууллагууд хамтын ажиллагааг сайжруулах ➢ Номын сангууд нэгдсэн каталог, програм ашиглах ➢ Нэгдсэн нэг ангилал ашиглах ➢ Гадаадын хөрөнгө оруулалт татах	Аюул ➢ Барилга МХГ, ОБГ зэрэг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтүүд гарсан, ашиглалтын хугацаа дууссан ➢ Улс орныг хамарсан гэнэтийн /Ковид 19 гэх мэт/ гамшиг ослын нөхцөл байдлын эрсдэл

2.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

2022 онд Аймгийн засаг дарга, Соёл урлагийн газартай гүйцэтгэлийн гэрээ байгуулан 3 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж

100% үр дүнтэй - 24

70-99% тодорхой үр дүнд хүрсэн -15

31-69% Эрчимжүүлэх шаардлагатай -0

0-30% үр дүнгүй -1 ажил хэрэгжилтийн дундаж 91,0%-тай үнэлэгдлээ.

Номын сангийн шинэ барилгын зураг төсвийг хийлгэж Соёлын яаманд бүрэн хянуулсан. Улсын төсөвт тусгуулахаар хүлээгдэж байна.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны төлөвлөгөөнд 8 ажил хийж гүйцэтгэхээр тусгаж 100% хэрэгжүүлсэн.

Ажиллагсадын 2022 оны 03 сарын 28-ны өдрийн хурлаар байгууллагын дотоод журамд шинэчлэл өөрчлөлт хийсэн. Дотоод журамд өөрчлөлт оруулахдаа аймгийн Хууль зүйн хэлтэсээс хууль эрх зүйн зөвлөгөө авч ажилласан. Хөдөлмөрийн дотоод журамд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн заалтуудыг тусгаж өгсөн.

Аймгийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм, цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх журам, Соёлын ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох, улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам, орон нутгийн өмчийн Соёлын байгууллагын Соёлын ажилтанд тэтгэмж олгох журамын төсөлд ажиллагсад саналаа тусган хүргүүлсэн.

АНУ-ын элчин сайдын яамны төлөөлөгчийн газарт Америк соёл мэдээллийн төвийг Булган аймагт номын санг түшиглэн байгуулах санал хүргүүлсэн.

“Хүүхдийн бүтээлч уншлага” аяныг удирдамж гарган Булган сумын хэмжээнд зохион байгуулж 13 ангийн 360 хүүхдийг хамруулж гарааны сорил, ахицын үнэлгээг гарган шалгаруулла. 2023 онд энэхүү аяныг аймгийн хэмжээнд зарлахаар удирдамжийг боловсруулсан.

Хутаг-Өндөр сумын номын санг аймгийн хэмжээнд сан хөмрөгийн зохион байгуулалт, анхан шатны бүртгэл хөтлөлтөөр “Жишиг номын сан” болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлж 2022 оны 7 сард Соёл урлагийн газар, Төв номын сангаас зөвлөн туслах баг ажиллуулсан.

АЗД-ын тэтгэлэгт 12 дугаар анги төгссөн 1 хүүхдийг хамруулж СУИС-ийн Соёлын сургуульд номын санчаар, мэргэжлийн бус 2 номын санчийг СУИС-ийн Соёлын сургуульд эчнээгээр суралцуулж байна.

Номын сангийн хамт олон Төв, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн номын сангуудаар туршлага судлах аялалыг зохион байгуулсан.

Ажиллагсадын дунд үндэсний бичиг, англи хэл, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж жилийн ажлаа дүгнэлээ.

3.УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ

Уншигч: 2577 Үүнээс байнгын 1943, шинэ 634 байна.

Ирэгсэд: 15740

Ном олголт: Нийт олгосон 13691. Үүнээс ном-12972**,** сонин- 719 байна. Уншлагын танхимаар 8402, гэрээр 2319 , зөөврөөр 2853, цахимаар 67 байна.

Ном хангамж: $\dfrac{\textbf{НФ-35775}}{\textbf{У-2577}}$ **= 138**

Ном уншилт: $\dfrac{\textbf{НО-13691}}{\textbf{У-2577}}$ **= 5,3**

НО-13691

Фондын эргэлт: ———————— **= 38,2%**

НФ-35775

2010-2022 оны уншигч, ирэгсэд, ном олголтын тоон үзүүлэлтийг харуулав



4.ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

21 газарт 128 удаа 849 уншигч, 6289 ирэгсэдэд 2853 номоор үйлчилсэн.

2015-2022 оны нүүдэл, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн тоон үзүүлэлт

2015-2022 оны нүүдэл, зөөврийн үйлчилгээний
уншигч, ирэгсэд, ном олголтын тоон үзүүлэлт
Уншигч
Ирэгсэд
Ном олголт
1426
4365
4900
677
2708
750
757
4300
4446
1713
3607
7754
872
2548
2153
67
1562
3926
186
610
328
849
6289
2853
2015
2016
2017
2018
2019
2020
2021
2022

НҮҮДЭЛ ЗӨӨВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

№	Байгууллагын нэр	Давтамж	Хамтран ажилласан	Он,сар, өдөр	Уншигч	Ирэгсэд	Ном олголт	Хариуцсан номын сан
1	ШШГГ-ын харьяа 439-р анги	2	Хууль зүйн хэлтэс	2.24	6	36	40	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, Сан хөмрөгч Б.Ариунжаргал
2	Насан туршийн боловсролын төв	1	Насан туршийн боловсролын төв	3	10	22	32	Аргазүйч Б.Эрдэнэцацралт
3	Булган хангайн МСҮТ-д	1	МСҮТ	4.28	3	142	9	Аргазүйч Б.Эрдэнэцацралт
4	Аймгийн мэргэжлийн хяналтын газар	1	МХГ	5.3	0	18	0	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, номын санч Ц.Долгор
5	Ахмадын хороо	1	Ахмадын хороо	5.06	3	84	9	Арга зүйч Б.Эрдэнэцацралт Номын санч Ц.Долгор
6	ОУ-ын хүүхдийн баярын өдөрт	1		6.01	70	1000	70	Номын санч Ц.Долгор
7	Айраг наадам-2022	1	СУГ	8.13	151	1200	200	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, номын санч Д.Мөнхгэрэл
8	1-р баг	5	Багийн хөгжлийн төв	06.28-6.30	19	141	40	Номын санч Г.Энхбилэг, Ч.Мөнхцэцэг
9	2-р баг	5	Багийн хөгжлийн төв	06.20-06.24	28	146	42	Номын санч Г.Энхбилэг, Ч.Мөнхцэцэг
10	3-р баг	5	Багийн хөгжлийн төв	06.20-06.24	49	172	70	Номын санч Ц.Долгор, Д.Мөнхгэрэл
11	4-р баг	5	Багийн хөгжлийн төв	06.20-06.24	32	131	63	Номын санч Ц.Долгор, Д.Мөнхгэрэл
12	5-р баг	5	Багийн хөгжлийн төв	06.28-6.30	36	145	80	Номын санч Ц.Долгор, Д.Мөнхгэрэл
13	6-р баг	5	Багийн хөгжлийн төв	06.28-6.31	52	176	54	Номын санч Г.Энхбилэг, Ч.Мөнхцэцэг
14	ЭӨЦС	39	ЭӨЦС-ийн монгол хэл, анги удирдсан багш нар	02.01-11.26	212	1275	965	Номын санч Г.Энхбилэг, Ц.Долгор
15	1-р 12 жил	38	1-р 12 жилийн монгол хэл, анги удирдсан багш нар	02.01-11.26	136	1350	981	Номын санч Г.Энхбилэг, Ц.Долгор
16	3-р сургууль	5	3-р 12 жилийн Монгол хэл, анги удирдсан багш	02.01-06.15	13	174	87	Номын санч Ц.Одмаа, Мөнхцэцэг
17	Онцгой байдлын газар	2	Сургалт хариуцсан	9.27	12	32	29	Номын санч Б.Ариунжаргал
18	ТЭС ШТС	1	Эрхлэгч Д.Лхагважав	9.28	12	25	18	Номын санч Б.Ариунжаргал
19	Шүүх	1	Хэлтсийн дарга Г.Ангирмаа	9.3	1	10	1	Номын санч Б.Ариунжаргал
20	Орхон Соёлын төв	1	Номын санч Б.Амарцэцэг	11.08	1	7	60	Номын санч Б.Ариунжаргал
21	Зөөврөөр ном хүргэлтийн үйлчилгээ	3	6-р баг	11.01-11.30	3	3	3	Номын санч О.Анар
	Нийт	128			849	6289	2853	

5.САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ

2022 онд нийт 448 нэр төрлийн 958 ширхэг 14304250 төгрөгний номоор фонд баяжилт хийсэн. Үүнээс улсын төсвөөс худалдаагаар 187 нэр төрлийн 674 ширхэг 9774200 төгрөгний, бэлгээр 261 нэр төрлийн 284 ширхэг 4530050 төгрөгний номоор 27 удаа орлого авсан байна. Шинээр баяжилт хийсэн ном хэвлэлийн 100% данс бүртгэл, програмд оруулж уншлага үйлчилгээнд гаргасан.



Ном хэвлэлийг програмд бүртгэсэн мэдээ:

6.САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Мэргэжлийн байгууллагаар 1 удаа ариутгал, 2 удаа шавьж устгал хийж 211800 төгрөгний төсөв зарцуулсан.

Сан хөмрөгийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж 482,000 төгрөгөөр 5 м сунадаг А шат авч ашиглаж байна.

2005-2018 оны орон нутгийн тогтмол хэвлэл болох “Булганы мэдээ” сонины 1790 нүүр хуудсыг фото зургаар авч файлаар цахимд хадгалсан.

Үндсэн фондын ээлжит тооллого, уншлагын танхимуудын ээлжит бус тооллогыг хийж тооллогоор үндсэн фонд, гэрээр ном олгох танхимаас уншигчийн гар дээр байгаа, уншигчийн үрэгдүүлсэн, солилцоогоор явуулсан нийт 265 тоологдоогүйгээс үрэгдүүлсэн 99 номыг алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журмын дагуу төлүүлж жилийн эцэст данс бүртгэл авлаа. Уншигчийн гар дээр байгаа үлдсэн 166 номыг татан авалт хийж тоолж байна.

Фондын даац эмх цэгцийг сайжруулах зорилгоор уншлагад гарахгүй эргэлтэд орохгүй олон хувьтай буюу 5-аас дээш тоотой байгаа номыг 2-3 ширхэгийг үлдээн актлахаар ангилан ялгалт хийлээ.

Нийт 134 номыг сэлбэн зассан.

- Үндсэн фонд, Гэрээр ном олгох танхим- 38
- Хүүхдийн уншлагын танхим-60
- Нийтийн уншлагын танхим-36

7. ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Нийт 5544 лавлагаа өгөгдсөн. Үүнээс утсаар 1742, цахимаар 1832, амаар 1849, бичгээр 123 байна. Өгөгдсөн лавлагаа заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор харуулав. Өгөгдсөн лавлагааны тоо нэмэгдсэн нь лавлагааны бүртгэлийг хялбар аргаар тэмдэглэл хөтлөж туршсан. БШСУ-ны сайдын 2005 оны 441 дүгээр тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэл”-ийн маягтыг орчин цагийн үйлчилгээний стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

- ✓ Хүүхдийн уншлагын танхим-949 /Үүнээс амаар 394, цахимаар 329 утсаар 269 бичгээр 7
- ✓ Нийтийн уншлагын танхим-1186 / Үүнээс амаар 467, цахимаар 386, утсаар 325 бичгээр 8
- ✓ Гэрээр ном олгох танхим-1041 /Үүнээс амаар 402, цахимаар 339, утсаар 289 бичгээр 11/
- ✓ Арга зүйч-2280 /Үүнээс амаар 586, цахимаар 788, утсаар 859 Бичгээр 97/ номын санчдад 1530 лавлагаа өгөгдсөн байна.



8. ТАТГАЛЗАЛ:

Нийт 167 ном татгалзалд бүртгэгдсэн. 167 татгалзлаас хариулсан 112 татгалзал байна. Татгалзалд бүртгэгдсэн номноос бүрдүүлэлтээр 37 ном худалдан авсан.

- Хүүхдийн уншлагын танхим- 8 хариулсан 4
- Нийтийн уншлагын танхим- 138, хариулсан 99
- Гэрээр ном олгох танхим-21 хариулсан 9

Татгалзлын бүртгэлээс бүрдүүлэлт хийсэн номын жагсаалт

1. Цагаан бороо
2. Жаран цагаан хонь
3. 2022 оны элсэлтийн ерөнхий шалгалтын номнууд
4. Өрөг, тунхаг, тамга
5. Алтанхүү мөнгөнхүү хоёр
6. Power
7. Нил ягаан /secret-2/
8. Гашуун кофе
9. Байтаг богдын нүргээн
10. IELTS-800
11. Англи хэл сурах нь
12. Монгол бичиг сурах
13. Тодко Самсон Тэмүүлэл
14. Ээж
15. Хойд эх
16. Хөх шуурга
17. Урсгал-1,2
18. Тэмүүлэл тэнхэрэл
19. Шамарга
20. Жарны туульс
21. Харц хатан
22. Үзэхийн хязгаар
23. Хэрсүү охины өдрийн тэмдэглэл /1-6/
24. Цондоолэй Цүндээлэй /1-21/
25. Динза /1-46/
26. Есөн-Эрдэнэ хүү
27. Есөн-Эрдэнэ охин
28. Би бодохдоо /1-12/
29. Зоримог эмэгтэй
30. Миний түүх
31. Пиццаны шилдэг жор
32. Тулуй эзэн
33. Өгөөмөр охин Өүлэн
34. Эрдэмт охин Сорхугтан
35. Зоригт хүү Модунь
36. Нөхөрсөг хүү Тэмүжин
37. Мэргэн хүү Өгэдэй

9. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ

17 сум 1 тосгон, 19 сургуулийн номын санчдад утсаар цахимаар 1530 удаагийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

АТНС мэргэжлийн боловсон хүчин 8 байхаас 5 ажилтан мэргэжлийн 2 номын санч эчнээгээр суралцаж, 1 мэргэжлийн бус ажилтантай боловсон хүчний хангалт 62.5%-тай байна

Орон нутгийн номын санчдаас 17 сумаас 5 номын санч, 22 сургуулийн номын санчаас 5 номын санч мэргэжлийн байна. Сумын номын санчдын 29.4%, сургуулийн номын санчдын 22.7% нь мэргэжлийн ажиллагсад байна. Аймгийн хэмжээнд номын сангийн мэргэжлийн боловсон хүчний хангалт 38.9%-тай байна.

Хутаг-Өндөр сумын номын санг сонгон 2022 оны 7 сарын 4-8-ны өдрүүдэд зөвлөн туслах баг ажилласан. Номын данс шинэчлэх програмд оруулах ажил 80%-тай байна.

Баяннуур, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, ЭӨЦС, МСҮТ-ийн номын санчдад биечлэн номын сангийн программ дээр хэрхэн ажиллах, өдөр тутмын бүртгэл

хөтлөлт, номын ангилал, фонд зохион байгуулалт, СОНА зохион байгуулах зэрэг мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Сум, сургуулийн номын санчдад анхан шатны бүртгэл хөтлөлт, сан хөмрөгийн зохион байгуулалтаа сайжруулах цахим сургалтыг захирал Т.Мөнгөнтуяа зохион байгуулж 15 номын санч хамрагдсан.

2022 оны 10 сарын 6-7-ны өдрүүдэд "Орон нутгийн номын санчдыг чадавхжуулах нь" 2 өдрийн сургалтыг Монгол Улсын Үндэсний номын сангийн Мэдээлэл, арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Т.Хайдав, арга зүйч В.Түвшинтогтох нарыг урьж мэргэжлийн чиглэлээр сүүлийн үеийн шинэлэг мэдээллүүдээр зохион байгууллаа. Сургалтад Булган аймгийн сум, сургуулийн 27 номын санч Орхон аймгийн номын сангийн 8 номын санч хамрагдсан. Рашаант, Бугат сумын номын санчид, Гурванбулаг, Дашинчилэн, Сэлэнгэ, Хангал, ЭӨЦС, 3-р сургуулийн номын санчид шалтгаангүйгээр ирээгүй.

Сум, сургуулийн номын санчдын дунд "Ур чадварын уралдаан"-ыг анх удаа 3 үе шаттайгаа амжилттай зохион байгуулж 27 номын санч оролцсон.

10.НОМЗҮЙ

Шинээр нэмэгдсэн 929 ширхэг номыг анхан шатны бүртгэлд тусган техник ажиллагааг хийж, цахим каталогт оруулж заал танхимуудад хувиарлан уншлаганд гаргасан.

Хүүхдийн уран зохиол, Булганы түүх, лавлагааны номоор санамж өгөх номзүйн гарын авлага гаргасан.

2005-2018 оны хоорондох орон нутгийн тогтмол хэвлэлийн 1790 нүүр хуудсаар цахим сан үүсгэсэн.

Булган аймгийн түүхийн сэдэвт 10 номыг QR кодоор танилцуулга хийж цахимд байршуулсан.

11. КАТАЛОГ

Манай цахим каталогийн bulgan.lib4u.net хаягаар 5276 удаа уншигч, хэрэглэгчид хайлт хандалт хийсэн байна. Манай электрон каталогт 16,507 төрлийн 36,614 ширхэг материал бүртгэгдсэн байна. Номын тоо данс бүртгэлээс зөрүүтэй харагдаж байгаа нь актласан номыг цахим каталогоос хасалт хийгээгүй байгаатай холбоотой. Энэхүү ажил жилийн эцсийн байдлаар хасалт хийгдэж байна.

12. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН, СУРТАЛЧИЛГАА

59 удаа 3043 ширхэг номоор танхимаар болон цахимаар үзэсгэлэн гаргаж 5753 хүн үзсэн.

13. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

33 сургалтад давхардсан тоогоор 176 ажилтан хамрагдсан. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулав.

Сургалтууд				
2022.12.31				
№	Сургалтууд	Зохион байгуулсан газар	Хугацаа	Оролцсон хүний тоо
1	СУИС, СУГазар хамтарсан СУИС-ийн дэд захирал, доктор профессор Ж.Эрхэмтөгсийн "Соёлын бүтээлч үйлдвэрлэл" сургалт	Соёлын ордон	2.2	10
2	Татварын хэлтэсээс "Татварын тайлан хөнгөлөлт чөлөөлөлт" сэдвээр сургалт	Мэдээлэл аргазүйн танхим	2.4	10
3	Авлигаас урьдчилан сэргийлэхэд удирдах ажилтны үүрэг оролцоо	Цахимаар	2.22	2
4	Булган аймгийн соёл, урлагийн ажилтнуудын мэдээлэл солилцох сургалт	ХЖТ	3	10
5	МҮНС-ийг мэдээлэл, арга зүй, эрдэм шинжилгээний хэлтэсээс зохион байгуулж байгаа "Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №1	Цахимаар	3.3	7
6	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №2	Цахимаар	3.1	7
7	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №3	Цахимаар	3.17	7
8	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №4	Цахимаар	3.24	7
9	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №5	Цахимаар	3.31	7
10	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №6	Цахимаар	4.05	7
11	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №7	Цахимаар	4.12	7
12	Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт №8	Цахимаар	4.19	7
13	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	1.5	1
14	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	1.26	2
15	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	2.7	2
16	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	2.16	1
17	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	5.19	2
18	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	10.11	1
19	ТАХ-ын 7:4:10 сургалт	Цахимаар	11.17	1
20	ТАЦНС-ийн сургалт	Цахимаар	4 сар	2
21	ТАЦНС-ийн сургалт	Цахимаар	7 сар	1
22	ТАЦНС-ийн сургалт	Цахимаар	11.29	2
23	Шилэн дансны сургалт	Цахимаар	11 сард	1
24	Булган аймгийн соёлын салбарын залуучуудын уулзалт	Соёлын ордон	5.12	4
25	"Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний хөгжлийн үе шатууд" лекц	АЗДТГ	5.31	10
26	Соёлын бүтээлч үйлдвэрлэл сургалт	СУГ	9.26	10
27	Сум, сургуулийн номын санчдад анхан шатны бүртгэл хөтлөлт, сан хөмрөгийн зохион байгуулалтаа сайжруулах сургалт	Цахимаар	9.8	15
28	Орон нутгийн санчдыг чадавхжуулах сургалт	АЗДТГ	10.07	5
29	Орон нутгийн санчдыг чадавхжуулах сургалт	АТНС	10.08	5
30	Монголын үйлдвэрчний эвлэлийн хорооноос сургалт	Соёлын ордон	10.19	8
31	Library update-2022 "Цахим эрин дэх үндэсний ном зүйн цахим мэдээллийн сан"	Цахимаар	11.09	6
32	ОБГ-аас Объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ"	Мэдээлэл аргазүйн танхим	12.02	8
33	Жендэрийн эрх тэгш байдал эрэгтэйчүүдийн оролцоо	ГБХЗХГ	12.09	1
Нийт				176

14. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ

Номын сангаас 44 соёл олон нийтийн ажил зохион байгуулж 6149 хүн оролцсон байна. Соёл олон түмний ажлын дэлгэрэнгүй хүснэгтийг дор оруууллаа.

СОНА-2022					
2022.01.01					
№	Зохион явуулсан ажил	Хамтран ажилласан байгууллага	Хэзээ	Зохион байгуулсан ажилтан	Оролцсон хүний тоо
1	"Бахархал-Өв соёл" үндэсний бичгийн тэмцээн	СУГ, БШУГ	3.22	Аргазүйч Б.Эрдэнэцацралт	50
2	"Номын санч" мэргэжлийн талаар мэдээлэл хийсэн	Булган хангай МСҮТ	4.28	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, ХУТ-ын номын санч Ц.Долгор	42
3	Үндэсний бичгээр танин мэдэхүйн “60 секунд” тэмцээн	Булган хангай МСҮТ	4.28	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, ХУТ-ын номын санч Ц.Долгор	42
4	Албан байгууллагуудын дунд Үндэсний бичиг үсгийн баяраар "60 секунд" үндэсний бичгийн тэмцээн	Соёлын ордон	5.4	Б.Эрдэнэцацралт, Ц.Долгор, Б.Ариунжаргал, Д.Баасансүрэн	46
5	"Ахмадын өргөө"-нд хамтран ахмадуудын дунд алдартнуудын зургийг “60 секунд”-ын дотор таах тэмцээн	Ахмадын холбоо	5.6	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, ХУТ-ын номын санч Ц.Долгор	20
6	Номын санч мэргэжил сурталчилах өдрийг ЕБС-ийн 9-р ангийн сурагчдын дунд зохион явуулсан	1,2,3-р сургууль, Спортын дунд сургууль	5.12	Захирал Т.Мөнгөнтуяа, Аргазүйч Б.Эрдэнэцацралт	45
7	Номын баяр -2022 хаврын арга хэмжээ	СУГ	5.19	Бүх ажиллагсад	800
8	“Номын баяр”-2022 арга хэмжээний ардын аман зохиолын өртөө 5 үе шаттай тэмцээнийг зохион байгуулсан		5.19	Аргазүйч Б.Эрдэнэцацралт	50
9	Сансрын нисгэгч өртөөнөөс толь ашиглан том, жижиг 2 таван хошууны дундуур 3 дахь таван хошууг зурах тэмцээнийг зохион явуулж зохион явуулсан тэмцээн	Соёлын ордон	5.19	Соёлын ордны номын санч Ж.Маралмаа	102
10	Монгол наадгайн” өртөөнөөс шагай шүүрэх тэмцээнийг зохион явуулсан тэмцээн		5.19	Номын санч Г.Энхбилэг, Д.Мөнхгэрэл	77
11	Өв соёл өртөөнөөс музейн үзмэр, эд өлгийн зүйлс таалгах тэмцээнийг зохион явуулсан.	Аймгийн музей	5.19	Музейн ажилтан Б.Лхамсүрэн	50
12	Номын нэр таах” өртөөнөөс “60 секундын” хугацаанд номын нэр эвлүүлэх тэмцээнийг зохион явуулж, зохион явуулсан		5.19	Сан хөмрөгч Б.Ариунжаргал	40
13	Нээлттэй уншлага:Уучлахын ач тус богино өгүүллэгээр чанга уншлага хийж номын тэмдэглэл хөтөлж, өгүүллэгийн утга санаа, гол дүрийн тухай харилцан ярилцлага хийсэн.	ЕБС-ийн сурагчид	5.19	Номын санч Ч.Мөнхцэцэг	106
14	Аймгийн МХГазар “Бага насны хүүхдийн номонд дурлуулах нь” мэдээлэл хийсэн.	МХГ	5/30/2022	Аргазүйч Б.Эрдэнэцацралт	48
15	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт"Үнсгэлжин ба 7 одой” үлгэрийн дүрд хувиран хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудтай дурсгалын зураг авахуулах ажлуудыг зохион явуулсан		6.01	Бүх ажиллагсад	500
16	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт "Ардын аман зохиол"-ын тэмцээн /12-15 насны хүүхдүүдийн дунд/ зохион явуулсан		6.01	Аргазүйч Б.Эрдэнэцацралт	56
17	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт “Шагай наадгай” шагай шүүрэх тэмцээн		6.01	Номын санч Д.Мөнхгэрэл	75
18	Айраг наадам-2022"-д Ардын уламжлалт оньсон тоглоом эвлүүлэх тэмцээнийг зохион явуулсан		8.13	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, номын санч Д.Мөнхгэрэл	31
19	Айраг наадам-2022"-д шагай шүүрэх тэмцээн зохион явуулсан.		8.14	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, номын санч Д.Мөнхгэрэл	67
20	"Номтой аялал" ЕБС-ийн 9-р ангийн сурагчдын дунд зохион явуулсан.	Соёлын ордон	9.17	Номын санч Ц.Долгор, Д.Мөнхгэрэл	18

21	Номын санчдын ур чадварын уралдаан		10.07	Бүх ажиллагсад	45
22	"Динзагийн найзууд" өдөрлөг		10.07		200
23	"Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээн		10.11	Сан хөмрөгч Б.Ариунжаргал	32
24	Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Бичиг, соёлыг сурталчилах өдөрлөг	н ордон, ХЖТ,	11.07	Номын санчид	280
25	Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Үндэсний бичгийн сугалаа	Соёлын ордон	11.07	Аргазүйч Б.Эрдэнэцацралт, номын санч О.Анар	100
26	Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд"МОНГОЛ НААДГАЙ" уралдаан		11.11	Номын санч Г.Энхбилэг	232
27	Нацагдоржийн нэрэмжит шагналт яруу найрагч Д.Баянтунгалагийн "Гүлрансын мөнгөн навчис" шинэ номын баярыг	Булган аймгийн утга зохиолын нэгдэл	11.12	Бүх ажиллагсад	30
28	"АЙРАГТАЙ НАЙРАГТАЙ ЯРУУ НАЙРГИЙН ҮДЭШ" телевизийн нэвтрүүлэг	Булган аймгийн утга зохиолын нэгдэл	11.16	Номын санч О.Анар	6
29	"КИНО ТЭМДЭГЛЭЛ" уулзалт ярилцлага	ГБХЗХГ	11.18	Номын санч Г.Энхбилэг	144
30	НОМ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ шинээр эхлүүлэх		11.01-11.30	Номын санч О.Анар	3
31	Хүүхдийн уншлагын танхимд орон нутгийн танин мэдэхүйн буланг бий болгон эцэг эхчүүдэд танилцуулга хийсэн		11.3	Номын санч Г.Энхбилэг	10
32	"Бүтээлч уншлага" уралдаан		11.3	Номын санчид	360
33	Номын сантай танилцах аялал		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	420
34	АХА тэмцээн /11 удаа/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	189
35	Чанга шивнээ хөгжөөнт тэмцээн /10 удаа 164 сурагч/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	164
36	Номтой аялал /2удаа/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	169
37	Кино өдөрлөг /4 удаа/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	398
38	Мэргэжил бүхэн сайхан" аялал /2 удаа 58 сурагч/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	58
39	Монгол наадгай /2 сургуулийн 5 бүлгийн 224 сурагч 5 багш/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	229
40	Анги бүрт 15-20 минутын "Найз нөхөр гэж хэн бэ?", "Цаг төлөвлөлт" зэрэг чөлөөт сэдвээр багш сурагчидтай харилцан ярилцлага хийсэн. /12 удаа 201 сурагч/		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	225
41	Дэлхийн яруу найргийн өдөр-ийг тохиолдуулан уншигч зохиолчдын уулзалт хийсэн		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	173
42	"Дэлхийн номын өдөр"-ийг угтан яруу найрагч, зохиолч, орчуулагч Х.Байыт "Монгол яруу найраг" болон зохиолч, романч Д.Пүрэв "Гулзгай" шинэ номын баярыг зохион байгуулж "Зохиолч уншигчдын уулзалт"		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	160
43	Мэргэжил бүхэн сайхан" сурагчдын санал гаргасан албан газрын үйл ажиллагаатай танилцах аялал хийсэн.		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	132
44	"Номтой өртөөлчилсөн аялал" – Сансар 1, Цогт хунтайжийн талбай, Сансар 2, Аваргуудын хөшөө,		01.15-11.25	Номын санч Г.Энхбилэг	125
	ДҮН				6149

Ажилтан албан 20 удаагийн соёл олон нийтийн ажилд оролцсон байна.

15. ШИНЭЛЭГ АЖИЛ:

1. **"Хүүхдийн бүтээлч уншлага" аян**: Энэхүү аяны онцлог нь анги хамт олон, хувь хүүхдийн гарааны түвшинг тогтоож түүнээс 10% ахиц гаргах, номын тэмдэглэл хөтлүүлэх, цэвэр хуулан бичиг, цээж бичиг, түргэн уншлага, хувийн номын сан бий болгох, ном засаж сэлбэх, соёл олон нийтийн ажлын оролцоог идэвхжүүлэх, уншуулагч багш, номын санчийг урамшуулах зэрэг хүүхдийг олон талаар хөгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх явдал юм.
2. **"Уншаад хож"** үндэсний бичгийн сугалаа: Булган сумын Соёлын ордонтой хамтран явуулсан.Үндэсний бичгээр үг бичсэн сугалааг сугалаад түүнийгээ уншиж чадвал хонжвороо авна.
3. **Үндэсний бичгээр "60 секунд"** тэмцээнийг зохион байгуулсан.
4. **"Динзагийн найзууд"** өдөрлөг: Үндэсний комик ном Цондоолой, Цүндээлэй номын зохиогч А.Дэлгэржаргалтай хамтран хүүхэд багачуудын дунд 2 насны ангилалаар шагналын сан өндөр ном унших уралдаан зарласан. Шагналыг Ирмүүн ХХК бүрэн хариуцаж гаргасан.

5. **“Айрагтай найрагтай үдэш”** телевизийн нэвтрүүлэг: Булган аймгийн залуу яруу найрагчид тэдний уран бүтээлийг сурталчилах зорилгоор Сайхан Монгол ТВ, Соёлын ордонтой хамтран зохион байгуулсан.
6. **“Үнсгэлжин ба долоон одой” маскот:** Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр номын санчид үлгэрийн баатруудын дүрд хувирч соёл олон нийтийн ажлаа зохион байгуулсан нь хүүхэд багачуудын сонирхолыг маш их татсан.
7. **“Номын санчдын ур чадварын уралдаан”-**ыг аймагтаа анх удаа зохион байгууллаа.
8. **“Номтой аялал”** Булган сумын Соёлын ордны номын сантай хамтран “Анхдагч алдартнуудын музей”, “Диваажингийн сүм”, “Энергийн цэцэрлэгт хүрээлэн” гэсэн маршуртаар “Номтой аялал”-ыг хүүхдүүд баг болон даалгавар биелүүлж өрсөлдлөө.
9. **“Өсвөрийн номын санч”** дугуйлан хүүхдийн уншлагын танхимын дэргэд хичээллүүлж эхэлсэн

Амжилтууд:

- Номын сайн нөхөр уралдаанд “Шилдэг номын сан”-гаар шалгарсан
- Булган аймгийн 2022 оны Соёл урлагийн салбарын “Манлайлагч байгууллага”-аар шалгарсан

16. 2023 ОНД ШИНЭЭР :

- Хүүхдийн бүтээлч уншлага аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулна
- “Өглөөний уншлага” аянг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд явуулна
- Хоёр уншлагын танхимыг байнгын ажиллагаатай болгон амралтын өдрүүдэд ажиллуулна.

17. ХҮНИЙ НӨӨЦ, БОЛОВСОН ХҮЧИН

Булган аймгийн Нийтийн номын сан нь захирал, арга зүйч, сан хөмрөгч, номын сан 4, нягтлан бодогч, сахиул, үйлчлэгч гэсэн 10 орон тоотой ажиллаа. 2 мэргэжлийн номын санч 3 мэргэжлийн бус номын санч байна. 2022 онд салбар номын санч Д.Мөнхгэрэл, хүүхдийн уншлагын номын санч Б.Ариунжаргал нар СУИС-ийн Соёлын сургуульд эчнээгээр суралцаж байна. АТНС-ийн ажиллагсад мэргэжлийн чиглэлээр цахимаар 14 сургалт, танхимаар 1 сургалтад бусад чиглэлээр 19 сургалтад цахим болон танхимаар хамрагдаж мэдээлэл авсан.

2022 онд 10 ажилтан 6,7 сая төгрөгний үр дүнгийн урамшуулал авсан байна.

Булган аймгийн хэмжээнд сумын 17 номын сан, 22 сургуулийн номын санд 39 номын санч ажиллаж байгаагаас 5 сум, 5 сургуулийн 10 буюу 25,6% нь мэргэжлийн номын санч байна. Орон нутгийн номын санчид цахимаар 2 удаа танхимаар 1 удаа сургалтад хамрагдаж 3 удаагийн сургалтад 78 хүн хамрагдсан.

18. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

2022 онд улсын төсвийн санхүүжилт 189041.9, орон нутгийн төсвийн санхүүжилт 34451.8 төгрөг нийт 229686,2 төгрөгний төсөвтэй ажиллаа.

1.Улсын төсвийн санхүүжилт орлого : 189041.9 /Нэг зуун наян есөн сая дөчин нэгэн мянган есөн зуун төгрөг/

Үйл ажиллагааны зардал – 80101-150008.0

Урсгал зардал -80802 -12282,9

Эрдэм шинэжилгээний ажлын зардалд-80215- 12000,0

Нэмэлт дээд шатнаас - 83603 -210801 /Бусдаар гүйцэтгүүлэх ажиллагаа- 10000,0

83603 -210404 /Ном, хэвлэл/-4750,0

Аймгийн Засаг даргаас -80101 -210402- шатахуунд 500,0

2.Орон нутгийн төсвийн санхүүжилт орлого: 34451,8/ Гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин нэг мянга найман зуун төгрөг/
Үнэ төлбөргүй орлого -6192,5 / Соёлын яам/

Зарлага: 229269,8/ Хоёр зуун хорин есөн сая хоёр зуун жаран есөн мянга найман зуун төгрөг/

Цалин хөлс,нэмэгдэл, урамшуулал - 119408,2
НДШ – 15479,4
Хангамжийн бараа -7938,3
Нормын хувцас -145,1
Эд хогшил,урсгал засвар - 1999,6
Дотоод томилолт - 443,7
Бусдаар гүйцгүүлэх ажил үйлчилгээ - 3939,0
Бараа үйлчилгээний зардал - 8266,0
Эрдэм шинэжилгээний ажил - 12000,0
Нэг удаагийн тэтгэмж -768,0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид -11514,9
Нэмэлтээр номын баяр ажилд – 10000,0
Нэмэлтээр ном худалдан авахад - 4750,0
Халаалт, Цэвэр ус, гэрэл цахилгааны зардал 32667,8
Дансны үлдэгдэл 416,4 /Дөрвөн зуун арван зургаан мянга дөрвөн зуун төгрөг/

2022 онд ажиллагсадын нийгмийн асуудлаар үр дүнгийн урамшуулал давхадсан тоогоор 26 хүнд 6707,1 мян.төг, түлээ,нүүрс, халаалтын зардлын хөнгөглөлт 1550,0 мян.төг олгогдсон байна.

Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ чухал шаардлагатай байгаа техник хэрэгсэл, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж Соёл урлагийн газраас 6,192,500 төгрөгний үнэ бүхий 2 зөөврийн компьютер, шат, гэрэлтүүлэг, уншлагын танхимуудын номын тавиур, сандлын бүрээс, санхүүгийн компьютер зэрэгт 11,069,240 төгрөгний төсвийг зарцуулж нийт 17,261,740 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн.

Цагаан сар, ахмадын баяраар байгууллагын ахмадуудаа хүндэтгэл үзүүлэхэд 330.000 төгрөг зарцуулсан байна.

19.БУСАД АЖИЛ

- “Мөнгөн өвөл” цасны баярт байгууллага хамт олноороо оролцсон.
- Бүх ажиллагсад эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэгт 100% хамрагдсан.
- Эмч нартаа баярлалаа цахим уриалгад нэгдэж постер бэлтгэн хүргэсэн
- ГБХЗХГ-аас ОУ-ын эмэгтэйчүүдийн баярыг угтан зохион явуулсан АХА тэмцээнд захирал Т.Мөнгөнтуяа, аргазүйч Б.Эрдэнэцацралт нар оролцсон.
- Булган аймгийн соёл, урлагийн байгууллагуудын хооронд зохион явуулсан “СОЁЛЫН ТҮҮЧЭЭ” спортын наадмын гар бөмбөгийн төрөлд 4-р байрт шалгарсан
- Булганчуудын бахархалын өдөрт зориулсан "САНСАР МАРАФОН-2022" гүйлтэд эмэгтэй 5000 м зайд оролцсон.
- ОБГ-ын зарлан мэдээллэх дуут дохиогоор, дадлага сургуулилтад бэлтгэл хангаж хамрагдсан.
- Авто зам дагуух бүх нийтийн цэвэрлэгээнд цагдаагийн постноос цааш 800 м хуваарьт газраа 2 удаа цэвэрлэсэн.
- “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх нийтийн мод тарих өдрөөр Сансар-2 цэцэрлэгт хүрээлэнд 2 удаа нөхөн сэргээлтээр 110 ширхэг хайлаас, 1 ширхэг нарс мод тарьж усалгаа арчилгааг хийж байна. Ажиллагсад өрхийн

хэмжээнд 11 жимсний мод тарьж нийтдээ 460000 төгрөгөөр мод худалдан авсан.

- Илүүдэл жингүй-эртэч Монгол аянд хамрагдсан.
- Байгууллагын гаднах засварын ажлыг ажиллагсад өөрсдөө хийсэн.
- Байгууллагын ойр орчмын шарилж зулгаах хог цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулсан.
- Булган аймгийн соёл, урлагийн ажилтнууд 29 дэх удаагийн Соёлын ажилтны баяраараа аймгийн СУГ-аас санаачилсан "Соёлын орон зай" бүтээлч ажилд оролцож хамт олноороо нэгдэж Сансар-1, Сансар-2 цэцэрлэгт хүрээлэнгийн хөшөөнүүдийн будгийг сэргээн будсан.
- Монголын номын санчдын дундах спортын тэмцээнд Улаанбаатар хотод оролцсон.
- Булган аймгийн "Төрийн албан хаагчдын сарын аян"-ны хүрээнд зохион байгуулагдсан гар бөмбөгийн тэмцээнд хамт олноороо оролцож, илтгэлийн уралдаанд номны санч О.Анар тусгай байр, "Батак" тэмцээнд багаараа 5-р байр эзэлсэн.

20.СУДАЛГАА

Үйлчилгээний чанар хүртээмж, үйлчлүүлэгчийн эрэлт хүсэлт, ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийг тандан судлах зорилгоор дараах сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллаа.

Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар:

1.Номын сангийн ажилчдын харилцаа хандлага ямар вэ?

Гэсэн асуултанд 56 хүнээс 50 хүн нь буюу 89,2% харилцаа хандлага сайн 6 хүн нь буюу 10,8% дунд зэрэг гэж хариулсан байна.

2. Номын сангийн үйл ажиллагаанд өгөх таны үнэлгээ гэсэн асуултанд 56 хүнээс 51 хүн нь буюу 91% нь сайн 5 хүн нь буюу 9% дунд гэж хариулсан байна.

3.Номын сангийн орчин нөхцөл танд ямар санагддаг вэ гэсэн асуултанд 56 хүнээс 42 хүн нь буюу 75% сайн 14 хүн нь буюу 25% нь дунд гэж хариулсан байна.



4.Таны хэрэгцээт ном сэтгүүл хангалттай байдаг уу гэсэн асуултанд 56 хүнээс 34 хүн нь буюу 60,7% хангалттай 22 хүн нь буюу 39,3% заримдаа гэж хариулсан.

1. Номын сангаас зохион явуулж байгаа соёл олон нийтийн ажил цаг үеэ олсон, шинэлэг санагддаг уу? гэсэн асуултанд 56 хүнээс 54 хүн нь буюу 96,4% нь цаг үеэ олсон шинэлэг ажил зохион явуулдаг гэж хариулсан бол 2 хүн буюу 3,6% нь цаг үеэ олоогүй гэж хариулсан байна.

НОМЫН САНГИЙН БАРИЛГА, ОРЧИН НӨХЦӨЛИЙН ТАЛААР 85 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧЭЭС СУДАЛГАА АВСНААС

- 96.6% сэтгэл ханамжтай.
- 3,4% барилга орчины тал дээр сэтгэл ханамжгүй.

Номын сангийн уншлагын танхимуудыг орчин үеийн стандартад нийцүүлэн тохижуулах зэрэг саналуудын дагуу зохих арга хэмжээнүүдийг өөрсдийн нөөц боломцоогоо ашиглан цаашид авах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

21. ДҮГНЭЛТ

2020-2021 онд дэлхий нийтэд тархаад байсан цар тахлын улмаас хязгаарлагдаад байсан номын сангийн үйлчилгээ 2022 оноос сэргэж үйлчилгээний үзүүлэлтүүд нэмэгдлээ. Булган аймагт 9 сард дэгдсэн малын халдварт өвчний улмаас үндэсний “Номын баяр”-ыг төлөвлөсөн хугацаандаа явуулж чадаагүй.

Соёлын яам байгуулагдсанаар номын фонд баяжилт, Соёл олон нийтийн ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн нь номын сангийн үйл ажиллагааг чанартай өргөн хүрээнд явуулахад маш чухал байлаа.

Номын сангийн салбарын хүний нөөцийн дутагдлыг арилгах төлөвлөлтийг ойрын жилүүдэд хийх шаардлагатай байна. Мэргэжлийн бус хүнийг ажилд авах нь тогтвор суурьшилын байдал, ажлын чанарын үзүүлэлтэд сөрөг нөлөөтэй байна.

Номын сангийн шинэ барилгын зураг төсөв бүрэн хийгдсэн ч хэмнэлтийн хуулиар хөрөнгө оруулалтууд хязгаарлагдан 2023 оны төсөвт тусгуулж чадаагүй.

Манай номын сангийн хувьд уншлага үйлчилгээний заал танхимын хүрэлцээ хангамж хангалтгүй уншигчдаас ирж байгаа санал хүсэлтийн 90%-ийг барилга байшингаа томруулах санал эзэлж байна.

Холбоо барих утас: 75098999, 96519091
E mail: bulgannomiinsan@gmail.com
Сошиал хаяг: https://www.facebook.com/Bulgannomiinsan

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН Д.СҮРЬЕЭГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.16 Алтай хот

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО БҮТЭЦ

Нийтийн номын сан нь 2022 онд удирдах-1, мэргэжлийн-10, аж ахуй үйлчилгээний-6, нягтлан бодогч 0,5 нийт 17,5 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн, Нийтийн номын сангийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ханган биелүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газрын тогтоол, Соёлын сайдын тушаал, заавар, зөвлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. 2022 онд 1200 шинэ уншигч бүртгэж, 8450 ирцэд 10200 ном олголт хийж,
2. Уншигч үйлчлүүлэгчдийг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилтын хүрээнд 134 удаа лавлагаа , 72 татгалзал өгөв.
3. Фондын номын эдэлгээг уртасгах зорилгоор 630 ширхэг номыг сэлбэн засаж уншлага үйлчилгээнд гаргалаа.
4. Сонин сэтгүүлийн танхимаар 143 сонин, сэтгүүлээр уншигчдад үйлчилсэн байна.

5. 1-р сард Ёс заншил, Эх орончдын өдөр, 3-р сард Олон Улсын Эмэгтэйчүүдийн өдөрт зориулан сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Соёл Урлагийн ажилтаны анхдугаар зөвөлгөөнд шинэ болон Алтайн хөгжил сонины үзэсгэлэнг, 4-р сард Дэлхийн хүүхдийн номын өдөрт зориулан Андерсоны зохиолын болон дэлхийн хүүхдийн шилмэл зохиолын ном, Англи үлгэрийн номоор, Газар тариалан хүнсний ногоо эрхлэгчдэд зориулан сэдэвчилсэн номын үзэсгэлэн, 5-р сард Үндэсний бичиг соёл, номын өдрүүдэд шинэ болон ховор хуучин ном, Алтайн хөгжил сонины үзэсгэлэнг, 6-р сард ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт хүүхдийн үлгэрийн номуудаар, 7-р сард сэдэвчилсэн номын үзэсгэлэн, 9-р сард Хүүхдийн ном, гадаад ном , ховор ном, шинэ номын үзэсгэлэн, 10,11,12-р саруудад шинэ болон сэдэвчилэн номын үзэсэгэлэнг тус тус гарган уншигчдад сурталчлан ажиллаа. Мөн цахим хаягаараа дамжуулан 61 нэр төрлийн үлгэр, сургамжит өгүүллэгүүд байршуулан цахим уншлагын үйлчилгээ үзүүллээ.

3. ФОНД, КАТАЛОГИ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Фондын чийгшилт номын хадгалалтыг сайжруулан ажиллаж байна. 2022 онд 1015 ширхэг шинэ номоор фонд баяжилт хийлээ. Жилд 9-11 нэр төрлийн 411760 төгрөгийн сонин, сэтгүүл захиалан нэгж болгон үдэж уншлага үйлчилгээнд гарган уншигчдад үйлчилж байна. Манай аймаг хэвлэлийн хуудсанаа орон нутгийн картын санд Зууны мэдээ сонин -2, Өдрийн сонин -4, Өнөөдөр сонин-3 материал түүвэрлэн баяжилт хийн байрлуулав. Соёлын гавьяат зүтгэлтэн С.Пүрэв, Р.Чулуун, Б.Дашзэвэг, Ч.Сонгино, Ч.Лодойдамба, М.Цэдэндорж нарын нэрэмжит шагналт зохиолч З.Гүнсэн, хүүхдийн зохиолч Ж.Дашдондог, зохиолч Д.Урианхай нарын амьдрал уран бүтээлээр бүртгэн мэдээлэх ном зүйн бүртгэл хийлээ.

4.СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

1-р сард: Философич С.Молор-Эрдэнэтэй уншигч зохиолчдын уулзалтыг зохион байгууллаа.

4-р сард : 4-р сарын 12-ноос 04 сарын 25-ийг хүртэл "Дэлхийн хүүхдийн номын өдөр"-өөр **"Үлгэрийн ертөнцөөр аялъя**" номын тэмдэглэл хөтлөх уралдааныг ЕБС-ийн 4-6 ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Тус уралдаанд 1,3,4-р сургуулийн 50 гаруй хүүхэд багачууд оролцон Ханс Кристиан Андерсенийн зохиолоор бяцхан ном хийн оролцсон. Тус уралдаанд ирсэн бүтээлүүдээс дараах хүүхдүүдийн бяцхан номуудыг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнав.

5-р сард: 2022 оны 5-р сарын 3-наас 5-р сарын 24-ийг дуустал 7 хоног бүрийн мягмар гаригийн өглөө 7.00-8.00 цагийн хооронд Нийтийн номын сангийн уншлагын танхим, аймгийн Залуучуудын Холбоотой хамтран "Номын клуб, ном сонирхогчдын уулзалт- Номын өдөр"- ийг зохион байгуулан ажиллаа. 2022.05.10-ны өглөө 7 цагт дүгнэн ярилцах номын код Ч.Наминчимэд "ЦАГААН БОРОО" роман, 2022.05.17-ны өглөө 7 цагт дүгнэн ярилцах номын код Л.Түдэв "ОРОЙГҮЙ СҮМ" роман, 2022.05.24-ний өглөө 7 цагт дүгнэн ярилцах номын код Ч. Лодойдамбын "САЙХАН ХАЙР БАЙДАГ ЮМ ШҮҮ ОЛБОЛ ГАГЦХҮҮ АЛДАЖ Л БОЛОХГҮЙ" зохиолуудаар тус тус ярилцаж санал бодлоо солилцлоо. Уг өдөрлөгөөр яруу найрагч Батсүхийн Эрдэнэ-Очир сонирхсон номоо яаж үр дүнтэй байдлаар унших, номын соёлыг түгээх талаар зөвлөмж өгөн Их Алтай нутгийнхаа зохиолчид болон шилдэг бүтээлүүдийг танилцуулан "Хантайшир утга зохиолын нэгдэл"-н талаар мэдээлэл хүргэлээ. Уг арга хэмжээнд Залуучуудын холбооны хяналтын зөвлөлийн гишүүд, "Эртэч монгол клуб", 2, 3, 5, дугаар цэцэрлэгийн эрхлэгч нар, төрийн болон төрийн бус байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид гээд 80 гаруй хүн оролцлоо.

Хүүхдийн уншлагын танхимаас 5-р сарын 18-нд 1-р сургуулийн 3-в , 5-д, 2-д, Хантайшир –Эрдэм цогцолбор сургуулийн 3-а,б, 4-р сургуулийн 4-а,в, 1-а ангиудун нийт 200 сурагчдад " Үлгэрээс үлгэрлэе" чанга уншлагыг Аргат өвгөн, Вангийн цагаан уул, Зам дайралдсан бадарчин, Аргат хүү, 7 хожгор 1 можгор үлгэрүүдээр хийлээ.

Мөн 1,5,4,3-р сургуулиудын 8,9,10-р ангийн нийт 90 сурагчдад Номын сангийн танилцуулга яриа хийлээ.

5-р сарын 17-нд: Говь-Алтай аймгийн зохиолч яруу найрагч, уншигч хүүүхдүүдийн дунд "Уншигч зохиолчдын чөлөөт ярилцлага" уулзалтыг Насанд хүрэгчдийн уншлагын танхимд зохион байгуулав. Тус уулзалтанд яруу найрагч Г.Чардаг, С.Энхбаатар, Х.Чимэдрэгзэн, Д.Элбэгзаяа, Я.Мягмардорж нар оролцож өөрсдийн уран бүтээлээс уншиж сонирхууллаа. Уулзалтанд нийт 27 уншигч хүүхдүүд оролцлоо.

05-р сарын 20-нд Үндэсний бичиг үсгийн баяр: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль,”Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг Говь-Алтай аймгийн Монгол Улсын баатар Магсарын Жанчивын төв талбайд 2022 оны 05 дугаар сарын 20-ноос 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, номын баярын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчилан ажиллаа. Энэ жилийн гол онцлог нь Улсын Их Хурлын дарга Г. Занданшатарын ивээл дор бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өвийг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах зорилгоор “Илүү их уншъя” уриатайгаар 31 дэх номын баяраа өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. Тус үйл ажиллагааны хүрээнд Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчид, хувиараа бизнес эрхлэгчид, ТББ-ууд хүүхэд залуучууд, Есөнбулаг сумын нийт иргэдийн 75% оролцлоо. Номын баярын үйл ажиллагааг Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар, Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулж, иргэдэд шинэ, хуучин, ховор номын үзэсгэлэн, бүтээлийн үзэсгэлэн, гар урлал, номын худалдаа, иргэдийн гар дээрх соёлын үнэт өвийн үзэсгэлэн, Монгол бичгийн бүтээлийн үзэсгэлэн зэргийг гаргаж сурталчиллаа.

Хамтран зохион байгуулагчаар:

- АШУИС-ийн харьяа Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургуулийн номын сан, БШУЯ-ны харьяа Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн номын сан,Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулиудын номын сан.

-Ном хэвлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хувь хүмүүсийг татан оролцуулж, иргэдийг сонирхсон ном хэвлэлээ худалдан авах боломжоор ханган ажиллаа.

-“Бийрээ нийлье” арга хэмжээ: Есөнбулаг сумын ЕБС-ийн IX-XII ангийн сурагчдын дунд зарласан уран бичлэгийн “Уран бийр” уралдаанд ирсэн бүтээлүүдийн үзэсгэлэн гаргаж, байр эзэлсэн сурагчдад шагнал гардууллаа.

Тэргүүн байр- Есөнбулаг сумын улсын тэргүүний I сургуулийн 9В ангийн сурагч З. Хулан

Дэд байр- Есөнбулаг сумын Хантайшир эрдэм цогцолбор сургуулийн 9А ангийн сурагч С. Сүхбат

Гутгаар байр- Есөнбулаг сумын III сургуулийн 11А ангийн сурагч Д. Энхжин

Тусгай байр- Есөнбулаг сумын улсын тэргүүний I сургуулийн 10В ангийн сурагч Д. Ням-Өлзий нар тус тус эзэллээ.

Мөн аймгийн Нийтийн Номын санд хандив өргөсөн, номын санд хөрөнгө оруулсан хувь хүн албан байгууллагыг урамшуулах алдаршуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. Говь-Алтай аймгийн нийтийн номын сангийн “Хүүхдийн уншлагын танхим”-ийг иж бүрэн тохижуулж хүлээлгэн өгсөн Ч. Лодойдамба сангийн тэргүүн Лутаагийн Энхнасан болон Сүрьяагийн Цэцгээ нарт өргөмжлөл, дурсгалын зүйл гардуулав.

Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн сурталчилан таниулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Тэргүүний уншигч”-дыг шалгаруулж, шагнаж урамшуулав.

Бага анги- Давааням овогтой Азжаргал / I сургуулийн 4Д ангийн сурагч/

Дунд анги- Ганхуяг овогтой Мөнгөнтуяа / I сургуулийн 7Б ангийн сурагч/

Ахлах анги- Даваадорж овогтой Хүчитбаатар / IV сургуулийн 11А ангийн сурагч/

Аймгийн Нийтийн номын сан, Орон нутаг судлах музей, Ардын дуу бүжгийн Алтай чуулгын үйл ажиллагааг сурталчилсан асартай танилцах “Соёлын өртөөчилсөн аялалыг зохион байгуулж, иргэдэд сурталчиллаа.

Шилдэг уншигч:
-Гаахүү овогтой Бумцэнд / Аудитын Ерөнхий газар/
Гар урлалын бүтээлийн үзэсгэлэнгийн шилдэг оролцогч:
-Цэрэнбалдан Бүрэнбилэг / Хувиараа бизнес эрхлэгч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл/
Хамтран ажилладаг төрийн бус байгууллагуудыг алдаршуулах:
-Хантайшир утга зохиолын нэгдэл /Алтайн зохиолчдын төлөөлөл/
-Төрөлх- Алтай ТББ / жил бүр ном хандивлах үйл ажиллагаа зохион байгуулдаг/

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд:

-Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлийн үндэсний бичгийн тайлант үзэсгэлэн
-Үндэсний бичгийн **"Уран бийр"** уралдаанд ирсэн бүтээлийн үзэсгэлэн
-Аймгийн Нийтийн номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа болон ард иргэдийн гар дээрх үндэсний болон төвд үсгээр бичигдсэн ховор судар, номын үзэсгэлэн,мэдээлэл сурталчилгаа
-Аймгийн Нийтийн номын сангийн шинэ номын үзэсгэлэн,мэдээлэл сурталчилгаа
-Тэргүүний уншигч хүүхдүүдийн бүтээл,номын тэмдэглэлийн үзэсгэлэн
- Үндэсний гар урлал,тоглоомын худалдаа
-Нэрт яруу найрагч, соён гэгээрүүлэгч,,орчуулагч,дуун хөрвүүлэгч Мишигийн Цэдэндоржийн мэндэлсний 90 насны ойд зориулсан уран бүтээлийн үзэсгэлэнг тус тус зохион байгууллаа.

Номын худалдаа:

-Монголын Зохиолчдын Эвлэлийн салбар Говь-Алтай аймгийн "Хантайшир" нэгдлийн зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа
-Аймаг сумдын номын дэлгүүрүүдийн номын худалдаа
-Хэвлэх үйлдвэр, хэвлэлийн газар, зохиолчид, хувиараа ном цуглуулагчдын номын худалдаа
-Ховор,хуучин номын худалдаа
-Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн худалдаа зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

5-р сарын 25-нд : МУ-ын тэргүүний ардын авъяастан өв соёл судлаач, ерөөлч, магтаалч Х.Ивансан, МУ-ын СТА зохиолч Х.Батмэнд нарын "Тунамал оршихуй" шинэ номын нээлт боллоо. Нийтийн номын сангаас 10 ширхэг номыг фондод авлаа.

9-р сарын 16,17-нд Номын баяр : “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд зохион байгуулж бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өвийг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан Монгол улсын баатар Магсарын Жанчивын талбайд задгай тайз засаж нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, Алтайн зохиолчдын гарын үсэгтэй номын үзэсгэлэн худалдаа болон бүтээлийн үзэсгэлэн гаргаж, энэ удаагийн номын баярыг өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. Арга хэмжээг нээж Говь-Алтай аймгийн СУГ-ын дарга С. Цагаанбаатар үг хэлж, аймгийн авьяаслаг сурагчид урлагийн тоглолт үзүүллээ.

Мөн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг угтан дараах үйл ажиллагаануудыг явууллаа:

1. “Ном солилцох хөтөлбөр”
2. “Мэдлэгтэй аялал”
3. “Шарга даага” номын тэмдэглэл хөтлөх уралдаан
4. “Бүтээлчээр сэтгэж бүхнийг хийе” сэдэвт бүтээлийн уралдаан
5. “Номоор гангаръя” зургийн өртөөчилсөн аялал
6. “Солонгон соно” сэдэвт номын үзэсгэлэн
7. “Комик номын баатрууд амилсан нь” үлгэрийн баатрын дүрийн тоглолт
8. “Норовын намтар” хүүхдийн жүжигчилсэн тоглолт
9. “Open mic” хүүхэд залуучуудад зориулсан арга хэмжээ
10. Шагнал урамшуулал

Ном солилцох хөтөлбөр:

“Үндэсний бичиг соёл Номын өдрүүд-2022” арга хэмжээний хүрээнд хүүхэд багачуудын дунд ном солилцох, худалдах, бэлэглэх арга хэмжээг 9-р сарын 9, 12-ны өдрүүдэд Нийтийн номын санд зохион байгууллаа.

Уг арга хэмжээний үеэр хүүхэд багачууд өөрийн уншсан ном, хэрэглэж дууссан сурах бичгээ тохирсон үнэ өртөгөөр найз нөхөддөө худалдан бэлэглэж солилцов.

Энэ өдөрлөгт нийт 5 сургуулийн 300 гаруй сурагчид, анги удирдсан багш нар сурагчиддаа идэвх санаачлагатай оролцууллаа. Өдөрлөгт оролцсон хүүхдүүд уран зохиол, танин мэдэхүй, үлгэр, сурах бичгийн 450 гаруй номыг сурталчилсан үр дүнтэй ажил боллоо.

“Бүтээлчээр сэтгэж бүхнийг хийе” сэдэвт бүтээл хийх уралдаан

“Үндэсний бичиг соёл, номын өдөр-2022” арга хэмжээний хүрээнд Нийтийн номын сангаас “Бүтээлчээр сэтгэж бүхнийг хийе” сэдэвт бүтээлийн уралдааныг ЕБС-ийн номын санч нартай хамтран IX-XII ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Тус уралдаанд I,II,IV,V сургуулийн 30 гаруй сурагчид өөрсдийн сонирхсон зүйлийг гар доорхи материал ашиглан хийж авьяас чадвараа сорин оролцлоо.

Урадаанд ирсэн бүтээлүүдээр “Үндэсний бичиг соёл, номын өдөр-2022” арга хэмжээний үеэр үзэсгэлэн гарган сурталчиллаа. Уг уралдаанд ирсэн бүтээлүүд нь хүүхдийн уран сэтгэмж, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхээс гадна бусад хүүхдүүдэд үлгэр дуурайлал боллоо.

Уралдаанд ирсэн бүтээлүүдээс дараах хүүхдүүдийн бүтээлийг шалгаруулан Өргөмжлөл , мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

1. 4-р сургуулийн 12б ангийн сурагч Нямзориг
2. 5-р сургуулийн 11б ангийн сурагч Х.Мөнхцэцэг
3. 4-р сургуулийн 12б ангийн сурагч Б.Нархажи

Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2022 * арга хэмжээг угтан *Мэдлэгтэй аялал * хөтөлбөрийн хүрээнд зохиолч О.Сундуйн *Шарга даага* зохиолоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд явуулсан номын тэмдэглэл хөтлөх уралдаан:

Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд 2022 арга хэмжээг угтан *Мэдлэгтэй аялал* хөтөлбөрийн хүрээнд нийтийн номын сангийн Гадаад хэлний танхим , Хүүхдийн уншлагын танхим хамтран зохиолч О.Сундуйн *Шарга даага* зохиолоор ерөнхий боловсролын сургуулийн 7-9 р ангийн сурагчдын дунд номын тэмдэглэл хөтлөх уралдаан зохион байгууллаа. Уралдаанд нийт 40 гаруй бүтээл ирсэн бөгөөд 1,2,3 –р байрыг тус тус шалгаруулж шагнал гардуулав. 1-р байранд 4-р сургуулийн Г.Наранцацрал багштай 7-а ангийн сурагчдын бүтээл шалгарч *Автобусаар аялах эрх*, өргөмжлөл, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа. 2-р байранд 2-р сургуулийн 8-в ангийн сурагч Б.Тамирын бүтээл шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал, 3-р байранд 4-р сургуулийн 9-в ангийн сурагч С.Бумгаравын бүтээл шалгарч мөн өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. 1-р байранд шалгарсан анги хамт олон 09-р сарын 14-нд *Автобустай аялал*-аараа аймгийн Нийтийн номын сан, Орон нутаг судлах музей, Цахиур Төмөрийн хөшөө үзэж танилцлаа.

“Номоор гангаръя” зургийн өртөөчилсөн аялал:

“Комик номын баатрууд амилсан нь” үлгэрийн баатрын дүрийн тоглолт:

“Норовын намтар” хүүхдийн жүжигчилсэн тоглолт:

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд- 2022” арга хэмжээг угтан хүүхдийн нас сэтгэхүйд тохируулан бүх насны хүүхдүүдэд “Норовын намтар” хүүхдийн жүжигчилсэн тоглолтыг үнэ төлбөргүйгээр 4 удаа тоглолоо.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг угтан гаргасан номын үзэсгэлэн

10-р сард Ахмадын баяр: Аймгйин Ахмадын хороотой хамтран ахмадуудын дунд АХА тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд ахмад настан Хишигмаа түрүүллээ. Ахмадын хороонд байгууллагын зүгээс даралтын аппарат, сахар хэмжигч хандивлав.

11-р сард: 11-р сарын 24-нд АДБАЧуулгад Говь-Алтай аймгйин Халиун сумын уугуул Б.Номинчимэдтэй уулзсан уншигч зохиолчдын уулзалтанд Үндсэн фонд хадгалагдаж байгаа нэг хувьтай ном , аймгийн зохиолчдын гар бичмэлээр үзэсгэлэн гаргалаа.

11-р сард Монгол шагайн наадгай тэмцээн: Улс тунхагласаны баярын өдрийн тохиолдуулан 11-р сарын 25-ны 14 цагт НХУТанхимд 1,3,4,5-р сургуулиудын 8 ангийн сурагчдын дунд Шагайн наадгай тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнийг 3 үе шаттайгаар 1,3,4,5-р сургуулиудын 4 багийн дунд явууллаа. Сургууль тус бүрээс 5 сурагчидтай багууд оролцлоо. Тэмцээнд Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн Хантайшир баг 1-р байр, 3-р сургуулийн Атга шагай баг 2-р байр, 1-р сургуулийн Таван-Эрдэнэ баг 3-р байр эзэллээ.

12-р сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрт :

Хөгжлийн бэршээлтэй иргэд насанд хүрэгчдйин дунд Монгол киноны дүрээр хэсэгчилсэн жүжгийн тоглолт, ТА ТА ТУНГАА тэмцээнийг зохион явууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй нийт 64 хүн оролцов. Тус тоглолтонд 4 баг оролцсоноос тэргүүн байранд Тэмүүлэл баг, дэд байранд Зургаан гйахмашиг баг, гутгаар байранд Цэлмэг баг тус тус шалгарлаа.

ТА ТА ТУНГАА танин мэдэхүйн тэмцээнд 10 хүн оролцсоноос Т.Нансалмаа, З.Нарангарав нар тэргүүн байр эзлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд Д.Нацагдоржийн “Миний ээж “ шүлгийн уралдааныг зарлаж нийт 8 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцсоноос 1-р байрт 3-р сургуулийн 5-б ангийн сурагч З.Лхагвасан, 2-р байрт 2-р сургуулийн 4-а ангийн сурагч Б.Багабанди, 3-р байрт 2-р сургуулийн 6-в ангийн сурагч Л.Сэмжид нар шалгарлаа. Сурагчдын дунд зарласан Миний эх орон гар зургийн уралдаанд нийт 12 бүтээл ирсэнээс 1-р байрт 2-р сургуулийн 4-в ангийн сурагч Ц.Есүжингийн зураг шалгарав .

Ивээн тэтгэгчээр МСҮТ, Прокурорын газар, Улаан загалмайн хороо хамтран ажиллаа.

12-р сард Өвлөгддөг өв гэрийн номын сангийн цахим уралдаан: Тус уралдаанд ирсэн видео танилцуулгыг байгууллагын Fasebook   хуудсаар дамжуулан уншигчдад сурталчлан шалгаруууллаа.

5.СУРГАЛТ, АРГАЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

3-р сарын 21-22-ны өдрүүдэд Аймгийн Соёл Урлагийн Салбарын Хөгжлийн бодлого анхдугаар зөвлөгөөнийг Соёл Урлагийн Газраас зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Нийтийн номын сангийн арга зүйч П.Дарьсүрэн Номын сангийн шинэчлэгдсэн хууль, номын сангийн үйл ажиллагааны хэтийн төлөвийн талаар илтгэл тавилаа.

Тус зөвлөгөөний үеэр сумдын соёлын төвийн номын санчдад арга зүйн зөвөлгөө өгөн , сургалт зохион байгуулав.

2022 оны 03 дугаар сарын 24-ны 16 цагт Гамшгаас хамгаалах дуут дохио дуугарахад Нийтийн номын сангийн албан хаагчид ажлын байрнаасаа уншигчдыг аюулгүй авч гаран жагслаа.

3 сарын 25-нд Ажлын байран дахь ажилчдын стрессийг тайлах зорилгоор 4-р сургуулийн сэтгэл зүйч Ц.Байгальмааг урьж “Ажлын байран дахь стресс тайлах сургалт” –ыг зохион байгуулж албан хаагчдыг хамруулав.

2022 оны 6-р сарын 7-9-ний хооронд Соёлын салбарын удирдах ажилтны нэгдсэн хэлэлцүүлэг "Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого” сэдвийн дор Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Хэлэлцүүлэгт театр, музей, номын сан зэрэг Соёлын яамны харьяа болон аймаг, нийслэл, сумдын соёл урлагийн байгууллагын удирдлагууд тус тусын мэргэжил чиглэлийн дагуу салбар хэлэлцүүлэгт оролцлоо. Салбар хэлэлцүүлгийн хүрээнд Соёлын яамны Төрийн захиргаа удирдлагын газраас 21 аймгийн Соёл урлагийн газрын дарга нарт “Төрийн албаны шинэтгэл-Соёлын салбарт”, “Соёл, урлагийн хөгжлийн стратеги”, “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”, “Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвүүдээр илтгэл хэлэлцүүллээ.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор

ЕБСургуулийн сурагчдад Номын өргөөний ид шид танилцуулга, лекцийг хийлээ.

2022 оны 09 дүгээр сарын 26-нд Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиар, 10 дугаар сард Монгол хэлний тухай хуулиар, 11 дүгээр сард Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухйа, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчллөт оруулах тухай, Хууль зүйн туслалцааны тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулиудаар тус тус албан хаагчиддаа сургалт хийлээ.

6.ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2022 онд жилд байгууллагын гадна орчны цэвэрлэгээ болон цасыг тогтмол цэвэрлэн ажиллаа.

Соёлын өвийг хамгаалах өдрийг тохиолдуулан Алтай хотын төвд байгаа хөшөө дурсгалын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд тус байгууллага нь 40 жил өндөрлөгийг угааж цэвэрлэн ойр орчны цэвэрлэгээг хийлээ.

Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн,

аймгийн Засаг даргын санаачилсан "108 сая мод тарьж, ургуулах" аяны хүрээнд хаврын мод тарих өдрийн нээлтийн арга хэмжээ 2022 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдаж, аймгийн хэмжээнд 12 төрлийн 24000 орчим суулгацыг тарилаа. Тус аяны хүрээнд байгууллагын албан хаагчид Баянхайрхан багийн 9 дүгээр гудамжны арын талбайд 50 ширхэг хайлаас мод, цэцэрлэгт хүрээлэнд 7 ширхэг модыг тарьж, цаашид арчилж, тордон, ургуулах ажлыг хариуцахаар боллоо.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Удирдлага зохион байгуулалт:

Үйл ажиллагаандаа Номын сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Монгол хэлний тухай хууль болон Төрөөс соёлын талаар баримтлах бодлого хөтөлбөр, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Программын шинэчлэлийн 570,000 төгрөгийг Соёлын яамны соёл гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэгт хүсэлт гарган шийдвэрлүүлж 2022.04.22-ны өдөр "Волвес ХХК"-тай гэрээ байгуулан Lib4 номын сангийн цогц программ хангамжийн шинэчлэлийг хийлгэж Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн номын электрон каталогийг GOVISUMBER.LIB4U.NET линкээр болон QR кодыг уншуулан иргэд уншигчдыг гар утаснаасаа харах боломжийг бий болгосон.

Байгууллагын вэб сайтыг шинэнчлэн байгууллагын үйл ажилллагаатай холбоотой мэдээллүүдийг байршуулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу байгууллагын 2006-2021 оны үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой "А" тушаал 593 хуудас, 2012-2021 оны хүний нөөцийн холбогдолтой "Б" тушаал 693 хуудас, 2015-2021 оны 70 баримтыг pdf программд шилжүүлж архив, албан хэрэг хөтлөлтийн "AMSG" программд 100% оруулан цахим архив үүсгэсэн.

Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд: 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр админ эрх авч байгууллагын 10 албан хаагчдыг бүртгэн ERP системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

ERP системийн дэд цэсүүдийг бүрэн ашиглаж албан хаагчдад үүрэг даалгавар өгч, албан бичиг шилжүүлэх, ирсэн явсан бичгийг тогтмол хүлээн авч, ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн явуулах зэрэг албан байгууллагуудтай холбогдон үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж байна.

Иргэдэд ном хэвлэл мэдээллээр үйлчлэх ажлын хүрээнд:

Уншлагын танхимаар 4309 уншигчид 8959 номоор үйлчилж, шинээр 1450 уншигчид карт нээж үйлчилсэн.

Гэрээр ном олгох үйлчилгээг 467 уншигч иргэдэд 775 ширхэг ном олгож үйлчилсэн.

Зөөврийн номын үйлчилгээг 39 байгууллагын 236 албан хаагчдад 315 ном, хэвлэл олгож үйлчилсэн.

ШШГ 425 дугаар нээлттэй хорих ангийн Нийгмийн ажилтан Солонготой хамтран ажиллах гэрээ байгуулан тусгай бүлгийн 46-н иргэнд 288 ном олгож үйлчилсэн.

Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын сангийн пэйж хуудсанд давхардсан тоогоор 548 цахим номыг байршуулахад 14067 уншигч хандалт хийж уншсан байна.

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг хөдөөгийн 4,5,6 дугаар багын иргэдэд 2022 оны 05 дугаар сарын 04, 05, 06, 06 дугаар сарын 16, 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд нийт 3 удаа хүргэж үйлчилсэн. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулж, шинэ номын танилцуулга хийж брюшур гарын авлага 220 тарааж, 203 ширхэг шинэ номоор үзэсгэлэн гаргасан. 675 иргэд хамрагдсан.

Танин мэдэхүйн "АХА" цэнгээнт тэмцээн, С.Буяннэмэхийн нэрэмжит "Таван хором" шүлгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулсан. 4,6 дугаар 79 иргэн оролцсон. **Сан хөмрөгийг шинэ ном хэвлэлээр баяжуулах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

Фондын сан хөмрөгийг Нийт 713 нэр төрлийн 1445 ширхэг 26.098.294 төгрөгийн номоор баяжуулсан. Үүнээс:

Төсвийн хөрөнгөөр 453 нэр төрлийн 899 ширхэг 16.827.166 төгрөгийн бэлэг хандиваар: 260 нэр төрлийн 546 ширхэг 9.271.128 төгрөгийн тус тус баяжуулсан.

Фондын сан хөмрөгийн дулаан чийгшлийн бүртгэл хөтөлж, номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS5742:2019 стандартад заагдсан сан хөмрөгийн байрны дулааан (18 2) С, агаарын чийгшил 55%-д хүргэж сан хөмрөгийн дулаан чийгшлийг сайжруулсан.

Ном ариутгагч төхөөрөмжийг худалдан авч, ном хэвлэлийг стандартын дагуу цэвэрлэн, ариутган хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.

Ном хэвлэлийг мэрэгч амьтан, хортон шавьжнаас хамгаалах зоилгоор “Сүмбэр гурван бат” ХХК мэргэжлийн байгуулагаар 250 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.

Хөрөнгө, хөрөнгө оруулалт, бэлэг хандиваар шинээр ирсэн номонд хамгаалалтын соронзон ялтас байршуулж хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.

Ном хэвлэлийг сурталчилах ажлын хүрээнд:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 38 удаа 1111 ном хэвлэлээр гаргаж сурталчилсан. Нийт 1867 уншигч хамрагдсан. Үүнд:

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 25 удаа гаргаж, 759 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж, контент хийж сурталчилсан. 1275 уншигч хандалт авч хамрагдсан.

Шинэ номын үзэсгэлэнг 13 удаа 352 ширхэг номоор гаргасан 592 уншигч хамрагдсан.

Лавлагаа ном зүйн үйлчилгээний ажлын хүрээнд:

Лавлагаа ном зүйн үйлчилгээг цахимаар болон амаар, бичгээр нийт 861 уншигчдад лавлагаа өгсөн. Шинэ номын мэдээг 510 ширхэг номоор бэлтгэн гаргасан.

Электрон каталогт редакц хийж 850 ширхэг цаасан каталогийг төрөл анги үсэг дараалаар каталогийн шүүгээнд байршуулсан.

Уншлагыг дэмжих соёлын олон талт ажлыг зохион байгуулах, уншигчийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Ном уншлагын сарын аяныг 2022.04.20-ны өдрөөс 05.20-ны өдөр хүртлэх 1 сарын хугацаатай зохион байгуулсан. Нийт 1466 сурагчид хамрагдаж 4013 ширхэг ном уншсан байна.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан, Монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлах, монгол бичгийн цахим бичвэр боловсруулах чадварыг нэмэгдүүлэхэд зорилгоор “ЦАХИМ БИЧВЭР-2022**”** уралдаан, зохион байгуулсан. 31-н иргэд, уншигчид хамрагдсан.

Монгол бичгээр дагнасан номын үзэсгэлэнг цахимаар зохион байгуулсан. 96-н иргэд, уншигчид хандалт хийж үзсэн байна

УИХ-н дарга Г.Занданшатарын ивээл дор “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриан дор “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2022 НОМЫН БАЯР”-ын хүрээнд 28 арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 5377 иргэд, уншигчид хамрагдсан.

Боржигин түмний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, срталчилах ажлын хүрээнд 3 арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149-р зарлигт Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлийг томьёолж монголын түүх сурвалжуудыг ишлэсэн “ЭРДЭНИЙН СУДАР”-ыг төрийн ордноо дээдлэн залах зарлиг буулгасантай холбогдуулан монгол хүний эрхэмлэн дээдлэх 9-н үнэт зүйлсээр 85 гарын авлага бэлтгэж ЕБ-ын 2 дугаар сургууль, лаборатори 5 дугаар сургуулийн дунд ахлах ангийн сурагчдад сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 300 сурагчид хамрагдсан.

.Монгол хүний эрхэмлэн дээдлэх 9-н үнэт зүйлсээр контент бэлтгэн Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан пэйж, Говьсүмбэр номын сан фэйсбүүк,

library.gs.gov.mn цахим хуудсанд байршуулж иргэд уншигчдад хүргэсэн. Сурталчилгааг 525, контентийг 291 иргэд уншигчид хандалт хийж үзсэн байна.

Боржигины өв соёлыг сурталчилан “Боржигины өв соёл” номын танилцуулга контент хийсэн. 187 иргэд уншигчид хандалт хийж үзсэн байна.

“Номонд суурилсан бүтээлч сургалт” зохион байгуулах ажлын хүрээнд: Эсгий ширмэл урлалын багш Б.Буянжаргалыг урьж анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 31-н сурагчид хамрагдсан.

Соён гэгээрүүлэх танин мэдэхүйн 1090 мэдээллийг Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан пэйж хуудсанд байршуулсан. Нийт 10500 уншигч, иргэд хамрагдсан байна.

Орон нутгийн брэнд/-г бий болгох ажлын хүрээнд: Гавьяат зоо техникч Ц.Тэрбишийн “КАРАКУЛЬ ХОНЬ” номын тухай контент хийж уншигч иргэдэд сурталчилсан.

Контентийг Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын сан пэйж хуудсанд байршуулсан. Нийт 401 уншигч хандалт хийж үзсэн байна.

“Соёлын бүтээлч" сар ажлын хүрээнд:

Шилдэг ном "Цагаан хөмсөгт" номын зохиогч МУСГЗ РАГЧААГИЙН БАТЖАРГАЛ зохиолчийг урьж "ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ"-ыг зохион байгууллаа. Нийт 55 сурагч хүүхдүүд хамрагдсан.

"МОНГОЛ БИЧГИЙН НОМ" "ХОВОР НОМ СУДАР"-ын үзэсгэлэнг 2022 оны 11-р сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэнг 1917-1940 оны төвд хятад барын судар, Монгол бичгийн 1914-2022 оны номнуудаар гаргаж 71 уншигч иргэд хамрагдсан.

"Соёлын бүтээлч үйлдвэрлэл" Монгол бичгээр өөрсдийн хийсэн "Номын онч үг" Насанд хүрэгчид хүүхдийн номонд зориулсан "Номын хавчуурга" "Номын богц"-ыг байршуулан шинэ номоор үзэсгэлэн гаргасан. Нийт 48 уншигч хамрагдсан.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД:

Монгол бичгээр “оюуны чихэр”, “Номын хавчуурга”-ыг уншигч хүүхэд багачууд, иргэдэд зориулан 2 төрлөөр үндэсний бичгээр бичиж байгууллагын пэйж хуудсанд байршуулсан. Нийт 300 ширхэгийг хэвлэн гаргаж шинээр ирсэн ном хэвлэлд байршуулсан.

Игэдэд зориулан мэдээ мэдээллийг үндэсний бичгээр бичиж байгууллагын пэйж хуудсанд байршуулсан. Нийт 50 ширхэгийг хэвлэж гаргасан. Номын богц 2 ширхэгийг хийж зөөврийн номын үйлчилгээнд ашиглаж байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дархан-Уул 2022.12.05

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг Аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, соёл танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулж, оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэхийн төлөө бүхий л ажлаа чиглүүлэн цагийн нөхцөл байдалд тохируулан ажлын арга хэлбэрээ танхимын болон цахим хосолсон хэлбэрээр явуулж, номын сангийн таатай орчинг бүрдүүлж иргэд уншигчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг олон хэлбэрээр номын сангийн үйл ажиллагааг сурталчилан амжилттай ажиллаж байна.

<u>НЭГ. УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЛААР</u>

Аймгийн Төв номын сан нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Соёлын тухай, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Соёлын Яам, орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагуудаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж, Соёлын яам, Үндэсний номын сангийн чиглэл, арга зүйн хүрээнд номын сангуудын консерциум болон орон нутгийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавруудад хариуцлага санаачлагатай хандан хамтран ажиллаж ирэв. 2022 оны жилийн эцсийн байдлаар 15 ажиллагсадтай, 2 салбар номын сантайгаар орон нутгийн уншигч иргэдэд төрийн үйлчилгээг уламжлалт болон цахимаар үзүүлж ирлээ.

Түүнчлэн 2022 оны жилийн эцсийн байдлаар төсөв 288.591.800 төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл 288.591.800 төгрөг байна.

Утга	Төсөв	Гүйцэтгэл
Цалин хөлс	201 334 600	201 334 600
Нийгмийн даатгал	25 166 800	25 166 800
Байр ашиглалт	5 282 900	5 282 900
Хангамж бараа	11 314 300	11 314 300
Ном хэвлэл	5 000 000	5 000 000
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	33 469 400	33 469 400

- ✓ 2022 онд өр авлагагүй, төлөвлөгөөний гүйцэтгэлд 3673000 сая төгрөгийг өөрийн орлогоор нөхөн бүрдүүлээд байна.
- ✓ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс “Шилэн дансны болон төсөв санхүүгийн ил тод байдал” самбарыг цаасан болон цахим хэлбэрээр сар бүр тогтмол ажиллуулж номын сангийн төсвийн нээлттэй байдлыг хანган ажиллаж байна.
- ✓ Төрийн байгууллагуудын нэгдсэн **Эйбл** программаас шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

- **Зөвлөлдөх уулзалт:** Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Соёл, урлагийн газрын дэмжлэгтэйгээр "Музей, Номын сангийн үзэл баримтлал боловсруулах арга зүй" сэдвээр хамтарсан зөвлөлдөх уулзалтыг хийж сургалт, мэдээлэл солилцов.

  Тус сургалтад илтгэгчээр: Соёлын яамны НСБХЗ шинжээч Б.Баяраа, Монгол улсын Үндэсний номын сангийн ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох

хэлтсийн дарга Г.Гүнжинлхам, Үндэсний номын сангийн Ерөнхий номын санч Т.Баярлах, Байгалийн түүхийн музейн сан хөмрөгийн хэлтсийн дарга, доктор Ж.Мяндас, Японы соёлын өвийн гадаад хамтын ажиллагааны консорциумын гишүүн, сэргээн засварлагч, доктор О.Ангарагсүрэн нар оролцож Соёлын тухай хууль, Номын сангийн тухай, ЗГҮАХ-ийн хэрэгжилт, номын сангийн үзэл баримтлал, үндсэн чиглэл боловсруулах тухай ойлголт, хэрэгцээ шаардлага мэдээлэл танилцуулгыг хийхийн зэрэгцээ MNS ISO11799:2019 стандарт, MNS5742:2019 стандартыг шинэ номын сангийн үндсэн чиглэлд хэрхэн тусгах тухай ойлголт, Музейн тухай хууль, музейн үзэл баримтлал, үзүүлэг дэглэлтийн үндсэн чиглэл зэрэг чухал сургалт, мэдээллийг өглөө.

- **Нүүдэлчин Монгол наадам:** Дархан-Уул аймаг тус наадамд 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцсон бөгөөд Аймгийн Төв номын сангийн зүгээс Ахлах номын санч Г.Нямцэнд Соёлын биет бус өвийн гэрийг хариуцан оролцсоноор “Нүүдэлчин Монгол” наадамд оролцогчдын бүтээлийг 7000 гаруй иргэнд сурталчилж, тайлбарлан таниулсаны үр дүнд ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ-аар дараах хүмүүс шалгарлаа.
  - ✧ Монгол бичиг QR код" бүтээлээр Дархан-Уул аймгаас оролцогч, багш Б.Булганчимэг,
  - ✧ "Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд" төрөлд багш Ж.Эрхэмсайхан,
  - ✧ "Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл" төрөлд багш Ц.Буянхишиг нар шалгарч ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ медаль, мөнгөн шагналаар шагнууллаа.

ХОЁР. ФОНД, БҮРДҮҮЛЭЛТ, КАТАЛОГИ

Ном бүрдүүлэлтийг “Номын сангийн хууль” болон ном худалдан авах журмын дагуу татгалзлал, уншигчийн судалгаанд үндэслэн номын худалдаа, зохиолч, уран бүтээлчид, ард иргэдийн хандив, тусламжаар фондоо бүрдүүлж ирлээ.

2022 онд 15 818 450 төгрөгийн 1435 нэр төрлийн 1751 боть номоор фондоо бүрдүүлэв. Үүнд:

- ✓ Худалдаагаар 9 306 260 төгрөгний 250 нэр төрлийн 555 боть,
- ✓ Бэлэг хандиваар 6 512 190 төгрөгний 1185 нэр төрлийн 1196 боть номоор

Дархан-Уул аймгаас Лондон хотод ажиллаж амьдарч буй иргэдийн санаачлагаар англи хэл дээр хүүхдэд зориулсан 1000 орчим ном хандивласныг хүлээн авч, ном тус бүрт дардас дарж, үндсэн хөрөнгөнд бүртгэж авлаа.

Үнэт ховор номын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Ганжуур”, “Данжуур”, “Сангийн ном”, “Сүмбум” зэрэг 400 боть судар, шинээр ирсэн 1194548 төгрөгний 71 боть ном, уншигчийн хэрэгцээнд байнга гардаг шинжлэх ухаан болон уран зохиолын номонд нийт 900 ширхэг соронзон ялтас байршуулан байрлууллаа.

Нэгбүрчилсэн бүртгэл: 28922 боть

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2179 “Улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж хүргүүлэх тухай”, байгууллагын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/04 тоот тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс ойрын болон үндсэн фондны номыг салбар тус бүр шинээр нэгбүрчилсэнд бүртгэлд:

- Төв уншлагын танхим – 10728 боть
- Салбар номын сан – 9243 боть
- Архивын фонд - 8951 боть нийт **28922** боть номыг тус тус бүртгээд байна.

Номтой өдөр ба ном солилцоо: 8 удаа 402 ирцэд 300 гаруй боть ном

Дархан сумын ИТХын Тэргүүлэгчдийн тогтоолоор сар бүрийн 17-ныг “Ном солилцох өдөр” болгон зарласантай холбогдуулан сар бүрийн 17-нд тус үйл ажиллагааг нийт 8 удаа зохион байгуулж, 300 гаруй боть ном солилцож 402 иргэнийг хамрууллаа.

Үндэсний Тогтмол хэвлэлийн нэгдсэн санд: 1737 хуудас 6922 тал

Найрамдлын Дархан сонины 1983,1984,1985,1986,1988 оны 426 дугаар 1737 хуудас 6922 талыг цахим сүлжээнд оруууллаа.

Д/д	Сонины нэр	Он	Дугаар	Хуудас	Тал
1	Найрамдлын Дархан	1983	85	344	1376
2	Найрамдлын Дархан	1984	89	360	1410
3	Найрамдлын Дархан	1985	79	322	1288
4	Найрамдлын Дархан	1986	80	328	1312
5	Найрамдлын Дархан	1988	93	384	1536
		5	426	1737	6922

<u>Ном сэлбэн засалт:</u> 93 нэр төрлийн 121 боть ном, тогтмол хэвлэлийг сэлбэн засаж, үдэж хавтаслав.

- ✓ Н.Дариймаа. Монгол эрэгтэйн гарын ном 109 хуудастай 4 ном, Н.Дариймаа. Монгол эмэгтэйн гарын ном 118 хуудастай 2 ном, Н.Дариймаа. Монгол эрэгтэйн гарын ном 109 хуудастай 1 номны 9-49 дүгээр хуудсуудыг нөхөж цэгцэлж, сэлбэн засаж уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.
- ✓ ***Тогтмол хэвлэл:*** Тогтмол хэвлэлийг 82 нэгж болгон үдэж хавтаслан үндсэн фондонд шилжүүллээ.
  - 2018- 2021 оны тогтмол хэвлэл 51 нэгж
  - 2022 оны тогтмол хэвлэл 31 нэгж

<u>ГУРАВ. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ</u>

Аймгийн Төв номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын жагсаалт гаргах, ном хэвлэлийн тойм хийх, уншигчдад хэрэгцээтэй материалуудыг хувилах, онлайн хэлбэрт байршуулах, мэдээллийг түгээх зэргээр уншигчдын эрэлт хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Төлөвлөгөөт ажил:

Д/д	Ажил үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Байнгын уншигч	3800	5102	134,2%
2	Ирэгсэд	55 000	55053	100,09%
3	Ном олголт	60 000	70937	118,2%

Шинээр бүртгүүлсэн нийт 5102 уншигчдын зургийг авч, номын сангийн LIB4u программд бүртгэж, 3673000 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна.

Гэрээр ном олгох: 270 ***уншигчид*** 467 ***боть ном***
Номын санд удаан хугацаагаар суух боломжгүй иргэд уншигчид болон өндөр настан, бусад шалтгаантай 270 гаруй уншигчдад 467 боть ном олгож үйлчиллээ.

***Нүүдэл зөөврийн үйлчилгээ: 23 удаа 1037 хүнд 1360* боть ном олгож үйлчиллээ.**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/821 дүгээр тушаалын хэрэгжилтийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа. Үүнд:

- ✓ ШШГЕГ-ын хаалттай 435 дугаар ангийн номын сангийн захиалгын дагуу 3 удаа 83 боть,
- ✓ ОБГ-ын албан хаагчдын захиалгын дагуу 14 боть,
- ✓ Энэрэл цогцолбор сургуулийн номын санч Одгэрэлд захиалгын дагуу 8 боть ном,
- ✓ Эрүүл мэндийн газарт Анагаах ухаан эрүүл мэнд сэдвээр 20 хүнд 50 боть ном
- ✓ Онцгой байдлын газарт Амьдралын хичээл сэдвээр 110 хүнд 120 боть ном
- ✓ Зэвсэгт хүчний 0330 дугаар ангид Хувь хүний хөгжил сэдвээр 120 хүнд 120 боть ном
- ✓ Цайхун сургуульд Номын ертөнцөөр сэдвээр 240 хүнд 250 боть ном
- ✓ Шарын гол сумын 2,6-р сургуульд Номын сайн нөхөр сэдвээр 120 хүнд 120 боть ном
- ✓ Хонгор сум 14-р сургуульд Номын сайн нөхөр сэдвээр 100 хүнд 115 боть ном
- ✓ Хонгор сум 11-р сургуульд Залуу хүний заавал унших ном сэдвээр 140 хүнд 140 боть ном
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэст “Оюунлаг Дарханчууд-Улсын бүртгэлд” сэдвээр 30 хүнд 50 боть ном
- ✓ 3 дугаар цэцэрлэг бэлтгэл бүлэгт “Оюунлаг Дарханчууд-Цэцэрлэгт” сэдвээр 30 хүнд 60 боть ном
- ✓ Дархан дээд сургуульд 35 боть номыг хүлээлгэн өгч уншуулан буцаан авлаа.
- ✓ ГБХЗХГазар дээр 4 боть номыг 10 албан хаагч
- ✓ Ахмадын Хөгжлийн газар дээр 4 боть, 12 албан хаагч
- ✓ Дархан сумын ЗДТГ дээр 4 боть, 34 албан хаагч
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэс дээр 5 ном, 32 албан хаагч
- ✓ 22 дугаар цэцэрлэг 5 боть, 11 албан хаагчид
- ✓ 18-р цэцэрлэгт захиалгын дагуу 2 удаа 54 боть номоор
- ✓ 30-р цэцэрлэгт захиалгын дагуу 1 удаа 30 боть номоор
- ✓ 15-р сургууль 1 удаа 25 боть номоор
- ✓ 18-р сургууль 1 удаа 35 боть номоор
- ✓ Ангаахын их сургуульд 1 удаа 9 боть номоор тус тус нүүдэл зөөврийн номын сангаар хүлээлгэн өгч, авлаа.

Номын тойм: 9 удаа 218 ирцэд:

1.Бужинлхам.Д - Цойлогсод, Дулам.Б - Амьдралд бэлэн үү охин үр минь, Алтангэрэл.Ж- “Дархан” бүтээн босголтын он жилүүд зэрэг номуудаар 9 удаагийн тойм яриа хийсэн.

Чанга уншлага: 10 удаа 447 бяцхан хүүхэд багачуудад

- ✓ Төвөөс алслагдмал 6-р багийн нутаг дэвсгэрт байрлах 3 дугаар цэцэрлэгийн Болормаа багштай Бэлтгэл А бүлгийн 30 хүүхдэд “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлагыг “Усны үхрийн үзэсгэлэн гоо шалгаруулах уралдаан” сэдэвтэй үлгэрээр зохион байгууллаа.
- ✓ 18-р цэцэрлэгийн Бэлтгэл-А бүлгийн 27 хүүхдэд “Өнчин галт хорхой” үлгэрээр
- ✓ 10 дугаар цэцэрлэгийн 88 хүүхдэд “Бардам туулай” үлгэрээр
- ✓ 21 дүгээр цэцэрлэгийн 120 гаруй хүүхдэд “Бэлэн амт хулгана” үлгэрээр
- ✓ ОИЦ сургуулийн 3-11 ангийн 25 сурагчдад Д.Нацагдоржийн намтар уран бүтээлээр чанга уншлага хийж
- ✓ 31-р цэцэрлэг Бэлтгэл, Ахлах, Дунд, Бага бүлгийн нийт 92 хүүхдэд “Ягаан шаахай”, Сургажит өгүүллэг-3, Хүний мөс, Гэр бүлийн мод зэрэг нийт 10 удаа

382 бяцхан хүүхэд багачуудад үлгэрийн болон бусад сэдвээр чанга уншлага хийж хүүхэд багачуудад номоо сурталчиллаа.

Өглөөний уншлага аян: 5 байгууллага 25 боть ном

Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас гаргасан удирдамжийн дагуу "Удирдах ажилтны ширээний ном" уншлагын аяны арга хэмжээг ажилтан албан хаагчдад, дэлхийн хэмжээний сэтгэгчдийн шилдэг бүтээлүүдтэй уншиж танилцах, сэтгэлгээний урлагийн гоо сайхныг танин мэдэх боломжийг олгох зорилгоор зохион байгуулж, энэхүү аянд:

- Дархан-Уул аймгийн ГБХЗХГазар,
- Ахмадын Хөгжлийн Газар,
- Дархан сумын ЗДТГазар,
- Улсын Бүртгэлийн Газар
- 22 дугаар цэцэрлэг зэрэг 5 албан байгууллага хамрагдаж удирдамжинд заасан 5 боть номыг уншиж, уншсан номын тухай сэтгэгдлээ бусадтайгаа хуваалцан тус аяны бүртгэлд номын тухай тэмдэглэлээ бичиж үлдээлээ.

Урилгат уншлага: 20 ангийн 658 сурагч.

Жил бүр уламжлал болгон түүхт ой тэмдэглэлт өдрүүд болон Үндэсний бичиг үсгийн баяр, Дэлхийн номын өдөр зэрэг ном тойрсон үйл ажиллагааны хүрээнд урилгат уншлага зохион байгуулдаг. Үүнд:

- 4-р сургуулийн 6в ангийн 9 сурагч
- Од цогцолбор сургуулийн Одхүү багштай 6-4-р ангийн 35 сурагч
- ОИЦ-ын 4-3-р ангийн 45 сурагч
- 16-р сургуулийн Галтмаа багштай 4в ангийн 32 сурагч
- Янжмаа багштай 2в ангийн 33 сурагч
- Энэбиш багштай 4б ангийн 35 сурагч
- Чулуунцэцэг багштай 4г ангийн 38 сурагч
- Монгол-Оюу сургуулийн 1-2-р ангийн 28 сурагч
- Цайхун сургуулийн 4а ангийн 23 сурагч
- Од цогцолбор сургуулийн Д.Жавхлантөгс багштай 9д ангийн 35 сурагч
- Хонгор сумын 14 дүгээр сургуулийн Б.Урнаа багштай 6а ангийн 28 сурагч
- 1-р сургуулийн Марал-эрдэнэ багштай 8^{а} ангийн 34 сурагч,
- Оюунмандах багштай 5^{в} ангийн 30 сурагч,
- 16-р сургуулийн Ц.Энэбиш багштай 5^{б} ангийн 36 сурагч,
- 16-р сургуулийн Пүрэвсүрэн багштай 6^{б} ангийн 32 сурагч,
- 18-р сургуулийн Д.Номин багштай 10^{б} ангийн 24 сурагчдад
- 15-р сургуулийн С.Батбаатар багштай 4/д ангийн 46 сурагчдад
- Б.Энхбат багштай 5/б ангийн 46 сурагчдад
- Сэлэнгэ багштай 9/в 35 сурагчдад
- Баярмаа багштай 18-р сургуулийн 8/г анги 29 сурагчдад нийт 9 ангийн 312 хүүхдэд карт нээж, номын сангаа танилцуулан, электрон каталогоос хэрхэн ном хайх тухай танилцуулан уншигчаар бүртгэлээ.
- Сургуулийн номын санч Г.Адъяасүрэн, Соёлын төвийн номын санч Я.Цэцгээ болон сумын номын сангийн ахмад уншигч Хөдөлмөрийн баатар Ж. Батдэлэг болон идэвхтэн 5 уншигчийн хамтаар ирлээ.

Нийт 20 ангийн 658 сурагчдад номын санг танилцуулж, цахим номыг ашиглах, номоо хэрхэн захиалж унших талаар зөвлөгөө өгч, номын сангийн үйл ажиллагааны талаар танилцуулж, номын сангаар зочилсон хүүхдүүдэд үнэгүй карт нээж уншигчаар бүртгэв.

Зуны уншлага- 9 удаа 383 хүнд

№	Үйл ажиллагаа	Зохион байгуулах газар	Тоо	Тайлбар

1.	Зуны уншлага 4 удаа 195 хүн	5,6,15-р баг, “Дархан-50” цогцолбор дээр	85	Гүүд нейборс ОУБ-тай хамтран 15-р багийн 40 хүүхдүүдийн дунд, мөн “Дархан-50” цогцолборт 45 хүүхдийн дунд тус тус явууллаа. Зуны уншлаганд хүүхдийн болон хувь хүний хөгжлийн, танин мэдэхүйн номоор үзэсгэлэн гаргаж, хүүхдийн эрхийн тухай сургалт явуулж идэвхитэй оролцсон хүүхдүүдэд гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг хийлээ. Нийт 200 боть номоор үзэсгэлэн гаргаж уншлаганд гаргаж, үзэсгэлэнгээ танилцуулж ажиллаа.
2.		Найрамдал талбай дээр 2 удаа	110	Номын баярыг угтаж “Найрамдал талбайд” зуны уншлага”-г талбайгаар зорчиж байгаа иргэдийн дунд 2 удаа хийж уншигчдийг цэвэр агаарт ном унших таатай нөхцөлийг төрүүлж, хувь хүний хөгжлийн болон номын санд шинээр ирсэн номоор үзэсгэлэн гаргаж түүнийгээ танилцуулан уншигчдийн хүртээл болгон ажиллаа. Зуны уншлаганд Нийт 110 гаруй хүн уншлаганд хамрагдаж 100 гаруй хүн номын үзэсгэлэнг үзэж оролцлоо.

Номын сан хоорондын ном солилцоо: 218 нэр төрлийн 234 боть

Өөрийн номын сангийн фондонд байхгүй номыг уншигчдын захиалгын дагуу бусад номын сангаас ном солилцох журмын хүрээнд:

- Анагаахын сургуулийн багш оюутнуудад зориулан тэдний мэргэжлийн манай фондонд байхгүй 39 нэр төрлийн 55 боть номыг АШУҮИС-ийн номын сангаас солилцоогоор авч үйлчилж байна.
- Мөн Дархан дээд сургуульд 35 боть,
- 18-р цэцэрлэгт захиалгын дагуу 2 удаа 54 боть ном
- 30-р цэцэрлэгт захиалгын дагуу 1 удаа 30 боть ном
- 15-р сургууль 1 удаа 25 боть ном
- 18-р сургууль 1 удаа 35 боть ном нийт 7 байгууллага 218 нэр төрлийн 234 боть номоор солилцоо үйлчилгээ хийсэн байна.

Төв уншлагын танхимд байхгүй 14 боть номыг Архивын фондоос захиалгаар авч уншигчдад мэдээллийг цаг алдалгүй хүргэж үйлчиллээ.

Номын сантай танилцах аялал: 17 байгууллагын 574 иргэд

- 15 дугаар сургуулийн Л.Октябрь багштай 5в ангийн 46 сурагч,
- Э.Алтанцэцэг багштай ОИЦ сургуулийн 11-3 ангийн 37 сурагчид,
- Од цогцолбор сургуулийн Жавхлантөгс багштай 9д ангийн 34 сурагч
- ОИЦ сургуулийн Б.Энхтуяа багштай 4-1 ангийн 45 сурагч,
- 15-р сургуулийн Октябрь багштай 5в ангийн 32 сурагч,
- ОИЦ сургуулийн Батбаатар багштай 4-3 ангийн ангийн 45 сурагч,
- Од цогцолбор сургуулийн 6-4 ангийн 35 сурагчид,
- 4 дүгээр сургуулийн 6в ангийн 9 сурагч
- ОИЦ сургуулийн Нямгэрэл багштай 2-4 ангийн 37 сурагч,
- Цайхун сургуулийн 4а ангийн 23 сурагч,
- 16-р сургуулийн Галтмаа багштай 4в ангийн 32,
- Янжмаа багштай 2в ангийн 33 сурагч,
- Энэбиш багштай 4б ангийн 35,
- Чулуунцэцэг багштай 4г ангийн 38 сурагч,
- Хонгор сумын 14 дүгээр сургуулийн Б.Урнаа багштай 6а ангийн 28 сурагчид, сургуулийн номын санч Г.Адъяасүрэн, Соёлын төвийн номын санч Я.Цэцгээ болон сумын номын сангийн ахмад уншигч Хөдөлмөрийн баатар Ж. Батдэлэг болон идэвхтэн уншигч нарын хамтаар
- 12-дугаар цэцэрлэгийн Одшүрэн багштай бэлтгэл А бүлгийн 28 хүүхэд багачуудад номын сангийн үйл ажиллагааг танилцуулан, зурагтай номоор

зурагт уншлага хийлгэж, “Бээлий” хүүхдийн үлгэрийн номоор чанга уншлага хийлээ.

- 18-р сургуулийн Т.Ариунсанаа багштай 4а ангийн 37 сурагчид нийт 17 байгууллагын 574 иргэд номын сантай танилцах аялал хийсэн байна.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн: 37 ***удаа 2***698 ***боть номоор үзэсгэлэн гаргаж,*** 8309 ***хүнд сурталчилсан байна.***

Уншлага үйлчилгээний нэгж нь түүхт ой болон тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан номын сангийн фондонд байгаа ном хэвлэлээр үзэсгэлэн гаргаж уншигчдад, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, тэдний эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөт ажлын хүрээнд 40 удаа зохион байгуулахаас 37 удаа 2698 боть номоор үзэсгэлэн гаргаж цахимаар болон танхимаар сурталчилсан байна.

ДӨРӨВ.СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Нийт уншигч, олон нийтэд чиглэсэн 24 ***нэр төрлийн 280*** удаагийн Соёл, олон нийтийн ажлыг зохион байгуулснаар ***24 310*** уншигч, иргэд, төрийн албан хаагчид, сурагчид, эрх нь хязгаарлагдсан хүмүүжигчид зэрэг уншигчид оролцсон байна.Үүнд:

- ✓ **Уншигчдын бага хурал -1 удаа 80**
- ✓ **Эрдэм шинжилгээний хурал- 2 удаа 91 хүн,**
- ✓ **Сургалт- 43 удаа, 742 хүн**
- ✓ **Зохиолч уншигчийн уулзалт, шинэ номын нээлт - 6 удаа 349 хүн,**
- ✓ **Уралдаан - 23 удаа 6589 хүн**
- ✓ **Лекц- 25 удаа 1592 хүн,**
- ✓ **Өглөөлөг- 1 удаа, 20 хүнд**
- ✓ **Өдөрлөг - 19 удаа, 3844 хүнд**
- ✓ ***Үзэсгэлэн - 37 удаа 2698 боть ном 8309 хүнд***
- ✓ ***Уншигчдын бага хурал - 1 удаа 80 хүнд***
- ✓ ***Шинэ номын нээлт - 4 удаа 191 хүнд***
- ✓ ***Зуны уншлага - 9 удаа 383 хүнд гэх мэт...***

Чингис хааны эш хөрөг, монголын нууц товчоог хүндэтгэн залав

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД"-ийг Эзэн Богд Чингис хааны эш хөрөг болон түүхэн сурвалжийн ууган дээж бичиг Монголын нууц товчоог хүндэтгэн залах ажлаар эхлүүллээ. Тус үйл ажиллагаанд Дархан сумын ИТХ-ын дарга Я.Бат-Очир оролцож Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг сонордуулж, БШУГ-ын мэргэжилтэн А.Энхчимэг Их эзэн хааны үйл хэрэг, Монголын нууц товчооны талаар товч өгүүлж мэдээлэл хийлээ.

<u>Номын санчийн</u> “ХИШИГ ӨДӨР” зохион байгуулав

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны долоодугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор жил бүрийн есдүгээр сарын хоёр дахь ням гарагт Соёл, урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалын дагуу Монгол Улсын Соёл, урлагийн ажилтны 29 дэх өдрийг угтан Төв номын сангаас номын санчийн “ХИШИГ ӨДӨР”-ийг зохион байгууллаа.

Тус үйл ажиллагаанд зочин номын санчаар: Аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Дархан Сумын Засаг Дарга Т.Тулгаа, Сан хөмрөгчөөр: Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Ахмадын Хөгжлийн төвийн дарга А.Янжмаа, Дархан Сумын ИТХ-ын Төлөөлөгч, Ажил олгогч эздийн холбооны дарга Д.Соёлтуяа, Ном зүйчээр: Дархан Сумын ИТХ-ын Төлөөлөгч Б.Батцэцэг нар хүрэлцэн ирж Төв болон салбар номын сангуудад ажиллалаа.

<u>Номын баяр-2022</u>

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” үйл ажиллагааг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриатайгаар Соёлын яамны чиглэл, удирдлагын хүрээнд амжилттай зохион байгууллаа.

Улс орон даяар зохион байгуулсан тус үйл ажиллагааг аймгийн Төв номын сангийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай тушаал, төлөвлөгөөний дагуу 2 долоо хоногийн хугацаанд бүх шатны байгууллага, иргэд, уншигч олны дунд хүртээмжтэй байдлаар явуулж Соёл урлагийн газар, Төв номын сан, Музей, Залуучууд театр, Хүүхдийн номын ордон, бүх шатны боловсролын байгууллагууд зэрэг нийт 11 байгууллагын 90 гаруй ажилтан, албан хаагчид, СӨБ-ын байгууллагын 120 орчим хүүхэд багачууд, ЕБС-ийн 120 гаруй сурагч, 18 багийн ахмадын зөвлөлийн 230 гаруй ахмадууд номын баярын хөтөлбөрт үйл ажиллагаанд өнгө нэмж оролцов.

Номын баярын арга хэмжээнд УИХ-ын дарга Г.Занданшатар, УИХ-ын гишүүн МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, УИХ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайд Х.Болорчулуун, УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, УИХ-ын гишүүн Ч.Ундрам, Т.Аубакир нар оролцов.

<u>Уншигчдын бага хурал:</u>

1.	**Уншигчдын бага хурал**	Монголын уран зохиолын оргил гэгдэх "Монголын нууц товчоо", "Гэсэр", "Жангар" номоор	80	Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022 үйл ажиллагааг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих , номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ХИС-ийн харьяа Хүмүүнлэгийн дээд сургууль, АШУҮИСургуулийн оюутнууд оролцов.

<u>Сургалт</u> <u>4*3 удаа,* 742 ***хүнд:***</u>

№	Ажил үйлчилгээ	Зохиогдсон ажлын нэр	Орол -цогч	Хаана, хэнд зориулсан
	СУРГАЛТ: 43 удаа, 742 хүн	Сангийн сайд, Аймгийн Засаг даргатай уулзах уулзалт	5	Сангийн сайд, Аймгийн Засаг дарга нартай ТҮ-1-8-р цалинждаг ажилтнуудын төлөөлөл, цалин хөлсний талаар санал солицов. /2024.04.16/
		Номын сан-Музейн цогцолбор барилгын үзэл баримтлал боловсруулах ажлыг зохион байгуулах тухай цахим хурал	14	Номын сан-Музейн цогцолбор барилгын үзэл баримтлал боловсруулах ажлыг зохион байгуулах тухай цахим хурал зөвлөгөөнд оролцов. /2022.06.23/
		Монгол Улсын Үндэсний номын сан "Номын санч мэдээллийн ажилтны IX зөвлөгөөн"-нд цахимаар оролцов.	12	Монгол Улсын Засгийн газраас зорилт тавин хэрэгжүүлж буй "Цахим шилжилт", "Цахим үндэстэн", Соёлын яамнаас зарласан Соёлын бүтээлч сарын хүрээнд “Цахим эрин дэх үндэсний ном зүйн цахим мэдээллийн сан” сэдвийн дор зохион байгуулагдлаа.Зөвлөгөөний үеэр Олон Улсын Номын Сангийн Холбооноос гаргасан цахим номзүйн загвар болон бусад орнуудын цахим номзүйн судалгааны үр дүнд тулгуурлан цахим болон хэвлэмэл бүтээлийг улсын хэмжээнд нэгтгэн, мэдээллийн сан бий болгох, хэлэлцүүлэг зохион байгуулахаар болов.
		МУҮНСангийн Арга зүйчийн Цахим сан хөмрөг сэдэвт сургалт	3	Сан хөмрөгч, мэдээллийн ажилтанууд оролцов.
		"Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого" сургалт	1	Соёлын яам болон Соёл Урлагийн газраас Зохион байгуулсан Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого” цахимаар 1 хүн
		Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалт: “Статистик мэдээллийн нэгдсэн санг ашиглах”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үнэлгээ, анхаарах асуудал” сургалт	4	Удирдах ажилтан, бичиг хэргийн ажилтан нар хамрагдав.
		Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн цахим сургалтанд	20	Албан хаагчид, номын санчид хамрагдав.Давхардсан тоогоор 20 хүн хамрагдав.
		Харилцаа ба сэтгэл мэдрэмж” сэдэвт сургалтанд танхимаар	15	“Хайраас өвлөх хайр” ТББ-ын Тэргүүн, Сэтгэлзүйч М.Сарнай “
		б. Цахим сан хөмрөг МУҮНСан /цахим/	7	номын санч
		в. Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа" сэдэвт сургалтанд /танхим/	34	МУ-ын Үндэсний номын сангийн Мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Т.Хайдав 2022 оны III/29-өөс IV/01
	СУРГАЛТ: 43 удаа, 742 хүн	г. Номын санчдын техник технологийн сургалт /цахим/ Номын сангийн lib4u программын тухай нэгдсэн ойлголт буюу мөн программын үйл	27	ЕБС, Их дээд сургууль, Сумдуудын номын сангийн 27 номын санчийн бүрэлдэхүүнтэй цахимаар явагдаж эхэллээ. Сургалтыг номын сангийн программыг үүсгэн байгуулагч

		ажиллагааны талаар санал хүсэлтийг хэлэлцэх.		программист Инженер багш Гантулга явууллаа. /2022 оны 02 сарын 09/
		“Эрүүл идэвхтэй амьдарцгаая” эрүүл мэндийн сургалт	108	Дархан-Уул аймгийн Соёл урлагийн байгууллагуудын албан хаагчид хамрагдлаа.
		МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР: “Хос бичигтэн” сургалт	14	МУ-ын Үндэсний хөтөлбөрийн “Хос бичигтэн” болох ажлын хүрээнд Монгол бичгийн түвшин тогтоох судалгаанд хамрагдаж Монгол бичгийн 24 цаг
		Монгол бичгийн болон бийрэн бичлэгийн богино хугацааны сургалт	15	“Од” цогцолбор сургуулийн Монгол хэл, бичгийн багш Х.Одхүү /анхан шатны мэдлэг олгох/, С.Баасанхүү/бийрээр уран бичих/, Ц.Бадамцэцэг /цахимаар монгол бичгээр бичих арга/ зэрэг багш нар зааж сургалаа. “ТАТА ТУНГАА” хөгжөөнт тоглоомоор сонирхолтой хичээлээ оруулав.
		“Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх” цахим сургалтанд хамрагдав	3	Дархан-Уул аймгийн ҮЭ-ийн хорооноос зохион байгуулсан
		Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн цахим сургалтанд	3	Нэгжийн дарга нар
		Соёлын тухай хуулийн шинэчилсэн 24 дүрэм, хуучин 3 журмын тухай цахимаар	15	Номын санчид
		Үндэсний номын сангаас зохион байгуулсан “Номын сангийн сан хөмрөгт байхгүй түүх болон судалгаа, шинжилгээний ач холбогдол бүхий ном судрыг нөхөн бүрдүүлэх журам” цахим сургалтанд	5	Сан хөмрөгч, мэдээллийн ажилтан
		“Гамшигийн аюулын тухай зарлан мэдээлэл”-ийн дохиогоор ажиллах дадлага сургуулиулалтанд хамрагдав	58	ОБГ-аас 2022 оны 03 сарын 24-ний өдрийн 16:00 цагт орон даяар зохион байгуулсны дагуу уншигчдын хамт ажлын байраа түр орхин гадна талбайд гарч сургуулилтанд оролцлоо.
		Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын тухай сургалт	4	Захиргаа, аж ахуй
		Тогтвортой гэр бүл, хүрсэнээс минь илүү өндөр лекц	1	Гэр бүл судлаач, лектор Наранбаатар
		"Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний үе шатууд"	2	Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч, судлаач Ц.Буянзаяа
		Харилцааны 5 хэл лекц	14	Эртэч Дархан хөтөлбөрийн багш Б.Төмөр-Очир
	СУРГАЛТ: 43 удаа, 742 хүн	"Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", "Барим бичгийн стандарт MNS - 5140:2021" сэдэвт сургалт	1	Аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан Архивын сургалтанд хамрагдсан. /2022.04.29/
		"Номын ертөнц клуб" сэдэвт сургалт	31	Сургалтанд Аймаг орон нутгийн номын санчид оролцов.

		"Тэгш оролцоо-Тэгш хөгжил" сургалт	15	Аймгийн Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж буй "Тэгш оролцоо-Тэгш хөгжил" сургалтанд хамрагдлаа.Уг сургалтанд лектор Н.Энхбаатарын "Харилцаа ба Эерэг хандлага", сургагч багш н.Доржналжирмаагийн "Хайрын 5 хэл" номын сангийн албан хаагчид оролцов.
		"Хайрын хэл" гэж юу болох? сэдвээр сургагч багш Д.Доржналжирмаа, "Таны хүү залхуу биш" номоор орчуулагч Д.Дэмбэрэлмаа нар сургалт хийлээ.	4	Эртэч Дархан клубын Book Club-н нээлтийн үйл ажиллагаанд номын санчид оролцов.
		Соёлын боловсролын үндэсний сургагч багш" бэлтгэх сургалт	1	Улаанбаатар хотод 3 хоног
		Багш Отгонжаргалын "Иог" гэж юу вэ түүний ач холбогдол сэдэвт сургалт	15	Ажилтан албан хаагчид оролцов.
		Ёс зүйтэй, хүнд сурталгүй төрийн алба Эерэг хандлага,	15	Багш Амаржаргалийн сургалт номын сангийн уншлагын танхимд болов.
		Хамтран ажиллах ур чадвар сургалт	4	Удирдах болон бичиг хэргийн ажилтанууд оролцов. /2022.11.25/
		"Монгол урлал" даалин урлал, оёдлын сургалт	25	Аймгийн Эмэгтэйчүүдийн Холбоотой хамтарч, иргэд, уран бүтээлчид оролцов.
		"Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"	15	Дархан-Уул аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны "Зөв хөтөч" сургалтын төвийн багш Д.Мэндбаяр, Т.Баяржаргал нар "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"-аар сургалт мэдээлэл хийлээ.
		ҮЭ-ийн ажлыг эрчимжүүлэх 2 цагийн сургалт	1	ҮЭХ-н дарга С.Энхцэцэг оролцов. /2022.01.25/
		ҮЭ-ийн "Эмэгтэйчүдийн хөдөлмөрлөх эрх"	3	ҮЭХ-н дарга, тэргүүлэгчид хамрагдав. / 2022.01.27-нд/
		"Угийн бичгээ хөтөлцгөөе"	2	Аймгийн ГБХХЗГ-аас зохион байгуулсан 8 цагийн сургалт
		Хүүхдийн эрхийн сургалт	70	5,6,15-р багийн 70 гаруй хүүхдэд оролцов.
	СУРГАЛТ: 43 удаа, 742 хүн	Халдварт бус өвчин, эрүүл зөв зохистой хооллолт, "Идэвхтэй хөдөлгөөний ач тус" сургалт	135	Соёл урлагийн байгууллагын ажилтан албан хаагчид
		Үндэсний бичгийн цахим хэрэглээ сургалт	2	Соёлын байгууллагуудын хамарсан Хос бичигтэн сургалтанд монгол бичгээр бичих, гар утас ашиглах, үг хайх, галиглах, апп-суулгах, фонд суулгах зэргийг сурсан. /2022.11.17/
		Дархан-Уул аймгийн ҮЭ-ийн холбооны зөвлөлийн анхдугаар хуралдаан	2	2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Дархан-Уул аймгийн ҮЭ-ийн холбооны зөвлөлийн анхдугаар хуралдаан, ҮЭХ-н дарга нарын зөвлөгөөнд тус тус оролцов.
		"Эссэ" болон "Төсөл бичих арга" сургалт	15	2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Захиргаа аж ахуйгаас зохион байгуулав.
		Соёл урлагийн газраас зохион байгуулж буй Төрийн	8	Номын санч мэдээллийн ажилтанууд оролцов. /2022.05.11/

		албаны ажилчдын хүртээмж сэдэвтэй цахим сургалтанд хамрагдсан.		
		МУҮНС-аас судалгаа шинжилгээний ач холбогдол сэдэвт сургалт	32	Төв номын сан, Их дээд сургууль, ЕБС-ийн номын санчид оролцов. /2022.05.03/
		Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “1 дүгээрт хүүхэд” сэдэвтэй Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн анхдугаар зөвлөгөөн	3	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүд оролцов. /2022.05.04/
		Монголын ҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбаттай уулзалт, ярилцлага	1	ҮЭХ-н дарга оролцов. /2022.06.24/
		ҮЭ-ийн хороогоор шалгарсан Эрүүл мэндийн II дугаар төвийн ҮЭ-ийн хороотой танилцах, харилцан туршлага, мэдээлэл солилцох, зөвлөгөө, сургалт	1	ҮЭХ-н дарга хамрагдав. /2022.11.04/

“Харилцаа ба сэтгэл мэдрэмж” Сургалт

"Хайраас өвлөх хайр" ТББ-н тэргүүн, Сэтгэл зүйч М.Сарнай "ХАРИЛЦАА БА СЭТГЭЛ МЭДРЭМЖ" сэдэвт сургалтыг Төв номын сангийн хамт олонд орлоо.

"Тэгш оролцоо-Тэгш хөгжил” сургалтанд хамрагдав

Аймгийн Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж буй “Тэгш оролцоо-Тэгш хөгжил” сургалтанд Төв номын сангийн хамт олон оролцож Лектор Н.Энхбаатарын “Харилцаа ба Эерэг хандлага”, сургагч багш н.Доржналжирмаагийн “Хайрын 5 хэл” сэдэвт сургалт лекцийг сонсов.

Монгол бичгийн сургалт

Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын зорилгын хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангаж байгаа билээ. Төв номын сангийн хамт олон Од цогцолборын Монгол хэл, бичгийн багш Х.Одхүү, Ц.Бадамцэцэг, С.Баасанхүү нарын дэмжлэгтэйгээр Монгол бичгийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болох, уншиж, бичиж сурах богино хугацааны сургалтанд хамрагдав.

"Ёс зүйтэй, хүнд сурталгүй төрийн алба" Аяны хүрээнд
Өглөөний сургалт зохион байгуулав

ТӨРИЙН АЛБА” аян хэрэгжиж байгаа бөгөөд тус аяны хүрээнд ТӨВ НОМЫН САН-гийн хамт олон ӨГЛӨӨНИЙ СУРГАЛТ-нд хамрагдав. Сургалтыг Нийгмийн Ардчилалын академийн Үндэсний сургагч багш А.Амаржаргал "Эерэг хандлага", "Хамтран ажиллах ур чадвар" сэдвүүдээр зохион байгууллаа.

"Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга" сургалт

Төв номын сангийн ажилтан албан хаагчдад Дархан-Уул аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны "Зөв хөтөч" сургалтын төвийн багш Д.Мэндбаяр, Т.Баяржаргал нар "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"-аар сургалт мэдээлэл хийлээ.

<u>Номын санчид сургалтанд хамрагдаж байна</u>

Дархан-Уул аймгийн Төв номын сангаас хүсэлт тавьсаны дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн Мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Т.Хайдав "Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа" сэдэвт сургалтыг аймгийн нийт номын санчдад 2022.03.29-04.01-ний өдрүүдэд зохион байгуулав.

“Харилцаа- хандлага” Лекц

Төв номын сангийн хамт олон 2022 оныг хувь хүний хөгжлийн дэмжих жил болгон дотооддоо зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд Сэтгэл зүйч, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн номын санч П.Буянтогтохыг урин “**Харилцаа-Хандлага”** лекцийг зохион явууллаа.

"МОНГОЛ УРЛАЛ" сэдэвчилсэн номын үзэсгэлэн, сургалт, үзэсгэлэн худалдаа болов

"Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Аймгийн Төв номын сангаас "Монгол урлал" сургалтыг Эмэгтэйчүүдийн ордон, Дархан сумын Ахмадын хороотой хамтран зохион байгууллаа. Соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчид маань цуглаж Монгол хүний үнэт хэрэглээ болсон даалин, хөөрөг хэрхэн урлах, хэрхэн хэрэглэх талаарх мэдээ мэдээллийг өгч, зүү ороох хатгамалыг зааж, үзэсгэлэн худалдааг гаргалаа.

“СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ” бэлтгэх сургалт

“СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ” бэлтгэх сургалт сургалт 21 аймаг, 26 харьяа газар, агентлаг, 9 дүүргийн соёлын ордноос төлөөлөлтэйгээр явагдлаа. Тус сургалтанд Дархан-Уул аймгаас Төв номын сангийн захирал Б.Цэцэгсүрэн оролцож батламжаа авсан ба сургалтын зорилго нь бүх нийтийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх замаар соёл салбарын хууль эрх зүй, онол практикт суурилсан насанд хүрэгчдийн сургалтын арга зүйгээр дунд, анхан шатанд сургагч багшийн үндсэн үүрэг, ур чадварыг нэмэгдүүлэх, гэр бүлийн тэнцвэрт харилцаа, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн эерэг сэтгэл зүй, хандлагыг төлөвшүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийг шалтгаан нөхцлийг бууруулах, нөлөөллийн ажлыг зохион байгуулахад орших юм.

Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдав

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх арга зүйн сургалт “Статистик мэдээллийн нэгдсэн санг ашиглах” нь сэдвээр Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Жавзандулам, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үнэлгээ, анхаарах асуудал” сэдвээр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Мөнхсүрэн нарын удирдлага дор зохон байгуулагдлаа. Сургалтад 60 гаруй албан хаагч хамрагдсан бөгөөд Төв номын сангаас нэгжийн дарга нар хамрагдаж, мэдээлэл сонслоо.

Номын санч мэдээллийн ажилтнуудын улсын зөвлөгөөн болж байна

Монгол Улсын Үндэсний номын сангаас цахимаар зохион байгуулсан “Номын санч –Мэдээллийн ажилтны IX зөвлөгөөн”-ийг “Цахим шилжилт”, “Цахим эрин дэх үндэсний номзүйн цахим мэдээллийн сан” зөвлөгөөнд Аймгийн Төв номын сангийн хамт олон оролцов.

“Угийн бичгээ хөтөлцгөөе” сургалтанд хамрагдав

Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газар, Ахмадын хөгжлийн төв хамтран “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЦГӨӨЕ” сургалтыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт зохион байгууллаа.

Сургалтаар Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 256 дугаар тогтоолыг хэрэгжүүлж хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, ураг төрөл, хамаатны хүрээгээ тогтоох, угийн бичгээ үнэн зөв хөтөлж сурах, ураг удмаа эрхэмлэж угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг ойлгуулж таниулах сургагч багш нарыг бэлтгэх зорилготой ба Төв номын сангаас 2 хүн суралцаж, батламж авав.

<u>Эрдэм шинжилгээний хурал- 2 удаа 91 хүн</u>

1	ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ- ***2 удаа 91 хүн***	“Эрдэм шинжилгээ-Онол прагктикийн бага хурал”	46	ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн хурлын танхимд зохион байгуулсан
2		“Эрдэм шинжилгээний хурал”	45	Төв номын сангаас санаачилан Ахмадын хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулав.

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдэд зориулсан Эрдэм шинжилгээний хурал боллоо

Аймгийн Төв номын сан, Ахмадын хөгжлийн төв хамтран "Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд "Үндэсний бичиг үсгийн хэрэглээ" сэдвээр Од цогцолбор сургуулийн Монгол хэлний багш Х.Одхүү, "Үндэсний бичгийг хэрхэн түгээн дэлгэрүүлэх вэ?" сэдвээр Насан туршийн боловсролын төвийн багш Ч.Нансалмаа, "Үндэсний бичгийн цагаан толгойн үсгийг САВ, ШИМ ертөнцийн юмс үзэгдэлтэй холбон таних арга ба үр дүн" сэдвээр Үндэсний лаборатори ОИЦ сургуулийн Монгол хэлний багш Боловсрол судлалын ухааны доктор /Ph.D/ Ц.Буянхишиг, "Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт" сэдвээр аймгийн Музейн боловсролын ажилтан М.Мөнхтуяа, "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын хэрэгжилт, "Угийн бичиг хэрхэн хөтлөх, мэдээлэл хайх арга" сэдвээр Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд нар тус тус илтгэл тавьлаа.

Монгол бичгийн сургалтад хамрагдан судалж байгаа ахмад настнууд, Ахмадын хөгжлийн төвийн үйлчлүүлэгчид, XVI дунд сургуулийн 11в ангийн сайн дурын идэвхтэн сурагчид илтгэлүүдийг сонсож, ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд Төв номын сангийн зүгээс "Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв" номын үзэсгэлэн, "Миний мөрөөдлийн номын сан" ном бүтээх уралдааны материалын үзэсгэлэн, "Бийрийн эрдэм" уран бичгийн уралдааны бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж толилууллаа.

<u>Зохиолч уншигчийн уулзалт - 6 удаа 349 хүн:</u>

1		Зохиолч, Судлаач Ц.Буянзаяатай хийсэн уулзалт	37	Зохиолч, Судлаач Ц.Буянзаяа "Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний хөгжлийн үе шатууд"
2		МЗЭ-ийн гишүүн, утга зохиолын төлөө болон МЗЭ-ийн шагналт яруу найрагч Н.Төмөртогоо	80	15-р багийн иргэд
3		Улаанбаатар – Дарханы зохиолчдын хамтарсан уулзалт	70	Орон нутгийн удирдлагууд болон зохиолчид оролцов.
4	ЗОХИОЛЧ УНШИГЧИЙН УУЛЗАЛТ -6 **удаа 349 хүн**	Монгол улсын инженер, технологич, Техникийн ухааны магистр, МУ-ын Мастер тогооч Чулууны Зунгарай Зохиолч-уншигчдын уулзалт	70	Ахмадын хөгжлийн төвөөр үйлчлүүлдэг ахмадууд оролцов.
5		МЗЭ-ийн болон Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч яруу найрагч Р.Лхамрагчаа	42	Зохиолчид, Аймгийн багийн ахмадууд оролцов.
6		Ахмад багш, зохиолч, Ардын боловсролын тэргүүний ажилтан Д.Тэгшжаргал	50	Дархан сумын 13 дугаар баг, багийн Ахмадын зөвлөлтэй хамтран Д.Тэгшжаргал гуайн зохиол бүтээл, хөдөлмөр бүтээлийг алдаршуулах уулзалтанд шавь болон найз нөхөд үр хүүхэд иргэд оролцлоо.

Аймгийн Төв номын сан, Дархан сумын 13 дугаар баг, багийн Ахмадын зөвлөлтэй хамтран тус багийн иргэн Ахмад багш, зохиолч, Ардын боловсролын тэргүүний ажилтан Д.Тэгшжаргал гуайн зохиол бүтээл, хөдөлмөр алдрыг алдаршуулан "Зохиолч-уншигчдын уулзалт"-ыг зохион байгууллаа. 10 гаруй ном товхимол, дуу шүлгийн уран бүтээлтэй зохиолч маань насаараа багшийн алдрыг өндөрт өргөж 5000 гаруй шавьтай болсон ажээ.

Зохиолч-уншигчдын уулзалт “номын чуулган”

МЗЭ-ийн болон Утга зохиолын шагналт Зохиолч яруу найрагч Д.Цэрэндаваагийн “Уул усны минь Уянга” бүтээлийн дэвтэр шинэ номын нээлт, МЗЭ-ийн болон Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч яруу найрагч Р.Лхамрагчаагийн “Сүбээдэй баатар” туульсын номын хэлэлцүүлгийг нэгтгэн “НОМЫН ЧУУЛГАН”-ыг зохион байгууллаа.

Номын нээлтийг МУСТА, ерөөлч магтаалч Ц.Дүйнхэрсүрэн гуай нээж, хоёр зохиолчийн номын тухай ерөөл хайлан, хүрэлцэн ирсэн зохиолч, яруу найрагчид, судлаачид, уншигч иргэдэд эрүүл энх, эрдэм номын ерөөл айлтган эхлүүллээ.

“Уул усны минь Уянга” ном нь Д.Цэрэндаваа зохиолчийн бие даасан 12 дахь бүтээл бөгөөд төрсөн нутаг, уул ус, аав ээждээ зорилан бүтээсэн суварга гэдгээ онцоллоо. Харин “Сүбээдэй” баатар туульсын яруу найргийн хувьд Дарханд төдийгүй Монгол улсдаа онцлохоор бодит түүх, бодит дүрээс сэдэвлэн бичсэн, крилл, Монгол бичиг, сонсох ном хэлбэрээр уншигчдын хүртээл болоод байгаа бүтээл билээ.

Зохиолч, хэвлэн нийтлэгчидтэй уулзалт хийлээ

“Номын баяр-2022” намар үйл ажиллагааны хүрээнд аймаг орон нутгийн удирдлагуудыг төлөөлөн Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа, аймгийн Төв номын сангийн дарга Б.Цэцэгсүрэн нар "Номын соёлт ертөнц" ТББ-ын тэргүүн Б.Сувд, Хүүхдийн номын зохиолч П.Наранбаатар Ч.Наранцэцэг Э.Амарзаяа, Зохиолч Ш.Солонго, С.Батжаргал Ж.Нарана, Х.Дуламсүрэн, Б.Наминчимэд Б.Хулан, Бадрангуй, Б.Эрдэнэцэцэг, Зохиолч сэтгэл зүйч Д.Мөнцэцэг, аялагч Амай Орчуулагч Д.Болдбаатар, редактор Ц.Оюунчимэг, Судлаач лам М.Ууганбаяр зэрэг 30 гаруй зохиолч, хэвлэн нийтлэгчидтэй уулзаж яриа өрнүүлэн, орон нутгийн хөгжилтэй соёлын салбарын хөгжлийг хэрхэн холбох, энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллах талаар ярилцлаа.

Шинэ номын нээлт: 4 ***удаа 1***91 ***ирцэд***

№	Үйл ажиллааны нэр	Тоо	Тайлбар

1	Шинэ номын нээлт	МЗЭ-ийн болон Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч яруу найрагч Р.Лхамрагчаагийн “Сүбээдэй баатар” тууль	42	Орон нутгийн зохиолчид, идэвхитэн уншигчид
2		“Монгол уран зохиолын түүхэн товч” 2 боть бүтээлийн нээлт	37	Зохиолч, Судлаач Ц.Буянзаяатай хийсэн “Монгол уран зохиолын түүхэн товч” 2 боть бүтээлийн нээлт, номын худалдаа гаргав.
3		“Уул усны минь Уянга” бүтээлийн дэвтэр шинэ номын нээлт	42	МЗЭ-ийн болон Утга зохиолын шагналт Зохиолч яруу найрагч Д.Цэрэндаваагийн 12 дахь бүтээл бөгөөд төрсөн нутаг, уул ус, аав ээждээ зорилан бүтээсэн суварга гэдгээ онцоллоо.
4		"ЭМЧИЛГЭЭ БА ХООЛЛОЛТ"	70	Монгол улсын инженер, технологич, Техникийн ухааны магистр, МУ-ын Мастер тогооч Чулууны Зунгарай гуайн номын нээлтийг зохион байгуулав.

- ✓ Зохиолч, Судлаач Ц.Буянзаяатай хийсэн “Монгол уран зохиолын түүхэн товч” 2 боть номын нээлтэнд Монголын Зохиолчдын эвлэлийн Дархан салбарын төлөөлөл 37 хүн
- ✓ МЗЭ-ийн гишүүн, утга зохиолын төлөө болон МЗЭ-ийн шагналт яруу найрагч Н.Төмөртогоогийн номын нээлтэнд уншигч, зохиолчид болон 15 дугаар багийн иргэн нийт 80 хүн оролцов.
- ✓ МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, Төв номын сан хамтран Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч, судлаач Ц.Буянзаяагийн "Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний үе шатууд" лекц, ”Монголын уран зохиолын түүхэн товч” тоймын тэргүүн, дэд дэвтрийн нээлтийг зохион байгууллаа.

Тус үйл ажиллагаанд Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын дарга Р.Лхамрагчаа нар оролцож утга зохиол судлалын талаар үнэтэй сургалтыг зохион байгуулж, шинэ номын талаар тойм ярилцлага хийв.

Уралдаан - 23 удаа 6589 хүн:

1.	УРАЛДААН -23 удаа 6589 хүн оролцов.	1. Уран уншлага /Өгүүллэг, тууж/	63	ЕБС-ийн сурагчид бүтээлээр оролцсон.
2.		2. “Судар эрдэнийн Сувдан дагинас” номын санчдын цэнгээнт уралдаан	58	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтан Дархан-Уул аймгийн нийт номын санчдын дунд зохион байгуулагдсан.
3.		"Жаргалтай гэр бүл”	35	Дархан-Уул аймгийн нийт номын санчдын гэр бүлийн дунд зохион явуулсан уралдаант тэмцээнд номын сангаас 2 баг оролцов.

4.		3. “Цэрэг эх орон”	250	Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах ангийн ажилтан, албан хаагч оролцсон
5.		"Бид эх орны ирээдүй" эсээ бичлэгийн уралдаан	212	Уралдаанд аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, техник, мэргэжилийн коллеж зэрэг нийт 16 сургуулийн 212 сурагч, оюутнууд оролцсон бөгөөд эхний 10 байранд шалгарсан хүүхдүүдийн Шагналыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Д.Пүрэвсүрэн, Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд, арга зүйч С.Нэргүй нар гардуулж, хэлэлцүүлэг зохион байгууллаа.
6.		Эмч нарын өдөрт талархалын захидал бичих	100	Олон улсын эмч нарын өдөрт зориулан Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс зохион байгуулсан
7.		Номын баярын үйл ажиллагаанд “Ургаа уудалъя”- уралдааныг зохион байгуулж, идэвхитэй оролцсон 3 ахмадыг шалгаруууллаа	46	Дархан сумын 3-р багийн иргэн Я.Энэбишийн гэр бүл нөхрийн талын “Өнө мөнхөд бадрах ургийн бичиг” 7 үе, эхнэрийн талын “Баян авгынхан удмын шастир” 9 үеэрээ гаргасан ургийн бичгүүд шалгарлаа.
8.		“Онцлог содон ном” уралдаанд	60	15-р багийн иргэн Н.Төмөр- тогоогийн өөрийн бүтээл 1х5 м харьцаатай том ном, монгол бичгээр бичсэн номыг 1925 онд 5 төгрөгөөр худалдаж авсан үнэт ховор номууд шалгарав.
9.		Тэргүүний Ахмадын зөвлөлийг шалгаруулав.	21	18 баг, 3 аж ахуйн нэгж оролцсоноос 13-р багийн “Ахмадын зөвлөл” шалгарлаа.
10.		Ахмадын карнавалд зохиолын дүрд амжилттай хувирсан эмэгтэй, эрэгтэй дүрийн баатрыг шалгаруулав.	350	Эмэгтэй дүрийн баатар 13-р багийн ахмад настан М.Дуламжав, эрэгтэй дүрийг сайн гаргасан 14-р багийн ахмад Я.Ганхуяг нар шалгарсан.
11.		Үндэсний хувцсаараа ижиллэсэн хос дээлтнүүд номинацид	39	13-р багийн иргэн Даш-Очир, Эрдэнэцэцэг наын гэр бүл шалгарлаа.
12.		“Бийрээр нийлье” монгол бичгийн Уран бичлэгийн уралдаан	35	ЕБС-ийн багш, сурагчид оролцов.
13.		Бийрийн эрдэм монгол бичгийн уран бичлэгийн уралдаан	28	ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчид
14.		Монгол бичиг Монгол бахархал монгол бичгийн түргэн уншлагын уралдаан	96	Аймгийн нийт ЕБС-ийн 9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 8 сургуулийн 88 сурагч оролцож, өгөгдсөн сэдвүүдээс минутын уншлага хийлээ.
15.		Монгол бичиг Монгол бахархал монгол бичгийн түргэн уншлагын уралдаан	220	ЕБС-ийн 10 гаруй сургуулийн 9-р ангийн сурагчдын дунд зохион байгуулав.
16.		“Уран уншлага”	63	ЕБС-ийн сурагчдын хичээлийн программд орсон болон хичээлээс гадуур унших зохиолуудаар зохион байгуулж, шагналын санхүүжилтийг Номин Тав Трейд компани ивээн тэтгэн, уралдаанд 63 хүүхдийн материал ирснээс 12 хүүхдийн бүтээл шалгарч байр эзэллээ.
17.		“Караоке” дууны тэмцээн	35	Хонгор сумын Соёлын төвтэй хамтран нийт номын санчдын дунд караоке тэмцээнийг зохион байгуулж, их дээд

				сургууль, Төв номын сан, сумын соёлын төвийн хамтарсан 4 баг оролцлоо.
18.		“Монголын нууц товчоо” эсээ	6	МУҮНС-аас зохион байгуулсан “Монголын нууц товчоо” эсээ бичлэгийн уралдаанд номын санчид оролцов.
19.		“Газар доорх ус-Үл харагдах усыг таниулъя” сэдэвт эсээ, гар зураг	70	Дэлхийн усны өдөрт зориулан Хараа Ерөө сав газрын захиргаатай хамтран зохион байгуулав.
20.		“Миний анхны ном” сэдэвт өөрийн гараар бүтээсэн “Ном бүтээх уралдаан	69	Насанд хүрэгчид, СӨББ, ЕБС-ийн сурагчид оролцов.
21.		Төрийн албан хаагчдын бүх нийтийн марафон	5	Захирал Б.Цэцэгсүрэнгийн гэр бүл
22.		“НОМЫН САЙН НӨХӨР” номын баярын уралдааныг ЕБС, СӨБ-ын байгууллагуудын дунд зохион байгуулав.	90	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, ”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг хэрэгжүүлэх хүрээнд бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, угийн бичгийг хөтлөх, суралцах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулав. Үүнд: 10- цэцэрлэг, 8- ЕБС, 2 их, дээд сургууль оролцов.
23.		Шилдэг сургууль, Шилдэг цэцэрлэг, Шилдэг уншигч сурагч, насанд хүрэгч болон шилдэг номын санч, шилдэг номыг алдаршуулан сурталчилах	4638	ЕБС-ийн 8 сургуулийн 2797 багш сурагчид, СӨББ-ийн 10 цэцэрлэгийн 1841 багш сурагчид оролцсоноос шалгарсан сургууль хамт олныг “НОМЫН САЙН НӨХӨР” хүндэт дэвтэрт хүндэтгэн бичиж, сурталчилав.

"БИЙРЭЭ НИЙЛЬЕ" уран бичлэгийн уралдаан

Аймгийн Төв номын сан нь Монгол бичиг үсэг, өв соёлоо сурталчилсан төрөлжсөн уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, ярилцлага, соёл, уламжлалыг харуулсан цуврал үзэсгэлэнгүүд зэрэг олон нийтэд зориулсан төрөл бүрийн арга хэмжээг бүх шатны сургууль болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаагийн БИЙРЭЭ НИЙЛЬЕ уралдаанд:

1 байр: ОИЦ сургуулийн 12-4 ангийн сурагч Б.Үлэмж

2 байр: 4 дүгээр сургуулийн 11б ангийн сурагч Б.Алтантуяа

3 байр: ОИЦ сургуулийн 12-2 ангийн сурагч Г.Номин

Тусгай байр: 4 дүгээр сургуулийн 11б ангийн сурагч Б.Номин-Эрдэнэ, 18 сургуулийн 10в ангийн сурагч Б.Оюун-Эрдэнэ нар тус тус шалгарлаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан аймгийн нийт номын санчдын дунд "Судар эрдэнийн сувдан дагинасууд" цэнгээнт уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Их дээд сургуулийн номын санчид, ЕБС-ийн номын санчид, Орхон, Хонгор, Шарын гол сумын номын санчид зэрэг 5 баг өрсөлдөж:

- Сумдын номын санчдын "Монгол хатад" баг 1-р байр
- Их дээд сургуулийн номын санчдын "Эрдмийн хөтөч" баг 2-р байр тус тус эзэллээ.

"Би ээжийнхээ он цагийн үргэлжлэл"

Аймгийн Төв номын сан, УИХ-ын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлангийн ажлын алба, DBS телевизтэй хамтран зохион байгуулсан “БИ ЭЭЖИЙНХЭЭ ОН ЦАГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ" захидлын уралдаан амжилттай болж өндөрлөлөө. Найман настай балчраас ная, ерэн настай буурлын ээждээ зориулан бичсэн чин сэтгэлийн 400 гаруй захидал ирлээ.

Уралдаанд Орхон, Хонгор, Шарын гол сум, Дархан сумын ЕБС-ийн сурагчид, ШШГ хорих 435 дугаар анги, Улаанбаатар, Сэлэнгээс оролцсон юм. "БИ ЭЭЖИЙНХЭЭ ОН ЦАГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ" захидлын уралдаанд сэтгэлийн үгсээ уудлан, ертөнцийн хамгийн сайхан хүний эгэлгүй их хайр энэрэл, үлгэр дууриалал, хамтдаа бүтээсэн дурсамж, баяр талархлыг буулган бичиж шагналт байранд шалгасан шилдэг 12 захидлын эздэд шагналыг гардуулж өгөв.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Төв номын сангаас уншигч, иргэдийн дунд 3 насны ангиллаар зохион байгуулсан "Миний анхны ном" ном бүтээх уралдаан дүнгээ гаргалаа. Уралдаанд нийт 69 бүтээл ирсэн бөгөөд номын хэв, хийц маяг, агуулга дизайн бүр өөр өөрийн онцлогтой бүтээлч байдлыг хадгалсан байсан бөгөөд баг, анги хамт олноороо нэгдэж хийсэн бүтээл ч байлаа.

Цэцэрлэгийн насны хүүхдүүдийн ангилалд:
✅1 байр - Ж.Төгс-Ирээдүй /1-р цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг/
✅2 байр - Б.Маргад /1-р цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг/
✅3 байр - Ө.Адисад /3 дугаар цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг/
ЕБС-ийн сурагчдын насны ангилалд:
✅1 байр - Ж.Уранчимэг /12 сургуулийн 5А анги/
✅2 байр - Э.Анужин /Од цогцолбор сургуулийн 11-3 анги/
✅3 байр - Т.Мишээл /Шинэ-Алхам сургуулийн 3А анги/
Насанд хүрэгчдийн ангилалд:
✅1 байр - 1 дүгээр цэцэрлэгийн туслах багш нар
✅2 байр - 25 дугаар цэцэрлэгийн туслах багш нар
✅3 байр - Ш.Мөнхнаран /22 дугаар цэцэрлэгийн багш/

Дархан-Уул аймгийн номын санчдын дундах КАРАОКЕ тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа

Хонгор сумын Соёлын төвөөс Аймгийн Төв номын сантай хамтран нийт номын санчдын дунд караоке тэмцээнийг зохион байгууллаа. Уралдаанд их дээд сургууль, Төв номын сан, сумын соёлын төвийнхөн хамтарсан 4 баг оролцож:

1-р байранд Их дээд сургуулиудын "Эрдмийн хөтөч" баг

2-р байранд Төв номын сангийн "Дагинас" баг

3-р байранд "Ахмадын золбоо" баг тус тус шалгарлаа.

Төрийн албан хаагчдын урлагийн их наадам

Дархан-Уул аймгийн төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, авьяас билгийг нээн хөгжүүлэх, хамт олны уур амьсгалыг нягтруулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, нөхөрсөг, найрсаг харилцаа хандлагыг төлөвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын урлагийн их наадмыг зохион байгуулж 30 гаруй байгууллагын хамтарсан 11 баг оролцож авьяас билгээ сорилоо. Төв номын сангаас хамт олноо төлөөлөн урлагийн наадамд оролцсон С.Энхцэцэг, Д.Цэвэгмэд нар оролцов.

"МИНИЙ АНХНЫ НОМ" ном бүтээх уралдааны дүн гарлаа

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Төв номын сангаас уншигч, иргэдийн дунд 3 насны ангиллаар зохион байгуулсан "Миний анхны ном" ном бүтээх уралдаан явагдлаа. Уралдаанд нийт 69 бүтээл ирсэн бөгөөд номын хэв, хийц маяг, агуулга дизайн бүр өөр өөрийн онцлогтой бүтээлч байдлыг хадгалсан байсан бөгөөд баг, анги хамт олноороо нэгдэж хийсэн бүтээл ч байлаа.

Цэцэрлэгийн насны хүүхдүүдийн ангилалд:
1 байр - Ж.Төгс-Ирээдүй /1-р цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг/
2 байр - Б.Маргад /1-р цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг/
3 байр - Ө.Адисад /3 дугаар цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг/
ЕБС-ийн сурагчдын насны ангилалд:
1 байр - Ж.Уранчимэг /12 сургуулийн 5А анги/
2 байр - Э.Анужин /Од цогцолбор сургуулийн 11-3 анги/
3 байр - Т.Мишээл /Шинэ-Алхам сургуулийн 3А анги/
Насанд хүрэгчдийн ангилалд:
1 байр - 1 дүгээр цэцэрлэгийн туслах багш нар
2 байр - 25 дугаар цэцэрлэгийн туслах багш нар
3 байр - Ш.Мөнхнаран /22 дугаар цэцэрлэгийн багш/

“АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” цэнгээнт уралдаан

Олон Улсын гэр бүлийн өдөр, Хүүхдийн баярыг угтан Төв номын сан болон байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс санаачлан Энэрэл цогцолбор, 4 дүгээр сургуулийн номын санчидтай хамтарч аймгийнхаа нийт номын санчдын гэр бүлийн хүрээнд зохион байгуулсан “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” цэнгээнт уралдаан амжилттай болж өндөрлөлөө. Их дээд сургууль, ЕБС, сумдын соёлын төвүүдийн номын санчдын гэр бүл оролцсон тус тэмцээний:
1 байр – 15 дугаар сургуулийн номын санч Д.Отгонхишигийн гэр бүл

2 байр – 4 дүгээр сургуулийн номын санч Д.Ундрахцэцэгийн гэр бүл
3 байр – Төв номын сангийн захирал Б.Цэцэгсүрэнгийн гэр бүл тус тус шалгарлаа.

“УРАН УНШЛАГА’’-ын уралдаан

Монголын уран зохиолын өв баялагаас суралцах, үе тэнгийн найз нөхөдөө ном унших, судлах дадал зуршилд уриалах, өөрсдийн авьяас чадвараа нээн илрүүлэх хүсэл зорилгыг нь дэмжих, хүүхэд багачуудын амралтанд зориулан Аймгийн Төв номын сан, Дархан Номин худалдааны төвтэй хамтран зохион байгуулсан “УРАН УНШЛАГА’’-ын уралдааны дүн гарлаа. Уралдааны 1-5 ангийн ангилалд:

1 байр - Шарын гол сумын 4А ангийн сурагч О.Сумъяа "Ганц улаан гамбир" зохиол
2 байр - Од цогцолбор сургуулийн 1-1 анги Б.Билэгжаргал "Цэдэндамбааг мангас идчихлээ" зохиол
3 байр - ОИЦ сургуулийн 2-6 анги Э.Хулангоо "Цэдэндамбааг мангас идчихлээ" зохиол
Тусгай байр: ОИЦ сургуулийн 3 анги Б.Энхгүнж “Нэг ангийнхан” зохиол
6-9 ангийн ангилалд:
1 байр - Шарын гол сумын 7А анги Ө.Аянур "Би том болдог болов уу" зохиол
2 байр - Цайхун сургуулийн 6 анги О.Одонгарав "Хоршоо дэрэм" зохиол
3 байр - Орхон сумын 8 анги Ш.Отгончимэг
Тусгай байр: 15 сургуулийн 7 анги Б.Жаргалмаа "Мэнд эгч" зохиол
10-12 ангийн ангилалд:
1 байр - Од цогцолбор сургуулийн 11 анги Э.Энхмаа "Цагаан сар ба хар нулимс" зохиол

2 байр - Шарын гол сумын 10 анги С.Аня "Гэмшил" зохиол

3 байр - 16 сургуулийн 10 анги А.Мөнххүслэн "Өвгөн шувуу" зохиолоор тус тус шалгарлаа.

Бид уралдааныхаа удирдамжинд цэцэрлэгийн нас заагаагүй байсан боловч 10 гаруй бяцхан оролцогчид маань бүтээлээ ирүүлсэн учир нэг шилдэг оролцогчийг шалгаруулахаар шийдвэрлэлээ.

Цэцэрлэгийн насны ангилалд:

4 дүгээр цэцэрлэгийн Ө.Цэлмэг "Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй" зохиол

Уралдаанд оролцсон нийт хүүхэд багачууддаа сурлага, урлаг, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Эмч нарт “талархлын захидал” Илгээжээ

“Дэлхийн эмч нарын өдөр”-ийг тохиолдуулан Төв номын сангаас УИХ-ын гишүүн, БСШУС-ын байнгын хорооны дарга Гонгорын Дамдиннямын ажлын алба, Эрүүл мэндийн газартай хамтран Дархан-Уул аймгийнхаа нийт иргэдийн дунд эмч нартаа илгээх “Талархлын захидал”-ын уралдааныг зохион байгуулсан юм.

Уралдаанд нийт 100 гаруй чин сэтгэлийн захидал ирсэн шилдэг 5 захидлыг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав. Талархлын захидлын уралдаанд:

1 байр: Б.Хатанзаяа

2-р байр: Г.Мөнхгэрэл

3-р байр: У.Ганцэцэг

Тусгай байр: С.Чулуунхүү

Тусгай байр: А.Гэрэлмаа нар шалгарлаа.

Ард түмнийхээ эрүүл мэнд, амь насыг авран хамгаалахын төлөө хором мөч бүртэй уралдан хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж яваа алтан гартай ачит эмч нартаа баярлаж талархаж явдгаа уралдаанд захидлаа ирүүлсэн хүн бүр онцлон бичжээ.

<u>Лекц- 25 удаа, 1592 хүн:</u>

.	ЛЕКЦ- 25 удаа, 1592 хүн оролцов.	Эрүүл мэндийн газар “Эрүүл хооллолт”	300	ОИЦ сургуулийн багш сурагчид
.		Ус суваг ХК-аас “Усны хэрэглээ”		ОИЦ сургуулийн багш сурагчид
.		ШУТИС-аас “Усан хангамж ариутгах татуурга” тухай		ОИЦ сургуулийн багш сурагчид
.		Хараа Ерөө сав газрын мэргэжилтэн Оюунгэрэл “Дэлхийн усны нөөц”		ОИЦ сургуулийн багш сурагчид
.		Ургийн бичгээ хэрхэн хөтлөх аргачлал	25	Хонгор сумын Соёлын төв дээр насанд хүрэгчид
.		Угийн бичгийг хэрхэн хөтлөх, мэдээлэл хайх арга	250	Хонгор сумын Соёлын төв дээр ЕБС-ийн багш сурагчид, ард иргэдэд 2 удаа
.		Ургийн бичгээ хэрхэн хөтлөх арга зам	45	Ахмадын хөгжлийн төв дээр ахмадууд
.		Угийн бичгийг хэрхэн хөтлөх, мэдээлэл хайх арга	141	Хонгор сумын 11-р сургууль дээр
.		Угийн бичгийг хэрхэн хөтлөх, мэдээлэл хайх арга	120	Шарын гол сумын 2, 6-р сургуулийн багш сурагчдад
0.		"Ургаа уудалъя" сэдэвт сургалт	12	15-р багийн иргэдэд "УРГАА УУДАЛЪЯ" сэдэвт угийн бичгийн сургалт зохион байгуулав.
1.		Харилцааны 5 хэл лекц	48	Дархан сумын 8 дугаар багийн иргэдийн төлөөлөл, номын санчид
2.		Сайнд хөтлөх хүч номын нээлт лекц	46	Боловсролын салбар, сэтгэл зүйч багш нар, судлаачид оолцов.
3.		АУС-ийн номын санч П.Буянтогтох “Харилцаа, хандлага” сэдвээр лекц хийв.	15	Уншлагын танхимд зохион байгуулж бү х номын санчид хамрагдав.
4.		“Эртэч Дархан” клубын төслийн хүрээнд лектор Энхбаатар багшийн лекц,	4	“Эртэч Дархан” клубын төслийн хүрээнд лектор Энхбаатар багшийн лекц 2022.01.07-ны өдөр
5.		"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР"-ын хүрээнд "Гэр бүлийн үнэ цэнэ - Ёс заншил" лекц	70	Монгол хүн - Монголын бахархал байх зорилгын дор "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР"-ын хүрээнд ШУТИС-ийн номын сан, ГБХЗХГ-тай хамтран оюутан залуучуудад "Гэр бүлийн үнэ цэнэ - Ёс заншил" лекцийг "Жаргалант Дархан" ТББ-ын Тэргүүн, Гэр бүл судлаач Б.Дэмбэрэлмаа хийлээ.
6.		"Тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах" сэдвээр лекц	75	Аймгийн Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд ШУТИС-ийн 1.2 дугаар курсын оюутнууд болон лицей сургуулийн сурагчдад "Зуны тэтгэлэгт

			хөтөлбөрт хэрхэн хамрагдах тухай" мэдээллийг хийлээ.
7.	"Монгол хүний язгуур эрх, амьдралын үнэ цэнэ" сэдэвт лекц	250	"Номын баяр"-ын үйл ажиллагаатай холбогдуулан Үндэсний илтгэгч багш, Хүний нөөцийн аудитор Б.Батгэрэлийг урьж аймгийн ард иргэд болон соёлын салбарынхан, Онцгой байдлын газрын хамт олонд "Монгол хүний язгуур эрх, амьдралын үнэ цэнэ" сэдвийн хүрээнд 3 удаа 350 гаруй төрий албан хаагчид, багш, сурагчид оролцов.
8.	“Номын баяр-Бидний баяр”	40	Номын соёлт ертөнц ТББ-ын тэргүүн Б.Сувд Сургуулийн болон нийтийн номын сангийнхан, ЕБС-ийн нийгмийн ажилтан 40 хүн оролцов.
9.	“Номын ертөнц клуб юу хийдэг вэ?” сэдэвт лекц	40	Номын соёлт ертөнц ТББ-ын сурагч Т.Номин
0.	“Үндэсний номын баяр”	48	Үндэсний номын баярын зөвлөлийн гишүүн Б.Наминчимэд
1.	Сэтгэлээ шинжихүй сэдвээр	38	Зохиолч, Судлаач лам М.Ууганбаяр
2.	Ном бичихэд бэлэн үү?	45 хүн	Редактор Ц.Оюунчимэг,
3.	Юмханаар юм хийцгээе"	36	Зохиолч Б.Эрдэнэцэцэг,
4.	М.Горькийн нэрэмжит утга зохиолын сургуульд юу сурсан бэ”	47 хүн	ОИЦ сургуулийн ахлах ангийн сурагчдад Зохиолч Х.Дуламсүрэн уулзалт ярилцлага хийлээ.
5.	"Өсвөр насны сэтгэлзүйд юу тустай вэ?"	46 хүн	Зохиогч, сэтгэл зүйч Д.Мөнхцэцэг

"Эрүүл идэвхтэй амьдарцгаая” Лекц

Төв номын сан, Аймгийн Эрүүл мэндийн газар хамтран 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Дархан-Уул аймгийн нийт соёл, урлагийн байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан "Халдварт бус өвчин, эрүүл зөв зохистой хооллолт", "Идэвхтэй хөдөлгөөний ач тус" сургалтаас гадна албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруууллаа.

Угийн бичиг хөтлөх аргачлал лекц

Аймгийн Төв номын сангаас Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олонтой хамтран "Уншаад урагшлахуй - Оюунлаг дарханчууд" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд “УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ АРГАЧЛАЛ” лекцийг тавьж, угийн бичигтэй холбоотой ном, товхимолын талаар мэдээлэл өглөө.

Философич С.Молор-эрдэнийн номын танилцуулга, лекц болов

Философийн ухааны доктор С.Молор-эрдэнийн "Цуврал 3 ном" буюу ном доторх номын агуулга нь "Эрх чөлөө -Эрхэм үг, Тэгш эрх -Тэгш боломж, Шударга ёс - Шударга нийгэм" болон "Монголын өнөөдөр, маргааш, өчигдөр" зэргээс бүтдэг.

Философич маань тус номын нээлт, утга агуулга хийгээд Монгол хүн нийгэмд эрх чөлөөтэй юу, эр эм хосууд хоорондоо тэгш эрхтэй юу болон боловсрол яриад буй хүмүүс шударга ёсыг эрхэмлэдэг үү зэрэг олон асуултуудад хариулан эрх чөлөөгөө шалгаж, тэгш эрхээ хамгаалж, Монгол хүн мөн чанараа олох цаг дор соён гэгээрлийн ажлуудаа орон нутгуудад хийж яваа бөгөөд Дархан-Уул аймагт лекцээ зохион байгууллаа.

Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний хөгжлийн
Үе шатууд лекц сургалт болов

МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, Төв номын сан хамтран Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч, судлаач Ц.Буянзаяагийн "Үндэсний уран зохиол дахь сэтгэлгээний үе шатууд" лекц, сургалтыг Дархан-Уул аймгийн зохиолч, найрагчдад зориулан зохион байгууллаа. Тус сургалтын нээлтэд аймгийн Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын дарга Р.Лхамрагчаа нар оролцож утга зохиол судлалын талаар үнэтэй сургалтыг зохион байгуулж буйд талархал илэрхийлсэн юм. Мөн МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын зарим зохиолч, яруу найрагчдад Дархан хотын 60 жилийн ойн хүндэт тэмдгийг гардууллаа.

"БИДНИЙ БАХАРХАЛ - МОНГОЛ УРЛАГ" лекц, тоглолт болов

Соёлын бүтээлч сар 3 дахь долоо хоногтоо амжилттай үргэлжилж байна. Аймгийн төв номын сан Залуучууд театртай хамтран "Бидний бахархал- Монгол урлаг" үндэстэн ястны бүжиг, хувцасны соёл, түүнийг таниулан сурталчлах сэдэвчилсэн номын үзэсгэлэн, лекц ярилцлагыг АШУҮИС-ийн 100 орчим оюутнуудын дунд зохион байгуулав.

Торгууд, Баяд, Дөрвөд зэрэг 7 ястны бүжгийг Залуучууд театрын бүжигчид бүжиглэж, түүнтэй холбоотой соёл, уламжлал, онцлогийг холбогдох ном зохиолуудаас тоймлон хүргэж соёлын биет бус өвийг сурталчлан таниулах үр өгөөжтэй ажил боллоо. Тус үйл ажиллагааны үеэр оюутнуудын дунд бие биелгээ хийх, чөлөөт үзүүлбэрийн уралдааныг зохион байгуулж шалгарсан 3 оюутанд хувь хүний хөгжлийн номоор бэлэг барьж, урам хайрласан юм.

"ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ - ЁС ЗАНШИЛ" лекц болов

Аймгийн Төв номын сангаас ШУТИС-ийн номын сан, ГБХЗХГ-тай хамтран оюутан залуучуудад "Гэр бүлийн үнэ цэнэ - Ёс заншил" лекцийг хүргэж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлага, гэр бүлийн гишүүдийн бие биенээ хүндэтгэх ёсон, анхаарч цээрлэх үг, зан заншлын талаар мэдээлэл өглөө.

Тус лекцийг "Жаргалант Дархан" ТББ-ын Тэргүүн, Гэр бүл судлаач Б.Дэмбэрэлмаа уншиж хүргэсэн ба мөн лекцийн үеэр Монгол уламжлалт арга ухаан, гэр бүлийн үнэ цэнэ, соёлын өвийн талаарх сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргав.

"МОНГОЛ ХҮНИЙ ЯЗГУУР МӨН ЧАНАР, АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ" лекц болов

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд “МОНГОЛ ХҮНИЙ ЯЗГУУР МӨН ЧАНАР, АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ" лекцийг нийт иргэдэд зориулан Залуучууд театрт үнэ төлбөргүй зохион байгууллаа. Б.Батгэрэл, Хэл шинжлэлийн ухааны доктор Ц.Буянхишиг, Хэл шинжлэлийн ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй багш Ж.Эрхэмсайхан, Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэгч АБТА багш Б.Булганчимэг нар оролцов.

Мөн "Нүүдэлчин Монгол" их наадмын Шилдэг өвлөн уламжлагч багш нарын бүтээл болон “Монгол хүний өв соёл” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг Дарханчууддаа дэлгэн толилууллаа.



<u>Өглөөлөг-1 удаа, 20 хүнд</u>

№	Зохиогдсон ажлын нэр	Оролцсон хүний тоо	Хаана, хэнд зориулсан
1.	Оюунлаг Дарханчууд - Эрүүл Мэндийн газарт эмч нарын дунд	20	Эрүүл мэндийн төвийн 20 эмч

Өглөөний дархан- эрүүл мэндийн газар дээр

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, Төв номын сан хамтын ажиллагааны хүрээнд Дэлхий эмч нарын өдрийн угтан "Эмч тандаа баярлалаа" захидлын уралдаан, мөн Залуучууд театрын уран бүтээлчид, ажилтан, албан хаагчдад эрүүл зөв зохистой хооллолт, ажлын байрны идэвхтэй дасгал хөдөлгөөн,

эрчүүдийн эрүүл мэнд, халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулаад байна.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Төв номын сангаас сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, Эрүүл мэндийн ажилчдад өглөөний 15:00 минутын номын уншлага хийж, оюуны дархлааг дэмжлээ.

<u>Өдөрлөг 19 удаа, 3844 хүнд</u>

№	Зохиогдсон ажлын нэр	Оролцсон хүний тоо	Хаана, хэнд зориулсан
1.	Оюунлаг Дарханчууд - Эрүүл мэндийн газар"-т	21	Эрүүл мэндийн төвийн 21 эмч
2.	Эрүүл идэвхтэй амьдаргаая. Соёл урлагийн нийт ажилтан албан хаагчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан.	143	Ажилтан үзлэгт хамрагдсан
3.	Дэлхийн номын өдөр 4 сарын 23	500	иргэд хамрагдсан
4.	Спортын өдөрлөг : "Аз жаргалтай гэр бүл" номын санчдын гэр бүл	45	Номын санчид
5.	"Үндэсний бичиг соёл - Номын өдрүүд-2022" ажлын хүрээнд	1385	"Үнэт ховор ном"-ын үзэсгэлэн, "Ном бүтээх уралдаан"-ы шагнал гардуулах, Ном солилцооны булан ажиллуулах, "Ном бүтээх уралдаан"-д ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргав.
6.	Оюунлаг Дарханчууд Хонгор, Шарын гол сум Салхит баг ЕБС	370	Өдөрлөгт 370 хүүхэд оролцсон
7.	Үндэсний бичиг үсгийн баяраар "Өв соёлоо дээдэлъе" өдөрлөг	150	ЕБС-ийн 6 сургуулийн 150 сурагч оролцов.
8.	Оюунлаг Дарханчууд –Цайхун сургууль	240	Оролцсон хүүхдийн тоо
9.	Онцгой байдлын газар	110	Залуучууд театрын их танхимд Онцгой байдлын газрын албан хаагчид
10.	Зэвсэгт хүчний 0330 дугаар анги	120	Зэвсэгт хүчний 0330 дугаар ангийн албан хаагчид
11.	Улсын бүртгэлийн хэлтэс	30	Төрийн албан хаагч
12.	3 дугаар цэцэрлэг бэлтгэл бүлэг	30	СӨББ
13.	ОИЦ сургуулийн сурагчдын дунд зохион байгууллаа	300	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид

"Оюунлаг Дархан" өдөрлөг Шарын гол суманд явагдлаа

Аймгийн Төв номын сангаас зохион байгуулдаг "Оюунлаг Дарханчууд" өдөрлөг Шарын гол суманд явагдлаа. Өдөрлөгийн хүрээнд:

- Соёлын төв болон ЕБС-ийн номын санчдад арга зүйн зөвлөмж, 15 минутын уншлага, "Амьдралын хичээл" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тус тус гаргаж уншигч иргэдэд сурталчлан ажиллалаа.

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт
"ОЮУНЛАГ ДАРХАНЧУУД" өдөрлөгийг зохион байгуулав.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас 1995 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийг “Дэлхийн номын өдөр” болгон зарласан байдаг билээ. Энэ тэмдэглэлт өдрийн хүрээнд:

- ✓ “Харилцаа хандлага" сэдвээр ГБХЗХГ-ын сэтгэл зүйч О.Бужин
- ✓ "Номын ертөнцөөр" сэдвээр Төв номын сангийн мэдээллийн ажилтан Х.Отгонбаяр нар лекц уншиж, Хувь хүний хөгжил сэдэвт номын үзэсгэлэн, 15 минутын уншлага, Уншсан номын тухай сэтгэгдлээ ярилцав.

“Номын сайн нөхөр- Оюунлаг дарханчууд” өдөрлөг болов

"Цайхун" сургууль номын сайн нөхөр аяныг зохион байгуулж сурагчдадаа номын ач тусыг таниулан, номтой нөхөрлүүлж, Аймгийн Төв номын сангийн “Оюунлан Дархан” өдөрлөгийг сургууль дээрээ хамтран зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд 15 минутын ном уншлага, номын тухай тойм яриаг номын санч Ц.Долгорсүрэн, номын сангийн мэдээллийн ажилтан Х.Отгонбаяр "Номын ертөнцөөр" сэдвээр сургалт мэдээлэл хийв. Мөн сургуулийн зүгээс номын тэмдэглэл хөтлүүлэх уралдааныг зарлаж "Шилдэг уншигч-сурагч"-ийг шалгаруулж, сургалтын төлбөрийн хөнгөлөлийн эрхээр шагнаж урамшуулав.

<u>Дэлхийн усны өдөрт зориулсан өдөрлөг болов</u>

Дэлхийн усны өдөрт зориулан Аймгийн Төв номын сангаас Хараа Ерөө голын сав газрын захиргаатай хамтран "Оюунлаг Дарханчууд" өдөрлөгийг "Оюуны-Ирээдүй" сургуулийн ахлах ангийн 300 гаруй сурагчдын дунд зохион байгууллаа.

Уг өдөрлөгийн үеэр Эрүүл мэндийн газар, "Ус Суваг" ХК, ШУТИС, Хараа Ерөө голын сав газрын захиргаа зэрэг албан газрууд усны талаар сонирхолтой мэдээлэл хийж хамтран ажиллалаа.

“Соёлын орон зай” Нээлттэй өдөрлөг болов

Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан Найрамдал талбайд “Соёлын орон зай” нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагааны нээлтэд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Соёл Урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ нарын албаны хүмүүс болон соёл, урлагийн салбараас төрөн гарсан, эдүгээ Дархан хотноо ажиллаж, амьдарч байгаа гавъяатууд, хүүхэд багачууд, иргэдийн төлөөлөл оролцлоо.

Соёл, урлагийн ажилтны өдөрт зориулсан өдөрлөгийн үеэр Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэгээр Төв номын сангийн Ном зүйч, Мэдээллийн ажилтан Х.Отгонбаяр, Дархан хотын 60 жилийн ойн медалиар ахмад ажилтан С.Лхамсүрэн, Б.Бадамханд, Дя.Сарантуяа, Н.Солонго нар шагнагдав.

ТАВ. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙН СУРГАЛТЫН ТАЛААР

- ***Судалгаа - 3 удаа 432 хүнээс***
- ***Туршлага судлах ажил - 3 удаа 90 хүнд***
- ***Зөвлөн туслах ажил - 28 байгууллага 33 номын санч***
- Сургалт -3 удаа 58 номын санч

Нийт 4 нэр төрлийн 37 удаагийн мэргэжил арга зүйн ажилд давхардсан тоогоор 613 хүн хамрагдсан байна.

Сургалт -3 удаа 58 номын санч:

- МУҮНСангийн Арга зүйчийн зохион байгуулсан аймгуудын арга зүйчдийн цахим сургалт
- Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа” сэдэвт сургалт

- Номын санчдын техник технологийн сургалт: Номын сангийн lib4u программын тухай нэгдсэн ойлголт буюу мөн программын үйл ажиллагааны талаар санал хүсэлтийг хэлэлцэх

<u>Боловсон хүчнийг чадавхижуулах сургалт:</u>

Нийт 43 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 742 номын санч хамрагдсан байна. Үүнээс мэргэжлийн сургалт 4 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 72 номын санч хамрагджээ.

Сургалт 1: МУҮНСангаас зохион байгуулсан аймгуудын арга зүйчдийн цахим сургалтаар 2022 онд зохион байгуулах сургалт, арга зүйн ажлын талаар мэдээлэл хүргэж, санал солилцох, номын сангийн өдөр тутмын бүртгэл шинэчлэх хэрэгцээ шаардлага, цахим сан хөмрөг зохион байгуулалт сургалтын тухай, "Уншигчдын судалгаа" сургалтыг орон нутагт зохион байгуулах хэрэгцээ, боломжийн талаар харилцан санал солилцов..

Сургалт 2: "Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт" сургалтын агуулгын хүрээнд МУҮНСангаас аймаг, орон нутгуудад ажиллах арга зүйн сургалт явуулах ажлыг дэмжин өөрийн орон нутагт зохион байгуулах санал хүргүүлэв. Цахим сургалт нь цувралаар явагдсан бөгөөд сургалт бүр өгөгдсөн гэрийн даалгавартай байлаа.

ЦАХИМ САН ХӨМРӨГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ / Нийт цаг:28/

д/д	**Сэдэв**	**Нийт цаг**	**Хугацаа**
1	Цахим сан хөмрөгийн тухай ойлголт	4	2022.03.03
2	Цахим сан хөмрөг бүрдүүлэх бодлого	5	2022.03.04
3	Цахим сан хөмрөг бүрдүүлэх аргууд	8	2022.04.07-08
4	Цахим сан хөмрөгийн хадгалалт	5	2022.05.13
5	Цахим сан хөмрөгийн хэрэглээ	6	2022.06.03

Сургалт 3: Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа" сэдэвт сургалт

Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сайжруулах зорилготой уг сургалтыг 2022 оны 03 сарын 29-нөөс 04 сарын 01-ний өдрийг дуустал 4 өдөр Дархан-Уул аймгийн Төв номын сангаас зохион байгуулж Монгол Улсын Үндэсний номын сангийн Мэдээлэл арга зүй, Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Т.Хайдав багш удирдан явуулав.

Сургалтын зорилго уншигчийг судлах, нийтийн номын сангийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, уншигчийн судалгааны хэрэгцээ аргууд болон үйлчилгээний чанар мөн судалгаанд дүн шинжилгээ хэрхэн хийж ажиллах, судалгааны үр дүнд үйлчилгээний чанар хэрхэн сайжрах талаар зэрэг олон сэдвийн дагуу чухал хичээлүүд орлоо.

Сургалтанд түшиглэсэн дадлага ажлыг хийж, хийсэн бие даалтууд дээрээ ярилцаж дүгнэлт хийлээ. Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа" сэдэвт сургалтанд Төв номын сангийн 13 номын санч, Их дээд коллеж, Хүүхдийн номын ордон, ЕБСургуулийн номын санчид мөн Сумдын номын санчид болон нийт аймгийн 30 номын санчид хамрагдав.

Сургалт 4: Аймгийн Төв номын сангаас Номын санчдын техник технологийн сургалтыг зохион байгуулж, lib4u программын тухай нэгдсэн ойлголт, программын үйл ажиллагааны талаар санал хүсэлтийг хэлэлцэв. Тус сургалтыг номын сангийн программыг үүсгэн байгуулагч программист Инженер багш Гантулга удирдан явуулсан ба Дархан Уул аймгийн Төв номын сан, Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургууль, сумдын номын санчдын төлөөлөл 27 номын санчийн бүрэлдэхүүнтэй цахимаар оролцлоо. Сургалтаар:

1. Үүлэн технологид суурилсан онлайн програм
2. Номын санчийн програм
3. Уншигчийн каталогийн програм
4. Номын сангийн нэгдсэн бүртгэл

а/ Ном бүртгэх дараалал

б/ Ном актлах, акталсан номыг бүртгэлээс яаж хасах тухай

в/ Тогтмол хэвлэлийг программд хэрхэн бүртгэх тухай зэрэг сэдвүүдээр хичээл орсон бөгөөд номын санчид програмын талаар мэдлэгтэй болж, өөрийн байгууллагуудын удирдлагуудад хүсэлт тавих, цаашид программтай ажилласнаар ажлын ачаалал, цаг хэмнэх мөн уншигч, ирц, ном олголт болон фондын баяжилтын тоо баримтын тайлан мэдээг мэдээллэхэд асар их ач холбогдолтойг ойлгож авлаа.

б/ Их дээд сургуулийн номын санчид болон номын сангийн программтай номын санчид өөрсдийн программ дээр доголдолтой тал болон программд шинээр асуулт оруулах мөн нэмэлт мэдээлэл авах зэрэг мэдлэгийг олж авав.

<u>Зөвлөн туслах</u>: 28 байгууллага, 33 номын санчдад

Аймгийн Төв номын сангаас их дээд сургууль, ЕБС, Хонгор, Орхон, Шарын гол сумдын нийтийн номын сангуудаар очиж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сургуулийн номын сангуудын зохион байгуулалт, номын санчийн өдөр тутмын ажилтай танилцаж, нийт 28 байгууллагын 33 номын санчид арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна.

№	Зохион байгуулсан ажил		Тоо	Тайлбар
1.	ЗӨВЛӨН ТУСЛАХ: 28 байгууллага, 33 номын санчдад	Аймаг болон 3 сумдын, ЕБС, Их дээд сургуулийн номын санчдад	21	ЕБС, их дээд болон байгууллагуудын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, номын санчдад мэргэжлийн зөвлөгөө өгч зөвлөн туслах ажлыг гүйцэтгэж ирлээ.
2.		Аж ахуй нэгж байгууллагуудад	6	Номын сангийн хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдэд номын сан байгуулах талаар зөвлөгөө өгөв.
3.		Ахмадын хөгжлийн төвийн номын сан	5	“Ахмадын сургаал алт” төсөлд хамрагдаж Ахмадын хөгжлийн төвийн номын санд 80 цаг ажиллаж 700–гаад номыг номын сангийн стандартын дагуу техник ажиллагаа хийж, программд оруулж ажиллаа.
4.		Ахмадын хөгжлийн номын санч П.Дархансувдад зөвлөн туслах үйлчилгээ	1	Ахмадын хөгжлийн номын санч П.Дархансувдад номын сангийн үйлчилгээ, номын фондын зохион байгуулалт,хадгалалт хамгаалалт, электрон каталогт хэрхэн номоо оруулах, уншигчаа бүртгэх, үйлчилгээ хэрхэн хийх, номын санд хөтлөгт дэвтэр, маягтыг хэрхэн хөтлөх түүнийхээ дагуу номоо хэрхэн бүрдүүлэх гэх мэт

Аймгийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж арга зүйн зөвлөгөө өгсөн хуваарь

Сар өдөр	Ажиллах сургуулиуд	Номын сангийн програмтай эсэх	Уншигч, номын фондын тоо	Номын сангийн 17 маягтын хөтлөлт																
				өдөр тутам	Н.б.бүртгэ	Нэгдсэн	У.карт	зах.хуудас	каталог	Сэт.карт	Сон.карт	формуяр	татгалзал	лавлагаа	ном.солил	н.с.уншигч	н.т.акт	н.х.акт	у.н.бүртгэл	б.х.н.з.хууд
1 сар 10	1-р сургууль	үгүй	У- 930 Ф-20018		+		+													
4 сар 12	2-р сургууль	үгүй	У-1300 ф-19166		+		+		+			+								
1 сар 10	4-р сургууль	үгүй	У-1070 ф-20900		+		+					+								
4 сар 12	6-р сургууль	үгүй	У-300 ф-19000		+		+													

9 сар 22	8-р сургууль	тийм	У-280 ф-7700	+	+	+	+													
2 сар 10	9-р сургууль	үгүй	У-2315 ф-21443	+	+	+	+					+								
2 сар 10	10-р сургууль																			
3 сар 11	11-р сургууль	үгүй	У-230 ф-3000																	
1 сар 27	12-р сургууль	үгүй	У-330 ф-3400	+	+	+	+								+					
3 сар 11	14-р сургууль	үгүй	У-320 ф-10000		+		+													
3 сар 24	15-р сургууль	үгүй	У-2300 ф-46000		+		+													
3 сар 24	16-р сургууль	үгүй	У-1702 ф-25000	+	+		+		+											
4 сар 28	18-р сургууль	үгүй	У-1324 ф-15000																	
5 сар 12	19-р сургууль																			
4 сар 28	21-р сургууль																			
5 сар 12	22-р сургууль																			
1 сар 27	24-р сургууль		У-560 ф-18000	+	+	+	+				+	+								
6 сар 9	28-р сургууль																			
6 сар 9	29-р сургууль	тийм	У-		+		+		+											
9 сар 29	30-р сургууль																			
1 сар 04	Од цогцолбор	үгүй	У-1800 ф-25000		+		+													
1 сар 04	Од цогцолбор	үгүй	У-2060 ф-20000		+		+													
6 сар 23	ОИЦогцолбор																			
6 сар 23	ОИЦогцолбор																			
9 сар 22	Шинэ алхам																			
	Орхон сум	тийм	У-1500 ф-500		+		+													
	Хонгор сум	үгүй	У-5985 ф-6297		+															
				7	16	5	15		3		1	4			1					

Дээрх судалгаанаас үзэхэд номын сангийн 17 маягт бүрэн эхээрээ хөтлөгддөггүй, хөтөлсөн маягтууд дутуу бөглөгдсөн учраас ерөнхий боловсролын номын санчдад анхан шатны сургалт тэр тусмаа маягт хөтлөлтийн сургалт хэрэгтэй байгаа тоон үзүүлэлтүүд гарлаа.

<u>Судалгаа:</u> **3 удаа 432 хүнээс судалгаа авлаа**

1.	Судалгаа	МУҮНСангаас явуулсан Сан хөмрөг, Уншигч, Цахим уншигч, Ажилтаны судалгаа	1	МУҮНСангаас явуулсан Сан хөмрөг, Уншигч, Цахим уншигч, Ажилтаны судалгааг Ахлах номын санч Г.Нямцэндтэй хамтарч бөглөж мэдээг МУҮНСангийн аргазүйн хэлтэс рүү цахимаар явуулав.
2.		Нийтийн номын сангийн хүртээмжийн судалгаа	416	Хонгор сумын 100 иргэнээс Шарын гол сумын 100 иргэн болон Хонгор сумын Салхит багийн 50 иргэнээс нийт 250 иргэд болон аймгийн хэмжээнд нийт Нийтийн номын сангийн хүртээмжийн судалгаа 416 иргэнээс авч судалгааны программд бүртгэлээ.
3.		Соёл урлагийн ажилтны жендэрийн судалгаа	15	Соёлын Яамнаас гаргасан судалгааг бөглөж, СУГ-т хүргүүлэв.

<u>Дээд газраас ирсэн болон бусад судалгаа:</u>

- ✓ Төв номын сан болон бусад номын санчдын шагналын судалгааг авч 2022 оны 02 дугаар сарын байгууллагын хурлаар хэлэлцүүлэн төрийн одон медальд 5 хүн, салбар яамны шагнал 1 хүнийг тодорхойлон материалыг Дархан-Уул аймгийн Засаг даргад хүргүүлэв.
- ✓ Соёл урлагийн байгууллагын компьютер, интернэтийн хүчин чадлын судалгааг цахимаар,

- ✓ МХЕГ-аас ирүүлсэн “Номын сангийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд тандалт судалгаа хийх” сэдвээр ирүүлсэн судалгааг бөглөж цахимаар МХГ-ын улсын байцаагч М.Амарсанаад
- ✓ 5 жилийн тэтгэмж олгох албан хаагчдын судалгааг гаргаж СУГ-т
- ✓ Номын сангийн ажилтан албан хаагчдын санхүүгийн болон бусад дэлгэрэнгүй судалгаа
- ✓ Хүний нөөцийн боловсрол болон дэлгэрэнгүй судалгаануудыг гаргаж БСУГазрын мэргэжилтэн Ц.Отгонбаярт
- ✓ Соёлын яамны судалгааны багаас ирсэн 8 хуудастай судалгааг ажилтан, албан хаагч, уншигчдаар 15 хувийг бөглүүлэн БСУГ-ын мэргэжилтэн Ц.Отгонбаярт хүргүүлэв.
- ✓ “Соёл урлагийн байгууллагын санхүүгийн бодит байдлыг үнэлэх судалгаа”
- ✓ Соёлын Яамнаас явуулсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа дахь иргэдийн оролцоо, журмын хэрэгжилт, үр дүнг тандах судалгаа”-нд хамрагдлаа.
- ✓ Үндэсний бичгийн сургалтад хамрагдаж байсан төрийн албан хаагчдаас авах судалгаа”-нд 15 ажилтан албан хаагчид бүрэн хамрагдлаа.

Туршлага судлах ажилд номын санчдыг хамруулсан байдал: ***3 удаагийн аялалд 90 номын санч оролцов.***

1	**Тойрон аялал- 3 удаа 90 номын санч**	Номын санчдад туршлага судлуулах аялал	15	ТНС-ийн номын санчдыг Аймгийн Шилдэг сургуулиуд ХААИС, ШУТИСургуулийн Дархан дахь Технологийн сургуулиудын оюутны төслөөр тохижуулсан уншлага үйлчилгээний танхим, оюутны VIP өрөөнүүд болон номын сангийн үйлчилгээтэй танилцуулж туршлага судаллаа.
2		"Хотын бүтээлч аялал"-ыг зохион байгуулав	60	Соёлын Аялал Жуулчлал орон нутийн тогтвортой хөгжлийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 60 гаруй номын санчдыг Дархан хотын бүтээн байгуулалт, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцуулав
3		Номын санчид хөдөө орон нутагт	15	Төв аймгийн Нийтийн номын сангийн барилга, тохижилт засвар үйлчилгээ, үйл ажиллагааны арга туршлагатай нь танилцаж, санал бодлоо хуваалцлаа

Оюутны дадлагын хөтөлбөр:

Соёл Урлагийн Их Сургуулийн оюутан Д.Буянжаргал, М.Буяндэлгэр нар 2022 оны 04 сарын 25-ны өдрөөс 2022 оны 05 сарын 16-ны өдрийг хүртэл, Д.Нацагдоржийн нэрэмжит Утга Зохиол Нийгмийн Ажилтны Дээд Сургуулийн оюутан Б.Энхтуяа 03 сарын 14-нөөс 03 сарын 28-ныг хүртэлх хугацаанд Дархан-Уул аймгийн Төв номын санд эзэмшсэн онол мэдлэг, чадварт түшиглэн практик чадвар, дадлыг олгох зорилгоор дадлага хийлгэх, хамтран ажиллуулах сургуулийн хүсэлтийн дагуу дадлагын удирдамжийг үндэслэн оюутнуудыг хүлээн авч, дадлагын хөтөлбөрийг батлуулан арга зүйн зөвлөгөө өгч, номын санч нартаа ажил үүргийн хуваарийн дагуу хамтран ажиллаж дадлагажуулах ажлыг хийж гүйцэтгэж, дадлага хийсэн тодорхойлолтыг сургуулиудын захиргаанд хүргэж ажиллалаа.

ЗУРГАА. ЛАВЛАГАА-НОМЗҮЙН АЖИЛ

Лавлагаа үйлчилгээ: 232

Уншигчаас сонирхон лавласан аливаа асуултыг номын сангаас зохих цаг хугацаанд нь түргэн шуурхай биелүүлэхэд чиглэгдсэн үйлчилгээ юм. 2022 онд нийт уншигчийн асуусан 232 лавлагааг амаар өгч лавлагааны бүртгэлд бүртгэсэн байна.

Татгалзал: 312 боть

Тайлангийн хугацаанд номын сан нийт 300 гаруй боть номыг татагалзалд бүртгэснээс татгалзал 90%-тай биелээд байна.

Номзүй

Д/д	Хийж гүйцэтгэсэн ажлууд	Хэдэн удаа
1	Лавлагаа номзүйн үйлчилгээ	311
2	Номзүйн мэдлэгийг сурталчлав	38
3	Өгсөн лавлагааг хөтлөх фонд баяжилтанд санал оруулав	62
4	“Шинэ номын агуулгын тайлбартай бүртгэл”-ийг цахимд оруулав.	6
5	Цахим ном уншигчийн талаар танилцуулга	115
6	Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд мэдээлэл явуулав	1
7	Шинээр “Шинэ номын дата үүсгэв”	296 боть ном
8	Шинэ номын мэдээг лавлагааны компьютерт байршуулав	265 боть ном
9	Шинэ номын мэдээг аудио хэлбэрт буулгав	265 боть ном
НИЙТ		**1125**

Цахим сурталчилгаа 19 удаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр, албан ёсны хуудас, нүүр номоор 25 удаа : Номын сангийн төлөвлөгөөт ажлууд болон шинээр санаачлан хийсэн ажлуудыг олон нийтэд түгээх, номын сангийн үйл ажиллагааг сурталчлах хүрээнд:

- “Ганжуур Данжуур” судрын тухай тайлбар нэвтрүүлэг 1 удаа

- Номын баярын тухай нэвтрүүлэг 1 удаа
- Үндэсний бичиг соёл номын өдрүүд шторк 1 удаа
- Төв номын сангийн онцлох ажлууд нэвтрүүлэг 1 удаа
- Номын сангийн зохион байгуулсан үйл ажиллагаанаас бэлтгэсэн мэдээ 8 удаа
- Хэвлэлийн бага хурал 1 удаа
- Номын сангийн зохион байгуулсан үйл ажиллагаанаас бэлтгэсэн шууд лайв 3 удаа
- MGL радио, Гэр бүлийн радиогийн Орон нутгийн цаг нэвтрүүлэгт 3 удаа оролцов.
- Орон нутгийн хэвлэл мэдээллээр 5 удаа тус тус номын сангаас зохиосон олон нийтийн үйл ажиллагааг сурталчиллаа.

Цахим үйлчилгээ:

Д/д	Хийж гүйцэтгэсэн ажлууд	Хэдэн удаа
1	Техник хэрэгсэл, Хор цэнэглэлт, Интернет, Хяналтын камер	45
2	Мэдээлэл дамжуулалт	58
3	СТМАд оролцсон байдал	19
4	Фэйс бүүк	256
5	Номын сангийн lib4u	15
6	Өнгөт хэвлэл	279
7	И-Мэйл хаяг, болон утас	136
8	Ном зүй болон цахим ном	1386
9	Цахимаар лавлагаа болон датгалзал , цагийн хуваарь	311
10	Эйбли програм	44
11	Сургалт	18
12	Зураг авалт	499
13	Бусад ажил	16
НИЙТ		**3008**

ДОЛОО.ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР:

- ✓ 2022 онд 580,044,0 мянган төгрөгний 6 төсөл боловсруулж холбогдох газруудад хүргүүлж, “Ахмадын сургаал алт”, “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө” сэдэвт 36 хууд 1800000 төгрөгний 2 төсөл амжилттай хэрэгжиж дууслаа.
- ✓ 10,0 сая төгрөгний “Тусгай бүлгийн уншигчдад соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт төслийг бичиж Дархан суманд хүргүүлэв.
- ✓ 282 044 000 төгрөгний “Соёлын үйлчилгээний тэгш хүртээмж” төслийг бичиж Соёлын Яамны харъяа Соёл урлагийн газарт цахимаар явуулав.
- ✓ Аймгийн ЗДТГ-т “Номын сангийн тоног төхөөрөмж” төсөл 222 200 000 төгрөг
- ✓ Вьетнам улсын төсөлд “Иргэддээ мэдлэг түгээе” 64000000 /Жаран дөрвөн сая / төгрөгийн төслүүдийг тус тус бичиж хүргүүллээ.

НАЙМ. ТАЙЛАН, МЭДЭЭ ХҮРГЭЛТИЙН ТАЛААР

***Санхүүгийн тайлан*,** Бараа материалын гүйлгээ, тогтмол гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн гүйлгээ, зардал хоорондын шилжүүлэг, сар, улирал бүрийн санхүүгийн тайлан, санхүүгийн сар бүрийн мэдээ, НД-ын тайлангуудыг сар бүрээр, худалдан авах ажиллагааны тайлан, татварын тайлангуудыг улирал бүрээр, орон нутгийн өмчийн тайлан, санхүүгийн тайланг хагас жилээр гаргаж, холбогдох газруудад хүргүүллээ.

Мэдээ, тайлан судалгаа:

- ✓ 2021 оны гүйцэтгэлийн тайланг гаргаж, ТЗУ-ын хэлтэст, Байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний тайланг аймгийн Хяналт шинжилгээ дотоод аудитын хэлтэст,
- ✓ Номын сангийн 2021 оны үйл ажиллагааны Б-НС-1.1, Б-НС-1.2, Б-НС-1.3, Б-НС-2.1, Б-НС-2.2, Б-НС-2.3 мэдээнүүд, Соёл урлагийн байгууллагын хөрөнгө, санхүүгийн 2021 оны Б-СУХС-1.1, Б-СУХС-1.2 мэдээнүүдийг гаргаж БСУГ-аар уламжлагдан статистикийн газарт хүргүүлэв.
- ✓ Төвлөрсөн номын сангийн ҮЭХ-ны 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, татвар, статистикийн тайлангууд, болон сар улирал, 7 хоногийн мэдээг цаг хугацаанд нь холбогдох газруудад өгч ирлээ.
- ✓ 2021 оны үйл ажиллагааны тайлан, судалгааг Соёлын Яам, МУ-ын ҮНС-дад тус тус цахимаар хүргүүлэв.
- ✓ Хүний нөөцийн онлайн судалгааг дахин хянаж, санхүүгийн бүртгэл тооцоог шивж оруулж дуусгавар болголоо.
- ✓ Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлангууд,
- ✓ 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж, Аймгийн Засаг дарга Б.Азжаргалаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.
- ✓ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний хагас жилийн хэрэгжилтийн тайлан
- ✓ Дархан-Уул аймгийн БСУГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудын хэрэгжилтийн тайлан
- ✓ 2022 оны ажилтан, албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлэв.

Тооллого:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2179 “Улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж хүргүүлэх тухай”, байгууллагын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/04 тоот тушаалаар томилогдсон тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 02-р дугаар сараас 05 дугаар сарын 25-ны хугацаанд хийж дуусгалаа. Эд хөрөнгийн тооллогын ажлыг дараахь байдлаар хийж гүйцэтгэлээ. Үүнд :

- ✓ ТӨХ-1Дархан-Уул аймгийн Төвлөрсөн номын сангийн 9022287 тоот регистрийн дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээнд хуулийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн бүртгэл хийлгэв.
- ✓ ТӨХ-2Дархан сумын 8-р баг 17-р хороолол Дэвшил 2-ын 208 хаягт байрлах, нэгж талбарын 4506903755 дугаар бүхий 1066м.кв газрыг, улсын бүртгэлийн Э-2003000646 дугаарт бүртгүүлснийг цахим бүртгэлд оруулав.
- ✓ ТӨ-3 Санхүүгийн программ хангамж, LIB4U-net номын сангийн программ хангамжуудыг бүртгэж орууллаа.
- ✓ ТӨХ-3Барилга байгууламжийн үндсэн хөрөнгөндөө 2 ширхэг 110 688 504 төгрөгийн барилга программд оруулахдаа нэгбүрчилэн хэмжээс талбайг нарийн тусгаж тооцон бүртгэлд , 4 талт зургийг оруулдаа.
- ✓ ТӨХ-5 Маягт дээр Машин тоног төхөөрөмж 137 ширхэг, 56 628 418,80 мөнгөний
- ✓ ТӨХ-6.
    - o Автомашин, эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын хүрээнд жолоочийн хариуцлагын даатгалыг шалгуулж тамга даруулав
    - o Тээврийн хэрэгслэлийн гэрчилгээ солиулж, өмнөх оны торгуулиа төлөв.
    - o Авто машинаа оношлогоонд оруулж, 33000 төгрөг төлсөн.
    - o Е-Баримт хэвлэж авах
    - o Тээврийн хэрэгсэлийн 4 талын зургийг оруулав.

- ✓ ТӨХ-7Комиссын гишүүд маягтын дагуу програмдаа эд хөрөнгийн хэмжээ, үзүүлэлт, хурд, ажиллах цагуудыг нарийн бүртгэн оруулаа.
    - Тавилга эд хогшил-197 ширхэг- 29800537,04 төгрөг
    - Ном-56189 ширхэг, 189182013,55 төгрөг,
    - Бусад 2 ширхэг, 5 289 000,0 төгрөгний эд хөрөнгө бүртгэснийг тооллогын комисс тулган шалгалаа.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2179 "улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж хүргүүлэх тухай", байгууллагын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/04 тоот тушаалаар томилогдсон тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогыг хийж, элэгдлийн хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй, засвар авахгүй өнгө үзэмж муутай, сэлбэг запас нь олдохоо больсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг актлахаар нийт 32 нэр төрлийн машин, тоног төхөөрөмж, 23 нэр төрлийн тавилга эд хогшлыг актлуулахаар орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв. Дээрх жагсаалтын дагуу Аймгийн ИТХ-ын хуралдаанаар актлах шийдвэр гараад байна.

<u>Бусад ажил:</u>

Архивын ажлын хүрээнд:

Дархан-Уул аймгийн Архивын тасгаас жил бүр манай байгууллагын архивын баримтын тоо хэмжээ, хадгалалт хамгаалалтын талаарх мэдээг 2020 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар сан хөмрөг-175, хадгаламжийн нэгж-309, хуудас-25431, үүнээс байнга-143, түр-123, 70 жил хадгалах 43 баримт байгаагаас 1980-2015 оны 97 хадгаламжийн нэгжийн Дархан-Уул аймгийн Төрийн архивт хүлээлгэж өгсөн мэдээ тайланг маягтаар болон албан тоотоор хүргүүлэв.

Байгууллагын хэмжээнд 2021 онд хөтлөгдөж дууссан баримт бичгүүдийг нэгж тасгаас хүлээн авах ажлыг эхлүүлээд байна. Байгууллагын архивт байнга хадгалах хадгаламжийн нэгж 12 нэр төрлийн 769 хуудас, 70 жил хадгалагдах хадгаламжийн нэгж 2 нэр төрлийн 163 хуудас, түр хадгалагдах хадгаламжийн нэгж 42 нэр төрлийн 3231 хуудас, нийт 56 нэр төрлийн 4163 хуудас бичиг баримтыг үдэж архивлав. 4163 хуудас бичиг баримтуудыг скайнердаж /JPG, PDF/ цахим баримт үүсгэн хадгалаж байна.

- ✓ АРХИВЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДАГУУ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА
    - Аймгийн Архивын газраас Төв номын сангийн архивын сан хөмрөг, архивын баримтын тоо бүртгэл, тооллого, хадгалалт хамгаалалт, цахим сан бүрдүүлэлт, архивын баримтын ашиглалт зэрэг хэд хэдэн чиглэлээр хяналт шалгалтыг хийж, 19 төрлийн зөвлөмж өгсөн ба энэ дагуу холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Албан бичиг хэргийн хүрээнд:

Ирсэн 35 нэр төрлийн 85 хуудас
Явсан бичиг 139 нэр төрлийн 485 хуудас
Захирлын тушаал 37 нэр төрлийн 58 хуудас

Нийт 211 нэр төрлийн бичиг баримт үйлдэн бүртгэл хийж 628 хуудас скайнердаж jpg, pdf болгон хадгалахаас гадна Able программ дээр оруулан цахим болгон хадгалаж байна.

Мод тарих: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэр бум" мод үндэсний хөтөлбөр, Дархан-Уул Аймгийн Засаг даргын санаачилгаар "Ногоон-Дархан" мод тарих аянд нэгдэж, Миний монгол цэцэрлэгт хүрээлэнд 15 ширхэг Хайлаас мод, ахлах номын санч Г.Нямцэнд өөрийн хашаандаа 219 ширхэг хайлаас, 3ш монос, 3ш үрэлний мод, сан хөмрөгч П.Булгамаа 2 ширхэг нарс, 2 ширхэг голт бор нийтдээ

244 ширхэг мод тарив. Мөн Төрийн албан хаагчийн төгөл байгуулахад уриалгад нэгдэж 14 хүн нийт 394,100 төгрөгийг хандив болгон тушаасан байна.

Бүх нийтийн цэвэрлэгээ: Аймгийн Засаг даргын Захирамжийн дагуу сар бүрийн эхний 7 хоногийн Бямба гарагт бүх нийтийн цэвэрлэгээг хийдэг. Төв номын сангийн хамт олон хуваарьт талбайд тогтмол цэвэрлэгээ хийж байна.

ҮР ДҮН:

- ✓ ***Нийт албан хаагчдын цалин хөлс, хоол унаанд -*** 5.324.000
- ✓ ***Урамшуулал -*** 16.706.200
- ✓ ***Нэг удаагийн буцалтгүй тусламж - 768.000***
- ✓ ***Номын сангийн тоног төхөөрөмж-*** 5 849 900
- ✓ ***1 ш компьютер, 1ш түргэн скейнр***
- ✓ ***Үндсэн хөрөнгөд 1760 ширхэн 16.148.030 төгрөгийн ном үндсэн хөрөнгөнд бүртгэж авлаа. Үүнээс 5 000 000 төгрөгөөр төсвийн хөрөнгөөр номын баяжилт хийгдлээ.***
- ✓ ***2022 онд өмчийн улсын тооллого хийгдэж О үлдэгдэлтэй хөрөнгийг өмч хамгаалах газарт актлах санал хүргүүллээ.***
- ✓

2022 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ, АМЖИЛТ БҮТЭЭЛЭЭС:

- Монгол Улсын Соёлын яамнаас “Үндэсний бичиг үсгийн баяр-2022” хаврын үйл ажиллагааг “Үндэсний бичиг үсэг - Монгол соёлын үнэт өв” уриан дор зохион байгуулж тус баяраар 21 аймгийн Нийтийн номын сангуудаас шилдэг номын санг шалгаруулж “НОМ ЦОМ”-ыг Дархан-Уул аймгийн Төв номын санд гардуулан өгөв.
- “Үндэсний бичиг үсэг - Манай хамт олны өв соёл” цахим контентын уралдаанд хамт олноороо оролцож Үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, иргэд уншигчдыг үндэсний бичгээ сурах хүсэлд хөтлөх, урамшуулах олон ажлуудыг зохион байгуулсан дүнгээр 3 дугаар байр эзлэв.
- “Монгол хүний удмын сан, Угийн бичиг хөтлөх журам”-ыг хэрэгжүүлэх, сургагч багшаар ажиллах эрхийг номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд, Ном зүйч Х.Отгонбаяр нар, Соёлын боловсролын үндэсний сургагч багшаар ажиллах батламжийг захирал Б.Цэцэгсүрэн нар авч нийгмийн, нийтийн соён гэгээрүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

2022 оны бүтэн жилийн ТООН МЭДЭЭ

2022.12.06.

Д/д	Ажил үйлчилгээ	Дүн	Гүйцэтгэлийн хувь
1	Байнгын уншигч	5102	134%
2	Иргэсэд	55053	101%
3	Ном олголт	70937	118%
1	Нэгбүрчилсэн бүртгэл	Төв уншлага	10728
2		Уншлага	9243
3		Архив	8951
	Нэгбүрчилсэн бүртгэлийн дүн		**28922**
Соёл олон нийтийн ажлын тоон мэдээ			
		Хэдэн удаа	**Боть ном**
1	Сэдэвчилсэн номын үзэсгэлэн	37	2698
2	Нүүдэл зөөврийн номын сан /боть/	23	1360
3	Гэрээр ном олгох	270	467
4	Номын сан хоорондын ном солилцоо	218	234
	ДҮН	**548**	**4759**
		Хэдэн удаа	**Хүний тоо**
1	Хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг	4	89
2	Сургалт (танхимаар)	32	618
	Сургалт (цахимаар)	11	124
3	Зөвлөн туслах /хүн/	28	33
4	Судалгаа	3	432
5	Лекц /хүн/	25	1592
6	Эрдэм шинжилгээний хурал	2	91
7	Уншигчдын бага хурал	1	80
8	Шинэ номын нээлт	4	191
9	Зохиолч уншигчийн уулзалт	6	349
10	Уралдаан тэмцээн	23	6589
11	Өглөөлөг	1	20
12	Өдөрлөг	19	3844
13	Туршлага солилцох аялал	3	90
14	Сэдэвчилсэн номын үзэсгэлэн	37	8309
15	Хэвлэл мэдээллийн сурталчилгаа	25	
16	Ном солилцооны өдөрт	5	145
17	Номын сантай танилцах аялал	17	574
18	Өглөөний уншлагын аян	5	99
	24 нэр төрлийн, 280 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, 24310 хүн хамрагдсан байна.	**280**	**24,310**
19	Нүүдэл, зөөврийн уншлага	23	1037
20	Ном гэрээр олгох	270	270
21	Чанга уншлага	10	447
22	Урилгат уншлага	20	658
23	Зуны уншлага	9	383
24	Номын тойм	9	218
	ДҮН	***341***	***3,013***

ДОРНОГОВЬ АЙМГИЙН А.ЭРДЭНЭ-ОЧИРЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Эрхэм зорилго:

Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалж хамгаалах, ард иргэдэд ном соёлоор үйлчлэн тэдний оюуныг хөгжүүлэх, бүтээлч санаачлагыг өрнүүлэх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, тав тухтай тохилог орчинг бүрдүүлэх, номын сангийн стандартыг ханган ажиллахад оршино.

1.2 Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь **1945** онд байгуулагдсан, нийт **14** хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Номын сан нь уншлагын 2 танхим, Соёмбо салбар уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, үндсэн фонд, хэвлэлийн фонд, гэр бүлийн уншлагын танхим зэрэг танхимуудаар үйл ажиллагаагаа явуулдаг. Нийт 484м^2 талбайг номын сангийн үйлчилгээнд зориулан ашиглаж байна.

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: dg.library@yahoo.com

Цагийн хуваарь:
Насанд хүрэгчдийн уншлагын танхим:
Даваа-Лхагва 8^{00}-20^{00}, Пүрэв-Ням 8^{00}-17^{00}
Бусад тасаг танхим:
Даваа-Баасан 8^{00}-17^{00}
Байгууллагын утасны дугаар: 70522706
Номын сангийн захирал: А.Байгалмаа

2,САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2,1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт **121.833.484** төгрөгний **56758** ш номтой байснаас 2022 онд ном актлах саналыг аймгийн орон нутгийн өмчид хүсэлт гаргасанаар **17808ш 8,382,713** төгрөгний номыг акталсан болно. 2022 оны жилийн эцсийн байдлаар **39672ш 113,450,771** төгрөгний номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2 Сан хөмрөгийн бүрдүүлэлт

2021 оны фондын бүрдүүлэлтийг төсвийн санхүүжилтээр шинэ ном **11,302,798** төгрөгийн **540** ширхэг, хандив бэлгээр **1,153,800** төгрөгийн **182** ширхэг номоор нийтдээ **12,456,598** төгрөгний **722** ширхэг номоор сан хөмрөгийн баяжилтыг хийсэн. Мөн **8** нэр төрлийн **828** ширхэг **590440** төгрөгний хэвлэл захиалж иргэдийг өдөр тутмын мэдээ мэлээллээр ханган ажиллав.

Бүрдүүлэлт	Тоо ширхэг	Үнэ /төг/

Шинээр нэмэгдсэн нийт	722	12,456,598
Шинээр нэмэгдсэн ном	Шинэ ном-540 хандив-182	Шинэ ном – 11.302.798 Хандив – 1.153.800
Шинээр нэмэгдсэн Сонин, сэтгүүл	828	590440

Хийгдсэн ажил	Тоо хэмжээ
Электрон каталогт бүртгэгдсэн нийт ном	39672
Электрон каталогт шинээр нэмэгдсэн ном	722
Электрон каталогт хийгдсэн хайлтын тоо	1552

2.3 Каталог зохион байгуулалт

Номын санд шинээр ирсэн **722** ширхэг номонд техник ажиллагаа хийж данс бүртгэлд тусган электрон катологт бүрэн оруулж тасаг танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд гарган ажиллаж байна. Нийт номын сангийн хэмжээнд **39672** ширхэг номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

3, ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 **Уншлага үйлчилгээ:**

Жилийн эцсийн байдлаар нийт 1803 уншигч, 17394 ирцэд 25769 ном хэвлэл олгож үйлчиллээ. Энэхүү тоон үзүүлэлт зөвхөн төв номын сангийн уншигч, ирц, ном олголтын тоо юм.

Үзүүлэлт	Тоо, хэмжээ
Аймгийн төвийн иргэдийн тоо	69386
Бүртгэлтэй уншигчийн тоо	1803
Номын сангийн ирц	17394
Олгосон ном	25769

- Хөдөө орон нутаг болон алслагдсан айл өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өндөр настан зэрэг номын санд ирэх боломжгүй хүмүүст номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, уншигчдын хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сан болон “Номын багц” үйлчилгээг тогтмол ажиллуулж байна.
    - Зөөврийн номын үйлчилгээгээр 24 байгууллага давхардсан тоогоор 72 удаа үйлчлүүлж **1326** ирцэд 3950 ном олгож үйлчилсэн
    - “**Номын багц**” үйлчилгээ **14** удаа **508ш** номыг айл өрх албан байгууллагат гэрээгээр багц үйлчилгээг хүргэж ажилласан.

3.2 Номын үзэсгэлэн:

- Цаг үеийн болон сэдэвт үзэсгэлэнг 26 удаа дэлгэж 3585 номыг 1800 хүнд үзүүлэн фондын ном хэвлэлээ сурталчилан таниулсан.

4. **СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ:**

"МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ УЯА ЗАНГИЛАА"

Энэхүү сургалтыг иргэдийн дунд зохион явуулсан. Сургалтанд 70 гаруй иргэд оролцсон. Тэдний сурсан зүйлээр уралдаан явуулж шалгаруулахад Тэргүүн байранд Ч.Одгэрэл ЕБ-ын 5 дугаар сургуулийн 12в анги, Дэд байранд ЕБ-ын 3 дугаар сургуулийн Дотуур байрны хамт олон, Гутгаар байранд иргэн Л.Болор-Эрдэнэ нар шалгарлаа.

Сургагч багшаар Мандах сумын ахмад П.АваргаЗаан, Ө.Чулуу нар хамтран ажиллаа.

Үр дүн: Монголын уламжлалт уяа зангилааны соёлыг олон нийтэд сурталчлан түгээснээр ирээдүй болсон хүүхэд багачууд ахмад үеэсээ суралцан хийж бүтээж бодит үр дүнг үзүүллээ.

“БАРИМЛЫН ШАВРААР УРЛАХУЙ”

Энэ бүтээлийн уралдаанд нийт 78 хүүхэд оролцсон. Тэргүүн байранд У. Чингүүн, Дэд байранд Б.Мөнгөншүүдэр, Гутгаар байранд Э.Энхтамир, Тусгай байранд О. Хаш-Эрдэнэ, А. Билгүүн, Б.Сондор, Г. Хүрэлхүү, ЕБ-ын 5 дугаар сургуулийн 5в ангийн сурагчдын хамтын бүтээл шалгарсан байна.

Үр дүн: Хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж тэдний урлан бүтээхэд урам оруулсан гэж эцэг эх багш нар дүгнэн хэлсэн.

“МИНИЙ НАНДИН ЭРДЭНЭ”

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр өөрийн хайртай хүндээ барих бэлэг болгон зарладаг уралдааныг 6 дахь жилдээ зохион явуулж байна Хийж бүтээсэн зүйлээ зориулсан эзэнд нь өгч баярлуулдаг онцлогтой.

Тэргүүн байрыг ЕБ-ын 5 -р сургуулийн 5а ангийн сурагч Б.Номин, Дэд байрыг 2-р сургуулийн 6б ангийн сурагч М.Энхжин, Гутгаар байрыг 2 -р сургуулийн 3а ангийн сурагч Э.Нандин-Эрдэнэ, Тусгай байрыг 5 -р сургуулийн 1б ангийн сурагч А.Ачит, 2-р сургуулийн Х.Намуун, 2б ангийн сурагч О.Нарангоо, 3г ангийн Б.Шинэ-Өглөө нар эзлэв.

Үр дүн: Өөрийн хүндэлж хайрладаг эрхэм хүндээ сэтгэлийн бэлгийг өөрийн бүтээлээр илэрхийлж сурах мөн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан соёлын уламжлалт ажил болсон.

“ЭССЭ БИЧИЖ СУРАХ” ЛЕКЦ

ЕБС-ын ахлах ангийнханд эссэ хэрхэн бичих талаар, мөн ном уншихын ач тусын тухай сонирхолтой лекцийг зохиолч МЗЭ-н гүйцэтгэх захирал О.Энхжавхлан урьж ирүүлэн уншууллаа. Сайншанд сумын ЕБС4 сургуулийн төлөөлөл болох 300 гаруй хүүхэд хамрагдсан.

Үр дүн: Эссэг хэрхэн бичиж сурах талаар мэргэжлийн зөвлөгөөг анх удаа ахлах ангийнхан сонсож асуулт хариулт хийсэн үр өгөөжтэй сургалт боллоо.

“ХҮҮХДИЙН ЗОХИОЛЧТОЙ УУЛЗАЛТ”

“Хүүхэд хөгжил-2022” зорилтод жилийн хүрээнд Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт хүүхдийн зохиолч О.Сундуйг урьж “Зохиолч-Уншигчдын уулзалт”-ыг зохион байгууллаа. Уулзалтад СӨБ-ын ахлах, бэлтгэл бүлгийн хүүхэд багачууд оролцож, тэд зохиолчийн шүлгийг уншиж, дууг нь дуулж, зохиолчоор шүлэг уншуулан шинэ номын дээжээр шагнуулсан сайхан үйл ажиллагаа болж өнгөрлөө.

Үр дүн: Өөрийн уншдаг шүлэг, дуулдаг дууныхаа зохиогчтой хүүхдүүд нүүр тулан уулзсан нь тэдэнд урам өгсөн шинэлэг ажил боллоо.

“ҮЛГЭРЧ БАГШ”

Цэцэрлэгийн багш нарын дунд “Үлгэрч багш” уралдаан зарлаж шалгарсан багш нарын бүтээлийг цахимд байршууллаа.

Үр дүн: Багш нар хүүхдэд үлгэр ярих нь багшийн ур чадварыг хөгжүүлэх хүүхэд багшийн шүтэлцэх холбоог бий болгоход тус нэмэр болсон гэж үзэж байна.

“ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДАД НОМ СОЁЛЫГ ТҮГЭЭЕ”

Номын баярын хүрээнд нутгийн залуу яруу найрагч нарын уран бүтээлийг уншигч олонд сурталчлан таниулах зорилгоор Зүүнбаян багийн соёлын төв, Зэвсэгт хүчний 336-р анги нэгтгэлтэй хамтран тэргүүний уншигч шалгаруулах, асуулт хариултын “АХА” тэмцээн, яруу найрагч нар уран бүтээлээ толилуулах, Номын үзэсгэлэн гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.

Үр дүн: Тодорхой хүрээ хязгаарт тодорхой хугацаагаар хязгаарлагдсан залууст ард иргэдийн чөлөөт уулзалт номын соёл яруу найргийн уншлагыг хийсэн нь тэдний хувьд содон үйл ажиллагаа боллоо гэж ангийн захирагч дарга нар үнэлсэн.

“ЦАСНЫ ГЭГЭЭ” ЯРУУ НАЙРГИЙН УНШЛАГА

Соёлын яамнаас зарласан “Соёлын бүтээлч сар”-ын аяны хүрээнд байгууллагын соёл олон нийтийн ажлын хаалтын ажиллагаа болгон зохион байгуулан аймгийн хурмаст тэнгэр төвийн гишүүдтэй хамтран хээр цасанд яруу найргийн уншлагыг зохион байгуулаа. Мөн энэ үеэр зөөврийн номын сангийн үйлчилгээнд хамтран ажилдаг албан байгууллага, гэрээр ном олгох танхимаас “Тэргүүний уншигч” шалгаруулан шагнаж урамшуулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Зүүнбаян соёлын төвийн номын сан, Сайншанд сумын 10-р цэцэрлэгүүд “Оны шилдэг хамт олон”-оор шалгаран өргөмжлөл мөнгөн шагналаар, гэрээр ном олгох танхимаас 2022 онд хамгийн олон ном уншсан тэргүүний уншигчаар Л.Дасранг “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдэг, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. Нийт 30 хүн оролцсон.

Үр дүн: Хэвшмэл үйл ажиллагааг өөрчилж агаар салхинд соёлын ажлыг зохион байгуулсан нь уран бүтээлчдэд шинэлэг санаа болж мөн тэдний бүтээлийг орон нутгийн ТВ-ээр олон нийтэд түгээж сурталчиллаа.

“КОФЕТОЙ УНШЛАГА”

Аймгийн иргэд, уншигч түмэндээ шинэ соргог яруу найргийн уран тансагийг мэдрүүлэх таниулахын тулд энэхүү кофетой уншлагыг аймгийн төгөлдөр төвийн кофе шофод зохион байгуулсан. Тус арга хэмжээнд МЗЭ-ийн гүйцэтгэх захирал яруу найрагч О.Энхжавхлан, Сэтгүүлч яруу найрагч Р.Эмүжин, Болор цомын эзэн Н.Гантулга мөн аймгийн ”Хурмаст тэнгэр” төвийн гишүүн яруу найрагчид уран

бүтээлээ толилуулсан. Кофе шофт ном 20 орчим хандивлав. Нийт 60 гаруй хүн хамрагдсан.

Үр дүн: Кофе шофт ихэвчлэн ажил хэрэгч хүмүүс сууж ном унших, ярилцах чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөдөг тул энд олны танил зохиолчидтой уулзалт хийж номын санг баяжуулсан нь энд цугларагсдад оюуны хөрөнгө оруулалт болсон гэж үзлээ.

“ИЛТГЭХ УРЛАГИЙГ СУРТАЛЧИЛАХУЙ”

“Ж.ЛХАГВА-80” насны ойд зориулсан соёлын ажлыг Хөвсгөл сумын соёлын төвтэй хамтран хийлээ. Энэ үеэр номын үзэсгэлэн гаргаж сурагчдын дунд танин мэдэхүйн тэмцээн явуулан урамшуулж, Хурмаст тэнгэр төвийн уран бүтээлчид, сумын яруу найрагчид хамтран сумын иргэдэд уран бүтээлийн уулзалт хийлээ. Энэ үеэр сумын сургуулийн сурагчид Ж.Лхагваагийн бүтээлийг цээжээр уншиж толилуулсан. Мөн Уран илтгэгч Алтангэрэл уригдан ирж Ж.Лхагваагийн бүтээлээс уншсан нь олны сонирхлыг татсан юм.

Үр дүн: Сумын соёлын төвийн хамтын ажиллагааг өрнүүлж алслагдсан иргэдэд ном соёлын үйлчилгээг хүргэсэн.

“УУЛЫН ЭГШИГ”

Ханбаян зүрх хайрхан уулын хормойд МЗЭ-ийн гүйцэтгэх захирал яруу найрагч О.Энхжавхлан, Сэтгүүлч яруу найрагч Р.Эмүжин, Болор цомын эзэн Н.Гантулга мөн аймгийн ”Хурмаст тэнгэр” төвийн гишүүн яруу найрагчид оролцсон уншлагыг зохион явууллаа. Нийт 100 гаруй хүн үзэж сонирхсон арга хэмжээг ЕБС-ын номын санчид, хамрын хийдийн лам тайлбарлагчид хамтран ажиллав.

Үр дүн: Нутгийнхан төдийгүй монгол түмний шүтээн болсон ууланд эгшиг өргөх нь уул усаа дээдэлдэг түмэнд таалагдсан соёлын нэгэн шинэлэг ажил болсон.

“АЯЛАГХАН ЗАЛУУ НАС”

МУСГЗ Арлааны Эрдэнэ-Очир агсны 50 насны ойд зориулан 16-25 насны залуусын дунд “Аялгахан залуу нас” нэртэй шүлэг болон шилдэг бүтээлийн уралдааныг улс орон даяар цахимаар зарлан явууллаа. Тус наадамд нийт 20 хүн цахимаар шүлэг ирүүлж мөн 5 номыг шуудангаар ирүүлсэн юм. Шүлгийн 1-р байрт Б.Мөнхзул, 2-р байрт Б.Батцоож, 3-р байрт О.Алтангэрэл нар тус бүр байр эзэлсэн. Харин шилдэг бүтээлд М.Дэвээжаргалын “Загасны сормуус” яруу найргийн түүвэр ном шалгарлаа.

Үр дүн: Яруу найргийн ертөнцөд шинэ залуу хүн олж илрүүлэн урам өгч олонд алдаршуулсан.

"БЯЦХАН ЕРӨӨЛЧ"

Номын баярыг угтан сургуулийн өмнөх боловсролын ахлах болон бэлтгэл бүлгийн хүүхэд багачуудын дунд "Бяцхан ерөөлч" уралдааныг зохион явууллаа. Нийт 13-н цэцэрлэгийн 45 хүүхэд оролцлоо.

Үр дүн: Соёлын биет бус өвд бүртгэгдсэн ерөөл хэлэх төрөл зүйлийг хүүхэд багачуудад түгээн дэлгэрүүлэх өвлөн уламжлуулахад хувь нэмэр орууллаа.

"ҮГ ҮСЭГЛЭЛИЙН ХААД"

"Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тохиолдуулан ЕБС-ийн 7-8 ангийн сурагчдын дунд "ҮГ ҮСЭГЛЭЛИЙН ХААД" тэмцээнийг Америкийн соёл мэдээллийн төвтэй хамтран /Монгол хэл, Англи хэл, Монгол бичиг/ зохион явууллаа.

Үр дүн: Хүүхэд багачуудыг үг үсэглэх эрдэмд суралцах хөгжих сонирхолыг нь өрнүүлэв.

"НОМТОЙ ХАМТ"

Ном унших ач холбогдлыг таниулсан зохиомж, агуулгатай фото зургаар оролцон Тэргүүн байр Т.Мөнхбаатар /ЕБ-ын 5 дугаар сургууль/, Дэд байр М.Номин /ЕБ-ын 5

дугаар сургууль/, Гутгаар байр Т.Ананд /ЕБ-ын 1 дүгээр сургууль/, Тусгай байр Б.Ананд /Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг, Э.Энхжин нар шалгарч Талархал, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Үр дүн: Ном эрдмээр бахархан өөрийгөө чимэх номыг дээдлэх мөн зохиомж сэтгэмжийг нь дээшлүүлэхэд ач холбогдол өгөв.

“ҮРСИЙН ЗҮРХНИЙ ҮГ”

Эх үрсийн баярыг тохиолдуулан захидлын уралдааныг 8 дахь жилдээ явуулж захидлаас 3 захидлыг шалгаруулж шагнаж урамшуулсан. Захидлыг нь эзэнд нь шуудангаар болон биечлэн хүргэн өгсөн. Захидлын уралдаанд 15 хүн оролцсон.

Үр дүн: Эрх нь хязгаарлагдсан иргэд ном уншиж мөн захидал бичих соёл суралцаж өөрийн эрхэмлэдэг хэн нэгэнд хэлж зүрхлээгүй үгээ хэлж уучлалт хүсэх боломж бүрдүүлдэг.

“СУДАРТАЙ АЯЛАЛ”

Аймгийн Ахмадын хороо, Номын сан, аймгийн МАН-ын Ахмадын хороо хамтран 5 дахь жилдээ зохион явууллаа. Арга хэмжээний үеэр сан хөмрөгт хадгалагдаж буй Үнэт ховор номыг нийтэд таниулан, түгээн дэлгэрүүлж номын үзэсгэлэн дэлгэн толилуулав. Ахмадууд Зава Дамдингийн “Сүмбэн”, Ганжуур, Данжуур судруудыг барин БНМАУ-ын баатар Д.Данзанваанчигийн хөшөө хүртэл гороолж алхав. Аймгийн Дэчинчойнхорлин хийдийн лам Ганхүү номын айлтгал өргөж, оролцогчид

маани хөгжөөж Ардын дуу, шагайн тэмцээн уралдаан зэрэг соёл олон нийтийн арга хэмжээг явууллаа.

Үр дүн: Ахмад үе залуус хүүхдэд ном эрхэмлэх зан үйлийг сурталчилах үлгэр дууриалал болдог.

“БАГШДАА БАЯРЛАЛАА” ЗАХИДЛЫН УРАЛДААН

Хүн бүхний сэтгэл зүрхэнд багшийн тухай гэгээн дурсамж, гэрэлтэй мөрүүд байдаг. Тэр гэгээлэг бүхнээсээ захидлаар дамжуулан багшдаа талархах, сэтгэлийн илгээмж хүргэх, тэдний нандин харилцааг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн болон Монголын багш нарын баярыг угтаж захидлын уралдааныг зохион явууллаа. Уг уралдааны Тэргүүн байранд ХҮИС -ийн нэгдүгээр дамжааны оюутан, Эргэлт.мн сайтын сэтгүүлч О.Алтангэрэл, Дэд байранд СУГ-ын ХШҮСХМэргэжилтэн А. Наранжаргал, Гутгаар байранд ЕБ-ын лаборатори 2 дугаар сургуулийн 12а ангийн сурагч Э. Ариунзаяа нар шалгарч Талархал, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Үр дүн: Цахим орчинд цөөн үгээр товчлон бичиж монгол хэлний баялаг уран тансаг хэллэг цөөдсөн энэ үед үг болоод утгын баялгийг нэмэгдүүлэх зорилготой.

“ЗОХИОЛЧДЫН ГАР БИЧМЭЛ” НОМ

Зохиолчдын гар бичмэл бүтээлээр фондыг баяжуулах, тэдний зохиол бүтээлийг соёлын баримтат өв болгон хадгалж хамгаалах зорилгоор Дорноговь аймгийн 10 зохиолчийн гар бичмэл зохиол бүтээлээр фондоо баяжуулав.

Үр дүн: Олон арван жилийн дараа дахин олдохгүй үнэт ховор ном болно.

“МУСГЗ А.ЭРДЭНЭ-ОЧИРЫН 50 НАСНЫ ОЙ”

МУСГЗүтгэлтэн А.Эрдэнэ-Очирын 50 насны ойд зориулан зохиолчийн намтар, уран бүтээлээс танилцуулга бэлтгэн хүргэсэн. Мөн А.Эрдэнэ-Очирын ээж ах дүү, төрөл төрөгсөд, Арлааны Эрдэнэ-Очир сангаас түүний 50 насны ойг тохиолдуулан 2 сая гаруй төгрөгийн үнэ бүхий шинэ номыг манай номын санд хандивлалаа.

Үр дүн: Зохиолчийн зохиол бүтээлийг сурталчилах,түгээн дэлгэрүүлэх, номын фондын баяжилт нэмэгдсэн.

“НОМЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”

МУСГЗ зохиолч Г.Мэнд-Ооёогийн “ Гэгээнтэн” роман номоор хэлэлцүүлэг боллоо.

Үр дүн: Иргэдийн ном унших сонирхолыг өрнүүлэх, уншсан номоос төрсөн сэтгэгдлээ бусадтай хуваалцах

“НОМЫН ХАВЧУУРГА”

Үндэсний бичиг соёл, номын өдрийг тохиолдуулан Номын хавчуурга хийх бүтээлийн уралдааныг зарлан явууллаа. Уг уралдаанд 200 гаруй бүтээл ирүүлснээс Тэргүүн байр Политехникийн коллеж Э.Сармандах, Дэд байр ЕБ-ын 3 дугаар сургуулийн 12б ангийн сурагч Б.Баярбаясгалан, Гутгаар байр ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 11а ангийн сурагч М.Өсөхжаргал нар шалгарлаа.

Үр дүн: Ном унших соёлд суралцах, нэг номыг олон уншигчдын хүртээл болно.

“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН”

ЕБ-ын 12 жилийн 2-р сургуулийн 6б ангийн сурагч Б. Нинжин, 5-р сургуулийн 8в ангийн Ч.Энхриймаа, 5-р сургуулийн 10б ангийн сурагч Э.Дөлгөөнтамир, 3-12 жилийн 5б ангийн сурагч М.Мөнхин, Хатанбулаг сумын ЕБ-ын 5б ангийн сурагч Б.Намсрай, Тэргүүний анги хамт олон ЕБ-ын 12 жилийн 1-р сургуулийн Г.Амарбаясгалан багштай 4в анги, Тэргүүний уншигч хамт олон ЕБ-ын 12 жилийн 3-р сургуулийн байрны хүүхдүүд тус тус шалгарсан.

Үр дүн: Бүх нийтээр ном унших дадал хэвшилд суралцсан.

“НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ”

Уралдаанд Тэргүүн байр ЕБ-ын 12 жилийн 2-р сургуулийн 3в ангийн сурагч С.Мөнх-Ухаан, Дэд байр 5-р 12 жилийн 9б ангийн сурагч Э.Хулан, Дэлгэрэх сумын ЕБ-ын сурагч Ц.Цэрэн-Өлзий, Гутгаар байр Хатанбулаг сумын ЕБ-ын 2б ангийн сурагч Б.Гонгор, Гутгаар байр Дэлгэрэх сумын ЕБ-ын 8а ангийн сурагч О.Тэмүүжин, Тусгай байр ЕБ-ын 12 жилийн 1-р сургуулийн 12в анги Ц.Энхжин нар тус тус байр эзэллээ.

Үр дүн: Номоос төрсөн сэтгэгдэл, дадал хэвшилд суралцах

“ҮЛГЭР АМИЛАХ ДҮРИЙН ТОГЛОЛТ”

Дүрийн тоглолтонд нийт 10 баг оролцож Тэргүүн байр А.Энхээ эрхлэгчтэй 13-р цэцэрлэг, Дэд байр Д.Шинэжаргал эрхлэгчтэй 9-р цэцэрлэг, Гутгаар байр Б. Бямбацэцэг эрхлэгчтэй 12-р цэцэрлэг тус тус шалгарав.

Үр дүн: Бүтээлчээр сэтгэх, үг, төсөөллийг хөгжүүлэх ач тустай.

“МУСГЗ ЯРУУ НАЙРАГЧ А.ЭРДЭНЭ-ОЧИРЫН ШҮЛГИЙГ ХЭН САЙН УНШИХ ВЭ”

Яруу найрагч А.Эрдэнэ-Очирын 11 шүлгийг цээжээр уншдаг сурагчтай боллоо. “Номын баяр- 2022” арга хэмжээний хүрээнд "МУСГЗ, ЯРУУ НАЙРАГЧ А. ЭРДЭНЭ-

ОЧИР"-ын шүлгийг хэн сайн мэдэх вэ? уралдааныг зохион байгууллаа. ЕБС-ын ахлах ангийн нийт 10 гаруй хүүхэд оролцож зохиолчын уран бүтээлийг уншсан юм. 1 дүгээр сургуулийн 12а ангийн сурагч А. Уранзаяа 11 шүлэг цээжээр уншин тэргүүлж, 1 дүгээр сургуулийн 12а ангийн сурагч С.Эрдэнэтунгалаг удаалан, 3-р сургуулийн 12а ангийн сурагч А.Цогзолмаа дараах байранд шалгарлаа.

Үр дүн: Зохиолчийн зохиол бүтээлийг таниулах, шүлэг яруу найраг сонирхогчдыг нэмэгдүүлэх

“НОМЫН ДУГУЙЛАН”

Хүүхдийн зохиолч Л.Мөнхбат “Хүүхдийг хэрхэн номонд дуртай болгох”, “Ном яаж сонгож унших” тухай Ном уншлагын дугуйлан” хичээллэсэн.

Үр дүн: Ном сонирхон уншигч, эхлэн бичигчдэд насны онцлогт тохирсон зөвлөгөө, зохиолч өөрийн туршлагаас хуваалцаж танин мэдүүлэх ач холбогдолтой.

“НОМЫН САНТАЙ БАЙГУУЛЛАГА”

Байгууллага дээрээ номын сангийн орчныг бүрдүүлэн ном унших соёл, дадал хэвшлийг хэрэгжүүлж байгаа Шилдэг номын сантай байгууллага"-аар Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг, ХААН банк, Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэг шалгарсан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НОМЫН САНГИЙН ДЭРГЭДЭХ АМЕРИКИЙН СОЁЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Америкийн Соёл Мэдээллийн төв нь бүх нийтийн Англи хэлийг сайжруулах зорилготой хөтөлбөрүүд, Англи ном уран зохиол, сэтгүүл болон өндөр хурдны интернэт, компьютераар хангагдсан. Иргэдэд нээлттэй үнэ төлбөргүй үйл ажиллагааг явуулж байна. 2022 оны 1-2 саруудад Америкийн элчин сайдын хөрөнгө оруулалтаар барилгын засвар, тохижилтын ажлыг хийсэн бөгөөд 2022 оны 3-р сараас эхлэн мэргэжлийн Англи хэлний багш ажиллаж эхэлсэн. Тус төвд Англи хэл хөгжүүлэх хөтөлбөрөөс гадна Америк соёлыг түгээх үйл ажиллагааг тогтмол амжилттай явуулж байна.

- **Англи хэлний хөтөлбөр:**
    - **ABC English** - Анхан шатны англи хэлний сургалтыг тогтмол 7 хоногт 2 удаа явуулж байна. Сурагчдын тоо улам нэмэгдэж идэвхтэй оролцож байна.
    - **Тоглоомын өдөр** – Үдээс хойш хичээлтэй сурагчдад зориулж хичээлийн бус цагаар сурагчад англи хэлийг хөгжилтэй сурах боломжийг олгож тоглоомын цагийг 7 хоног бүр явуулж байна. Карт тоглоом болон Би хэн бэ тоглоомуудыг Англи хэлээр тоглож байна.
    - **Ярианы клуб** - Англи хэлний ярианы клубээр англи хэлээ сайжруулах сурагчид хамрагддаг. Бэлтгэсэн асуултанд хариулж ярилцах болон өөрсдийн бэлтгэсэн сэдвийн дагуу ярилцдаг.
    - **Дууны клуб** - Англи хэлийг дуугаар дамжуулж үгийн дуудлага сайжруулах зорилготой дууны клубыг явуулж байна. Сурагчид Англи хэлний сонсголоо болон хэллэгээ сайжруулахын тулд Англи дууг суралцаж гитар тоглох сонирхолтой сурагчдад гитартай дуулах боломжийг олгож байна
    - **Төслийн клуб –** Сурагчдын өөрсдийн сонирхолд тулгуурлан сар бүр хамтран бүтээлч үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь 10-р сард Төслийн клубын сурагчид гарын доорх материал ашиглан баярын чимэглэл хийсэн.
    - **Үгсийн сангийн клуб** - Дунд болон ахлах ангийн сурагчид тайлбар толь бичиг ашиглан үгсийн сангаа нэмэгдүүлэхийн тулд тоглоомын аргаар үгсийн сангаа баяжуулдаг. Англи хэлний мэдлэгтэй сурагчдад

Олон улсын англи хэлний шалгалтанд ирдэг үгс дээр ажиллаж үгийн нөхцөл, дагаварын даалгавар гүйцэтгэдэг.

- **“Хэлэлцүүлгийн клуб” –** АНУ-н засгийн газрын тэтгэлэгтэй FLEX ахлах ангийн сурагчдын хөтөлбөрийн 2021 оны төгсөгч Пүрэвдарь болон түүний Америк ээжтэй хамтран 7 хоног бүр хэлэлцүүлгийн клубыг өнгөрсөн 3 сараас хойш амжилттай явуулж байна.
- **Кино клуб -** Англи хэлээ кино үзэж сайжруулах зорилготой киноны клубыг явуулж байна. Бэлтгэсэн асуултын дагуу хэлэлцүүлэг хийх болон өөрсдийн сэтгэгдлээ англи хэлээр хуваалцдаг.

Америк соёл мэдээлийг түгээх зорилготой зохион байгуулсан үйл ажиллагаа

ОУ-н багш нарын баярыг тохиолдуулан аймгийн хэмжээнд “Багш бадрахуй” хөтөлбөрийг 10 сарын 1ны өдөр аймгийн Боловсролын газартай хамтран амжилттай явуулсан. Манай төвд аймаг сумдын 24 Англи хэлний багш нарын хөтөлбөр амжилттай явагдсан. АНУ-н санхүүжилттай багш нарын болон ахлах ангийн сурагчдын мэргэжил дээшлүүлэх тэтгэлэгт хөтөлбөр болон Америкийн Соёл мэдээллийн төвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

Сайншанд сумын ЕБ-н сургуулиудад зочилж 2021 оны FLEX хөтөлбөрийн төгсөгч 5-р сургуулийн сурагч Г.Пүрэвдарь болон аймгийн Боловсролын газартай хамтран мэдээлэл өгсөн. Америкийн Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагаа болоон АНУ-н санхүүжилттай ахлах ангийн сурагчдын FLEX тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хүсэлт гаргах болон манай төв сурагчдын эссэ бичлэгт зөвөлгөө өгөх боломжтой талаарх мэдээллийг тогтмол өгч байна.

НОМЫН ХАНДИВ

Дорноговь аймгийн иргэн Ганхуягийн гэр бүл манай төвд Англи хэл дээрх номуудыг хандивласан. Түүний АНУ-д амьдардаг охид болон зээ хүү Ананд үеийн найзууддаа өөрийн уншсан олон сонирхолтой номыг бидэнд илгээсэн.

Английн Лийдсийн Их Сургуулийн магистр, доктор, Удирдлагын академийн багш, дэд профессор Ж.Нарантуяа болон түүний охин Канадын Британиш Колумбын Их Сургуулийн магистр Б.Цэрэнбалжир нар Америкийн Соёл Мэдээллийн төвийн үйл ажиллагааг дэмжин, өөрсдийн зохиож, орчуулсан англи хэлийг шамдан суралцагсдад нэн шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлагыг хандивласан.

Сурагчдын англи хэлээр өөрсдийн мэдлэгээ хуваалцах боломжийг олгох, нийт сурагчдад гадаад хэлний чадвар болон ерөнхий мэдлэгийг ахиулах зорилготойгоор Аймгийн төв номын сангийн харъяа Америкийн Соёл Мэдээллийн төвөөс Англи хэл дээр мэтгэлцээнийг амжилттай зохион байгууллаа.

Үг үсэглэлийн тэмцээнийг аймгийн төв номын сантай хамтхан Англи хэл, Монгол хэл болон Монгол бичиг ашиглан зохион байгууллаа. Уралдаанд аймгийн төвийн 4 сургуулиас 8 багийн 48 сурагчид амжилттай оролцлоо. Уралдааныг 3 үе шаттайгаар явуулсан.

1. Үг үсэглэл
2. Өгөгдсөн үсгээр үг бүтээх
3. Өгөгдсөн үгсийг ашиглан утга төгөлдөр, хамгийн урт өгүүлбэрийг бичих

Тэргүүн байр – ЕБ-н 5-р сургууль “Star” баг
Дэд байр – ЕБ-н 1-р сургууль “Victoria Sharks” баг
Гутгаар байр – ЕБ-н 2-р сургууль “AFRODITA” баг

 АНУ-н элчин сайдын яамны зочид Америкийн Соёл мэдээллийн төвөөр тогтмол зочилж иргэдэд хэрэгцээ шаардлагатай мэдээлэл болон Америк соёл талаар мэдээлэл өгдөг. дэд сайд хадагтай Меласса зочиллоо. 10 сарын 27 ны өдөр сургуулийн сурагчдад гурван удаагийн уулзалтыг зохион байгуулаа. Оюутны визний төрөл хэрхэн виз мэдүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч сурагчдын хүссэн асуултанд хариулж ярилцлаа. Нийт 136 оюутан сурагчид хамрагдсан.

Америкийн Соёл Мэдээллийн төвөөс Англи хэл дээр мэтгэлцээнийг амжилттай зохион байгуууллаа. Тэргүүн байр 2-р сургууль Өнөмөнх, Сүх-Очир, Дэд байр 1-р сургууль Тодгэрэл, Саруулгэрэл, Гутгаар байр 3-р сургууль Азжаргал, Одбаяр нар шалгарсан. Сайншанд ЕБ-ын сурагчид болон Замын Үүд сургуулийн сурагчдаас ирж оролцсон.

ҮР ДҮН: Америкийн соёл мэдээллийн төвийн үйл ажиллагааг явуулснаар англи хэлийг сурах хүүхэд багачууд, иргэдийн тоо нэмэгдэж, гадаад орны соёлоос суралцах болон олон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах сонирхол, үр дүн харагдаж байна.

БУСАД АЖИЛ

- Мөн байгууллагын ДОРНОГОВЬ ТӨВ НОМЫН САН фэйсбүүк группэд зохиолчдын 4 мөрт шүлгийг монгол бичгээр байршуулан иргэд олон нийтэд нээлттэй сурталчилан таниулах ажлыг тогтмол зохион байгуулан ажилладаг.
- “Соёлын бүтээлч сар"-ын үйл ажиллагаанд үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэн ажиллах хүрээнд "Үндэсний бичиг"-ийн анхан шатны сургалтад насан туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын 13 албан хаагч хамрагдан суралцсан.

- Номын баярын үеэр монгол бичгийн багш нарын дунд “Монгол бичгийн уран бичвэр” уралдааныг зохион байгуулан 10 бүтээл оролцсоноос эхний 3 байрыг шалгаруулан урамшуулсан
- Хүүхэд багачуудад унших сонирхлыг төрүүлэх зорилгоор Тэр бумтан хүү, Том эгч, Инээмсэглэл Гайхамшиг, Мэлхий,Санхүүч-3 ширхэг. Би бодохдоо, Атаархсан, Би Хэрвээ чи, санхүүч, Шавьж, Хүний бие, Эрдэс чулуулаг, Эртний ром, Автомашин, Шинэ бүтээл-5, Most-6ширхэг, Гайхамшигт-7 цуврал Үлэг гүрвэл, Би бодохдоо-2,

Үүлэн серверийн зардалд 2,740,000 төгрөгийг орон нутгийн төсвөөр шийдвэрлэж шинээр 569 ширхэг номыг данслан техник ажиллагааг хийн программд оруулж баркоджуулсан.

өөр нүд, Хүндэтгэх шалтгаанууд зэрэг 72 шинэ номыг цахимаар оруулж хүргэн танилцуулсан., Энх-Оюун сургалтын төвтэй хамтран зохион явуулах *English competition* уралдаан, Олон улсын эх хэлний өдөрт зориулан номын үзэсгэлэн ,"Монголын эмэгтэй зохиолчид" номоор үзэсгэлэн, "Үндэсний бичиг соёлын өв" "Хаан цадиг" " Хатан цадиг" "Жанжин цадиг" зэрэг номуудаар уншигчдад цахим мэдээлэл өгч 26 удаа 3585 номыг 1800 хүнд дэлгэн толилуулсан.

- Аймгийн номын сан нь “Цахим соёл” арга хэмжээнд нэгдэж “Цахимаар уншицгаая” аян өрнүүлж ДОРНОГОВЬ ТӨВ НОМЫН САН фэйсбүүк групп нээснээр тогтмол хүүхэд багачууд болон ард иргэдэд Онч мэргэн сургаал үгс, монгол ардын үлгэр, танин мэдэхүй, цар тахалтай холбоотой болон бусад эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж, үндэсний хэл бичиг соёлыг таниулах, шинэ номын мэдээ мэдээлэл, хүүхдийн зохиол болон домог хууч яриа зэргийг оруулан мөн англи хэлний мэдлэгт зориулан зурган постор, ан амьтдын үр төлийг ялган таних зэрэг мэдээ мэдээллийг оруулсан.Мөн 7800 гаруй хүүхдүүдимйн бүтээлтийг нийтэд таниулсан сурталчиллаа. Мөн Америкийн соёл мэдээллийн төвөөс үйл ажиллагааныхаа талаарх мэдээ мэдээллийг сайт болон олон нийтийн фэйсбүүкийг ашиглан сурталчилан таниулах ажлыг зохион байгуулан ажилласан. Нийт 12 төрлийн 120 мэдээ мэдээлэл бэлтгэн оруулж 26700 иргэнд танилцуулсан байна.

- Соёл олон нийтийн ажлыг шинэлэг олон талт хэлбэрээр зохион байгуулан ажилласан. Соёлын яамнаас 10 сая төгрөг баталсантай холбогдуулан хийсэн ажил болон байгууллагын ажилчдын төлөвлөгөөнд тусгагдсан СОНА-ууд болон уламжлалт ажлуудаа зохион байгуулан ажиллаж нийт 38 төрлийн ажилд 1929 хүн хамрагдсан.
- Сэлбэн засах шаардлагатай 233 номыг наан сэлбэж, 1945-1998 оны хоорондох ялалт сонинг сэлбэн засаж сайжруулсан.

- Цахим каталогоос уншигчдад хэрэгцээт ном хэвлэлийг түргэн шуурхай эрэн хайх, цахим лавлагаа мэдээллийг өгөх зэрэг ажлыг өдөр тутамдаа нэвтрүүлэн ажиллаж 1552ш ном хайсан байна. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа бүртгэлгүй байсан Зава Дамдин 17 ширхэг судрыг нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэн бар коджуулсан.
- Үүлэн серверийн зардалд 2,740,000 төгрөгийг орон нутгийн төсвөөр шийдвэрлэж шинээр 569 ширхэг номыг данслан техник ажиллагааг хийн программд оруулж бар коджуулсан.

- МЗЭ-ийн Хурмаст тэнгэр төвийн гишүүн Г.Баярчимэгийн “Зүүдний цэнхэр Хорго” номын нээлтийн арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэнд 15ш номыг зөөврөөр хүргэж өгч үйлчилсэн.
- Мэдээллийн төв байх зорилтод хүрээнд тогтмол хэвлэлийг захиалан заалаар уншигчдад түгээж ерөнхий боловсролын сурагчдад эссэ хэрхэн бичих талаар лекц сонсгож “Хөнгөн хэмнэл” төрийн бус байгууллагынхантай цагийг хэрхэн зөв өнгөрөөх талаар хэлэлцүүлэг хийж мөн Гэгээнтэн романы уншигчдыг цуглуулан ярилцлага зохиож АНУ-н соёл мэдээллийн төвөөр дамжуулан хэл хэрхэн сурах тэтгэлэгт хөтөлбөрт яаж хамрагдах талаар мэдээлэл тогмтол хийж найман төрлийн хөтөлбөрт иргэд сурагчдыг хамруулан сургаж байна.
- Дорноговь аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/95 дугаар захирамжаар "Хүүхэд хөгжил-2022" зорилтот жил болгон зарласантай холбогдуулан байгууллагын хүрээнд улирал бүр төлөвлөгөө боловсруулан батлуулан ажилласан. Бага ангийн сурагчид, цэцэрлэгийн хүүхэд багачууд, эцэг эхчүүд бага насны хүүхэдтэйгээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж хамтдаа ном уншиж ярилцах мөн эко орчинд монголын уламжлалт тоглоом наадгайгаар тоглох зэрэг тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор нэг өрөөг тусгайлан тохижуулж “АЗ ЖАРГАЛЫН ӨРГӨӨ"-г байгуулан ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар тус өргөөгөөр албан байгууллага гэр бүл болон 13-н цэцэрлэгийн 395 хүүхэд, багш эцэг, эхчүүдэд үйлчилсэн байна.

АРГА ЗҮЙН АЖИЛ:

- Мөн Англи хэлний багш нарын цахим групп ашиглан сумдын багш нарт онлайнаар алсын зайнаас сургалт мэдээллээр ханган зөвөлгөө зөвлөмжийг тухайн бүрт өгч ажиллаж байна. Нийтдээ давтагдсан тоогоор 224 хөтөлбөрт 3132 иргэн хамрагдсан. Нийт ирцийн тоо 4173 Өнгөрсөн жилийнхээс 50 хувиар өссөн байна.
- Насанд хүрэгчдийн хувьд төслийн клубт 162 иргэн, Уулзалт сургалтад 51 албан хаагч тус бүр оролцсон байна. Мөн албан байгууллагын сургалт 21 удаа зохиож 201 албан хаагч, англи хэлний багш нарын сургалтад аймгийн төвийн ерөнхий боловсролын дөрвөн сургуулийн давхардсан тоогоор 58 багш сургаж англи хэлний мэдлэг олгосон.
- Аймгийн номын сангийн дэргэдэх АНУ-н соёл мэдээллийн төвөөс англи хэлтэй Дорноговь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн 2022 оны 3-р сараас эхлэн мэргэжлийн англи хэлний багш ажиллаж байна. Тус төвд англи хэл хөгжүүлэх хөтөлбөрөөс гадна Америкийн соёлыг түгээх үйл ажиллагааг тогтмол амжилттай явуулж байна. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор тогтмол явагдаж буй ABC English, Тоглоомын өдөр, Ярианы клуб, Дууны клуб, Үгсийн сангийн клуб, Хэлэлцүүлгийн клуб, Кино клуб зэрэг 176 хөтөлбөрт оролцсон иргэдийн тоо 2743, нийт ирэгсэдийн тоо 3346 иргэн англи хэлний мэдлэг ахиулах сургалтад хамрагдсан байна.
- Номын санчдыг чадавхжуулах сургалтыг тогтмол явуулж байна. “Mongolian library update-2022” номын санч-мэдээллийн ажилтнуудын IX зөвлөгөөн цахим сургалтад төв болон сумдын бүх номын санчид хамрагдсан. Мөн Монголын үндэсний номын сангаас зохион байгуулсан "Цахим сан хөмрөгийн бүрдүүлэлт", “Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт”, Төрийн албаны зөвлөлөөс явуулсан “Зан үйлд нөлөөлөх ухааныг төрийн бодлогод ашиглах нь” Монгол Улсын

Үндэсний номын сан, Монголын номын сангийн консерцум болон EBSCO хамтран нийтийн номын сангуудад зориулсан "Цахим ном, сэтгүүлийн ойлголтууд болон хүртээмжийг нэмэгдүүлэх: Өнөөдрийн сорилтууд ба маргаашийн боломжууд" сэдэвт сургалт, Мөн Соёлын сургуулиас зохион байгуулж буй “Номын сангийн цахим шилжилт” онлайн сургалтад номын санч цахимаар хамрагдсан.

- MNS 5271:2012 Номзүйн бичилт. Ерөнхий шаардлага стандартыг хэрэгжүүлэх, MNS ISO 4:2003 Мэдээлэл ба баримт бичиг. Гарчиг үг ба ном хэвлэлийн гарчгийн товчлол стандартыг хэрэгжүүлэх, MNS ISO 11799:2007 Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандартыг хэрэгжүүлэх зэрэг стандартын хэрэгжилтийг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.
- Сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гаригт “Ном сэлбэн засах өдөр” болгон зарласантай холбогдуулан урагдаж гэмтсэн номуудад стандартын дагуу сэлбэн засалт хийж ажиллаж байна.
- 2022 онд Аймгийн номын сан сумдын соёлын төвийн номын сангуудтай танилцах тэдэнд арга зүйн зөвөлгөөг өгөх зорилгоор Замын-үүд, Иххэт, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Зүүнбаян гэх мэт 10 сумдын номын санчидтай хамтран ажилласан.
- Сумдын номын сангуудад арга зүйн зөвөлгөөг тогтмол өгч нийтдээ давхардсан тоогоор 62 удаа өгч үйлчилсэн.
- Сумдын соёлын төвийн номын санчдад “Номын сангийн анхан шатны бүртгэл” сэдвээр цахимаар сургалт зохион байгуулж сум, сургуулийн нийт 26 хүн хамрагдсан.
- Мөн сар бүрийн эхний долоо хоног сүүлийн долоо хонгийн 5 дах өдөр цахимаар холбогдон харилцан туршлага солилцон ажиллаж байна.
- Аймгийн номын санд шинээр номын санч-мэдээллийн ажилтан ажилд авсантай холбогдуулсан СУИС-ийн Соёлын Сургуулиас зохион байгуулсан “Номын сан-цахим шилжилт” вебинар сургалтад хамрагдан гэрчилгээ олгосон.
- "Хил хязгааргүй номын сан" төсөл хөтөлбөрийн сургалтад аймаг, сум, сургуулийн нийт 25 номын санч оролцсон. Энэхүү сургалтыг Австралийн элчин сайдын яам, МҮНС, Монголын номын сангуудын холбоо хамтран хэрэгжүүлж орон нутгийн номын санчидтай санал солилцож иргэн төвтэй номын сан байгуулах, шинэлэг санаа ололт амжилтыг олгосон маш үр өгөөжтэй сургалт болсон. Номын санч мэргэжилтнүүдэд орчин үеийн нийтийн номын сангийн шилдэг туршлагаас хуваалцаж, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах боломж буйг мэдрүүлж таниулсан сургалт болсон. Мөн хүүхдийн номын фондонд шинэ номын хандив өргөсөн.

ДОРНОД АЙМГИЙН Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.05 Чойбалсан хот

НЭГ: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, албан тушаалын тодорхойлолт, албан хаагчдын анкетыг шинэчилсэн.
- 2023 онд ажлын байранд нь сэлгэн ажиллуулах бодлого барьж байна.

Цаашид:

- Байгууллагадаа брэндбүүктэй болох. Шаардлагатай бол Лого шинэчлэх /уур амьсгал оруулахын тулд/
- Цахим номын санг тогтвортой ажиллуулах

ХОЁР: СОЁЛЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

- Нийт орон тоо 2022 онд 18 ажилтантай, сан тенхикч, цахилгаанчин гэрээтээр ажиллуулах зайлшгүй шаардлагатай.
- МҮИС, МУБИС, Хүүхдийн ордон, Чингэлтэй дүүргийн номын сангуудаар туршлага судлан 8 албан хаагчийг мэдлэг боловсролоо дээшлүүлэх сургалтад хамруулсан. Мөн 3 албан хаагчийг ая тухтай амьдрах нөхцлөөр хангахад зориулж түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн.

ГУРАВ: СОЁЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР

Дараахь хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллгаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

- Хөдөлмөрийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- ХАБЭА тухай хууль
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль

Хөдөлмөрийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулиудаар албан хаагчдад сургалт зохион байгуулсан. ХАБЭА сургалтанд 1 ажилтныг хамруулсан.

ДӨРӨВ: СОЁЛЫН САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. СОЁЛ ГЭГЭЭРЛИЙН ТАЛААР:

Д/д	2021	2022	хувь
Шинэ уншигч	3000	5588	53%
Байнгын уншигч	24500	72675	33.7%
Ном олголт	32000	113249	29.6%
Гэр бүлийн богц	80	95	29.6%

- Зөөврийн үйлчилгээг: нийгмийн цогц үйлчилгээ, ЕБС болон албан байгууллагад нийт-24 удаа 3044 хүнд 2797 ном олгож үйлчилсэн.
- Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, номтой нөхөрлүүлэх, ном унших сэдэл тэмүүллийг бий болгох, номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “***Ном хожъё***” оюун ухааны тэмцээнийг 28 удаа зохион байгуулж, байгууллага аж ахуй нэгж, ЕБС-ийн нийт 216 албан хаагч оролцсон.

- Сэдэвчилсэн болон тэгш ой тохиож буй зохиолчийн үзэсгэлэн 71 удаа гаргаж 1455 номоор 5543 хүнд үйлчилсэн. Энэ нь өмнөх оныхоос 40.8%-иар өссөн.

Үндэсний бичиг үсгийн баяр:

- "Эх хэлээ дээдэлье" цэцэг өргөх арга хэмжээ 5 дугаар сард ЕБС-ийн 1 дүгээр ангийн төлөөлөл, 9 дүгээр сард 6 дугаар ангийн төлөөлөл оролцож Ц.Дамдинсүрэнгийн "Миний нутаг" шүлгийг уншиж хөшөөнд цэцэг өргөлөө. Нийт -1700 гаруй сурагчид хамрагдсан.

Номын баяр:

- Олон улсын хүүхдийн номын өдөрт зориулж, "Сэтгэхүйн хурд" тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээн 3 үе шаттай явагдаж 15 сурагч 5 баг амжилттай оролцсон.
- "Илүү их уншъя" уриан дор зохион байгуулагдсан номын баярын арга хэмжээнд Дорнод нутгийн зохиолчид, хүүхдийн зохиолчдын номын үзэсгэлэн, Д.Нацагдорж тэмдэгтэн, Тэргүүний анги хамт олон, Шилдэг гэр бүл, шилдэг хүүхэд шалгаруулж "Аглагхан талаасаа" уран бүтээлийн дурсамжит цэнгүүнийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 1500 гаруй хүн оролцлоо.

Зохиолч уншигчдын уулзалт

- Р.Лүндэв "Учрахуйн тавилан", Алтантуяа "Гоё бүр гоё",Н.Бямбасүрэн "Хөхөмдөг алс" номын нээлт Философич Молор-эрдэнэ "Тэгш эрх-Тэгш боломж", Байх ба Биш" номоор, философийн ярилцлага, орон нутгийн зохиолч Н.Мөнхсайхан, Ц.Дугар нартай уншигчдын уулзалт хийсэн.

"Соёлын орон зай"

- Аймгийн хэмжээнд Соёлын байгууллагууд хамтран Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан номын үзэсгэлэн, номын худалдаа, "Цахим номын сан"-гийн үйлчилгээний танилцуулга зэрэг олон арга хэмжээ явууллаа. "Чөлөөт индэр" ажиллуулж-авьяаслаг хүүхэд, залуус иргэд шүлэг яруу найраг өөрсдийн зохиолоо *уншиж* сонирхуулсан.

4.2. УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН ТАЛААР
4.3. СОЁЛЫН ӨВИЙН ТАЛААР:

- Фондын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, судар номыг сэргээн засварлан дансжуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж одоогоор 850 судрын гарчиг нэр тодруулан, шифр өгч, тайлбар бичиж дансжуулан нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэээд байна.
- Аймгийн төв номын сангийн цахим хуудсанд С.Дулам "Цагаан сарын бэлгэдэл" номноос Цээрлэх ёс, Тавгийн идээ засах ёс, Битүүлэх ёс, Шинэлэх ёс зэргээр 4 контент бэлтгэн 1374 хүн үзсэн.
- 2-р цэцэрлэгийн 40 гэр бүлд "Монгол гэр барих" ёс заншлын мэдлэг олгох хөгжөөнт тэмцээн зохион байгуулж 400 хүүхдэд гэр барих дараалрыг танилцуулсан. Мөн тус номын сангийн хүүхдийн өргөө 7 хоног бүр хуваарь гарган үйлчилгээ үзүүлж байна.

ТАВ: САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

ЗУРГАА: САЛБАРЫН ЦАХИМ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

- Цахим номын сан байгуулах төсөл боловсруулж, Соёлын яамнаас зарлагдсан төсөл шалгаруулах уралдаанд амжилттай оролцсон.
- Цахим номын сангаа уншигчдад түгээхэд зориулж books.darnod-libraryu.mn вэбсайтаа байгуулсан. Цахим номын сангийн /цахим номын биш/ вэбсайт манай улсад ховор, бараг байхгүй тул гадаадын вэбсайтуудаас туршлага судалж бүтээгдсэн. Дээр хэлсэнчлэн бэлэн плагин, модуль байхгүй учир код бичих зэргээр цаг хугацаа ажиллагаа их шаардаж байна.
- Вэбсайтын шинэчлэл, хэвийн үйл ажиллагааг байнга хянан ажиллаж байна.
- Гишүүнчлэлийн вэбсайт учир өдөр бүр нөөцлөх, нөөцийг татаж хадгалах, хуучин нөөцүүдийг устгах зэрэг ажлууд хийгддэг.
- Аудио ном бүтээхээр уншсан хоолойг засварлах ажил хийгдэж байна.
- Видео ном бүтээх аргачлал боловсруулж, номын санчдын бүтээсэн дүрс, текст, дууг холбож видео контент бэлтгэдэг. Dailymotion.com видео контентын вэбсайтад Номын сангийн суваг үүсгэж видео хэлбэрийн үзэх үлгэрүүдээ байршуулж байгаа.
- Уншдаг ном бүтээхэд зориулж ном татах, засварлах, хөрвүүлэх аргачлалуудыг бэлтгэн, номын санчидтай хамтран ажиллаж байна.
- Монгол бичгээр уншдаг цахим ном бүтээх аргачлал боловсруулсан.
- Сурталчилгаанд зориулсан контент, постер бэлтгэн байна.



ДОЛОО: САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гадна, дотно камержуулалтыг 15 сая төгрөгний өртгөөр "Нүргэлэнт" ХХК –р гүйцэтгүүлж 29 камер суулгасан.
- Байгууллагын гадна тохижилт гэрэлтүүлэгийг 9.9 сая төгрөгний өртгөөр ажлыг "Их ханас" ХХК-р гүйцэтгүүлсэн.
- Байгууллагын тохижилт үйлчилгээнд 12.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Одоогоор дээврийн болон сантехникийн их засварын ажлыг зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

НАЙМ: САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР

- Номын сангийн үйл ажиллагааны тайлан су мэдээг нэгтгэн гаргаж СУГазарт хугацаанд нь хүргэн ажиллаж байна.

ҮР ДҮН:

- Уншлага үйлчилгээ 2021 оноос
  Уншигч- 53%
  Байнгын уншигч -38.7%
  Ном олголт -29.6%
  Гэр бүлийн богц олголт -40.8% нийт уншлага -39%-иар өссөн.
- Үзэсгэлэнгийн тоо 2021 онд 29% өссөн.
- "Цахим номын сан"-гийн үйлчилгээг сошиал орчны группт шэйрлэх, лайв хийх, номын клубт нэвтрүүлсэн.

ДУНДГОВЬ АЙМГИЙН С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. Байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг хэрхэн шийдэж, дэмжин ажилласан байдал, мэргэжил боловсролыг дээшлүүлэлт, мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх зэрэг хийсэн ажлын үр дүн, ахиц дэвшил, санхүүжилт

Сүлжээний инженер, хүний нөөцийн ажилтан Ө.Ууганбаяр Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн “Төрийн байгууллагын харилцааны маркетинг” сэдэвт богино хугацааны танхим цахим хосолсон сургалтанд хамрагдаж “Үнэмлэх”-тэй боллоо.

Үйлчлэгч СИТИ их сургуулиас зохион байгуулсан Номын сангийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж “Мэргэжлийн үнэмлэх”-тэй боллоо.

Дундговь политехникийн коллежийн төгсөх ангийн оюутан О.Буяндэлгэрийг дадлагажуулан, сургалтын албаны удирдамжийн дагуу бэлтгэн, удирдаж, холбогдох бичиг баримтыг хүргүүллээ.

Монгол Улсын Үндэсний номын сангаас зохион байгуулсан "Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт" онлайн сургалт, Mongolian library update-2022, “Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт”, “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан” зэрэг сургалтуудад мэргэжилтнүүд Zoom программыг ашиглан хамрагдав.

Австралийн Элчин Сайдын Яамны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Үндэсний номын сангаас зохион байгуулсан "Орон нутгийн номын санчдыг чадавхжуулах" сургалтанд 12 алба хаагчдыг хамруулсан.

Дэлгэрхангай, Дэрэн сумын сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж 3 номын санчид мэргэжил арга зүйн зөвлөгөө, онол дадлага хосолсон сургалт явууллаа.

Хүүхэд хамгааллын болон хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын алба хаагчдыг нийгмийн баталгааг дэмжих зорилгоор “Байгууллагын дотоод журам”-д ажилтны хүүхдийн төрсөн өдрөөр ажилтанд 1 өдрийн цалинтай чөлөө олгох заалтыг тусгаж шинэчилсэн.

“Дундговь аймгийн Төрийн албан хаагчид” цахим пэйж хуудсаар зохион байгуулагдсан цахим 7*4*10 сургалтанд ажилчид 90% ирцтэй тогтмол хамрагдаж, цахим хэрэглээний чадварт давхар суралцлаа. Цалин хөлс, ур чадварын нэмэгдэл, түлш, хоолны хөнгөлөлтийг бүх алба хаагчид олгож, зарим алба хаагчдад эмчилгээний болон шинэ байранд орсны тусламж дэмжлэгийг үзүүлэн нийгмийн баталгааг хангаж ажиллаа:

Цалин хөлс, ур чадварын нэмэгдэл, түлш, хоолны хөнгөлөлтийг бүх алба хаагчид олгож, зарим алба хаагчдад эмчилгээний болон шинэ байранд орсны тусламж дэмжлэгийг үзүүлэн нийгмийн баталгааг хангаж ажиллаа.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж нийт 30.774.674 төгрөгийг зарцуулсан. Үүнд:

1. Ур чадварын нэмэгдэлд 15.168.080 төгрөг
2. Үр дүнгийн нэмэгдэлд 4.803.594 төгрөг
3. Унаа хоолны зардалд 8.685.000 төгрөг
4. Түлшний хөнгөлөлтөд ердийн галлагаатай сууцанд амьдардаг 3 албан хаагчид 750.000 төгрөг

5. Нэг алба хаагчид 200.000 төгрөгийн буцалтгүй тусламж, 50.600 төгрөгийн бензин
6. Эмчилгээний зардалд 2 албан хаагчид 468.000 төгрөг
7. Шинэ төрсөн хүүхдэд 100.000 төгрөгийн буцалтгүй тусламж
8. Байгууллагын шилдэг 2 алба хаагчид 600.000 төгрөг
9. Алба хаагчдад эмчилгээний зардалд 3.860.220 төгрөгийн зарцуулж Улаанбаатар хотын Грандмед эмнэлэгт нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.

Хүний нөөцийн бодлогыг аймгийн бодлогод нийцүүлэн боловсруулах шатанд явж байна. Мөн Хөдөлмөрийн дотоод журамд хүний нөөцийг чадавхжуулах, сайжруулах талаар нэлээд олон заалтуудыг нэмж орууллаа.

Байгууллагын хэмжээнд 6 арга хэмжээ бүхий тусгай төлөвлөгөө боловсруулан баталж, ЭДЦС-ийн Үндэсний бичгийн сургагч багш Ш.Мөнхзултай багш сургагч багшаар ажиллан бүх алба хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулж батламж гардуулав.

ХОЁР. Тухайн оны үйл ажиллагааны онцлог амжилт, соёлын бүтээлч

үйлдвэрлэл-менежмент, зарцуулсан санхүүжилт, үр дүн

Алдарт гавьяат уранзохиолч С.Буяннэмэхийн мэндэлсний 120 жилийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд хавар, намрын номын баярыг Их зохиолчийн нэрэмжит болгон зохион байгуулж, түүний амьдрал, уран бүтээлийг хүүхэд залуучууд, иргэдэд сурталчлах, алдаршуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Бидний мэдэх их зохиолч аян”-ыг зохион байгуулсан. Тус аянаар Танд ойрхон номын сангийн үйлчилгээ”-г 2 удаа, С.Буяннэмэхийн амьдрал, уран бүтээлийн үзэсгэлэнг 12 удаа, Шилдэг номын санч уралдаан, С.Буяннэмэх бүтээлийн уралдаан, “Тэргүүний хурдан уншигч” уралдаан, “Номын санчдын мэргэжил аргазүйн сургалт-2022”, “Миний уншсан ном Дүрслэх урлагт уралдаан” нийт 19 үйл ажиллагаа, уралдаан тэмцээнийг зохион байгуулж 512 хүнийг хамруулсан.Тус арга хэмжээний төсвийг үр дүнд суурилсан санхүүжилтээс гаргаж нийтдээ 2.645.000 төгрөгийг зарцуулсан байна.

НОМЫН САНЧДЫН МЭРГЭЖИЛ, АРГАЗҮЙН СУРГАЛТ-2022-оор алдарт, гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойн хүрээнд Дундговь аймгийн нийтийн номын санч, Ерөнхий боловсролын сургуулиудын 36 номын санч нарт “Мэргэжил, аргазүйн сургалт”-ыг Аймгийн Засаг Даргын Тамгын газрын “Говь” танхимд зохион байгууллаа.

“Номын санчдын мэргэжил, аргазүйн сургалт-2022”-ын хүрээнд:🔽

📖Соёл, Урлагын газрын мэдээлэл – СУГ-ын мэргэжилтэн С.Намжилмаа

📖Номын сангийн ажлын ерөнхий ойлголт, арга зүй - С.Буяннэмэхийн нэрэмжит Төв номын сангийн Захирал, сурган хүмүүжүүлэх ухааны Доктор А.Нансалмаа

📖Каталог зохион байгуулах аргазүй - Ном зүйч, сан хөмрөгч Э.Биндэръяа

📖Цахим номын сан, цахим сан хөмрөгийн ерөнхий ойлголт - МҮНС-ийн Мэдээлэл, Арга зүй, эрдэм шинжилгээний Хэлтсийн арга зүйч В.Түвшинтогтох

📖"Төгөлдөр Буяннэмэх" ТББ-ын танилцуулга, мэдээлэл, төлөвлөгөө - "Төгөлдөр Буяннэмэх" ТББ-ийн тэргүүн Л.Амаржаргал (цахимаар)

📖Боловсрол, Шинжлэх Ухааны Яамнаас сурах бичгийн талаар хэрэгжүүлж буй бодлого - БШУГазрын мэргэжилтэн Л.Мөнхзул

📖Монголын ЕБСургуулиудын номын сангийн холбооны танилцуулга - МЕБСНСХолбооны сургалтын албан хэрэг хөтлөлтийн хариуцагч Б. Долгоржав

📖Алдарт, гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойн хүрээнд зохион байгуулах ажлын танилцуулга, “Ашгийн бус төслийг амжилттай бичиж, хэрэгжүүлэх нь” –Арга зүйч, ном бүрдүүлэгч Б.Гэрэлсүрэн

📖Нийтийн болон сургуулийн номын сангуудын “Сайн туршлага”

📖Хэлэлцүүлэг, номын санчдад тулгамдаж буй асуудал, шийдэл, судалгаа, санал авах зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Аргазүйч Дэлгэрхангай суманд Охидын номын хэлэлцүүлэгийн клубыг байгуулж аргазүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.

Төгөлдөр Буяннэмэх сан ТББ-тай хамтран 5 контент, подкаст нэвтрүүлгийг хийж дүрсжүүлэн С.Буяннэмэх 120 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллгаануудад 9 удаа, МҮОНТ-ийн нэвтрүүлэг, FM, радиогаар 3, байгууллагын цахим хаягаар цацаж С.Буяннэмэхийн амьдрал уран бүтээлийг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.

“Үндэсний бичиг, соёл номын өдрүүд-2022” 31 дэх удаагийн хаврын номын баяр, С.Буяннэмэх 120 жилийн ойг тохиолдуулан намрын номын баярыг зохион байгуулж тус 2 удаагийн номын баяраар уншлагыг дэмжих, соён гэгээрүүлэх 32 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 1197 хүнийг хамруулж, цахимаар 4389 хүн үзсэн байна. Тус номын баяраар дараах онцлог үйл ажиллагааг зохион байгуулсан.

Үүнд: “Poetry night”-яруу найргийн үдэш “Уран үгсийн чуулган” Дундговь урлаг сан, аймгийн зохиолчдын эвлэл, ТХДЖТеатртай хамтран “Poetry night-Уран үгсийн чуулган”-ыг зохион байгуулсан. Чуулганд Дундговь аймгаас төрсөн алдарт уран зохиолч, яруу найрагчдын намтар, бүтээлийн дээжсийг ТХДЖТ-ын 10 жүжигчин, уран уншигч уншиж ард иргэдэд хүргэсэн. Яруу найргийн үдэшлэгт **70** зохиолч, яруу найрагчид оролцож яруу найрагт дуртай иргэд сонирхон үзэж, 2.225.000 төгрөгийг зарцуулсан байна.

- Зохиолчдын шинэ ном нээх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж С.Буяннэмэхийн 120 жилийн ой, Дундговь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулан бүтээсэн 5, бусад 2 нийт 7 удаагийн номын нээлтийг хийсэн байна.
- Номын хөөрөлдөөн уншигч, зохиолчдын уулзалт, өглөөлгийг зохион байгуулж, “Эртэч номтой хүүхдүүд номын клуб”-ын хүүхдүүд аймгийн өндөр настан номын сайн нөхөр, С.Чулуунбаттай өглөөний уулзалтыг зохион байгуулсан. Өглөөлөгт номын санч 10, хүүхдүүд 12, зочин 1 нийт 23 хүнийг хамруулсан.

Аймгийн ИТХ-тай хамтран “Ном хандивлах сайхан” хандивын эвент арга хэмжээг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Дундговь аймгийн уугуул иргэдийг ном хандивын аянд нэгдүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулж үүний үр дүнд 400 гаруй номын иргэдээс байгууллага, аж ахуй нэгжүүдээс цуглуулан Өлзийт сумын нийтийн номын санд “Сумаа номжуулъя” уриаг дэвшүүлэн хандиваар цугласан номнуудыг хүлээлгэн өгөхөөр болсон.

Сан хөмрөгт байгаа Төвд номын судалгааг хийж, Төвд номын нэг бүрчилсэн бүртгэлийг шинээр нээж, сан хөмрөгөөс 61 ширхэг номыг бүртгэсэн.

Орон нутгийн картын сан, төрөл ангийн каталогийг шинэчлэн зохион байгуулж, шоголын ялгагч, ангилалыг шинээр гаргаж,картын сангийн шүүгээг засварласан. НСМА-уудад сонингуудыг хуваарилан, картын санд 1347 карт, төрөл ангийн каталогт 300 карт, номзүйн мэдээллийг гарган шоголд стандартын дагуу техник ажиллагаа хийн байршуулсан. Өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэл, татгалзлын бүртгэлийг цахимаар буюу гүгл шийт үүсгэн, 8 номын санч-мэдээллийн ажилтнуудад хуваалцан, уншигч, хэрэглэгчдээс ирсэн татгалзал, лавлагааг бүртгэн авч ажиллаа. 4 удаа, нийт 260 номын татгалзал бүртгэсэн байна.

СУИС-ийн Театр урлагийн их сургуультай хамтран “С.Буяннэмэх-120” эрдэм шинжилгээнийй хурлыг зохион байгуулж 34 эрдэмтэн судлаач оролцож, 12 бүтээл хэлэлцүүлэгдсэн.

ГУРАВ. Зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээ, түүнд хамрагдагсдын тоо, үйл ажиллагааны орлого, зарцуулсан санхүүжилт, ахиц өөрчлөлт, үр дүн

Монгол Үндэсний ёс заншил, түүх соёлоос суралцах, соёлын биет бус өвийг өвлөн уламжлах, хойч үедээ түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Монгол бахархал-ёс заншил" уралдааныг СӨБ-ийн хүүхдүүдийн дунд "Монгол бахархал - Ёс заншил" цахим уралдааныг зохион байгуулж 17 бүтээл оролцуулж, 44 хүүхдийг хамруулллаа.

Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран төрийн албан хаагчдын дунд Дэвжээ, түүх нийгмийн ухааны багш нарын дунд Үндсэн хуулийн хэлэлцүүлэг, үндсэн хуулийн ховор номын үзэсгэлэнг зохион байгуулж, 89 төрийн албан хаагч, удирдлагуудыг хамруулллаа.

Монгол бахархлын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Мөнх тэнгэрийн бичиг” уран бичвэр сайхан бичигтэн уралдааныг зохион байгуулж, 42 хүний бүтээлийг хүлээн авч шилдгүүдийг шалгаруулсан. Уралдаанд 23 төрийн албан хаагч бүтээлээ ирүүлсэн байна.

Үйл ажиллагааны орлого 2.616.000 төгрөгийг төрийн сан банкинд тушааж, төвлөрүүлсэн.

Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III хэрэгжүүлэн “Хос бичгийн үзэсгэлэн” “Тэргүүний хурдан уншигч” уралдаан, байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан “Бид эх хэлээрээ бахархана” батламж гардуулах ёслол, Уран бичвэрийн клубын хүүхдүүдийн үзэсгэлэн, “Мөнхтэнгэрийн бичиг” уран бичвэрийн уралдаан зэрэг 5 томоохон үйл ажиллагаа зохион байгуулж, 23 төрийн албан хаагч, 405 сурагч, 93 иргэд нийт 521 хүнийг үйл ажиллагаандаа оролцуулсан. Үйл ажиллагааны бичлэгийг цахимаар сурталчлан 1500 гаруй цахим хандалтай байна. Байгууллагын ажиллагсдын 75 % дунд шатны монгол бичигтэн, 25% нь анхан шатны түвшинд суралцаж байна.Үндэсний хэл бичгээ түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн аянд нэгдэж, Монгол бичгийн хэрэглээгээ нэмэгдүүлж “ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН” хамт олон болох зорилт тавин ажиллаж байна.

ДӨРӨВ. Хөдөөгийн иргэдэд хүргэсэн явуулын үйлчилгээ, түүнд хамрагдагсдын тоо, олсон орлого, зарцуулсан санхүүжилт, ахиц өөрчлөлт, үр дүн

“Бидний мэдэх их зохиолч” аяны хүрээнд “Танд ойрхон номын сангийн үйлчилгээ”-г ЕБС-2, төрийн байгууллагуудад 5 удаа хүргэж, 512 хүнийг хамруулллаа. Соёлын үйл ажиллагаа нээсэн богино хугацаанд Мандал худалдааны түрээслэгч нарт 55 нэрийн шинэ номоор үзэсгэлэн гаргаж үйлчилснээр 35 шинэ уншигч бүртгэгдсэн.

Алслагдсан хөдөөгийн иргэд буюу Сайнцагаан сумын 2 багийн иргэдийн өдөрлөгөөр малчдад, Дэлгэрхангай, Дэрэн сумын нийт 629 иргэдэд 325 номоор 4 удаагийн Зөөврийн номын сангийн явуулын үйлчилгээг үзүүлж, алслагдсан иргэдэд ном унших, соёлын олон талт хэрэгцээг хангаж ажиллалаа.

Хүүхдийн уншлага”-ыг дэмжих зорилгоор Уншлагын танхимын “Ангийн номын санч клуб”, хүүхдийн уншлагын танхимын “Эртэч номтой хүүхдүүд” Дэлгэрхангай

сумын “Охидын номын хэлэлцүүлэг клуб”ыг байгуулж нийтдээ 45 сурагчид номын клубын гишүүнээр ажиллан чиглүүлэгч багшаар аргазүйч, танхимын 2 номын санч нар ажиллаж байна. Номын клубээр дамжуулан хүүхдүүдэд ном унших эрэг дадлыг бий болгох, номын сангийн үйл ажиллагааг сургууль дээр сурталчлах, анги хамт олныг үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Матилда шидэт ном бүтээх” хэлэлцүүлэг, “Алтан хонх” танин мэдэхүйн уралдаан, “Танд ойрхон номын сан өдөрлөг”-2, “Монгол бахархлын өдөр”, “Бидний мэдэх их зохиолч аян”, ном солилцоо зэрэг 7 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаа, сургалт, хэлэлцүүлэг, ном унших өдөрлөгийг зохион байгуулсан.

“Дуудлагын номын сангийн үйлчилгээний цахим, цаасан танилцуулгыг хийж дуудлагын номын сангийн үйлчилгээг 23 иргэнд хүргэж, 32 номоор үйлчилгээ үзүүллээ.

ТАВ. Соёл, урлагийн чиглэлээр зохион байгуулсан сургалтын үйл ажиллагаа, түүнд хамрагдагсдын тоо, зарцуулсан санхүүжилт, ахиц өөрчлөлт, үр дүн

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан ТТХТ-ын Дэлгэрмаа багштай драм ангийн хүүхдүүд “Номын ертөнцөөр аялъя” хүүхдийн жүжиг, “Үлгэрийн орноор аялцгаая” 3D үзэсгэлэн, Бидний мэдэх их зохиолч үзэсгэлэн зэрэг зорилтод 3 үйл ажиллагааг уншигчдад танхимаар болон шууд бичлэгээр хүргэсэн. Үйл ажиллагаанд 230 бага ангийн сурагчдыг хамруулсан.

2022 оны ололт амжилыг дүгнэх, тухайн жилдээ ном унших эерэг дадалд манлайлан оролцсон, хамгийн их ном уншсан хүүхэд, залуучууд, иргэдийг шалгаруулах зорилгоор “Номтой шинэ жил” уншигчийн шинэ жилийг зохион байгууллаа. Энэ үеэр С.Буяннэмэх тэмдэгтэн, Д.Нацагдорж тэмдэгтэн, Миний уншсан ном дүрслэх урлагт уралдаан, Номын сайн нөхөр зэрэг арга хэмжээний шилдгүүдийг шалгаруулж шагналыг гардуулсан. Шинэ жилд Хулд, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Гурвансайхан сумын хүүхдүүд идэвхтэй оролцож шинэ жилд 120 хүнийг урилгаар оролцууллаа.

Дэлхийн номын өдрөөр бага ангийн сурагчдын бүтээлчээр ном унших чадварыг дэмжих зорилгоор ЭДЦС-ийн Наранбат багштай 3б ангийн 42 сурагчийн 23 бүтээлээр “Үлгэрийн орноор аялацгаая” 3D бүтээлийн үзэсгэлэнг зохион байгууллаа.

Хүүхдүүдийн ном унших эерэг хандлагыг нэмэгдүүлэх, бүтээлч чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Миний уншсан ном дүрслэх урлагт” зохион байгуулж, уралдаанд ганцаарчилсан ба шилдэг баг, анги хамт олны ангилалд 124 сурагч бүтээлээ ирүүлснээс 62 сурагчийн бүтээл шалгарч Номтой шинэ жил-2022 уншигчийн шинэ жилээр бүтээлийн үзэсгэлэнг гаргаж алдаршуулсан.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг С.Буяннэмэх тэмдэгтэн уншигч уралдааныг зохион байгуулж 48 сурагч “С.Буяннэмэх тэмдэгтэн” сурагчаар шалгарч “Номтой шинэ жил” уншигчийн шинэ жилээр тэмдэг, үнэмлэхийг Аймгийн Засаг даргаас гардан авсан.

ЗУРГАА. Угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулсан байдал, хөтөлж байгаа өрхийн тоо, хувь ахиц, үр дүн, зарцуулсан санхүүжилт

Төв номын сангийн 13, Сайнцагаан сумын 6, 8 дугаар цэцэрлэгийн 28, нийт 41 алба хаагчид угийн бичиг хөтлөлтийн сургалт, зөвлөгөө өгч ажиллалаа. Сургалтад хамрагдсанаар 3 байгууллагын 28 өрх шинээр угийн бичиг хөтөлж эхлээд байгаа бөгөөд алба хаагчдын 7 нь угийн баяраа хийж угийн бичгээ хөтлөн ном болгон хөгжүүлсэн 9 алба хаагч байв.

ДОЛОО. Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээ,

түүнд хамрагдагсдын тоо, ном баяжилт, үйл ажиллагааны орлого, зарцуулсан санхүүжилт, ахиц нөлөө

2022 оны “С.Буяннэмэх тэмдэгтэн” сурагчдын бүтээлийг хүлээн авч шалгаруулалтыг хийн 2021, 2022 оны шилдэг бүтээлээр үзэсгэлэн гаргаж хүүхэд багачууд, иргэдэд сурталчиллаа.

Шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 23 удаа 621 нэр төрлийн ном, сонин, сэтгүүлээр гаргаж уншигч, иргэдэд танхимаар болон цахимаар сурталчилан ажиллаж байна. Үүнд:

1. “С.Буяннэхэмийн бүтээл” 30 ном /10 удаа/
2. “Үндсэн хууль 30 жил” 29 ном
3. “Шилдэг шинэ ном” 26 ном
4. “Уран үгсийн чуулган” 45
5. “Хос бичигтэн Дундговь” 25
6. “Аймгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчид” 40 ном
7. ЭЕШалгалтанд бэлтгэгч, Их дээд сургуульд элсэгчдэд 43 ном
8. “Шинэ ном” 56
9. “Дундговийн зохиолчид” 48
10. “Хувь хүний хөгжлийн бэст сэллэр ном” 59
11. “Хүүхдийн шинэ ном” 100 /5 удаа/ үзэсгэлэн гаргасан байна.
12. Брайль үсгийн ном-45
13. Эх хэл бичиг-34 /2 удаа/
14. Ховор номын үзэсгэлэн-18
15. Ялалтын баяр-23 тус тус үзэсгэлэн гаргав.

ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ

Д/д	ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
1	УНШИГЧ	3000	2114	70.4
2	НОМ ОЛГОЛТ	40000	41162	102.9
3	НОМ СЭЛБЭН ЗАСАЛТ	2100	2115	100.7

Татгалзлаар ирүүлсэн 260 номын жагсаалтаас нэн шаардлагатай номын татгалзлыг 100 хувь барагдуулж, 8,587,050 төгрөгөөр 250 нэр төрлийн 339 номыг шинээр бүрдүүлсэн байна. “Хамгийн сайхан өглөгч хүн ном хандивлагч Та” хандивын аян, АИТХ-тай хамтран зохион байгуулсан “Ном хандивлах сайхан” эвент 2 томоохон үйл ажиллагааг зохион байгуулж, 25 ном хандивлагчдаас 167 нэр төрлийн 300 ширхэг, 4.649.869,60 мөнгөний номыг цуглуулж үнэлэн, санхүүгийн программд орлогодуулан, нэг бүрчилсэн бүртгэл, электрон каталогт бүртгэн авч, үйлчилгээний танхимуудад хуваарилан, техник ажиллагаа хийсэн.

НАЙМ. Байгууллагын засвар тохижолт, бүтээн байгуулалтын ажил, хөрөнгө оруулалтын талаар хийсэн ажил, санхүүжилтийн эх үүсвэр, ахиц өөрчлөлт, үр дүн

Уншлагын танхимын орчин нөхцөл, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор хуучин лангууг сольж шинээр хийсэн, ном нээх ёслолд зориулан тайзыг өөрийн бололцоонд тулгуурлан хийж тохижууллаа.

Дундговь аймаг байгуулагдсны 80 жилийн ойг тохиолдуулан байгууллагын гадна орчны өнгө үзэмжийг сайжрууллаа.

Аймгийн Засаг даргаас уриалсан "Дундговио ногооруулъя" хөдөлгөөнд идэвхтэй оролцож, Хэлмэгсдийн талбайд “Соёлын төгөл”-д 25 метрийн уртай 3 шуудуу ухаж, 29 ш улиас, 20 ш хайлаас нийт 49 ш модыг суургалаа.

Мөн Улаанбаатар-Мандалговь хотын зам дагуу тарьсан модоо арчилж, 48 ш мод шинээр нэмж суулгасан. Сайнцагаан сумын ЗДТГ-аас гаргасан хуваарьт усалгааны дагуу цаг тухайд нь усалсан.

2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналд байгууллагын нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг 2 удаа гаргаж холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэв.

Ажлын байрны дулаан байдал, эрүүл цэвэр байхад анхаарч ариутгалын бодистой усаар цэвэрлэгээ тогтмол хийх, чийгшүүлж тоосжилтыг багасгах зэрэг ажлуудыг тогтмол хийсэн.

ЕС. Сум, аймаг, бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцсон оролцоо, амжилт, шагнал урамшил, санхүүжилт үр дүн

Номын сангийн консорциумаас жил бүр зохион байгуулдаг “Зургаан төрөлт цогцолбор тэмцээн”-д нийтийн болон сум сургуулийн номын санчдаас бүрдсэн баг Мөнгөн медаль эзлэн, багийн дүнгээр Тусгай байр эзэлсэн амжиттай оролцсон.

“Нүүдэлчин монгол” дэлхийд монгол өв соёлыг сурталчлах их наадамд оролцож 21 аймаг, 9 дүүрэг оролцсоноос Тусгай байрын шагналыг эзэлсэн.

Улсын алдарт гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн түүхт ойг тохиолдуулан их зохиолчийг алдаршуулах, түүний амьдрал уран бүтээлийг сурталчлах таниулах, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулахад онцгой хувь нэмэр оруулсан хүмүүсд Шагнал гардуулж алдаршуулсан.

Үүнд:

- **Аймгийн Хүндэт тэмдэгээр:**

- Өлзийт сумын нийтийн номын сангийн номын санч Ц.Шинэбаяр
- Хулд сумын нийтийн номын сангийн номын санч Н.Батцэцэг
- Дэлгэрхангай сумын нийтийн номын сангийн номын санч С.Нармандах
- Сайхан-Овоо сумын нийтийн номын сангийн номын санч Д.Навчаа
- ЭДЦСургуулийн номын санч Хандмаа

- **Аймгийн Засаг даргын Жуух бичгээр :**

- Төв номын сангийн нярав харуул хамгааллын ажилтан Ч.Одбаяр
- Адаацаг сумын нийтийн номын сангийн номын санч О.Тэгжаргал
- Төгөлдөр Буяннэмэх сан

- **Аймгийн 80 жилийн ойн медалиар**

- Баянжаргал сумын нийтийн номын сангийн номын санч П.Отгончимэг
- Дэлгэрцогт сумын нийтийн номын сангийн номын санч С.Одонтуяа
- Говь-Угтаал сумын нийтийн номын сангийн номын санч Х.Энхтуяа
- Дэрэн сумын нийтийн номын сангийн номын санч Ч.Алтантуяа
- Луус сумын нийтийн номын сангийн номын санч Б.Эрдэнэтуяа
- Гурвансайхан сумын нийтийн номын сангийн номын санч Б.Оюунтулга

“С.Буяннэмэх-120” жилийн ойг тохиолдуулан Аймгийн Төв номын сан, Төгөлдөр Буяннэмэх ТББ хамтран аймгийн хэмжээний бүх номын сангуудын дунд “Шилдэг номын сан шалгаруулах уралдаан”-ыг зохион байгуулсан.Тус уралдаанд “Шилдэг сумын номын сан”-аар Дэлгэрхангай сумын нийтийн номын сан, “Шилдэг сургуулийн номын сан”-аар ЭДЦС-ийн номын сан тус тус шалгарсан.

Байгууллагуудын дунд зохион байгуулсан урлагийн үзлэгт бусад байгууллагуудын хамтаар Тэргүүн байр эзэлсэн.

Монгол бичгийн тэргүүний уншлагын тэмцээнийг зохион байгуулж, 10 хүүхдийг улсын уралдаанд явах эрхийг олгож, замын зардлыг шийдэж өгсөн.

Арав. Байгууллагын үйл ажиллагаанд хийгдсэн өөрийн болон хөндлөнгийн хяналт шинжилгээний дүн мэдээ, түүний дагуу авсан арга хэмжээ, ажлын үр дүн, ахиц өөрчлөлт

Дөрвөн танхимын үйл ажиллагааны онцлогт тохирсон сэтгэл ханамжийн судалгааны асуултыг бэлтгэж 15 асуулгын хүрээнд 220 хүнээс санал асуулга авч, судалгааны нэгтгэлд дүн шинжилгээ хийж улирал бүрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Байгууллагын 12 алба хаагчийг монгол бичгийн модуль сургалтанд хамруулж батламж гардуулсан. Үүний үр дүнд ажилтнууд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг мангол бичгээр тайлагнадаг боллоо.

Алба хаагчид өөрийн болон байгууллагын гүйцэтгэлийн хэрэгжилтийн тайланд Свот дүн шинжилгээ хийж, эрсдэл, боломж, давуу, сул талуудыг гаргаж ирэн асуудлыг шийдвэрлэх замаар дараагийн ажлын төлөвлөгөөндөө тусгадаг болсон.

2022 онд хувиарлагдан ирсэн төсвийг зөв зохистой зарцуулснаар өр авлага үүсгээгүй ба номын санчдын ажлын хүртээмжийг дээшлүүлэх, ажлын байрны онцлогт тохируулан шинэ санал санаачлага гаргаж ажиллуулах зорилгоор танхимуудын номын санчдыг сэлгэн ажиллуулж, ур чадварыг нэмэгдүүлж байна.

2023 онд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх, шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэхээр төсвийн төсөлдөө тусгаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Арван нэг. Иргэд, байгууллагын өргөдөл гомдол, түүнийг барагдуулсан байдал

Байгууллагын 8 алба хаагчдаас ирсэн өргөдлийг хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн, хариуг хүргүүллээ.

Арван хоёр. Бусад ажил

Байгууллагын алба хаагчдыг туршлага судлах аялалд хамруулан Дорноговь, Сүхбаатар аймгийн нийтийн номын сантай хамтран “Онцлох-5” сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх туршлага судлах ажлыг хамтран зохион байгуулж байгууллагын 13 алба хаагчдыг хамруулж аймгуудын номын сантай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

13 ажилтанг 6 удаагийн хувь хүний хөгжлийн модуль сургалт, төрийн албанаас зохион байгуулж буй сургалтууд, “Жендерийн тухай ойлголт”, “Багт дотор би” “Миний гэр бүлийн баяр хөөр” “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” "Харилцаа ба арилжаа", “Хандлага халдварладдаг” сургалтад тус тус хамруулсан байна.

Ажил мэргэжлээ сурталчлан таниулах зорилгоор “Номын сангийн хишиг” өдрийг зохион байгуулж “Хувь хүний хөгжлийг дэмжих жил”, “Хандлагаа өөрчилж-Хамтдаа хөгжье” аяны хүрээнд байгууллагын алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, номын сангийн ажилтнуудын ажил мэргэжлийг сурталчлах, байгууллага, ажилтан, гэр бүлийн эерэг харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор байгууллагын эцэг алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг нэг өдөр номын сангийн ажил үйлчилгээг уншигчдад хүргэх ажлыг хийлгүүлэх шинэлэг ажлыг эхийн зөвлөл, спорт хамтлагаас зохион байгууллаа.

“Хандлагаа өөрчилж-Хамтдаа хөгжье” аяныг байгууллагын алба хаагчдын дунд зарлан үйлчилгээний хүртээмж, төрийн алба хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, бүтэлч ажил гэх зэрэг шалгуур үзүүлэлтээр дүгнэн шилдэг алба хаагч, шилдэг багийг шалгаруулсан.

--- o0o ---

ЗАВХАН АЙМГИЙН Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга: Завхан аймгийн номын сан нь 1946 онд Гэгээрлийн хэлтсийн даргын 65 тоот тушаалаар аймгийн бага хурлын номын сан нэртэйгээр 500 номтойгоор 1 орон тоотой анх байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 109-р тогтоолоор төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Явуухулангийн нэрэмжит болон 76 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго: Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт, өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй”** төв болох

ХОЁР: НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус номын сан нь 2022 оны байдлаар 55304 ширхэг 132477936 төгрөгийн Монгол, Англи, Орос, Төвд хэл дээрх ном хэвлэлтэй бөгөөд Монгол номын фонд- 2, гадаад /орос/ номын фонд- 1, Гадаад /англи/ номын фонд -1 үйл ажиллагаагаа явуулж байна. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг худалдаа, хандиваар бүрдүүлдэг бөгөөд ном хэвлэл худалдан авах журмаар бүрдүүлэн ажиллаж байна.

2022 онд 328 нэр төрлийн 747 ширхэг 11502500 төгрөгийн ном хэвлэлээр сан хөмрөгөө бүрдүүлснээс:

- Худалдаагаар 296 нэр төрлийн 679 ширхэг 10586500 төгрөгийн ном
- Хандиваар 32 нэр төрлийн 68 ширхэг 966000 төгрөгийн номоор фондоо баяжуулан үндсэн фонд болон тасаг танхимуудад хүлээлгэн өгч ажилласан байна.
- Мөн Германы хөрөнгө оруулалтаар 2011 онд Book bridge сургалтын танхим байгуулагдсан ба тус танхимын ном хэвлэл, тавилгыг манай байгууллагад хандивлах зөвшөөрөл 2022 онд ирснээр 4526 ширхэг 4176800 төгрөгийн ном хэвлэлийг номын сангийн данс бүртгэлд тусган ажиллалаа.

Уншлага үйлчилгээнд ашиглагдах боломжгүй болсон **175** ширхэг номыг сэлбэн засах мөн Туяа сонины бүх дугаарыг шинэчлэн үдэж хавтаслах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сан хөмрөгт хадгалагдаж буй Төвд хэлээр бичигдсэн болон гар бичмэл, судруудын хадгалалт хамгаалалтыг сайжруулан сэлбэн засалт болон баринтаг солих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2022 онд Нийтийн уншлагын танхим, Bookbridge сургалтын танхимын ээлжит тооллого, Хүүхдийн уншлагын танхимын ээлжит бус тооллогыг хийж акт үйлдэн архивт хүлээлгэн өгч ажиллалаа.

Мөн 2022 онд ИТХ-ын А/48 тогтоолоор 2754 ширхэг 2239116 төгрөгийн номыг актлуулан номын сангийн үндсэн бүртгэлүүдээс хасалт хийх ажлыг хийж гүйцэтгэлээ.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь Уншлага үйлчилгээний:

- Нийтийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр ном олгох тасаг

- Англи хэлний сургалтын танхимаар үйлчилгээ явуулдаг бөгөөд

Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс 2518 уншигч 7744 ирэгсдэд 10127 ном олгож үйлчиллээ. Уншигч- 66.29%-тай, ном олголт 18,4%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Уншлага үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тасаг танхмын номын санч нар өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн ном уншлагын аянуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Уншлага үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор дараах СОНА-уудыг зохион байгууллаа. Үүнд:

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу "Үндэсний бичиг үсгийн баяр" арга хэмжээний хүрээнд "Босоо бичигтэн" уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд энэ жил Албан байгууллагын албан хаагчид болон ЕБС-ын суралцагчид гэсэн ангиллаар амжилттай зохион байгууллаа. Уралдааныг "Бийрэн бичлэг", "Хичээнгүй бичиг", "Уралдаант уншлага" гэсэн 3 төрлөөр зохион байгуулж шилдгүүдээ шагнаж урамшууллаа. Тус үйл ажиллагаанд албан хаагчдын ангилалд 23 оролцогч, ЕБС-н суралцагчдын ангилалд 19 хүүхэд идэвхтэй оролцлоо.

Дорнын их яруу найрагчийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан Улиастай сумын ЕБС-иудын бага, дунд ангийн суралцагчдын дунд “Алаг дэлхийд төрсөн минь учиртай” шүлгийн уралдаан зохион байгуулан нийт 125 оролцогч оролцлоо. Мөн ЧЭЛС-ийн 8 дугаар ангийн суралцагчдын дундУншигчдын бага хурал зохион байгуулсан ба их найрагчийн уран бүтээлийг уншигчад сурталчлах зорилгоор пэйж хуудсанд түүний намтар уран бүтээлийн намтар номзүйг байршуулан ажиллалаа. Их найрагчийн мэндэлсэн өдөрт зориулсан арга хэмжээнд нийт 210 гаруй уншигч хамрагдсан дүн мэдээтэй байна.

Хүүхэд багачуудын уран сэтгэмж, танин мэдэхүй авьяас чадварыг хөгжүүлэх зорилготой “Миний дуртай бяцхан ном” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ЕБС–н 5 сургуулийн 45 суралцагч идэвхтэй оролцож бүтээлээ ирүүлснээс 3-н суралцагчийн бүтээлийг шалгарууллаа.

Монгол хэлний үгсийн баялаг, зөв бичих дүрмийг таниулах зорилготой Үсэглэлийн хаад зорилтот уралдааныг ЕБС-н 5-р ангийн суралдагчдын дунд зохион байгууллаа. Уралдаанд 40-н суралцагчид хамрагдлаа. Мөн соёлын бүтээлч сар аяны хүрээнд Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол шүлгийг хэн сайн унших вэ” шүлгийн уралдааныг 6-9-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 9 бүлгийн 216 суралцагчид хамрагдлаа.

Англи хэл сурч буй хүүхэд багачуудын англи хэл сурахад нь дэмжлэг үзүүлэх, англи хэл дээрх номыг тогтмол уншсанаар хэл сурахад ямар үр дүнд хүрэх давуу талыг олгох, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх, тус ажлыг зохион байгуулснаар ЕБС-н англи хэлний багшийн хичээлийн үйл ажиллагаанд нь дэмжлэг болох зорилготой BOOKFRIEND аяныг 1 сарын хугацаанд өрнүүллээ. Аянд ЧЭЛС, БД 3-р сургуулийн 6-8-р ангийн суралцагчдыг хамрагдсан бөгөөд нийт 420 суралцагч тус арга хэмжээнд оролцож 46 хүүхдийг шалгаруулан урамшууллаа. Мөн ангийн суралцагчдаа идэвхтэй оролцуулсан англи хэлний багш нарыг урамшуулж, хамтран ажиллалаа.

Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сангийн дэргэдэх “УНШИХУЙ” клубын гишүүдийн хоёрдугаар ээлжийн уулзалтыг “Ном уншихын ач тус” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Тус уулзалтад ахлах ангийн 45-н суралцагчид хамрагдлаа.

Ном уншиж номтой нөхөрлөх боломжийг бүрдүүлэн өгдөг оюуны өргөөг магтан алдаршуулах зорилготой “Номын сан-Миний амьдралд” эсээ бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд дунд, ахлах бүлгийн 52-н суралцагчид эсээ бичлэгээ ирүүлснээс 6-н суралцагчдын эсээ бичлэгийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.



Суралцагчдын авъяас ур чадварыг дэмжих, эх хэлний боловсролыг дээшлүүлэх, монгол хэлний уран үгсийн арвин баялаг сантай танилцах, уран тод ярих, уран сайхны сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор **“Уран жиргээ”** богино өгүүллэгийн уралдааныг ЕБС-ийн 5-8-р дугаар ангийн суралцагчдын дунд зохион байгуулж 26 суралцагчид оролцлоо.

BOOKFRIEND аяны хүрээнд англи хэлний үгсийн санг нэмэгдүүлэх, ярианы хэллэгийг зөв хөрвүүлэн бичих зорилготой SPELLING BEE үсэглэлийн тэмцээнийг 7-8-р ангийн суралцагчдын дунд зохион байгууллаа. Уралдаанд 134 суралцагч оролцож 8-н суралцагч бусдыгаа манлайлан шалгарч амжилттай оролцлоо.

Угийн бичиг хөтлөх, түүний арга аргачлалыг судлан танин мэдэх бусдад түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Төв номын сан пэйж хуудсанд 15-н удаа угийн бичиг хөтлөх, төрөл аргыг харуулсан бичлэг болон цуврал мэдээллийг байршуулсан. Мөн “Удам судраа судалж, угсаа гарлаа мэдье” сэдэвт угийн бичиг хөтлөх арга аргачлалыг таниулах сургалтыг ЕБС-ийн 20 суралцагч, Соёл урлагийн байгууллагын 15 ажилтан, Товцог багийн 55 иргэнд зохион байгууллаа.

Үндэсний бичиг соёл, номын өдрүүд арга хэмжээний хүрээнд

Үндэсний бичиг соёл, номын баярын арга хэмжээг 2022 оны 05-р сарын 20-22-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган Улиастай хотын Төв талбайд нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хаврын “Номын баяр-2022” арга хэмжээнд 150 гаруй иргэд уншигчид хамрагдлаа. Тус арга хэмжээнд зориулан гэрэл зургийн үзэсгэлэн болон Боролдой номын дэлгүүртэй хамтарсан шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2080 номоор гаргаж үйлчиллээ. Уншигчдын дунд гар зургийн уралдаан, эсээ бичлэг богино өгүүллэгийн уралдаан, ном уншлагын аян, дүрийн тоглолтууд, номтой зочин, ном хож, зохиолч уншигчдын уулзалт зэрэг 33 нэр төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж нийт 3279 иргэд уншигчид хамрагдлаа.

Намрын “Номын баяр-2022” арга хэмжээг Завхан аймгийн Улиастай сум болон 23 сумдын номын сангууд 2022 оны 09 сарын 16-26-ны өдрүүдэд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” нэртэйгээр зохион байгууллаа. Сумдын номын сангууд уг үйл ажиллагааг угтаж 92 төрлийн СОНА зохион байгууллаа. Нээлтийн үйл

ажиллагаанд 4554 идэвхтэн уншигч дэмжин оролцлоо. Мөн энэ үеэр 3289 ширхэг номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж уншигч үйлчлүүлэгчдээ хүргэн ажилласан байна.

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд "Бадархундага яруу-2022" яруу найргийн наадмыг Улаанбаатар хотод АЗДТГ, СУГ-тай хамтран зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Завхан аймгаас төрөн гарсан эрдэмтэн зохиолчдын номын дээжээс түүвэрлэн "Цадиг түүхт цаст уулынхан" нэртэй номын үзэсгэлэнг гаргаж оролцлоо. Нийт 112 ширхэг номоор үзэсгэлэн гаргалаа.

Ардын аман зохиол, ерөөл магтаал эртний домог түүхийн талаар цуврал бэлтгэн Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сан пэйж группт 16 удаа мэдээлэл байршуулж тус сэдвийн хүрээнд 5 бичлэг хүлээн авч шалгаруулллаа.

ДӨРӨВ: КАТАЛОГ, ЛАВЛАГАА НОМЗҮЙН АЖИЛ

Каталог, картын сангийн зохион байгуулалт:

Шинээр ирсэн 747 ширхэг номонд техник ажиллагаа хийн Электрон каталогт оруулан цаасан каталог хэвлэн байрлууллаа.

LIB4U болон Монбиблио програмын хэвийн үйл ажиллагааг ханган сумдын номын санчдад зөвлөгөө өгөн ажиллаж байна.

Номзүйн ажил:

Zotero програмд Туяа сонины 1965 оны өгүүллүүдийг оруулан МҮНС-ийн нэгдсэн системд хүргүүлэн ажиллалаа.





Омека програмд номын сангийн сан хөмрөгт байхгүй дугааруудыг Архивын газраас авч скайнердаж 5 оны дугаарыг оруулллаа.

2010-2022 оны хооронд гаргасан Санамж өгөх номзүйн бүртгэлүүдээ Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сангийн фэйж хуудсанд байршуулан уншигчдад лавлагаа мэдээлэл өгөн ажиллаж байна.

“Завхан цахим түүх” влогт 23 сумын номын санчидтай хамтран Завхан аймгийн 100 жилийн ойг угтан Завхан нутгаас төрөн гарсан Зохиол, Яруу найрагчдын намтар уран бүтээлийг оруулан уншигчдад мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна.

ТАВ. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛ

Сумдын номын сангуудын Монбиблио програмыг онлайнд холбуулан тэдний ажлыг шууд хянах боломж бүрдэж байгаа бөгөөд СУИС-ийн багш Т.Хайдавтай хамтран уг програмын тухай заавар зөвлөмжийг тухай бүр нь хүргэн ажиллаж байна. Мөн өөрийн байгууллагын LIB4U програмын хэвийн ажиллах нөхцлийг ханган Волвес компанийн инженер Гантулгаас утсаар болон фэйсбүүкээр заавар зөвлөгөө аван өөрийн ажилтнуудад програмын шинэчлэлт, програмд гарсан засвар үйлчилгээний талаар мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

Номын сангийн цахим сангийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын нөөц сангаас 10 сая төгрөгийг шийдүүлж цахим санг бүрдүүлэхэд шаардлагатай байгаа хэрэгцээт тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан. Сонин бусад ном хэвлэлийг сканердах 4 үйлдэлт скайн, Dell core I7 notebook, Galaxy I7 tab зэргийг авснаар цахим уншлага үйлчилгээнд нэвтрүүлээд байна. Мөн интернэтийн хурдыг сайжруулж “Гайхмаар хурд” ХХК-тай 3 жилийн гэрээ байгуулж 4GB-ийн хурдаар интернэт авч ашиглаж байна.

ЗУРГАА: АРГА ЗҮЙН АЖИЛ

МҮНС-тай хамтран “Уншигчийн судалгаа хийх” сургалтыг 06 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтыг МҮНС-ийн МАЗЭШХ-ийн дарга Т.Хайдав, Арга зүйч В.Түвшинтогтох нар сумдын номын санчдад мэргэжлийн хичээлээр мөн төв номын сангийн ажилтнуудад уншигчийн судалгаа хийх сургалтыг зохион байгуулан нийт 260 гаруй уншигчдаас судалгаа аван үр дүнг нь тооцон уншлага үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Сургалтад нийт 31 номын санч оролцлоо.

“Монгол бичиг-Сайхан бичиг” уриалга гарган ЧЭЛС-ийн хэл уран зохиолын багштай хамтран Монгол хэл бичгийн 3 удаагийн 20 цагийн анхан шатны сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд 11 албан хаагчдыг хамруулллаа.

ЗДТГ-н төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Вансэмбэрүү “Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал” сэдэвт сургалтыг сумын номын санч нарт зохион байгууллаа. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ажлын байрны ёс зүй” сэдвүүдээр байгууллагын ёс зүйн хорооны дарга, гишүүд илтгэл тавьж, нийт 11 ажилтнуудыг хамрууллаа.

Монгол бичгээр хэвлэгддэг "Хүмүүн бичиг" сониныг захиалан авч, 7 хоног бүрийн Пүрэв гарагт албан хаагчдад зориулсан "Хүмүүн бичиг, Хүн бүрийн бичиг" уриатай уншлагын цагийг гарган, тус сонины дугаарыг тараан өгч уншуулах ажлыг зохион байгуулж монгол бичгийн хэлний мэдлэгийг нь дээшлүүлж байна.

ДОЛОО: ХҮНИЙ НӨӨЦ

Манай номын сан нь захирал, нягтлан бодогч, ном зүйч, мэдээллийн технологич, мэдээллийн ажилтан, фондчин, номын санч-3, зөөврийн номын санч, үйлчлэгч сахиул гэсэн 11 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Эдгээр ажилтнуудаас Мэргэжлийн номын санч-4, Номын сангийн чиглэлээр Магистр хамгаалсан ажилтан – 3 ажилтан ажиллаж байгаа бөгөөд номын санчдыг

мэргэшүүлэн сургах сургалтанд хамруулж чиглэл чиглэлээр нь туршлага судлуулсан дадлага ажлуудыг холбогдох газруудад хийлгэж кредит цагийн сургалтуудад номын санчдыг хамруулах шаардлага тулгарч байгаа.

Байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг тэлэх зорилгоор тухайн жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлон улирал бүр мэдлэг олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

8. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд байгууллагын албан хаагчдыг хуваарьт өдрүүдийн дагуу спорт зааланд өглөө бүр эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнд идэвхтэй оролцуулан 7 удаагийн хөдөлгөөнт дасгалд хамруулаад байна.

Хавар намрын бүх нийтийн хог цэвэрлэгээнд байгууллага хамт олноороо өөрийн хуваарьт газар болох богдын гол багийн голын ай сав газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг идэвхтэй гүйцэтгэлээ. Мөн хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах үүднээс, орчин тойрны 100 м талбайн цэвэрлэгээ хийж, идэвхтэй хандлагыг өрнүүлэн, хэрэгжилт үр дүнг тооцож мэдээ тайлан Улиастай сумын ЗДТГ-т хугацаанд нь хүргүүллээ.

Байгууллагын гадна талбай болон төв замын цас мөсийг цэвэрлэн халтиргаа гулгаа, осол гэмтлээс сэргийлж ажиллалаа. Мөн холбогдох тайлан мэдээг Улиастай сумын ЗДТГ-т албажуулан хүргэлээ.

Байгууллагын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төрөл бүрийн цэцгийн үрсэлгээ авч, үрслүүлэн тарьж, цэцгийн төрлөө нэмж байна. Одоогоор тасалгааны 8 нэр төрлийн цэцэг үрслүүлэн тарилаа. Гадна талын талбайн хайсанд цэцгийн мандал ногоон зүлгийг үрслүүлэн тарьж бургас, шар хуайс зэрэг 15-н ширхэг модны суулгацыг тарин ургуулж байна.

ДҮГНЭЛТ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь 2022 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 100%-тай хийж гүйцэтгэсэн ба ХШҮДАХ-ээс 94,2%-тай үнэлэгдсэн байна.

Уншлага үйлчилгээний хувьд: Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс 2580 уншигч 7742 ирэгсдэд 10127 ном олгож үйлчиллээ. Уншигч- 66.9%-тай, Ном олголт- 18.6%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна. Цаашид уншигчийн тоо нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай нь харагдаж байна.

Номын сангийн сан хөмрөгийн хувьд: Өмнөх жилүүдтэй харьцуулахад сан хөмрөгийн нэр төрлийг шинэчлэн уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан ажиллалаа. Мөн 2011 онд байгуулагдсан Сургалтын номын сангийн 4526 ширхэг номыг орлогот авах эрх үүсэж данс бүртгэлүүдэд бүрэн тусган ажиллалаа.

Арга зүйн ажлын хувьд: 2022 оны төлөвлөгөөт сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллалаа. Цахимаар номын санчдыг сургах олон төрлийн сургалтуудыг зохион байгуулан зохих үр дүнд хүрч ажилласан байна. Сумдын номын санчдыг өөрийн байгууллага дээр дадлагажуулах ажлыг зохион байгуулан тодорхой үр дүнд хүрч байна.

Соёл олон нийтийн ажлын тухайд: 2022 оны төлөвлөгөөнд орсон ажил үйлчилгээ 100% хийгдсэн ба нэмэлтээр олон төрлийн уншигч руу чиглэсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 2022 онд 30-40 нэр төрлийн СОНА зохион байгуулан 4500-аас дээш уншигчийг хамруулан ажилласан байна.

ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Эрхэм зорилго. Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй ирэнийг төлөвшүүлэхэд оршино.

Зорилт 1*: "Номын өргөө" бүхий цогцолбор барилгыг эхлүүлэх*
/ Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр СУГ-ын дарга, зургийн автортай уулзаж 4 давхарын зурганд өөрчлөлт оруулан 1 уншлагын танхимын талбайн хэмжээг нэмэгдүүлэх талаар зөвшилцсөн.Барилгын ажлын явц 2022-11-22 ны байдлаар 70 орчим хувьтай байна. / Аймгийн Таван жилийн үндсэн чиглэлийн 1.3.1, ЗДҮАХ-ийн 3.2, 3.1.2 /

Зорилт 2: ***Номын сангийн тогтмол хэвлэлийг номын сангийн программд оруулах*** /2021 оны "Зууны мэдээ ", "Өдрийн сонин" шивж оруулсан

Зорилт 3: ***Номын сангийн коридор танхимуудыг камержуулах, FREE WIFI орчин бүрдүүлэх*** ./ МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.6.1.8/: Номын сангийн орчныг FREE WIFI орчин бүрдүүлэв.

2022 онд дараах бодлогын баримт бичигт турлгуурлан үйл ажиллагаагаа явууллаа.

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Соёлын яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөө
- Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
- Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Соёлын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ
- Нийтийн номын сангийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

1993 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 131 тогтоолоор "Номын төв" гэсэн нэршилтэйгээр ажиллаж байсныг 2007 онд батлагдсан "Аймаг нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм", 2014 онд батлагдсан "Номын сангийн тухай хууль" болон бусад албаны баримт бичиг, дүрэм, журманд нийцүүлэх үүднээс амйгийн ИТХ-ын 2022 оны 07 сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 10/04 тоот тогтоолоор "Орхон аймгийн Нийтийн номын сан" гэсэн нэршилтэй болж үйл ажиллагаа явуулж байна..

. Аймгийн номын сан нь 1 салбар номын сан 4 танхимаар номын сангийн уншлага үйлчилгээг аймгийн 104,0 мянган хүнд ном соёлыг хүргэн ажиллаж байна.

ХОЁР. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Аймгийн номын сан нь сан хөмрөгтөө нийт 35,4 мянган номтой бөгөөд 25,3 мянган монгол хэл дээрх, 7,5 мянган орос хэл дээрх, 1,8 бусад хэл дээрх номтой үүнээс танхимуудын ойрын фондуудад 18,8 мянган ширхэг номнууд эргэлтээр уншигдаж байна. Энэ онд үндсэн фондын архиваас 19 нэрийн сонин 157 номыг захиалгаар авч үйлчлүүлсэн байна. Энэ онд байгууллагын төсөвд ном авах зардал 5,0 сая төгрөг батлагдаж, соёлын яамнаас хүүхдийн уран зохиолын ном авах 4750,0 янган төгрөг батлагдан төсвөөр 317 нэрийн 490 ширхэг 7077,7 мянган төгрөгийн ном 21 нэрийн 1148,8 мянган төгрөгийн сонин, сэтгүүл, хандиваар 64 нэрийн 101 ширхэг 1900,9 мянган төгрөгийн ном авч нийт 381 нэрийн 591 ширхэг 10502,0 мянган төгрөгийн номоо номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлтийг хийсэн байна.

Номын сангийн фондын монгол хэл дээр хэвлэгдсэн хуучин номын судалгааг гаргалаа. Уг судалгааг номын сангийн программ болох LIB4U дээр үндэслэн гаргасан. 1950 он хүртэл хэвлэгдсэн ном хэвлэл болон 1951-1960 оны хооронд хэвлэгдсэн ном хэвлэл, 1961-1970 оны хооронд хэвлэгдсэн ном хэвлэл, 1971-1980 оны хооронд хэвлэгдсэн ном хэвлэл гэж ангилан гаргалаа. Уг судалгаанаас үзэхэд номын сан хөмрөгийн 8,2%-г монгол хэл дээр хэвлэгдсэн хуучин ном буюу 1980 он хүртэл хэвлэгдсэн ном хэвлэл эзэлж байна. Нийт монгол хэл дээрх ном хэвлэлийн 11.7%-г эзэлж байна.

Орхон аймгийн номын төвийн фондонд байгаа хамгийн хуучин ном 1912 онд хэвлэгдсэн Кешоков А. “Гаймшигт эгшин роман”, 1923 онд хэвлэгдсэн “Хувьсгалын дуу”, 1929 онд хэвлэгдсэн “Монгол ард улсын угсаатны судлал хэлний шинжлэлийн атлас тэргүүн боть” хэмээх номнууд байна.

Номын сангийн ээлжит тооллогыг жилийн эцсээр бар код уншигчаар 4 танхим, 1 салбар номын сан хийж нийт 68 ном дутагдаж уншигчийн гар дээр 18, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 50 гаруйн ном дутагдсан байна. Салбар номын сангийн номыг үүлэн технологийн программ авсан анхны жил тул анх удаа бар кодоор тоолох ажлыг хийсэн байна. Танхим, салбар номын сангийн номын санчид нийт 335 номыг сэлбэн зассан ба нийт номын 60 гаруй хувийг хүүхдийн уран зохиолын ном байна. Үндсэн фондын ном хадгалалт нь өдрийн 2 цагийн зайтай агааржуулалт ажиллуулан чийгшүүлэлтийг саванд ус хийж тавих маягаар хийж байна.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Номын сангийн үйлчилгээ

Орхон аймгийн хэмжээнд номын сангийн үйлчилгээг уламжлалт хэлбэрээр 4 танхим 1 салбар номын сангаар 227 суудал бүхий танхимуудаар 7606 хүнд шинээр карт нээж 66763 байнгын ирэгсдэд 133910 ном олгож үйлчилсэн байна. Нийт 66763 ирэгсдийн 63124 танхимаар 774 гэрээр 2516 ном зөөврөөр 260 хүн лавлагаа номзүйн танхимаар үйлчлүүлсэн байна. Нийт ирэгсдийн судалгаанаас харахад 18-аас доош насны 48053 хүүхэд үйлчлүүлсэн байна.

Номын сангийн танхимын үйлчилгээнээс гадна лавлагаа номзүйн үйлчилгээг 349 удаа, номын татгалзал 198 удаа, Солонгос улсын койка-ын тэтгэлэгт хөтөлбөр, Австралын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн тухай зэрэг сургалт семинар 20 удаа, уншигчдын дунд уралдаан тэмцээн 20 удаа, номын шинэ болон сэдэвчилсэн үзэсгэлэн 84 удаа, томоохон хэмжээний эвент ажиллагаа 8 удаа зохион байгуулсан байна. Номын сангийн Lib4U программын шинэчилсэн үүлэн технологийн суурилсан хувилбарт шилжсэнээр аймгийн иргэдэд интернеттэй газраас номын сангийн сонирхсон номтой танилцах боломж нээгдэж сонин сэтгүүлийг программд шивж оруулсанаар мөн мэдээллийг түргэн шуурхай авах боломжоор хангагдаж байна.

Соёл олон нийтийн ажил

2022 онд номын сангийн танхимын номын санчид уншигч хүүхэд багачууд иргэд, албан байгууллагын ажиллагсдын дунд 68 удаагийн СОНА-ыг 25,0 сая төгрөгийн зардалтай зохион байгууллаа. Үүнээс уралдаан гар зураг 5 удаа 156 хүнд, асуулт хариулт АХА тэмцээнийг 24 удаа 1101 хүнд, Уншигчийн бага хурал, илтгэлийн тэмцээнийг 2 удаа 25 хүнд, Номын баяр, Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэлт өдрийг 7 удаа 2359 хүнд, эссэ зохион бичлэг 8 удаа 175 хүнд, уулзалт ярилцлага лекц хэлэлцүүлэг 20 удаа 1846 хүнд цахимаар 6 удаа, өдөрлөг үдэшлэг 2 удаа 90 хүнд зохион байгуулж хамтран зохион байгуулсан газруудаас 632,0 мянган төгрөг зарцуулсан байна. **Энэхүү хийсэн ажлуудаас онцолбол:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигаар хийгддэг ***намрын Номын баяр***

Сургуулийн өмнөх насны ахлах бүлгийн хүүхдүүдэд “Би уран уншигч” уран уншлагын тэмцээн, МУ-ын гавьяат зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойд “Бүтэлгүй Гомбын маргааш” өгүүллэгээр ЕБС-ийн 8 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж өгүүллэгийн өгүүлэмжээр дүр бүтээх, асуулт хариултын уралдаан, ЕБС-ийн бага насны ангийн сурагчдын дунд “Аавтайгаа уншсан миний ном” өдөрлөг хүүхдүүд аавтайгаа ном сэлбэн засаж, тата тунгаа хөгжөөнт уралдаан, аавууд хүүхдүүддээ үлгэр унших зэрэг сонирхолтой ажлууд хийж СОНА-д нийт 90 гаруй сурагчид хамрагдлаа.

Аймгийн төрийн байгууллагуудын дунд номын өдрүүдийг танин мэдүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих зорилгоор болон үлгэрийн дүрийг бүтээсэн парадын жагсаалыг СУГ-тай хамтран нийт 21 байгууллагын 300 гаруй ажилчин албан хаагчид 13 машин морь оролцсон жасгаал зохион байгууллаа. Мэргэжлийн жүжигчид, найруулагч нараас бүрдсэн шүүгчийн баг ажиллан эцсийн дүнг гаргасан бөгөөд номын баярын жагсаалын

1. Тэргүүн байрыг "Нийгмийн даатгалын хэлтэс"
2. Дэд байрыг Баян-Өндөр сумын ЗДТГ
3. Гутгаар байрыг "Онцгой байдлын газар",
4. Тусгай байрыг "22-р цэцэрлэг", "7-р сургууль" тус тус эзэллээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигаар хийгддэг ***хаврын Номын баяр***

Соёлын сайдын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/125 дугаар тушаалыг үндэслэн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг Орхон аймагт нэгдсэн удирдамжаар амжилттай зохион байгуулж 13 төрлийн арга хэмжээнд нийт 1100 гаруй хүн хамрагдсан

Аймгийн нийтийн номын сангаас 2022 оны 16,17-ны өдрүүдэд 13 төрлийн СОНА-ыг ЕБС-ийн сурагчид, оюутнууд, сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд номын баярын тухай хэлэлцүүлэг, “Алтан хонх” тэмцээнийг насны ангиллаар, Үлгэрлээс үлгэрлэе чанга уншлага**,** Үсэглэлийн хаад, Англи хэл дээр АХА тэмцээн**,** Яруу найргийн үдэш, “Номын баяр бидний баяр” гар зургийн уралдаан, 50 номын уналт, үг таах хөгжөөнт тэмцээн зэрэг соёл, урлагийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Нийтийн уншлагын танхимаас ЕБС-ийн 8-9-р анги, 10-12-р ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн асуулт хариултын “Алтан хонх” тэмцээнийг нийтийн уншлагын танхимдаа амжилттай зохион явууллаа.2022 оны 09 сарын 16-ны “Алтан хонх” тэмцээнийг 8-9 анги, 10-12 анги гэсэн 2 ангиллаар явуулж нийт 60 хүүхэд оролцсоноос16-р сургуулийн 9а анги Г.Гантулга, 15-р сургуулийн 9б анги Г.Ган-Очир, 16-р сургуулийн 8а анги Б.Жаргал нар тэргүүлж 10-12-р ангийн 40 гаруй хүүхэд оролцсоноос 5-р сургууль 12г анги Б.Арвин, 16-р сургууль 10а анги С.Шинэбаяр, 16-р сургууль 12а анги М.Өлзийжаргал нар тэргүүлсэн байна. Мөн 2022 оны 09 сарын 17 ны өдрийн “Алтан хонх” тэмцээнд нийт 30 хүүхэд оролцож 2-р сургууль 12а анги М.Ариун-Эрдэнэ, 20-р сургуулийн 11а анги Д.Бүрэнжаргал, 2-р сургууль 12а анги О.Энх-Ану нар шалгарсан байна. Тэмцээнд амжилттай оролцож шалгарсан хүүхдүүдэд 260,000 төгрөгийн үнэ бүхий ном хэвлэлээр шагналын хур буулгалаа.

2022-09-17-ны өдөр “50-н ном хож” асуулт хариултын тэмцээнийг ИДС, МСҮТ-ийн оюутнуудын дунд 2 оюутан нэг баг болон оролцож 1-3 үетэй 9 асуултанд хариулан 50 ширхэг шинэ болон хуучин ном хэвлэлийг хожих тэмцээнд нийт 9 багийн 18 оюутан сурагчид оролцсоноос МСҮТ-ийн “Аз” багийн Тэмүжин, Болорцэцэг нар 1-2 үеийн асуултанд амжилттай оролцон амжилттай сайн хариулж “Элбэрэл хайрын 10 нууц” “Торгоны зам” гэсэн номын эзэд боллоо. Нийт 300.000 мянган төгрөгний 15 ширхэг ном хэвлэлийг шагналд зарцуулсан байна.

Хүүхдийн уншлагын танхим, салбар номын сантай хамтран ЕБС-ийн 4,5-р ангийн сурагчдын дунд "Үг таах хөгжөөнт" тэмцээнийг 2 үе шаттайгаар амжилттай зохион явууллаа. Тус тэмцээний зорилго нь: Сурагчдын сэтгэн бодох чадвар, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, бие биенээсээ суралцах, танин мэдэхүйн мэдлэгээ өргөжүүлэхэд оршино. Тус тэмцээнд 42 сурагчид баг болон оролцсоноос 1-р байранд 1-р сургуулийн сурагч 4 г ангийн сурагч М. Байгаль, 4ё сурагч Б. Төгсжаргал 2-р байранд 5-р сургуулийн 5 г ангийн сурагч Б. Шинэнаран, 5 д сурагч Б. Нандин-эрдэнэ 3-р байранд 5-р сургуулийн 5 в ангийн сурагч Гэрэл- эрдэнэ, 5 б сурагч Номинжин тусгай байрт 13-р сургуулийн 5 б ангийн сурагч Мөнхжаргал, 5 в сурагч Азжаргал нар шалгарлаа. "Үг таах хөгжөөнт" тэмцээний төсөв: 1-р байр-40000, 2-р байр-35000, 3-р байр-30000, 4-р байр-25000 нийт 130000 төгрөгийн зардал гаргалаа.

ЕБС-ийн 6,7-р ангийн сурагчдын дунд "**Номын баяр-Бидний баяр**" сэдэвт гар зургийн уралдааныг явууллаа. Тус тэмцээний зорилго нь: Сурагчдын сэтгэн бодох чадвар, зураг урах сэдлийг нэмэгдүүлэх, авъяас чадварыг нээн илрүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, номын сан сургуулийн хамтын ажиллагааг сайжруулахад оршино. Тус тэмцээнээр сэдвийн дагуу бүх хүүхдүүд нэг цагт эхэлж тэмцээний үргэлжлэх хугацаа 30 минутанд хүүхэд өгөгдсөн сэдвийн дагуу өөрийн бэлтгэж ирсэн зурах материал багажаа ашиглан зурсан. Тус тэмцээнд ЕБС-аас нийт 22 сурагчид бүртгүүлэн оролцсоноос тэргүүн байранд 13-р сургуулийн 6 б ангийн сурагч Б. Тулуй, хоёрдугаар байранд 13-р сургуулийн 7б ангийн сурагч Д. Намуунжаргал, гуравдугаар байранд 4-р сургуулийн 7д ангийн сурагч Г. Мөнхтулга, дөрөвдүгээр байранд 7-р сургуулийн 7б ангийн сурагч Ц. Анужин нарын зураг тус тус шалгарлаа. Тус гар зургийн уралдааны төсөв: 1-р байр-35000, 2-р байр-30000, 3-р байр-25000, 4-р байр-20000 нийт 110000 төгрөгийн номын урамшуулал олголоо. Шүүгчээр Зураач урчуудын холбооны тэргүүн Нэмэхням шүүн явууллаа.

ЕБС-ийн 2,3-р ангийн сурагчдын дунд "***Үсэглэлийн хаад"*** танин мэдэхүйн тэмцээнийг 2022 оны 9 сарын 16- ны 14 цагаас Нийтийн номын сангийн Хүүхдийн уншлагын танхимд 4 үе шаттайгаар амжилттай зохион явууллаа. Тус тэмцээний зорилго нь: Сурагчдын монгол хэлний мэдлэг чадварыг сорих, үндэсний хэл соёлоо дэлгэрүүлэх, номын сан сургуулийн хамтын ажиллагааг сайжруулахад оршино. Тус тэмцээнд 46 сурагчид бүртгүүлэн оролцсоноос тэргүүн байранд 5-р сургуулийн 2 б ангийн сурагч А. Түвшинзаяа, хоёрдугаар байранд 16-р сургуулийн 3 а ангийн сурагч С. Очмаа, гуравдугаар байранд 4-р сургуулийн 3 ж ангийн сурагч Б. Ариунтөгс, дөрөвдүгээр байранд 3-р сургуулийн 3 в ангийн сурагч Г. Тоджаргал нар тус тус бусдыгаа хошуучлан түрүүллээ. Тус тэмцээнд оролцсон хүүхдүүд эцэг эхчүүддээ сурлага хөдөлмөрийн амжилтыг хүсэн ерөөе. Тус "Үсэглэлийн хаад" тэмцээний төсөв: 1-р байр-35000, 2-р байр-30000, 3-р байр-25000, 4-р байр-20000 нийт 110000 төгрөгийн зардал гаргалаа.

Соёлын яамны "Соёлын бүтээлч сар", "Соёл түгээе" сарын хүрээнд

1. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар

- Номын сангийн үйлчилгээ, номын санчдын харицааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр байгууллагын 21 хүн, хүүхэд залуучуудын театрын 8 хүнд харилцааны доктор Н.Алтанцоожоор үйлчлүүлэгчидтэй харилцах харилцаа хандлагын чиглэлээр 3 цагийн сургалт зохион байгуулав.

- Танхимуудын уншигчдаас санал хүсэлтйн дэвтрээр ирсэн санал

хүсэлтийг талархал, санал хүсэлт, гомдол гэсэн гурван төрлөөр хуваан үзэж санал хүсэлтийг дараа жилийн ажилд тусгах, уншигчдаас ирсэн гомдолд анализ хийсэн байна.

- Сарын аяны хүрээнд байгууллагын дотоод засвар үйлчилгээг

өөрсдийн нөөц бололцоогоор үүдний угтах уншигчдын ном хайх хайлтын компьютерийн 2 хэсгийг тохижуууллаа.

2. Аймгийн төрийн болон төрийн бус байгууллага иргэдэд хүргэсэн соёлын үйлчилгээ

- Соёлыг түгээе аяны нээлтийг аймгийн ЗДТГ, СУГ Улаанбаатар хотоос "Номын ертөнц" ТББ-ын зохиолч яруу найрагчид, хэвлэлийн газрууд нийлсэн 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг ирж оролцлоо. Байгууллгагын зүгээс ирсэн хүмүүсийг буудалд байрлуулах ачаа тээшийг зохицуулах, Номын сангийн байранд зохиолч уншигчдын уулзалт зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- Нийтийн номын сангийн дарга Д.Цэнд-Аюуш Бямба гарагийн 2 өдөр өглөө эцэг эхчүүдэд зориулсан "Соёл гэж юу вэ", "Хүүхдээ номд хөтлөх вэ?", "Гэрийн номын сангаа хэрхэн тохижуулах вэ?" сэдвээр лекц ярилцлага зохион байгуулж нийт 50 гаруй хүн хамрагдсан байна.
- Соёлын бүтээлч сарын ажлын хүрээнд Хутагт ламын Ганданшадүвлин хийдтэй хамтран 108 Данжур хөлгөн судрыг Нийтийн номын санд байрлуулан иргэд олон нийтэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж нийт 70 гаруй хүн оролцлоо.
- Соёлын бүтээлч сарын хүрээнд Эрдэнэтийн зохиолчидтой хамтран Соёлын төвүүдээр явж иргэдтэй уулзалт зохион байгууллаа. Энэ үеэр Эрдэнэтийн зохиолчдын зохиосон дууг уран бүтээлчид дуулж иргэдэд хүргэсэн. Энэхүү уулзалтад Эрдэнэт хотын 40 орчим зохиолчид оролцсон бөгөөд уулзалтад нийт 591 иргэн ирж хамрагдсан байна.
- "ТЭНГЭРИЙН БИЧИГ" монгол бичгийн бүтээлийн үзэсгэлэнг 14 сургуулийн Одбаяр багшийн болон дугуйлангийн хүүхдүүдийн бүтээлээр аймгийн нийтийн номын сангийн уншлагын танхимд гаргалаа. Тус үзэсгэлэнд Үндэсний бичиг үсгийн өдрийн бүтээлийн уралдаанд шалгарсан бүтээлээс мөн тавигдсан байна. Үзэсгэлэнгийн үеэр монгол бийрийн бичиг сонирхогч хүүхдүүдэд дугуйлангийн сурагчид харилцан бичиж заах ажил хийгдсэн байна.
- Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нацагдоржийн тэмдэгтэн Зохиолч С.Дашдэндэвийн 110 жилийн ойд "Бидний мэдэх зохиолч" АСТ тэмцээнийг ЕБС-ийн 10 дугаар ангиудын дунд зохион байгуулж 11 сургуулийн 65 хүүхэд хамрагдлаа.
- Аймгийн багуудын дунд номын өдөрлөг зохион байгуулж 4 багийн 32 хүн оролцож сонирхолтой танин мэдэхүйн асуулт хариулт, Тата Тунга тэмцээн боллоо.
- **"Орхон аймаг дахь биет болон биет бус соёлын элементүүд, тэдгээрийн өнөө ба ирээдүйн хөгжлийн чиг хандлага"** сэдвийн дор явагдсан эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд 11 хүн материалаа ирүүлж 10 хүн амжилттай оролцлоо. Илтгэлийн уралдааны тэргүүн байрыг 1 сургуулийн түүх нийгмийн ухааны багш Б.Хандмаа, дэд байранд Нийтийн номын сангийн номзүйч Ч.Эрдэнэсувд, гутгаар байранд Маргад сургуулийн багш Г.Мөнгөнчимэг, тусгай байранд ШУТИС-ийн профессор Б.Хээрийнбаатар, 1 сургуулийн Түүх нийгмийн багш Р.Наранбулаг нар орлоо. Тэмцээний шүүгчээр Ази номхон далайн бүсийн өв соёл музейн судлалын холбооны ерөнхийлөгч, Монголын эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгийн тэргүүн доктор профессор С.Хаш-Эрдэнэ, Улс төрийн боловсролын академийн захирал М.Толя, Боловсролын магистр тэргүүлэх багш Б.Өлзийжаргал нар ажиллалаа.

Ном уншилтыг сайжруулах чиглэлээр

Бага дунд ахлах ангийн сурагчдын дунд ном уншилтыг сайжруулах тэдэнд эртний зохиолчдын уран бүтээлийг таниулах үүднээс Үндэсний номын баяр бусад СОНА-ыг зохион байгуулахдаа тэгш ой тохиож байгаа зохиолчдын намтар уран бүтээлээс нэг зохиолыг сонгон авч асуулт хариултын уралдаан, илтгэлийн тэмцээн, бага насны хүүхдүүдийн дунд "Аавтайгаа уншсан миний ном" өдөрлөг, "Дараагийн хуудас" цаг хөтөлбөрийг зохион байгуулж аймгийн "Соёлыг түгээе","Соёлын бүтээлч сарын аян"-ы хүрээнд зохиолч уншигчдын уулзалтыг багуудын иргэд хүүхдүүдэд, Соёл гэж юу вэ?, Хүүхдээ номд хөтлөх?, Гэрийн номын сангаа хэрхэн тохижуулах вэ? лекцийг эцэг эхчүүдэд хийсэн байна. Хүүхдийн уншлагын танхимын " Дараагийн хуудас цаг хөтөлбөр" ажлыг хүүхдүүдийн ном унших дадлыг сэргээхэд чухал ач холбогдолтой байдаг.

Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал

Аймгийн хэмжээнд номын сангийн үйлчилгээг нийт ойрын алслагдсан бүхий л нэгжээр хүргэхийн зэрэгцээ баруун буюу хорооллын алслагдсан чиглэл рүү 3 соёлын төв, зүүн талын тосгон, говил, Жаргалант сумын 3 соёлын төвийн номын сангийн үйлчилгээг хүргэж байна. Баг сумын соёлын номын сангуудад ном зөөврөөр олгох тэдний явуулж байгаа СОНА-д оролцож хамтран зохион байгуулах тэдэнд ажлын арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг мэтээр ажлыг зохицуулсан байна.

Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх

Энэ онд аймгийн ЕБС, албан газрын ажилтан албан хаагчдад зориулсан 82 удаагийн 1754 номоор зөөврийн номын сангийн үйлчилгээ хийж 2516 хүнд хүргэж үйлчилсэн байна. Энэхүү зөөврийн үйлчилгээг сургууль, соёлын төвийн номын санчид авч өөрсдийн сургуулийн хүүхдүүдэд уншуулах ажлыг зохион байгуулдаг. Харин гэрээр олгох танхимаас төлөвлөгөөт ажлын дагуу тухайн байгууллага дээр 5 өдрөөр төрийн 14 байгууллагын 224 хүнд шинээр номын сангийн уншигчаар бүртгэн 191 хүнд 188 ном олгож үйлчилсэн байна. Энэ ажлыг хийх явцдаа 13 байгууллага дээр монгол бичгээр "Алтан хонх" тэмцээнийг зохион байгуулж шалгарсан хүмүүсийн дунд "Үндэсний бичиг үсгийн баяр"-аар финалийн шатыг зохион байгуулж шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Тэргүүн байранд Э.Эрдэнэбат ОБГазар, Дэд байранд П.Алтанжаргал МХГ, Гутгаар байранд О.Эрдэнэбулган БӨ сумын ЗДТГ, Тусгай байранд Д.Болортунгалаг МХГ-ын албан хаагчид тус тус байр эзэллээ.

Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

Аймгийн статистик тоон үзүүлэлтээр нийт 37200 гаруй хүүхэд байдаг ба үүнээс номын сангаар давхардсан тоогоор нийт 56000 хүүхдэд ном унших тэдний дунд СОНА болон бусад үйл ажиллагааны үйлчилгээ үзүүлсэн байна.

Номын сангийн 1-7 ангийн хүүхэд үйлчилдэг уншлагын танхим нь 30 суудалтай нэг танхимаар үйлчилгээ хийдэг бөгөөд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд анги бүлгээрээ номын сангийн уншлагын танхимаар үйлчлүүлэх ажил хийгдэж 61 удаагийн 61 бүлгийн 1937 хүүхдүүд хамрагдсан байна. Аймгийн "Соёлыг түгээе" аяны хүрээнд ЕБС-ийн 14 сургуулийн 8-10 ангийн 497 хүүхдийг номын сангийн уншигчаар бүртгүүлэн картжуулах номын санд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Энэ жил хүүхдийн Янзага зусланд амарч байгаа 70 гаруй хүүхдүүдэд ном уншлага зохион байгуулж асуулт хариулттай буухиа тэмцээн, зуны зугаатай аяллыг

Ном сайн уншдаг хүүхэд багачуудыг урамшуулах зорилгоор Тэргүүний уншигч анги хамт олноор 7 сургуулийн 6 анги шалгуулснаас "Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн" болзолыг хангаж 15 сургуулийн Д.Одсүрэн багштай 5а анги, 20 сургуулийн Н.Соёлэрдэнэ багштай 3а анги,12-р сургуулийн С.Хишгээ багштай 3е анги шалгарсан байна. Эдгээр шалгарсан ангиуд нь хамт олноор номын тэмдэглэл хөтлөх, Д.Нацагдоржийн намтар уран бүтээлийг уншиж судлан өөрсдийн

ойлгоцоор зургаар идэрхийлэх эскиз бүтээх, үлгэрийг бодит зүйлээр хийж бие биендээ ярьж дүрийн тоглолт хийх зэрэг сонирхолтой олон ажлыг зохион байгуулсан бол Тэргүүний уншигч Д.Нацагдож тэмдэгтэн хүүхдээр 21 сурагч шалгарчээ.

Жич. Оны нийт уншлага үйлчилгээ СОНА-д хүүхдэд зориулсан үйл ажиллагаа давхар орсон болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ

Номын сангаас зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрээр ном олгох, гэрт нь ном хүргэж өгөх ажлыг зохион байгуулж байна. Ном хүргэлтийн ажлыг хийхдээ багийн судалгаанаас авч хийдэг болно. Энэ онд 66 удаа 114 номоор үйлчилсэн ба үүний 44 удаагийн өөрсдөө ирж үйлчлүүлэн 22 удаагийн гэрт нь хаягаар өгч үйлчлүүлсэн байна.

Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн

Номын сангийн үйлчилгээг уламжлалт маягаар явуулахын зэрэгцээ олон төрлийн үйлчилгээний хэлбэрүүдийг зохион байгуулж уншигч хүүхдүүдэд нөлөөллийн ажил зохион байгуулдаг. Соёл урлагийн цогцолборын хөөмийч М.Саруултөгстэй хамтран” Монгол Жангар” тууль хайлах хэлбэрээр эвтэй найртай амьдрах , нөхөрлөх, эх нутгай хайрлан хамгаалах зэрэг хүмүүжлийн ач холбогдлыг өсвөр үе, хүүхэд багачууд олон нийтэд ойлгуулах өв соёл, уламжлал түүх, ёс заншлаа танин мэдэх, сэргээх, бахархах түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн ЕБС-ийн 8-11 ангийн 5 сургуулийн 280 гаруй сурагчдад сургалт лекц зохион байгуулж тууль хайлах хэлбэрээр сурталчлах ажил хийлээ.

Ахлах ангийнханд зориулан "Мэргэжил бүхэн сайхан-Мэргэжил сонголт" болон "Харилцаа хандлага-Зөв хооллолт" сэдвээр хийсэн уулзалт ярилцлага маань амжилттай болж заал дүүрэн хүүхдүүд хамрагдлаа. Уг арга хэмжээнд Номын төвийн УҮАД-Н.Отгонцагаан, Биотехнологич, "NEWDAY" фитнесс клубын багш дасгалжуулагч А.Батцэнгэл нар ментор хийлээ. Мөн 5 сургуулийн 10-А анги хамт олноороо хүрэлцэн ирж уншигч болцгоолоо

Дэлхийн ДОХ-ын өдрөөр ахлах ангийн сурагчдад аймгийн ЭМГ, Улаан загалмайн хороотой хамтран “Өсвөр насныхны сэтгэлзүйн асуудал”,” Хүн бүр оролцоё”, лекц сургалтыг зохион байгуулж 160 гаруй хүүхэд хамрагдлаа.

Хүүхдийн амралтыг зөв зохистой өнгөрүүлэх зорилгын хүрээнд зуны уншигч хүүхдүүдээ 8 сард Ар мэргэний уулын аманд /12 хүүхэд хамрагдав/ дагуулан агаар салхинд гаран хүүхдүүд маань чөлөөт уншлагыг хийн нэг нэгэндээ өөр өөрсдийн уншсан номынхоо утгыг ярилцаж бусдад аа мэдээлэл өгч, номын санч эгч нь үлгэр уншиж өгөхийн зэрэгцээ хүүхдүүдийнхээ дунд хөгжөөнт таавар тэмцээнийг зохион явууллаа.

Аймгаас 70 км зайд орших хүүхдийн Янзага зуслангийн амрагч хүүхдүүдэд номоор үйлчлэн танин мэдэхүйн хөгжөөнт буухиа асуулт хариултын тэмцээн зохион байгуулж 70 гаруй хүүхэд хамрагдсан байна.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн уйл ажиллагаанд лавлагаа номзуйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар

1. Эрдэнэт хотын анхны тогтмол хэвлэл болох “Эрдэнэт” сонинд 1976-1990 оны хооронд хэвлэгдсэн нийтлэлүүдэд нэр төрөл, он дараалын судалгааг хийж, нийтлэл тус бүрээр карт бичсэн нь лавлагаа номзүйн үйлчилгээг хялбарчилсан нэг ажил боллоо.
2. Эрдэнэт хотын түүхтэй холбогдолтой 4 ширхэг ном цахим хэлбэрт оруулсан нь эрдэнэт хоттой холбоотой ном хэвлэлийн лавлагааг цахимаар авах боломж бүрдсэн.

3. Гэрээр ном олгох танхимд ZOTERO программ суулгаж өдөр тутмын сониноос орон нутгийн номзүйг түүвэрлэн бичиж эхэлсэн нь уншигч хэрэглэгчдэд лавлагаа өгөх үйлчилгээг боловсронгуй болгон ажиллаж байна.
4. Номын танилцуулга, шинэ номын мэдээг QRcode ашиглан мэдээлэл авах боломжтойгоор бэлтгэн цахим болон цаасан хэлбэрээр нийт уншигч, хэрэглэгчдэд хүргэх ажлыг тогтмол хийж байгаа бөгөөд уг кодын тусламжтайгаар электрон каталогит шууд хайлт хийх боломж бүрдсэн нь каталогит хандах иргэдийн тоо өсөн нэмэгдэх боломж бүрдсэн.

"Номын цахим хэлэлцүүлэг" блогийг цахим хаягаараа дамжуулан live хийж нийт иргэдэд тогтмол хугацаанд байнга хүргэж ажиллаа. 2022 онд нийт 12 дугаар хийсэн үүнээс МУБИС, Баянхонгор аймгийн нийтийн номын сантай хамтарсан ба номонд дуртай идэвхтэн уншигчдын төлөөлөлийг зочноор урьж хамтран хийж, номын тухай яриа өрнүүлсэн байна. Мөн үндэсний номын баярын өдрүүдийг жил бүр уламжлал болгон тэмдэглэхэд идэвх зүтгэл гарган оролцдог сургуулийн сурагч, захирал, Д.Нацагдорж тэмдэгтэн сурагч, зохиолч, номын санч болон уншигчдын төлөөлөлтэй номын тухай ярилцлага нийт 6 удаа хийсэн.

"Төрийн шагналт зохиолчид" цувралыг нийт 37 зохиолчын намтар уран бүтээл болон төрийн шагнал хүртсэн бүтээлийг нь эмхтгэн видео хэлбэрээр нийт иргэдэд зориулан бэлтгэсэн. Тэгш ой нь тохиож байгаа зохиолчдын намтар уран бүтээлийг ЕБС-н сурагч, багш, номын санч нарт сурталчлан хамтран ажилласан. Тэмдэглэлт үйл явдалтай уялдуулан мэдээлэл номзүйн үйлчилгээг цахимаар байнга хүргэн ажиллаа.

2022 онд шинээр ирсэн 296 ширхэг ном хэвлэлийн картыг Lib4U программаас 2% хэвлэн гаргаж каталогийн шүүгэнд төрөл анги болон үсэг дараалаар байршуулсан ба 1% танхимууд болон салбар номын санд хүлээлгэн өгч тус тусын каталогит байршуулсан.

Танхимын номын санчдын боловсруулсан номзүйн бүртгэлтэй танилцан, номзүйн бичилтийг стандартын дагуу хийсэн эсэхт зөвлөгөө өгсөн.

Шинэ номын мэдээ, номын танилцуулга болон ZOTERO программд сонин шивж оруулах зэрэг ажилд номзүйн бичилтийг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

ТАВ. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг соёлын төв болон музейтэй хамтран соёлын биет өвийн судалгаа, соёлын биет бус өв тээгчдийн судалгааг авч нэгтгэсэн нь аймгийн хэмжээнд байгаа өв тээгчдийн судалгааг гарган, лавлагаа авахаар ирсэн иргэдэд лавлагаа өгөхөд хялбар болсон.

1. МУ-ын гавьяат зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойд зориулсан намтар номзүй
2. СГЗ, зохиолч С.Дашдэндэвийн 125 жилийн ойд зориулсан намтар номзүй
3. Монгол ардын үлгэрээр бүртгэн мэдээлэх номзүй
4. Эрдэнэт хотод хэвлэгдэн гарсан ном хэвлэлийн бүртгэн мэдээлэх номзүй /1976-2022 он/
5. "Эрдэнэт" сонины 1976-1990 оны хооронд нэр төрөл, он дараалын судалгаа болон соёл, урлагийн талаар нийтэлсаэн зүйлийн судалгааг эрхлэн гаргасан.
6. Монголын соёл урлаг судлалд "Эрдэнэт" сонины судалгааны талаарх өгүүлэл хэвлүүлсэн.

Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг соёлын төв болон музейтэй хамтран соёлын биет өвийн судалгаа, соёлын биет бус өв тээгчдийн судалгааг авч нэгтгэсэн нь аймгийн хэмжээнд байгаа өв тээгчдийн судалгааг гарган, лавлагаа авхаар ирсэн иргэдэд лавлагаа өгхөд хялбар болсон.

2022 он хүртэл Орхон аймагт хэвлэгдэн гарсан ном хэвлэлийн судалгааг гаргасан. Нийт 214 ном хэвлэгдсэн ба уг судалгааг графикаар үзүүлбэл.

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн Lib4U программын шинэчилсэн үүлэн технологийн суурилсан хувилбарт шилжиж, Компьютерын програм хангамж, мэдээллийн санг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээний жилийн 2,500,0 мянган төгрөгөөр сунгалт хийж, нийт ажиллагсад сургалтанд цахимаар хамрагдлаа

Номын сангийн уншлагын гол ажлын хөнгөвчлөх нэг багаж хэрэгсэл болох barcode уншигчийг өөрсдийн нөөц бололцоогоор 396,0 мянган төгрөгөөр 4 ш төхөөрөмж авсан.

Уншигч хэрэглэгчдийн цахим хэрэглээг хангах үүднээс өөрсдийн нөөц бололцоогоор 829,0 мянган төгрөгөөр 2 ш төхөөрөмж авч 300 метрийн радиуст сүлжээ цацаж 300 хэрэглэгч нэгэн зэрэг холбогдох хүчин чадалтай Номын сангийн орчныг FREE WIFI орчин бүрдүүлэв.

Байгууллага дахь хяналтын камеруудын тоог нэмэгдүүлж гэм хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна. 5ш камер 800.0 мянган төгрөгөөр суурлуулсан ба мөн 2023 онд үргэлжлэн 2 давхарыг бүрэн камержуулна. 9ш камер, Swich 1ш, NVR 1ш, hard 1ш нийт 3.680.0 мянган төгрөгөөр хийгдэнэ. Манай байгууллагаа 2009 оноос эхлэн үйлчлүүлэгч, уншигчддаа PVC пластик barcode-тай уншигчийн үнэмлэх хэвлэн үйлчлүүлсээр ирсэн энэ оноос техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж 1.250.0 мянган төгрөгөөр ID datacard машиныг нэвтрүүлж ажиллаж байна.

ДОЛОО. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын номын санд ажилладаг мэргэжлийн болон мэргэжлийн бус гадаад хэлний танхимын номын санчдад ажлын төлөвлөгөө боловсруулах ном ангиллын чиглэлээр аман зөвлөгөөг 14 удаа, сургууль Аялгуу, Жаргалант соёлын төв, Жаргалант сумын 2 сургуулийн номын санчдад номзүйч Ч.Эрдэнэсувдын хамтаар 5 удаа, Соёлын төвүүдийн номын сангийн үйл ажиллагаанд УҮА-ны дарга Н.Отгонцагаан МХГ-ын байцаагч Биндэрьяа, СУГ-ын хэлтсийн дарга Д.Бэхбилэг нартай 5 соёлын төвийн ажилтай танилцаж номзүйч Ч.Эрдэнэсувдтай 5 удаагийн аргазүйн зөвлөгөө өгсөн байна.

Булган аймагт болсон номын санчдын ур чадвар шалгаруулах сургалт тэмцээнд нийтийн номын сангийн 9 хүн оролцож сургалтанд сууж ур чадварын тэмцээнд шүүгчээр ажилласан байна.

Улаанбаатар хотын Үндэсний номын санд ном, хэвлэл сэлбэн засах практик дадлага хийх сургалтанд номын санч Л.Гантуяа, Г.Мөнхдулам нар суулаа. Энэхүү сургалтыг сэлбэн засалтын тэнхмийн сэлбэн засагч Б.Аймшиггүй, Эрдэнэчимэг нар зааж /сонинг багцлаж үдэх, сэтгүүлийг нэглэх болон номын хавтас солих, урагдсан хуудсыг калькан цаасаар наах , үдэх мөн жанхууг буцалгах/ сургалаа.

Сургалтын давуу тал нь өөрсдөө биечилж, практик дээр номыг засаж, сэлбэж сурсан нь их өгөөжтэй байлаа.

Аймгийн нийтийн номын сангийн мэргэжлийн номын санчдын ахисан шатны сургалтыг “Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа” сэдвээр Улаанбаатар хотын МҮНС-ийн мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга арга зүйч Т.Хайдав, аргазүйч В.Түвшигтогтох нар 2 өдрийн сургалт орлоо. Сургалтанд нийтийн номын сангийн 12 номын санч хамрагдаж номын сангийн уншигчдын хамрагдсан байдлыг судалгааг оршин суугаа хаягаар нь гаргаж практик судалгааг хийж номын санд үйлчлүүлэгсэд холын болон ойрын үйлчилүүлэгч давуу буюу дутмаг байдаг талаар дүгнэлт гарган ажилласан байна.

Улаанбаатар хотын номын сангийн сургагч багш Оюунбилэг, Баяраа нараар аймгийн сургууль, соёлын төвийн номын санчдын дунд 2 хоногийн сургалт зохион байгууллаа. Соёлын төв, сургуулиудын номын санчдад зориулсан сургалт нь номын сангийн салбарт хэрэгжиж буй хууль эрх зүй, стандарт, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэгийг олгох зорилготой юм. явуулж байгаа бөгөөд хоёр өдөр үргэлжилсэн байна.

Тус сургалтад хамрагдаж буй номын санчид сүүлийн хоёр гурван жилийн хугацаанд номын сангийн салбарт нэвтэрч буй шинэлэг зүйлүүдийг сурч байгаагаараа давуу талтай юм.

"Соёл урлаг" сэтгүүлд 2022 оны 2 улирлын дугаарт "Эрдэнэт хотын тогтмол хэвлэлийг цахим болгох нь" сэдвээр номзүйч Ч.Эрдэнэсувдын өгүүлэл, "Номын санч" сэтгүүлийн 2022 оны №01 Уншлага үйлчилгээний албаны дарга Н.Отгонцагааны "Үзүүлэн таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах нь" өгүүлэл тус тус хэвлүүлэн гаргасан байна.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Аймгийн нийтийн номын сан нь 21 хүний орон тоотой уншлага үйлчилгээний номын санч 9, уншлага үйлчилгээний албаны дарга-фондоч-1, номзүйч 1,мэдээллийн ажилтан 1, болон мэргэжлийн боловсон хүчин 12, захиргаа аж ахуйн ажилтан 9 хүн ажилладаг.4 танхим нь 2 ээлжийн номын санчтай амралтын өдөргүйгээр уншлага үйлчилгээгээ явуулдаг. Хүний нөөцийн хангалт сайн. 2023 онд аймагт Хүүхдийн номын ордон шинээр ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байгаа.

Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр аймгийн харилцааны багш Н.Алтанцоож багшаар харилцаа хандлагын чиглэлээр 2 удаа, нийгмийн даатгал, хөдөлмөрийн хуулиар мэргэжлийн байцаагч нарыг урьж 2 удаа сургалт, мэргэжлийн чиглэлээр цахим сургалтуудад хамрагдсан байна. Нийт ажиллагсдад үр дүнгийн урамшууллыг улиралд 30-45 хувиар жилийн эцэст 75 хувиар урамшуулал олгож байгууллагын шилдэг ажилтнаа уншлага үйлчилгээний алба, захиргаа аж ахуйн албанаас тус бүр нэг хүн, шилдэг танхим шалгаруулан нийт 500,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. 2022 онд бид ажиллагсдын компьютер техник хэрэгсэл авах 55,0 сая төгрөгийг аймгаас батлуулсан. .

Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар

ажиллаж номын санчдын ширээ сандал шинэчлэх, ажиллагсдын амрах өрөөг тохижуулах зэрэг ажлыг зорилгоо тавин ажиллана

Мэдээллийн эрин зуун дахь технологийн шинэчлэлт нь уламжлалт номын сангийн үйл ажиллагааны орчинг өөрчлөн шинэчилж, нэг талаас сан хөмрөгийг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй болгох, нөгөө талаас технологийн дэвшил ашиглан хурдан шуурхай үйлчлэх боломжийг номын санд нэвтрүүлэх

- Электрон хэлбэрээр гарах номын тоо өсөхийн хэрээр тэдгээрийг унших, ашиглах, хадгалах хэрэгслүүд шинэчлэгдэн улам боловсронгуй болж уншигчдад олон сонголтууд бий болгох.
- Номын сан хөмрөгт байгаа ганц хувьтай номын жагсаалт, сан хөмрөгт буй цахимжуулах шаардлагатай номын тоо, цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх.
- Цахим мэдээллийн сан үүсгэх техник тоног төхөөрөмжийн судалгаа хийж, техникийн тодорхойлолтын гаргаж нэвтрүүлэх.
- Ном хэвлэлийг цахим хэлбэрт оруулах аргачлалыг нэвтрүүлэх.
- "Цахим ном бэлтгэхэд хэрэглэгддэг программ
    - Дэвтэрчлэн харуулах програмын лиценз
    - Оффис програмын лиценз

- Зурган файлыг текст хэлбэрт шилжүүлэх програмын лиценз гэх мэт лицензтэй программ ашиглах.

9. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

2022 онд 269944,2 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авсанаас өөрийн орлогын биелэлт 6520.8 мянган төгрөг болж Сангийн сайдын 74 дүгээр тушаалыг үндэслэн 6520,8 мянган төгрөгийн давсан орлогыг Номын баярын соёл танин мэдэхүйн ажлын шагнал Нэг удаагийн тэтгэмж 2290,0 мянган төгрөг, Урсгал засвар зардал 3781,4 сая гаруй мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна. Нийт ажиллагсдын цалингийн сан 255 229,5 төгрөгөөр батлагдсанаас үндсэн цалинд 188487,4 төгрөг зарцуулж ур чадвар үр дүн 24346,2 төгрөг, унаа хоолны зардалд 20398,0 төгрөг, илүү цаг, шөнийн нэмэгдэл 2650,8 Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 хавсралтаар орон нутгийн нэмэгдэл 7507,1,0 төгрөгийг тус тус олгосон байна.. Урсгал засвар 2100,0 мянган төгрөг батлагдсаныг байгууллагын дээврийн засвар, дотор хана шат будах, цахилгааны монтаж шинэчлэх зэрэг ажил хийж гүйцэтгэлээ.

10. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Аймгийн ЗДТГ, СУГ-аас зохион байгуулсан нийт соёлын ажилчдын бэсрэг наадамд оролцож эрийн гурван наадамд оролцож Бөхөөр тэргүүн байр, сур харваагаар 2,3 байр, мориор 3,4 байр тус тус орж наадамчин олныг баясгалаа.
- Жил бүрийн 10 дугаар сард тохиодог ахмадыг баярын үеэр Номын сан, номын худалдаанд ажиллаж багаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.
- Байгууллагын дотоод засвар үйлчилгээг өөрсдийн нөөц бололцоогоор хийж тохижууллаа. Үүдний угтах хэсэг болон 2 давхарын коридорын хэсгийг засварлалаа.
- Нийтийн танхимын дээврийн ус зайлуулах трапп бөглөрсөн, баруун хэсгээс дусаал гоождог байсныг аваарын зардлаар 21 орчим сая төгрөгөөр засварлууллаа.
- Соёл урлагийн байгууллагуудын нэгдсэн "Хотын их цэвэрлэгээ" аяныг угтаж Дөмөг захын урд талбай, гуу жалгаас эхлэн Баянцагаан багийн урд рашаан хүртлэх талбайн хог хаягдлыг цэвэрлэхэд оролцлоо.
- Хүүхэд гэр бүл, хөгжлийн газраас зохион байгуулсан “Нэг байгууллага Нэг сайн үйлс”-ийн аянд Номын сангийн залуучууд Хүрэнбулаг багийн хүүхдийн тоглоомын талбайнуудыг угааж, орчны хог хаягдал бохирдлыг цэвэрлэлээ.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигтай болон “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд хавар намрын мод тарилтаар нийт 42 ширхэг модыг сархиа ууланд тарьж хаврын тарьсан моднуудаа цэнэг усалгаа хийлээ.
- Өвлийн улиралд цас орж халтиргаа гулгаа үүсэх нөхцөл бүрдсэн үед байгууллагын ойр орчмын 50 метр газрын цас мөсийг тогтмол цэвэрлэж иргэдийн аюулгүй зорчих боломжийг ханган ажиллаж байна.
- Улаанбаатар хотод болсон Номын сангуудын дундах улсын спортын тэмцээнд гар бөмбөгийн төрлөөр эрэгтэйчүүд мөнгөн медаль, эмэгтэйчүүд хүрэл медаль хүртлээ.
- Оны эцэст номын сангийн салбар болон танхим тус бүрээс 5-10 тэргүүний уншигч хүүхдийг шалгаруулан шагнаж урамшууллаа. Нийт 35 хүүхэд 6 сургуулийн номын санчийг шалгаруулан урамшуулсан байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2021 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. НОМЫН САНГИЙН АЛСЫН ХАРАА ЗОРИЛГО ЗОРИЛТ

Алсын хараа:

Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн уншигчдад бие даан суралцах,боловсрол эзэмших, цахимжуулах, номын санг нээлттэй мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд оршино.

Зорилго:

Уншигч, иргэдэд мэдээлэл, мэдлэг олж авах орон нутгийн оюуны хөгжлийн нээлттэй мэдээллийн төв болох

Зорилт:

Номын сангийн үйлчилгээг хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхтэй мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс "Бүтээлч уншлагын жил" болгон зорилт тавин ажилласан.

ХОЁР. САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Сан хөмрөгт 23202 нэр төрлийн 50732 номтой. Зохион байгуулалтын хувьд: Англи орос номын фонд, Монгол номын фонд төрөл анги, үсэг дараалаар байрлагдсан.

Танхим бүрд ойрын фондтой. /хүснэгтээр/

№	Танхимын нэр	Номын нэр төрөл	Ойрын фондын номын тоо
1.	Үндсэн фонд	19661	42816
2.	Хүүхдийн номын өргөө /салбар/	2001	2653
3.	Хүүхдийн уншлагын Ирээдүй танхим	805	1493
4.	Боловсрол танхим	475	581
5.	Гэрээр ном олгох танхим	2204	2829
6.	Лавлагаа ном зүй	275	360

Фондын сан хөмрөгийг шинээр хэвлэгдэн гарсан шилдэг ном зохиолууд болон иргэд уншигчдын эрэлт хэрэгцээний дагуу санал хүсэлтийг үндэслэн бүрдүүлж, төсвөөр 17668.0 төгрөгний 1425 ш, хандиваар 2273.8 төгрөгний 169 ш, нийт 21576.8 сая төгрөгний 930 нэр төрлийн 1425 номоор фондыг бүрдүүлэн уншлага үйлчилгээнд гаргасан.

Уншигчдын захиалгаар Гэрээр ном олгох танхимд 159, Хүүхдийн номын өргөөнд 161 , Хүүхдийн уншлагын "Ирээдүй" танхимд 12, Боловсрол танхимд 8, Лавлагаа ном зүйн танхимд 7, бүгд 340 номыг фондноос шилжүүлгээр олгож үйлчилсэн.

Номын сангийн танхимуудын тооллогыг хийн, уншигчдын гар дээр удсан,алга болсон номын судалгааг гарган номын санчидтай хамтран бүрдүүлэх ажлыг хийж, дотоод хяналт тавин нийт 100 гаруй номыг эргүүлэн авч ажилласан.

Фондын номонд судалгаа хийж, ашиглагдах боломжгүй сурах бичиг, агуулга хуучирсан урагдаж элэгдсэн 2068.2 төгрөгний 2513 номыг ялган Өмчийн хэлтэст бичиг хүргүүлэн зөвшөөрснөөр фондоос чөлөөлж устгалд оруулав.

Ажилчдын дунд " Хамтдаа хөгжиж хандлагаа өөрчилье" 14 хоногийн аяныг өрнүүлж урагдаж гэмтсэн, хуудас дутуу, хавтас салсан 337 номыг сэлбэн засаж үйлчилгээнд гаргасан.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Хүүхдийн номын өргөө /салбар номын сан/
- Хүүхдийн уншлагын Ирээдүй танхим
- Боловсрол танхим
- Гэрээр ном олгох танхим
- Лавлагаа номзүйн танхим
- Интернэт танхимаар уншигчдад номын сангийн үйлчилгээг танхимаар,гэрээр, цахимаар, зөөврөөр 2012 уншигч, 14801 ирэгсдэд 14893 номоор үйлчилгээ үзүүлж ном соёлын үйлчилгээг хүргэн ажиллалаа.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 6 байгууллагад нийт 301 номоор хүргэж үйлчилсэн байна.

- Политехник коллеж -95
- Хүүхэд гэр бүл хөгжлийн газар-25
- Татварын алба-30
- ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байр- 62
- ЕБ-ын 5 дугаар сургууль-24
- Хүүхдийн уншлагын танхим-65

Уншигчдыг хичээл давтах, ном уншлагаас гадна цагийг үр бүтээлтэй өнгөрөөх хөгжүүлэх зорилгоор даам, шатар, шагайн наадгайнууд тоглох цаг гаргасан.

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдээр цахимаар мэдээлллийг хүргэн номын үзэсгэлэнг тайлбартайгаар уншигчдад сурталчилан 1338 номоор үзэсгэлэн гаргасан байна.

- Номын баяраар-180
- Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Баянгол,Төгрөг,Сант сумдад -500
- Үндэсний бичиг үсгийн баяр -145
- Дэлхийн номын өдөр-215
- “Номын амт” хэлэлцүүлэгт-110
- Монгол бахархал -60
- Өвөрмөц номын үзэсгэлэн-20
- Угийн бичиг-15
- Монгол соёл-25
- Англи номын үзэсгэлэн-50
- Эх үрсийн баяр-18

ДӨРӨВ .СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР”-ыг 2022 оны 09 дугаар сарын 16-ны өдөр Хүүхдийн номын өргөөнд, Бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 11:00 цагт Аюуш баатрын талбайд тэмдэглэн 2 удаа хийсэн ба нийтдээ 600- аад иргэд, 1500 сурагчдыг хамруулсан соёл танин мэдэхүйн ажил боллоо.

Үндэсний бичиг үсгийн баяраа угтан “ Бүтээлч уншлага-2022” аяныг зохион байгуулан 1198 уншигч 8636 ирэгсдэд 8625 ном олгож, уншигчдыг анги хамт олноор нь ном уншуулах, чанга уншлага хийх, номын бүтээлчээр унших арга зүйд суралцах дадал зүйг эзэмшүүллээ.

Номын санд анги хамт олноороо карт нээлгэн уншлаганд хамрагдан хамгийн олон ном уншсан хамт олон,багш нарыг шалгаруулсан байна.

405 ном уншсан Мэргэд цогцолбор сургуулийн Б.Мөнх-Адьяа багштай 5а анги I байр,

375 ном уншсан ЕБ-ын 4 дүгээр сургуулийн Г.Пүрэвжаргал багштай 5д анги II байр,

320 ном уншсан ЕБ-ын 4 дүгээр сургуулийн Н.Нэргүй багштай 7в ангийн хамт олон шалгарсан байна. Нийт 1100 ном уншсан байна.

Ангийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном унших дадал зүйд сургахад сурагчдаа хамгийн их хамруулсан багшийг урамшууллаа.

“Миний уншсан хамгийн сайхан ном” уралдааныг ЕБ-ын сургуулийн 3-5 дугаар ангийн сурагчдын дунд зарлаж, өөрийн уншсан номын тухай хүүхдүүдэд чанга уншлага хийж,номын тухай тойм яриа хийсэн сурагчдыг шалгаруулж дүгнэсэн.

I байр 1-р сургуулийн 5е ангийн сурагч Ариунаагийн Мичидмаа

II байр 1-р сургуулийн 5ж ангийн сурагч Санжаагийн Буяндалай

III байр 4 -р сургуулийн 5д ангийн сурагч Бадамхандын Оюуннасан нар шалгарлаа.

“Миний уншсан ном уран зургаар” уралдааныг ЕБ-ын сургуулийн 6-8 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж,өөрийн уншсан номын тухай уран зургаар зурж илэрхийлж оролцож түрүүлсэн сурагчдыг шагнаж урамшууллаа.

I байр: ЕБ-4 -р сургуулийн 7в ангийн сурагч М. Нацагням “ Мэргэн галуу ба тэнэг мэлхий” үлгэрээр

II байр: ЕБ-4 сургуулийн 7в ангийн сурагч Х. Ням-Очир “Болдогггүй бор өвгөн” үлгэрээр

III байр: ЕБ-4-р сургуулийн 7 в Б. Тэмүүлэн “Хөхөө намжил” уран зургаар шалгарсан байна.

“Миний мөрөөдлийн номын сан” эссээ бичлэгийн уралдааныг ЕБ-ын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион дүгнэлээ.

I байрЕБ-1-р сургуулийн 12 б ангийн сурагч М. Нарансолонго

II байр: ЕБ-2- р сургуулийн 11в ангийн сурагч Н. Уранзаяа

III байр: ЕБ- 4-р сургуулийн 11а ангийн сурагч Б. Даариймаа

Арвайхээр сумын иргэдийн дунд “Оюунлаг гэр бүл” уралдааныг зохион гэр бүлээрээ номын санд ном уншдаг, номын багцаар үйлчлүүлдэг,олон ном уншсан гэр бүлийг дэмжиж ажиллалаа.

I байр 5 дугаар багийн иргэн Энхбаярын гэр бүл 110 ном

II байр 11 дүгээр багийн иргэн Анхжаргалын гэр бүл 104 ном

III байр 13 дугаар багийн иргэн Цэцэгсүрэнгийн гэр бүл 82 ном уншиж, хүүхдүүдэд номын сангийн ач тусыг ойлгуулж,багаас нь ном унших аргад сургаж,чөлөөт цагаа хүүхдүүддээ зориулдаг гэр бүлүүд шалгарсан байна.

Хамгийн олон ном уншиж, номын сангаар байнга үйлчлүүлдэг Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдэгтний болзол хангасан 8 сурагчдыг шагнаж урамшууллаа.

ЕБ-н 1- р сургуулийн 5ж ангийн сурагч Дамдинчоймбол овогтой Буянравжих

ЕБ-н 4-р сургуулийн 4А ангийн сурагч Доржцэндийн Аюурзана.

ЕБ-н 1-р сургуулийн 6д ангийн сурагч Лхавгасүрэнгийн Уранмандах

ЕБ-н 1-р сургуулийн 6б ангийн сурагч Энхбаярын Дөлгөөн

ЕБ-н 2-р сургуулийн 12б ангийн сурагч Амарбаясгалангийн Жавзандулам

ЕБ-н 1- р сургуулийн 12д ангийн сурагч Лхагвабаатарийн Бямбасан

ЕБ-н 2- р сургуулийн 10в ангийн сурагч Э. Оюунтөгөлдөр

Тэмүүлэл эрдэм сургуулийн 9а ангийн сурагч М. Уранчимэг

Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд Монгол улсын их сургуулиас номын санчдын дунд “Монголын нууц товчоо” эссэ бичлэгийн уралдааныг сумын болон сургуулийн номын санчдын дунд зохион нийт 16 эссэ бичвэр ирснээс:

I байр Аймгийн төв номын сангийн Гэрээр ном олгох танхимын номын санч мэдээллийн ажилтан Даваажавын Болортуяа

II байр Нарийн тээл сумын соёлын төвийн номын санч Чагнаадорж Цэцэгжаргал

IIIбайранд: Аймгийн төв номын сангийн санч мэдээллийн ажилтан Осорын Долгормаа нар шалгарлаа.

Шалгарсан эссэг Улсын уралдаанд оролцууллаа.

Хурдан зөв унших уралдааныг 6-7, 8-9 дугаар ангийн сурагчдын дунд аймгийн хэмжээнд зохион нийт 315 сурагч оролцсоноос шалгарсан 92 сурагчийг Хэлний бодлогын салбар зөвлөлийн гишүүд уншуулан дүгнэж:

I байр: Арвайхээр сумын 2-р сургуулийн сурагч Лха. Жанчивдолгор

II байр: Арвайхээр сумын 4-р сургуулийн сурагч Ж. Гэрэлчулуун

III байр: Баруунбаян-Улаан сумын ЕБС-н сурагч Ө.Төгөлдөрмандах

8-9 дугаар ангийн хурдан зөв унших уралдаанд:

1-р байр: Арвайхээр сумын 4-р сургуулийн сурагч З. Сайнбилэг

2-р байр: Арвайхээр сумын ЕБс-н 2-р сургууль Э. Мөнхзул

3-р байр.Өлзийт сумын Ебс-н сурагч Э. Ичинхорлоо нар тус тус түрүүлсэн байна.

"Алдаагүй зөв бичигтэн" уралдаан 6-8 анги

I байранд: Хужирт сумын Б. Мөнхдалай

II байранд: Арвайхээр сумын 2-р сургуулийн И. Энэрэл

III байранд: М. Санжхорол

"Хичээнгүй бичигтэн" уралдаан 10-12 анги

1-р байр: Арвайхээр сумын 4-р сургуулийн сурагч Н. Хандсүрэн

2-р байр: Арвайхээр сумын 2-р сургуулийн сурагч Т. Энхтуяа

3-р байр: Мэргэд лаборатори сургуулийн сурагч Н. Нямбазар

"Цахим монгол бичиг" уралдааныг 10-12 ангийн сурагчдын дунд зохион нийт 36 цахим бичвэр ирснээс:

1-р байр: Хужирт сумын ЕБС-н сурагч Ариунжаргал

2-р байр: Арвайхээр сумын 1-р сургуулийн сурагч Жанцалдиймаа

3-р байр: Арвайхээр сумын 4-р сургуулийн сурагч Солонго нар түрүүлж шагнал авсан байна.

"Уран дүрст бичлэг" уралдаанд нийт 50-аад бүтээл ирснээс 2 дугаар шатанд шүүгчид газар дээр нь номын тухай онч мэргэн үгсийг уран бичвэрээр бичүүлж шалгарууллаа.

I байр: Хархорин сумын багш Ш. Амарбат

II байр: Арвайхээр сумын иргэн М. Даваажаргал

III байр: Баруунбаян-Улаан сумын ЕБс-н багш Л. Гантогтох

__ Мөн монгол хэл бичгийг түгээн дэлгэрүүлэх хамт олноороо суралцах, монгол бичгийн хичээлийг байгууллага дээрээ сайн зохион байгуулсан байгууллагуудыг шалгаруулаа. "ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН" хамт олноор:

-Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

-Арвайхээр сумын 13дугаар цэцэрлэг

Арвайхээр сумын 8 дугаар цэцэрлэгийн хамт олон шалгарч,батламж мөнгөн шагналаар шагнагдсан байна.

Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх,хамгийн олон төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулсан, монгол бичгээр байгууллагуудын хаягийг хийсэн,бусдыгаа манлайлан монгол бичигт сургах олон талт ажлыг зохион байгуулсан Баруун баян улаан, Хархорин,Уянга сумын Засаг даргын тамгын газрыг шагнаж Батламж мөнгөн шагналыг олгосон байна.

Үндэсний бичгээ эрхэмлэгч шилдэг төрийн албан хаагчийг тодруулж, Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан байна.

Үндэсний бичиг үсэг,номын баяраар "Алтан бярга" утга зохиолын нэгдлийн зохиолчидтой хамтран ажиллалаа. Номын баярт хүрэлцэн ирсэн уншигч иргэдэд зохиолч яруу найрагч Д.Эрдэнэбат шинэ номоо танилцуулж,туулийн тухай мэдээллийг олгож,тууль хайлан үзүүллээ.

Яруу найрагч Б.Жаргал "Ерэн намрын шүүдэр" шүлгийн түүврээ танилцууллаа. Мөн БШУ-ны мэргэжилтэн Мөнх-Эрдэнэ уншигч хүүхдүүдэд ном уншихын ач тус, номын клубын сурагчдын танилцуулга хийв.

Үндэсний бичиг үсэг, номын баяраа угтан уншигчдын татгалзлын дагуу 3 удаа шинэ ном авч сан хөмрөг болон танхимуудын ойрын фондыг 8282179 төгрөгний 281 нэр төрлийн 573 ширхэг шинэ номоор баяжуулж,уншигчдад оюуны хөрөнгө оруулалт хийлээ. Мөн шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 280 номоор гаргаж уншигчдад сурталчиллаа.

Хос бичигтэн болох зорилгын хүрээнд Аймгийн төв номын сан нь монгол бичгийн булан байгуулж, 740,0 мянган төгрөгний 38 ширхэг монгол бичгийн номоор фондоо баяжууллаа.

ЕБ-ын 1-р сургуулийн Амарбаяр багштай 6а ангийн хамт олон номын сантай хамтран "Номтой аялал" явган аяллыг зохион ном уншиж ,танин мэдэхүйн АХА тэмцээн зохиолоо. Мөн аман өвийг сурталчилж, "Зүйр цэцэн үгийг хэн сайн мэдэх вэ" тэмцээнийг зохиож, шалгаруулсан байна.

"Өвөрхангайн соёлын өдрүүд" нэгдсэн арга хэмжээг Төгрөг, Баянгол, Сант сумдад ажлын хэсгийн 6 хүний бүрэлдэхүүнтэй номын сангийн үйлчилгээг хүргэх, зөөврийн номоор үйлчлэх, үндэсний бичиг соёлыг сурталчилж нийт 1215 иргэд,хүүхэд залуучууд номын сангийн үйлчилгээнд хамрагдаж, соёл олон нийтийн ажилд оролцлоо.

Номын санд хамгийн олон уншигдсан зохиолчдын номыг сурталчилж мэдээлэл хүргэн ажиллаа. Төрийн шагналт,Ардын уран зохиолч Д.Төрбат, Соёлын гавьяат зүтгэлтэн

Б.Сарантуяа, Зохиолч Б.Шүүдэрцэцэг , зохиолч Б.Мягмартогтох, зохиолч Б.Баярхүүгийн оюуны бүтээлүүд болох нийтдээ 81 номоор тайлбартайгаар үзэсгэлэн гаргасан.

- Монголын түүх соёл
- “Эзэн Чингис хаан”
- “Угийн бичиг”
- “Монгол бичгээрээ уншья”
- “Үлгэрийн орноор” хүүхдэд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүдийг 130 номоор гаргасан.

Үндэсний бичиг соёлыг сурталчилах ажлын хүрээнд ахлах дунд ангийн сурагчдын дунд “Алдаагүй цэвэр сайхан бичигтэн” уралдааныг монгол хэл уран зохиолын багш нартай хамтран явууллаа. Нийт 85 сурагч оролцож, амжилттай оролцсон 9 сурагчдад шагнал гардуулсан.

Бага ангийн сурагчдын дунд аман өвийг сурталчилж,тайлбар хийн, оньсого зүйр цэцэн үгийн тэмцээнийг явуулж нийт 46 хүүхэд оролцсон.

Мөн хүүхдүүдэд чанга уншлага хийж, уншсан номын талаар харилцан ярилцлаа.

Танин мэдэхүйн Алтан хонх тэмцээнийг 3 удаа явуулж, нийт 161 сурагчид оролцсон.

“Номын амт” уулзалт хэлэлцүүлэгт хүний хөгжил,монгол бичиг, уран зохиолын шинэ номоор үзэсгэлэн гаргаж, угийн бичгийн апп танилцуулга хийн, 300 хүүхэд оролцсон.

2022 ОНЫ “ОНЦЛОХ АЖИЛ”

Нэг. Монгол банктай хамтран санхүүгийн боловсрол олгох мэдээллийн булан байгуулж, Хаан банк, Хас банк, Төрийн банк, Голомт банк хамтран уншигчдад мөнгөний үнэ цэнэ сургалт хэлэлцүүлэг хийж, 170ш ном, тавиур өгч номын санд хандивлалаа.

Хоёр. 2025 оноос хос бичигтэн болох зорилгын хүрээнд төрийн албан хаагч, иргэд,уншигчдад зориулсан Монгол бичгийн санг 100 гаруй номоор баяжуулан, уншигчид хэрэглэх нөхцлийг бүрдүүлж чөлөөт сонголтоор байрлуулсан. Монгол бичгийн номуудыг цувралаар цахим орчинд сурталчилах ажлыг хийж 25 номын мэдээллийг оруулаад байна.

Гурав. Танхимуудын ойрын фондын номонд тооллого хийж, уншигчдад зориулсан номын тавиуруудыг шинээр хийж,тохижилтыг сайжруулсан.

Дөрөв. Сумын болон сургуулийн номын санчдыг чадавхжуулах, ажлын байранд хөгжүүлэх зорилгоор “Бүтээлч номын санч” уралдааныг зарлан дүгнэлээ.

Тав. “Өвөрхангайн номын санчид” дурсамж уулзалт зохион байгуулж, хүндэтгэл үзүүллээ. Мөн сургуулийн болон сумын номын санчдын төлөөлөл 18 хүн оролцож ажлын туршлага, ажиллаж байсан үеийн дурсамж сэтгэгдлээс хуваалцсан.

Зургаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд брайль үсэг сурах 14 хоногийн сургалтыг аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран сургалтанд 18 хүн хамрагдсан болно. Брайль 67 номоор фондоо баяжуулсан.

Долоо. “Уншаад урагшлая” хотхон байгуулан шинэлэг үйлчилгээг нэвтрүүлсэн.

ТАВ. ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022-оны 01 сарын 10-наас эхлэн 02 сарын 01 –ны дотор өөрийн фондонд хадгалагдаж буй Хөдөлмөрийн төлөө сонины

-1958-1979 оны 21 нэгж

-1981-1987 оны 7 нэгж

-1989 оны 1 нэгж 9012 ширхэг сонины зургийг авч цэвэрлэн, Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа мэдээллийн цахим санд оруулахад бэлтгэж байна. Нийт 1206 ширхэг сонины нүүрийг засварлаж цэвэрлэн цахимд оруулахад бэлэн болголоо.

2022 онд шинээр ирсэн 930 нэр төрлийн 1425 ширхэг номыг дагалдах баримттай нь тулгаж хүлээн авч нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэсэн.

Номонд ангилалт хийн стандартын дагуу техник ажиллагааг хийж электрон каталогит оруулан мэдээллийн сан үүсгэж фондонд хүлээлгэн өгсөн.

Уламжлалт цаасан каталогийн картыг үүсгэж, стандартын дагуу засвар хийж хэвлэхэд бэлтгэгдэж байна.

МҮНС-ийн Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд “Улирал ба зохиолч “ сэтгүүлээс I. II. III улирлын 143 мэдээлийг оруулж цахим мэдээллийн сангийн серверт байршуулж байна.

Номын сангийн уншигчдад 1501 лавлагааг өгч үйлчиллээ.

Мөн электрон каталогиос уншигчдын эрэлт хүсэлтийн дагуу 1566 хайлт хийж өгсөн ба уншигчдад каталогиос ном хэрхэн хайх талаар зөвлөгөө өгч ажилласан.

Шинээр карт нээлгэсэн 914 уншигч, эрх сунгуулсан 172 уншигчийн мэдээллийг “lib4u” программд бүртгэж, Гэрээр ном олгох танхим, Боловсрол танхим,Хүүхдийн уншлагын Ирээдүй танхимд шилжүүлэн ажилласан.

Уншлага үйлчилгээнд гарч бар код хуучирч, кодгүй болсон 71 ширхэг номыг дахин коджуулж үйлчилгээнд гаргасан.

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн төв номын сан нь 2010 оноос үйл ажиллагаандаа “Волвес” компанийн “lib4u” цогц программыг авч хэрэглэсэн бөгөөд 2017 оноос дэвшилтэт хувилбар болох интернэтэд суурилсан “Үүлэн технологи” нэвтрүүлэн 7 танхимаар нэгж болгон үйлчилгээндээ ашиглаж байна.

Сумдын номын сангуудыг техник технологийн шинэчлэл хийж Аймгийн соёл урлагийн газарт хүсэлт тавьж компьютержүүлж 17 номын санд программыг нэвтрүүлж “Номын сангийн нэгдсэн мэдээллийн систем”-д нэгтгэх зорилт тавин ажиллаж байна.

Бүх нийтийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор бүх танхимаас **Өвөрхангай төв номын сан** хуудсанд байршуулж, нийт 392 мэдээлэл 6580 хүнд хүргэн ажилласан байна. 270 цахим номтой уншигчдад үйлчилж байна.

Постер болон видео шторк хэлбэрээр цахим орчиноор дамжуулан иргэдэд хүргэх ажлыг идэвхитэй хийж, бүх нийтэд нөлөөлөх нөлөөллийг сайжруулсан мөн **Соёлын өв хөгжлийн дархлаа** page хуудас маань 24,319 like, 27.000 дагагчтай болсон.
Монгол түгээмэл ёс заншлын тунгаамал өв

- Титэм үг
- Мэргэн ухааны цагаан толгой
- Эрдэнийн сан субашид
- Бодь мөрийн зэрэг
- Онч мэргэн үг /англи монгол хэлээр/
- 11.12 дүгээр ангийн заавал унших зохиол
- Монгол бичиг
- Ёс заншил
- Шинэ номын мэдээ
- Эрдэм ном,нөхөрлөл,хөдөлмөрийн тухай зүйр цэцэн үг
- Номоо хэрхэн хадгалах зөвлөмж
- Үлгэр
- Сургамжит үлгэр өгүүллэгүүд зэрэг олон мэдээллийг цахим орчинд түгээн уншигчдад сурталчилан мэдээлэл өгч ажилласан байна.

ДОЛОО. АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллаж байна.

“ Хил хязгааргүй номын сан” төслийн хүрээнд номын санчдыг чадавхжуулах сургалтыг хийж, нийт 45 номын санч мэдээллийн ажилтнууд оролцлоо. Мөн 185 ширхэг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн шинэ номыг аймгийн төв номын санд хандивласан.

Аймгийн Соёл урлагийн газартай хамтран Бат-Өлзий сумын номын санд тооллого хийж, зөвлөн туслах арга зүйн зөвлөмжийг өгч 5 хоног ажилласан.

Хайрхандулаан сумын номын санчаар шинээр орсон Дорждуламд биеэр очин ашиглах боломжгүй болсон урагдсан элэгдсэн номуудыг ялган байрлуулж, ангилал,фондын зохион байгуулалт,стандартын талаар зөвлөн туслан 4 хоног ажилласан.

“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Баянгол, Төгрөг, Сант суманд ажиллаж, сум сургуулийн номын санд арга зүйн зөвлөгөө өглөө.

Сумын номын санг шинэ техник хэрэгсэлтэй болгох, номын санчдыг чадавхижуулах хүрээнд компьютерээр ханган, “Волвес” ХХК тай гэрээ байгуулан “Lib4u” программ суулган сургалт зохион байгуулсан.

Баруунбаян-Улаан, Хархорин, Бат-Өлзий, Есөнзүйл, Баянгол, Уянга сумын номын санчдад Lib4u программ дээр хэрхэн ажиллах талаар зөвлөгөө өгч дадлага хийлгэлээ.

Нийт 48 номын санч мэдээллийн ажилтнуудад арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажилласан байна.

- Номын сангийн ангилал
- Электрон каталоги зохион байгуулалт
- Номзүйн бичилтээр ном тодорхойлох
- Номын сангийн программ дээр хэрхэн ажиллах
- Ажлын байрны тодорхойлолт
- Байнгын уншигч,иргэдийн талаарх ойлголт
- Номын нэг бүрчилсэн бүртгэл
- Нэгдсэн бүртгэл
- Номын сангийн стандарт
- Хүүхдийн ном зохиолоор сан хөмрөгийг баяжуулах худалдан авах зэрэг сэдвээр мэдээлэл хүргэн ажилласан.

Аймгийн төв номын сан нь нийт 14 удаагийн сургалт семинарыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж 532 хүн хамрагдсан. Сургалтыг нэрлэвэл:

- Соёлын байгууллагын үр дүнгийн гэрээ баталгаажуулах сургалт- 25
- “Хил хязгааргүй номын сан” төсөл-45
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Брайл үсгийн сургалт, өдөрлөг-80
- “Уртын дууны өв” сургалт-40
- Ёс зүй харилцаа хандлага сургалт 58
- Төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзах уулзалт-19
- Мөнгөн хуримтлал сургалт-60
- Зохиолч уншигчдын уулзалт- 50
- Номын санч мэдээллийн ажилтны сургалт-20
- Соёлын байгууллагын ажлын үнэлгээ тайлан сургалт-45
- Намайг алгас”сургалт мэдээлэл-13
- “Угийн бичиг” сургалт аймгийн газрын алба -36
- “Угийн бичиг” -ахмадуудад 23
- “Угийн бичиг”-2 дугаар баг 18

Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн баримт бичгийн хүрээнд дүрэм журам, төлөвлөгөө,тайланг зааврын дагуу чанартай, үнэн зөв бодитой гаргах, хариуцсан ажлын чиглэлээр мэдээ баримтыг боловсруулахад анхааран ажиллаж байна.

ДОЛОО . ТӨСӨВ САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Төсвийн тухай шинэ хуулийг мөрдөн ажиллан байгууллагын эрхэм зорилго,үйл ажиллагааны зорилтод тулгуурлан төсөв болон тодотгосон төсвийн сар,улирлын хувиарын дагуу санхүүжилт авч, өр авлагагүй ажилласан. 2022 онд улсын төсвөөс 215880.9 сая, орон нутгийн төсвөөс 71745.2 сая төгрөгийн санхүүжилттэйгээр өр авлагагүй ажилласан. Аймгийн төв номын сан нь 2 номын санч мэдээллийн ажилтан, 1 жижүүр угтагчийн орон тоо шаардлагатай байгаа тул холбогдох соёл урлагийн газарт уламжлан ажиллаж байна.

Үйлчилгээний ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор 755.000 төгрөгний тоос сорогч,шал арчигч 2-ийг авч өгсөн.

Нүүдлийн номын сангаар үйлчлэх ажлын хүрээнд байгууллагын автомашиныг засах мотор боолгох зардалд 1400.0 мянган төгрөгийг урсгал зардлын санхүүжилтаас зарцуулсан.

Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын танхим, ОО-ын өрөөг тохижуулсан.

1. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бичиг хэрэгслээр 324600 хангасан.
2. Интернэт, номын сангийн программ хангамж, байнгын тасралтгүй ажиллагааг ханган ажилласан.
3. Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ 8 ажилтанд ур чадварын нэмэгдэл ,2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэж буй 20 хувийн нэмэгдэл олгон ажилласан.
4. “Өглөөний уншлага” “Номын сангийн ээлжит тооллого” -ын үед ажилласан номын санч ажилтнуудад илүү цагийн хөлсийг олгосон.
5. Албан хаагчдын ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, амжилт гаргасан идэвх зүтгэлийг үнэлэн 5 ажилтанг шагнал урамшилд тодорхойлсноос нягтлан бодогч

Ч.Цэрэннадмид Алтан гадас одонгоор, сан хөмрөгч С.Энхтогтох хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан.

6. Гэр бүлийн гишүүн өвдсөн тохиолдолд цалинтай чөлөө олгосон ба цахимаар ажиллуулсан.
7. Мэдээллийн технологийн ажилтан Даваахүү, Цэрэнпүрэв нарт хүүхдээ асрах аавуудад ажлын 10-аас доошгүй өдрийн цалинтай чөлөөг ажил олгосон.
8. Эх үрсийн баяраар ажилчдын 16 хүртэлх насны хүүхдүүдэд 420.0 мянган төгрөгний хүүхдийн бэлэг олгосон.
9. Ажилчдад сар бүр хоолны мөнгө олгож байгаа бөгөөд 8120.0 төгрөг зарцуулсан.
10. Байгууллагаас тэтгэвэрт орсон ахмадуудад цагааан сар,ахмадын баяраар 300.0 төгрөг, “ Өвөрхангайн номын санчид” уулзалт зохион ахмад номын санчдад 900.0 төгрөг зарцуулж хүндэтгэл үзүүлсэн.

НАЙМ. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголын номын санчдын консорциумаас зохион байгуулсан спортын наадамд 13 хүний бүрэлдэхүүнтэй Аймгийн төв номын сан болон сумын номын санчид ивээн тэтгэж амжилттай оролцлоо.

“Байгалиа хамгаалья” нэгдсэн арга хэмжээнд оролцож, хамт олноороо мод худалдан авч, нийт 33 модыг тарьлаа. Мөн арчилж ургуулах талаар нэгдсэн зөвлөмж авч, усалгаа арчилгааг 3 удаа хийсэн. Мод авахад зориулж 78000 төгрөг ажилчдаас хураасан болно. Мөн байгууллагын урд талбайн ногоон байгууламжийг услах,тордох,цэвэрлэх ажлыг тогтмол хийж байна. Орчны бохирдлыг бууруулах олон нийтийн арга хэмжээнд 2 удаа гарч хамт олноороо хог цэвэрлэсэн.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Уншлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх номын сангийн соёл танин мэдэхүйн ажлын чанарыг сайжруулж иргэдийн оролцоог хангах тал дээр анхаарч ажиллаа.

1. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Үзүү-лэлт	Хүүхдийн уншлагын танхим	Нийтийн уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Мэдээллийн төв	Сан хөмрөг	Зөөврөөр	Цахим	Нийт
Уншигч	1506	950	218	160				**2834**
Ирэгсэд	4973	2794	2782	292	224	5485	33482	**50032**
Ном олголт	11143	3386	4148	564	824	3788	33482	**57335**

2. УРИЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүүхэд багачуудыг ном уншлагад татах, номын сангаар үйлчлүүлэх соёлыг төлөвшүүлэх анги хамт олны урилгат үйлчилгээнд анги хамт олныг хамруулан ажиллаа. Үүнд: ЕБСургуулиудын 36 анги, СӨБ-ийн 21 бүлгийн нийт 1672 хүүхдийг хамруулж 2234 ном олгож үйлчиллээ.

3. ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /80 удаа 5299 ирц 4219 ном олголт/

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг сургуулиудад / 7 удаа 804 ирцэд 1078 ном олголт/

1. III/04. Өмнөговь аймгийн Улсын тэргүүний лаборатори 1-р сургууль 194 ном, 162 хүүхэд
2. III/10."Оюуны мэлмий" 4-р сургууль 170 номоор 163 хүүхдэд
3. III/15. 2-р сургууль 186 ном, 156 хүүхдэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
4. III/30. 3-р сургууль 185 ном, 171 хүүхэд
5. IV/28. Даланзадгад сумын төрөлжсөн сургалттай биеийн тамир спортын 7-р дунд сургуулийн нийт 57 сурагч багш нарт 84 номоор номын сангийн үйлчилгээ үзүүлж “Өмнөговь нутгийн бахархал” аяны хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэсэн.
6. X/14. Политехникийн коллежийн "Суралцагчдад зөвлөн туслах" өдөрлөгт мэргэжлийн болон шинэ номоор үзэсгэлэн гаргаж уншлага үйлчилгээ хүргэн ажиллаа. (30 ном 150 хүн)
7. XI/04. 5-р сургуульд нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр 38 номоор 74 хүнд

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг цэцэрлэгүүдэд / 11 удаа 1054 ирцэд 664 ном олголт/

1. **V/17** Даланзадгад сумын 26-р цэцэрлэгийн Буянхишиг багштай Ахлах "Б" бүлгийн 26 хүүхдүүдэд Каталогч М.Баасанжавын хамт 40 хүүхдийн үлгэр болон зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлсэн. Цахим хандалт 340
2. **IX/8-IX/14** Даланзадгад сумын 1-р цэцэрлэгийн Х.Наранцэцэг багштай Бэлтгэл "А" бүлгийн 40 хүүхдүүдэд 28 хүүхдийн үлгэрийн ном болон 15 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлсэн. Цахим хандалтын тоо: 275
3. **IX/16-IX/20** Даланзадгад сумын 2-р цэцэрлэгийн Ахлах, Бэлтгэл бүлгийн нийт 160 хүүхдүүдэд 35 хүүхдийн үлгэр болон 17 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын "Манжин" үлгэрээр аялуулсан.Цахим хандалтын тоо: 73
4. **X/06** 23-р цэцэрлэгийн Ахлах, Бэлтгэл бүлгийн нийт 64 хүүхдүүдэд 48 үлгэрийн ном болон 28 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын үлгэрээр аялуулсан. Цахим хандалтын тоо: 137
5. **X/07**24-р цэцэрлэгийн Ахлах, Бэлтгэл бүлгийн нийт 88 хүүхдүүдэд 45 үлгэрийн номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын үлгэрээр аялуулсан. Цахим хандалтын тоо: 244
6. **X/12** 4-р цэцэрлэгийн Ахлах, Бэлтгэл бүлгийн нийт 130 хүүхдүүдэд 50 үлгэрийн ном болон 12 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын үлгэрээр аялуулсан. Цахим хандалтын тоо: 117
7. **X/17** 8-р цэцэрлэгийн Ахлах, Бэлтгэл бүлгийн нийт 134 хүүхдүүдэд 55 үлгэрийн ном болон 20 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын үлгэрээр аялуулсан. Цахим хандалтын тоо: 204
8. **XI/04** 5-р сургууль дээр нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр нийт 61 номоор уншлага үйлчилгээ үзүүлж, 19 сурагчидад уншигчийн карт нээж, 6-с дээш ангийн 20 сурагчидын дунд танин мэдэхүй АХА тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 74 сурагч, багш, ажилчид хамрагдсан. Цахим хандалтын тоо: 191
9. **XI/9** 9-р цэцэрлэгийн Дунд, Бага бүлгийн нийт 58 хүүхдүүдэд 43 үлгэрийн ном болон 12 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын үлгэрээр аялуулсан. Цахим хандалтын тоо: 179
10. **XI/23** Соёлын сарын хүрээнд нүүдлийн номын сангаар Цогт-цэций сумын 7-р цэцэрлэг, 30-р цэцэрлэгийн нийт 280 хүүхдэд 75 үлгэрийн ном болон Хормогчин театрын үлгэрээр хүрч үйлчиллээ.

11. **XII/9**25-р цэцэрлэгийн Ахлах, Бэлтгэл бүлгийн нийт хүүхдүүдэд 50 үлгэрийн ном болон 10 англи зурагт номоор уншлага үйлчилгээ үзүүлж, хормогчин театрын үлгэрээр аялуулсан. Цахим хандалтын тоо:

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг байгууллагуудад /17 удаа 845 ирцэд 825 ном олголт /

1. I/19 Эрүүл мэндийн газарын хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 44ш номоор 26 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
2. I/20 “Ус цаг уур”-ын хамт олонд 36ш номоор 34ирцэд 9 карт нээсэн.
3. II/16 “Аймгийн ахмадын чөлөөт холбоо”-ны хамт олонд 50ш номоор 46 ирцэд 5 карт нээсэн.
4. II/29 “Зэвсэгт хүчний 0167-р” ангийн хамт олонд 110ш номоор 163 ирцэд уншлага үйлчилгээээ үзүүлсэн.
5. VI/08 Цэргийн гавьяаны одонт Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн хамт олонд 100ш номоор 98 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
6. VII/02 "БУЯНТ" зусланд амрагч хүүхэд багачуудад зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэн АХА тэмцээн зохион байгууллаа. Ирц-115
7. IX/21Өмнөговь аймаг дахь цагдаагийн газарын хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 50ш номоор 31 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
8. IX/05 ШШГГазрын хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 35ш номоор 21 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
9. X/12 Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 30ш номоор 27 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
10. X/14 9-р цэцэрлэгийн хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 30ш номоор 16 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
11. X/14 Политехникийн коллежийн сурагчдад зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 20ш номоор уншлага үйлчилгээ үзүүлсэн.

12. X/20 Музейн хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 30ш номоор 13 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
13. X/24 ГБХЗХГазрын хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 30ш номоор 14 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
14. X/25 Нутгийн удирдлагын ордны хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 50ш номоор 31 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
15. XI/02 0131-р ангийн цэргүүд болон ажилчдад зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 70ш номоор 64 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
16. XI/08 0167-р ангийн цэргүүд болон ажилчдад зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 100ш номоор 120 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн
17. XI/23 Биеийн тамир спортын газрын хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 40ш номоор 26 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг сумдад /13 сумын 1711 ирцэд 1074 ном олголт /

Хөдөөгийн иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэж, шинэ ном хэвлэлийг танилцуулах Нүүдлийн номын сангийн үйлчилгээг 13 суманд хүргэн 1711 ирцэд 1074 ном олгож үйлчилсэн. Нүүдлийн номын сангийн үйлчилгээний хүрээнд сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн,цэцэрлэгийн болон сургуулийн бага ангийн сурагчдад Хормогчин театрын үзүүлбэрээр үйлчиллээ.

Түүнчлэн “Номын баярын” хүрээнд сумдад бага насны хүүхдийн уншлага үйлчилгээнд хэрэглэгдэхүүн болгох 2 төрлийн “Хормогчин театр”, хандиваар цугласан номуудыг хүлээлгэн өглөө.

1. IX/22. Хүрмэн сум
2. IX/23. Булган сум
3. X/5. Ханхонгор сум
4. X/12.Ноён сум
5. X/13. Гурвантэс сум
6. X/14.Сэврэй сум

7. X/21. Баяндалай сум

8. X/26.Ханбогд сум
9. X/27. Баян-Овоо сум
10. X/28. Номгон сум
11. XI/7. Цогт-Овоо сум
12. XI/8. Манлай сум
13. XI/23. Цогтцэций сум

Зөврийн номын сангийн үйлчилгээ /7 байгууллагад нийт 32удаа 578ш номоор 885 ирцэд үйлчилгээ үзүүлэв/

4. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Иргэдийн ном унших идэвхийг өрнүүлэх, соёлын түвшинг дээшлүүлэх, хүүхэд залуучуудын авьяас чадварыг хөгжүүлэх, нээн илрүүлэх зорилго бүхий 68 соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулж 25292 хүнийг хамрууллаа.
Үүнд:

4.1. “МИНИЙ ОРОН ЗАЙ”номын нээлт /I/14/

МЗЭ-ийн Өмнөговь аймаг дахь салбарын гишүүн, "Эгшиглэнт говь" наадмын тэргүүн яруу найрагч Тэрбишийн Энх-Эрдэнийн "МИНИЙ ОРОН ЗАЙ" номын нээлтийг Өмнөговь аймаг дахь МЗЭ-ийн салбартай хамтран зохион байгууллаа.Нээлтийг цар тахлын дэглэмийг баримтлан зохион байгуулж цахимаар олон нийтэд хүргэв. Оролцогч 36

4.2. “ҮЛГЭРИЙН ЦАГ” чанга уншлага /II/15-III/29/

Хүүхэд багачуудыг үлгэрээр дамжуулан ном унших хүсэл сонирхолтой болгох МАА-ын үлгэрээр хөгжүүлэх зорилгоор уг арга хэмжээг 5 удаа зохион байгуулж 132 хүүхдийг хамруулан чанга уншлага хийж 195 үлгэрээр үйлчилсэн байна.

1. II/15. 32 ном, 23 хүүхэд
2. II/18. 45 ном, 27 хүүхэд
3. III/16. 38 ном, 25 хүүхэд
4. III/28. 36 ном, 25 хүүхэд 2-р цэцэрлэг Оюунтуяа багштай бэлтгэл а бүлэг
5. III/29. 44 ном, 2-р цэцэрлэг Мөнхцэцэг багштай ахлах бүлэг 32 хүүхэд, 44 ном

4.3. “ГЭР БҮЛИЙН ҮЛГЭРИЙН ЦАГ” уралдаан /II/28-III/16/

Монгол ардын аман зохиолын төрөл болох үлгэрээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, өрх гэр бүлийн гишүүдийн хамтын уншлага, бүтээлч байдлыг дэмжих зорилготой уг уралдаанд 21 гэр бүл хуруун хүүхэлдэйн жүжигчилсэн тоглолт бүхий видео бичлэгээ ирүүлж оролцсоноос

1-р байр. Ж.Тулгийн гэр бүл
2-р байр. Ө.Мөнх-Эрдэнийн гэр бүл
3-р байр. В.Энхээгийн гэр бүл
Тусгай байр Д.Болдын гэр бүлийг шалгаруулан өргөмжлөл, гэр бүлийн номын сангийн багцаар шагнаж урамшууллаа.

4.4. *“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЯРЫН НОМЫН АЗТАН”цахим азтан шалгаруулалт /III/08/*

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Номын азтан шалгаруулах цахим уралдаан зарласан. Уралдаанд нийт 206 оролцогч оролцож, 1815 хүнд хүрсэн. Уг Цахим уралдааны азтанаар М.Оюунбилэг шалгарч номын багцаар шагнуулсан.

4.5. *“ЗОХИОЛЧИДТОЙ ХИЙСЭН ӨГЛӨӨЛӨГ”уулзалт хэлэлцүүлэг /III/19/*

"Дэлхийн яруу найргийн өдөр"-ийг угтан Өмнөговь аймгийнхаа зохиолч, яруу найрагчидтай өглөөлөг уулзалтыг зохион байгууллаа.Уулзалт арга хэмжээний хүрээнд Төв номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаа, 2022 онд зохион байгуулах соёл танин мэдэхүйн ажлын төлөвлөгөө, цаашид МЗЭ-ийн салбар зөвлөлтэй хамтран ажиллах саналуудыг танилцуулсан ба зохиолчдын зүгээс сүүлийн үеийн шүлэг зохиолоос дээжлэн уншиж харилцан халуун дотно хэлэлцүүлэг өрнүүллээ. Оролцогчид 10.

4.6. *“ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ”/III/21/*

"Дэлхийн яруу найргийн өдөр"-ийг тохиолдуулан Өмнөговь аймгийнхаа зохиолч, яруу найрагчидтай шүлэг яруу найраг сонирхогч уншигчдын төлөөллийг уулзуулж нутгийн зохиолч яруу найрагчид болон зохиол бүтээлийг сурталчлах, харилцан уран бүтээл болон шүлэг зохиол бичих талаар зөвлөгөө, зөвлөмжийн халуун дотно яриа өрнүүлэх боломжийг олголоо.

Мөн уулзалтад оролцогч сурагчдын дунд “Миний ертөнц” сэдэвт шүлгийн тэмцээн зохион байгуулахад 4-р сургуулийн 7В ангийн сурагч Б.Должидмаа манлайлан, 4-р сургуулийн 7А ангийн сурагч М.Ганбаатар удааллаа. Оролцогч 33.

4.7. *“ДЭЭВРИЙН ӨРӨӨН ДЭХ МИНИЙ МӨРӨӨДӨЛ” номын хэлэлцүүлэг/III/23/*

Хүүхэд багачуудын ном уншлагыг дэмжих, хувь хүний хөгжлийн шилдэг номуудыг нийтэд танилцуулан сурталчлах зорилгоор 1-р сургуулийн П.Нэргүй багштай 8Д ангийн сурагчдын дунд "ДЭЭВРИЙН ӨРӨӨН ДЭХ МИНИЙ МӨРӨӨДӨЛ" номын хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын дунд зохион байгуулсан "Миний мөрөөдөл" сэдэвт зохион бичлэгт

Ж.Номин-Эрдэнэ, Б.Долгорсүрэн нарын зохион бичлэг шилдгээр шалгарч ном дурсгалын зүйлээр шагнууллаа.

4.8. “СУРАГЧДЫН АМРАЛТАД ЗОРИУЛСАН СУРГАЛТУУД”/IV/5-V/8/

Сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номын сангаар үйлчлүүлэх соёлд суралцуулах зорилгоор сурагчдын амралтыг тохиолдуулан 3 төрлийн 5 удаагийн сургалтыг зохион байгуулж 31 хүүхдийг хамрууллаа. Үүнд:

- V/6. Мэдээллийн төвийнхөө англи хэл дээрх номыг сурагчдад танилцуулах англи хэлний танилцуулга сургалт. 9 хүүхэд
- V/6, V/8. Мэдээллийн төвийн үйлчилгээ үйл ажиллагааг танилцуулан зургийн Paint программын сургалт. 12 хүүхэд
- V/6, V/8. Номыг ариг гамтай унших, номын хавчуурга урлах дэгээ зүүний сургалт 10 хүүхэд.

4.9. “ӨМНӨГОВЬ НУТГИЙН БАХАРХАЛ” аян / IV/11-V/11 /

“Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийн номоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэх, монгол үндэсний бичиг, хэл соёлыг зааж сургах, өвлүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уг аяныг зохион байгуулан ажилласан.

Өмнөговь аймгийн бахархал болсон түүхэн хүмүүс, түүхэн үйл явдал, газар усны түүх, домгийг сурагчдад сурталчлан танилцуулах, номоор дамжуулан өсөж төрсөн нутаг орныхоо түүх, түүнийг бүтээсэн гайхамшигт хүмүүсээс суралцахад дэмжлэг үзүүлж эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Өмнөговь нутгийн бахархал” аяныг Өмнөговь аймгийн ЕБСургуулиуд, сургуулиудын номын санчид, Өмнөговь аймгийн ЕБСургуулиудын сурагчдын дунд 2022 оны 04-р сарын 11-ний өдрөөс05-р сарын 11-ний өдөр хүртэл зохион байгуулсан.

Манай номын сангаас аяны хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Нийт 1404хүнд хүрч ажилласан.

- **“ЗУРГАН АХА” ТЭМЦЭЭН / Оролцогч 57сурагч/**

Өмнөговь аймгийн бахархал болсон түүхэн хүмүүс, түүхэн үйл явдал, газар усны түүх, домгийг сурагчдад сурталчлан танилцуулах, номоор дамжуулан өсөж төрсөн нутаг орныхоо түүх, түүнийг бүтээсэн гайхамшигт хүмүүсээс суралцахад дэмжлэг үзүүлж эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор сурагчдын дунд **“ЗУРГАН АХА”** тэмцээнийг зохион байгуулсан.

- 4-5 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан **“ЗУРГАН АХА”** тэмцээнд сургуулиудын төлөөлөл 17 хүүхэд оролцсон.

    1-р байр 4-р сургууль 4а ангийн сурагч Г.Мөнхсүлд

    2-р байр 3-р сургууль 5б ангийн сурагч Б.Нандин-Эрдэнэ нар шалгарсан байна.

- Булган сумын ЕБС-ийн Э.Дулмаа багштай 3а ангийн 16 сурагчдын дунд **“ЗУРГАН АХА”** тэмцээн зохион байгуулсан.

  1-р байр 3а ангийн сурагч Б.Энхмэнд

  2-р байр 3а ангийн сурагч Г.Хангал-Эрдэнэ нар шалгарлаа.

- 6-7 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан **“ЗУРГАН АХА”** тэмцээнд сургуулиудын төлөөлөл 24 хүүхэд оролцсон.

  1-р байр 4-р сургууль 7в ангийн сурагч Г.Номин-Эрдэнэ

  2-р байр 3-р сургууль 6а ангийн сурагч А.Ням-Эрдэнэ нар шалгарсан байна.

- **“ЭСЭЭ” БИЧЛЭГИЙН УРАЛДААН /Оролцогч 26 сурагч/**

Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, судалж мэдсэн зүйлээ бичгээр оновчтой илэрхийлэх, эсээгээр дамжуулан өөрийн санаа, үзэл бодлоо бусдад цэгцтэй хүргэх нэгтгэн дүгнэх, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд зорилгоор Өмнөговь аймгийн ЕБСургуулийн 8-11 дугаар ангийн сурагчдын дунд 2022.04-26-05-08-ний өдрийн хооронд эсээ бичлэгийн уралдааныг зарласан. Төв хөдөөгийн 26 сурагчдын эсээ бичлэг ирснээс
/1-р сургууль-3, 2-р сургууль-16, 3-р сургууль-5, 4-р сургууль-, Гурван тэс сумын ЕБСургууль-1/

1-р байр 2-р сургууль 8б ангийн сурагч Б.Мишээл

2-р байр 3-р сургууль 11а ангийн сурагч М.Маралгуа

3-р байр 2-р сургууль 11а анги сурагч Б.Минжинсор нарын бичсэн эсээ шилдгээр шалгарсан байна.

- IV/25-V/20хооронд “Өмнөговь нутгийн бахархал” аяны хүрээнд уншиж судлах номоор үзэсгэлэн гаргаж ажилласан.

  /32 номоор 217 ирцэд/

- Ардын Боловсролын тэргүүний ажилтан, Чингис хааны дэлхийн академийн гишүүн академич Л.Мажаа гуай нь нутаг орныхоо түүх, түүхэн хүмүүсийн тухай олон сайхан номуудыг эмхэтгэж, хойч үеийнхэндээ нутаг орныхоо түүхийг өвлүүлэн үлдээхэд үнэтэй хувь нэмрээ оруулж буй нэгэн билээ. III/12-нд Номын сангийн ахмад уншигч Л.Мажаа гуайг Өмнөговь нутгийн бахархал аянаараа дамжуулан онцолж Мэлмий видео сайттай хамтран нэвтрүүлэг бэлтгэн цахим хуудсанд байршуулан ажилласан. /**Үзэгч-818/**

- **“УРИЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ”**

  Өмнөговь нутгийн бахархал аяны хүрээнд ЕБС-ын сурагчдыг сурагчдыг урилгат үйлчилгээгээр урьж Өмнөговь нутгийн бахархалт ан амьтан ургамлын талаар мэдээлэл өгч ажилласан.

  /6 сургуулийн 286 сурагчдад мэдээлэл өгсөн/

  - 1-р сургуулийн Д.Арвайхээр багштай 4б ангийн 33 сурагч
  - 1-р сургуулийн М.Бямбажав багштай 4в ангийн 25 сурагч
  - 1-р сургуулийн Г. Мөнх-од багштай 2а анги 32 сурагч
  - 1-р сургуулийн Б.Төмөртогоо багштай 11г 26 сурагч
  - 1-р сургууль Г.Цэцэгжаргал багштай 1г ангийн 45 сурагч
  - 3-р сургууль Ц.Сарантуяа багштай 8г ангийн 16 сурагч

- 3-р сургууль Ц.Сайнзаяа багштай 8а ангийн 15 сурагч
- 7-р сургууль С.Хоролсүрэн багштай 6а ангийн 22 сурагч
- 5-р сургуулийн Ө.Мягмарсүрэн багштай 2б ангийн 30 сурагч
- 2-р сургуулийн Б.Шижиртуяа багштай 4б ангийн 26 сурагч
- Булган сумын ЕБС-ийн Э.Дулмаа багштай 3а ангийн 16 сурагч

“Өмнөговь нутгийн бахархал” аянд 7 сургуульдирдамжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан./Нийт 5900 хүнд хүрч ажилласан байна./

Аяныг идэвхтэй хэрэгжүүлж зохион байгуулах ажлыг чиглэл бүрээр хэрэгжүүлсэн ажлын болон хамрагдсан хүүхдийн тоо, үр дүнг харгалзан сургууль, сургуулийн номын санчийг шалгаруулж шагнаж урамшуулсан.

- Аяныг идэвхтэй зохион байгуулж 1539 багш сурагчдыг хамруулж, интернэт орчинд нийт 26 пост бэлтгэж оруулсан амжилтаараа Улсын тэргүүний 3-р сургууль шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.
- “Өмнөговь нутгийн бахархал” аяны хүрээнд 816 багш, сурагч, эцэг, эхчүүд хамруулж, интернэт орчинд нийт 20 пост бэлтгэж оруулсан амжилтаараа 7-р сургуулийн номын санч М.Хишигт шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан байна.

Номын баяр-2022 арга хэмжээний үеэр сургуулиуд “Өмнөговь нутгийн бахархал” аяны хүрээнд багш, сурагчдын хийсэн бүтээлээрээ үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлан ажиллаа.

4.10. *“БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” уран бичвэрийн уралдаан /IV/18-IV/29/*

Өмнөговь аймгийн ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдын дунд зарласан уг уралдаанд нийт 20 сурагч өөрийн уран бичсэн бүтээлийг ирүүллээ.

Сурагчдын бүтээлийг уран бичээч Г.Ганзориг шүүж, шилдэг бүтээлүүдийг шалгаруулсан.

1-р байр 2-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Маралжингоо
2-р байр 4-р сургуулийн 12б ангийн сурагч Э.Арвин
3-р байр 3-р сургуулийн 12в ангийн сурагч М.Бадамханд

Тусгай байр 4-р сургуулийн 12а ангийн сурагч М.Шижирбат нарыг шалгаруулан Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнан урамшууллаа.

4.11. ***“БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” монгол бичгийн хичээнгүй, цэвэр бичлэгийн уралдаан /IV/20-IV/29/***

Өмнөговь аймгийн ЕБС-ийн 7-12 дугаар ангийн сурагчдын дунд зарласан. Энэхүү уралдааны мэдээ постерыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан. Уг уралдаанд төв, хөдөөгийн 12 сургуулийн 677 сурагчдын хичээнгүй, цэвэр бичиг ирсэн. Бичвэрүүдийг нэг бүрчлэн үзэж сүүлчийн шалгаруулалтад 120 гаруй хичээнгүй, цэвэр бичгийг үлдээж мэргэжлийн багш нарын бүрэлдэхүүнтэй комисс үзэж шалгарууллаа.

Сурагчдын хичээнгүй, цэвэр бичгийг Ц.Амарсайхан /Монгол хэлний багш/, Ч.Цоодол /Монгол хэлний багш/, Ү.Мөнхбалжир /Уран бичээч, монгол хэлний багш/ нар шүүж, шилдэг бичвэрүүдийг шалгаруулсан.

1-р байр 5-р сургуулийн 12б ангийн сурагч Х.Намуунбайгаль
2-р байр 4-р сургуулийн 11а ангийн сурагч Ү.Дэлгэрмөрөн
3-р байр 2-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Маралжингоо
Тусгай байр 4-р сургуулийн 11а ангийн сурагч Г.Золзаяа нарыг шалгаруулан Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнан урамшууллаа.



4.12. ***“БАГШИЙН ЭРДЭМ ШАВЬД” багш, шавийн хамтарсан уран бичвэрийн бүтээлийн уралдаан /IV/18-IV/29/***

“БАГШИЙН ЭРДЭМ ШАВЬД” багш, сурагчдын монгол бичгийн уран бичвэрийн үзэсгэлэнгийн уралдааныг зарласан. Уг уралдаанд Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын багш 5 хүртэлх шавьтайгаа хамтран өөрийн болон шавь нарынхаа монгол бичгийн уран бичвэрийн төрлөөр хийсэн бүтээл, бичвэрүүдээр үзэсгэлэн гаргаж оролцлоо. Уралдаанд нийт 6 багийн 30 хүн бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргаж оролцсон. Үзэсгэлэнг мэргэжлийн багш нарын бүрэлдэхүүнтэй комисс үзэж шалгарууллаа.

1-р байр Ү.Мөнхбалжир багштай баг хамт олон
2-р байр Э.Батцэцэг багштай 5-р сургуулийн баг хамт олон

3-р байр С.Буянболдмаа багштай 4-р сургуулийн баг хамт олныг шалгаруулан Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

4.13. *“ӨСВӨР НАСНЫХНЫ ДЭЭДЛЖ МӨРДӨХ 7 ЗУРШИЛ” номын хэлэлцүүлэг/IV/22/*

Хэлэлцүүлгийг “Ирээдүйн ээзд” номын клубын хүүхдүүдийн дунд зохион байгуулж идэвхтэй оролцсон 4-р сургуулийн 8в анги Б.Буяндэлгэр, 1-р сургуулийн 8д анги Ж.Номин-Эрдэнэ нарыг шагнаж урамшууллаа. Оролцогч 17.

4.14. *“УТГА УЯНГА” уран уншлагын уралдаан /IV/15-IV/29/*

Дэлхийн номын өдөрт зориулан Монголын зохиол бүтээлийг уншигчдад сурталчлах сурагчдын уран яруу унших авьяас чадварыг нээн илрүүлж дэмжих номтой нөхөрлүүлэх зорилгоор "Утга уянга" богино өгүүллэгийн уран уншлагын уралдааныг Өмнөговь аймгийн ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Уралдаанд Ханхонгор сумаас -3, Гурвантэс сумаас-1, Эрдмийн гэгээ 2-р сургуулиас- 5, Гуравдугаар сургууль -3 нийт 12 бичлэг ирснээс

1-р байр 2-р сургууль 11а Т.Мөнхсондор "Шалгалт "
2-р байр 3-р сургууль 8в анги Б.Энхжин "Шалгалт"
3-р байр 2-р сургууль 8б анги Номин "Цэдэндамбаа"
Тусгай байр 3-р сургууль 11в анги Ч.Батзориг "Ээждээ очоорой" зохиолуудаар оролцон шалгарлаа.

4.15. *“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР”/V/7/*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг тэмдэглэж эх хэл, бичиг үсгээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах, олон түмэнд таниулах, иргэд хүүхэд залуучуудад монгол бичгээ эзэмших сэдэл тэмүүллийг бий болгох зорилгоор “Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд 2022 оны “Үндэсний бичиг үсгийн баяр-”ын өдрийг зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүллээ.

Үндэсний бичиг үсгийн баярыг 05-р сарын 07-ны өдөр Багш хөгжлийн ордонд Төв номын сан,

Боловсрол, Шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулсан. Уг өдөр бичиг

үсгийн баярын өдрийг угтан зохион байгуулсан уралдаан арга хэмжээнүүдийн шагнал гардуулах, үндэсний бичиг үсгийн дурсгалыг сурталчилсан ном болон архивын баримтууд, монгол бичгийн уралдаануудад ирсэн багш, сурагчдын уран бичвэр, хичээнгүй бичгийн үзэсгэлэнгүүдийг гаргаж олон нийтэд танилцуулан өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлсэн.

Уг баярыг угтан болон баярын өдрөөр дараах уралдаан арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

- ***“БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” уран бичвэрийн уралдаан*** “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” монгол бичгийн хичээнгүй, цэвэр бичлэгийн уралдаан
- ***“БАГШИЙН ЭРДЭМ ШАВЬД” багш, сурагчдын монгол бичгийн уран бичвэрийн үзэсгэлэн***
- ***“МОНГОЛ БИЧГИЙН ҮСЭГЛЭЛ” тэмцээн*** **/V/07/**

Сурагчдыг босоо монгол бичгээрээ алдаагүй зөв бичиж, уншиж сурахад уриалан, монгол бичигт амжилттай суралцаж буй хүүхдүүдийг урамшуулан дэмжих зорилгоор "Монгол бичгийн үсэглэл" тэмцээнийг Даланзадгад сумын ЕБС-ийн 7-8 дугаар ангийн сурагчдын дунд Бичиг үсгийн баярын өдөр зохион байгуулсан.

Тэмцээнд Даланзадгадын ЕБСургуулиудын 7,8 дугаар ангийн төлөөлөл 24 сурагч оролцож, өөрсдийн мэдлэг чадвараараа монгол бичгийн үгсийг галиглан үсэглэж амжилттай оролцож

1-р байр 1-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Энхжин

2-р байр 1-р сургуулийн 7г Б.Намуун нар шилдэг оролцогчоор шалгарч Дурсамж, мөнгөн шагналын эзэд боллоо.Оролцогчид бэлдсэн 250 үгийг монгол бичгийн галигаар үсэглэх ба2 үг алдсан тохиолдолд дараагийн үсгийг дуудах журмаар явагдсан ба

оролцсон сурагчдадаа гарын бэлэг гардуулж урамшуулсан.

- ***“ШИЛДЭГ ГАРЫН ҮСЭГ” тэмцээн*** **/V/07/**

V/07“Үндэсний бичиг үсгийн баяр”**-**т хүрэлцэн ирсэн оролцогчдын дунд жил бүр уламжлал болгон зохиогддог босоо Монгол бичгээр бичигдсэн шилдэг бичвэртэй гарын үсэг шалгаруулах тэмцээн зохион байгуулсан.

Баярын үеэр зохион байгуулсан энэхүү тэмцээнд монгол бичгийг хэрэглээ болгон гарын үсгээ зурж хэвшсэн нийт 25 хүн оролцож шилдэг гарын үсгийн эзнээр 4 дүгээр сургуулийн багш Б.Чулуун шалгарч дурсамж, мөнгөн шагналаар шагнууллаа.

- ***“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫН ӨДӨР”-т зориулсан номын үзэсгэлэн***

V/05-10“БИДНИЙ БАХАРХАЛ МОНГОЛ БИЧИГ” сэдэвт бичиг үсгийн түүх, уран бичвэр болон монгол бичиг толь, сурах бичгийн 32 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж танилцууллаа. /25 хүнд/
V/05“БИЧИГ СОЁЛ” сэдэвт үзэсгэлэнг сан хөмрөгтөө хадгалагдаж байдаг хуучны гар бичмэл, ховор эртний ном судраас бүрдсэн 28 ширхэг номыг олон нийтэд танилцуулж сурталчилсан. / 96 хүнд/
V/05. “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” уран бичвэр, хичээнгүй, цэвэр бичгийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийн үзэсгэлэн, аймгийн Архивын газар ховор бичмэлийн үзэсгэлэн гаргаж баярын үйл ажиллагаанд ирсэн иргэдэд танилцуулан сурталчлав.

Өмнөговь аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас зохион байгуулсан "Үндэсний бичиг-бидний бахархал" хичээнгүй бичгийн аянд манай хамт олон нэгдэж 5

төрлийн сэдвийг хичээнгүй цэвэр бичиж амжилттай оролцлоо.

МҮОНРТ-ээс санаачлан өрнүүлж буй "ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН МОНГОЛЧУУД" аянд Сүхбаатар аймгийн номын сангийн дуудсанаар манай номын сангийн хамт олон, үндэсний бичиг үсгийн баярт оролцсон иргэдийн хамт нэгдэж уриалгад оролцон дараагийн номын сангаа уриалан дуудсан бичлэгээ илгээлээ.

Үндэсний бичиг үсгийн баярын уран бичвэрийн уралдаанд ирсэн сурагчдын бүтээлийг босоо Монгол бичгээ сурталчлах, сурагчдын идэвхоролцоог дэмжих, нийтийн хүртээл болгох зорилгоор "Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөрийг санаачлан, хэрэгжүүлэгч аймгийн Засаг дарга Р.Сэддорж болон уг хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч байгууллага, хамт олонд гардуулан өглөө.

4.16. *“НОМЫГ БҮТЭЭЛЧЭЭР УНШИХ, НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ АРГА” сургалт/V/12- V/13/*

“Ирээдүйн эзэд” номын клубын сурагчдыг 2 ээлж болгон номыг бүтээлчээр унших болон номын тэмдэглэл хөтлөх талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 30 сурагч хамрагдлаа.

4.17. *“СУМЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН НОМТОЙ АЯЛАЛ”/V/19/*

Булган сумын ЕБС-ийн С.Дулмаа багштай 3а ангийг хүлээн авч номын сангийн танилцуулга мэдээлэл, хамт олны уншлага хийж танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгууллаа. Ангийн 16 сурагчдаас мэдлэг, авхаалж самбаагаараа шалгарсан 2 сурагчийг Дурсамж, номын багцаар шагнаж урамшуулсан.

4.18. *“ХАМТ ОЛНЫ УРАН УНШЛАГА” уралдаан /IV/25-V/21/*

Сурагчдад шүлэг яруу найргаар дамжуулан эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүүхдийн уран яруу унших авьяас чадварыг нээн илрүүлж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Даланзадгад сумын ЗДТГазартай хамтран Даланзадгад сумын ЕБСургуулиудын 6-11-р ангиудын сурагчдын дунд уг уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгууллаа. 1-р шатыг цахимаар зохион байгуулсан бан уг шатанд 5 сургуулийн 600 гаруй сурагчид оролцсон 26 анги хамт олны бичлэг ирсэн ба 2-р шатанд шилдэг 4 бичлэгийг шалгаруулан Ёл кино театрт шалгаруулалтыг зохион байгууллаа. Цахим хуудсанд байршуулсан бичлэгүүд10885үзэгчдэд хүрсэн байна.

Уралдааны 1-р байр7-р сургууль С. Хоролсүрэн багштай 6ᵃ анги / “Чингис” шүлэг/

2-р байр 4-р сургууль Ш.Уранцэцэг багштай 6ᵃ анги /П.Бадарч “Есөн эрдэнийн орон” шүлэг/

3-р байр 1-р сургууль Гэгээнзаяа багштай 11ᴦ анги /Д.Пүрэвдорж “Тусгаар тогтнол” шүлэг/

Тусгай байр 1-р сургууль Оюунчимэг багштай 10ᵇ анги /С.Сүрэнжав “Багш найраглал”/ тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

4.19. *“ШИЛДЭГ ДҮРИЙН ТОГЛОЛТ” уралдаан /IV/25-V/21/*

Хамт олны бүтээлч уншлагыг дэмжин, сурагчдыг зохиолын дүр дүрслэлийг илэрхийлэх, жүжиглэх авьяас чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэх зорилгоор Даланзадгад сумын ЗДТГазартай хамтран Даланзадгад сумын ЕБСургуулиудын 3-9-р ангиудын дунд бага, дунд гэсэн 2 насны ангиллаар 2 үе шаттай уг уралдааныг зохион байгууллаа.

Уралдааны 1-р шатанд 4 сургуулийн 76 сурагч анги хамт олноороо оролцож цахим хуудсанд байршуулсан бичлэгийг нийт 6593 үзэгчид үзэж сонирхсон хүрсэн байна. Уралдааны 1-р шатанд ирсэн бүтээлүүдээс 2-р шатны шалгаруултад орох 6 дүрийн тоглолтыг Боловсрол соёл хариуцсан мэргэжилтэн С.Болд, Фондчин Т.Нямсүрэн, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа нар шүүж явууллаа. Шилдэг дүрийн тоглолтын 2-р шатны шалгаруулалт Ёл танхимд зохион байгуулагдав.

Бага анги төрөлд:

1-р байр 5-р сургуулийн 3в анги “ЦАРЦАА НАМЖИЛ” үлгэрээр

2-р байр 3-р сургуулийн 3б анги “ЭРХИЙ МЭРГЭН” үлгэрээр

3-р байр 3-р сургуулийн 3в анги “БЭТГЭЛЖИН БОР” үлгэрээр

Дунд анги төрөлд

1-р байр 4-р сургуулийн 9в анги “ЦАСАНГАА”

2-р байр 7-р сургуулийн 8а анги “ЗАЛУУС ДҮҮ НАРТАА ХҮРГЭХ ШҮЛЭГ”

3-р байр 4-р сургуулийн 7а анги БУРХАН БОГД ААВДАА зэрэг үлгэр, зохиолоор тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

4.20. “ШИЛДЭГ НОМЫН ТЭМДЭГЛЭЛ” уралдаан /IV/25-V/21/

Сурагчдын бүтээлч уншлагыг дэмжих, номын тэмдэглэл хөтлөх шилдэг арга туршлагыг хүүхэд залуучуудад сурталчлах зорилгоор Даланзадгад сумын ЕБС-ийн 6-11 дүгээр ангийн сурагчдын дунд 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Сургууль бүр ангилалд хамаарах сурагчдын номын тэмдэглэлээр үзэсгэлэн гаргаж шилдэгт тооцогдох 10 тэмдэглэлийг 05 сарын 13-ны 18^{00} цаг хүртэл хурааснаар 1-р шатны шалгаруулалт дууссан.

Нийт 3 сургуулийн 31 сурагчийн номын тэмдэглэлийг 2-р шатны шалгаруулалтад хүлээн авч тэмдэглэл хөтөлсөн онцлог, бүтээлч байдал, тэмдэглэл хөтөлсөн цаг хугацаа, хэмжээ зэргийг харгалзаж Боловсрол соёл хариуцсан мэргэжилтэн С.Болд, Номын сангийн Фондчин Т.Нямсүрэн, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа нар шүүж шилдгүүдийг шалгаруулллаа.

Шилдэг номын тэмдэглэлийн эзэд:

1-р байр 3-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Бужмаа

2-р байр 4-р сургуулийн 10а ангийн сурагч Т.Ганзолбоо

3-р байр 3-р сургуулийн 8а ангийн сурагч О.Хүсэлцэцэг нар өөрсдийн хөтөлсөн номын тэмдэглэлээрээ тус тус шагналт байр эзэллээ.

4.21. *“НОМЫН БАЯР”/V/20-V/22/*

МУ-ын ерөнхийлөгчийн 2012 оны "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, иргэд, хүүхэд, залуучуудыг номтой нөхөрлүүлэх, бүх нийтийн ном уншлагыг дэмжих Үндэсний номын баяр-2022 арга хэмжээг “Илүү их уншъя” уриан дор 05 сарын 20-22-ны өдрүүдэд орон нутагт тэмдэглэн өнгөрүүлж, номын сангийн сангуудын хөмрөгийг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Даян хааны төв талбайд нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Нээлтийн арга хэмжээнд Даланзадгад сумын сургууль цэцэрлэг болон Цогтцэций сумын ЕБС-ийн сурагчид, төрийн болон төрийн бус байгууллагууд нийт 400 гаруй иргэд хүүхэд залуус уг өдрийн арга хэмжээнд оролцлоо. Нээлтийн үйл ажиллагааг нээж Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ц.Бадамцэрэн, Соёл, урлагийн газрын даргаТ.Мөнгөнтуул, Номын сангийн дарга А.Одончимэг нар нээж үг хэллээ.

Уг арга хэмжээний үеэр:

- Урлагийн үзүүлбэр
- Сумдын Номын сангуудын төлөөллүүдэд ном гардуулах, хандивлах
- “МИНИЙ ХАЙРТАЙ ЗОХИОЛЫН БААТРУУД” үлгэр, зохиолын дүрд хувирсан оролцогчдын жагсаал
- Сургуулийн номын сангуудын танилцуулга үзэсгэлэн
- Шилдэг уншигчдын номын тэмдэглэлийн үзэсгэлэн
- Шинэ, хуучин номын худалдаа, солилцоо
- “Өмнөговь нутгийн бахархал” аяны шилдгээр шалгарсан сургууль, сургуулийн номын санчийн тайлан үзэсгэлэн
- Шилдэг тэргүүний уншигчид, шилдэг номын санч, шилдэг уншигч хувь хүн, байгууллага хамт олныг шагнаж урамшуулах
- Танин мэдэхүйн “АХА” тэмцээн
- Арга хэмжээнд оролцогчдын дунд “Номын азтан” шалгаруулж, номын багцаар шагнан урамшуулах
- Төв номын сангийн сан хөмрөгт шинээр ирсэн ном хэвлэлийг танилцуулах үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

2022 оны Номын баярын арга хэмжээний мэдээлэл сурталчилгаа, зарлал, зурагт хуудаснуудыг өөрийн цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлснээр 2360 орчим хандалт авсан.

Сумдын соёлын төвийн номын сангуудын сан хөмрөгийг хүүхдийн ном хэвлэлээр баяжуулах ажлын хүрээнд Ханхонгор сумын номын санчид номын дээжээс уг арга хэмжээний үеэр гардууллаа.

V/20. “ТАНИН МЭДЭХҮЙН АХА” тэмцээн

Номын баярын үйл ажиллагаанд оролцогч иргэдийн дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд 82 хүүхэд залуучууд хамрагдаж оюуны мэдлэгээ сорьж, тэргүүн байрыг “ЭРДЭНИЙН ГҮН” ХХК-ны нягтлан бодогч Б.Оюун-Ундрал шалгарч номын багцаар шагнууллаа.

V/20.“НОМЫН АЗТАН”

Баярын арга хэмжээний үеэр оролцогчдын дунд 360ш сугалааг сугалуулж 3 азтанд Номын багцын бэлэг гардууллаа. 262 сугалаа сугалснаас:

Азтан-1 24-р цэцэрлэгийн сурагч Э.Ариунзаяа

Азтан-2 4 сургууль 9в ангийн сурагч Х.Хүслэн

Азтан-3 Төв номын сангийн нярав Ц.Бадамханд нар азтанаар шалгарч номын багцаар шагнууллаа.

V/20. “МИНИЙ ХАЙРТАЙ ЗОХИОЛЫН БААТРУУД” үлгэр зохиолын баатрын дүрд хувирах жагсаал

Хүүхэд багачуудын ном унших, номд дурлах сэдлийг төрүүлэх, ном уншдаг иргэд, хүүхэд залуучуудыг урамшуулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагууд иргэд хүүхэд залуучуудын дунд Номын баярын өдөр энэхүү жагсаалыг зохион байгууллаа.Жагсаалд төв хөдөөгийн нийт 11 байгууллага, 200 гаруй оролцогч оролцож хайртай дүрийнхээ баатрыг өөрийн бүтээлч байдал, хувцаслалтаараа амилуулж нээлтийн үйл ажиллагааг төв талбайг тойрч эхлүүлсэн юм.Жагсаалд идэвхтэй оролцогчдоос:

Баг хамт олны төрөлд:

1-р байр Цогт-цэций сумын 2-р сургуулийн 6а анги "101 ГӨЛӨГ" үлгэрийн дүрээр *(33 багш, сурагчид)*

2-р байр Даланзадгад сумын 24-р цэцэрлэг "ХӨГЖИЛТЭЙ ЦИРКЧИД" дүрээр (50 багш, эцэг эхчүүд, хүүхдүүд)

Хувь хүн төрөлд:

Шилдэг эрэгтэй 1-р цэцэрлэгийн багш Б.Сүхбат "ЭЭЖ ГАХАЙ" дүрээр

Шилдэг эмэгтэй 1-р цэцэрлэгийн тогооч Г.Сумъяасүрэн "БОНГО" дүрээр

Хүүхдийн төрөлд:

Шилдэг эрэгтэй 3-р сургуулийн 3а ангийн сурагч Б.Хүрэлсүрэн "ЦАРЦАА НАМЖИЛ" дүрээр

Шилдэг эмэгтэй 4-р сургуулийн 9в ангийн сурагч О.Оюунхишиг "ЦАСАНГАА" дүрээр тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

V/20. “ШИЛДЭГ УНШИГЧ, НОМЫН ЭЛЧ, ШИЛДЭГ УНШИГЧ БАЙГУУЛЛАГА”

Мэдлэг оюунаа хөгжүүлэн номтой нөхөрлөж номын соёлыг түгээн дэлгэрүүлэх, хамт олноо ном уншихад уриалсан уралдаан арга хэмжээ зохион байгуулдаг,номын сангийн үйл ажиллагааг сурталчлан бидэнтэй хамтран ажилладаг уншигч хувь хүн байгууллагыг шалгаруулан “Шилдэг уншигч”, “Номын элч”, “Шилдэг уншигч хамт олон”-ыг шалгаруууллаа. Үүнд:

*“**Шилдэг уншигч**”-аар ахмад настан, ахмад уншигч П.Долгор*

*“**Номын элч”**-ээр 1-р сургуулийн Биологийн багш П.Нэргүй*

*“**Уншигч хамт олон**”-оор “Ус, цаг уур орчны шинжилгээний төв”-ийн хамт олныг* шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж шагнаж урамшуулсан.

V/20- V/22. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

Онцлог номын үзэсгэлэн: Жил бүрийн номын баяраар уншигчдад номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байдаг ховор хуучин, өвөрмөц номуудаа дэлгэн үзэсгэлэнгээ танилцуулдаг бол энэ жилийн баяраар “ОНЦЛОГ НОМ”-ын үзэсгэлэнг 21 ширхэг номоор гаргалаа.

Шинэ номын үзэсгэлэн: Номын сангийн сан хөмрөгт шинээр ирсэн 40 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж баярт ирсэн оролцогчдод дэлгэн танилцуулсан.

ЕБСургуулиуд, сургуулиудын номын санчийн тайлан, үзэсгэлэн: “Өмнөговь нутгийн бахархал” аянд оролцсон шилдэг сургууль, сургуулиуд аяны хүрээнд хийсэн ажлуудын тайлан, үзэсгэлэн гаргаж нийтэд танилцуулсан.

Байгууллагын номын үзэсгэлэн: Баярт оролцогч байгууллагууд номын үзэсгэлэн гаргаж өөрсдийн үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилж манай номын баярын арга хэмжээнд нэгдэж хамтран ажиллалаа.

V/20. Тэргүүний уншигч хүүхдүүдийг “Тэргүүний уншигч Д.Нацагдорж” тэмдгээр шагнав.

Номын баярыг тохиолдуулан ном уншдаг хүүхдүүдээ урамшуулах, хүүхдүүдийн идэвхийг дэмжих зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиудаас шилдэг уншигч хүүхдүүдийг тодруулан шагнав. Төв хөдөөгийн сургуулиудаас нийт 9 сурагчийг уг тэмдгээр шагнаж урамшууллаа.

1. Б. Энхмэнд (5-р сургуулийн 11Б анги)
2. Б.Бадамлянхуа (7-р сургуулийн 12Б анги)
3. Ж. Энхсувд (3-р сургуулийн 11В анги)
4. Б.Отгонтуяа (4-р сургуулийн 12А анги)
5. Л.Болортуяа (3-р сургуулийн 12В анги)
6. Б.Гэгээнзаяа (7-р сургуулийн 12Б анги)
7. Г.Ариунаа (2-р сургуулийн 8Б анги)
8. Б.Буяндэлгэр (Гурвантэс сум)
9. Номин-Эрдэнэ (Гурвантэс сум)

4.22. ***“БИ УНШИХ ДУРТАЙ” гар зургийн уралдаан /IV/23-VI/1/***

Бага ангийн сурагчдын авьяас чадварыг дэмжих, ном унших хүсэл сонирхлыг төрүүлж, номоор дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор ЕБСургуулиудын 1-5 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан гар зургийн уралдаанд 23 сурагч зохиолын сэдэвт зургаараа оролцсоноос

1-р байр 4-р сургуулийн 2а ангийн сурагч О.Энхчимэг
2-р байр 2-р сургуулийн 3б ангийн сурагч Н.Учрал
3-р байр 1-р сургуулийн 5г ангийн сурагч М.Ган-эрдэнэ
Тусгай байр 1-р сургуулийн 5г ангийн сурагч Э.Номинзул нар шалгарлаа.

4.23. *“НОМТОЙ БЭЛЭГ”/V/23-V/1/*

“Мөндөөлэй” номын зохиолч С.Гантогтохтой хамтран зохион байгуулдаг уламжлалт уралдааныг энэ жил зохиолчийн дууг дуулж бичлэгээ ирүүлсэн хүүхдүүдэд номтой бэлэг авх боломжийг олгон зохион байгуулсан ба 11 хүүхдийн бичлэгийг хүлээн авч хүүхдийн баярын талбайн арга хэмжээн бэлгийг гардуулан өглөө.

4.24. *“ХҮҮХДИЙН БАЯР- НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД АРГА ХЭМЖЭЭ”/V/1/*

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан Ажнай талбайд зохион байгуулсан "Нэгдүгээрт хүүхэд" нэгдсэн арга хэмжээнд хүүхэд багачуудаа "НОМЫН ӨРГӨӨ"-нд зочлуулж "Би унших дуртай" гар зургийн уралдаанд оролцогчдын ирүүлсэн зургаар үзэсгэлэн гарган шилдгүүдийн шагналыг гардууллаа. Мөн хүүхдүүдэд

"Оюуны чихэр" тарааж 3 номын азтан шалгаруулан Хүүхдийн зохиолч С.Гантогтохтой хамтарсан "Номтой бэлэг" уралдааны шилдэг оролцогчдын шагналыг гардуулан, шинэ номын худалдаа зохион байгуулж ажилласан.

4.25. *“ЗОРИЛГОТОЙ ИРЭЭДҮЙ”/VI/3/*

“Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийн номоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэх, монгол үндэсний бичиг, хэл соёлыг зааж сургах, өвлүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг дарга Р.Сэддоржийн ивээл дор Төв номын сан болон Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар хамтран ЕБС-ийн 11-р ангийн сурагчдад ирээдүйгээ төлөвлөж зорьсон зорилгодоо хүрэх арга замыг өөрийн гараар бүтээх боломжтойг танилцуулж чиглүүлэх, улмаар сурагчдын унших, төлөвлөх, чадваруудыг эзэмшүүлэх зорилгоор"Зорилготой ирээдүй" уулзалт, хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгууллаа.

Уулзалтыг нээн Аймгийн засаг дарга Р.Сэддорж үг хэлж, сурагчдад "Teenage plan" төлөвлөгчийг гардуулан ирээдүйн зорилгодоо хүрэхэд хичээн суралцахыг онцгойлон захьлаа. Улмаар авьяаслаг сурагчид урлагийн үзүүлбэрээр зочдод мэндчилгээ дэвшүүлэн, Өмнөговь нутгаас төрөн гарсан МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Э.Амарзаяагийн сурагчидтай хийсэн зохиол бүтээлийн тухай, өөрийн ном бичиж эхэлсэн түүхээсээ хуваалцан ярилцсан уулзалт зохион байгуулагдлаа.

4.26. *“ЗУНЫ УНШЛАГА ХӨТӨЛБӨР” /VII/5-VIII/22/*

Хүүхдийн авьяас болон оюуны хөгжлийг дэмжсэн уншлага, бүтээлч сургалтыг сурагчдын зуны амралтыг тохиолдуулан зохион байгууллаа.

Үүнд:

- ***VII/5.*** Сурагчдыг номыг бүтээлчээр унших арга барилд сургах, номын тэмдэглэл хөтлөх аргуудыг танилцуулах “Номын тэмдэглэл” сургалтыг зохион байгуулж 12 хүүхдийг хамруууллаа.
- ***VII/06.*** “Хүүхэд бүр бүтээлч” сургалтаар савхан модоор гар утасны тавиур, үзгийн сав хийх сургалтыг 8-12 насны 10 хүүхдэд зохион байгуулсан. /10/
- ***VII/7.*** 6-12 дугаар ангийн сурагчидын дунд “Сутаж гар урлал” сургалтыг зохион байгуулж 15 хүүхдийг хамруууллаа.
- ***VII/8.*** Хүүхдийн бүтээлч сэтгэхүй, гарын булчин хөгжүүлэх **“Цаасан урлал”-**ын сургалтыг зохион байгуулж 12 хүүхэд хамруулан ном уншихын ач тус, номын сангийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах тухай болон шинээр ирсэн номуудаа танилцуулж ажиллаа.
- ***VII/20.*** Хүүхдийн танин мэдэхүй, бүтээлч байдал, гарын булчинг хөгжүүлэх “Баримлаар урлахуй” сургалтанд 10 хүүхэд хамрагдаж таван хошуу малын талаар уншиж судлангаа урлаж сурлаа.
- ***VII/27, VIII/17.*** Номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааг танилцуулах, ном уншлагад хүүхдийг татах нэг арга болсон оролцоот сургалтын нэг хэлбэр болох гар урлалын сургалтыг шүрэн урлалын төрлөөр 2 удаа зохион байгууллаа. 2 удаагийн “Шүрээр урлахуй” сургалтад 23 хүүхэд хамрагдан Хүүхдийн уншлагын танхид ирсэн шинэ номыг уншиж танилцан өөрин гоёлоо урлаж сурлаа.
- ***VIII/20.*** Гар урлалын өвөрмөц төрөл болох давсан урлалын төрлийг танилцуулах явцдаа ном уншихын ач тус, номын сангийн шинэ номуудыг уншиж танилцах боломжийг олгосон “Давсаар урлахуй” сургалтад 10 хүүхэд хамрагдлаа.
- ***VIII/22.*** “Аймаг бүрт 1000 ном” төслийн хүрээнд тус номын санд ирсэн англи хэлний сонирхолтой номуудыг уншиж танилцан “Номын тэмдэглэл” сургалтад 24 хүүхэд хамрагдан номыг бүтээлчээр унших арга барил, номын тэмдэглэл хөтлөх аргуудаас суралцлаа.

4.27. “ХУВЬ ТАВИЛАНГИЙН ЭЭДРЭЭ”номын нээлт / VIII/5 /

Ахмад уран сайханч Ж.Нордогийн “Хувь тавилангийн ээдрээ” номын нээлтийг МЗЭ-ийн Өмнөговь салбартай хамтран зохион байгууллаа. Оролцогчид 28.

4.28. “ШИЛДЭГ НОМЫН САНЧ” уралдаан /IX/6-IX/14/

Үндэсний бичиг, соёл, номын өдрүүдийг угтан номын санчдын бүтээлч санаачилгыг идэвхжүүлж урамшуулах, харилцан бие биеэсээ суралцах, тэргүүн туршлагыг сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор сумдын Соёлын төвийн номын санчдын дунд “Шилдэг номын санч” уралдааныг 9-р сарын 06-14-ний хооронд зохион байгууллаа. Уралдаанд 8 номын санч номын сангийн танилцуулга болон эссэ бичлэгээ ирүүлж оролцсоноос

1-р байр Булган сумын номын санч Ц.Тогоохүү
2-р байр Хүрмэн сумын номын санч Б.Цэвэлмаа
3-р байр Ханбогд сумын номын санч П.Чулуунцэцэг нар шалгарч Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Уралдааны шилдгүүдээр шалгарсан номын санчдын тэргүүн туршлагыг 11-р сард зохион байгуулсан номын санчдын сургалт дээр танилцууллаа.

4.29. *“НОМТОЙ ӨНГӨРҮҮЛСЭН ЗУН” уралдаан /IX/5-IX/14/*

Үндэсний бичиг, соёл, номын өдрүүдийг угтан Өмнөговь аймгийн ЕБСургуулиудын сурагчдын дунд бүтээлч уншлагыг дэмжих, тэргүүний сурагчдын ном унших, номын тэмдэглэл хөтлөх арга барилыг сурталчлах тэргүүн туршлагыг бусдад хуваалцах зорилгоор “Номтой өнгөрүүлсэн зун” зуны амралтаар уншиж хөтөлсөн номын тэмдэглэлийн уралдааныг дунд, ахлах 2 насны ангиллаар зохион байгууллаа. Уралдаанд 75 сурагч номын тэмдэглэлээ ирүүлснээс

Дунд ангийн төрөлд /40 сурагч/

1-р байр Б.Должидмаа (4 дүгээр сургуулийн 8в анги)
2-р байр Б.Мягмарбаатар (4-р сургуулийн 6в анги)
3-р байр Б.Цэцэгдэлгэр (4-р сургуулийн 7б анги)

Ахлах ангийн төрөлд /35 сурагч/

1-р байр М.Гэгээ (3-р сургуулийн 9а анги)
2-р байр Ж.Энхсувд (3-р сургуулийн 12в анги)
3-р байр Б.Намуун (1-р сургуулийн 11б анги) нар тус тус шалгарч дурсамж, номын багцаар шагнууллаа.

4.30. *“ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД” /IX/16-IX/18/*

МУ-ын ерөнхийлөгчийн 2012 оны "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, иргэд, хүүхэд, залуучуудыг номтой нөхөрлүүлэх бүх нийтийн ном уншлагыг дэмжих 32 дахь удаагийн Үндэсний номын баяр-2022 арга хэмжээг “Илүү их уншъя” уриандор 09 сарын 16-19-ний өдрүүдэд орон нутагт тэмдэглэн өнгөрүүлж, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн төв Ажнай талбайд нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Арга хэмжээний зохион байгуулагчаар **Соёл, урлагийн газар, хамтран зохион байгуулагчаар** Аймгийн ЗДТГазар Нийгмийн Бодлогын хэлтэс, Соёл урлагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Төв номын сан, ХЖТеатр, Говийн байгаль түүхийн музей, Насан туршийн боловсролын төв, Хүүхдийн Ордон, Сургуулиуд МонголынЗохиолчдынЭвлэлийн Өмнөговь салбар, Хүслийн өргөө төв зэрэг төр болон төрийн бус байгууллагууд оролцлоо.

Арга хэмжээг нээж Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Амартөгс үг хэллээ. Номын баярын өдрүүдэд

IX/16-ны өдөр

5. Урлагийн үзүүлбэр
6. Шилдэг тэргүүний уншигчид, шилдэг ном, шилдэг уншигч гэр бүл, номын санд хөрөнгө оруулсан хувь хүн, “номтой өнгөрүүлсэн зун”, “шилдэг номын санч” шалгаруулах номын баярыг угтан зохион байгуулсануралдаануудын шилдэг оролцогчдын шагналыг гардуулах
7. “Бийрээ нийлье, Ургаа уудалья” үндэсний бичиг, угийн бичгийн сургалт
8. Шинэ, хуучин номын худалдаа
9. Номоо хандивлая аян
10. Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа

IX/17-ныөдөр

11. “Номын тэмдэглэл хөтлөх арга зүй” номын тэмдэглэл хөтлөх сургалт
12. Тэгш ой тохиож буй зохиолчийн номын үзэсгэлэн
13. “Соёлын өртөөчилсөн аялал” ЕБС-иудын төлөөллүүд
14. Танин мэдэхүйн “АХА” тэмцээн
15. “Номын азтан” шалгаруулах “ОЮУНЫ ЧИХЭР” онч үгтэй сугалаа
16. “Сугалаатай судалгаа” уншигчдын дунд номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны талаар судалгаа
17. “Үлгэр амилах цаг” хүүхэд хөгжүүлэх арга хэмжээ
18. ‘’MC children’s book’’ төслөөр ирсэн хүүхдэд зориулсан англи номын үзэсгэлэн
19. Төв номын сангийн сан хөмрөгт шинээр ирсэн ном хэвлэлийг танилцуулах үзэсгэлэн

IX/18-ны өдөр

- “Үлгэр амилах цаг” хүүхэд хөгжүүлэх арга хэмжээ
- ‘’Хүүхдээ хэрхэн номоор хөгжүүлэх вэ?’’сургалт, мэдээллийн арга хэмжээ
- Зөөврийн номын сангийн үйлчилгээ зэрэг үйл ажиллагаануудыгзохион байгууллаа.

Өмнөговь аймгийн Хүүхдийн ордны морин хуурын “Гурван сайхны эгшиглэн” чуулга, дууны дугуйлангийн сурагчид, амьд хөгжмийн хамтлагийн сурагчид “Миний ном” дуу, бүжигчин сурагч Б.Тэмүүлэн чөлөөт бүжгийн үзүүлбэрийн тоглолтуудаар номын баярын нээлтийн үйл ажиллагааг мялаалаа.

“ШИЛДЭГ НОМЫН САНЧ” уралдаан

Номын санчдын бүтээлч санаачилгыг идэвхжүүлж дэмжин урамшуулах, харилцан бие биеэсээ суралцах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор сумдын соёлын төвүүдийн номын санчдын дунд зарласан уралдаанд өөрсдийн ажил үйлсээрээ манлайлан идэвхтэй оролцож 7 сумын номын санч материалаа ирүүлж оролцсон.

IX/16“НОМТОЙ ӨНГӨРҮҮЛСЭН ЗУН” уралдаан

Өмнөговь аймгийн ЕБС-ийн 6-8, 9-12 дугаар ангийн сурагчдын бүтээлч уншлагыг дэмжих, номын тэмдэглэл хөтлөх арга барилыг сурталчлах, урамшуулах, тэдний туршлагыг бусдад хуваалцах зорилгоор “НОМТОЙ ӨНГӨРҮҮЛСЭН ЗУН” номын тэмдэглэлийн уралдааныг 09 сарын 05-14-ний өдрийн хооронд зохион байгууллаа.

“ОЮУНЫ ЧИХЭР”онч үгстэй номын азтаны сугалаа

Баярын арга хэмжээний үеэр оролцогчдын дунд 200ш сугалааг сугалуулж 1 азтанд номын багцын бэлэг гардууллаа. ***Азтан:*** 4-р сургуулийн 6а ангийн сурагч Г.Баярбаясгалан шалгарч номын багцаар шагнууллаа.

“ТАНИН МЭДЭХҮЙН АХА”тэмцээн

Номын баярын үйл ажиллагаанд оролцогч сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд 31 хүүхэд хамрагдаж оюуны мэдлэгээ сорьж оролцсоноос

1-р байр 3-р сургуулийн 8г ангийн сурагч М.Ганбаатар 2-р байртад 1-р сургуулийн 10б ангийн сурагч Л.Энх-Үжин нар шалгарч номын багцаар шагнууллаа.

“ҮЛГЭР АМИЛАХ ЦАГ” хүүхэд хөгжүүлэх арга хэмжээ

"Хүслийн өргөө" төвтэй хамтран хүүхдийг бага наснаас нь эхлэн номд дуртай болгох, хэл ярианы хөгжлийг нь дэмжих, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх зорилгоор 0-6 насны хүүхдүүдэд хормогчин театрын үзүүлбэр, чөлөөт уншлагыг зохион байгууллаа. Хүүхэд хөгжүүлэх өдрийн арга хэмжээнд 40 хүүхэд эцэг эхийн хамтаар оролцлоо.

“ХҮҮХДЭЭ ХЭРХЭН НОМООР ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?”сургалт, мэдээллийн арга хэмжээ

Ирээдүйн уншдаг иргэдийг төлөвшүүлэхэд эцэг эхчүүдийн оролцоог дээшлүүлэх, хүүхдүүддээ ном уншиж өгөхөд цаг гаргах, хамтдаа цагийг өнгөрөөх зорилгоор зохион байгуулсан арга хэмжээнд 21 эцэг эх хүүхдийнхээ хамт оролцсон.

“НОМ ХАНДИВЛАЯ” аян

- Сумдын номын сангийн сан хөмрөгийг баяжуулах хандивын хайрцгийг байршуулж

байгууллага хувь хүмүүсийн номын 20 ширхэг ном хандивын хайрцагтаа цуглууллаа.

- Монголын Зохиолчдын Эвлэлийн гишүүн Өмнөговь аймаг дахь салбарын тэргүүн Ц.Галбадрах өөрийн зохион гаргасан номын дээжүүдээс манай сан хөмрөгт хандивласан.

“ШИЛДЭГ ХАНДИВЛАГЧ” шагнал гардуулах үйл ажиллагаа

Номын санд хамгийн олон ном хандивласан,сан хөмрөгийг танин мэдэхүй, уран зохиол, хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх 67 нэр төрлийн 87 ширхэг, 2 сая төгрөгийн номоор баяжуулсан иргэнээр Б.Эрдэнэбаярын гэр бүлийг шалгаруулан шилдэг хандивлагч өргөмжлөлөөр шагнасан.

“БИЙРЭЭ НИЙЛЬЕ, УРГАА УУДАЛЪЯ”

Үндэсний бичиг, угийн бичгийн “Удмаа мэдэж судраа цуглуулъя” сэдэвт сургалт сурталчилгаа хийж, иргэдэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулж мэдээлэл зөвлөгөө өглөө. "ЗАЛУУС" хөтөлбөрийн хүрээнд "Өв соёл" өдөрлөгийг зохион байгуулж үндэсний бичиг үсэг,өв соёлоороо бахархан судалж уламжлан хөгжүүлэх, уран бичлэгт сонирхон суралцуулах үйлийг дэмжсэн үйл ажиллагааг Өмнөговь аймгийн Насан туршийн боловсролын төвийн хамт олон зохион байгуулж ажиллалаа.

“БИЙРЭЭ НИЙЛЬЕ” уран бичвэрийн уралдааны нээлтийн үйл ажиллагаанд оролцож буй ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохиож, номын сангийн байранд бичвэрүүдээр үзэсгэлэн гаргаж шилдэг бичвэрийг шалгаруулллаа. Нийт 18 сурагч уран бичвэр бичиж оролцсоноос шилдэг 3 оролцогчийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

1-р байр Б.Энхмэнд /5-р сургууль 12б анги/

2-р байр Х.Маралжингоо /5-р сургууль 10б анги/

3-р байр Ө.Ганди /1-р сургууль 12г анги/ нар тус тус шалгарч дурсамж, номын багцаар шагнаж урамшууллаа.

“СОЁЛЫН ӨРТӨӨЧИЛСӨН АЯЛАЛ” номын сан, музей, театр зэрэг соёлын байгууллагуудын үйл ажиллагаатай сурагчдыг танилцуулах аялалд 31 хүүхэд оролцож номын сангийн үйлчилгээний танхимууд, иргэдэд хүргэдэг үйлчилгээний талаар мэдээ мэдээллийг хүргэлээ.

“НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ АРГА ЗҮЙ” сургалт

ЕБСургуулийн 5-9-рангийн сурагчдын дунд ном уншлагыг сурталчлах, бүтээлч байдлыг идэвхжүүлэх, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх тухай сургалтыг номын баярын хүрээнд зохион байгууллаа. Сургалтад 20 хүүхэд хамрагдсан.

СЭДЭВЧИЛСЭН номын үзэсгэлэн

- "MC CHIDREN’S BOOK" төслийн "Аймаг бүрд 1000 ном" аянаар манай номын сангийн англи хэлний танхимд ирсэн хүүхдэд зориулсан англи хэл дээрх 80 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж уншигч иргэддээ танилцууллаа.
- IX/06-19 өдрийн хооронд Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан номын баярын өдрүүдэд Соёл урлаг сэтгүүлүүдээр үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнд 25 сэтгүүлийг гаргаж 154 хүнд хүргэн ажиллалаа.
- IX/06-19 өдрийн хооронд номын баярыг тохиолдуулан "Алтан намар" номын үзэсгэлэнг 32 ширхэг номоор гаргаж 154 уншигчид хүргэн ажилласан.

ШИНЭ номын үзэсгэлэн

Номын санд шинээр ирсэн номуудаар шинэ номын үзэсгэлэн гаргаж талбай дээр болон номын сандаа гарган нийтэд танилцууллаа. Уран зохиолын болон хүүхдийн танин мэдэхүйн 60 ширхэг номоор хүнд хүргэлээ.

“ШИНЭ НОМЫН ХУДАЛДАА”

Аз хур номын их дэлгүүртэй хамтран номын баярын өдрүүдэд иргэдэд зориулсан хувь хүний хөгжил болон уран зохиолын олон нэр төрлийн номын худалдааг зохион байгууллаа.

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ ХҮҮХДҮҮДИЙН НОМЫН ТЭМДЭГЛЭЛИЙН үзэсгэлэн

Ном уншдаг хүүхдүүдийн зуны амралтаараа хийсэн номын тэмдэглэлүүдээр үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Үзэсгэлэнд нийт 75 хүүхдүүд тэмдэглэлээ ирүүлсэн.

“ТЭГШ ОЙ” тохиож буй зохиолчдын номын үзэсгэлэн

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг, алдарт Гавьяат уран зохиолч, хувьсгалт хэвлэл, утга зохиол, судлал шүүмжлэл, урлагийн нэрт зүтгэлтэн С.Буяннэмэхийн 120 жилийн ой, Төрийн хошой шагналт, УГЗ, Монголын орчин үеийн уран зохиолын гол төлөөлөгчдийн нэг, жүжгийн зохиолч, монголын театрын урлагийн анхдагчдын нэг Д.Намдагийн 101 жилийн ойг тохиолдуулан уг зохиолчдын 45 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж олон нийтэд толилууллаа.

ОНЦЛОГ НОМЫН үзэсгэлэн

Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байдаг хамгийн жижиг болон том, 1957 онд хэвлэгдсэн Үндсэн хууль, арьсан хавтастай хуучин номуудаар үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Үзэсгэлэнд 40 ширхэг ном багтсан.

“Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГ” гардуулах үйл ажиллагаа

Номын баярыг тохиолдуулан ном уншдаг хүүхдүүдээ урамшуулах, хүүхдүүдийн идэвхийг дэмжих зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиудаас шилдэг уншигч хүүхдүүдийг Д.Нацагдоржийн тэмдгээр шагнахаар шалгаруулав.

Б. Должидмаа (4-р сургуулийн 8В анги)

Ц.Содном-Янжид (1-р сургуулийн 10А анги)

М.Өлзийхишиг (3-р сургуулийн 9А анги) нар тус тус тодорч шагнагдлаа.

"ШИЛДЭГ УНШИГЧ ГЭР БҮЛ" шагнал гардуулах үйл ажиллагаа

Өрхийнгишүүн бүр нь ном уншиж өөрсдийгөө хөгжүүлэхээс гадна орчин тойрныхоо хүмүүсийг ном уншлагад уриалдаг, номын сангийн байнгын уншигч шилдэг уншигч гэр бүлээр А.Мөнхжаргалын гэр бүлийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

"ЗОХИОЛЧДЫН ГАРЫН ҮСЭГТЭЙ" номын худалдаа, үзэсгэлэн

Орон нутгийн зохиолчдын төлөөлөл МЗЭ-ийн Өмнөговь аймаг дахь салбарынхан Номын баярын арга хэмжээнд ном зохиолоо сурталчлан танилцуулан оролцож, гарын үсэгтэй номын худалдааг зохион байгуулсан.

"СУГАЛААТАЙ СУДАЛГАА"Номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаа, ном, хэвлэлийн хүрэлцээ хангамжийн тухай судалгааг бүх насны иргэдээс авсан. Судалгаанд 70 хүн хамрагдаж өөрсдийн санал хүсэлтээ ирүүлсэн. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор судалгааг сугалаатай зохион байгуулж азтанаар Б.Энх-Амгалан тодорч номын багцаар шагнуулсан.

ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН үйлчилгээ

Номын баярын үйл ажиллагааг сумдад тэмдэглэх, ном хэвлэлийг сурталчлах, ажил мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулах зорилгоор Хүрмэн, Булган, Ханхонгор сумдад зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллалаа. Уг өдрүүдэд сумдад дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

- Сурагчдын дунд "АХА" тэмцээн
- Бага ангийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдэд "ХОРМОГЧИН ТЕАТР"
- Дунд ангийн сурагчдын дунд "НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ" сургалт
- Номын санчдын ажил арга зүйн "ЗӨВЛӨН ТУСЛАХ" үйлчилгээ
- "ШИНЭ НОМ"-ын үзэсгэлэн
- "ШИНЭ НОМ"-ын худалдаа

"АХА" тэмцээн

Сурагчдын дунд зохион байгуулсан танин мэдэхүйн "АХА" тэмцээнд дунд ангийн сурагчид оролцож оюун ухаанаараа уралдлаа. Нийт 71 сурагч хүүхдүүд оролцсон.

"ХОРМОГЧИН ТЕАТР"

Хүүхэд багачуудад үлгэрийг сонирхолтой аргаар уншиж өгөх, үлгэрээр хүүхдийг хөгжүүлэх, соёл танин мэдэхүйн ажилд хүүхдийг тэш оролцуулах хэрэглүүр болгон ашиглах Хормогчин театрыг номын баярын зардлаас сум тус бүрд 2 ширхэгийг шийдвэрлэн хүргүүлж ажиллаа.

"НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ" сургалт

Өөрсдийн уншсан номоор хэрхэн тэмдэглэл хөтлөх талаар сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 60 сурагчдыг сургалтад хамрууллаа.

"ЗӨВЛӨН ТУСЛАХ" үйлчилгээ

Номын санчдын өдөр тутмын ажлын үйл ажиллагаа, бүртгэлийн дэвтрийн хөтөлгөө, номзүйн бичилт, фондын эмх цэгц, программд ном оруулсан байдал, данс бүртгэлүүдийн үнэн зөв эсэх дээр хяналт тавин ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

"ШИНЭ НОМ"-ын үзэсгэлэн

Номын санд шинээр ирсэн хүүхдийн, уран зохиол болон бусад шинжлэх ухааны Монгол, англи 105 ширхэг номуудаар үзэсгэлэн гаргаж танилцууллаа.

4.31. “МЭДЛЭГТЭЙ, МЭДЭЭЛЭЛТЭЙ 40 ХОРОМ” /X/11/

Хүүхдийг номтой нөхөрлүүлэх, хамтын уншлагыг дэмжих зорилгоор 1-р сургуулийн С.Түмэнжаргал багштай 4д ангийн сурагчдын дунд өдрийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Мэдэээлийн арга хэмжээнийн хүрээнд номын сангийн үйл ажиллагаа, зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээний талаар мэдээлэл хүргэн "Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ?" сургалт, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгууллаа. АХА тэмцээнд сурагч Г.Маралчмичид, М.Дарханбат нар хамт олноо манлайлан оролцож дурсгалын зүйл, номын бэлгийн эзэн боллоо. Оролцогч 48.

4.32. “ДАРААГИЙН ХУУДАС” хэлэлцүүлэг /X/13/

Нэпко Кидс хэвлэлийн газартай хамтран сургуулийн номын санчид, цэцэрлэг, сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтнуудад хүүхдийн номын онцлог, хүүхдийн шилдэг номдын танилцуулга, хүүхдэд ном уншуулах арга зүйн талаар харилцан мэдээлэл солилцох хэлэлцүүлэг мэдээллийн арга хэмжээг зохион байгууллаа. Оролцогчид 24.

4.33. “ЭРХЭМ ЗОХИОЛЧ ТАНАА” / XI/1-XI/16 /

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан, “Соёлын сар”-ын хүрээнд зохион байгуулсан зохиолчид хандсан захидлын уралдааныг Өмнөговь аймгийн иргэд, хүүхэд залуучуудын дунд уралдааныг 3 насны ангиллаар зохион байгууллаа. Иргэдийн уншиж хөгжиж буй сайн туршлагыг бусдад хуваалцах бүтээлч уншлагыг дэмжих, тэдний уншиж буй зохиол бүтээл, зохиолчийн тухай судалгаа дүгнэлт гарган номын сангийн цаашдын соёл танин мэдэхүйн ажил үйл ажиллагааг төлөвлөхөд хэрэглэгдэхүүн болгон ашиглах зорилгоор зарласан уг уралдаанд 125 оролцогч захидлаа ирүүлж оролцсоноос

Насанд хүрэгчдийн ангилалд

I байр Ч.Амгалан
II байр А.Мөнхжаргал
III байр Г.Цэнгэлмаа
IV байр М.Ууганцэцэг

Ахлах ангийн ангилалд

I байр Б.Энхмэнд 5-р сургууль 12Б ангийн сурагч
II байр Э.Сарангарав Политехникийн коллеж III курсийн оюутан
III байр Т.Мөнхзаяа Политехникийн коллеж 10А ангийн сурагч
IV байр Б.Энхнаран I сургууль 11Б ангийн сурагч

Дунд ангийн ангилалд

I байр Э.Тэнүүн II сургууль 5А анги сурагч

II байр Б.Мишээл I сургууль 8А анги сурагч
III байр П.Зулзаяа II сургууль 5А анги сурагч
IV байр А.Монголжин I сургууль 5Б анги сурагч нар тус тус шалгарлаа.

Уралдааны шилдэг оролцогчид маань шагналаа Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдөр зохион байгуулагдсан Зохиолч-Уншигчдын уулзалтын үеэр өөрсдийн хайрлаж хүндэтгэдэг зохиолчдоос шагналаа гардан авсан төдийгүй, хаяглан бичсэн зохиолчдоо захидлуудаа гардуулан өгсөн юм.

Хамгийн олон захидал хаягласан зохиолч яруу найрагчид:
МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Т.Очирхүүд 11 захидал
Төрийн шагналт, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнд 10 захидал
МЗЭ-ийн шагналт Хүүхдийн зохиолч О.Сундуйд 9 захидал
МУСГЗүтгэлтэн Яруу найрагч Ц.Хуланд 7 захидал хаягласан ирүүлсэн байлаа.

4.34. “МОНГОЛ БИЧГИЙН СУРГАЛТ” /XI/3/

Соёлын сарын хүрээнд соёл урлагийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан болон ЕБСургуулиудын мэргэжлийн номын санчдын дунд компьютер дээр Монгол бичгээр бичих анхан шатны сургалтыг зохион байгууллаа. Хамрагдсан хүн 11.

4.35. “ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ” / XI/17/

Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан, “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг зохион байгууллаа.

Уулзалтанд Өмнөговь аймагт зохион байгуулагдсан "УРАН ҮГСИЙН ЧУУЛГАН"-д урилгаар оролцогч Ардын багш, Соёлын гавьяат зүтгэлтэн, эрдэмтэн зохиолч Лувсандамбын Дашням, Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн, “Болор цом”-ын эзэн Дамбын Төрбат, Соёлын гавьяат зүтгэлтэн, Д.Нацагдоржийн шагналт, яруу найрагч Эрэнжидийн Хархүү, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Санжаагийн Байгальсайхан, Д.Нацагдоржийн шагналт яруу найрагч, доктор Хургаагийн Сүглэгмаа, Д.Нацагдоржийн шагналт яруу найрагч Пэрэнлэйн Нямлхагва, ”Болор цом”-

ын эзэн, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Норовын Гантулга, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Балжийн Бүргэд болон чөлөөт уран бүтээлчид, Даланзадгад сумын "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэг"-т сурагчид, утга зохиол сонирхогч номын клубын хүүхдүүд оролцлоо. Оролцогчид 72.

5. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээнүүдийг Говь HD-3 удаа, Говийн наран ТВ-4, Мэлмий сайтаар 7 удаа, Олон нийттэй харилцах хэлтэсд 4 удаа тус тус хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 18 удаа, байгууллагын нүүр ном хуудсаар 531 удаа мэдээ, мэдээлэл тавьж олон нийтэд үйлчилгээ үйл ажиллагаагаа сурталчилж ажиллав. 30 хүнд интернэт, компьютерийн үйлчилгээ үзүүлж мэдээлэл өгч ажиллав.

Сан хөмрөгийн хуучин ном хэвлэлийг сурталчлах, тэмдэглэлт өдрүүд, тодорхой сэдвийг хамарсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 51 удаа 1658 ширхэг номооргарган 6191 хүнд, шинэ ном хэвлэлийг уншигчид олон нийтэд танилцуулах номын үзэсгэлэнг нийт 17 удаа 618 ширхэг номоор гарган 1689 хүнд танилцуулж ажиллалаа.

5.31. Шинэ номын үзэсгэлэн /17 удаа 618 ширхэг номоор 1689 хүнд/

- Нийтийн уншлагын танхим – 4 удаа 73 ширхэг номоор /558 хүнд/
- Гэрээр ном олгох танхим – 4 удаа 130 ширхэг номоор /187 хүнд/
- Хүүхдийн уншлагын танхимаас- 2 удаа 115 ширхэг номоор/297 хүнд/
- Үндсэн сан хөмрөгөөс -6 удаа 244 номоор 437 үзэгч
- Мэдээллийн төвөөс – 1 удаа 56 номоор 210 хүнд

5.32. Номын сэдэвчилсэн үзэсгэлэн /51 удаа 1658 ширхэг номоор 6191 хүнд/

Нийтийн уншлагын танхимаас 11 удаагийн үзэсгэлэнг нийт 480 ширхэг номоор гаргаж 1047 хүн үзэж сонирхсон

1. II/21. Гадаад хэлний номын үзэсгэлэн 35 ном 55 хүн үзсэн
2. III/03. Төрөл бүрийн хоолны номоор үзэсгэлэн гаргасан 32 ном 145 хүн үзсэн
3. III/17. Яруу найргийн номоор үзэсгэлэн гаргасан 36 ном 83 хүн
4. III/30. Өсвөр насны хүүхдүүдэд зориулсан номын үзэсгэлэн 35 номоор
5. IV/8. Хамгийн их борлуулалттай номын үзэсгэлэн 34 номоор 146 хүн үзсэн
6. V/16. Өрхийн үйлдвэрлэл сэтгүүлээр үзэсгэлэн гаргасан 96 сэтгүүл 52 хүн
7. VI/27. Хувь хүний хөгжлийн номоор үзэсгэлэн гаргасан34ном 57хүн
8.VIII/11.Залуу эмэгтэй заавал унших номоор үзэсгэлэн гаргасан 32ш ном 170 хүн
9.IX/28. Монголын түүх номоор үзэсгэлэн гаргасан 27ш ном 64хүн үзсэн
10.X/14. Мэргэжлийн номоор үзэсгэлэн гаргасан. 30ш ном 150 хүн үзсэн
11. XI/15. Ууран үгсийн чуулган 2022 зохиолч яруу найрагчдын номын үзэсгэлэн нийт 89 ном 67 хүн

Хүүхдийн уншлагын танхимаас 11 удаа 282 номоор үзэсгэлэн гаргаж 1769 хүүхэд, багачуудад танилцуулсан байна

1. **I/25.** Монгол ардын үлгэрийн номоор үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэн 17 номоор, цахимаар нийт 69 хүн үзсэн.
2. **II/16.** Ханс Кристиан Андерсений зохиолоор үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэн 20 номоор, цахимаар нийт 84 хүн үзсэн.
3. **III/11.** Хүүхдийн зохиолч Д.Гармаагийн уран бүтээлээр номын үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэн 20 номоор, цахимаар нийт 77 хүн үзсэн.
4. **IV/16.** Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол “Эрдэнэсийн сан”-108 боть 36ш номоор үзэсгэлэн гаргаж, цахимаар 124 хүн үзэж, танхимаар 2 ангийн 62 сурагчид уншиж танилцсан.
5. **V/9.** О.Сундуйн зохиол 10ш номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 15 хүн үзэж, танхимаар 5 ангийн 135 сурагчид уншиж танилцсан.
6. **VI/11.** Ч.Алагсай зохиол 16 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 150 хүн үзэж, танхимаар 93 сурагчид уншиж танилцсан.
7. **VII/9.** А.Барто зохиол 16 номоор сэдэьчилсэн үзэсгэлэн гаргаж цахимаар 71 хүн үзэж, танхимаар 33 сурагчид уншиж танилцсан.
   танхимаар 52 хүүхэд уншиж танилцсан байна.
8. **VIII/15.** Орос ардын үлгэр сэдэвчилсэн үзэсгэлэн 27 номоор гаргаж цахимаар 77 хүн үзэж, танхимаар 21 сурагчид уншиж танилцсан байна.
9. **IX/10.** С.Маршакийн зохиолоор сэдэвчилсэн үзэсгэлэн 20 номоор гаргаж цахимаар 51 хүн үзэж, танхимаар 54 хүүхэд уншиж танилцсан байна.
10. **X/15.** Монгол ардын үлгэрээр сэдэвчилсэн үзэсгэлэн нийт 50 номоор гаргаж, цахимаар 197 хүн үзэж, танхимаар 180 хүүхэд уншиж танилцсан.
11. **X/24.** Танин мэдэхүй болон уран зохиолын нийт 50 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 180 хүн үзэж, танхимаар 96 хүүхэд уншиж танилцсан.

Гэрээр ном олгох танхимаас үзэсгэлэнг 10 удаа 338 номоор гаргаж 695 хүн үзэж танилцсан

1. I/31. Ардын дууны номоор 32ш номоор үзэсгэлэн 67 хүнд хүрсэн
2. II/10. Хайр сэдэвт 32ш номоор үзэсгэлэн 210 хүнд хүрсэн
3. III/7. Март сэдэвт 32ш номоор үзэсгэлэн 114 хүнд хүрсэн
4. III/18. Цэргийн баярт зориулсан 32ш номоор үзэсгэлэн 46 хүнд хүрсэн
5. V/13. “Жаргалтай гэр бүл” сэдэвт 50ш номоор үзэсгэлэн гаргаж 83 хүнд хүрсэн
6. V/31. “Бяцхан уншигчиддаа сэдэвт 32ш номоор үзэсгэлэн гаргаж 58 хүнд хүрсэн
7. VIII/01."Хувь хүний хөгжил"сэдэвт 32ш номоор үзэсгэлэн гаргаж 41 хүнд хүрсэн
8. X/07. Эрүүл мэнд сэдэвт 32ш номоор үзэсгэлэн гаргаж 28 хүнд хүрсэн
9. XI/22. Эх түүх сэдэвт 32ш номоор үзэсгэлэн гаргаж 21 хүнд хүрсэн
10. XII/9. Баярын ширээ сэдэвт номын үзэсгэлэн 32ш ном 27 хүнд хүрсэн

Үндсэн сан хөмрөгөөс 15 удаагийн үзэсгэлэнг 436 ширхэг номоор 2238 хүн үзэж танилцсан.

Мэдээллийн төвөөс 4 удаагийн үзэсгэлэнг гаргаж 122 ширхэг номоор 442 хүн үзэж танилцсан.

1. САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

2022 онд **500** нэр төрлийн **1057** ширхэг монгол ном, **32** нэгж сонин, сэтгүүлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. /Нийт **19,431,500** төгрөгийн/

Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр – 14,218,600 төгрөгийн 364 нэр төрлийн 794 ширхэг ном
- Орон нутгийн төсвөөр- 900,000 төгрөгийн 23 нэр төрлийн 39 ширхэг ном
- Бэлэг хандиваар ирсэн – 3,261,500 төгрөгийн 109 нэр төрлийн 209 ширхэг ном
- Заавал авах хувиар авсан – 520,000 төгрөгийн 4 нэр төрлийн 15ширхэг ном
- Сонин сэтгүүл– 531,400 төгрөгийн 32 нэгж

Сан хөмрөгийн баяжилт шинжлэх ухааны ангиар

Ашиглалтын явцад урагдаж гэмтсэн **219** ширхэг номын сэлбэн засаж ашиглалтыг уртасгах арга хэмжээ авч ажиллалаа.

Байгууллагын их цэвэрлэгээний өдрөөр өрөө танхим болон ном хэвлэлийг ариутган ажиллахын зэрэгцээ гэрээр болон танхимаар уншлага үйлчилгээнд гарсан 1058 ширхэг номыг 21 удаа ариутгасан байна.

Ном хэвлэл хадгалалт, хамгаалалт, орчин, нөхцлийн стандарт хангалтад анхаарч барилгын одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох МХГазрын дүгнэлт гаргуулан барилгын их засварын асуудлыг аймаг орон нутагт уламжиллаа.

2. КАТАЛОГИ, НОМЗҮЙ, ЛАВЛАГАА

- 2022 онд 451 нэр төрлийн 1011 ширхэг ном, сонин, сэтгүүлд падаан бичиж, иж бүрэн техник ажиллагаа хийж, нэг бүрчилсэн бүртгэл болон танхимуудын дансанд бичиж, https://lib4u.net/pro/?lib=umnugovi программд оруулж, бар кодыг хэвлэж заал танхимуудад хуваарилан хүлээлгэн өгсөн.
- Цахим каталогт хандалтын тоо 4310
- Иргэд, уншигчдад цахим болон бусад хэлбэрээр нийт 4552 лавлагааг хүргэснээс
    - Цахим 4344
    - Сэдэвчилсэн лавлагаа 127
    - Ном зүйн лавлагаа 30
    - Тодотгосон лавлагаа 87
    - Статистик тоо баримт 18
- Татгалзалд 64 ном бүртгэгдсэн байна.
- 2022 онд мэргэжлийн ажилтнууд 7 ном зүйг бэлтгэн гаргаж үйлчилгээнд ашиглаж байна. Үүнд: Каталогч М.Баасанжав 2 удаа шинэ номын мэдээ, Хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Ренчиндаваа Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол “Эрдэнэсийн сан” -108 боть номын 40 номоор ном зүйг хийж уншигчдад хүргэсэн бол Нийтийн уншлагын танхимын номын санч Н.Даваажаргал “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” номзүй, Гэрээр ном олгох танхимын номын сан М.Сувданцэцэг “Монгол ардын ёс заншил”, Фондчин Т.Нямсүрэн Их зохиолч Д.Нацагдоржийн намтар ном зүй, Орчин цагийн монгол хэлний дүрмийг үндэслэгч эрдэмтэн, орчуулагч, зохиолч Ц.Дамдинсүрэнгийн32ш номоор бүртгэн мэдээлэх номзүйг тус тус хийж үйлчилгээ, лавлагаанд ашиглаж байна.
- Сан хөмрөгийн 5 номыг цахим хэлбэрт оруулж уншигчид цахимаар ашиглах боломжийг бүрдүүлсэн ба хуучин онуудад цахим болгосон номуудыг оролцуулаад хагас жилээр нийт 12 төрлийн ном, номзүйг 9187 удаа уншсан байна.
- Өмнөговь нутгийн бахархал аяны хүрээнд аймгийн түүхэн хүмүүс, газар нутаг, ан амьтны талаар 8 мэдээлэл бэлтгэн цахимд байршуулсныг 2339 хүн үзсэн хандалттай.
- Үлгэрийн цаг видео контентыг 342 хүн, номын сангаас бэлтгэн цахимд байршуулсан видеонуудыг 1234 хүн үзсэн хандалттай байна.

3. СУРГАЛТ, АРГА ЗҮЙ

Зохион байгуулсан арга зүйн ажлууд

- IV/24. Тус номын сангаас сумдын номын санчдыг мэргэжил, арга зүйгээр хангах ажлын хүрээнд жишиг номын сангийн туршлага, номын санчийн ажлын төлөвлөлт, хэрэгжилт хэрхэн хийх талаар зөвлөгөө, зөвлөмж өгч, аймгийн хэмжээнд зарлагдаж буй номтой холбоотой уралдаан, арга хэмжээнүүдийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны асуудлуудыг цахим уулзалтаар хэлэлцэж ярилцлаа.
- III/25. Даланзадгад сумын хэмжээнд иргэд, хүүхэд, залуучуудын ном уншлагыг нэмэгдүүлэх, иргэдийг номоор дамжуулан хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлын чанар хүртээмжийг сайжруулахад талуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах зорилготой уулзалт арга хэмжээ амжилттай зохион байгууллаа. Уулзалтад Даланзадгад сумын Засаг дарга Х.Батболд, АЗДТГазрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн Э.Мягмарсүрэн,

Даланзадгад сумын Боловсрол, соёл хариуцсан бодлогын мэргэжилтэн С.Болд, Даланзадгад сумын ЕБСургуулиудын номын санчид, Даланзадгад сумын 8 багийн зохион байгуулагч нар оролцлоо.Уулзалт, хэлэлцүүлэгт оролцогсдод аймгийн Төв номын сангийн зүгээс үйлчилгээ үйл ажиллагааны танилцуулга хийж, хамтран ажиллах шийдлүүдийг санал болгон толилууллаа. Үүнд:

Дарга А.Одончимэг Номын сангийн Соёл танин мэдэхүйн ажлууд, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа Номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны мэдээлэл, Фондчин Т.Нямсүрэн номын сангийн цахим үйлчилгээнүүдийн талаар мэдээлэл хүргэлээ.

- IV/04-IV/08. Шинэ номын санчдыг дадлагажуулах хүрээнд ажлын байрны дадлага Сургалтад Сэврэй сумын Соёлын төвийн номын санч Ц.Дэлгэрмаа, Цогтцэций сумын номын санч Б.Шинэбаяр нарыг хамруулж номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны талаарх мэдлэг, чадварыг олголоо
- Сүхбаатар аймгийн нийтийн номын сан манай номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны сайн туршлага судлахаар ирсэнтэй холбогдуулан тэдэнд үйл ажиллагаагаа танилцуулан, “Монгол бичгээр цахимд бичих нь” сургалтыг өгч арга зүйн ажил зохион байгууллаа.
- 13 сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын санчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. 2022 онд “Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд хуваарилсан номуудыг бүртгэсэн эсэх, данс бүртгэлүүдийг үнэн зөв хөтөлж буй байдал, Openbiblio программд ном оруулсан байдал, өдөр тутмын үйл ажиллагаатай танилцаж зөвлөн тусалж ажиллалаа.
- Өмнөговь аймгийн сумдын соёлын төвүүдийн болон сургуулиудын номын санчдад зориулсан "Номын сангийн үйл ажиллагаанд хөтлөгдөх бүртгэлүүд", байгууллагын мэргэжлийн ажиллагсадад "Номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа" сургалтыг XI/14-XI/16-ны өдрүүдэд МҮНСантай хамтран зохион байгууллаа. Сургалтад 20 номын санч, мэргэжилтэн хамрагдлаа.
- XI/04. Соёлын сарыг тохолдуулан соёлын байгууллагын бичиг хэргийн ажилтан албан хаагчдын дунд “Монгол бичгээр компьютер дээр бичих нь” анхан шатны сургалтыг зохион байгууллаа.

Дотоодын сургалт

1. I/20. “Ухаалаг цахим хэрэглээ”НТБТөв багш Э.Амартүвшин
2. II/17. “Хөдөлмөрийн шинэчилсэн найруулга” Үйлдвэрчний эвлэлийн ажилтан Т.Будсүрэн
3. III/25. “Амьдралаа гайхамшиг болгоё”НТБТөв багш О.Нарантуяа
4. III/31. “Мөнгөө ухаалгаар удирдах нь”НТБТөв багш Э.Амартүвшин
5. IV/28. Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Т.Ганболд манай хамт олны дунд "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хууль" сэдэвт сургалт.
6. X/06. Хаан банкны бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга мэдээлэл.

7. X/20.“Өөрийгөө хайрлахуй” сургалт ГБХЗХГазар сэтгэл зүйч Ц.Оролзод.
8. XI/14-16."Номын сангийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа" сургалт МҮНСангийн МАЭШХэлтсийн дарга Т.Хайдав
9. XI/30.“Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалт Н.Даваажаргал
10. XI/30.“Номын сангийн стандарт” сургалт каталогч М.Баасанжав
11. XII/01.“Төрийн албан хаагчийн үйлчилгээний бүтээмж” сургалт М.Сувданцэцэг
12. Монгол бичгийн хэрэглээ болгох зорилгоор ажилтнууд бие даан монгол бичгийн чадвараа дээшлүүлэх Сургалтад хамрагдахын зэрэгцээ монгол бичгийн хуулан бичлэг, хичээнгүй бичлэгийн дэвтэртэй болж монгол бичгийн мэдлэгээ сайжруулж ажиллалаа.

Ажилтан, ажиллагсад гадны сургалт, зөвлөгөөнд хамрагдсан байдал

1. II/25. Аймгийн соёл, урлагийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн /А.Одончимэг, Н.Даваажаргал, Т.Нямсүрэн/
2. III/03. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дагаж гарсан журмын тухай хууль” бичиг хэргийн ажилчдын нэгдсэн сургалт / Б.Оюунзаяа /
3. III/30. Цахим Өмнөговь И-Монгол аппликэшний Төрийн албан хаагчдад зориулсан сургалт / Б.Оюунзаяа, А.Одончимэг /
4. IV/22. Өмнөговь аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн хуралдаан /Б.Оюунзаяа, Т.Нямсүрэн, Г.Ренчиндаваа, М.Баасанжав, М.Сувданцэцэг/
5. IV/29. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого Нягтлан Т.Нарантуяа, Нярав Ц.Бадамханд
6. V/13. Хөгжлийн шийдэл ТББ-аас зохион байгуулсан “Зорилготой ажилтан” сургалт / Т.Нарантуяа Т.Нямсүрэн Х.Мөнххуяг З.Батхуяг Ц.Бадамханд /
7. V/19. Даланзадгад сумын албан байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөний үйл ажиллагаанд оролцсон./Ц.Бадамханд М.Сувданцэцэг/
8. VI/7-VI/9. “Соёлын салбарын шинэтгэлийн бодлого” төв хөдөөгийн соёлын байгууллагуудын удирдлагууд оролцсон хэлэлцүүлэг /Дарга А.Одончимэг/
9. VI/11. Даланзадгад сумаас зохион байгуулсан ХБИргэдийн тэгш боломжийг хангах нь сургалт, нөлөөллийн арга хэмжээ /Б.Ренчидаваа/

10. X/06. “Урлагийн салбарын залуучууд ба бидний нөлөөлөл” Өмнөговь аймгийн соёлын салбарын залуучуудын анхдугаар чуулганд Т.Нарантуяа, Н.Даваажаргал нар оролцсон.
11. XI/04. **"Mongolian library update-2022"** номын санч-мэдээллийн ажилтнуудын IX зөвлөгөөнд цахимаар мэргэжилтнүүд /6/

12. XI/29-XII/1. “Соёлын боловсролын үндэсний сургагч багш”-ийн анхан шатны сургалтанд А.Одончимэг.
13. XII/6-XII/7. Олон улсын санхүүгийн корпорацийн Хөгжлийн төлөө ил тод байдал хөтөлбөрөөс зохион байгуулсан “Уул уурхайн өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах нь” сургагч багшийн сургалтад А.Одончимэг

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн сургалт

1. I/13 “Аз жаргалтай ажиллахын нууц”
2. I/20 “Улсын их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцаа”-ны талаар
3. I/27 “Орчин үеийн хөгжлийн мегатрэнүүд” /гол хандлага/
4. II/10“Монгол орны хөгжлийн хэтийн төлөв”
5. II/17 “Коронавируст халдвар /ковид-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын талаар
6. III/10 “Харилцан адилгүй үеийнхнийг үр дүнтэй манлайлах нь”
7. III/17“Хүлээлтэд нийцсэн гүйцэтгэлийг тодорхойлж өгөх нь”
8. III/24“Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь”
9. III/31“Гүйцэтгэлийн сайжруулах көүчинг хийх нь”
10. IV/7 “Төрийн байгууллагын бүтээмж”
11. IV/14. “Чанарын менежментийн тогтолцоо”
12. V/5. “Төрийн албан хаагчдын ур чадварын түвшин”
13. X/20. “Төрийн албан хаагчийн ёс зүй” зэрэг сургалтуудад байгууллагын ажилтан, албан хаагчид цахимаар хамрагдан мэдлэг ур чадвараа дээшлүүллээ.

4. БУСАД АЖИЛ

1. IV/1 "Хүүхдээ сонсох өдөр"-ийн хүрээнд Даланзадгад сумын ЕБСургуулиудын 8-р ангийн сурагчдын төлөөллийг хүлээн авч уулзан тэдний уншиж буй болон уншихыг хүсдэг ном, зохиолын сэдэв, гэр бүл, сургууль, номын сангийн орчинд ном уншихад учирч буй саад бэрхшээл боломж гэээд олон сэдвээр харилцан ярилцлаа.
2. IV/29. “Хуваалцах өдөр” өдөрлөгт нэгдэж өөрсдийн хүүхдийн багадсан хувцас болон тоглоом, гоо сайхны бүтээгдэхүүн, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнээ ГБХЗХГазар, Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан “Хуваалцах өдөр” өдөрлөгт хандивласан. 11нэр төрлийн 63ш бараа материал хүлээлгэн өгсөн.
3. V/5-нд"**Үндэсний бичиг-бидний бахархал**" хичээнгүй бичгийн аянд хамт олноороо нэгдэж **“*Монгол улсын Төрийн дуулал*”**-ыг монгол бичгээр бичиж оролцсон.
4. V/8. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэж хамт олноороо мод тарьсан.

5. V/14. Даланзадгад сумын ЗДТГ-ын санаачилгаар зохион байгуулсан “Хөдөлгөөнт баг” төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх арга хэмжээнд номын сангийн үйлчилгээг хүргэж ажилласан.
6. V/18. Өмнөговь аймгийн шинэ музейн нээлтийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажилласан.

7. V/21.Аймгийн ЗДТГазраас ирүүлсэн удирдамжийн дагуу Төв номын сангийн хамт олон нийтийг хамарсан их цэвэрлэгээнд хамрагдаж хуваарьт газрын хогийг түүж цэвэрлэлээ.
8. V/30. Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөрт хамт олноороо нэгдэж оролцсон.
9. V/8. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэж хамт олноороо мод тарилаа.
10. VI/29. Хамт олноороо урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан.
11. XII/5. Томуугийн эсрэг вакцинд хамт олноороо хамрагдсан.

5. ДҮГНЭЛТ

- Цар тахлын нөхцөл байдал намжсантай холбоотой нийтийг хамарсан уралдаан, арга хэмжээнүүдийг өргөн дэлгэр зохион байгууллаа.
- Өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад танхимын үйлчилгээнд хамрагдах байдал нэмэгдэж гэрээр ном олгох үйлчилгээний тоо хэмжээний хувьд өссөн хэдий ч нийт үйлчилгээнд эзлэх хувь хэмжээний хувьд буурсан байдал харагдаж байна.
- 2022 байнгын уншигчдын тоон үзүүлтэд цэцэрлэгийн ахлах болон бэлтгэл ангийн хүүхдүүдийн номын сангаар үйлчлүүлсэн үйлчилгээний тоог оруулаагүйгээс 23 ангийн 616 хүүхдийн бүртгэл дутуу хийгдсэн. Энэ тоог уншигчдын тоонд оролцуулж тооцвол байнгын уншигчдын бодит тоо 3450 хүрсэн үзүүлэлт гарч ирж байна.
- Соёлын яам болон орон нутгийн зүгээс соёл танин мэдэхүйн ажил явуулах зардлыг шийдвэрлэж ажилласны дүнд соёл танин мэдэхүйн ажлын нэр төрөл,

тоо хэмжээ болон түүнд оролцогчдын тоо өссөн.

Сул тал:

- Барилгын давхар хооронд суулт өгсөн.
- Хүний нөөц хангалтгүй.
- Зөөврийн үйлчилгээ, сургалт зохион байгуулахад зөөврийн компьютер хэрэгцээ хангахаа байсан.

Давуу тал:

- Шинэ барилгын зураг төсөвтэй болж 2022 оны улсын төсөвт барилга барьж эхлэх төсөв суусан. Барилгын гүйцэтгэгчээр “Тэлмүүн Доной” ХХК шалгарч шав тавих ёслолыг зохион байуулсан.
- Соёл танин мэдэхүйн ажил, арга хэмжээ зохион байгуулахад яам болон орон нутгийн згээс төсвийн дэмжлэг үзүүлж байгаа.
- Өмнөх онтой харьцуулахад сан хөмрөгийн баяжилт нэмэгдсэн.
- Аймгаас хүүхдийн уншлагыг дэмжсэн “Уншдаг хүүхэд хөгждөг” аян хэрэгжүүлж байгаа нь эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид хүүхдийг номоор хөгжүүлэхэд томоохон хөшүүрэг болж байгаа нь анги хамт олны урилгат үйлчилгээ авах хүсэлтүүд, сургууль, цэцэрлэг, ангийн номын сангуудыг хүүхдийн номоор баяжуулж буй байдлаас харагдаж байгаа.

СҮХБААТАР АЙМГИЙН Г.МЭНД-ООЁОГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм зорилгын хүрээнд:

Мэдээллийн эрин зуунд номын сангийн үйлчилгээг автоматжуулах зорилгоор 12 сумдын номын санг үүлэн технологид суурилсан дэвшилтэд хувилбар LIB4U нэгдсэн программд холбож аймгийн хэмжээнд номын сангийн цахим баазыг бий болгон иргэд, монгол орны болон дэлхийн өнцөг булан бүрт байгаа хэнд ч цаг хугацаа, орон зайн хамааралгүйгээр хэрэгцээт мэдээллийг бодитой шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлээд байна. Улс болон орон нутгийн телевиз, мэдээллийн сайтууд, болон байгууллагын пэйж, пэйсбүүк хуудсуудаар үйл ажиллагааг тогтмол олон нийтэд хүргэн мэдээллээр тасралтгүй хангаж ажиллаж ирсэн.

Үйл ажиллагааны зорилт, зорилго:

Аймгийн нийтийн номын сан нь иргэдэд ном, соёлын үйлчилгээг тасралтгүй хүргэх, тэднийг мэдээ мэдээллээр хангах, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний соёлын байгууллага юм.

Номын баяжилтыг нэмэгдүүлэх, үндсэн данс бүртгэл, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд Фондын сан хөмрөгийг шинээр хэвлэгдэн гарсан шилдэг ном зохиолууд болон иргэд, уншигчдын эрэлт хэрэгцээний дагуу санал хүсэлт, татгалзал үндэслэн бүрдүүлж, төсөв болон хандиваар 11.868.374 мянган төгрөгийн 396 нэр төрлийн 722 ширхэг номыг техник ажиллагаа хийж, номын мэдээллийг электрон каталогт оруулж баркоджуулж, уншлага үйлчилгээнд гаргасан.

Мөн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор үндсэн фондын ээлжит тооллогыг зохион байгуулж, МҮҮНС-гаас өгсөн зөвлөмжийн дагуу данс бүртгэлийг шинэчилж, ангилалыг бүрэн сольж, баркод шинээр нааж хаяг ялгагч хийсэн.

Нийгмийн зорилтот бүлгүүдэд хүрч үйлчлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш ялгаваргүйгээр оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх ззорилтын хүрээнд ХБИ-д “Бид чадна-Хамтдаа хөгжье"-4 хөтөлбөрт сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна.

Тэргүүлэх чиглэл:

Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээ, арга барилыг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг өргөжүүлэн хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхтэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар номын сангийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай, хүртээмжтэй явуулахад анхаарч Судар эгшиглэн, Сониуч хүүгийн адал явдал, гэх мэт төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Номын сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодит байдлын үнэлгээ, тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам

Аймгийн Нийтийн номын сан нь өөрийн гэсэн бие даасан байргүй “Жаахан шарга” ХЖТ-т байрладаг бөгөөд Номын сангийн орчны үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5742:2019 стандартыг хангахгүй байгаа талаар 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн № 33 тоот албан бичгээр МХГ-т хүсэлт хүргүүлж, улсын байцаагчийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн №17-07-037/69 тоот дүгнэлт гарч, холбогдох газруудад тогтмол санал хүргүүлэн ажиллаж ирсэн бөгөөд аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгуулсан.

Захиргаа удирдлага зохион байгуулалтын ажил:

Уншлага үйлчилгээний чанарыг сайжруулж, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, уншигч, ирэгсэд, ном олголтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.

Байгууллагын дотоод хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөөг шинэчлэн баталж, ажлын цагийн тасалдал, цагийг үр бүтээлтэй ашиглаж хэвшин, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хугацаатай үүрэг, албан даалгаврын хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн, төсөв, санхүүгийн зарцуулалт, худалдан авч байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, байгууллагын өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан.

Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам, төлөвлөгөө, тайлан, бусад холбогдох эрх зүйн актын хүрээн дэхь хэрэгжилтийг зохих журам, дүрэм, зааврын дагуу чанартай, үнэн зөв, бодитой гарган, хариуцсан ажлын чиглэлээр мэдээ, баримтыг боловсруулахад анхаарч номын сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад үнэн зөв гаргаж өгч ажиллалаа.

Аливаа үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, албан бичгийг төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем, болон соёлын байгууллагуудын webmail.su.moc.gov.mn ашиглаж хэвшсэн. Мөн цахим гүйлгээ, төлбөр тооцоо зэргийг тоон гарын үсэг нэвтрүүлэн ашиглаж байна. Байгууллагын нийт ажиллагчдын бүртгэлийг ERP системд бүртгэн хүн бүрт нууц код болон нэвтрэх нэрийг хүлээлгэн өгч, ашиглаж байна.

НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал

Фондын сан хөмрөгийг уншигчдын эрэлт хэрэгцээт ном болон тогтмол хэвлэл, хэвлэмэл бус бүтээгдэхүүнээр бүрдүүлж, нутгийн зохиолчдын уран бүтээл, хүүхдэд зориулсан зохиол, шилдэг ном зэргийг худалдан авч, фондоо баяжуулж ирсэн**.**

Төсвөөр: 11284374 төгрөгний 388 нэр төрлийн 705 ширхэг ном

Хандиваар: 584000 төгрөгийн 8 нэр төрлийн 17 ш ном

нийт 11868374 төгрөгний 396 нэр төрлийн 722 ном худалдан авч, техник ажиллагааг бүрэн хийж, номын мэдээллийг электрон каталогт оруулан, баркоджуулж, уншлага үйлчилгээнд гаргасан.

Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН ТООЛЛОГО:

Номын фондын ээлжит тооллогыг хийж, 9689 нэр төрлийн 21729 номыг тоолж, тооллогоны явцад электрон каталогит алдаатай орсон ном болон ангилал солилтонд нягтлан шалгалт хийж, данс давхардсан номыг цахимаас хасах, баркодыг шинэчилж хэвлэн, тавиурт номыг ББК ангиллаар шинжлэх ухааны салбараар байрлуулж, хаяг ялгагчийг шинээр солих ажлыг давхар хийсэн.

Фондын сан хөмрөг дахь цөөн хувьтай 120 гаруй номыг тооллогоны явцад авч, бүртгэлжүүлж, урагдаж гэмтсэн 60 номонд сэлбэн засалт хийж, засварласан.

Номын санд байгаа тогтмол хэвлэлийн фондыг цэгцэлж, архив дахь 54 нэгж сонинг үдэж цэгцэлсэн.

НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн эсэх

Номын сангийн үйлчилгээг чанартай явуулах зорилгоор үйлчилгээний журмыг захирлын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/06 тоот тушаалын дагуу шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Танхимаар

- Байнгын уншигч-1868
- Ирэгсэд-8840
- Ном олголт- 14109 үйлчилсэн.

НОМЫН ҮЗЭСГЭЛЭН: Номын үзэсгэлэнг шинэ номоор болон тэмдэглэлт өдрүүдэд зориулж тогтмол гарган сурталчилсан.

1. Шинэ номын үзэсгэлэн-722
2. “Танин мэдэхүй” номын үзэсгэлэн-30 ном
3. “Хүүхдийн зохиолчдын бүтээл”-29 ном
4. “Нутгийн зохиолчдын бүтээл”-60 ном
5. “Монголын нууц товчоо”-50 ном
6. “Баатарлаг туульс” – 22
7. Эмэгтэйчүүдийн эрхийн өдөрт – 30
8. Хүүхдийн зохиолч Н. Доржцэрэнгийн уран бүтээл-29
9. Дэлхийн хүүхдийн зохиолч Х. Андерсений амьдрал, уран бүтээл-12
10. Дэлхийн болон монголын хүүхдийн зохиол бүтээлүүд-30
11. “Номын баяр-2022” арга хэмжээний хүрээнд шилдэг ном зохиолууд-50
12. Гэр бүлийн холбогдолтой-20
13. ЭЕШ ном- 24
14. Үнэт ховор -8
15. Монгол бахархалын өдөрт-50 номоор нийт 25 удаа 1166 номоор сурталчилсан.

“Цахим соёл” арга хэмжээний хүрээнд “SB Library“ Цахим сэтгүүл” -г тогтмол эрхлэн гаргаж:

Номын мэдээлийг цахимаар

- Б. Содонгоо “Гашуун кофе” гэр бүлийн хүчирхийллийн сэдэвт зохиол
- Б. Батзаяа “Өрсөлдөх чадвар” хувь хүний хөгжил
- Б. Наминчмиэд “Цагаан бороо”
- Х. Калашников “Догшин жаран”
- “Солонгон загас”
- “Аз жаргалтай хүүхдийн 7 дадал”
-"Бяцхан бамбаруушийн аялал"
- Жамбалдоржийн “Тэмээ тэнгэрийн амьтан” ,“Морин Эрдэнэ”
-“Гадаадад сурах гарц”
-“Эрхэмсэг ганган амьдрахуй”
-“Амьдралд бэлэн үү охин минь”
-“Хааны бичсэн таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг I-III” боть ном
- Үнэт ховор номуудыг АУДИО хэлбэрээр гэх зэргээр нийт 48 удаа сурталчилсан.

Танин мэдэхүйн буланг цахимаар:

- Хавар болохыг цэцэгс яаж мэддэг вэ?, Өвөлжөө амьтад хэрхэн ичдэг вэ ?, Нар, сар, од эрхсийн тухай, Нүүдлийн шувууд буцаж нисэх ёстойгоо яаж мэддэг вэ?, Өндгөн дээрх үсэг, тоо ямар утга илэрхийлдэг вэ?, Хог хаанаас үүсдэг вэ?, Хаврын улирлын тухай, Кассын машин барааны үнийг хэрхэн таньдаг вэ?, Гариг эрхсийн тухай, Нүүдлийн цувууд буцаж нисэх ёстойгоо яаж мэддэг вэ?, Өндгөн дээрх үсэг, тоо ямар утга илэрхийлдэг вэ?, Гэрэл энергийн нэг хэлбэр юм гэх зэрэг сэдвээр бэлтгэн нийт 38 удаа хүргэж сурталчилсан.

Номын сангийн шинэлэг үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр

Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээ, арга барилыг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг өргөжүүлэн хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхтэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар номын сангийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай, хүртээмжтэй явуулахад анхаарч “Судар эгшиглэн”, “Сониуч хүүгийн адал явдал”төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

“СОНИУЧ ХҮҮГИЙН АДАЛ ЯВДАЛ” ТӨСӨЛ

Соёл, урлагийг дэмжих сангаас 2022 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын хүрээнд Хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүмүүжил төлөвшилд нь эерэгээр нөлөөлөх, монголчуудын эрт дээр үеэс үр хүүхэддээ заан сургаж ирсэн ёс заншил, өв соёл, үүх түүхийг таниулах, уран сайхан болон гоо зүйн мэдлэг олгох бүрэн хэмжээний дүрст болон аудио хос хуурцаг бүтээж Монгол улсын зах зээл дээр гаргахад зорилгоор **“Сониуч хүүгийн адал явдал”** цуврал өгүүллэгээр / Дүрст видео ном, Аудио сонсдог ном / дабль CD / хуурцаг / бүтээх төслийг бичиж, уг төсөл шалгарч, 11 дүгээр сарын 21-ний өдөр нээлтээ хийж, төсөлд оролцсон хүүхэд, багачуудад батламж гардуулж, төслийн үйл явц харуулсан бичлэг болон киноны 1-р ангийг цэцэрлэгийн болон ЕБС-ийн 200 гаруй хүүхдэд үзүүлж сонирхуулсан.



ОНЫ ШИЛДЭГ УНШИГЧ ШАЛГАРУУЛАХ “СУДАР ЭГШИГЛЭН-2022” ТӨСӨЛ

Иргэд, хүүхэд залуусын бүх нийтийг номтой нөхөрлүүлэх, номд шимтэхийн ач холбогдол, үнэ цэнэд уриалан дуудах, номоор дамжуулж өөрийн ертөнцөө бүтээхэд нь туслах, дэмжих зорилгоор **Судар эгшиглэн-2022** төслийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

2021 онд уг төслийн санхүүжилтийг Соёлын яам 4.500.000 төгрөг, УИХ-ын гишүүн Н. Ганибал 14.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба 2022 онд аймгийн ИТХ 20 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

Судар эгшиглэн төслийн хугацаанд :

-Номын тэмдэглэлийн уралдаан-д 1785 оролцогчийн 14000 номын тэмдэглэл

- Бүтээлийн уралдаан-д 429 оролцогчийн 1389 бүтээл

- Номын хавчуурганы уралдаан-д 667 оролцогчийн 1167 хавчуурга тус тус ирсэн бгөөд нийт **2881** оролцогчийн **16656** бүтээл ирсэн байна.

Нийт бүтээлүүдээр 11 сарын 28.29-ний өдөр Улаанбаатар хотод хүүхдийн номын ордон дээр гаргаж сурталчиллаа.

НОМЫН ТЭМДЭГЛЭЛИЙН УРАЛДААН:

Номын тэмдэглэлийн уралдаанд 2022 онд номын тэмдэглэлийн уралдаанд нийт 1785 оролцогчийн 14000 тэмдэглэл ирсэн.

НОМЫН ХАВЧУУРГАНЫ УРАЛДААН:

“Судар эгшиглэн” төслийн хүрээнд номын хавчуурга бүтээлийн уралдаан зохион байгуулахад 667 оролцогчийн 3367 бүтээл бүтээлүүд ирснээс:

“Байгууллага, хамт олон” уралдааны ангилалд:

1.Мөнххаан сумын Бумбаалай цэцэрлэгийн хамт олон /30 нэр төрлийн 66 бүтээл /

2. Баяндэлгэр сумын багш нарын хамтарсан бүтээл /Ямааны арьсан бүтээл 30 ширхэг/
3.Баруун-Урт сумын 9-р цэцэрлэгийн хамт олон / 42 нэр төрлийн 166 төрлийн бүтээл/

Насанд хүрэгсдийн ангилалд:

1. Д.Ариунгэрэл Мөнххаан сумын ЕБС-ийн багш /12 төрлийн сүлжмэл/
2. Б.Оюунзул Баруун-Урт сумын 11-р цэцэрлэгийн бүлгийн багш /6 нэр төрлийн 30 бүтээл/
3. П.Эрдэнэчимэг Баруун-Урт сумын 6-р багийн иргэн /өлзий бүтээл 3 ширхэг/
4. Г.Цэзсүрэн /Мөнххаан сумын ахмад багш /оёдол, нэхмэл 12 төрөл/

Хүүхдийн насны ангилалд:

1. 1-р сургууль 3д анги Г.Хүслэн /наамал, эсгий, баримлын шавар/
2. 1-р сургууль 7в ангийн сурагч Б.Маралгуа /сүлжмэл/
3. 1-р сургууль 7в М.Марал /сүлжмэл / нар шалгарсан.

“СУДАР ЭГШИГЛЭН” БҮТЭЭЛИЙН УРАЛДААН:

Хүүхэд залуусын дунд бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, нийгэмд номын ач холбогдлыг ойлгуулж, номтой нөхөрлүүлэх, зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл “Судар эгшиглэн” бүтээлийн уралдааныг бүх насныхны дунд зарлахад 429 оролцогчийн 1389 бүтээл ирсэн.

“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд 11-р сарын 07,08-ны өдрүүдэд "Нобелийн шагналтнууд" хүүхдийн номын сангийн үүсгэн байгуулагч, зөвлөх багш Батцэцэгтэй хамтран “Хүүхэд бүр номтой нөхөрлөөсэй” аяныг зохион байгуулж, үлгэрчилсэн тоглолтыг Баруун-Урт сумын ЕБ-ын 1-4-р сургууль, Халзан, Уулбаян суманд зохион байгуулж 1000 гаруй хүүхэд хамрагдсан.

Уг ирсэн бүтээлүүдээр 11 сарын 21-ний өдөр аймгийн ЗДТГ-т удирдлагуудын шуурхай зөвлөгөөний үеэр үзэсгэлэн гаргаж сурталчилсан.

НОМЫН САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ :

Номын сангийн “LIB4U программ”-д 13 сумдын соёлын төвийн номын сангийн үндсэн сан хөмрөгийг нэгдсэн мэдээллийн баазад нэгтгэх, программ хангамжийн ашиглалтыг сайжруулахад анхаарч ажиллан “Үүлэн технологи”-д суурилсан шинэлэг үйлчилгээг 2019 оноос нэвтрүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Сумдын соёлын төвийн номын сангуудыг номын сангийн нэгдсэн цогц Lib4U программ"-д холбох ажлын хүрээнд мэдээллийн нэгдсэн баазад сумдын соёлын төвийн номын сангуудыг холбон, прораммын сургалтыг “Волвейс ХХК”-тай хамтран тогтмол зохион байгуулж, бүх сумын номын санч нарыг хамруулан, мэдээллийн баазад хэрхэн нэгтгэх талаар болон цахим каталогт ном оруулах ажлын дадлага хийлгэж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласнаар аймгийн хэмжээнд нийт 22428 нэр төрлийн 55630 ном байршсан.

Цахим мэдээллийн нэгдсэн сан-12 сумдын соёлын төвийн номын сан хөмрөгийн мэдээ:

12 сумд мэдээллийн нэгдсэн баазад номоо оруулан ажиллаж байна.

№	Сумдууд	Тоо
1	Асгат	3171
2	Баяндэлгэр	2116
3	Дарьганга	2373
4	Мөнххаан	365
5	Наран	27
6	Онгон	550
7	Сүхбаатар	3148
8	Түвшинширээ	315
9	Түмэнцогт	1
10	Уулбаян	181
11	Халзан	23
12	Эрдэнэцагаан	589
	Нийт **38645 ном**	12858

Электрон каталогит 3300 ш номны хавтасны зураг, тогтмол хэвлэлийн 70 дугаарыг оруулж бүртгэлжүүлсэн

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулан ажиллаж, 15000 гаруй хүн хамрагдсан.

“ЦАГААН САР-БИДНИЙ БАЯР” БАРИМЛЫН ШАВРААР БҮТЭЭЛ ХИЙХ УРАЛДААН:

Сар шинийн баярыг угтаж, хүүхэд багачууд, өсвөр үеийнхнийг монгол ёс заншлаа судлах, өв уламжлалаа хадгалах хамгаалах, дээдлэн хүндлэх, үндэсний соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор цэцэрлэгийн нас, бага ангийн сурагчдын дунд зохион байгуулсан баримлын шаврын уралдаанд нийт 63 бүтээл ирсэнээс:

Сургуулийн бага насны ангилалд:

Тэргүүн байр: Баяндэлгэр сумын ЕБС-ын 5в ангийн сурагч А. Цэндхорол

Дэд байр: ЕБ-ын 3 дугаар сургуулийн 3а ангийн сурагч А. Энхрий

Гутгаар байр: ЕБ-ын 4-р сургуулийн 1а ангийн сурагч Н. Өнө-Энхэрлэн

Тусгай байр: ЕБ-ын 1-р сургуулийн 5а ангийн сурагч Э. Энхжин

Цэцэрлэгийн насны ангилалд:

Тэргүүн байр: Мандарваа цэцэрлэгийн ахлах “Б” бүлэг”

Дэд байр: 11-р цэцэрлэгийн ” Ахлах” бүлэг И. Энхмэнд

Гутгаар байр: 9-р цэцэрлэгийн “Ахлах А”бүлгийн У. Билгүүн нар тус тус шалгарсан.

"ДЭЛХИЙН ЯРУУ НАЙРГИЙН ӨДӨР"-Т “ЯРУУ ҮДЭШ-2022” АРГА ХЭМЖЭЭ:

Дэлхийн яруу найргийн өдрийг Утга зохиолын "Дөрвөн цаг" нэгдэлтэй хамтран **"Уран үгс-Эгшиг дууны "Яруу үдэш"** нэртэйгээр зохион байгуулж, уг арга хэмжээнд аймгийн төв, хөдөөгийн 20 гаруй яруу найрагчид, сум, сургуулийн номын санчид нийт 70 гаруй хүн оролцож, яруу найрагчид шинэ шүлгэн уншлагаараа мялаалга өргөж, "Жаахан шарга" ХЖТ-ын уран бүтээлчид яруу найрагчдын дуугаар ая дууны мэндчилгээ дэвшүүлэв. Уг арга хэмжээн дээр уншигдсан шүлгүүдээр **“Яруу үдэш-2022”** шинэ шүлгэн уншлага нэртэй товхимол хэвлэн гаргаж, яруу найрагчдад хүргэсэн.

“БИДНИЙ ХАЙРТАЙ ҮЛГЭРИЙН БААТАР” ГАР ЗУРГИЙН УРАЛДААН:

Олон улсын “Хүүхдийн номын өдөр”-ийг тохиолдуулан Дэлхийн хүүхдийн их зохиолч Ханс Кристиан Андерсены мэндэлсний 217 жилийн ойд зориулан зохиол бүтээлээс нь сурталчлах, хүүхэд багачуудын зурж, дүрслэх авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор ЕБС-ын 3-7 ангийн сурагчдын дунд “БИДНИЙ ХАЙРТАЙ ҮЛГЭРИЙН БААТАР” гар зургийн уралдааныг явуулахад 28 сурагч бүтээлээ ирүүлж оролцсоноос:

Тэргүүн байрт: Халзан сумын ЕБС-ийн 6а ангийн сурагч М. Цэлмэг

Дэд байрт: Халзан сумын ЕБС-ийн 5а ангийн сурагч Э. Есүй

Гутгаар байрт: Дарьганга сумын ЕБС-ийн 5а ангийн сурагч А. Буянхишиг
Тусгай байрт: Баруун-Урт сумын 4 дүгээр сургуулийн 3а ангийн сурагч Т. Эмүжин нар тус тус шалгарсан.

“ОЛОН УЛСЫН ОХИДЫН ӨДӨР-Т

Дэлхийн охидын өдөр" - т зориулан уншигч охидын дунд залуу зохиолч Ц. Энхсайханы "Дүүлэн нис охин минь" туужаар хүүрнэл ярилцлагыг ЭМГ-ын мэргэжилтэн Ганчимэгтэй хамтран зохион байгуулж, өсвөр насны охидын сэтгэл зүй, охидын эрүүл ахуйн талаар мэдээлэл зөвлөгөөг өгч, нийт 42 охидууд хамрагдсан.

БИД-НОМЫН САНГИЙН НАЙЗУУД” –УРАЛДААН:

Хүүхэд, багачуудыг номтой нөхөрлүүлэх, ном унших сонирхол, идэвхийг илүү өргөн хүрээнд дэмжих, хөгжүүлэх, номтой нөхөрлөгч, номыг дэмжигч анги хамт олныг шалгаруулж урамшуулах зорилгоор 1-5 ангийн сурагчдыг картжуулах аяныг зохион байгуулахад 178 хүүхэд шинээр карт нээлгэж, байнгын уншигч болж, 466 ирэгсдэд үйлчилсэн байна.

ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР-Т Дэлхийн номын өдрийг тохиолдуулан яруу найрагч Ц.Лхамсүрэнтай “**Зохиолч-Уншигчийн уулзалт”-**ыг зохион байгуулж, зохиолч, яруу найрагчид, номын клубын нийт 120 гаруй хүүхэд багачууд оролцсон. Мөн **“Миний унших дуртай шүлэг'”** -ийн цахим шүлгийн уралдаан, **"Ном хож"** тэмцээнийг явуулсан.

“БАЙГАЛЬ-ӨГЛӨӨНИЙ УНШЛАГА”-Дэлхийн номын өдрөөр “Байгаль-Өглөөний уншлага”-ыг ЕБ-ын 4-р сургуулийн “НОМТОЙ НӨХӨРЛӨЕ” клуб, МСҮТ-ийн “ BOOK TIME” клуб, номын сангийн “БИД-УНШИГЧ” клубууд хамтран зохион байгуулсан.

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 тоот зарлигийг үндэслэн жил бүрийн тавдугаар сарын эхний долоо хоногийг “Үндэсний бичиг соёлын өдөр” болгон тэмдэглэсэнтэй холбогдуулан МҮОНРТ-ээс санаачлан өрнүүлж буй “Үндэсний_бичигтэн монголчууд үндэсний хэл бичгээ сурталчлах **ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ - МОНГОЛ СОЁЛЫН ҮНЭТ ӨВ** аянд Монгол Улсын Үндэсний номын сангийн хамт олон челенжид урьсан дагуу уг челенжид нэгдсэн.

“ХҮМҮҮН БИЧИГ - ХҮН БҮРИЙН БИЧИГ” УРАЛДААН

Аймгийн ЗДТГ, БШУГ, НТБТ-тэй хамтарч жил бүр зохион байгуулдаг “Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг” уралдааныг 5 дахь жилдээ зохион байгуулахад 8 байгууллагын 40 гаруй ажилтан, албан хаагчид оролцож:

Тэргүүн байр-ыг Баруун Урт сумын 1-р сургуулийн “Тэнгэрийн зурлага” баг
Дэд байр-ыг Нийгмийн даатгалын хэлтсийн “Шүхэр” баг
Гутгаар байр-ыг УЦУОШГ-ын “Эх хэл ” баг
“Зөв хурдан уншигч” төрөлд Баруун-Урт сумын 11-р цэцэрлэгийн “Уйгаржин” багийн ахлагч бүлгийн багш С.Өнөржаргал
“Сайхан бичигтэн” төрөлд Баруун-Урт сумын 1-р сургуулийн “Тэнгэрийн зурлага” багийн гишүүн хөгжмийн багш Э.Янжиндулам
“Шилдэг контент” төрөлд Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын “Хийморь” баг

“Шилдэг мэндчилгээ” төрөлд Баруун Урт сумын 11-р цэцэрлэгийн “Уйгаржин” баг тус тус шалгарсан.

“Монгол бичгийн” үзэсгэлэн гаргаж сурталчлав.

"МОНГОЛЫН БИЧГИЙН АВАРГА УНШИГЧ" ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН:

Монгол үндэсний бичиг соёл, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, судлах, монгол бичгээ сурч эзэмших, хойч үедээ өвлүүлэх, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх сурталчлах зорилгоор "Монголын бичгийн аварга уншигч" шалгаруулах уралдааныг ЕБС- ийн 6-7, 10-12 анги, Насанд хүрэгсдийн дунд зохион байгуулахад нийт 66 хүн хамрагдаж:

Насанд хүрэгсдийн ангилалд:
- Тэргүүн байр: Б. Ариунзул (Баруун-Урт дахь Төрийн аудитын аудитор)
- Дэд байр: Б. Тэмүүлэн (" Жаахан шарга" ХЖТ - ын хүний нөөцийн мэргэжилтэн)
- Гутгаар байр: Баруун - Урт сумын 9 дүгээр цэцэрлэгийн багш Ц. Ундрах
- Тусгай байр: Баруун- Урт сумын 11 дүгээр цэцэрлэгийн багш С.Өнөржаргал

ЕБС- ийн 10-12 дугаар ангийн ангилалд:
- Тэргүүн байр: Мөнххаан сумын ЕБС- ийн 12а ангийн сурагч Б. Отгонмөнх
- Дэд байр: Баруун- Урт сумын ЕБ- ийн 4 дүгээр сургуулийн 12а ангийн сурагч Э. Цэцэгмаа
- Гутгаар байр: Баруун- Урт сумын 1 дүгээр сургуулийн 10а ангийн сурагч Н. Ану- Үжин

6-7 ангийнхны ангилалд:

Тэргүүн байр: 7б ангийн сурагч Б.Энхзаяа
Дэд байр: 7б ангийн сурагч Г.Болорчимэг
Гутгаар байр: 6б ангийн сурагч Х.Номуунаа нар тус тус шалгарсан.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН БАЯР-2022”

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, **“Алсын хараа”-2025”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх **“Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2022”** арга хэмжээг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор **“ИЛҮҮ ИХ УНШЪЯ”** уриатайгаар улс орон даяар нэгэн зэрэг 2 удаа явагдаж, хаврын нээлтийн үйл ажиллагааг Д. Сүхбаатарын төв талбайд 2022 оны 05 дугаар сарын 20-22-ны өдөр, намрын үйл ажиллагааг Хөлбөмбөгийн талбайд 2022 оны 09 сарын 16-18 өдрүүдэд зохион байгуулж, соёлын олон талт үйл ажиллагааг явуулж, 5000 гаруй хүн хамрагдсан.

Нээлтийн үйл ажиллагааг "Миний дуртай баатрууд" үлгэрийн баатруудын жагсаал, дүрийн үзүүлбэр, ХЖТ-ын уран бүтээлчдийн урлагийн номер, номын ппашмоб, номын үзэсгэлэн / дэлхийн болон монголын, хүүхдийн шилдэг номын үзэсгэлэн, нутгийн зохиолчдын, ховор номын/ бүтээлийн үзэсгэлэн, сум, сургуулийн номын сангийн үйл ажиллагааг сурталчилсан үзэсгэлэн, үндэсний үйлдвэрлэлийн худалдаа, монгол бичгийн уран бичвэр, шагнал гардуулалт, санал асуулга, хүүхдэд зориулсан тоглоомын үйл ажиллагаа, "Сүхбаатар нутгийн түүхэн товчоо" номын нээлт, "Алтан хонх" тэмцээн, Үндэсний тоглоом наадгай, "Номын тухай шилдэг аффоризм" уралдаан, “Дарцагт аялал” зэрэг нийт 30 гаруй хөтөлбөртэйгээр зохион байгуулсан.

Арга хэмжээний хамтран зохион байгуулагчаар аймгийн Соёл, урлагийн газар, Угсаатны зүй музей, "Жаахан шарга" ХЖТ-тай хамтран ажиллаж, Соёлын яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Баяраа, МУҮНС-ын арга зүйч В.Түвшинтогтох, Монголын Хүүхдийн номын ордны захирал асан Оюунбилэг, МУБИС-ийн номын сангийн захирал Ж.Баатарсүрэн, зохиолч, яруу найрагчид, ахмад номын санчид болон сум, сургуулийн номын санчид, ном хэвлэл болон үндэсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, ном сонирхогч, борлуулагч, номын клуын сурагчид, “Нарны хүүхдүүд” дуу бүжгийн клубын хүүхдүүд, уншигчид, цэцэрлэгийн хүүхэд, багачууд оролцсон.

Номын баярын нээлтийн үйл ажиллагаа:

“Номын баяр-2022” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан ажлууд:

ШИЛДЭГ ДҮРИЙН УРАЛДААН: Хүүхэд багачуудын ном унших, номонд дурлах сэдлийг төрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх илэрхийлэх авьяасыг хөхиүлэн дэмжиж урамшуулах зорилгоор цэцэрлэгийн насныхны дунд зохион байгуулахад
нийт 120 хүүхэд оролцсоноос:

Тэргүүн байр: байр Баруун-Урт сумын 9-р цэцэрлэг

Дэд байр: Баруун-Урт сумын 2-р цэцэрлэг

Гутгаар байр: Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг

Шилдэг эмэгтэй дүр: Баруун-Урт сумын 3-р цэцэрлэгийн бага бүлгийн суралцагч н.Дүүрэнсарнай /Фиона гүнжийн дүр/

Шилдэг эрэгтэй дүр: Баруун-Урт сумын 4- цэцэрлэгийн бага бүлгийн суралцагч Б.Ивээл /Тансан ламын дүр/ нар тус тус шалгарсан.

ШИНЭ БОЛОН СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН, НУТГИЙН ЗОХИОЛЧИЙН, ХОВОР НОМЫН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА:

Шинэ номын болон шилдэг ном зохиол, нутгийн зохиолчдын, ховор номын үзэсгэлэн мөн төрөл бүрийн материалаар бүтээсэн ном, баринтаг, номын хавчуурга, номын тэмдэглэлийн, тэргүүний уншигч хүүхдүүдийн бүтээлээр үзэсгэлэн зохион байгуулав.

"УНШААД УРАГШЛАХУЙ" АЯН: Хүүхэд залуучуудад ном уншлагыг суртачлах, сэдэлжүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор дэлхийн болон монголын шилдэг зохиол бүтээлүүдийг сурталчлан таниулах зорилгоор ЕБС-ийн 1-4 сургууль, МСҮТ-ийн номын клубын дунд "**Уншаад урагшлахуй"** аяныг зохион байгуулав.

ӨРТӨӨЧИЛСӨН АЯЛАЛ: Монголын соёлын биет болон биет бус өвийг түгээн таниулах, номын ертөнцөөр аялуулах зорилгоор **"Өртөөчилсөн аялал"-** ыг 5 хэсэгтэйгээр зохион байгуулж, Дэлхийд гайхагдсан монгол дархчуулын ховор үзмэрүүд, Монголын үнэт, дахин давтагдашгүй соёлын биет болон биет бус өвийн гайхамшгийн талаар сурталчилж, угсаатны зүйн музейн түүхэн замналыг танилцуулж, ХЖТ-ын уран бүтээлийн тоглолтын бэлтгэлтэй танилцаж, бяцхан тоглолтыг үзүүлж, номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, ном уншихын ач холбогдлын талаар харилцан ярилцлаа. Мөн уг арга хэмжээний үеэр таниулсан танин мэдэхүйн мэдлэгийг нь бататгаж “АХА” тэмцээнийг зохион явуулахад

Тэргүүн байр: ЕБ-ын 2-р сургуулийн сурагч Д. Чинхүслэн

Дэд байр: ЕБ-ын 2-р сургуулийн сурагч Х.Мөнхцацрал

Гутгаар байр: ЕБ-ын 3-р сургуулийн сурагч Б.Сансар нар тус тус эзэлж, тэмцээнийг ННС, УЗМ, ХЖТ ивээн тэтгэсэн.

ШИЛДЭГ НОМ, ЗОХИОЛЧ ШАЛГАРУУЛАЛТ: Сүхбаатар нутгийн яруу найрагч, зохиолчдын 2019-2022 онд хэвлэгдэн гарсан номоор “**ШИЛДЭГ ШИНЭ НОМ, ЗОХИОЛЧ, ЯРУУ НАЙРАГЧ"** шалгаруулах цахим уралдааны зохион байгуулахад Баяндэлгэр сумын харьяат У. Буд **"Шилдэг зохиолч, яруу найрагч”-** аар, “**Шилдэг ном”-**оор Г Баатарнумын **" Богц дүүрэн инээд"** ном шалгарсан.

НОМЫН ПЛАШМОБ:

Номын сангийн тухай хууль болон ном зүйн лавлагаа, мэдээлэл:

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ, СУРАГЧ, ГЭР БҮЛ, БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ, СУРТАЛЧЛАХ, АЛДАРШУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ:

Тэргүүний уншигч сурагч, гэр бүл, байгууллагыг шалгаруулахад: **“Тэргүүний уншигч сурагч”**-аар

1-7 ангийн ангилалд: ЕБС-ийн 7 ангийн сурагч Ш. Эрхэмбилэг

8-12 ангийн ангилалд: ЕБС-ийн 3 дугаар сургуулийн ангийн сурагч 9б М. Баярмаа

Насанд хүрэгсдийн ангилалд Б. Уранцэцэг / хувираа хөдөлмөр эрхлэгч /

“Тэргүүний уншигч гэр бүл”-ээр М. Өлзиймөнхийн гэр бүл

“Тэргүүний уншигч байгууллага”-аар Мөнххаан сумын “Бумбаалай“ цэцэрлэг тус тус шалгарсан.

“НОМЫН ТУХАЙ” ПОДКАСТ:

Номын тухай подкастыг номын сангийн эрхлэгч асан Ж. Ариунжаргалтай хийв.





"ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЭ" АЯН:

Сургуулийн өмнөх боловсролын 1-11 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд монгол ардын үлгэрээр чанга уншлага хийж, 512 хүүхэд хамрагдав.

ХҮҮХДИЙН ТАЛБАЙН ТОГЛООМ, ҮНДЭСНИЙ УЛАМЖЛАЛТ ТОГЛООМ АЖИЛЛУУЛАВ.

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮҮХЭН ТОВЧОО”

НОМЫН НЭЭЛТ:

ШИЛДЭГ АФОРИЗМ:

Шилдэг афоризм уралдаанд нийт 70 гаруй хүн оролцож, 168 эрдэмтэн, зохиолчдын, номын тухай эшлэл үг ирснээс:

Баруун-Урт сумын 8-р цэцэрлэгийн арга зүйч М.Баярцэцэг

Баруун-Урт сумын 11-р цэцэрлэгийн багш Б.Оюунзул

Уулбаян сумын Соёлын төвийн номын санч П.Ганцэцэг нар шалгарлаа.

“НОМЫН САЙН НӨХӨР” УРАЛДААН:

Хүүхэд, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, нийтийн уншлагыг дэмжих, ном сурталчлах, номын орчин болон ном хэвлэлийн салбарыг өргөн хүрээнд хөхиүлэн дэмжихэд энэхүү журмын зорилго орших зорилгоор “Номын сайн нөхөр” болзолт уралдааныг зохион байгуулсан.

-“Шилдэг уншигч-анги, хамт олон”-оор Уулбаян сумын ЕБС-ийн 2б анги

- Шилдэг уншигч-сурагч”-аар /6-9 ангийн ангилалд: Э. Даваасугар /ЕБ-ын 1-р сургууль. 9а/

-“**Шилдэг уншигч-сурагч”-/**10-12 ангийн ангилалд: Б. Мөнхгэрэл /Мөнххаан. 12б/

-“Шилдэг уншигч-насанд хүрэгч” -ээр Л. Мөнхтуяа / Уулбаян сумын ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш/ нар тус тус шалгарсан.

"АЛТАН ХОНХ" ТЭМЦЭЭН:

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022" арга хэмжээний хүрээнд аймгийн Нийтийн номын сангаас ЕБС- ийн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн "Алтан хонх" тэмцээнийг зохион байгуулж, нийт 20 гаруй хүүхэд хамрагдлаа. Тэргүүн, дэд, гутгаар байруудад ЕБ- ын 3 дугаар сургуулийн 11б ангийн сурагч У. Пүрэв бат, Б.Азжаргал, М. Энхбаясгалан нар шалгарлаа.

“УНШААД УРАГШЛАХУЙ” АЯН:

Уншлагын хүрээг өргөн болгож, хүүхэд нэг бүрийг хамруулах зорилгоор “Дарцагт-уншлага“ аяныг ЕБС-иудын дунд зохион байгуулж, “Номын ач холбогдол” ийг таниулсан яриа таниулга хийх урилгыг гардуулан өртөөлчилсөн аялал хийж, нийт тус арга хэмжээнд 112 сурагчид хамрагдсан.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар хийсэн ном, баринтаг, хавчуурга болон бусад зүйлсийн үзэсгэлэн: лавлагаа, ном зүй, үзүүлэн таниулах, мэдээлэл сурталчилгааны ажил:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг:

Шинэ ирсэн ном-2022- 40, Ховор ном-12, Монгол бичгийн-20, Хүүхдийн номоор үзэсгэлэн-36 нийт 108 номоор үзэсгэлэн гаргаж сурталчилсан.

“Саран хөхөөний намтар”,”Монгол утгын зүйл хуваасан толь бичиг”, “Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл”, Инжинашийн “Улаанаа уйлах танхим”, “Төвд монгол шидэт хүүрийн үлгэр”, “Заяын Гэсэрийн тууж”, Дагий жанчүв”, Довог Сэндом-4 гэх зэрэг ховор номоор гаргаж сурталчилсан.

“Судар эгшиглэн” төслийн оролцогчдын номын тэмдэглэлийн үзэсгэлэн, “Номын хавчуурга” уралдаанд ирүүлсэн бүтээл, Тэргүүний уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэлээр үзэсгэлэн гаргаж сурталчилсан.

"НАЙРСАГ БАРУУН УРТ-ТЕАТР" өдөрлөгт аймгийн Нийтийн номын сангаас шинэ болон хүүхдийн номын үзэсгэлэн, байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан брошур тараах, номын худалдаа гарган сурталчилж, уншигчдад шинээр карт нээн,

номын татгалзлын болон сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллалаа. Мөн Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран монгол бичгийн номын болон уран бичвэрийн үзэсгэлэн гарган сурталчилж, ЕБС-ийн багш нар уран бичвэрээр бичиж үйлчлэв.

"НАЙРГИЙН ОРНЫ НАЙРАГЧ ХҮҮХДҮҮД" УРАН УНШЛАГЫН НААДАМ:

Сүхбаатарын аймгийн "Сүхбаатарын өнгө" сонины 5 жилийн ойг тохиолдуулан "Найргийн орны найрагч хүүхдүүд" уран уншлагын наадмын 2-р шатны уралдааныг "Сүхбаатарын өнгө" сонин, Аймгийн Нийтийн номын сан хамтран 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион явуулахад 180 хүүхэд, багачууд оролцож, авъяас чадвараа сорьж уралдсан.

Цэцэрлэгийн насанд:

Тэргүүн байр: Т. Аялгуу-3-р цэцэрлэг. Дунд бүлэг
Дэд байр: Б. Батзолбоо-Сүхбаатар сум. Бэлтгэл бүлэг
Гутгаар байр: А. Номин. 9-р цэцэрлэг. Бэлтгэл бүлэг
Шүүгчийн нэрэмжит шагнал: Б. Ананд. 10-р цэцэрлэг. Бэлтгэл бүлэг.
Номын сангийн нэрэмжит шагналаар: Б. Насанжаргал: 2-р цэцэрлэг. Ахлах бүлэг.

ЕБС-ийн 1-5 дугаар ангийн ангилалд:

Тэргүүн байр: А. Мөнх-Алтан. ЕБ-ын 1 дүгээр сургууль. 5а анги
Дэд байр: М. Бат-Оргил. Эрдэнэцагаан сумын ЕБС. 1б анги
Гутгаар байр: Х. Хүчиттөгөлдөр. ЕБ-ын 2 дугаар сургууль. 5г анги
Шүүгчийн нэрэмжит шагналаар: Д. Нандин-Эрдэнэ. Мөнххаан. 5б анги.
Номын сангийн нэрэмжит шагналаар: Э. Индра. ЕБ-ын 2 дугаар сургууль. 1б анги

ЕБС-ийн 6-9 дугаар ангийн ангилалд:

Тэргүүн байр: С. Баяржавхлан. Асгат сумын ЕБС. 9а анги
Дэд байр: Б. Сарангоо. Асгат сумын ЕБС. 8а анги
Гутгаар байр: М. Үүрийнцолмон. Халзан сумын ЕБС-ийн 8а анги

Шүүгчийн нэрэмжит шагналаар: Э. Батдулам. Баруун-Урт сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн 8б анги

Номын сангийн нэрэмжит шагналаар: У. Жаргалан. Баруун-Урт сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 9в анги

ЕБС-ийн 10-12 дугаар ангийн ангилалд:

Тэргүүн байр: Д. Нарансолонго. Мөнххаан сумын ЕБС-ийн 10а анги

Дэд байр: Э. Ганганжинжиймаа. Түмэнцогт сумын ЕБС-ийн 10-р анги

Гутгаар байр: Б. Гэрэлтуяа. Түмэнцогт сумын ЕБС-ийн 11-р анги нар тус тус шалгарсан.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР: Соёлын яамнаас 11 сарыг “Соёлын бүтээлч сар” болгосонтой холбогдуулан

1 дэхь 7 хоног: Үндэсний нэгдмэл үнэт зүйл сэдвийн дор Монголын нууц товчоо номын үзэсгэлэн, МНТ-гоо уншъя, судалъя” хэлэлцүүлгийг чөлөөт уран бүтээлч А. Гантулгыг урьж оролцуулан зохион байгуулсан.

2 дахь 7 хоног: Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд Монгол бичгийн үүсэл гарал түүх, монгол бичгээр хэрэглээний программ дээр шивж сурах, монгол бичгээр бичих заавар, угийн бичиг хөтлөх аргачлал зэрэг олон талт мэдээллийг байгууллагын цахим хуудсаар тогтмол сурталчилж, монгол бичгээр бичвэр бичиж тогтмол оруулж сурталчилсан.

“Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангийн 70 жилийн ойд зориулсан “Номын өргөөний түүхэн шастир” ном, “Сүхбаатар аймгийн бичгийн мэргэдийн намтар ном зүй” номыг цахим хэлбэрт оруулан цахим санд байршууллаа.

3 дахь 7 хоног: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсын монгол бичгийн албан бланктай болж, хос бичгээр хөтлөх ажлыг турших зорилгоор аймгийн архивын тасагт 2022 оны 11 дүгээр сарын өдөр хүсэлтээ өгсөн.

“Судар эгшиглэн” бүтээлийн уралдааныг бүх насныхны дунд зарлахад 429 оролцогчийн 1389 бүтээл ирсэн бөгөөд ирсэн уг бүтээлүүдээр 11 сарын 21-ний өдөр аймгийн ЗДТГ-т удирдлагуудын шуурхай зөвлөгөөн дээр болон 11 сарын 28.29-ний өдөр Улаанбаатар хотод Хүүхдийн номын ордон дээр гаргаж сурталчилсан.

Соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Соёл, урлагийг дэмжих сангаас 2022 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын хүрээнд Хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүмүүжил төлөвшилд нь эерэгээр нөлөөлөх, монголчуудын эрт дээр үеэс үр хүүхэддээ зааж сургаж ирсэн ёс заншил, өв соёл, үүх түүхийг таниулах, уран сайхан болон гоо зүйн мэдлэг олгох бүрэн хэмжээний дүрст болон аудио хос хуурцаг бүтээж Монгол улсын зах зээл дээр гаргах /гавъяат багш Ш. Чулуунбор/ “Сониуч хүүгийн адал явдал” цуврал өгүүллэгээр / Дүрст

видео ном, Аудио сонсдог ном / дабль CD, хуурцаг / бүтээх төслийг бичиж, уг төсөл шалгарч, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр нээлтээ хийлээ.

Соёл, урлагийн салбарын ахмад ажилтнуудын анхдугаар зөвлөгөөнд номын санд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 3 ахмадыг хамруулсан.

4 дэх 7 хоног: Соёлын аялал жуулчлалын хүрээнд “Нобелийн шагналтнууд” хүүхдийн номын сангийн үүсгэн байгуулагч, зөвлөх багш Батцэцэгтэй хамтран “Хүүхэд бүр Номтой нөхөрлөөсэй” аян Баруун-Урт сумын ЕБ-ын 1-4-р сургууль, Халзан, Уулбаян суманд 11-р сарын 07,08-ны өдрүүдэд зохион байгуулж, 1000 гаруй хүүхэд хамрагдсан.

Монгол бахархлын өдөрт Угсаатны зүйн музейтэй хамтарч монгол бичгийн бичвэрийн болон номын үзэсгэлэнг зохин байгуулж, 120 гаруй хүүхэд хамрагдсан.

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО НОМОО УНШЪЯ, СУДАЛЪЯ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монголын нууц товчоог унших сарын аяныг Баруун-Урт сумын ЕБ-ын 1-4 сургууль, "Монголын нууц товчоо номоо уншъя, судалъя” хэлэлцүүлгийг ахмад багш Мандахтуяа, чөлөөт уран бүтээлч А. Гантулгатай хийж, Монголын нууц товчооны номын үзэсгэлэн гаргаж, бүтээл, жижиг ном хийх уралдаан, АХА тэмцээн, айл өрхийн судалгаа зэргийг гаргаж ажилласан.

Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал
"УРАН ҮГС ЭГШИГ ДУУНЫ ЯРУУ ҮДЭШ-2022" АРГА ХЭМЖЭЭ:

Аймгийн Нийтийн номын сангаас Нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг сурталчлах "УРАН ҮГС ЭГШИГ ДУУНЫ ЯРУУ ҮДЭШ" яруу найргийн арга хэмжээг 12 суманд амжилттай зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн зохиолч, яруу найрагчдыг сурталчилж, шүлэг, яруу найргаас нь уншиж сонирхуулан, тэдний зохиосон уран бүтээлийг нутгийн ард иргэдэд хүргэж таниулж, цэнгүүнийг сум бүрт зохион байгуулан, уг арга хэмжээний үеэр шилдэг ном зохиол болон нутгийн зохиолчдын номоор зөөврийн номын сангийн үйлчилгээ, хүүхдийн номын худалдааг хүргэж, номын санд мэргэжил арга зүйн зөвлөгөөг ахмад номын санч нартай хамтран өгч, Тэргүүний уншигч хүүхэд багачуудыг Д.Нацагдорж тэмдгээр шагнаж урамшуулан, номын азтан тодруулах арга хэмжээг давхар зохион байгуулсан.

Яруу найргийн дуун цэнгүүнийг төлбөртэй зохион байгуулж, цэнгүүнээс орсон орлогыг Сүхбаатар аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойд хандивлах зорилгоор явуулсан бөгөөд өнөөдөр аймгийн Засаг дарга М. Идэрбатад 2.000.000 төгрөгийг гардуулан өглөө. Уг арга хэмжээг сумдын Засаг дарга нар болоод сум, сургуулийн номын санч нарын бүрэн туслалцаа орсон бөгөөд орлогоороо зардлаа санхүүжүүлэн, энэхүү түүхт ойн хандивт нэгдэн хөрөнгө босгосон.

ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: Зөөврийн номын үйлчилгээг **3781** номоор **7036** хүнд хүргэсэн байна.

№	Зөөврийн номын үйлчилгээ үзүүлсэн газар	Номын тоо	Хамрагдсан хүний тоо	Тайлбар
Гэрээр ном олгох танхим				
1.	Онгон сумын ахмад хороо	150	45	“Судар эгшиглэн” төслийн шилдэг оролцогч.
2.	Түвшинширээ сумын ЕБС	250	82	
3.	Түмэнцогт сумын соёлын төв	150	57	
4.	Баруун-Урт сумын 3-р сургууль	185	55	
5.	Уулбаян сумын соёлын төв	600	120	
6.	Халзан сумын соёлын төв	400	60	
7.	Бумбаалай хүүхдийн цэцэрлэг	200	52	32 ажилтан багш нар уншигчийн карт нээлгэсэн. “Судар эгшиглэн” төсөлд 100 хувь хамрагдсан.
8.	Баруун-Урт 9-р цэцэрлэг	56	30	“Судар эгшиглэн” төсөлд оролцогч
9.	Баруун-Урт 2-р цэцэрлэг	45	25	
10.	Баруун-Урт 11-р цэцэрлэг	45	25	“Судар эгшиглэн” төсөлд 100 хувь хамрагдсан

11.	Барилгын цэргийн 338-р цэргийн анги	200	55	
12.	Баруун-Урт сумын Мандарваа цэцэрлэг	28	75	28 багш ажилчид уншигчийн карт нээлгэж, Судар эгшиглэн төсөлд 100 хувь хамрагдсан.
		2139	**681**	
	Фондноос			
13.	12 сумдад	360	1200	Уран үгс эгшиг дууны үдэш-2022” арга хэмжээнд
	Номын баяр-2022	30	500	
		390	**1700**	
Хүүхдийн танхимаас				
14.	ЕБ-ын 1-4 сургууль	55	1300	
	1-11 цэцэрлэг	260	720	
	12 сумдад	300	1200	
		615	**3835**	
Нийтийн уншлагын танхимаас				
	4-р сургууль	18	24	
	Асгат сумын ЕБС	18	22	
	10-р цэцэрлэг	28	32	
	6-р цэцэрлэг	32	36	
	Мөнххаан сумын ЕБС	17	45	
	Мандарваа цэцэрлэг	20	18	
	Мандарваа	18	36	Судар эгшиглэнгийн захиалгат ном
	Уулбаян сумын соёлын төвийн номын сан	25	50	
	6 - р Цэцэрлэг	35	18	Судар эгшиглэнгийн захиалгат
	Соёл урлагийн газар	21	12	Мэргэжлийн болон судалгааны
	Байгаль орчны газар	20	18	
	Түр хамгаалах байр	36	11	Гэр бүл, уран – зохиолын
	Угсаатны зүйн музей	20	20	Мэргэжлийн болон судалгааны номууд
	ГБХЗХГ	25	14	
	10-р цэцэрлэг	20	38	СӨБ-ийн мэргэжлийн болон тогооч нарын гарын гарын авлагууд
	МСҮТ	42	51	
	БӨНДБ	46	52	ЭЕШ өгөх сурагчдад зориулсан
	БӨНДБ	28	62	
	Номын баяр	40	500	
	Найрсаг Баруун - Урт	36	80	Монгол бичгийн номуудаар
	4-р цэцэрлэг	32	42	Ардын аман зохиолоор
	МСҮТ	60	40	Судар эгшиглэнгийн захиалгат ном
		637	**820**	
	Нийт	**3781**	**7036**	

ХҮҮХДЭД НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ:

Хүүхдэд зориулсан зохиол бүтээлийг уншигч, хүүхэд, эцэг эхчүүдэд хүргэх зорилгоор “Хүүхдийн танхим-“ цахим хуудас ажиллуулж, хүүхдэд зориулсан зохиол бүтээл, мэдээ мэдээллийг өдөр бүр тогтмол оруулж сурталчлан 250 хүн хандалт өгсөн.

Хүүхдийн амралтанд зориулсан “Бүтээлч уншлага” аян зохион байгуулж,14 хүүхэд 100 гаруй ном уншин тэмдэглэл хөтөлсөн.

Хүүхэд хөгжүүлэх чиглэлээр ХЖТ-ын багштай хамтран дугуйлан хичээллүүлж, хүүхдийн танхимд мини театр ажиллуулах тайз хийн, Болортуяа багш 4-6 ангийн 8 сурагчийн хамт Жамьянсүрэнгийн зохиол "Тэрх нуурын дэгдээхэй " жүжигчилсэн тоглолт хийсэн.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ

Нийгмийн зорилтот бүлгүүдэд хүрч үйлчлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн **"Бид чадна-4"** хөтөлбөрт сургалт, "Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах нь-4" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Канад сангаас санхүүжүүлсэн "Харааны бэрхшээлтэй иргэдийг харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах" төсөл хэрэгжсэнтэй холбогдуулан, бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх бүхий иж бүрэн компьютер техник хэрэгсэл, ширээ сандал, скайнер, аудио болон сонсдог төхөөрөмж ба дэйзи тоглуулагч бусад техник хэрэгсэл, сонсдог болон брайл номоор үйлчилдэг. Энэхүү төслийн хүрээнд Хараагүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 200 гаруй харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан.

Номын санч В.Энхтуяа Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк, Японы буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн Дэлхийн зөн олон улсын байгууллагаас зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Сургагч багш”-аар эхний шатанд эсээ бичлэг, 2 дахь шат нь ярилцлагаар 30 гаруй хүнээс сонгогдон сайн дурын “Сургагч багш”-. ийн 70 цагийн сургалтанд хамрагдаж, сургагч багшийн үнэмлэх, сертификаттай болсон.

Хөгжлийн бэрхшээл ба нийгмийн загвар, Хүний эрх ба ялгаварлан гадуурхалт, Ялгаварлан гадуурхалтыг туулах арга зам, Хөгжлийн бэрхшээлтэй хүнйи эрхийн тухай хууль, Гэр бүлийн харилцаа хандлага сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт тус тус хамрагдсан.

НОМЫН САН БОЛОН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ

Санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж, нээлттэй хаалганы үеэр номын сангийн үйл ажиллагааны талаар 10 асуулга бүхий судалгааг уншигчдаас авахад ихэнх нь шинэ номын хүрэлцээ муу, номын сан өвөлдөө маш хүйтэн, дуу чимээ ихтэй байдаг, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ширээ сандлын хүрэлцээ муу зэрэг саналууд олноор ирсэн байна.

ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар

Байгууллагын үйл ажиллагааг нийтэд сурталчлах, ил тод нээлттэй, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор байгууллагын үйл ажиллагааг Сүхбаатар аймгийн Номын сан www.facebook.com/, МУСГЗ, Г. Мэнд-Ооёогийн нэрэмжит Сүхбаатар аймгийн нийтийн номын сан фэйж хуудаст байршуулан тогтмол сурталчлан хүргэж, 6500 гаруй пост оруулж нийтдээ 17560 хүн хандалт өгчээ.

- Соёлын тухай хууль, Номын сангийн хууль тогтоомж, Номын сангийн үйлчилгээний тухай, Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ, Нутгийн яруу найрагчдын цуврал, Үнэт ховор номын сурталчилгаа, Шинэ номын мэдээлэл, Танин мэдэхүйн цувралуудаар уншигчдад зориулан лавлагааны 20 гаруй хуудастай аудио мэдээлэл нийтдээ 200 гаруй хуудастай цахим мэдээллийн эх бэлтгэн орон нутгийн иргэдэд сурталчлан түгээсэн бөгөөд нийтдээ 4300 гаруй хандалт авчээ.

Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл-номзүйн үйлчилгээгээр хангасан байдал:

Уншигч хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан гэр бүлийн уншлагын өдрийг дэмжих, хүүхдүүдтэйгээ чөлөөт цагаа зөв өнгөрөөх, гэр бүлийн үүрэг, гэр бүлийн харилцааг номоор дамжуулан олон нийтэд сурталчлах, түгээх, ном соёлын хүрээг өргөжүүлэх, гэр бүл дэх цахим орчны хэрэглээг багасгах зорилгоор сар бүрийн 15-ны өдрийг **“Гэр бүлийн уншлагын өдөр”** болгон зарлаж, оролцох уншигчдад урилга өгөн оролцуулж,

1. Сүхбаатар Анхтуяа / Баруун-Урт сумын 2-р цэцэрлэгийн бүлгийн багш/
2. Н. Олзвой /Мөнххаан сумын ЕБС-ийн англи хэлний багш/
3. Мөнхбаяр Алтантуяа /Мөнххаан сумын ЕБС-ийн номын санч/
4. Ө. Байгальсайхан /Баруун-Урт сумын ЕБ-ийн 4-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш/
5. Б. Баярсайхан /Баяндэлгэр сумын ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш нар тус тус оролцсон.

Баруун-Урт сумын 1-11 цэцэрлэг, ЕБС-иуд, дотуур байранд чанга уншлага, номын мэдээлэл хийж, номын сантай танилцах аялалыг зохион байгуулж, хүүхдүүдэд зориулсан номоор үзэсгэлэн гаргаж ажилласан.

НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орон нутаг судлах цогц төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар хийсэн ажил:

Сүхбаатар аймгийн соёл, урлагийн өдрүүдийн хүрээнд "Соёл урлаг-80" онол практикийн хурал 2022 оны 06 сарын 10- ны өдөр Д.Нацагдоржийн нэрэмжит УБ хотын Нийтийн Төв номын санд боллоо. Онол практикийн хуралд Хэл бичгийн ухааны доктор Х. Хүрэлбаатар " Зөөлөн ай- н таван аксиом, Хэл бичгийн ухааны доктор А. Мөнх-Оргил " Дарьгангын сургуулийнхны эх орны сэтгэлгээний хэлбэр, Магистр Д. Амараа " Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын " Зүүн нүхт- ээс шинээр илрүүлсэн хүн чулууд, СУИС- ийн Соёлын сургуулийн тэнхимийн эрхлэгч, доктор Б. Мөнхбадрал "Монголын Үндэсний нүүдлийн соёлыгбүтээлч аялал жуулчлалаар хөгжүүлэх нь, Г. Маралмаа СУИС Монголын драмын урлагийн салбар дахь талант менежментийн өнөөгийн төлөв байдал, ШУХ, ХЗХ, сурвалж бичиг, төвд судлалын салбарын эрхлэгч Д. Наранцэцэг "Наран мандах нутагт мэндэлсэн бичгийн их хүмүүн, Ардын жүжигчин, Хэл шинжлэлийн ухааны доктор Ш. Чимэдцээ "Дарьганга дууны ая аялгууны онцлог", Бүх нийтийн соёлын боловсрол орон нутагт сэдвээр Соёлын яамны Соёлын боловсролын зохицуулах газрын шинжээч, доктор Ш. Оюундэлгэрэх нар тус тус илтгэл тавьсан. Уг онол практикийн хурлын сэдвүүдээр эмхэтгэл хэвлэн гаргасан.

ОРОН НУТГИЙН КАРТЫН САН, НОМЗҮЙН БҮРТГЭЛ ЭРХЛЭН ГАРГАСАН ЭСЭХ

Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж, **“Сүхбаатар нутгийн бичгийн мэргэдийн орон нутгийн намтар ном зүй”-г** эмхэтгэн гаргаж, 500 ш хэвлүүлэв. Тус номонд нийтдээ нутгийн 280 гаруй яруу найрагч, эрдэмтэн, зохиолч нарын намтар, бүтээлийн жагсаалт орсон бөгөөд Монгол Улсын Үндэсний номын сангийн Арга зүйч В. Түвшинтогтох, редактораар Хэл бичгийн ухааны доктор Б. Магсаржав, сэтгүүлч Г.Сүхээ,



Б. Энхтуяа нар хянан тохиолдуулж, УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь 10 сая төгрөгөөр ивээн тэтгэж, номын нээлтийг зохион байгуулсан.

Орон нутаг судлалын сан хөмрөгийг бүрдүүлж, хөгжүүлэх талаар хийсэн ажлын талаар

Орон нутгийн тогтмол хэвлэл Сүхбаатарын өнгө сонин болон сэтгүүлийн мэдээллиийг “Zotero” программд оруулах ажлын хүрээнд улсын тогтмол хэвлэлийн мэдээллийн нэгдсэн сан болон уг программд аймгийн Сүхбаатарын өнгө” сонины 44 дугаарын бүх мэдээллийг нэмж оруулсан.

НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын санд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, технологийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн ажлуудын талаар:

Номын санд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж хэрэглээний программ хангамжийг хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж, суурин компьютер-14, зөөврийн компьютер -3 ажиллаж байгаа бөгөөд 5 компьютерт засвар үйлчилгээ хийж, хэрэглээний програмуудыг бүрэн суулган ажилласан.

Байгууллагын дотоод сүлжээ болон хяналт хамгаалалтын системийн хэвийн ажиллагааг ханган, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах эх бэлтгэл, видео бичлэг, контент, урилга, аппиш зэргийг 300 гаруй удаа бэлтгэн ажиллалаа.

АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын санчдад арга зүйн зөвлөгөөг амаар болон биечлэн хүргэсэн байдал

Номын санчдын дотоод групп хуудсаар /*Сүхбаатар аймгийн сум, сургуулийн номын санчид*/ номын сангийн талаарх хууль тогтоомж, эрх зүйн баримт, бусад холбогдох мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны талаарх хөтөлбөр, төлөвлөгөө, албан бичгийг хүргэн, цаг үеийн байдалтай уялдуулан цахим хурлыг тогтмол хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Баруун-Урт сумын ЕБ-ын 1.2.4-р сургууль, МСҮТ-ийн номын сан, бүх сумдын номын сангийн үйл ажиллагаатай ахмад номын санч нартай хамтран газар дээр нь очиж танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Номын санд томилолтоор явж туршлага судалсан, арга зүйн туслалцаа үзүүлсэн болон дүн шинжилгээ хийсэн байдал

Дундговь, Өмнөговь аймгийн номын сангийн үйл ажиллагаатай очиж танилцан, харилцан туршлага солилцон, сургалт, ажил хэргийн уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааг сайжруулах санамж бичиг байгуулав.

МУИС-ийн 80 жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн номын сангаас зохион байгуулсан "НОМЫН САНЧ МЭРГЭЖИЛ: ӨНӨӨДӨР, МАРГААШ" семинар, хэлэлцүүлэгт захирал Х. Мөнгөн-Өлзий оролцож, **"Хөдөө орон нутгийн номын санч нарт мэргэжлийн хувьд тулгарч буй бэрхшээл"** сэдвээр илтгэл тавьж оролцсон.

Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байдал:

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, хийж хэрэгжүүлж буй ажлын талаар болон Дэлхийн номын өдөр, Яруу найргийн баяр, Үндэсний бичиг үсгийн баяр, Аймаг байгуулагдсаны 80 жил угтсан ажил, Номын баяр-2022, “Уран үгс эгшиг дууны яруу

үдэш” арга хэмжээ, “Судар эгшиглэн” төсөл, “Анимэшн” төсөл зэргийг “BBS телевиз”, “Сүхбаатарын өнгө” сонингоор тогтмол сурталчилсан.

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Төсвийн зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах хүрээнд төсвийн тухай шинэ хуулийг мөрдөж ажиллан, байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтод тулгуурлан төсвийг дунд хугацаагаар төлөвлөн, төсөв болон тодотгосон төсвийн сар, улирлын хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явуулсны үр дүнд 202666700 төгрөгний санхүүжилттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

МУСГЗ, Чингис хаан одонт зохиолч, яруу найрагч Г. Мэнд-Ооёогийн нэрэмжит Сүхбаатар Аймгийн Нийтийн номын сан сайт, пэйж хуудас, "Судар-Эгшиглэн" пэйж хуудас, Сүхбаатар аймаг Номын сан гэсэн пэйсбүүк зэрэг олон нийтэд мэдээлэл дамжуулах нийгмийн сүлжээний хаягуудаараа дамжуулан олон нийттэй харилцах, номын сангийн үйл ажиллагаа, шинэ номын мэдээ мэдээлэл, уншигч, иргэдийн дунд зохион байгуулсан соёл олон нийтийн ажил арга хэмжээ, уншлага үйлчилгээний талаар байнга уншигч, иргэддээ мэдээлж байна.

Мөн танхимаар үйлчлүүлэгч нарт байгууллагын ил тод байдлын самбарт албан хаагчдын мэдээлэл, албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, уншигчдын санал хүсэлтийг авах хайрцаг, үйлчилгээний журам, харилцах утас, имэйл хаяг зэргийг тодорхой бичиж зургийн хамт байршуулан тухай бүр нь шинэчилж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Хүний нөөцийг чадавхижуулсан байдал (сургалт, семинар, урамшуулал)

Аймгийн нийтийн номын сан нь нийтдээ13-н орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Үндсэн-12, гэрээт-1, байна.

Байгууллагын зорилт, чиг үүргийг хүрээнд албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, идэвхжүүлэх, хүний нөөцийн манлайллыг хангах, хамт олон болон хувь хүний хөгжилд анхаарч, байгууллагын хүний нөөцийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, ажилтан, албан хаагчдыг мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч ажлын байран дахь болон мэргэшүүлэх, туршлага солилцох сургалтуудад тогтмол хамруулан цахим болон танхимын сургалтыг зохион байгуулан ажилласан.

Байгууллагын дотоод сургалт:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн асуудлаар онлайн хурлыг 5 удаа зохион байгуулж, сум,сургуулийн номын санчдыг хамруулан ажилласан.

“НОМЫН САНЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ” НОМЫН САНЧДЫН НЭГДСЭН СУРГАЛТ: **"Номын санчдыг чадавхжуулах нь"** нэгдсэн сургалтыг 03 сарын 16-ны өдөр зохион байгуулж, сургалтаар МУҮНС-аас Дорнод, Сүхбаатар аймгийн номын санчдын хүсэлтийг үндэслэн "Ном зүй, каталогийн ялгаа, "Номын сангийн орчны нөхцөлд тавигдах шаардлага "сэдвээр онлайн сургалт;

"Үйлчилгээний соёл ба харилцаа" сэдвээр УБ хотын Нийтийн Төв номын сангийн захирал, соёл судлаач Д.Индра илтгэл”

Номын сангийн “LIB4U” программын дадлага ажлын сургалт, аймгийн Соёл, урлагийн газрын мэдээлэл, номын сангийн үйл ажиллагаа ба арга зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн талаар мэдээлэл өгч ажилласан. Сургалтанд сум, сургуулийн 32 номын санч нэгэн зэрэг хамрагдсан.

“НОМЫН САНЧДЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” НЭГДСЭН СУРГАЛТ

"Номын санчдын нэгдсэн сургалт"-аар Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Баяраа "Номын сангийн салбарын хүний нөөцийн чадавхийн асуудал", МУҮНС-ийн арга зүйч В.Түвшинтогтох "Уншлагын үйлчилгээний үеийн харилцааны зарим асуудал", багш Д.Оюунбилэг "Хүүхдийн уншлага, түүнтэй холбогдох асуудал", МУБИС-ийн номын сангийн захирал Ж.Баатарсүрэн "Цахим номын сангийн хөгжил", "Соёл олон нийтийн ажлыг танин мэдэхүйн аргаар зохион байгуулах нь" сэдвээр тус тус явуулсан.

"АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААН"

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд Номын санчдыг чадавхижуулах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, хөгжүүлэх зорилгоор "Ажил мэргэжлийн уралдаан"-г зохион байгуулж, номын сангийн бүртгэл хөтлөлт, каталоги зохион байгуулалт, ном зүйн бичилт, асуулт хариулт, тест ажилбар, монгол бичгийн чадвар, багийн ажиллагааг харуулсан үзүүлэлтээр өрсөлдөв.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээний үеэр **"Бийрээ нийлье, ургаа уудалъя"** үндэсний бичиг, угийн бичгийн сургалтыг сум, сургуулийн номын санчдын дунд зохион байгуулахад 20 гаруй номын санч, мэдээллийн ажилтан хамрагдав.

Гаднахь сургалт:

Соёлын яам, Жендерийн үндэсний хороо хамтран жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжүүлэхэд соёлын салбарын оролцоо, дэмжлэг нэн хэрэгцээтэй байгаад үндэслэн соёлын салбарт баримтлах жендэрийн бодлогыг боловсруулахаар Жендэрийн үндэсний хорооны зөвлөх баг, Соёлын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хөгжлийн хөтөлбөр, хүний эрх, жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн М. Сэлэнгээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна.

#**СОЁЛЫН_БҮТЭЭЛЧ_САР**

"MONGOLIAN LIBRARY update 2022" номын санч- мэдээллийн ажилтнуудын улсын IX зөвлөгөөн 2022 оны 11 сарын 09-нд Соёлын яамнаас зарласан Соёлын бүтээлч сарын хүрээнд “Цахим эрин дэх үндэсний ном зүйн цахим мэдээллийн сан” сэдвийн дор зохион байгуулагдлаа.

Философич, зохиолч, лектор, олон нийтийн сэхээн С. Молор-Эрдэнийн “**Номын танилцуулга уулзалт”-**нд нийт ажилтан, албан хаагчид, уншигчид хамрагдсан.

-МУҮНС-аас зохион байгуулсан "Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт" цуврал live сургалтанд сум, сургуулийн 18 номын санчид хамрагдсан.

- Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг нэвтрүүлэх нь

-Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого-2022

- Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт үнэлгээ, шинжилгээний сургалтанд тус тус нийт ажилтан, албан хаагчид хамрагдсан.

“Монголын нууц товчоо эсээ бичлэгийн анхдугаар уралдаан”

МУИС-ийн Номын сан "Үндэсний бичиг үсгийн баяр-2022" өдөрлөгийн хүрээнд Монголын нууц товчоо эсээ бичлэгийн анхдугаар уралдааныг 21 аймаг, төрийн өмчийн их сургуулийн номын санчдын дунд 2 үе шаттайгаар зохион байгуулж, нэгдүгээр шатанд шалгарсан эсээнээс хоёрдугаар шатанд шилдэг гурван эсээг шалгаруулахад гэрээр ном олгох танхимын номын санч В. Энхтуяа 3-р байрт шалгарсан.

БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сүхбаатар аймгийн соёл, урлагийн салбарын ахмад ажилтнуудын анхдугаар зөвлөгөөнд номын санд ажиллаж байсан ахмадуудыг хамруулж, номын сангийн ахмад ажилтан М. Дэнсмаа, С. Халтар нар соёлын салбарын ахмадын зөвлөлийн тэргүүлэгч гишүүнээр сонгогдов.

НОМЫН САНЧДЫН СПОРТЫН НААДАМ

"Илүүдэл жингүй-Эртэч Монгол аян"- ны хүрээнд Монголын номын санчдын уламжлалт спортын наадамд оролцох оролцогчдыг сонгон шалгаруулах, баг, хамтлаг бүрдүүлэх , номын сангийн албан хаагчдыг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх зорилгоор сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, дартс, ширээний теннис зэрэг 5-н төрөлт спортын наадмыг 2022 оны 03 дугаар сарын 21- ний өдөр зохион байгуулахад аймгийн бүх сум , сургуулийн 30 гаруй номын санчид хамрагдав.

Монголын Номын сангуудын дунд зохион байгуулагдаж байгаа ҮБХИС-ын нэрэмжит 6 төрөлт цогцолбор тэмцээнд амжилттай оролцож Хос мөнгөн медаль хүртлээ.

Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газраас согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "**Зөвийг зөвлөе"** арга хэмжээ болон цагдаагийн газрын 2021 оны үйл ажиллагааны талаар Аймгийн Нийтийн номын сангийн ажилтан, албан хаагчдад танилцуулж, сонирхсон асуултад хариулав.

Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн "Бямба" гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласны дагуу аймгийн 4.5 дугаар тойргийн зам дагуух модыг усалж тордон, нөхөн тарьснаас гадна хуваарьт газар Мандарваа цэцэрлэг болон шинэ наадмын талбайн хойд тал, ХЖТ-ын зүүн талын хуваарьт талбайг тогтмол цэвэрлэж, **"НЭГ ТЭРБУМ МОД"** хөдөлгөөнд хамрагдаж, Амгалан хошуунд 220 мод тарьсан.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

1. ТАЙЛАНГЫН БҮТЭЦ, ТОВЧ АГУУЛГА

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2022 онд Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, номын санг нээлттэй мэдлэг мэдээллийн төв болгон хөгжүүлэх бодлого чиглэлийг баримтлан ажиллаа.

Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөг "Алсын Хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын яамны 2021-2024 стратеги төлөвлөгөөтэй уялдуулан, Засгийн Газрын 100 дугаар тогтоолын хүрээнд боловсруулж, Сэлэнгэ Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж бодлогын баримт бичгийн хэрэгжилт 90%, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх үйл ажиллагаа 87.6% гүйцэтгэлтэй үнэлэгдэж, үр дүнтэй ажиллалаа.

Уншигч хэрэглэгчдэдээ ном унших таатай орчин бүрдүүлэх, тэдэнд уншлага үйлчилгээг хүргэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, номын сангийн уламжлалт үйлчилгээг төгөлдөршүүлэх, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх ажлуудыг хэрэгжүүлж, шинээр үүсэн буй болж байгаа цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна.

Ажилтан албан хаагчдад Алсын Хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого төлөвлөлтийг танилцуулж сурталчлан таниулах ажлыг улирал тутам зохион байгуулж, бодлого төлөвлөлтийн шинэчлэлтүүдийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

2022 оноос эхлэн хэрэгжиж байгаа Хөдөлмөрийн тухай хууль, Соёлын тухай хуулиудыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн зохион байгуулав.

Номын сангийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж Захиргаа аж ахуй, Арга зүй мэдээлэл, Уншлага үйлчилгээний гэсэн 3 хэлтэс болон үйл ажиллагааны уялдаа холбоо, ажлын чиг үүргийн ялгарал холбоо хамаарлыг тодорхой болгон ажлын чиг үүргүүдийн шинэчлэн зохион байгуулав.

Номын сангийн " Стратеги төлөвлөгөө"-г боловсруулах ажлыг үр дүнтэй зохион байгууллаа.

Ажиллагсдын "Нийгмийн баталгаа" хөтөлбөрийн хүрээнд ажилтанд амьдралын нөхцөлөө сайжруулах, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, гэр байшингаа тохижуулах ажилд нь дэмжлэг үзүүлэн тус бүр 1-14 хоногийн цалинтай чөлөөг олгож, 0-12 насны хүүхэдтэй ээжүүдэд гэрээр ажиллах, богиносгосон цагаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, улиралын урамшууллыг зохих хувиар тогтмол олгож , байгууллагын эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж, ажиллагсдын ажиллах таатай орчинг бүрдүүлэн ажиллалаа.

Номын сан нийгмийн сайн сайхан байдлын төлөө "Ногоон орчин" бий болгох, зам талбайгаа цэвэрлэх иргэдэд ээлтэй таатай орчин бүрдүүлэх мод цэцэг тарих ажлыг тогтмол зохион байгуулж ирлээ.

Номын санг мэдээлэл хөгжлийн төв болгох зорилгоор Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагатай хамтран охид, эмэгтэйчүүд иргэд албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд зориулсан хүний хөгжлийн сургалтуудыг 18 удаа зохион байгуулж, хүүхэд хамгаалал, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үлгэрлэн ажилласан.

2. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Соёлын өвийг хадгалаж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх сурталчлах, иргэд аж ахуй нэгжтэй хамтран ажиллах, зөвлөмж, зөвлөгөө өгөх, хамтын ажиллагааг

идэвхжүүлэх ажлыг Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт номын санч нарыг хамруулан ажиллаж байна.

Номын сангийн фондонд хадгалагдаж буй ховор ном сударуудын хадгалалт хамгаалалт, орчин нөхцлийг сайжруулах зорилгоор хуучин ном, судруудын баринтаг болон тавиуруудыг шинэчилж, ном хэвлэлээс тусад нь байрлуулан ажилласан.

Соёлын өвийг хамгаалах орон нутгаас нээн илрүүлэх ажлын хүрээнд Соёлын баримтат өв болох "Б.Цэдэн-Иш генералын хилийн зурвасыг бүртгэсэн гар бичмэл, гар зургийг Сэлэнгэ аймгийн Хилийн цэргийн 0243-р ангид хадгалагдаж байгааг нээн илрүүлж ховор ном судрын бүртгэлд бүртгэн бусад сум ,орон нутгийн соёлын өвийн судалгааны бүртгэл гарган цаг тухай бүрт нь хөтлөн, баяжилт хийн ажиллаж байна .

Баримтат өв болох ном, судруудыг нэг бүрчлэн бүртгэж, хадгалалт хамгаалалтын стандартыг хангах. Соёлын баримтат өвийн бүртгэл, мэдээллийн санг үүсгэх , Баримтат өв, ном судрын талаар мэдээллийг 17 сум 4 тосгоны соёлын төвийн номын санчидтай хамтран судалгаа тандалт хийх ажлыг эхлүүлэн 4 сумаас баримт материал хүлээн авч өөрийн сан хөмрөгт хадгалагдаж буй хуучин ном, судрын бүртгэлийг шинэчиллээ судалгаа, бүртгэлийн ажлын явц 50% хувь байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор " Соёлын бүтээлч сар " аяны хүрээнд өрхийн үйлдвэр эрхлэгчид, гар урлал бүтээгчид нарын дунд сургалт зөвлөгөөг зохион байгуулж туслах аж ахуй, гар урлалын аж ахуйг харуулсан зохиол бүтээлийг танилцууллаа.

Фондын ном, хэвлэлийн хүртээмж, үр өгөөж, уншигч хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх зорилгоор номын хүрэлцээ хангамжийн 8 асуулттай судалгаа боловсруулж 30 уншигчдын дунд явуулхад дараах дүгнэлтэнд хүрч байна.

Тууль хайлах урлагийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах аянг зохион байгуулж энэхүү аяны хүрээнд Монгол тууль гарал үүсэл , Монголын нууц товчооны тухай гарын авлага бэлтгэж 60 хүнд суртчилан ажиллаа.

Халгалалт хамгаалалт :

Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3,2,6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, урагдаж гэмтсэн 16 ширхэг номонд сэлбэн засалт хийв. Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын стандартыг сахиж, хөмрөгийг физик, химий болон биологийн шинж чанарын өөрчлөлтөөс үүсдэг шавьж хорхойноос хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ном ариутгагч төхөөрөмжийг ашиглаж байна. Ном хэвлэлийг хуурайшилтаас хамгаалах зорилгоор агаар чийгшүүлэгчийг байнга ажиллуулж байна.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангаас зохион байгуулж буй "Загвар номын сан " сургалт мэдээллийг төвийн бүсийн номын санчдад , Соёлын баримтат өвийн судалгаа бүртгэлийг бий болгох зорилгын хүрээнд " Соёлын баримтат өв, түүний төрөл бүртгэн баримтжуулалт " сэдвээр Нийтийн номын сангийн мэргэжлийн ажилчид 3 соёлын төвийн номын санч 5, байгууллагын номын санч 1 тус бүр хамруулан ажиллаа. Мөн цахим сургалтыг 17 сум 4 тосгоны номын санчдыг хамруулан " Соёлын өв " сэдвээр сургалт, мэдээлэл хийлээ.

Номын үзэсгэлэн :

ГНОТ-аас санаачилж зохион явуулсан "Тунгалаг тамир"уншигчдын бага хурал арга хэмжээнд танхимаар " Ч.Лодойдамбын зохиол ,уран бүтээл " сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 20 ном, бүтээлээр сурталчлан, зохиолчийн амьдрал, зохиол бүтээл туурвилын дээжээс гаргаж уншигч багачуудад танилцуулан мэдээлэл хийлээ.

Уншигч хэрэглэгчдэд ном хэвлэлийг үзүүлэн, таниулах ажлын хүрээнд Дэлхийн сонгодог утга зохиолууд цуврал боть болон сонсдог ном, бүтээлүүдээр танхимаар 1 удаа цахимаар 1 удаа нийт 60 гаран ном бүтээлийн үзэсгэлэн гарган цуврал

бүтээлүүдийг номын сангийн Page хуудсаар дамжуулан иргэдэд сурталчлан ажиллаа.

Монголын зохиолчдын эвлэлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн 60 жилийн ой, хойд бүсийн яруу найргийн наадмийн үеэр Сэлэнгийн зохиолчдынхоо зохиол, намтар уран бүтээлийг харуулсан номын үзэсгэлэнг гаргаж ажиллаа.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангаас зохион байгуулсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдэд “ Нутгийн Брэнд хэрхэн бүтээх вэ “ сургалтын үеэр “Бид бүтээгч үйлдвэрлэгч “ сэдвээр 64 ширхэг номоор үзэсгэлэн гаргалаа.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангаас зохион байгуулсан “ Номын санч мэдээллийн ажилтан” анхан шатны мэдлэг олгох сургалтыг “ Номын сангийн фонд зохион байгуулалт” сэдвээр зааж зөвлөгөө сургалт өгж ажиллаа.

Сэлэнгэ аймгийн төрийн албан хаагчдын дунд засаг даргын нэрэмжит 7 төрөлт “Спортын нөхөрсөг тэмцээнд соёл урлагын байгууллагуудын мэргэжилтэнүүдтэй хамтран Гар бөмбөг, Сагсан бөмбөгийн төрөлд амжилттай оролцсон.

3. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Сэлэнгэ аймгийн иргэдийг ном хэвлэлээр хангаж, уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, ном олголтын хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.

Уншлагын танхимаар үйлчлүүлж байгаа сургуулийн өмнөх болон 1-12 ангийн сурагчид, иргэд олон нийтийн уншлагын чанарыг сайжруулах, шинэ уншигч, ирэгсэд, ном олголтыг нэмэгдүүлэх, Соёл олон нийтийн ажлуудыг өргөн хүрээнд хамруулан зохион байгууллаа.

Уншлага үйлчилгээ

2022 оны жилийн эцэст 1395 шинэ уншигч, 11110 ирэгсдэд 16223 ширхэг ном хэвлэлээр үйлчиллээ. Уншигчдад өдөр тутмын тогтмол хэвлэл болон шинэ мэдээ мэдээллээр үйлчилж байна.

Номын сангийн өдөр тутмын бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэлүүдийг стандартын дагуу бүртгэж, номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд уншигчдын гар дээр уншигдаж байх явцад урагдаж гэмтсэн болон ярлык, уут, формуляр нь алга болсон 504 ширхэг номонд сэлбэн засалт хийв. Өгөгдсөн номзүйн лавлагааг 245 хүнд өгч, татгалзлыг 116 хүнд өгсөн. Уншигчдад өгсөн татгалзлын дагуу шинээр нөхөн бүрдүүлэх ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг бүрдүүлж фондын хүрээ хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Зөөврийн номын сангийн үйлчилгээ нь Номын сангийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаа. 2022 оны 01-р сарын 02-оос 11-р сарын 30-ны байдлаар тусгай чиг үүргийн байгууллага болох Хилийн цэргийн 0243 анги , Хилийн цэргийн 0101 анги ,ШШГГ, Ахмадын сувилал мөн,ЕБ-ын 3,5-р сургууль, МСҮТ, Алтанбулаг сумын соёлын төвийн номын сан СБ сумын 4-р багийн удирдлагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаа

Зөөврийн номын сан нь 2022 оны 01-р сараас 12 сарын 12 хүртэлх хугацаанд ГНОТ-аас 52 удаа 1148 ном, фондоос 12 удаа 117 ном, ХУТ-аас 11 удаа 132 ном авч зөөврийн номын үйлчилгээг тусгай чиг үүргийн байгууллагад 33 удаа 242 /шинэ уншигч/ 932 ирэгсэд 11 шинэ уншигч /хүүхэд/ нийт 1185 уншигчид 1655 ном олголт мөн ЕБС,МСҮТөвд 20 удаа 65 шинэ уншигч, 170 ирэгсэд ,102 шинэ уншигч /хүүхэд/ 263 ирэгсэд /хүүхэд/ нийт 600 уншигчид 726 ном олголт СБ-сумын алслагдсан 4-р баг,Алтанбула сумын иргэдэд 5 удаа 59 /шинэ уншигч/ 23 ирэгсэд 29 шинэ уншигч /хүүхэд / нийт 111 иргэнд 116 ном олголт хийн үйлчиллээ.

Тусгай чиг үүргийн байгууллага,ЕБС,МСҮТ, СБ-сумын алслагдсан 4-р баг,Алтанбулаг сумдад нийт 58 удаа, 1896 уншигчид 2497 ном олголт хийн тус тус үйлчиллээ.

Цахим уншлагыг дэмжих ажлын хүрээнд:

МҮОНРТ-ээс санаачлан 2025 оноос хос бичигтэн болохтой холбогдуулан зохион байгуулж буй "Үндэсний бичигтэн Монголчууд" цахим аянд 61 хүн гарын үсгээ зурж бичлэгээ илгээж чэллэнжид нэгдсэн.

Уншлагын танхимиудаас дараах цуврал мэдээллийг хүүхдэд багачууддаа зориулан хүргэлээ. Үүнд:

Дэлхийн хүүхдийн сонгодог зохиолиуд болох "Бяцхан гүнж", "Нарлаг горхи эдлэнгийн Рэбакка охин", "Бемби ба ойн амьдрал", "Мөрөн голоор аялсан нь", "Жаалхан авхай нар", "Чүдэнз худалдагч охин", "Эмили Бронте", "Зэст уулын эзэгтэй, "Хайд, Жекил нарын хачирхалтай явлууд" зэрэг Эрдэнэсийн сан 108 боть цуврал номыг цахимаар сурталчиллаа. 16 удаагийн цахим сурталчилгааг 5783 хүнд хүрсэн.

Хүүхэд залууст зориулан монголын эх түүхийн талаарх Монголын нууц товчоог сонирхолтой видео хэлбэрээр 10 бүлгийг цахимаар хүргэлээ. Энэхүү бичлэгийг 4420 хүн үзэж сонирхсон

Бага дунд ангийн сурагчдын уран зохиолын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Заавал унших зохиол бүтээл"-ээс "Оюун түлхүүр сургааль", "Сургамжит өгүүллэг", "Тэнгэрээс заяат төрсөн Тэмүжин хүү", "Ламбугайн нулимс", "Нууцыг задруулсан захиа", "Үрэгдсэнийг хүлээгч" зэрэг 16 удаагийн цуврал мэдээлэл оруулж 5746 хүнд хүрсэн.

Нүүдэлчин ард түмний соёлын нэг үндсэн хэсэг болсон "Монгол гэрийн үүсэл хөгжил"-ийн талаарх мэдээллийг бэлтгэж цахимаар сурталчилж 1863 хүн үзэж сонирхсон байна.

Их зохиолчийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан жил бүр Нацагдорж тэмдэгтэн шалгаруулдаг билээ. Ийнхүү Нацагдорж тэмдэгтний болзолыг бага нас, өсвөр насныханд зориулан сурталчлан таниулах чиглэлээр 7 мэдээллийг бэлтгэн цахимаар сурталчилж 10088 хүн үзэж сонирхсон байна.

Монголын алтан үеийн болон шинэ үеийн зохиолчийн намтар уран бүтээлийг судлан үндэсний сонгодог "Ч.Лодойдамбын Тунгалаг тамир", "Хүжийн гал", "Ж. Пүрэвийн Хөгжмийн эгшиг", "Д.Маамын Гишгэх газаргүй хөл, Газар шороо", "Ш.Шажинбатын Элс цас" бүтээлүүдийг 12 удаа цахимаар сурталчлан 3551 хүн үзэж сонирхсон байна.

Уншигчдад дэлхийн уран зохиолын хөгжилд үлэмжийн их хувь нэмэр оруулсан "Дэлхийн сонгодог" бүтээлүүдийг сурталчлах зорилгоор "Мастер Маргарита хоёр", "Федерико Феллини", "Виктор- Мари Хюго", "Франф Кафка Кафкагийн цээрлүүлэгч цаг хугацаа", "Пабло Нэрудо", "Дэлхийн сонгомол яруу найраг, "Бовари хатагтай" зэрэг зохиолчийн намтар уран бүтээлийн агуулгыг 7 удаагийн мэдээллээр бэлтгэн хүргэж 2157 хүн үзэж сонирхсон байна.

Үеэс үед уламжлан өвлөгдөж ирсэн ардын зан заншлыг өсвөр насныханд сурталчлах зорилгоор "Усаа хайрлан хамгаалах уламжлалт ёс заншил", "Бэр шинжих ёс", "Хүргэн шинжих ёс", "Бурхан өршөөг-хэлдэг учир", "Явуу", "Ерөөл" гэсэн 6 мэдээллийг бэлтгэж 1936 хүн үзэж сонирхсон байна

Нийт уншигч хэрэглэгчдээ шинээр номын санд ирсэн ном хэвлэлийг сурталчлан таниулах зорилгоор "Шинэ ном"-ын мэдээлэл бэлтгэж 1885 хүн үзэж сонирхсон байна.

Соёл олон нийтийн ажлын хүрээнд:

Хүүхэд багачуудыг дэлгэцийн донтолтоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилго тавин нас сэтгэхүйн онцлогт тохируулан дараах соёл олон нийтийн ажлыг зохион байгууллаа:

1. Өвлийн хөтөлбөр

“Уншъя, ухааръя, хөгжъе” сурагчдын өвлийн амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилготой хөтөлбөрт дараах сургалт дугуйланг зохион байгуулсан. Үүнд:

- Ном бүтээлчээр уншиж номын тэдэглэл хөтлөх дугуйлан
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шүрээр урлах дугуйлан
- ICE BREAKER Англи хэлний ярианы клуб

Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчид өвлийн хөтөлбөрт хамрагдаж Хүүхдийн уншлагын танхимын номын санч А. Цэнд 30 сурагчдад 10 удаагийн хичээлээр Ном бүтээлчээр унших дадал, номын тэмдэглэл хөтлөх анхан шатны сургалт дугуйланг хичээллүүлсэн. Боловсрол, Шинжлэх ухааны газрын англи хэлний мэргэжилтэн Э. Энхмаа болон ЕБС-ийн Англи хэлний багш нартай хамтарч өөрийгөө хөгжүүлэх, ярианы түвшингөө дээшлүүлэх хүсэлтэй 45 сурагчдад “ICE BREAKER” клуб нээж Гэрээр ном олгох, нийтийн уншлагын танхимын номын санч М. Орхон хариуцаж ажилласан. Гэрээр ном олгох, Нийтийн уншлагын танхимын номын санч Г. Баярмаа дунд ангийн сурагч нар дунд шүрээр урлах дугуйлан хичээллүүлж 13 сурагч нар хамрагдан өвлийн хөтөлбөрийг амжилттай зохион байгууллаа.

2. “Тоглонгоо уншъя” хөтөлбөр

Сүхбаатар сумын сургуулийн өмнөх боловсролын 2 цэцэрлэгийн дунд, бэлтгэл бүлгийн 60 бяцхан хүүхэд багачууд болон ерөнхий боловсролын 2, 5 сургуулийн 4 дүгаар анги, 7,8 дугаар ангийн нийт 212 сурагчдын дунд дэлгэцийн хор уршигаас сэргийлэх, нас сэтгэхүйд нь тохирсон Монгол ардын үлгэр Муур багш, Алтан хүү, Мөнгөн хүү, Өвгөн бар хоёр, Үнэг чоно үлгэрүүдээр “Уншлага- Дүрийн тоглолт” жүжигчилсэн үзүүлбэр, Сэтгэхүй хөгжүүлэх ой тогтоолтын “Адил дүрсийг ол” тоглоом тоглож, “Монгол ёс заншил” танин мэдэхүйн картан тоглоом тоглов. Мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэсэн. Нийт 10525 хүнд хүрсэн.

3. Монгол тууль- Дэлхийн өв

Тууль хайлах урлагийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах аяны хүрээнд Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн монгол хэл уран зохиолын багш нарын хамтарсан Монгол баатарлыг туулсын дүрийн хайчилбар бүтээлээр оролцсон. Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, туульчдаа алдаршуулах зорилгоор М. Парчин туулийн намтар “Бум- Эрдэнэ”, “Эргэл түргэл” туулийн хэсгээс олон нийтэд цахимаар танилцуулж, 413 хүн үзэж сонирхсон байна.

4. “Хооллох соёл- Ширээ засалт” сургалт

Мэргэжил сурталт үйлдвэлрэлийн төвтэй хамтран 15 сурагчдын дунд Номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, үнэ төлбөргүй карт нээж үйлчилсэн. Хооллох соёл, ширээ засалтын сургалт явуулсан ба гэр бүлийн тоглоом тоглож, хайрын таван хэл сэтгэлзүйн тест авч, Тоог үсгээр орлуулах хөгжөөнт тэмцээн зохион явуулав.

5. “Дэлгэцтэй биш, дэлгэсэн номтой нөхөрлөе” нөлөөллийн аян

Дэлгэцийн донтолтын эсрэг олон нийтийн дунд дэлгэцийн хамаарлын хор уршгийг таниулах, тэдний номтой нөхөрлүүлэх, ном унших ач холбогдлыг сурталчлах зорилгоор төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид дунд “Дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөе” сургалтыг Зөөврийн номын санч П. Баасандортой хамтран зохион байгуулсан. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн 0243 дугаар ангийн 68 албан хаагч
- Ж. Нэхийтийн нэрэмжит 0101 дүгээр ангийн 89 албан хаагч
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 35 албан хаагч
- ЕБ 5-р сургуулийн номын санч Ө. Угантуяатай хамтран дунд ахлах бүлгийн 72 сурагч
- ЕБ 3 дугаар сургуулийн номын санч А. Байгальмаатай хамтран дунд ахлах бүлгийн 195 сурагч нарт зохион байгуулж нийт 459 хүн хамрагдсан.

6. “Үлгэрээр хүмүүжье” чанга уншлага

Нийтийн Номын Сангийн номын санчид цэцэрлэгийн хүүхдүүдэд номын сангийн танхимуудыг танилцуулж, Боролдой хүү ба бяцхан амьтдын дүрд хувирч “Туулайн бяцхан байшин”, “Ойн бяцхан байшин” хэмээх үлгэрүүдээр театрчилсан дүрийн тоглолт тоглож, Х.Х. Андесений “Нойрсож буй гүнж”, “Нугасны муухай дэгдээхэй” үлгэрийг видео бичлэгээр үзүүлж, хамтран дуу дуулж, нас сэтгэхүйн онцлогт тохирсон номтой танилцаж хүүхдийн

уншлагын танхимын номын санч Д. Бүрэнжаргал танин мэдэхүйн картууд танилцуулсан. Нийт 7 цэцэрлэгийн 26 бүлгийн 489 хүүхдэд багачуудад 16 удаагийн "Үлгэрээр хүмүүжье" чанга уншлага зохион байгуулсан.

7. "Бид эх орны хөвгүүд" өдөрлөг

Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн Сэтгэлзүйн хангалтын албатай хамтран Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1-6 дугаар сургуулийн 10-12-р ангийн сурагчид, МСҮТөвийн нийт 22 сурагчид эх оронч, эр зоригийн хүмүүжил олгох, эх орноо хайрлан хамгаалах сэтгэлтэй болгох зорилгоор "Бид эх орны хөвгүүд" өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгөөр:

- Монгол улсын баатар Жадамбын Нэхийтийн нэрэмжит Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн товч түүх, танилцуулгыг сонсож, Алдарын тасалгаа үзэж сонирхсон.

-Харуул хамгаалалтын тусгай салбар, Хугацаат цэргийн албан хаагчдын байр обьекттой танилцаж, Хил хамгаалалтанд ашиглаж байгаа зэвсэг, техник хэрэгсэл, бусад хамгаалалтын үзүүлэн таниулах хэрэгсэлтэй танилцсан.

Үдийн цайны цагаар тус ангийн тогооч нар сурагчдад иж бүрдэл хоолоор үйлчилсэн. Өдрийн нэгдэлтэн дээр хөгжимтэй дасгал хөдөлгөөн, биеийн тамирын 1,2,3 дугаар дасгал хийх, бие хамгаалах урлагийн анхан шатны дасгал хөдөлгөөн заалгасан. Үүний дараа ангийн автобусаар Алтанбулаг сум дахь Хилийн 0312 дугаар салбарын үйл ажиллагаатай танилцаж, сурагчдад албаны нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг танилцуулж, нохойн үзүүлбэр сургалтыг үзүүлсэн.

Мөн Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейг үзэж, Монгол Улсын хилийн дугаар багана дээр очин дурсгалын зураг татуулсан.

8. Дэлхийн хүүхдийн номын өдөр

Дэлхийн хүүхдийн номын өдөр буюу Ханс Христиан Андерсений мэндэлсэн өдрийг угтан Нэрт зохиолчийн намтар уран бүтээлийн номын үзэсгэлэн гаргаж, сургуулийн өмнөх боловсролын 4-р цэцэрлэгийн ахлах бүлгийн 30 хүүхэд багачуудад "Бяцхан давхар байшин" жүжигчилсэн дүрийн тоглолт толилуулж, "Нойрсож буй гүнж" үлгэрийг видео бичлэгээр үзүүлж, Бяцхан тоорой, Хэрвээ сайхан амьдарч байвал дуунуудыг хамтран дуулж бүжиглэн, хүүхдэд зориулсан "Дэлгэцтэй биш, дэлгэсэн номтой нөхөрлөе" гарын авлага дурсгал болгон өгч цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэв.

9. Уншигчдын бага хурал

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн номын санч А. Мөнхсанаа , Монгол хэл уран зохиолын багш Н. Дуламцэцэг багш нартай хамтран Гагнуурчин 1а, Компьютер операторчин 1а, Авто машин засварчин 1а ангийн нийт 15 оюутан сурагчдын дунд зохион байгууллаа. Уншигчдын бага хуралд Ч. Лодойдамба гуайн намтар, уран бүтээлийн, XX зууны шилдэг роман болон "Тунгалаг тамир" зохиолын агуулга, утга санааны тухай МХУЗ- ын багш Н. Дуламцэцэг, компьютер операторчины 1а ангийн оюутан н. Номин- Эрдэнэ , Лодойдамба гуайн намтар Тунгалаг тамир зохиолын сонирхолтой судалгааг ННС-ийн номын санч М. Орхон нар мэдээлэл хүргэж нийт оюутнууд зохиолын тухай санал бодлоо чөлөөтэй ярилцаж, өөрсдийн сэтгэгдлийг хуваалцав.

10. Үндэсний бичиг үсгийн баяр

Үндэсний бичигтэн Монголчууд хөдөлгөөний нээлтийг хийж, төрийн албан хаагчдын дунд үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэгч байгууллага, хүн бичиг-уран бичигтэн, Үндэсний өвлөн уламжлагч - тод түргэн уншигч, зөв цэвэр бичигтэнг шалгаруулах аянг зарласан. Аянд нийт 17 байгууллагын 43 албан хаагч хамрагдсан. Сайхан сумын 5 багш, 2 сурагчдын уран бичгийн үзэсгэлэнг Сэлэнгийн долгио чуулгын зааланд иргэд олон нийтэд танилцуулан сурталчилсан. Арга хэмжээнд нийт 200 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан.

➢ "ШИЛДЭГ ҮНДЭСНИЙ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ" буюу зөв цэвэр бичигтнээр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Номин-Эрдэнэ

- “ШИЛДЭГ ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙГ СОНОРДУУЛАГЧ” буюу түргэн, тод уншигчаар Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын бүжигчин Ч.Энхтуул
- “ХҮН БИЧИГ” буюу уран бичигтэнээр Боловсрол шинжлэх ухааны газрын хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Золжаргал
- " ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА "-аар “Ус цаг уур, орчны шинжилгээний төв”-ийн хамт олон, “Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга”-ын хамт олон

Нийт 650 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан.

11. “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийн тайлан

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд 2021 онд нэмэлт өөрчлөлт орсноор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг 5 болон 9 дүгээр сарын гурав дах долоо хоногт тэмдэглэх болсон билээ.

2022онд “Үндэсний бичиг соёл, номын өдрийн” 32 дахь арга хэмжээ Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор 09 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан дараах ажлуудыг зохион байгууллаа.

1. *Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд* ***“Номын өргөөний ид шид”*** *жүжигчилсэн дүрийн тоглолтыг нийт хүүхэд багачуудыг соён гэгээрүүлэх номын өргөөтэй танилцуулах, хүүхэд бүрийн уншигч болгон номтой нөхөрлүүлэх, номын ач тусыг мэдрүүлж нийгмийн эерэг хандлага зөв нөлөөллийг бий болгох, бүх нийтээрээ ном уншихыг уриалах зорилготойгоор зохион байгуулсан. Уралдаанд Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1,3.6-р сургуулийн нийт 102 сурагчид авьяас чадвараа уралдуулан оролцсоноос Тэргүүн байранд Г. Бумцэндийн нэрэмжит Улсын Тэргүүний 1 дүгээр сургууль “Монголын нууц товчоо” дүрийн тоглолтоороо тэргүүлэн 250,000төгрөгний ном худалдан авах эрхийн бичиг, өргөмжлөл бэлэг дурсгалын зүйлсээр шагналаа.*
2. *Өсвөр үеийнхний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, үзэл бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх, сурагчдын хамтын ажиллагаа, харилцааны чадварыг хөгжүүлэх зорилготойгоор “Номын мэтгэлцээн”-ийг Сүхбаатар сумын ЕБ-ын 1,2,3,6 дугаар сургуулийн номын санчидтай хамтран ахлах ангийн багш, сурагчдын дунд зохион байгууллаа. Уг мэтгэлцээнийг Энэрэлт Бэрцэцэг НҮТББ-ын тэргүүн П. Солонго удирдан явуулж нийт 35 багш, сурагчид оролцлоо.*
3. *Сургуулийн өмнөх боловсролын хүүхэд багачуудад хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх, номонд дуртай болгох, үлгэрээр дамжуулан эр зоригтой, үнэнч шударга, ажилч хөдөлмөрч болгон хүмүүжүүлэхийг эцэг эхчүүдэд уриалах зорилгоор “Үлгэрээр үлгэрлэе” чанга уншлагыг Сүхбаатар сумын 8-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш хүүхдүүдийн дунд зохион байгууллаа.*
   Уншлаганд нийт 15 хүүхэд оролцож, “Туулайн бяцхан байшин” дүрийн тоглолтыг үзүүлэн таниулах аргаар сурталчилсан.
4. *Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн иргэд олон нийтийг дэмжиж, номын хавчуурга, номын баринтаг болон гар урлалаар хийсэн шинэлэг бүтээлүүдийг сурталчлах зорилгоор Сэлэнгэ аймгийн хэмжээнд* ***“Бүтээлчээр урлая”*** *уралдааныг зохион байгууллаа. Энэхүү уралдаанд Сүхбаатар сумын 2-р цэцэрлэг, 8-р цэцэрлэг, 1-р сургууль, 3-р сургууль, Спортын бүрэн дунд сургууль, Номгон тосгоны ЕБСургууль, Зүүнбүрэн соёлын төв, Орхон сумын соёлын төв, Дулаанхаан сумын соёлын төв зэрэг баг хамт олон оролцлоо.*
   - *“Номын баринтаг”- урлах төрөлд 5 бүтээл ирсэнээс Номгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч П. Хувьзаягийн бүтээл шалгарч Өргөмжлөл 200,000 төгрөгний эрхийн бичиг*

- *“Ном бүтээх” төрөлд 16 бүтээл ирсэнээс Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн хамт олны “Шаазгай хүү” давуун ном шалгарч Өргөмжлөл, 200,000 төгрөгний эрхийн бичиг*
- *“Номын хавчуурга болон бусад дагалдах хэрэгсэл” бүтээх төрөлд нийт 212 ширхэг хавчуурга ирсэнээс Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн хамт олны 67ширхэг номын хавчуурга бусдаасаа шинэлэг санаа, өнгө загвараараа шалгарч Өргөмжлөл, 100,000 төгрөгний эрхийн бичигээр тус тус шагнаж урамшуулав.*

5. *Номын хандив өргөсөн, номын санд хөрөнгө оруулсан хувь хүнийг алдаршуулах зорилгоор **“Ном хандивлагчаа алдаршуулъя”** ажлын хүрээнд хамгийн олон номын хандив өргөсөн ном хандивлагчаар MC Children’s Books хүүхдийн номын аяныг санаачлагч, багш Баяраагийн Эрдэнэчимэгийг тодруулсан байна. Нийтийн номын санд нийт 1200 гаруй ном, DVD, сургалтыг дэмжих тоглоомнууд хандивласан билээ. Энэхүү хандивын аянаа Англи дахь Монголчууд болон хамтран ажилладаг байгууллага найз нөхдийн дунд номын хандив өрнүүлж нийт Монгол улсын хэмжээнд 32000 гаруй ном хэвлэл, сургалтын материалыг орон нутгийн алслагдсан сум дүүргүүдийн хүүхэд багачуудад хандивласан байна.*
6. *Монголын зохиолчдын эвлэлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Сэлэнгэ аймгийн зохиолчдын номын үзэсгэлэн”-г АДБ-ын Сэлэнгийн долгио чуулга дээр зохион байгууллаа. Үзэсгэлэнд нийт 38 ном үзүүлэн таниулах аргаар сурталчилж, 63 иргэд, зохиолч, яруу найрагчид үзэж сонирхсон байна.*
7. *Ховор хуучин ном, Шинэ номын үзэсгэлэн, Заавал унших зохиолуудын номын үзэсгэлэн, Дэлхийн сонгодог зохиолууд, Англи номын үзэсгэлэн, Бүтээлчээр урлая уралдааны үзэсгэлэн, сурагчдын бүтээлийн үзэсгэлэнгүүдийг Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн гэрээр ном олгох, нийтийн уншлагын танхимд 2022.09.22-ныг хүртэл иргэд олон нийтэд сурталчлан таниуллаа.*
8. *Орон нутгийн номын сангуудын мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, номын сантай холбоотой аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах, номын санчдын мэдлэг боловсролыг дээшлүүлж, чадавхжуулах зорилгоор “Номын санчдын ур чадварын уралдаан”-ыг Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны Соёлын төв, ЕБС-ийн номын санчдын дунд*
   - *Номын сангийн мэргэжлийн мэдлэг шалгах тест*
   - *Номонд техник ажиллагаа хийх*
   - *СОНА-ын удирдамж, төлөвлөгөө, төсөв, тайлан гаргах төрлүүдээр зохион байгууллаа. Уралдаанд нийт 37 номын санчид оролцож Хушаат сумын соёлын төвийн номын санч Ж.Ганцэцэг тэргүүлж Өргөмжлөл, Дурсгалын зүйлсээр шагнаж урамшууллаа.*
9. *МЗЭ-ийн Сэлэнгэ аймаг дахь салбар үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан Сэлэнгэ аймгийн зохиолчдын уран бүтээлийг өсвөр үеийнхэнд сурталчлан таниулах, өвлүүлэн үлдээх, яруу найраг, утга зохиол сонирхогчид зохиолчидтой уулзалт зохион байгуулна. Уулзалтанд Монголын зохиолчдын эвлэлийн гүйцэтгэх захирал О.Энхжавхлан оролцож, санал сэтгэгдлээ хуваалцаж, цаашид хамтран зохион байгуулах ажлын талаар ярилцлаа.*

12. Номын хотхон

Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт Нэгдүгээрт хүүхэд уриан дор тэмдэглэн өнгөрүүлж “Номын хотхон” асарт Ирмүүн хэвлэлийн газартай хамтран Динза ба Цондоолой багц номын худалдаа, Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн , Танин мэдэхүйн картын худалдаа, АХА тэмцээн уралдааныг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд 500 гаруй иргэд хүрэлцэн ирснээс 250 хүүхэд багачууд хамрагдсан.

13. Ном хож

Жил бүрийн зарлан мэдээллэх дуут дохиогоор газар хөдлөлтийн мэдээллийг сургуулилтийн журмаар гамшигийн үеийн аюулыг зарлан мэдээллэх үйл ажиллагаанд багийн дарга Т.Мөнхтуяатай хамтран цугларан ирсэн 4-р багийн 36 иргэдийн дунд "Ном хож" тэмцээнийг амжилттай зохион байгуулж П. Оюунцэцэг тэргүүллээ.

14. Зуны хөтөлбөр

"Оюунлаг, бүтээлч ирээдүйн төлөө" уриатай сурагчдын амралт,чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, үе тэнгийнхнээсээ суралцаж, хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан ЗУНЫ ХӨТӨЛБӨР"-ийн үйл ажиллагааг 2 ээлжээр явуулсан. Үүнд:

1. Номын тухай сэтгэгдэл ярилцах уулзалт

Номын тухай сэтгэгдэл ярилцах 20 удаагийн уулзалт, ярилцлагын хүрээнд дэлхийн хүүхдийн сонгодог болон монголын үндэсний сонгодог уран зохиолын номыг уншиж танилцан бусадтай хуваалцаж, аливааг олон өнцгөөс харж, номноос олон төрлийн мэдлэг мэдээлэл авч ярилцав.

2. Англи хэлний анхан шатны сургалт дугуйлан

Мэргэжлийн англи хэлний багшаар удирдуулан ерөнхий боловсролын сургуулийн 3-12 ангийн 32 сурагч хамрагдаж, англи хэлний анхан шатны ярих, сонсох, бичих чадваруудаа хөгжүүлэв.

3. Зургийн дугуйлан

Уран зургийн олон төрлийг танин мэдэх, зургийн техник зохиомжийн аргачлалуудаас үзэж танилцах зэрэг олон чадваруудыг багтаасан 10 удаагийн сонирхолтой хөтөлбөрөөр 14 хүүхэд багачууд хамрагдав.

4. Ном бүтээлчээр уншиж номын тэмдэглэл хөтлөх дугуйлан

Өөрсдийн нас сэтгэхүйд тохирсон үлгэр, өгүүллэг, туужаас сонгон уншаад номын гол утга санааг ойлгож бүтээлчээр зурж, тэмдэглэн номын тэмдэглэх дугуйланд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хамрагдлаа.

5. Орос хэлний анхан шатны сургалт

Орос хэл сурах хүсэл эрмэлзэлтэй хүүхэд багачуудад Орос хэлний цагаан толгой, авиа зүй, үгийн өргөлт, үг холбох, энгийн өргөн хэрэглээний үг хэллэг зэрэг хөтөлбөрөөр хичээллэж 10 хүүхэд хамрагдсан.

6. Мэтгэлцээний клуб

Өсвөр үеийн хүүхэд залууст өөрийгөө таньж мэдэх, бусадтай харилцан санал бодлоо чөлөөтэй хуваалцах, тодорхой сэдвийн хүрээнд мэтгэлцэх ур чадвараа сайжруулах арга барилд суралцаж 10-16 насны хүүхэд хамрагдаж судалгаа хийх, бүтээлчээр сэтгэх, уран илтгэх, сонсох болон тэмдэглэл хөтлөх чадваруудыг эзэмшлээ.

7. Урлан бүтээх дугуйлан

Хүүхэд багачуудын сэтгэхүй хөгжүүлэх "Шүрэн гоёл" хийх сургалтыг зохион байгуулж 4-14 насны 55 хүүхэд хамрагдаж толгойн гоёл-шанх, сүлжмэл бугуйвч, хэлхээ бугуйвч, бөгж, невдиктэй сувдан гоёл, хүзүүний цэцгэн гоёл, үсний даруулга, ээмэг зэрэг бүтээлүүдийг хийх ур чавдар эзэмшлээ.

15. Номын сантай танилцах аялал

Номын сантай танилцах аялалд Г.Бумцэндийн нэрэмжит УТ-ний 1 дүгээр сургуулийн Уянга багштай 6г ангийн 28 сурагчид, Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн дунд ахлах бүлгийн 45 суралцагчид, 4-р цэцэрлэгийн бэлтгэл "Б" бүлгийн Болорцэцэг багштай 25 хүүхэд багачууд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилтан ажиллагсадын 30 хүүхэд багачуудыг номын сантай танилцуулан "Туулайн

бяцхан байшин” үлгэрээр дүрийн жүжигчилсэн тоглолт толилуулж өөрсдийн сонирхсон номоо уншиж, танин мэдэхүйн карт таалцан тоглож, Хараацай хэдгэнэ хоёр үлгэрийг сонсож уншигчийн карт нээлгэж номын сантай танилцах аялалд 128 хүүхэд багачууд хамрагдсан.

16. Хүүхдээ сонсоё

Монгол улсын Засгын Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Зөв хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдээ сонсоё” нээлттэй хаалганы өдөрлөгөөр Арга зүйч Т. Нарандалай хүүхэд багачуудад номыг бүтээлчээр унших аргын талаар “Оновчтой уншлага” сургалт мэдээллийг хүргэж номыг зөв унших арга барилд уриалж, номын санч Г.Баярмаа шүрээр урлан бүтээх сургалтыг явуулж номын санч А.Цэнд сурагчдад үнэ төлбөргүй карт нээж шинэ номын үзэсгэлэн гаргаж номын сангаас хүүхэд багачуудад зориулсан сургалт дугуйланг танилцууллаа. Нийт 50 хүүхэд 20 эцэг эхчүүд хамрагдав.

17. Эх хэлний өдөр

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүрийн 09-р сарын 01-ны өдрийг “Эх хэлний өдөр” болгон зарласан. Энэхүү өдөр номын сангийн гадна дотно орчныг чимэглэж, эх хэлний холбогдолтой ном судраар үзэсгэлэн гаргаж, хүүхэд залуучуудын заавал унших монголын болон дэлхийн уран зохиолын номуудаар сурталчилан таниулсан арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд үнэ төлбөргүй карт нээж үйлчилж 135 хүүхэд залуус хамрагдсан.

18. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” нэгдсэн 32 дахь арга хэмжээ

Зохиолч С.Молор- Эрдэнэ “Шинэ номын танилцуулга уулзалт

Монголын "Философийн Академи” - ийг үүсгэн байгуулагч, Философич, зохиолч, лектор, олон нийтийн сэхээтэн Санжаадоржийн Молор-Эрдэнийн "Номын уулзалт, ярилцлага"-ыг амжилттай зохион байгууллаа. Уулзалтын хүрээнд зохиолч өөрийн шинээр гаргасан “Орчин үеийн асуудал”, “Чөлөөлөлтийн онол” цуврал номын талаар танилцуулж, монгол хүн бүрийн мэдлэг боловсролд тус болохуйц мэдлэг мэдээлэлээ хуваалцаж зохиолч уншигч хооронд сонирхолтой ярилцлага боллоо. Уулзалтанд Хилийн 0101-р анги, 0243-р ангийн албан хаагчдийн төлөөлөл болон идэвхтэн 48 уншигч нар оролцсон.

19. Номыг шинжихүй

Хамтран ажиллагч байгууллаг болох Б. Цэдэн-Ишийн нэрэмжит Хилийн 0243 дугаар ангийн ажилтан албан хаагчдад “Номыг шинжихүй” уншлагын аяны хүрээнд “Монголын нууц товчоог шинжихүй” сургалт зохион байгуулав. Уг сургалтын хүрээнд номын сангийн идэвхтэн уншигч Г.Хүлэг-Эрдэнэ Монголын нууц товчооны нууцын тухай сонирхолтой мэдээлэл хүргэлээ. Сургалтанд 77 албан хаагч хамрагдсан.

20. Соёлын бүтээлч сар

Соёлын яамнаас хэрэгжүүлж буй “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд дараах чиглэлийн дагуу хүүхэд залуус, иргэд олон нийтэд соёлын боловсрол олгох ажлуудыг зохион байгуулсан.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл чиглэлийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Эзэн Богд Чингис хааны суу алдар, агуу их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдаршуулан мөнхжүүлэх, төрт ёсны үнэт өвийг бэхжүүлэх, эв эеийг бататгах, “Чингис хааны эш хөрөг залах”зарлиг сургаалийг судлах, сурталчлах зорилгоор цахим хаягаар 3 удаагийн мэдээллийг бэлтгэн сурталчилж нийт 458 хүнд хүрсэн байна. Уг ажлын хүрээнд 150 гаруй материалыг иргэдэд үзүүлэн таниулах аргаар сурталчилсан.

Монголын нууц товчоог сурталчилах ажлын хүрээнд 0243 дугаар ангийн номын санч Д. Болортой хамтран “Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ” АХА

тэмцээнийг 50 гаруй албан хаагч дунд зохион байгуулсан. Тэмцээнд хилийн албаны тасгийн бэлэн байдал, дүн шинжилгээний ахлах офицер Б.Нямдорж тэргүүллээ.

Монгол бичиг үсгээ сурталчлан эх хэлний дархлааг сайжруулах зорилгоор “Эх хэл мину” монгол хэлний тэмцээнийг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1,2,3,4,5,6 дугаар сургуулийн 12 дугаар ангийн 9 багийн 45 сурагчид дунд зохион байгууллаа.

Тэргүүн байранд: ЕБ-ын 4 дүгээр сургуулийн “Тэнгэрийн судар” баг

Дэд байранд: ЕБ-ын 4 дүгээр сургуулийн “Монголын нууц товчоо” баг

Гутгаар байранд: ЕБ-ын 6 дугаар сургуулийн “Шинэ алхам” баг тус тус шалгарсан.

“Номтой өглөө” 30 минутын уншлага

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн тамгын газар, Цагдаагийн газар, Төрийн үйлчилгээг хүргэх “Нэг цонхны үйлчилгээ”- ний төвийн хамт олон болон Сүхбаатар сумын ЕБС-ийн 1,4,5 сургуулийн албан хаагч, багш ажилчдын дунд Хүүхдийн уншлагын танхим болон Гэрээр ном олгох, нийтийн уншлагын танхимын номын санч нар ном уншихын ач холбогдлын талаар мэдээлэл өгч “Номтой өглөө” сургалтыг зохион байгууллаа. Уншлаганд хамрагдсан албан хаагчид сонгосон номоо 15 минут уншиж ерөнхий агуулгатай танилцан үлдсэн 15 минутанд уншиж танилцсан номоо бусадтайгаа хуваалцаж санал сэтгэгдэлээ хуваалцсан. Арга хэмжээнд нийт 198 албан хаагчид оролцсон.

Ном сонирхогчдын уулзалт

Ижил сонирхолтой үеийн хүүхэд залуустай өөрийн уншсан сэтгэлд хоногшсон номыг хуваалцаж, номын тухай хүүрнэн ярилцаж, номноос олон төрлийн мэдлэг мэдээлэл авч, шинэ хүрээлэл бий болгох зорилготой “Ном сонирхогчдын уулзалт”-ыг зохион байгууллаа. Уулзалтанд номын сангийн идэвхтэн уншигчид болон ЕБ-ын 1, 6-р сургуулийн дунд ахлах ангийн нийт 30 сурагчид оролцож өөрийн сэтгэлд хоногшсон номын тухай ярилцаж, 1-р сургуулийн сурагч Б.Номин номын тэмдэглэл хөтөлсөн аргачлалаас бусадтайгаа хуваалцлаа.

“Шинэ номын эвэнт” арга хэмжээ

Номын сангийн фондонд нөхөн бүрдүүлсэн шинэ номуудаа уншигч хэрэглэгчдэдээ сурталчлах “Шинэ номын эвент” арга хэмжээг зохион байгуулсан. Шинээр ирсэн 160 гаруй номуудаар Хүүхдийн уншлагын танхим болон Гэрээр ном олгох нийтийн уншлагын танхимуудад номын үзэсгэлэн гаргаж нийт 145 уншигчдадаа үзүүлэн таниулах аргаар сурталчилан гэрээр ном олгох үйлчилгээ үзүүллээ. Мөн Сүхбаатар сумын багийн дарга нар үзэсгэлэнд оролцож мэдээ мэдээлэл авлаа. Тус арга хэмжээний хүрээнд шинээр уншигч болсон иргэдэд үнэ төлбөргүй уншигчийн карт нээх үйлчилгээ үзүүлсэн.

“Сэлэнгийн зохиолчдыг хэн сайн мэдэх вэ? цахим уралдаан

Сэлэнгэ аймгийн 17 сум 6 тосгоны номын санчдын дунд “Сэлэнгийн зохиолчдыг хэн сайн мэдэх вэ?” цахим уралдааныг зохион байгууллаа. Уг уралдаанд 21 номын санчид оролцож Сумдын соёлын төвийн номын санчдаас Тэргүүн байранд Шаамар сумын соёлын төвийн номын санч Б. Ариунсарнай, Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдаас 6-р сургуулийн номын санч Б.Долгорсүрэн нарыг шалгаруулж тус бүр 50,000 төгрөг, Өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа.

“Үндэсний уран зохиол-Соёл гэгээрэл” сошал давалгаанд Монголын зохиолчдын эвлэлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл нэгдэж цахимаар шүлэг яруу найргаасаа уншиж, туурвисан хэвлүүлсэн ном бүтээлээ танилцуулан, нутаг орноо соён гэгээрүүлж явсан эрхэм хүмүүсийн тухай дурсан ярилцлаа. Уулзалтанд МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Л.Банзрагч, Т.Доржсүрэн, Хэнтийн Батхүү, Д.Цэвээнгэрэл, Л.Мэндбаяр нар оролцож ном сонирхогч уншигч олныхоо соноорыг мялаалаа. Зохиолчид номын дээжээсээ номын сангийн фондонд хандивлалаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэл

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Аймгийн ИХТөлөөлөгч Сэлэнгэ хаан

банкны захирал О.Дамдинпүрэв, ДЗМОУБ Сэлэнгэ ОНХ-ийн хөгжлийн чиглүүлэгч Э.Эрдэнэбат нартаа хамтран "НУТГИЙН БРЕНД ХЭРХЭН БҮТЭЭХ ВЭ? сургалтыг цахим болон танхимаар 8 багийн хувиараа үйлдвэрлэл эрхлэдэг 31 иргэн, Сүхбаатар, Шаамар сумын МСҮТ-ийн 12 сурагч хамрагдан өөрсдийн бүтээлүүдээр үзэсгэлэн худалдаа гаргалаа.

Соёлын аялал жуулчлал

Аймгийн дурсгалт газруудын талаар мэдээлэл бэлтгэн цахим хаягаар болон үзүүлэн таниулах аргаар сурталчилж нийт 560 гаруй иргэдэд хүрсэн байна.

Сэлэнгэ айгаруй хмгийн түүхэн дурсгалт газар болох “Буур хээрийн тал” –аар мэдээлэл бэлтгэн цахим хаягаар сурталчилан ажиллаа. Нийт 120 хандалт авсан байна.

“Өглөөний уншлага” хөтөлбөр

Үндэсний хэмжээнд зарлагдсан “Өглөөний уншлага”-нд Сүхбаатар сумын ЕБ-ын 4-р сургуулийн Б. Гүнжидмаа багштай 9б ангийн 22 сурагч, 1-р сургуулийн Б. Уранбилэг багштай 10в ангийн 25 сурагч, 4 сургуулийн З.Хонгор багштай 4а ангийн 34 сурагч, Ө. Нямаанямбуу багштай 4в ангийн 39 сурагчдад Номын унших ач холбогдол, Оновчтой уншлага, Номын тэмдэглэл хөтлөх аргын талаар сургалт мэдээлэл өгсөн. Нийт 98 сурагч хамрагдсан.

Номын сангийн дэргэдэх Номын клуб байгуулах

Бүх нийтийн соёлын боловсролыг дэмжих чиглэлийн дагуу сурагчдад номын сан, номоор дамжуулан мэдлэг, мэдээллийг хүргэх, ном унших соёлыг сурталчлан таниулах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжих, нийгэмд эерэг хандлага түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор "Номын клуб"-ыг Сүхбаатар сумын ЕБС-ийн 6-10 ангийн 30 сурагчдыг хамруулан Номын клубын нээлтийн уулзалт, Номын сантай танилцах, номын санчийн нэг өдөртэй танилцах аялал, “Ном сонирхогчдын эртэч уулзалт, Хэн намайг ийм болгов? Хэн намайг эмчлэв? Ном сэлбэн засалт гэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

21. “Зохист аялгуу-2022” богино өгүүллэгийн наадам

    Сэлэнгэ аймгийн хэмжээнд 5-12 дугаар ангийн сурагчид дунд Монголын зохиолчдын эвлэлийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлтэй хамтран “Зохист аялгуу” богино өгүүллэгийн наадмыг зохион байгууллаа. Наадамд 10 сум 2 тосгоны 18 сурагчид оролцож 80 гаруй иргэд хамрагдлаа.

22. “Буудай ба Сэлэнгэ ” хүүхэлдэйн баатрын дүр бүтээх цахим уралдаан

    Буудай ба сарнай дижитал комик дүр бүтээх цахим уралдааныг улсын хэмжээнд зарласан. Уралдаанд сэлэнгэ нутгийн онцлогийг тусгасан 2 дүрийг шалгаруулж өөрийн байгууллагын дүртэй болж гарын авлага, материалдаа сурталчлан таниулах болно.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, уншигч үйлчлүүлэгчдийн хэрэгцээ сонирхлыг судлах, санал хүсэлтийг сонсох, номын сангийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах зорилгоор 90 судалгааг авсан. Энэхүү судалгаа нь нийт 2 хэсэг 16 асуулттай. Асуумжийн эхний хэсэгт ерөнхий мэдээллийг багтаасан бол дараагийн хэсэгт номын сангийн уншигч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн талаарх холбоотой асуултуудыг багтааж цаашдын хүсэл сонирхолыг нь асуусан. Судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн 1-12 ангийн сурагчид болон насанд хүрэгчид хамрагдаж номын сангийн тухай ойлголт, үйл ажиллагаа болон танхимуудын номын хүрэлцээ хүртээмж, шинэ номын баяжилт номын санчийн харилцаа, хандлагын талаар тодорхой үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Уг судалгааны ажлыг хийснээр дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

- Номын сан нь шинээр хэвлэгдсэн ном, сонин сэтгүүлийг уншигчдын эрэлт, санал хүсэлтэнд хэрэгцээнд тулгуурлан тогтмол авдаг байх
- Шинэ номын хүрэлцээ хангамж дутагдалтай
- Өвлийн улиралд номын сангийн уншлагын танхимууд маш хүйтэн, гадуур хувцастай их суудаг

- Номын сангийн танхимуудын дулааны асуудлыг шийдэх, уншигчдын тав тухтай орчинг бүрдүүлэх
- Гадаад хэлний номыг гэрээр болон танхимаар уншлаганд гаргах
- Орчин үеийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилтой болох
- Номын сангийн баяжилтанд анхаарах /Элсэлтийн ерөнхий шалгалтын тест, гарын авлага, материалын шинэ ном хэвлэл /

“Соёлын боловсролын үндэсний сургагч багш” бэлтгэх вакум сургалт

Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний үндсэн үзэл баримтлал нь төрөөс үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулах хөгжлийн төлөөх түншлэлийг хөгжүүлэх зэрэг тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудад суурилсан сургалтанд 21 аймгийн соёл урлагын газрын мэргэжилтэн, номын сангийн албан хаагчид хамрагдсан.

4. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн номзүйн ажлыг хэрэгжүүлэх, уншигч хэрэглэгчдэд төрөл бүрийн номзүйн лавлагаа мэдээллийг өгөх, католог зохион байгуулах, шинээр ирсэн болон хандиваар ирсэн ном хэвлэлүүдийг данслан, техник ажиллагаа хийн танхимуудад хуваарилах ажлыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жилийн эцсээр номын сангийн фондоо төсвийн хөрөнгөөр 421 ширхэг 8.310.930 төгрөг, Хандиваар 686 ширхэг 12,330,100 төгрөгний номуудыг дахин үнэлэх журмын дагуу үнэлэн авч нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэн уншлага үйлчилгээнд ашиглуулж байна.

Номын санчдын татгалзлын дэвтэрт дүн шинжилгээ хийж нөхөн бүрдүүлэх шаардлагатай ном хэвлэлийн талаар удирдалагад танилцуулан ажиллаа.

Номын сангийн нэгдсэн болон нэг бүрчилсэн бүртгэлийг стандартын дагуу үнэн зөв бүртгэж, статистик тайлан мэдээг удирдах байгууллагад хүргүүлэн ажилласан.

Шинээр болон хандиваар ирсэн 420 гаруй номонд каталогийн карт бичин шоголд байрлуулан цаг үеийн редакцийг 4 удаа зохион байгуулсан. 42 уншигчид болон номын санчдад каталоги ашиглах зааварчилгаа өгсөн

Жилийн эцсийн байдлаар уншигчдын асуусан 103 лавлагаанд цахимаар болон танхимаар хариу өгч, ном хэвлэлийг олж ашиглахад нь дэмжин ажилласан.

Уншигч хэрэглэгчдэд ном хэвлэлийг сурталчлан таниулах зорилгоор шинэ номын мэдээ 4 удаа, сэдэвчилсэн номзүйн мэдээлэлийг 8 удаа цахимаар болон танхимаар сурталчилж нийт 5203 иргэд олон нийтэд хүргэсэн байна.

Номын сангийн татгалзалын дэвтэрт дүн шинжилгээ хийж номын санд нөхөн бүрдүүлэх шаардлагатай 300 гаруй ном хэвлэлийг нөхөн бүрдүүлж, фондын эргэлтийг сайжруулан ажилласан. Өмнөх оны хандивын номтой харьцуулахад 70%-аар өссөн дүнтэй байна

Сэлэнгэ аймгийн зохиолчдын намтар номзүйн бүртгэл гаргахаар төлөвлөж МЗЭ-ийн шагналт яруу найрагч Т.Доржсүрэн болон Д. Бадарч нартай уулзан зөвлөгөө авч хамтран ажиллаж байна. Сэлэнгэ аймагт уран бүтээлээ туурвиж байсан болон одоо ажиллаж амьдарч байгаа 42 зохиолчдын намтар уран бүтээлийг судлаад байна. Цаашид өөр орон нутагт амьдарч байгаа зохиолчдын мэдээллийг хүлээн авах, уулзах ажлуудыг төлөвлөн, зохиолчдын намтар уран бүтээлийн мэдээллийг шинэчилсээр байна.

Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд олон нийтэд ардын аман зохиолыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “ Нүүдлийн соёл иргэншлийн бэлгэ тэмдэг болсон монгол гэрийн үүсэл хөгжлийн талаар цахимаар сурталчлан 816 иргэдэд хүрсэн байна.

Үндэсний бичиг соёл номын өдөр”-үүд нэгдсэн арга хэмжээнд оролцож, “Бид үндэсний бичигтэн Монголчууд” аянд нэгдэж төрийн албан хаагчдын нэрсийг монгол бичгээр бичүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт нэгдсэн арга хэмжээнд 600 гаруй иргэд оролцсон. Тус арга хэмжээнд зориулан Үндэсний бичгээр бичсэн номуудаар номзүйн бүртгэл гарган 260 гаруй иргэдэд сурталчилсан

Сэлэнгэ аймгийн үзэсгэлэнт, түүхэн дурсгалт газруудын талаар мэдээлэл бэлтгэн аялал жуулчлалаар орон нутагт зорчилж байгаа жуулчидад зориулан 50 ширхэг гарын авлагыг тарааж сурталчилан ажилласан

Сумдын соёлын төвийн болон ЕБ-н сургуулийн номын санчдад “Номын сангийн каталог, картын сангийн зохион байгуулалт”, “Номын сангийн номзүйн тухай ойлголт” сэдвүүдээр танхимын сургалтуудыг зохион байгуулсан. Нийт 16 номын санчид хамрагдсан.

5. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн үйлчилгээг цахимжуулах, иргэд уншигчдад хандсан номын сангийн мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор цогц вэб сайтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. Номын сангийн техник технологийн чадамжийг сайжруулах зорилгоор камержуулалт, компьютер тоног төхөөрөмжүүдийн зах зээлийн судалгаанд үндэслэн төсөвүүдийг хийж гүйцэтгэлээ.

Цахим орчны чиг хандлага, Цахим мэдээллийн сан бүрдүүлэлт сэдэвт сургалтыг нийт ажилчдын дунд 8 удаа зохион байгуулж давтан тоогоор 80 хүнийг хамруулллаа.Номын сангийн цахимжуулалттай холбоотойгоор дата бааз үүсгэх, хадгалалт хамгаалалтын шинэ технологийг судлан таних зорилгоор Блокчэйн технологийн талаар судалгаа хийж мэдээлэл хүргэв.“НОМЫН САНЧ” онол аргазүйн сэтгүүлийг Аргазүйч, Номын санчтай хамтран бэлтгэж 200 ширхэгийг хэвлэсэн.Номын сангийн автоматжуулалтын өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагын талаар сургалт мэтгэлцээнийг нийт ажилчдын дунд зохион байгууллаа.

Номын сангийн электрон каталогийг сурталчилах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор электрон каталогийн мэдээлэл, нэвтрэх QR код бүхий 2 төрлийн брошур 50 ширхэг хэвлэж номын санчдад хүлээлгэн өгсөн, цахим хаягаар 2 удаагийн мэдээлэл оруулсан байна.Номын сангийн танилцуулга брошурын өнгө загварыг шинэчлэн 100 ширхэгийг хэвлэж бүхий л төрлийн ажил, арга хэмжээнд иргэд, уншигчдад тараав.

Аймгийн сумд болон сургуулиудын нийт номын санчдын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор СЭЛЭНГЭ АЙМГИЙН НОМЫН САНЧИД facebook грүп үүсгэн сургалтын материал, зураг, мэдээлэлээр тогтмол ханган идэвхитэй ажиллуулж байна.

Зах зээлийн суурь судалгаа бүхий номын сангийн камержуулалтын төсөв гүйцэтгэж холбогдох газар хүргүүлэв

ХУТанхим, ГНОТанхимтай хамтран Өвлийн хөтөлбөр, ICE BREAKER англи хэлний ярианы клуб, Номыг бүтээлчээр унших гарын авлага, Тоглонгоо уншъя, Монгол тууль-Дэлхийн өв, Дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөе, Үлгэрээр хүмүүжье, Бид эх орны хөвгүүд өдөрлөг, Дэлхийн хүүхдийн номын өдөр, Уншигчдын бага хурал зэрэг нийт 33 ажлуудад постер, цахим мэдээлэл бэлтгэх, өргөмжлөл, талархал, гарын авлага бүхий 80 гаруй хэвлэлийн бүтээгдэхүүнийг бэлтгэн хамтран ажиллаа.

Үндэсний бичиг үсгийн баяр, Номын баярын арга хэмжээнд нийт 8 төрлийн постер, 5 танилцуулга видео, 11 видео шторк, 18 төрлийн 150 ширхэг талархал, өргөмжлөл хэвлэн бэлтгэлээ. Мөн бусад төрлийн арга хэмжээ, ажил үйлчилгээнд зориулан 270 гаруй хэвлэлийн бүтээгдэхүүн хэвлэн бэлтгэсэн байна.

Сумдын номын сангийн хүрээнд

Байгууллагын 2 компьютерыг засаж service хийв. Мөн Ерөө сумын компьютерыг форматлаж программыг дахин ачааллаа. Бүс нутгийн загвар номын санг хөгжүүлэх ажлын хүрээнд аргазүйчтэй хамтран Ерөө, Зүүнбүрэн сумуудад ажиллан "Цахим орчинд ажиллахуй" сэдэв сургалт явуулах, номын сангийн компьютер программуудад үйлчилгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Сумдын номын санчдын чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд лхагва гараг бүрт ZOOM ашиглан 1-2 цагийн сургалтыг нийт 3 удаа зохион байгууллаа.

6. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аргазүйн ажлын хүрээнд сумд болон сургуулиудын номын санчдад аргазүйн зөвлөлгөөг амаар болон биечлэн 51 удаа хүргэсэн байна.

Улаанбаатар хотын Хүүхдийн Төв Номын сангийн аргазүйн хэлтэстэй хамтран Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын нийт 25 номын санчдад "Номын сангийн ажлыг зохион байгуулахад номын санчийн гүйцэтгэх үүрэг" сэдвээр 2 өдрийн мэргэжил онолын сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Үүнд:

- "ЕБС-ийн номын санчийн харилцаа хандлага"
- "ЕБС-ийн үйл ажиллагаа"
- "Сургуулийн номын санч сурган хүмүүжүүлэх арга зүйд суралцах нь"
- "Хүүхдийн уншлаганд эцэг эхийн оролцоо"
- "Цар тахлын үеийн сургуулийн номын сангийн үйл ажиллагаа"
- "Орчин цагийн номын сангийн үйлчилгээ уншигчийн хэрэгцээ" зэрэг 6 сэдвийн хичээлийг сонслоо.

Энэ ажлын хүрээнд Улаанбаатар хотын хүүхдийн болон сургуулийн шилдэг номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцон мэдлэг боловсролоо дээшлүүлж өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна..

Номын сангийн үндсэн бүртгэлүүдийг хөтлөх тухай, номын фондыг цэвэрлэх,ариутгах зэрэг мэргэжлийн 2 аргачлал зөвлөмжийг боловсруулан номын санчдад хүргэсэн.

Сэлэнгийн зохиолчдын намтар уран бүлээлээр мэргэжлийн ур чадварын тэмцээнийг нэг удаа зохион байгуулсан

"Ерөө, Сэлэнгэ Бэлчир бүсийн номын санчдыг мэргэжил аргазүйгээр хангах нь"сургалтыг "Номын сангийн заах аргазүй, "Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх аргачлал" ," Номын сангийн ном солилцоо" "Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах тухай" сэдвээр зохион байгуулж нийт 21 номын санчид оролцож мэдлэг боловсролоо дээшлүүллээ. Орон нутгийн 23 номын санчдад 6 удаа цахим соёлд суралцах болон мэргэжлийн сургалтуудыг зохион байгууллаа. зориулж Номын санч -Мэдээллийн ажилтан "-ы мэдлэг олгох 5 хоногийн 40 цагийн сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтанд Ерөө, Хөтөл, Баруунбүрэн, Шаамар, Сүхбаатар сумын нийт 8 номын санчид хамрагдаж, номын сангийн 12 төрлийн хичээлийг судалж дадлага хийв.

Номын санчдад зориулсан Номын санч- онол аргазүйн сэтгүүл нэг дугаар гаргаж, мэдээллээр чанарыг сайжруулав

7. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь нийт 18 орон тоогоор батлагдаж үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнээс 8 нь захиргаа үйлчилгээний ажилтан, 10 Мэргэжлийн ажиллагсад ажиллаж, төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд үзүүлж байна.

Номын санчдын мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлж, сургалт семинарт тогтмол хамруулж, ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. "Монгол Улсын Үндэсний Номын Сан", "Австралийн Элчин Сайдын Яам"-ны хамтарсан цахим болон танхимын сургалтаар орчин үеийн нийтийн номын сангийн шилдэг туршлага, жишиг хөтөлбөрүүдийг танилцуулах аргазүйн сургалтанд хамрагдаж туршлага хуримтлуулсан. Нийт сумдын болон Ерөнхий боловсролын сургуулийн 45 номын санчдыг хамруулан зохион байгуулав.

Улаанбаатар хотын Хүүхдийн төв номын сантай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, туршлага солилцох

танилцах арга хэмжээнд хамрагдсан. Цахим болон танхимын сургалтанд нийт 85 номын санч хамрагдсан.

Монголын Үндэсний номын сангийн аргазүйн хэлтсээс зохион байгуулсан “Цахим сан хөмрөг бүрдүүлэх тухай”,”Аймаг Нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийг шинэчлэх” санал асуулга,”Соёлын бодлого ба бүтээлч үйлдвэрлэл”,”Соёлын бодлого хэрэгжилтийг үнэлэх үзэл баримтлал,бодлого хэрэгжилт” зэрэг цахим сургалтанд хамрагдлаа.

Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл

- Номын санчдыг хөгжүүлэх нэгдсэн бодлого байхгүй
- Номын санчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт хамруулах төсөв, санхүүгийн дэмжлэг байхгүй.
- Номын санчийн нийгмийн асуудалд анхаардаггүй, төрөөс гаргасан бодлого шийдвэр нь хэрэгждэггүй зэрэг шалтгааны улмаас мэргэжлийн боловсон хүчин хүний нөөцийн хангамж дутмаг байгаагаас номын санд мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байгаа нь номын сангийн үндсэн үйл ажиллагааг алдагдуулж номын сангийн салбар хөгжихгүй байх гол шалтгаан болж байна

8. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Номын сангийн төсвийг үр дүнтэй удирдаж 2022 онд өр авлага үүсгэхгүй ажиллаж, сар бүрийн 15-нд шилэн дансандаа мэдээлэл оруулж, ил тод байдлыг самбарыг тогтмол хөтлөн ажилласан.

9. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аугаа их ялалтын баярын 77 жилийн ойг тохиолдуулан “Ялалтын баяр ба Монголчууд” сэдэвт уулзалт ярилцлага зохион байгуулав. Нийт 18 сурагчид хамрагдсан.

Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Дэлхийн зөн олон улсын байгууллагын мэргэжилтэн Б. Батжаргалтай хамтран гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүрдүүлж, хүн бүрт хүүхэд бүрийг хайрлах, эерэг сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор “Бид- Аз жаргалтай гэр бүл” сургалтанд хамрагдсан.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, уншигч үйлчлүүлэгчдийн хэрэгцээ сонирхлыг судлах, санал хүсэлтийг сонсох, номын сангийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах зорилгоор 90 судалгааг авсан. Энэхүү судалгаа нь нийт 2 хэсэг 16 асуулттай. Асуумжийн эхний хэсэгт ерөнхий мэдээллийг багтаасан бол дараагийн хэсэгт номын сангийн уншигч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн талаарх холбоотой асуултуудыг багтааж цаашдын хүсэл сонирхолыг нь асуусан. Судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн 1-12 ангийн сурагчид болон насанд хүрэгчид хамрагдаж номын сангийн тухай ойлголт, үйл ажиллагаа болон танхимуудын номын хүрэлцээ хүртээмж, шинэ номын баяжилт номын санчийн харилцаа, хандлагын талаар тодорхой үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Уг судалгааны ажлыг хийснээр дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

- Номын сан нь шинээр хэвлэгдсэн ном, сонин сэтгүүлийг уншигчдын эрэлт, санал хүсэлтэнд хэрэгцээнд тулгуурлан тогтмол авдаг байх
- Шинэ номын хүрэлцээ хангамж дутагдалтай
- Өвлийн улиралд номын сангийн уншлагын танхимууд маш хүйтэн, гадуур хувцастай их суудаг
- Номын сангийн танхимуудын дулааны асуудлыг шийдэх, уншигчдын тав тухтай орчинг бүрдүүлэх
- Гадаад хэлний номыг гэрээр болон танхимаар уншлаганд гаргах
- Орчин үеийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилтой болох
- Номын сангийн баяжилтанд анхаарах /Элсэлтийн ерөнхий шалгалтын тест, гарын авлага, материалын шинэ ном хэвлэл /

“Соёлын боловсролын үндэсний сургагч багш” бэлтгэх вакум сургалт

Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний үндсэн үзэл баримтлал нь төрөөс үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулах хөгжлийн төлөөх түншлэлийг хөгжүүлэх зэрэг тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудад суурилсан сургалтанд 21 аймгийн соёл урлагын газрын мэргэжилтэн, номын сангийн албан хаагчид хамрагдсан.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, түүхэн баримт болон үлдэх онцлог зургуудыг ашиглан дурсамж мэдээллийн булантай болох ажлыг хийж гүйцэтгэлээ

10. ХАВСРАЛТ /ЗУРАГ, СХЕМ, ДИАГРАММ/

Уншлага үйлчилгээний схем 1

2022 оны Соёл олон нийтийн ажлын тоон үзүүлэлт

Д/д	Зохион явуулсан Соёл олон нийтийн ажил	Хамрагдсан оролцогчид		Зарцуулсан төсөв	Зохион байгуулсан огноо
		Бүртгэлтэй	Бүртгэлгүй		
1.	Өвлийн хөтөлбөр	61	17	30000	2022.01.04
2.	Тоглонгоо уншъя	53	126	30000	2022.01.09
3.	Монгол тууль- Дэлхийн өв	3			2022.02.07
4.	Дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөе	168	291	15000	2022.02.22
5.	Хооллох соёл- Ширээ засалт	15			2022.03.05
6.	Үлгэрээр хүмүүжье чанга уншлага		489		2022.03.10
7.	Дэлхийн хүүхдийн номын өдөр	3	27		2022.04.01

8	Бид эх орны хөвгүүд	22			2022.04.13
9.	Уншигчийн бага хурал	12	3		2022.04.29
10	Үндэсний бичиг үсгийн баяр	200	450		2022.05.17
11	Үндэсний бичиг үсэг номын баяр	150	251		2022.05.20
12	Номын хотхон	100	400		2022.06.01
13	Ном хож	10	26		2022.06.03
14	Оюунлаг бүтээлч ирээдүйн төлөө уриатай “Зуны хөтөлбөр”	56	86		2022.06-15-08.18
15	Эх хэлний өдөр	68	67		2022.09.01
16	Номын сантай танилцах аялал	58	135		2022.09.01-12.15
17	Хүүхдээ сонсоё аян	30	40		2022.09.10
18	Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2022 арга хэмжээ	150	251		2022.09.15
19	Зохиолч С.Молор- Эрдэнэ “Шинэ номын танилцуулга уулзалт	15	33		2022.10.24
20	Номыг шинжихүй	7	70		2022.10.27
21	Соёлын бүтээлч сар Үндэсний нэгдмэл үнэт зүйл	153	400		2022.10.03
22	Соёлын бүтээлч сар Бүх нийтийн соёлын боловсрол	26	170		2022.10.09
23	Соёлын бүтээлч сар Соёлын бүтээлч үйлдвэрлэл	10	33		2022.10.15
24	“Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн сурагч болцгооё” аян зохион байгуулах		6635		2022.11.05
25	Номын сангийн дэргэдэх номын клуб байгуулах	10	15		2022.11.10
26	Үлгэрч багачууд цахим уралдаан зохион байгуулах		15		2022.11.11
27	Номтой өглөө 30 минутын уншлага		198		2022.11.12
28.	Өглөөний уншлага	48	50		2022.11.13
29	“Зохист аялгуу-2022”	29	69		2022.11.16
30	Улирлын шилдэг уншигч шалгаруулах	4			2022.4,8,11, сарууд

31	Соёлын бүтээлч сар Соёлын аялал жуулчлал	153	224		2022.11.25
32	“Буудай ба Сарнай” Комик дүр		5		2022.12.10
	Нийт дүн	1614	10576		

2022 оны цахим уншлагыг дэмжих ажлын тоон үзүүлэлт

Д/д	Цахим мэдээлэл сурталчилгаа	Мэдээлэл хүрсэн иргэдийн тоо	Зарцуулсан төсөв төсөв	Зохион байгуулсан огноо
1.	Үндэсний сонгодог зохиол	3551		2022.01-11.30
2.	Дэлхийн сонгодог хүүхдийн зохиол	5783		2022.01-11.30
3.	Монголын нуут товчоо	4420		2022.01-11.30
4.	Монгол гэрийн үүсэл хөгжил	18		2022.01-11.30
5.	Заавал унших зохиолууд бага дунд ангийн	5746		2022.01-11.30
6.	Дэлхийн сонгодог зохиол	1936		2022.01-11.30
7.	Монгол ардын өв соёл уламжлал	2157		2022.01-11.30
8.	Шинэ номын мэдээлэл	1885		2022.01-11.30
9.	Нацагдорж тэмдэгтний болзолыг сурталчлан таниулах	10088		2022.01-11.30
	Нийт	35584		

Номын үзэсгэлэн

д/д	Номын нэр	Дэлгэгдсэн номын Тоо	Хамрагдсан хүүхдийн тоо
1.	Амьтдын ертөнц номын үзэсгэлэн	19	36
2.	Гэр бүлийн баяр хөөр үзэсгэлэн	26	57
3.	Шинэ номын үзэсгэлэн	350	820
4.	“Ардын хувьсгалын өлгий” номын үзэсгэлэн	17	92
5.	Өөрийгөө хөгжүүлэх номын үзэсгэлэн	35	76
6.	Х. Андерсен зохиолчийн номын үзэсгэлэн	36	66

7.	Ардын аман зохиолын номын үзэсгэлэн	20	85
8.	Эргэн дурсахуй номын үзэсгэлэн	27	81
9.	Хөвгүүдийн үлгэрийн номын үзэсгэлэн	18	90
10.	Лодойдамба зохиолчын зохиолын номын үзэсгэлэн	21	116
11	Цуврал номын үзэсгэлэн	46	174
12	Англи хүүхдийн номын үзэсгэлэн	59	205
13	Ялалтын баярын номын үзэсгэлэн	162	229
14	Дэлхийн сонгодог зохиолын номын үзэсгэлэн	141	265
15	Хууль эрх зүйн номын үзэсгэлэн	19	125
16	Хүүхэд залуусын заавал унших номын үзэсгэлэн	42	212
17	Өөрийгөө хөгжүүлэхүй номын үзэсгэлэн	52	216
18	Монгол бахархал номын үзэсгэлэн	26	188
19	Ховор номын үзэсгэлэн	23	226
20	Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан номын үзэсгэлэн	35	355
21	Түүхэн номын үзэсгэлэн	40	210
22	Хүүхдийн шинжлэх ухааны толь номын үзэсгэлэн	24	296
23	Үндэсний сонгодог зохиолууд номын үзэсгэлэн	54	245
24	Сэлэнгийн зохиолчдын номын үзэсгэлэн	26	455
25	Бүтээлчээр урлая номын үзэсгэлэн	25	177
26	Өглөөний уншлага номын үзэсгэлэн	589	318
27	Эрүүл амьдралын хөтөч номын үзэсгэлэн	21	219
28	Комик номын үзэсгэлэн	70	450
29	Өсвөр үе номын үзэсгэлэн	48	228
30	Монголын алтан үе номын үзэсгэлэн	46	221
	Нийт	2117	6533

БРЕНД
БҮТЭЭХ

БРЕНД
БҮТЭЭХ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.01

НЭГ: “КОВИД-19” БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЦАГ ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

1.1 Байгууллагын ажлын бодлого төлөвлөлт, уншигчдад үйлчлэх ажлыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх: Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан танхимын үйлчилгээг бүрэн дүүргэлттэйгээр зохион байгуулж, хэвийн ажиллаж байна. Танхимын үйлчилгээнээс гадна цахим хэрэгслийг ашиглан номын сангийн үйлчилгээг уншигчдад хүргэж, цахим орчинд 392 удаа мэдээлэл тавьж, 6409 хандалттай ажиллаж байна.

1.2 Цар тахлын халдвар, тархалтаас сэргийлэх бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх: Мандал сумын нийтийн номын сангийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 тоот “Ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг эрчимжүүлэх тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын ариутгал, халдваргүйтгэлийг хийхдээ Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлан гаргасан “Корона вирус (Covid-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа”-ны дагуу байгууллагын байр, орчны нийт 1278 м2 талбайд их цэвэрлэгээ, ариутгалыг 10 удаа хийж, байгууллагын байранд орсон хүмүүсийн бүртгэлийг хөтөлж, биеийн халууныг хянаж, гар ариутгагчаар гарыг ариутгаж, амны хаалттай оруулах, албан хаагчид амны хаалт, бээлийтэй ажиллах, хүн хоорондын зай авах, зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, албан хаагчдадаа 1 хүнд 5 хайрцаг буюу 300ш ногдохоор бодож нийт 600,000 төгрөгийн үнэ бүхий 3000 ширхэг амны хаалтыг албан хаагчдынхаа хэрэгцээнд олгож халдвараас хамгаалж байна.

Оны эхнээс 4 нэр төрлийн 28200 төгрөгийн бүтээгдэхүүнээр ариутгал, халдваргүйтгэлийн нөөцөө баяжуулж, одоо нийт 510,793 төгрөгийн 831 ш бүтээгдэхүүний нөөцтэй байна.

<u>Ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгслийн нөөц:</u>

№	Материал	Ширхэг	Боодол	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Зарцуулсан	Үлдэгдэл	Үнэ
1	Малгай /Нэг удаагийн/	4		450	1 800	1	3	1 350
2	Халаат /Нэг удаагийн/	1		4 000	4 000	1	0	0
3	Бээлий /Нэг удаагийн/	100	2	22 500	45 000	100	0	0
4	Халуун бууруулах эм	1		2 500	2 500	0	1	2 500
5	Духны халуун хэмжигч	1		80 000	80 000	0	1	80 000
6	Жавельсин	300		150	45 000	300	0	0
7	Электрон даралтны аппарат	1		90 000	90 000	0	1	90 000
8	Улавч /Нэг удаагийн/	25		120	3 000	0	25	3 000
9	Амны хаалт /Нэг удаагийн/	200	4	15 000	60 000	100	100	30 000
10	Комбинзон /Нэг удаагийн/	1		23 500	23 500	1	0	0
12	Шал угаах автомат хувин, алчуур	1		50 000	50 000	0	1	50 000
13	Гар ариутгагч / Санитол /	2		16 000	32 000	2	0	0
Нөөцийн баяжилт 2021.04.02								

14	Гар ариутгагч / Санитол /	2		16 000	32 000	2	0	0
15	Бээлий /Нэг удаагийн/	50	1	32 000	32 000	0	50	32 000
16	Ариун цэврийн цаас	42	1	25 000	25 000	42	0	0
	Нөөцийн баяжилт 2021.04.30 "Шуурхай штаб"-аас							
17	Гар ариутгагч / Санитол /	10		5 000	50 000	10	0	0
18	Ариун цэврийн цаас	12		600	7 200	12	0	0
	Нөөцийн баяжилт 2021.05.21 "Шуурхай штаб"-аас							
19	Гар ариутгагч / Санитол /	20		5 000	100 000	18	2	10 000
20	Жавельсин	300	1	32 000	32 000	0	300	32 000
21	Бээлий /Нэг удаагийн/	50	1	16 000	16 000	20	30	9 600
	Нөөцийн баяжилт 2021.05.27							
22	Амны хаалт /Нэг удаагийн/	250	5	100	25 000	0	250	25 000
23	KF-94 амны хаалт	50	10	800	40 000	0	50	40 000
	Нөөцийн баяжилт 2021.09.06							
24	Ариун цэврийн цаас	42	1	25 000	25 000	30	12	7 143
	Мананцарын буу	1		70 000	70 000		1	70 000
	Санитол	1		23500	23500		1	23500
	Парацетамол	2		400	800		2	800
	Ибуденк	1		3900	3900		1	3900
	НИЙТ	**1 470**			**919 200**	**639**	**831**	**510 793**

1.3 Цар тахлын халдвараас сэргийлэх олон нийтийн эргүүл, жижүүр, урьдчилан сэргийлэх болон бусад ажилд оролцох: Сумын нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасагт байрлаж буй "Халдвар тархварын багийн судалгаа"-ны ажилд тусалж 2022 оны 1-р сарын 15--ны өдрөөс 2-р сарын 11-ний өдрийг хүртэл өдөр бүр 2 номын санчийг ээлжээр томилж ажиллууллаа.

Мөн хүйтний улирал эхэлж ханиад томуу, томуу төст өвчин, короновирусын тархалт ихдэж байгаатай холбогдуулан Сэлэнгэ аймаг Соёл, урлагийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 18 өдрийн 104 дүгээр албан тоотын хэрэгжилтийг хангаж, халдвар хамгааллын дэглэмийг баримталж, бага насны хүүхдүүдэд, тогтоосон цагийн хязгаараар үйлчилж байна.

Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:

ХОЁР: ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НОМЫН САНГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

2.1 Монгол улсын төрийн бодлого, чиглэлийн хүрээнд номын сангийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжилтийг хангах: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, Монгол улсын Засгийн газар болон Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүд, Аймаг, сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг төрийн бодлого, чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор тухайн бодлого, хөтөлбөрүүдэд номын сан, соёлын талаар тусгасан заалтуудын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг байгууллагын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Мөн байгууллагыг 2021-2025 онд хөгжүүлэх Стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.

2.2 Соёл, урлагийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн “Цахим соёл, “Бүх нийтийн соёлын боловсрол”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” үндэсний хөтөлбөрүүд, “Номын сайн нөхөр” сумын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах:

“Цахим соёл”, “Бүх нийтийн боловсрол”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр, “Соёлын баримтат өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөр, “Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, БСШУЯ-ны “Номын сан, соёлын салбарын талаар төрөөс баримтлах бодлого” хөтөлбөр, “Соёл, урлаг хүний хөгжилд” аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах, монголын уламжлалт бичиг соёлын өвийг хадгалан үлдээх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах, иргэд, хүүхэд, залуусыг номтой нөхөрлүүлэх зорилгоор Сумын ИТХ-ын 2017.10.09-ний өдрийн 107 тоот тогтоолоор “Номын сайн нөхөр” хөтөлбөр батлуулан 2018, 2019, 2020, 2021, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж, тус хөтөлбөрийн биелэлт 87 %-тай байна.

“Цахим соёл”, “Бүх нийтийн боловсрол”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл II” зэрэг үндэсний зорилтод арга хэмжээнүүдийн холбогдох заалтуудыг байгууллагын бодлого төлөвлөлтөнд тусган хэрэгжилтийг хангаж байна.

Иргэдэд үйлчлэх номын сангийн үйлчилгээний нөр төрлийг нэмэгдүүлэх, уншигчдад хүрч үйлчлэх, номоор дамжуулан иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор цахим хэрэгслийг ашиглан 392 удаа цахим мэдээлэл оруулж, 6409 удаагийн хандалттай ажиллаж, үндэсний болон танин мэдэхүйн сэдэвт соёл, олон нийтийн ажлуудыг 18

удаа зохион байгуулж, нийт 1736 хүнийг хамрууллаа. Мөн албан хаагчдыг мэдлэгийг нэмэгдүүлж, чадваржуулах сургалтад хамруулж албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж байна.

2.3 Аймгийн "Бүтээн байгуулалт-нийгмийн хөгжлийг дэмжих *жил*" зарласан жилийн хэрэгжилтийг хангах: Аймгийн "Бүтээн байгуулалт-нийгмийн хөгжлийг дэмжих *жил*" зарласан жилийн хэрэгжилтийг хангах зорилгоор 6 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. “Эртэч уулзалт” арга хэмжээг уламжлал болгон байгууллагын хэмжээнд 4 удаа, “Ёс зүйн сарын аян”-ыг 1 удаа тус бүр зохион байгуулж, хувь хүний хөгжлийг дэмжих сургалтад 2 удаа албан хаагчдыг хамруулж, “Ажлын байраа тохижуулья” бүтээлч ажлын хүрээнд байгууллагын урсгал засвар, тохижилтын ажлыг хийж, төв, орон нутгийн сургалт, мэдээлэлд албан хаагчдыг тогтмол хамруулан, ур чадварыг нь нэмэгдүүлж байна.

2.4 Номын сангийн олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах: Мандал сумын зохиолч, уран бүтээлчдийн “ХАРААГИЙН УЯНГА” зохиолч, уран бүтээлчдийн нэгдэлтэй хамтран ажиллаж, 2 Соёл олон нийтийн ажлыг хамтран зохион байгууллаа. Орон нутгийн яруу найрагч С.Мөнхцэцэгийг “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдэг болон “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, зохиолч, яруу найрагч Б.Наранцэцэгийг “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр тус бүр тодорхойлон шагнуулж, хөдөлмөр бүтээлийг нь үнэлүүллээ. Мөн шефийн холбоотой хамтран ажилладаг 1 байгууллагын 2 албан хаагчийг “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр тодорхойлон шагнууллаа. Ийнхүү тухайн жилд хамтран ажилладаг 4 хүнийг яамны шагналаар шагнуулж, хөдөлмөр, бүтээлийг нь үнэлүүлсэн амжилттай ажиллаж байна.

ХҮҮХДИЙН ДРАМЫН "ХҮННҮ" ДУГУЙЛАН: Хүүхдийн амралт, чөлөөт цагийг бүтээлч хэлбэрээр зохион байгуулах, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хүүхдийн хөгжил, хүмүүжил, гоо зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий хүүхдийн драмын "Хүннү" дугуйланг бэлтгэлийн байр, хэрэгцээт ном зохиолоор хангаж, туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байна. Тус дугуйлангийн хүүхдүүдийн уран бүтээл Д.Содномдоржийн "Аз жаргалын эрэлчин" жүжгийг тайзнаа тавихад бэлэн боллоо. Энэхүү дугуйланд 4-р сургуулийн 7-а, б анги 21 хүүхэд хамрагдаж байна.

ГУРАВ: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭХ, ЧАДАВХЖУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

3.1 “Хүний хөгжлийн бодлого”, “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2022-2024” богино хугацааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангаж, номын санчийн мэргэжил эзэмших сургалтад 1 удаа, 1 номын санч, төв, орон нутгийн сургалтад 13 удаа, 22 албан хаагч, ажлын байрны сургалтад 6 удаа, 41 албан хаагч нийт 19 удаагийн сургалтад давхардсан тоогоор 65 албан хаагчийг хамруулсан нь албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, тайлант оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжиж буй үр дүнтэй байна.

№	Сургалтын нэр	Хэзээ	Хүний тоо	Хаанаас зохион байгуулсан
	Нэг. Мэргэжил эзэмших сургалт			
1	СУИС-ын “Номын сан судал”-ын бакалаврын эчнээ анги	2022 он	1	СУИС
	Хоёр. Төв, орон нутгийн богино хугацааны сургалт			

1	“21 аймаг, сумдын удирдах болон ахлах ажилтны давтан сургалт”	2022.02.22	1	Авлигатай тэмцэх газар
2	“Нийтийн номын сангийн тайлан нэгтгэл, арга зүйчдээс авах санал асуулга, номын сангийн өдөр тутмын бүртгэл, цахим сан хөмрөг, уншигчдын судалгаа, аймгийн нийтийн номын сангийн тоног төхөөрөмж”	2022.02.24	1	Үндэсний номын сан Т.Хайдав
3	“Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж байгаа тодорхой асуудал”	2022.03.01	1	
4	“Цахим сан хөмрөгийн тухай ойлголт”	2022.03.03	1	Үндэсний номын сан
5	“Цахим сан хөмрөг бүрдүүлэх бодлого”	2022.03.04	1	Үндэсний номын сан
6	“Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”	2022.03.10	1	Дэлхийн зөн, Хүүхдийн ордон
7	“Гүйцэтгэлийн төлөвлөгөө бичих аргачлал”	2022.03.30	1	Аймгийн Нийтийн номын сан
8	Австралийн болон Үндэсний номын санд хэрэглэгдэж буй үйлчлүүлэгч төвтэй шилдэг туршлага	2022.04.05	2	Үндэсний номын сан
9	“Оюуны өмчийн сургалт”	2022.05.04	1	Оюуны өмчийн газар
10	“Төрийн тахилгат Ноён уулын түүх, соёл” сэдэвт эрдэм, шинжилгээний бага хурал	2022.05.14	1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
11	Төрийн албан хаагчийн ёс зүй	2022.10.10	9	Төрийн албаны зөвлөл
12	“Монгол хэл бичгийн хөтөлбөр III”	2022.10.27	1	Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газар
13	Архивын систем нэвтрүүлэх сургалт	2022.11.18	1	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар
	Гурав. Ажлын байрны сургалт			
1	“Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”	2022.03.23	8	Нийтийн номын сан
2	“Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”	2022.03.23	8	Нийтийн номын сан
3	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт”	2022.05.12	9	Сумын “ХАБЭА-н зөвлөл”-ийн гишүүн С.Наранханд
4	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга зам	2022.10.12	1	Номын санч Г.Орхон
5	“Хос бичигтэн болцгооё” уйгуржин бичгийн давтан сургалт	2022.12.01	8	Нийтийн номын сан
6	“Улаан загалмайн нийгэмлэгийн тухай”	2022.11.02	7	Нийтийн номын сан
19	**НИЙТ**		**65**	

3.2 “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хүрээнд “Хос бичигтэн болцгооё” уйгуржин бичгийн давтан сургалтыг зохион байгуулж, албан хаагчдаа хамруулах: Албан хаагчдыг “Хос бичигтэн болцгооё” уйгуржин монгол бичгийн 7 хоногийн давтан сургалтад бүрэн хамруулж, мэдлэгийг бататгаж, Зүүнхараа Политехник коллежийн монгол хэл, уран зохиолын багш Х.Бямбасүрэн багшаар хичээл заалгаж байна.

ДӨРӨВ: НОМЫН ФОНДЫГ БАЯЖУУЛЖ, НОМ ХЭВЛЭЛИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, КАТАЛОГЖУУЛАЛТЫН АЖЛЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

Номын фондын баяжилтыг нэмэгдүүлэх: Номын фондын нөөцийг үндэсний болон дэлхийн сонгодог зохиолын номоор нэмэгдүүлэн баяжуулах зорилгоор төсвийн санхүүжилтээр 212 нэр төрлийн 214ш 4831,000 төгрөгийн ном, соёлын яамны санхүүжилтээр 344 нэр төрлийн 344ш 4749,200 төгрөгийн ном, хандиваар 31 нэр төрлийн 32ш 189,788 төгрөгийн ном, номын төлбөрт 27 нэр төрлийн 27ш 556,568 төгрөгийн ном нийт 614 нэр төрлийн 630ш 10334,356 төгрөгийн номоор шинэ номын баяжилтыг хийж, өмнөх оны мөн үеийнхээс фондын номын нийт тоо 2,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

№	Төрөл	Ямар журмаар авсан	Хаанаас	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ
1		Хандив	Н.Байгал	15	16	140,488
2			Чинбатын Ундрам хөгжлийн сан /Хандив/	7	7	6,000
3	Ном		Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан	9	9	43,300
4			**Нийт**	**31**	**32**	**189,788**
5		Номын төлбөрт	Д.Учралсайхан	15	15	338,978
6			Н.Даваасүрэн	2	2	34,800
7			Ч.Даваасүрэн	10	10	182,790
			Нийт	**27**	**27**	**556,568**
8		Худалдаж авсан	Аз хур	156	158	3508,000
9			Интерном	56	56	1323,000
			Нийт	**212**	**214**	**4831,000**
			Аз хур	293	293	3459,000
			Интерном	43	43	1110,200
10			Хэвлэлийн хүрээлэн	8	8	180,000
			Нийт	**344**	**344**	**4749,200**
ЗАРДЛЫН НЭГДСЭН ЗАДАРГАА						
	Төсвийн санхүүжилтээр			208	210	4808,000
	Соёлын яамны санхүүжилтээр			344	344	4750,000
	Хандиваар			31	32	189,788
	Номын төлбөрт			27	27	556,568
10	**НИЙТ**			**614**	**630**	**10334,356**

Нийтийн номын сангийн фондын нийт номын дүн:

Он	2020 он	2021 он	2022	Үзүүлэлт
Номын тоо	28270	28524	29137	2,1%

4.2 Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ариутгал, цэвэрлэгээ, сэлбэн засалт хийх: Корона вирус (Covid-19)-ын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ном хэвлэлийг уншлагад гаргах, авахдаа ариутгалын уусмалаар тухай бүр тогтмол ариутгаж, фондод 15 удаа ариутгал, халдваргүйтгэл хийсэн нь тайлант оны төлөвлөгөө 50 хувиар, ашиглалтын явцад элэгдэж, гэмтсэн нийт 329 ш номд сэлбэн засалт 65,8 хувиар биелэгдсэн дүнтэй байна. Фондод шинээр бүрүүлсэн 652ш номд техник ажиллагаа хийлээ.

Ном сэлбэн засалт, техник ажиллагааны тоон мэдээ:

	Номын сэлбэн засалт	Техник ажиллагаа
Нийт	**329**	**652**

4.1 Ном, хэвлэлийн анхан шатны данс бүртгэлүүд, номын тооллого тооцоо, цаасан каталогийн зохион байгуулалтыг сайжруулах: Байгууллагын сан хөмрөгт хадгалагдаж буй нийт номын данс бүртгэлд хяналт шалгалт хийж, дутагдсан номыг төлүүлэх, тооллогын бүртгэлийг алдаа мадаггүй, бүрэн гаргах зорилгоор 2022 онд бүртгэл, тооллогын ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд эцсийн дүн хараахан гарч дуусаагүй байна. Тухайн тооллогын ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:

-Уншигчдын гар дээр уншлагад гарсан, зөөврийн номын үйлчилгээнээс тооцогдож ирээгүй, дутсан шалтгаан тодорхойгүй зэрэг 400 гаруй номын тооцоог барагдуулж, ном нэг бүрийг фондод эргүүлэн татах, дутагдсан номыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 415 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт болох “Алдагдсан болон гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэх журам”-ыг баримтлан төлүүлэхээр гаргасан Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/15 дугаар тоот тушаалын дагуу хугацаа хэтэрсэн номыг төлж, барагдуулах ажлыг 2022 оны 04 сарын 12-ны өдрөөс 15-ны өдрийг хүртэл 4 хоногийн хугацаанд 349ш номыг буцаан авахаар 123 уншигчидтай холбогдож, гэрээр болон аж ахуйн нэгж байгууллагуудаар явж 192ш номын тооцоог бүрэн дуусгалаа.

-Тодорхой шалтгааны улмаас Нийтийн уншлагын танхимын ойрын фондын номонд 2 удаа, Хүүхдийн уншлагын танхимын ойрын фондын номонд 3 удаа тус бүр “Номын тооллогын ажлын комисс”-ыг томилон номыг тоолж, дутагдсан номыг акт үйлдэн, эргүүлэн төлүүлэх ажлыг тухай бүр хийж байна.

-Байгууллагын Захирлын 2022 оны 06-р сарын 06-ны өдрийн А/64 тоот тушаалаар номын санч Г.Одгэрэлд Үндсэн фондын номыг 2022 оны 06-р сарын 10-ны өдрөөс 2022 оны 08-р сарын 26-ны өдрүүдэд хүлээлгэн өгч дууслаа. Үндсэн фондод 23528 (хорин гурван мянга таван зуун хорин найман) ширхэг ном бүртгэлтэй байна.Тооллогын явцад урагдаж, элэгдсэн 57 номыг **тухай бүр нь засаж сэлбэн, актлах шаардлагатай 132 номын жагсаалт гаргаж,** Монбиблио програмтай тулган тооллогын цонхонд бүртгэж тооллоо. **Үндсэн**

фондын номын нэг бүрчилсэн бүртгэлийн 200 хуудастай дэврийг хэвлэж бэлтгэлээ.

Тооллогын тоон мэдээ.

д/д	Нийт тоолсон ном	Програмтай тулгах явцад гарсан алдаа			Монгол номын бүртгэлтэй	Орос номын бүртгэлтэй
		Мэдээлэл дутуу	Огт байсан	бүртгэгдээгүй		
1	23528	637	91		**21796**	**1732**

-Дутсан номыг нягтлан шалгах, цахим програмтай тулгаж, алдааг засварлах хяналт шалгалтын ажил үргэлжилж байна.

-Үндсэн фондод орсон, гарсан хүмүүсийн бүртгэлийг тухай бүр хөтөлж ном алдагдахаас сэргийлж байна.

-Шинээр авсан 59 ш номыг Monbiblio программын цахим бүртгэлд бүрэн бүртгэлээ.

ТАВ: ИРГЭДЭД НҮҮДЛИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

5.1 Нүүдлийн номын сангийн үйлчилгээний уншигч, ном олголтыг нэмэгдүүлэх:



Сумын төвөөс алслагдсан иргэд, малчид болон байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын байранд хүргэх номын сангийн үйлчилгээг сайжруулах зорилгоор жил бүр нүүдлийн болон зөөврийн номын сангийн үйлчилгээг зохион байгуулж байна. Тус онд алслагдсан Гурван салааны малчин иргэд, ШШГА-ны 413-р ангийн хаалттай бүлгийн иргэдэд нүүдлийн үйлчилгээгээр, Мишээл цэцэрлэг, Шунхлай ШТС, Сод монгол, сумын ЗДТГ, Сэлэнгэ аймгийн СУГ, ЕБ-ын 1-р сургууль зэрэг 8 байрлал чиглэлд, 7 байгууллага болон малчин иргэдэд үйлчилж, нийт 82 уншигчид шинээр уншигчийн карт нээж, 449 ирэгсэд, 552 ш ном олгож нэгдсэн дүн мэдээ өмнөх оны мөн үеийнхээс шинэ уншигч 44 хувиар, ирэгсэд 49 хувиар, ном олголт 1,2 хувиар тус тус буурсан дүнтэй байна. Энэ нь 2020 он, 2021 оны цар тахлын жилүүдэд гэрээр, зөөврөөр ном олгох бодлогыг түлхүү баримталж, 2022 оноос цар тахал намжиж, танхимын үйл ажиллагаа хэвийн эхэлсэнтэй холбоотой юм. Тухайн оны төлөвлөгөөний биелэлт шинэ уншигч 82 хувиар, ирэгсэд 89,8 хувиар, ном олголт 51,5 хувиар тус тус хэрэгжсэн дүнтэй байна. Тус үйлчилгээгээр уншигчдын дунд “Чанга уншлага”, “Ном унших ын ач холбогдол сургалт”, “Уги йн бичиг хөтлөхийн ач холбогдол” мэдээлэл, “Ховор номын үзэсгэлэн”, “Шинэ номын үзэсгэлэн”, “Номын солилцоо”, “АХА” тэмцээн”, “Зөвлөгөө-аргазүй”-н ажлыг тус бүр зохион байгууллаа.

Сүүлийн гурван жилийн нэгтгэлийн харьцуулалт:

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	Хувь
Ирэгсэд	777	803	449	-44%
Ном олголт	1 135	1072	552	-49%
Шинэ уншигч	280	83	82	-1,2%

5.1.1 Сумын төвөөс алслагдсан багийн иргэд, малчид, хаалттай бүлгийн иргэдэд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэх:

Алслагдсан багийн иргэдэд үйлчлэх нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр Гурван салааны малчин иргэд, ШШГА-ны 413-р ангийн хаалттай бүлгийн иргэдэд үйлчилж, шинэ уншигч 14 хүнд карт нээж, 53 ирэгсдэд 85 ш номоор үйлчилж, Гурван салааны зуслангийн хүүхдүүдэд зориулан 70 ш номоор үзэсгэлэн гаргаж, "Хайр", "Хүндлэл", "Хариуцлага", "Зөгийчин Жозеф" номуудаас чанга уншлага хийж, ажилч хичээнгүй байх нь ямар сайн зүйлд хүргэж болдгийн тод жишээг хүүхдүүдтэй харилцан ярилцлаа.

Нүүдлийн үйлчилгээний тоон мэдээ-2022 он:

д/д	Чиглэл	Шинэ уншигч	Ирэгсэд	Ном олголт	Номын үзэсгэлэнгийн номын тоо
1	ШШГ 413-р анги	6	22	30	39
2	Гурван салаа	8	31	55	70
	НИЙТ	**14**	**53**	**85**	**109**

5.1.2 Байгууллага, аж ахуйн нэгжид зөөврийн номын үйлчилгээг хүргэх:

Номын зөөврийн үйлчилгээгээр 6 байгууллагад үйлчилж, 68 шинэ уншигч, уншигч байгууллага "МИШЭЭЛ" IY цэцэрлэг нь ном уншлагын аяны "ОЮУНЛАГ БАЙГУУЛЛАГА"-аар шалгарсан амжилттай ажиллаж байна.

Зөөврийн үйлчилгээнд хамрагдсан байгууллагын тоон мэдээ:

д/д	Байгууллагын нэрс	Шинэ уншигч	Ирэгсэд	Ном олголт	Номын үзэсгэлэнгийн номын тоо
1	"Мишээл" IY цэцэрлэг	3	18	30	41
2	Шунхлай ШТС	2	10	15	11
3	Сод Монгол	1	5	10	13
4	ЗДТГ	13	75	80	87
5	Сэлэнгэ аймаг СУГазар		170	180	33
6	ЕБ-ын 1-р сургууль	49	118	122	58
	НИЙТ	**68**	**396**	**437**	**243**

5.2 "Байгалийн номын сан" ажиллуулах: Хүүхдүүдийн уншлагын орчныг сонирхолтой хэлбэрээр зохион байгуулах, номтой нөхөрлүүлэх зорилгоор "Байгалийн номын сан" сэдэвт байгалийн уншлагыг зохион байгуулж байна. Эхний удаагийн уншлагад 4-р сургуулийн 4г анги, 3-р сургуулийн 4в анги, 5б ангийн нийт 16 хүүхэд оролцон явган аялал хийж, байгальд алхаж, хамтдаа номоо уншиж нэг өдрийг зугаатай, үр дүнтэй өнгөрөөлөө.

ЗУРГАА: ИРГЭДИЙГ НОМТОЙ НӨХӨРЛҮҮЛЭХ СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН АЖИЛ, НОМЫН СУРТАЛЧИЛГАА, ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН АЖЛУУДЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

6.1 Соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах: Иргэдэд номын сангийн үйлчилгээг сурталчлах, номтой нөхөрлүүлэх, мэдлэгийг нь нэмэгдүүлэх зорилгоор соёл, олон нийтийн ажлуудыг 18 удаа зохион байгуулж, 1736 хүнийг хамруулаад байгаа нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт зохион байгуулсан арга хэмжээний тоо 105,8 хувиар, хамруулсан хүний тоо 289 хувиар хэрэгжиж, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулсан дүнгээр зохион байгуулсан арга хэмжээний тоо 5,8 хувиар, хамруулсан хүний тоо 200 хувиар өссөн дүнтэй байна. Өмнө нь Нийтийн номын сангуудад соёл, олон нийтийн ажил зохион байгуулах зардал төсөвт огт тусгагддаггүй байсан тул бид өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан ивээн тэтгэгчдээс жил ойролцоогоор 5 сая хүртэлх төгрөгийн санхүүжилтийг авч ажилладаг байсан. Харин 2022 онд тус зардалд зориулан Соёлын яамнаас 10,000,000 төгрөгийн зардлыг төсөвт суулгаж өгсөн нь уншигчдыг урамшуулах, иргэдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх, мэдлэг олгох ажлуудыг зохион байгуулахад маш том дэмжлэг болсон. Үүний зэрэгцээ ивээн тэтгэгчдээс 1278,000 төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн. Ингээд тус тайлант онд нийт 11278,000 төгрөгийн задлаар соёл олон нийтийн ажлуудыг зохион байгууллаа.



	СОНА-ын тоо ширхэг	Хамрагдсан хүний тоо	СОНА-ын нэр төрөл
2020 он	15	1640	15
2021 он	17	578	17
2022 он	18	1736	18
үзүүлэлт	5.80%	200.00%	5.80%

<u>Соёл олон нийтийн ажлын сүүлийн гурван жилийн харьцуулалт:</u>

Соёл, олон нийтийн ажлын жагсаалт, тоон мэдээ:

№	Нэрс	Хугацаа	Байгууллага	Оролцогчдын тоо
1	“Номын сан-4 улиралд” ном уншлагын хөтөлбөр	2022.01.10-2022.12.01		113
2	“Ноён уул-Нутгийн брэнд” ном, бүтээлийн үзэсгэлэн, өдөрлөг	2022.05.14		65
3	Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан “Монгол бахархал” уран бичлэгийн үзэсгэлэн, лекц зохион байгуулах	2022.05.16-2022.05.25	16	170
4	“Үгийн бичгээ хөтөлж-ураг удмаа мэдэцгээе” сургалт, өдөрлөгийг зохион байгуулах.	2022.10.10-2022.11.15	7	268
5	“Бүх нийтийн уншлагын өдөр” зохион байгуулах тухай	2022.10.15-2022.11.15	2	169
6	“Хараагийн аялгуу-9” хүүхдийн яруу найргийн наадам	2022.02.08-2022.03.10		30
7	“Оюунлаг-бүтээлч гэр бүл” ном соёлоо дээдлэн гэрийн номын санг бүтээлчээр бий болгосон шилдэг гэр бүлийг шалгаруулах уралдаан	2022.05.11-2022.05.22		5
8	“Мөрөөдлийн ном” хаалттай болон зорилтот бүлгийн иргэдийг номтой нөхөрлүүлэх 1 сарын аяныг зохион байгуулах	2022.10.14		**10**
9	“Монгол соёл-Монголын дархлаа” илтгэлийн уралдаан	2022.10.20-2022.10.28		27
10	“Гэр бүл-хамт олноороо уншицгаая” ном уншлагын 1 сарын аян	2022.03.01-2022.04.01		189
11	Цахим орчинд соёл түгээх “Хайр түгээе” захидлын цахим уралдааныг зохион байгуулах	2022.01.20-2022-03.05		26
12	Монгол хэлний их тайлбар толийг уншигчдад сурталчлах “Эх хэлээ хэн сайн мэдэх вэ” үгийн тайлбарын уралдаан	2022.03.31-2022.04.01		49
13	“Ахмад уншигчдын уулзалт өдөрлөг, явган аялал”	2022.11.25		10
14	“Би уншиж ойлгосноо ярьж чадна” ном уншлагын уралдааныг зохион байгуулах	2022.11.15-2022.11.30		20
15	“Дэлгэцийн донтолтоос сэргийлж- Номоо уншиж, найзуудтайгаа дуртай зүйлсээ хийцгээе” найзуудын уншлага	2022.03.22-2022.05.19		330
16	“Өвөрмөц нэгэн захидал” бэлэгтэй уншлага	2022.10.13-2022.11.25		**2**
17	Хүүхдийн баярын арга хэмжээ	2022.06.01		109
18	Миний мэргэжил-Номын санч” мэргэжил сурталчлах өдөрлөг	2022.11.13-2022.11.25		144
	Нийт 18 арга хэмжээнд 25 байгууллага 1736 хүн оролцсон байна.		**25**	**1736**

6.1.1 ‘’НОМЫН САН-4 УЛИРАЛД” ХӨТӨЛБӨРИЙН
‘’АНХНЫ ЯРГУЙ – ШИДЭТ НОМ‘’ номын тэмдэглэл
хөтөлж сурах хаврын хөтөлбөр

Хүүхдийг номтой нөхөрлүүлж, бие даан мэдлэг, боловсролоо нэмэгдүүлэн, багаар ажиллаж, бүтээлчээр унших арга арга барилд сургах, ирээдүйн уншигч, оюунлаг иргэнийг төлөвшүүлэх зорилго бүхий жилийн туршид үргэлжилсэн “НОМЫН САН-4 УЛИРАЛД” ном уншлагын хөтөлбөр амжилттай хэрэгжиж, 113 хүүхдийг хамруулж доорх 4 үе шаттай зохион байгуулж, соёл олон нийтийн ажлын зардлаас 2155,500 төгрөг, ивээн тэтгэгчийн хандив 50,000 төгрөгийг зарцуулж, идэвхтэй оролцогч 40 хүүхдийг нийт 160ш 1040,000 төгрөгийн үнэ бүхий шинэ номын багц номоор шагнаж урамшууллаа. Үүнд:

1.Хаврын номын сан: “Анхны яргуй-Шидэт” номын тэмдэглэл хөтөлж сурах
2.Зуны номын сан: “Зуслангийн найзууд-Зугаатай ном” уншсан номын сэдвээрээ бүтээл хийж сурах
3.Намрын номын сан: “Алтан навчис-Амтат ном” уншсан номоороо бяцхан ном бүтээж сурах
4.Өвлийн номын сан: “Мөсөн аялал-Цасан ном” Гэрийн бяцхан номын санг бүтээлчээр бий болгож сурах “Номын сан-4 улиралд” ном уншлагын хөтөлбөр гэсэн 4 үе шаттай зохион байгууллаа.

<u>Хаврын номын сан: “Анхны яргуй-Шидэт” номын тэмдэглэл хөтөлж сурах хөтөлбөр:</u> Хүүхдүүдийн номтой нөхөрлөх сонирхлыг нэмэгдүүлэх, тэргүүний уншигчдыг урамшуулах, номыг зөв унших арга барилд сургах зорилгоор зохион байгуулж буй ‘’Номын сан-4 улиралд” сэдэвт хөтөлбөрийн V-VII ангийн сурагчдын дунд зохион байгуулсан ‘’АНХНЫ ЯРГУЙ – ШИДЭТ НОМ‘’ номын тэмдэглэл хөтөлж сурах хаврын хөтөлбөрт 11 сурагч оролцож, номын тэмдэглэл хөтлөхөд суралцан, найз нөхдөдөө зааж сургах арга барил эзэмшлээ. Идэвхтэй оролцсон тэргүүний сурагчдаа урамшуулан 5 сурагчийг ивээн тэтгэгчийн зардлаар Өргөмжлөл, 50,000 төгрөгийн мөнгөн шагналаар, 5 сурагчийг соёл олон нийтийн ажлын зардлаас шинэ номын багц номоор урамшууллаа.

<u>Зуны номын сан: “Зуслангийн найзууд-Зугаатай ном” уншсан номын сэдвээрээ бүтээл хийж сурах хөтөлбөр:</u> Сурагчдын зуны амралтыг зугаатай өнгөрүүлэх зорилгоор сумын хэмжээний ЕБС-ийн 5-6-р ангийн сурагчдын дунд “Зуслангийн найзууд-Зугаатай ном” уншсан номоороо бүтээл хийх уралдаан зохион явууллаа. Уралдаанд нийт 32 сурагч оролцож, нэг өдрийг Хараа голын эрэг дээр зугаатай өнгөрүүллээ. Идэвхтэй оролцсон сурагчдаа урамшуулан 10 сурагчийг багц номоор урамшууллаа.

<u>Намрын номын сан: “Алтан навчис-Амтат ном” уншсан номоороо бяцхан ном бүтээж сурах хөтөлбөр:</u> Хүүхдийн сэтгэн бодох, бүтээл хийх санаачлагыг дэмжих зорилгоор “Алтан навчис-Амтат ном” уншсан номоороо бяцхан ном бүтээж сурах уралдааныг зохион байгууллаа.

Уралдаан 41 хүүхэд бүтээлээ ирүүлснээс идэвхтэй оролцсон 10 сурагчийг багц номоор урамшууллаа.

Зуны амралтаар хүүхдүүд мэдсэн сурсан зүйлээрээ намрын байгалийн навчисыг ашиглан бяцхан ном хийсэн нь олны хүртээл болохоор бүтээл болсон байлаа.

<u>Өвлийн номын сан: “Мөсөн аялал-Цасан ном” Гэрийн бяцхан номын санг бүтээлчээр бий болгож сурах “Номын сан-4 улиралд” ном уншлагын хөтөлбөр:</u> Өөрийн уншсан номоор гэрийн бяцхан номын санг бүтээлчээр бий болгож сургах зорилгоор “Мөсөн аялал-Цасан ном” гэрийн бяцхан номын санг бүтээлчээр бий болгож сурах хөтөлбөрийг зохион байгууллаа.

Уралдаанд нийт 29 сурагч оролцсоноос идэвхтэй оролцсон 10 сурагчийг шалгаруулж, багц номоор урамшуулав.

Хүүхдийг номтой нөхөрлүүлж, бие даан мэдлэг, боловсролоо нэмэгдүүлэн, багаар ажиллаж, бүтээлчээр сурах, унших арга барилд сурч, цаашид анги хамт олон, найз нөхөд, гэр бүлдээ мэдээлэл түгээх, зааж сурах чадвар суулгасан ач холбогдолтой ажил боллоо.

6.1.2 “НОЁН УУЛ-НУТГИЙН БРЭНД” НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Төрийн тахилгат Ноён уулын түүх, соёл” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2022.05.14-ний өдөр зохион байгуулагдахад, Мандал сумын Нийтийн номын сангаас Ноён уул, аймаг, орон нутгийн холбогдолтой түүх, судалгааны ном, Ховор ном, Ноён уулаас олдсон Хүнну гүрний түүх, соёлын олдворын фото зургаар тус бүр танилцуулга, үзэсгэлэн бэлтгэн оролцож, нутгийн брэнд Ноён уулаа сурталчлан ажиллалаа.

Хуралд Монгол Улсын түүхийн шинжлэх ухааны эрдэмтэн докторууд, Ерөнхийлөгчийн зөвлөх доктор, профессор Д.Бум-Очир, УИХ-ын гишүүн Ч.Ундрам, аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа, аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж болон сумын удирдлагууд, иргэдийн төлөөлөл нийлсэн 65 хүн оролцсон бөгөөд үзэсгэлэнг үзэж танилцлаа.

6.1.3 “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ “МОНГОЛ БАХАРХАЛ-2022” УРАН БИЧЛЭГИЙН УРАЛДААН, ҮЗЭСГЭЛЭН, ЛЕКЦ

“Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор “Монгол бахархал-2022” уран бичлэгийн уралдаан, үзэсгэлэн, лекцийг 2022.05.16-2022.05.25-ны өдөр зохион байгуулж, зөвлөхөөр Монгол улсын соёлын элч, төлөөлөгч, “Титэм-Арт” академийн тэргүүн, Урлаг судлалын докторант, дэд профессор, “Аригун каллиграф”-ийн Уран бичээч, Каллиграфер, МУСТА, багш Э.Ариунболд удирдан чиглүүлж, ажиллаж, нийт 16 байгууллагын гаруй албан хаагч болон иргэдийг хамруулж, зохион байгуулалт, шагнал, урамшуулал, зөвлөх багшийн зардалд зориулан соёл олон нийтийн ажлын

зардлаас 1900,000 төгрөг, ивээн тэтгэгчийн хандив 500,000 төгрөг, нийт 2600,000 төгрөгийг зарцуууллаа. Тус ажлын хүрээнд:

1.”Монгол бахархал” уйгуржин монгол бичгийн уран бичлэгийн уралдаан

2.“Үндэсний уйгуржин бичгийн хэрэглээ, ач холбогдол” олон нийтийн лекцийг зохион байгуулж, шилдэг оролцогчдыг шалгаруулан, урамшууллаа. Үүнд:

-“ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛОО ДЭЭДЛЭГЧ БАЙГУУЛЛАГА” шагналаар:

I байр: "Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ-Зүүнхараа салбар"

II байр: “Цант-Орхон” ОНӨААТҮГ

III байр: ЕБ-ын I сургууль

-“ШИЛДЭГ УРАН БИЧИГТЭН” шагналаар:

I байр: Д.Ариунсэлэнгэ ЕБ-ын IV сургуулийн багш

II байр: Н.Дөлгөөн ЕБ-ын I сургуулийн сурагч

-“ХИЧЭЭНГҮЙ БИЧИГТЭН” шагналаар:

I байр: Д.Болормаа ЕБ-ын II сургуулийн менежер

II байр: Т.Дагина Зүүнхараа политехник коллеж оюутан

-“ШИЛДЭГ ЦАХИМ КОНТЕНТ” шагналаар:

I байр: ЕБ-ын I сургууль

II байр:“Цант-Орхон” ОНӨААТҮГ тус тус шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар тус бүр шагнагдлаа.

Мөн тус арга хэмжээг тохиолдуулан:

-“МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” цол, тэмдгээр яруу найрагч, МЗЭ-ийн гишүүн, “Хараагийн уянга” ЗУБН-ийн гишүүн С.Мөнхцэцэг,

-“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ-Д.НАЦАГДОРЖ” тэмдгээр

ЕБ-ын I сургуулийн сурагч А.Дөл

ЕБ-ын III сургуулийн сурагч Ч.Наранзуун

ЕБ-ын IV сургуулийн сурагч Г.Нарангарвуу гэсэн уншигч хүүхэд шагнагдлаа.

Мөн багш Э.Ариунболд багш маань (Arigun Calligraphy page) үзэсгэлэн, лекцэд хүрэлцэн ирсэн 50 гаруй хүн, 6 байгууллагыг онцлон урамшуулан тус бүрийн нэрийг муутуу цаас, торгон артай бэлдэц зэрэг дээр уран бичлэгээр үнэ төлбөргүй бичиж өгч урамшууллаа.

Дээрх арга хэмжээ нь үндэсний өв соёлоо дээдлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил боллоо. Шагнал урамшуулалд ивээн тэтгэгчийн зардлаас нийт 752,000 төгрөг зарцуулсан бөгөөд Ч.УНДРАМ ХӨГЖЛИЙН САН-гаас УИХ-ын гишүүн Ч.Ундрам 500,000 төгрөг болон номын цуглуулгыг бэлэглэж, уншигч хүүхэд, залуус, иргэдийн оюуны боловсролд үнэтэй хувь нэмэр оруулаа.

6.1.4 “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ-УРАГ УДМАА МЭДЭЦГЭЭЕ” СУРГАЛТ, ӨДӨРЛӨГ

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, “Угийн бичиг хөтлөх”-ийн ач холбогдлыг сурталчлан, иргэдэд мэдлэг олгож, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлж, урамшуулах зорилгоор Мандал сумын Нийтийн номын сангаас Монголын угийн бичгийн академийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлтэй хамтран сумын иргэд, ЕБС-ийн болон

Зүүнхараа Политехник коллежийн оюутан, сурагчид, аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдын дунд 2022.10.10-2022.11.15 өдрүүдэд “Угийн бичгээ хөтөлж-ураг удмаа мэдэцгээе” сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, 7 байгууллага, 268 хүнийг хамруулж, зохион байгуулалт, шагналын зардалд зориулан, соёл олон нийтийн ажлын зардлаас 1750,500 төгрөгийг зарцуулав. Тус ажлын хүрээнд:

-”Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” зөвлөгөө, мэдээлэл

-“Угийн бичгээ хөтөлцгөөе” шилдэг угийн бичиг шалгаруулах уралдааныг тус тус зохион байгуулж, шилдэг оролцогчдыг шалгаруулан урамшууллаа. Үүнд:

Угийн бичгийн уралдаанд:
БАЙГУУЛЛАГА ХАМТ ОЛОН:

Тэргүүн байр: Зүүнхараа Политехник коллеж (Өргөмжлөл, 200000 төгрөг)
Дэд байр: ЕБ-ын 1-р сургууль (Өргөмжлөл, 150000 төгрөг)
Гутгаар байр: ЕБ-ын 2-р сургууль (Өргөмжлөл, 100000 төгрөг)

ИРГЭД:

Тэргүүн байр: 1-р багийн иргэн Т.Мэндсайхан (Өргөмжлөл, 100000 төгрөг)
Дэд байр: Өндөр настан Б.Өлзийсүрэн (Өргөмжлөл, 80000 төгрөг)
Гутгаар байр: 1-р сургууль 7-в анги Д.Отгон-Эрдэнэ (Өргөмжлөл 50000 төгрөг)

Шагналт байранд:

1-р сургуулийн 7-в ангийн сурагч Б.Болд-Эрдэнэ (Өргөмжлөл, 40000 төгрөг)
3-р сургуулийн 8-в ангийн сурагч Г.Анударь (Өргөмжлөл, 40000 төгрөг) нар тус тус шалгарлаа.

Монгол хүний удмын санг хамгаалах, ураг төрлөө таньж мэдэх, угийн бичиг хөтлөхийн ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

6.1.5 “БҮХ НИЙТИЙН УНШЛАГА” НОМ УНШЛАГЫН АЯН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлиг, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, иргэдийг номтой нөхөрлүүлэх зорилгоор “Бүх нийтийн уншлага” ном уншлагын аянг сумын иргэд, төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүд, ЕБС, Политехник коллежийн оюутан, сурагчид, багш нар дунд 2022.11.15-2022.11.25-ны өдрүүдэд зохион байгуулж, 2 байгууллага болон бусад 169 хүнийг хамруулан, зохион байгуулалт, шагнал урамшууллын зардалд зориулан соёл, олон нийтийн ажлын зардлаас 1900,000 төгрөгийг зарцууллаа. Тус ажлын хүрээнд:

1.“Номтой нөхөрлөхийн ач холбогдол” сэдэвт цахим сэтгэгдлийн уралдаан
2.“Зөв найруулж, бичиж сурцгаая” сэдэвт байгууллагын уралдаан
3.“Номоо солилцъё” номын солилцооны өдөрлөг, номын үзэсгэлэн зохион байгууллаа.

<u>“Номтой нөхөрлөхийн ач холбогдол” цахим сэтгэгдлийн уралдаанд:</u> Номтой нөхөрлөхийн ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилж, үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор зохион байгуулсан уралдаанд нийт 29 хүн оролцсоноос шилдэг оролцогч 5 хүнийг шалгаруулж, өргөмжлөл, нийт 160,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. Үүнд:

I байр- Х.Бямбасүрэн (Политехник коллеж)-Өргөмжлөл, 50,000 төгрөг
II байр- М.Нандагмаа (Политехник коллеж) -Өргөмжлөл, 40,000 төгрөг
III байр-Э.Бат-Ирээдүй (1-р сургууль 12-б анги) -Өргөмжлөл, 30,000 төгрөг
Тусгай байранд- Ц.Хүслэн(1-р сургууль 11 анги) -Өргөмжлөл, 20,000 төгрөг

А.Одгэрэл (1-р багийн иргэн) нар тус тус шалгарлаа. -Өргөмжлөл, 20,000 төгрөг

<u>“Зөв найруулж, бичиж сурцгаая” уралдаанд:</u> Сумын төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, албан хаагчдын дунд “Бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан бичиг хэрэг хөтлөлтийг сайжруулах зорилгоор зохион байгуулж, удирдамжийн дагуу хийсэн ажлын тайланг ирүүлсэн 2 байгууллагыг нийт 350,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд:

I байр: Зүүнхараа политехник коллеж шалгарч 200.000 төгрөг, өргөмжлөлөөр

II байр: ЕБ-ын 3 дугаар сургууль шалгарч 150.000 төгрөг, өргөмжлөлөөр тус тус шагнаж урамшууллаа.

<u>“Номоо солилцъё” номын солилцооны өдөрлөг, номын үзэсгэлэн:</u>

Өөрийн гар дээр байгаа номоо солилцон унших, уншсан номынхоо талаар харилцан ярилцаж, мэдээлэл солилцох зорилгоор “Номоо солилцъё” номын солилцооны өдөрлөг, номын үзэсгэлэнг зохион байгуулж, нийт 71 хүнийг хамруулан, 31 номыг хоорондоо солилцож, идэвхтэй оролцсон 10 хүнийг нийт 250,000 төгрөгийн шинэ номоор шагнаж урамшуулав.

Дээрх аян нь ном уншлагад бүх нийтийг хамруулах, эх хэлээрээ зөв, найруулга сайтай бичих дадалд суралцаж, хойч үедээ үлгэр дууриайлал үзүүлэн, оюунлаг, бүтээлч иргэдийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах үр дүнтэй ажил боллоо.

6.1.6 “ХАРААГИЙН АЯЛГУУ-9" ХҮҮХДИЙН ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

Өсвөр үеийн хүүхдүүдийн эх хэлний уран яруу хэллэг, үгийн баялгийг нэмэгдүүлэх, тэдний уран сэтгэмж, найруулан бичих чадварыг хөгжүүлэх, авьяас сонирхлыг нь дэмжих зорилгоор “Хараагийн аялгуу” хүүхдийн яруу найргийн наадмыг 9 дэх жилдээ уламжлал болгон зохион байгуулж, өсвөрийн яруу найрагч 30 хүүхдийг хамруулан, шагнал, урамшууллын зардалд ивээн тэтгэгчийн хандив 153,000 төгрөгийг зарцууллаа. Үүнд:

I байр: Ө.Шинэцэцэг (Түнхэл тосгоны ЕБС-ийн 11а ангийн сурагч)

II байр: О.Чинзүрх (Түнхэл тосгоны ЕБС-ийн 8б ангийн сурагч)

III байр: Б.Баттулга (Мандал сумын ЕБ-ын 1-р сургуулийн 11а ангийн сурагч)

Тусгай байр:Э.Тэмүүжин (Зүүнхараа политехник коллеж) нар шалгарлаа.

Хүүхдүүдийн эх хэлний уран яруу хэллэг, үгийн баялгийг нэмэгдүүлэх, тэдний уран сэтгэмж, найруулан бичих чадварыг хөгжүүлэхэд энэхүү уралдаан чухал ач холбогдолтой боллоо.

6.1.7 “ОЮУНЛАГ-БҮТЭЭЛЧ ГЭР БҮЛ” НОМ СОЁЛОО ДЭЭДЛЭН ГЭРИЙН НОМЫН САНГ БҮТЭЭЛЧЭЭР БИЙ БОЛГОСОН ШИЛДЭГ ГЭР БҮЛИЙГ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН

Гэрийн номын санг бүтээлчээр бий болгож, гэр бүлээрээ номтой нөхөрлөж буй сумын тэргүүний 5 гэр бүлээс хамгийн шилдгээр одоо гэрийн номын сандаа дэлхийн шилдэг сонгодог уран зохиол, хүүхдийн зохиол, үлгэр, аман зохиол, танин мэдэхүй, шинжлэх ухааны 200 гаруй номтой үлгэр жишээ Б.Цэнд-Аюушийн гэр бүл шалгарч, аймгийн төв Сүхбаатар суманд 2022.05.22-ны өдөр зохион байгуулагдсан “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийн арга хэмжээнээс “Аймгийн шилдэг гэрийн номын сантай өрх”-өөр шалгарч, Өргөмжлөл, 100,000 төгрөгийн ном худалдан авах эрхээр шагнуулсан нь номтой нөхөрлөж, гэр бүлээрээ уншиж буй иргэдийг урамшуулах үр дүнтэй ажил боллоо.

6.1.8 “МӨРӨӨДЛИЙН НОМ” ХААЛТТАЙ БОЛОН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙГ НОМТОЙ НӨХӨРЛҮҮЛЭХ 1 САРЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Сумын зорилтот бүлгийн хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх зорилгоор ЕБС-иудын дунд номтой нөхөрлөх аян зарлаж, аянд идэвхтэй оролцсон сурагчдаас сургуулиудын саналыг харгалзан сонгосон зорилтот бүлгийн 10 сурагч тус бүрд сурагчийн шинэ цүнх, хүүхдийн уран зохиолын ном бэлэглэж, номын сангийн уншигчаар бүртгэн, номтой нөхөрлүүлж байна. Соёл олон нийтийн ажлын зардлаас нийт 600,0 төгрөгийн төсөв зарцуулагдсан.

№	Сургуулийн нэр	Хүүхдийн тоо
1	1-р сургууль	1
2	2-р сургууль	5
3	3-р сургууль	1
4	4-р сургууль	1
5	Түнхэл ЕБС	1
6	Хэрх ЕБС	1
	Нийт	**10**

Дээрх арга хэмжээ нь зорилтот бүлгийн хүүхдүүдэд туслах, номтой нөхөрлөхөд дэмжих үр дүнтэй ажил боллоо.

6.1.9 “МОНГОЛ СОЁЛ-МОНГОЛЫН ДАРХЛАА” ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Төрөөс соёлын талаар баримтлах

бодлого”-ын хүрээнд монгол үндэстний оршин тогтнохын дархлаа болсон үндэсний соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Монгол соёл-Монголын дархлаа” илтгэлийн уралдааныг сумын ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 27 оролцогчийг хамруулан, шилдэг оролцогчдыг шалгаруулж, соёл олон нийтийн ажлын зардлаас 149,500 төгрөгийг зарцууллаа. Үүнд:

I байр-1 хүүхэд Өргөмжлөл, 50,000 төг,
II байр-1 хүүхэд Өргөмжлөл, 30,000 төг,
III байр-1 хүүхэд Өргөмжлөл, 20,000 төг, Тусгай байр-7 хүүхэд тус бүр Өргөмжлөл, 5,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан нь үндэсний соёлыг сурталчлах үр дүнтэй ажил боллоо.

6.1.10 ГЭР БҮЛ, ХАМТ ОЛНООРОО УНШИЦГААЯ” НОМ УНШЛАГЫН САРЫН АЯН

"Гэр бүл, хамт олноороо уншицгаая” ном уншлагын сарын аянд нийт 4-н байгууллагын 55 албан хаагч, ЕБС-ийн 5-н ангийн 123 сурагч, 3-н гэр бүлийн 12 гишүүд нийт 189 уншигч оролцож, нийт 317 ном уншиж, шилдэг уншигч “Оюунлаг байгууллага”-аар Мишээл IV цэцэрлэг, “Оюунлаг анги хамт олон”-оор IV сургуулийн 4г анги, “Оюунлаг гэр бүл”-ээр уншигч С.Чулуунпүрэвийн гэр бүл тус тус шалгарч, нийт 200,000 төгрөгийн төсөв бүхий ивээн тэтгэгчийн шагналаар шагнасан нь номтой нөхөрлөгч байгууллага, иргэд, хүүхэд багачуудыг урамшуулсан үр дүнтэй ажил боллоо.

д/д	Нэрс, огноо	Сургууль	Хэдэн хүүхэд	Уншсан номын тоо	Ном уншихын ач холбогдол сургалт
I	**ЕБС-ийн анги, хамт олон**	**Нийт 5 анги**			
1	2022.04.03	Ж.Соёлчимэг багштай 3-р сургуулийн 3б ангийн 3б ангийн сурагчид	27	27	Хамрагдсан
2	2022.04.05	Б.Түвдэндорж багштай 3-р сургуулийн 7а ангийн сурагчид	20	34	
3	2022.04.15	Ц.Аюуш багштай 3-р сургуулийн 5-б ангийн сурагчид	20	20	
4	2022.04.15	Ч.Сайнбаяр багштай 3-р сургуулийн 7а ангийн сурагчид	34	40	Хамрагдсан
5	2022:04:19	Ц.Ундармаа багштай 4-р сургуулийн 4-г ангийн сурагчид	22	50	Хамрагдсан
II	**Гэр бүл**	**Нийт 3 гэр бүл**			
		С.Чулуунпүрэв	7	42	
		Д.Батсайхан	2	6	
		Амарсанаа	3	13	
III	**Байгууллага**	**Нийт 4 байгууллага**			
		ШШГ 413-р анги	22	30	
		Мишээл цэцэрлэг	18	30	
		Шунхлай ШТС	10	15	
		Сод Монгол	5	10	
	Нийт	**5 анги хамт олон** **3 гэр бүл** **4 байгууллага**	**189 хүн хамрагдав**	**317**	

6.1.11 “ХАЙР ТҮГЭЭЕ” ЗАХИДЛЫН УРАЛДААН

Хайртай бүхэндээ чин сэтгэлийн үгээ захидлаар дамжуулан нандин бүхний утга учир юунд оршдогийг уран яруу, оновчтой илэрхийлэн хамгийн гэгээлэг бүхнийг шингээсэн захидлыг шалгаруулах “ХАЙР ТҮГЭЭЕ-2022” цахим захидлын уралдааныг зохион байгуулж, 26 оролцогчийн захидлаас шилдэг захидлыг шалгаруулж, нийт 180,000 төгрөгийн төсөв бүхий ивээн тэтгэгчийн шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд:

I байр - Ариунболорын Аззаяа /Мандал сум Политехник коллеж/

II байр - Жамсрангийн Болормаа /Мандал сум 3-р багийн иргэн/

III байр -Батмөнхийн Батцэцэг /Сэлэнгэ аймаг Сант сум/ нар шалгарлаа.

Хэн нэгэнд өгсөн урмын үг, хайр энхрийлэл шингэсэн үг, өгүүлбэр, хүмүүний сэтгэлд баяр баясгалан, урам зориг, онгод бэлэглэсэн чухал ач холбогдолтой ажил боллоо.

6.1.12 “ЭХ ХЭЛЭЭ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ” АСУУЛТ, ХАРИУЛТЫН УРАЛДААН

"Монгол хэлний их тайлбар толь"-ийг уншигчдад сурталчлах ажлын хүрээнд “Эх хэлээ хэн сайн мэдэх вэ” асуулт, хариултын уралдааныг зохион байгууллаа. Цахим орчинд Google form апликейшн ашиглан 40 асуулт бэлтгэн 2 үе шаттайгаар зохион байгуулж 49 хүнийг хамруулав.

Тэргүүн байранд: Мандал сумын ЕБС-ийн багш С.Саранчимэг

Дэд байранд: Мандал сумын иргэн Б.Эрдэнэцэцэг нар шалгарлаа. Шилдэг 2 оролцогчийг ивээн тэтгэгчийн зардлаар 50,000 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан нь иргэдийн эх хэл, соёлын мэдлэгийг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил боллоо.

6.1.13 “АХМАД УНШИГЧДЫН УУЛЗАЛТ ӨДӨРЛӨГ, ЯВГАН АЯЛАЛ”

Номтой нөхөрлөсөн ахмад уншигчдын ном унших болон зөв амьдрахуйн арга туршлага, амьдралын үнэ цэнтэй зүйлийн талаарх зөвлөгөө сургамжийг хүүхэд, залууст хүргэж, үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор ”Ахмад уншигчдын уулзалт-өдөрлөг, явган аяллыг зохион байгуулж, идэвхтэн уншигч 10 ахмадыг оролцуулан, уулзалт, ярилцлага, асуулт хариултын “АХА” тэмцээнийг зохион байгуулж, оролцсон ахмадуудыг дурсамж, 20,000 төгрөгөөр тус бүр шагнаж урамшуулж, цахим орчинд сурталчлан ажиллалаа. Тус арга хэмжээнд соёл олон нийтийн ажлын зардлаас нийт 278,000 төгрөгийг зарцууллаа.

6.1.14 “БИ УНШИЖ ОЙЛГОСНОО ЯРЬЖ ЧАДНА” НОМ УНШЛАГЫН УРАЛДААН

Бага насны сурагчдын унших чадварыг нэмэгдүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор “Би уншиж ойлгосноо ярьж чадна" уралдааныг цэцэрлэгийн бэлтгэл бүлэг, 1-р ангийн бяцхан уншигчдын дунд 1 сарын турш цахимаар зохион байгууллаа. Энэхүү уралдаанд 20 хүүхэд оролцсоноос шилдэг оролцогч 10 хүүхдийг шалгаруулж, соёл олон нийтийн ажлын зардлаас нийт 80,000 төгрөгийн мөнгөн шагнал болон 10ш шинэ номыг зарцуулав. Үүнд:

I байр: Өргөмжлөл, шинэ ном, 20,000 төг
II байр: Өргөмжлөл, шинэ ном, 15,000 төг
III байр: Өргөмжлөл, шинэ ном, 10,000 төг
Тусгай байр-7: Өргөмжлөл, шинэ ном, 5,000 төгрөгөөр шагнаж, урамшууллаа.

Ном эрдмийн далайд аялж, хорвоотой танилцаж яваа бяцхан сурагчид маань бүтэн сарын хугацаанд өдөр бүр эгдүүтэй хөөрхөн төрх, ухаалаг яриагаараа “Сэлэнгэ Мандал Номын сан” нүүр номыг чимж, Монголын ирээдүйн оюунлаг иргэн болохоор суралцаж, хөгжиж, том болж байгаагаа аав, ээж, гэр бүл, багш, нүүр номын найзууддаа харуулж, уншсан номынхоо талаар тоймлон ярих, найзуудтайгаа харилцан ярилцах, хамтран уншихад суралцан цагийг бүтээлчээр өнгөрөөж, мэдлэгээ нэмэгдүүллээ.

6.1.15 “ДЭЛГЭЦИЙН ХАМААРЛААС СЭРГИЙЛЖ- НОМОО УНШИЖ, НАЙЗУУДТАЙГАА ДУРТАЙ ЗҮЙЛСЭЭ ХИЙЦГЭЭЕ” НАЙЗУУДЫН УНШЛАГА

Хүүхдүүдийн утас, дэлгэцийн хамаарлыг бууруулж, номтой нөхөрлүүлэх зорилгоор ‘’Номоо уншиж, найзуудтайгаа дуртай зүйлсээ хийцгээе” найзуудын уншлагыг зохион байгуулж IV, III, I зэрэг ЕБС-иудын IV-VIII анги болон Сургуулийн өмнөх боловсролын нийт 330 сурагчийг анги хамт олных нь хамт номын санд урьж, ном уншлага зохион байгуулан, дэлгэцийн хамаарлын талаар мэдээлэл хүргэж, цахим хэрэглээгээ зөв зохицуулах, номтой нөхөрлөхийн ач холбогдлын талаар таниулан, тус ажлын хүрээнд “Дэлхийн номын өдөр”-ийг тэмдэглэж, 26 уншигч хүүхдүүдийг оролцуулан нийт 45,000 төгрөгийн үнэ бүхий бяцхан бэлгээр урамшуулсан нь хүүхдүүдийн дэлгэцийн хамаарлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, номтой нөхөрлүүлэх, урамшуулах үр дүнтэй ажил боллоо.

д/д	Хэзээ	Сургууль, цэцэрлэг	Хэдэн хүүхэд	Уншсан номын тоо	Ном уншихын ач холбогдол сургалт	Чанга уншлага
	ЕБС, СӨБ-ын нийт 11 анги, хамт олон					
1	2022.04.23	‘’Өнөөдрийн уншигч маргаашийн удирдагч’’ өдөрлөгт IV сургуулийн Ц.Ундармаа багштай 4г анги-9 сурагч, III сургуулийн Ц.Аюуш багштай 5Б ангийн-12 сурагч, I сургуулийн Пүрэвдорж багштай 7в ангийн-5 сурагч	26	27	Хамрагдсан	Хамрагдсан
2	2022.04.30	“Дэлгэцийг биш номыг сонгосон оюунлаг нөхөрлөл”	15	32	хамрагдсан	

		III сургуулийн Түвдэндорж багштай 5а ангийн сурагчид					
3	2022.05.02	Улсын тэргүүний “Нархан” 3-р цэцэрлэгийн Ё.Баасанхүү багштай Бэлтгэл-А бүлгийн хүүхдүүд	26	27		хамрагдсан
4	2022.05.02	‘’Дэлгэцтэй бус- номтой нөхөрлөх’’ аянд III сургуулийн Түвдэндорж багштай 5а ангийн 18 сураг, Ц.Аюуш багштай 5б ангийн 12 сурагч	30	40	Хамрагдсан	
5	2022:05.10	“Номын сан маань ‘’Цэцгхэн’’ I цэцэрлэгийн Цэцгэн хүүхдүүд-ийн хөлд дарагдлаа” ном унших өдөрт Байгалмаа багштай Ахлах-А бүлгийн 21, Ц.Батжаргал багштай 24 цагийн ангийн 17, Б.Соёлмаа багштай Ахлах-Б бүлгийн 22 хүүхэд	60	60	Хамрагдсан	хамрагдсан
6	2022.05.17	Ерөнхий боловсролын I сургуулийн Ж.Пүрэвдорж багштай 7в ангийн сургачид	24	30	Хамрагдсан	
7	2022.05.11	Улсын тэргүүний “ЭКО” I сургуулийн Т.Болортуяа багштай 7а ангийн сурагчид	24	25	Хамрагдсан	
8	2022.05.12	"Цэцэгхэн" I цэцэрлэгийн Баярцэцэг багштай ахлах-А бүлгийн 22, Оргилмаа багштай Ахлах Б бүлгийн 20 хүүхэд	42	45		Хамрагдсан
9	2022.05.14	Улсын тэргүүний ‘’Олимп” цэцэрлэгийн Ахлах А бүлгийн 27 хүүхэд	27	30		Хамрагдсан
10	2022.05.17	Улсын тэргүүний ‘’Нархан’ цэцэрлэгийн Ч.Баасанхүү багштай Бэлтгэл-А бүлгийн 26 хүүхэд	26	26		Хамрагдсан
11	2022.05.17	Мандал сумын ЕБ-ын Эко III сургуулийн Ц.Аюуш багштай 5Б ангийн багш, сурагчид	30	30		Хамрагдсан
	Нийт		**330**	**372**	**6**	**7**

Мөн өнөөдрийн нийгмийн тулгамдсан асуудал болох хүүхдийг цахим донтолтоос сэргийлэх үндсэн зорилготой "Дэлгэцийн донтолтоос сэргийлж-ном уншъя" уриан дор цахим хэрэглээгээ зөв зохицуулахад зориулж, богино хэмжээний видео бэлтгэн дэлгэцийн хэрэглээний хор уршиг, хүүхдүүдэд дэлгэцээс ангид дадал хэвшил суулгах, эцэг эхчүүдийг үр хүүхдэдээ эергээр нөлөөлж, гэр бүлийн амьд харилцааг эрхэмлэхийг уриалсан зөвлөмжийг “Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хаягаар цувралаар хүргэж байна.

6.1.16 “ӨВӨРМӨЦ НЭГЭН ЗАХИДАЛ” БЭЛЭГТЭЙ УНШЛАГА

Хүүхдийг номтой нөхөрлүүлэх "Өвөрмөц нэгэн захидал" арга хэмжээг Герман улсын номын сангуудын туршлагаар 2017 оноос эхлэн уламжлал болгон Мандал сумандаа зохион байгуулж байгаа билээ.

2022 оны захидлын эзэн 3-р сургуулийн 1 -р сургуулийн 12 дугаар ангийн сурагч А.Оргил, 4-р сургуулийн 12-б ангийн сурагч Д.Тэмүүжин нар байлаа.
Төрсөн өдрөөр нь номын сангаас очсон "Номтой бэлэг" нь ном, номын сан хэмээх гайхалтай ертөнцөд тэднийг зочлуулах мартагдашгүй гэнэтийн бэлэг болдгоороо энэхүү арга хэмжээ чухал ач холбогдолтой. 2 оролцогчийг соёл, олон нийтийн ажлын зардлаас нийт 132,400 төгрөгийн гарын бэлэг, шинэ номоор шагнаж урамшуулсан байна.
6.2 Ном хэвлэлийн танхимын сурталчилгааг уламжлалт хэлбэрээр зохион байгуулах: Номын танхимын сурталчилгаагаар тойм яриа, чанга уншлагыг 37 удаа 782 хүнд, номын үзэсгэлэнг 21 удаа 752 хүнд нийт 58 удаагийн сурталчилгаагаар 1534 хүнд үйлчилсэн нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт зохион байгуулсан ажлын тоо 166

хувиар, хамруулсан хүний тоо 192 хувиар хэрэгжиж, өмнөх оны мөн үеийнхээс зохион байгуулсан тоо 171 хувиар, хамрагдсан хүний тоо 193 хувиар өссөн дүнтэй байна.
Номын сурталчилгааны төрөл, тоон мэдээ:

№	Үзүүлэлт	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Тойм яриа, чанга уншлага	37	782
3	Номын үзэсгэлэн	21	752
	Нийт дүн	**58**	1534

Сүүлийн гурван жилийн харьцуулалт:

№	Нэр	2020 он	2021 он	2022 он	Биелэлтийн Хувь
1	Зохион байгуулсан тоо	47	34	58	171 %
2	Хамрагдсан хүний тоо	1528	793	1534	193 %

6.2.1 “Ном уншихын ач холбогдол” сургалтыг зохион байгуулах: “Ном уншихын ач холбогдол” сургалтад ЕБ-ын 3-р сургуулийн 3а анги, 7а анги, 4-р сургуулийн 4г анги, Олимп цэцэрлэг, Цэцэгхэн цэцэрлэг зэрэг нийт 11 анги бүлгийн 407 хүүхдийг хамруулж, номын ач тус, номтой нөхөрлөхийн үр дүн, номыг хэрхэн зөв унших, номын тэмдэглэл хөтлөх талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил боллоо.
Тоон мэдээ:

Зохион байгуулсан тоо	Оролцсон хүний тоо
11	407

6.2.2 “Ноён уул-түүх соёлын үнэт өв” сэдэвчилсэн ном зүйн бүртгэл хийх. Лавлагаа, татгалзлын бүртгэлийг хөтлөх: Номзүйн бүртгэлийг хийх материал цуглуулах, бүртгэлжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, Ноён уултай холбоотой ном, хэвлэл, цахим орчинд нийтлэгдсэн мэдээллийн бүртгэлийг хийж, тайлан оны төлөвлөгөөний биелэлт 80 хувьтай хэрэгжээд байна.

Лавлагаа мэдээллээр уншигчдын сонирхсон 73 лавлагаанд хариулт өгч программд бүртгэж, “Номын татгалзлын бүртгэл”-д 130 ш номыг бүртгэлээ.



ДОЛОО: ИРГЭДИЙГ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨРГӨНӨӨР ХАМРУУЛЖ, УНШИГЧДЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

7.1 Уншигчдын хүрээг өргөжүүлж, ном олголтыг нэмэгдүүлэх: Иргэдийг номтой нөхөрлүүлэх, номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор ном тойрсон олон талт ажлуудыг зохион байгуулж, ном уншлагын клуб, дугуйланг ажиллуулж, байгууллагын нөөц бололцоог дайчлан ажиллаж, нийт 1972 шинэ уншигч, 8003 ирэгсэдэд, 11315 ш ном олгосон нь жилийн төлөвлөгөөний биелэлт шинэ уншигч 98,6 хувь, ирэгсэд 100 хувь, ном олголт 75,4 хувь хэрэгжиж, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулсан дүнгээр шинэ уншигч

449 хувь, ирэгсэд 648 хувь, ном олголт 191 хувиар өссөн дүнтэй харагдаж байгаа нь энэ онд номын сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэнтэй холбоотой юм.

Сүүлийн гурван жилийн харьцуулалт:



Үзүүлэлт	2020	2021	2022	Хувь
Суудлын тоо	42	42	42	
Уншигчдын тоо (байнгын /шинэ)	**1105**	**439**	1972	449 %
Ирэгсэд	**8888**	**1235**	8003	648 %
Олгосон номын тоо	**10359**	**1685**	11315	191 %

Уншигч, ирэгсэд, ном олголтын төрөл:

№	Нэрс	Танхимын үйлчилгээ	Гэрээр	Явуулын үйлчилгээ	Номын солилцоо	Бүгд
	Уншигч	1590	215	167		**1972**
	Ирэгсэд	6992	438	502	71	**8003**
	Ном олголт	9054	1717	513	31	**11315**

УНШИГЧ, ИРЭГСЭД, НОМ ОЛГОЛТЫН БҮРТГЭЛ-2022 ОН

Мөн

2022 оны Номын сангийн өдөр тутмын бүртгэл -Уншигчийн байдал

Бүх уншигчийн тоо	Ажил эрхлэлт								
	Ажилтан, албан хаагч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Бусад	Сургуулийн өмнөх насны	Дунд сургууль I-IV анги	Дунд сургууль V-VIII анги	Дунд сургууль IX-XII анги	Их дээд сургууль, Коллеж	МСҮТ
1972	213	121	115	175	737	266	226	119	

Бүх уншигчийн тоо	Боловсрол					Нас					Хүйс		Иргэншил	
	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд	18 хүртэлх	18-24 нас	25-35 нас	36-50 нас	50-с дээш нас	Эрэгтэй	Эмэгтэй	Монгол	Гадаад
1972	460	761	370	118	263	1111	252	203	189	217	743	1229	1972	

2022 оны өдөр тутмын бүртгэл - Ном олголт

ном	хэвлэмэл бус	сонин	сэтгүүл	хөлөгт тоглоом	сонсдог ном	интернет орчинд	Нийт
9920	302			368	331	394	11315

байгаль	техник	ХАА	анагаах ухаан	социологи	түүх	эдийн засаг	улс төр	төр эрх хууль цааз	цэргийн шинжлэх ухаан	соёл шу боловсрол	хэл шинжлэл	аман зохиол	уран зохиол	урлаг	шашин	гүн ухаан	сэтгэл судлал	лавлах хэвлэл
471	181	239	164	93	426	373	193	130	13	501	1400	2846	3500	187	11	112	124	351

Түнхэл тосгоны Соёлын төвтэй болон номын солилцооны өдөрлөгөөр номын солилцоог нийт 3 удаа 52ш номоор хийлээ.

Номын солилцооны тоон мэдээ:

Хаана	Хэдэн удаа	Номын тоо
Түнхэл Соёлын төв номын сан	2	21
Номын солилцооны өдөрлөг	1	31
Нийт	**3**	**52**

Идэвхтэн уншигчдыг урамшуулах: 2022 оны эхний хагас жилд Номын сангаас зохион байгуулсан соёл, олон нийтийн ажилд идэвхтэй оролцсон 11 байгууллага, 138 уншигчийг соёл олон нийтийн ажлын зардал болон, ивээн тэтгэгчийн хандиваар нийт 5307,000 төгрөгийн төсөв бүхий шагналаар, 3 уншигчийг "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж" тэмдгээр, 200 гаруй номтой уншигч Б.Цэнд-Аюушийн гэр бүл "Аймгийн шилдэг гэрийн номын сантай өрх"-өөр шалгарч, Өргөмжлөл, 100,000 төгрөгийн ном худалдан авах эрх, уншигч Ж.Амарзориг "Аймгийн тэргүүний уншигч хүүхэд"-ээр шалгарч өргөмжлөл, дурсгалын зүйлээр тус тус шагнууллаа.

Урамшууллын тоон мэдээ:

№	Нэрс	Шагнал, урамшуулал		
		Хүний тоо	Байгууллагын тоо	Мөнгөн дүн
1	“Номын сан-4 улиралд” ном уншлагын хөтөлбөр	12		310000
2	“Ноён уул-Нутгийн брэнд” ном, бүтээлийн үзэсгэлэн, өдөрлөг	0		0
3	Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан “Монгол бахархал” уран бичлэгийн үзэсгэлэн, лекц зохион байгуулах	7	5	752000
4	“Угийн бичгээ хөтөлж-ураг удмаа мэдэцгээе” сургалт, өдөрлөгийг зохион байгуулах.	5	3	1030000
5	“Бүх нийтийн уншлагын өдөр” зохион байгуулах тухай	15	2	760000
6	“Хараагийн аялгуу-9” хүүхдийн яруу найргийн наадам	3		153000
7	“Оюунлаг-бүтээлч гэр бүл” ном соёлоо дээдлэн гэрийн номын санг бүтээлчээр бий болгосон шилдэг гэр бүлийг шалгаруулах уралдаан	1		100000
8	“Мөрөөдлийн ном” хаалттай болон зорилтот бүлгийн иргэдийг номтой нөхөрлүүлэх 1 сарын аяныг зохион байгуулах	10		600000
9	“Монгол соёл-Монголын дархлаа” илтгэлийн уралдаан	10		184500
10	“Гэр бүл-хамт олноороо уншицгаая” ном уншлагын 1 сарын аян	2	1	200000
11	Цахим орчинд соёл түгээх “Хайр түгээе” захидлын цахим уралдааныг зохион байгуулах	3		75000
12	Монгол хэлний их тайлбар толийг уншигчдад сурталчлах “Эх хэлээ хэн сайн мэдэх вэ” үгийн тайлбарын уралдаан	2		50000
13	“Ахмад уншигчдын уулзалт өдөрлөг, явган аялал”	10		278000
14	“Би уншиж ойлгосноо ярьж чадна” ном уншлагын уралдааныг зохион байгуулах	10		382100
15	“Дэлгэцийн донтолтоос сэргийлж- Номоо уншиж, найзуудтайгаа дуртай зүйлсээ хийцгээе” найзуудын уншлага	28		45000
16	“Өвөрмөц нэгэн захидал” бэлэгтэй уншлага	2		132400
17	“Миний мэдэх номын сан” эссэ бичлэгийн уралдаан	5		80000
18	"Номын санч"-ийн мэргэжил сурталчлах өдөрлөг	3		75000
19	Хүүхдийн баярын арга хэмжээ	10		100000
	Нийт	**138**	**11**	**5307000**

7.2 Ном уншлагын клуб, дугуйлан хичээллүүлэх: “Өсвөрийн номын санч” дугуйланд 10 хүүхэд хамрагдаж, номын санчийн ажил, номтой ажиллах мэдлэгээ нэмэгдүүлж байна.

ӨСВӨРИЙН НОМЫН САНЧДЫН УУЛЗАЛТ, СУРГАЛТ

Номын санчийн мэргэжил, номтой нөхөрлөхийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Өсвөрийн номын санчдын уулзалт, сургалт”-ыг зохион байгуулж, 6 хүүхдийг хамруулж, номын санчийн ажлын талаар мэдлэг олгож, мэдээлэл хүргэсэн ач холбогдолтой ажил боллоо.

НАЙМ: ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ЦАХИМ НОМЫН ФОНД, КОМПЬЮТЕР, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

8.1 Ном, хэвлэлийн цахим сурталчилгаа, мэдээллээр үйлчлэх: Номын сангийн үйлчилгээг цахим хэрэгсэл ашиглан зохион байгуулж, ном хэвлэлийн сурталчилгаа, цахим ном, үндэсний өв соёл, танин мэдэхүй, орон нутгийн түүх, соёлын талаарх мэдээллийг 292 удаа цахим хуудсаар хүргэж, 5125 хандалттай байгаа нь тайлант оны төлөвлөгөөний оруулсан мэдээллийн тоог 195 хувиар, хандалтын тоог 102,5 хувиар хэрэгжүүлж буй дүнтэй байна.

Ном, хэвлэлийн цахим сурталчилгааны тоон мэдээ:

Цахим номын үзэсгэлэн	21
Үндэсний бичиг, өв соёлыг сурталчлах	28
Үлгэрийн цаг	51
Цахим ном, өгүүллэг	95
Танин мэдэхүйн мэдээлэл	73
Миний сайхан Мандал сум	24
Нийт 292 удаа 5125 хандалт	

8.2 Номын цахим /электрон/ каталогиор үйлчлэх: Фондод хадгалагдаж буй 28,000 гаруй номыг бүрэн оруулсан Mandal.monbiblio.mn цахим каталогоор уншигчдад үйлчилж байна.

8.3 “Цахим номын фонд”-ын баяжилтыг нэмэгдүүлэх: Цахим номыг гэрээсээ үнэгүй унших “Номтой нөхөрлөе” бүлэг нь 668 дагагчтай, 514 номтой ажиллаж байна. 25ш шинэ цахим номоор баяжилт хийлээ.



8.4 “Цахим засаглал хөтөлбөр”-ийн хүрээнд номын сангийн үйл ажиллагааг цахимжуулах компьютер, техник хэрэгслийн тоог нэмэгдүүлэх: Номын сангийн компьютер, техник хэрэгслийг сайжруулах зорилгоор 34 сая төгрөгийн өртөг бүхий “Цахим номын сан” төслийг бичиж, сумын Засаг даргаас дэмжлэг бүхий албан бичигтэйгээр Аймгийн Засаг даргад 2 удаа албан бичиг, Аймгийн СУГ-т 1 удаа албан бичиг, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст 1 удаа албан бичиг явуулж хүсэлт гарган, Аймгийн ИТХ-ын дарга, Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст тус тус танилцуулсан бөгөөд санхүүжилтийг дэмжих боломжгүй гэсэн татгалзсан хариуг албан бичгээр авсан байдалтай байна. Мөн орон нутгаас төлөөлөл бүхий УИХ-ын гишүүдэд хүсэлт гаргасан.

2022 онд орсон дуу, цахилгаан, аянгатай борооны үеэр номын сангийн хэмжээнд ашиглагдаж байсан 4ш суурин компьютерийн 2ш нь шатаж огт ажиллагаагүй болсон, нийт 8ш хяналтын камерын 4 ш нь ажиллагаагүй болж, тэжээлийн блок шатаж, шугамд гэмтэл гарсан бөгөөд компьютер, хяналтын камерууд бүгд ашиглалтын хугацаа дууссан, засаж сэлбэх, дахин ашиглах боломжгүй хүндрэлтэй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна. Энэ тухай сумын Засаг даргад танилцуулж, дэмжлэг хүссэн албан бичгийг хүргүүлсэн боловч 2023 оны сумын төсөв хэлэлцэх Засаг даргын зөвлөлийн хурлаар дэмжигдээгүй.

2022 оны төсвийн зардлаас 1ш notebookd 2200,000 төгрөг, 4ш процессорт нийт 3400,000 төгрөг, 10ш хяналтын камерт 3500,000 төгрөгөөр тус тус иж бүрэн засвар үйлчилгээг Улаанбаатар хотын GRID NETICS ХХК-иар хийлгэж, хэвийн үйл ажиллагааг хангалаа.

ЕС: ОРОН НУТГИЙН НОМЫН САНГУУДАД МЭРГЭЖИЛ, АРГАЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

9.1 “Миний мэргэжил-Номын санч” сэдэвт мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулах:

Номын санчийн мэргэжлийг өсвөрийн хүүхэд багачууд, залууст сурталчлан таниулах зорилгоор ахмад номын санчидтай хийх уулзалтыг зохион байгууллаа.

“Миний мэргэжил-номын санч” мэргэжил сурталчлах өдөрлөгт Политехник коллежийнг оюутнууд, Сумын ЕБС-иудын 12 дугаар ангийн нийт 144 хүүхдийг хамруулж, доорх ажлыг зохион байгууллаа. Үүнд:

1.Номын сантай танилцах аялал

2.Ахмад номын санчидтай хийх уулзалт

3.“Миний мэдэх номын сан” эсээ бичлэгийн уралдаан

4.АХА тэмцээнийг зохион байгуулж, шилдэг оролцогчдыг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Эсээ бичлэг:

I байр: Өргөмжлөл, 25,000 төг- О.Эрдэнэтунгалаг (3-р ЕБС 10в

II байр: Өргөмжлөл, 20,000 төг- Г.Мишээл (2-р ЕБС 12а)

III байр: Өргөмжлөл, 15,000 төг- Б.Мөнгөлдэй (3-р ЕБС 11а)

Тусгай байр-2: Өргөмжлөл, 10,000 төг- Ц.Нямсүрэн (2-р ЕБС 12б)
А.Пүрэвцэцэг (2-р ЕБС 12а)

АХА тэмцээн:

Шилдэг оролцогч: Шинэ ном- Ө.Сувд-Эрдэнэ (5-р ЕБС 10а)
Шинэ ном- С.Анхбаяр(4-р ЕБС 12б анги)
Шинэ ном- С.Номин(4-р ЕБС 12б анги)

Сурагчдын мэргэжил сонголтод нь туслах зорилгоор номын санчийн мэргэжлийг сурталчилж, номын сангийн ажилтнууд ажил мэргэжлээрээ бахархсан үр дүнтэй ажил боллоо.

9.2 “Хараа” бүсийн номын санчдын сургалт зохион байгуулах:

ХАРАА БҮСИЙН НОМЫН САНЧДЫН
“НОМЫН САНЧ НАР-ХАМТДАА ХӨГЖЬЕ-II” УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хараа бүсийн Соёлын байгууллагуудын хэлэлцээний дагуу 2022 онд “Дэлхийн номын өдөр”-ийг Баянгол сумын Соёлын төв хариуцан зохион байгуулж, тус ажлын хүрээнд Хараа бүсийн номын санчдын “Номын санч нар-Хамтдаа хөгжье-II” уулзалт, хэлэлцүүлгийг хийлээ. Үүнд:

1. “Соёл олон нийтийн ажлын арга туршлага”
2. “Номын сан хоорондын номын солилцооны түншлэлийн ач холбогдол”
3. “Номын санч нар-Хамтдаа хөгжье” сэдвүүдээр туршлага судлах, мэдлэг олгох хэлэлцүүлэг, ярилцлагыг зохион байгуулж, номын санч нарын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил боллоо.

Мандал сумын Нийтийн номын сангийн номын санч-4, Баянгол сумын Соёлын төвийн номын санч-1, Хэрх тосгоны Соёлын төвийн номын санч-1, Баянгол сумын сургуулийн номын санч-1 нийт 7 номын санч оролцлоо.

9.3 Орон нутгийн номын сангуудад ажлын байрны аргазүйн зөвлөгөө өгөх:

Ажлын байрны мэргэжил арга зүйн зөвлөгөөг 11 хүнд 8 удаа, уулзалт хэлэлцүүлэгт 7 хүнийг 1 удаа, нийт 9 удаа 18 хүнийг хамруулж, номын санч нарын мэдлэгийг нэмэгдүүлсэн нь тайлант онд зохион байгуулах тоог 225 хувиар, хамруулсан хүнийг тоог мөн 225 хувиар биелүүлсэн үр дүнтэй байна.

№	Сэдэв	Хаана	Зөвлөгөө авсан	Зөвлөгөө өгсөн	Хамрагдсан хүний тоо
1	“Номын санч нар-Хамтдаа хөгжье-II” уулзалт, хэлэлцүүлэг	Баянгол сумын Соёлын төвд	Хараа бүсийн номын санч нар	Мандал сумын Нийтийн номын сан Б.Байгалмаа	7
2	Номын сангийн СОНА-ын зохион байгуулалт болон бусад	Нийтийн номын сангийн байранд	Номын санч Н.Болорцэцэг, Г.Одгэрэл		2

3	СОНА-ын зохион байгуулалт	ЕБ-ын 4-р сургууль	Номын санч Б.Шүрэнцэцэг		1
4	Тайлан, төлөвлөгөө бичих аргачлал	Нийтийн номын сангийн байранд	Номын санч Н.Болорцэцэг, Г.Одгэрэл		2
5	Монбиблио програм суулгах, ном бүртгэх	ЕБ-ын 2-р сургууль	Т.Дуламсүрэн		1
6	Ном солилцооны тухай	ЕБ-ын 5-р сургууль	Г.Ганзул		1
7	СОНА-ын удирдамж боловсруулах	Нийтийн номын сангийн байранд	Номын санч Г.Одгэрэл Б.Номин-Эрдэнэ	Захирал А.Оюунсүрэн	2
8	Номын техник ажиллагаа	Нийтийн номын сангийн байранд	Номын санч С.Цэндсүрэн	Мандал сумын Нийтийн номын сан Б.Байгалмаа	1
9	Монбиблио програмд ном бүртгэх		Номын санч Б.Номин-Эрдэнэ		1
Нийт					**18**

Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:

АРАВ: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

10.1 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж ажиллан “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх: Албан хаагчдын эрүүл мэндэд анхааран, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөөг 16 зүйлтэйгээр боловсруулж, хэрэгжилтийг хангаж байна. Үүнд:

- Байгууллагын “ХАБЭА-н дүрэм”, "Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химиi, биологийн бүтээгдэхүүний нэгдсэн жагсаалт”, “Химийн бүтээгдэхүүнтэй зүй зохистой харьцах, хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж”, “Химийн бүтээгдэхүүний хордлогод өртөж болзошгүй эрсдэл бүхий ажлын байр, албан хаагчдын нэгдсэн жагсаалт”-ыг тус бүр шинэчлэн гаргаж, хэрэгжүүлж байна.
- Албан хаагчдыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлж ажиллах, эмчилгээ, сувилалд хамруулах, дархлааг дэмжих, түр амрах, хооллох нөхцөлийг хангаж, шинэ ажилтнуудад “Зааварчилгааны хяналтын хуудас”-аар ХАБЭА-н зааварчилгааг өгч байна.
- Сумын Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 6 албан хаагчийг хамруулсан. 1 албан хаагч өөрийн хүсэлтээр үзлэгт ороогүй. 1 албан хаагч эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан тул давхар урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахгүй гэж эмнэлгийн зүгээс шийдвэрлэсэн.
- Албан хаагчдыг ажлын байрны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсан “Мандал сумын нийтийн номын сангийн албан хаагчид ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэглэм баримтлах анхааруулга, санамж”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, албан хаагчид ажлын ээлж эхлэх бүртээ анхааруулга санамжтай танилцан гарын үсэг зурж ажлаа эхлүүлж байна.
- “Ажлын байрны ХАБЭА-н үзлэг, хяналтын төлөвлөгөө”-г 5 зүйлтэйгээр

боловсруулж, ажлын байрны хяналт шалгалтыг 1 удаа, өдөр тутмын хяналтыг тогтмол зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулж байна.

- Байгууллагын “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аянд нэгдэж албан хаагчид өглөө ажил эхлэхээс өмнө эрүүл мэндэд тустай дасгал хөдөлгөөн хийж, спортоор хичээллэн эрч хүч дүүрэн ажлаа эхлүүлж байна.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ёс зүйн ажлыг сайжруулах үүднээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй орчинд ажиллах” хөтөлбөрийн хүрээнд ажил зохион байгуулж, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын сарын аян”-г байгууллагын хэмжээнд 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл зарлалаа.
- “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ”-г мэргэжлийн байгууллагаар хийлгэх, “Хүүхэд төвтэй гамшгийн эрсдэлийг бууруулах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж ажиллах тухай” Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус байнгын комисс”-т, “Ажлын байрны дарамт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх журмыг боловсруулах тухай” үүргийг “Ёс зүйн зөвлөл”-д тус тус үүрэг болгон ажиллаж байна.



- Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах үүднээс албан хаагчдад ээлжит болон ээлжит бус “Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа”-г гүйцэтгэх ажил үүрэгт нь тохируулан тухай бүр бичгээр гаргаж танилцуулан, байгууллагын Захирлын гарын үсэг, тэмдэг, танилцсан албан хаагчдын гарын үсэг, огноогоор баталгаажуулан, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.
- Байгууллагад хэрэглэгдэж буй цахилгаан хэрэгслүүд, галын хор, цахилгааны шугам зэрэг эрсдэл гарч болзошгүй газруудад “Аюулгүйн санамж”-уудыг байрлуулж, анхааруулж, сануулж байна.
- Тайлант хугацаанд коронавирусын халдвараар 2 албан хаагч өвчилж, эдгэрсэн. Өөр тохиолдол илрээгүй.
- Ханиад, томуууны улиралд албан хаагчдын өвчлөлөөс сэргийлэн зөвлөгөө мэдээлэл өгөх, дулаан хувцсаар хангах ажлыг зохион байгуулж байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ

Байгууллагын "ХАБЭА-н сарын аян"-ны хүрээнд зохион байгуулж буй "ХАБЭА-н сургалт"-ыг 2022.05.12-ны өдөр Сумын "ХАБЭА-н зөвлөл"-ийн гишүүн С.Наранханд уригдан ирж, албан хаагчдад зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажиллалаа.

Тус сургалтад Нийтийн номын сангийн албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ 9 албан хаагч хамрагдаж, ХАБЭА-н хууль, ХАБЭА-н байгууллагын хүлээх үүрэг, ажилтны

үүрэг, эмнэлгийн анхны тусламж, байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийх талаар заавар, зөвлөгөө авч ажиллалаа.

АРВАН НЭГ: АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

11.1 “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр хэрэгжүүлэх:

- Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018.03.14-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийн байгууллагын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.
- “Албан хаагчдын цалин, хөлс”-ний судалгааг шинэчлэн гаргаж, 1 албан хаагчийн ажлын үр дүн, байгууллагад ажилласан жилийг харгалзан цалингийн шатлалыг, мөн 1 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ахиулан нэмэгдүүллээ.
- “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 6, 7 дугаар хавсралтын дагуу үйлчилгээний ажилчдын цалинг тогтоон олголоо.
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг үндэслэл болгон улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг давхардсан тоогоор 22 хүнд 40 хувиар, ур чадварын нэмэгдлийг 64 хүнд 25 хувиар олголоо.
- 5 албан хаагчид илүү цагийн нэмэгдлийг 1 удаа 16 цагаар олгоод байна.
- Нийт 600,000 төгрөгийн үнэ бүхий 3,000 ш амны хаалтыг хандиваар бүрдүүлэн авч байгууллагын албан хаагчдад хуваан олгож эрсдэлээс хамгаалж байна.
- Ковидоор өвчилсөн 2 албан хаагч тус бүрд 35,000 төгрөг нийт 70,000 төгрөгөөр хамт олны сэтгэлийн дэмжлэг үзүүллээ.
- Байгууллагын “Албан хаагчдын орон сууцны судалгаа”-г бүрэн гаргасан. Одоогийн байдлаар нийтийн орон сууцанд 3 албан хаагч, хувийн хашаа байшинд 6 албан хаагч амьдарч байна. Албан хаагчдад хувийн орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх талаар анхаарч банкны зээлд хамрагдахад нь шаардлагатай байгууллагын тодорхойлолтыг гаргаж туслалцаа үзүүлдэг.
- Албан хаагчид өөрсдийн боломж бололцоогоо ашиглан өөрийн сонирхлын дагуу өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь тусалж, 7 хүнд тус бүр 5 хоногийн цалинтай чөлөөг 1 удаа олгон дэмжлээ.
- “Албан хаагчдын гэр бүлийн судалгаа”-г шинэчлэн гаргаж, бага насны хүүхдээ сургууль, цэцэрлэгт өгч, авдаг албан хаагчдад ажлын цагаар хүссэн үед нь чөлөө олгодог. Одоогийн байдлаар цэцэрлэг, сургуулийн бага ангийн насны хүүхэдтэй 2 албан хаагч байна.
- “Албан хаагчдын банкны зээлийн судалгаа”-г тус онд шинэчлэн гаргасан бөгөөд одоогийн байдлаар 6 албан хаагч 11 төрлийн зээлд хамрагдаж, тус онд 5 албан хаагч шинээр банкны зээл авсан байна. Албан хаагчдын банкнаас авах цалингийн болон бусад хэрэглээний зээлд байгууллагаас шаардлагатай баримт материалыг саадгүй гаргаж өгдөг.
- Төрийн албан хаагчдын хүн амын орлогын албан татварын хөнгөлөлт эдлэхэд байгууллагаас шаардлагатай баримт материалыг гаргаж өгдөг.
- “Албан хаагчдын газар өмчлөлийн судалгаа”-г гаргалаа. Үүнд: байгууллагын 9 албан хаагчаас өөрийн нэр дээр өмчлөлийн газар бүхий 3 албан хаагч, газаргүй 5 албан хаагч, газар авахаар хүсэлт гаргасан 1 албан хаагч байна.
- Албан хаагчдын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэж байгаа талаарх, албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэв, шагнал урамшуулал олгосон тухай “Албан хаагчдын шагнал, урамшууллын судалгаа”-г гаргаж, тухай бүр баяжилт хийж байна. Номын санч Б.Байгалмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны "Хөдөлмөрийн тэргүүний ажилтан" цол, тэмдгээр, жижүүр С.Цэндсүрэнг Соёлын яамны “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр тус тус тодорхойлон шагнуулсан бөгөөд 1 албан хаагчийг “Алтан гадас” одон, 1 албан хаагчийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулах хүсэлтийг тус тус холбогдох дээд газарт гаргаад байна.

- Албан хаагчдын 2022 оны ээлжийн амралтын хуваарийг баталж, хуваарийн дагуу амралтыг олгож, биеэр эдлүүлсэн.
- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн 1 албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийг 2022 оны төсөвт тусгуулан бүрэн олголоо.
- Байгууллагын орон тооны бус зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж байна.
- Урт болон богино хугацааны сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдын цалинг бүрэн олгодог бөгөөд тайлант хугацаанд 1 албан хаагч урт хугацааны сургалтын чөлөөнд хамрагдсан.
- 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байгууллагын шинэчилсэн Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан заалтын дагуу албан хаагчдад хувийн чөлөө олгох журмыг тогтоож, ажлын өдөрт 2 хүртэл цагийн чөлөөг харьяалах албаны Ахлах ажилтан амаар өгөх тул “Гадуур ажлын дэвтэр” гарган хөтлүүлж, чөлөөг тэмдэглүүлж эхэллээ. 1-6 хоногийн чөлөөг хувийн чөлөөний хуудсаар албан хаагч хүсэлт гаргаж, байгууллагын Захирал баталгаажуулж өгөх тул Нийтийн номын сангийн Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/12тоот тушаалаар байгууллагын “Хувийн чөлөөний хуудас”-ыг баталж, мөрдүүлж эхэллээ. Тус онд хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчид хуулийн дагуу чөлөөг олгосон бөгөөд ажлын байр хадгалагдаж байна. Хувийн чөлөө хүссэн 5, өвчний чөлөө хүссэн 3 албан хаагч байна.
- Бие даан хувиараа суралцаж буй 1 албан хаагчид цалинтай чөлөө олгон дэмжиж байна.
- Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/193 тоот захирамжийн дагуу байгууллагын Захирлын 2022 оны 05 сарын 14-ний өдрийн А/46 тоот “Байгууллагын ажлын цагийн хуваарьт түр зохицуулалт хийх тухай” тушаалыг гаргаж, байгууллагын ажлын цагийн ерөнхий хуваарийг 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд эхлэх цагийг 08 цаг 00 минут, тарах цагийг 17 цаг 00 минут, цайны цагийг 12 цаг 00 минутаас 13 цаг 00 минут байхаар зохицуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.
- Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 9 албан хаагчид нэг бүр нь 15,000 төгрөгийн үнэ бүхий дотор өмсөх үслэг дулаан хантааз 9ш, нэг бүр нь 21,000 төгрөгийн үнэ бүхий дулаан зузаан цамц 9ш, нэг бүр нь 35,000 төгрөгийн үнэ бүхий эмэгтэй нимгэн цамц 7ш, нэг бүр нь 30,000 төгрөгийн үнэ бүхий эрэгтэй нимгэн цамц 2 ш нийт 635,000 төгрөгийн үнэ бүхий 27ш, 6000 төгрөгийн үнэ бүхий үсний хавчаар 1ш худалдан авч албан хаагчдын хувцасны жигдрэлт, өнгө үзэмжийг сайжруулж, тав тухтай дулаан байдлыг хангалаа. Тус ажлын зардалд төсвийн зохих зардлаас 330,000 төг, хандиваар 305,000 төгрөгийг зарцууллаа.
- 2022 оны “Шилдэг албан хаагч”-аар номын санч Т.Байгалмаа, “Бүтээлч албан хаагч”-аар

жижүүр Д.Гантулга, “Инээмсэглэл-талархал”-ын шагналаар жижүүр С.Цэндсүрэн нар тус бүр шалгарч, байгууллагаас хүн тус бүрд Өргөмжлөл, 100,000 төгрөг, нийт 300,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

АРВАН ХОЁР: БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, ТӨСӨВ САНХҮҮ, ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

12.1 Дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх: Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор “Дотоод хяналт”-ын комиссыг Мандал сумын Нийтийн номын

сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/27 тушаалаар шинэчлэн томилсон. Дотоод хяналтын комиссын гишүүд 1 удаа хуралдаж, доорх асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

- 2022 оны төлөвлөгөө болон 2021 оны тайланг сонсож дүгнэлт хийж, харилцан ярилцлаа.
- Уншигч үйлчлүүлэгчдээс орчин нөхцөл болоод номын санчдын харилцаа хандлагын судалгааг авч ажиллахаар боллоо.
- Үйлчлүүлэгчдээс "Нийтийн номын сангийн үйлчилгээний журам"-аас өөрөөр зөвшөөрөлгүй төлбөр хураамж авсан эсэхэд хяналт тавин ажиллах зэрэг асуудлыг ярилцлаа.

"Дотоод хяналтын комисс"-ын үйл ажиллагааг сайжруулж, дотоод хяналтын ажилтныг "Монголын дотоод хяналтын институт"-ын дотоод мэргэшсэн аудитор бэлтгэх анхан шатны сургалтад хамруулж, гарын авлага, заавар зөвлөмжөөр хангагдлаа.

Дотоод хяналтын ажилтан нь номын сангийн үйл ажиллагааны ил тод байдал, эд хөрөнгийн ашиглалт бүрэн бүтэн байдал, ариутгал халдваргүйтгэл, уншигч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйлчилгээний орчин нөхцөлийн талаар судалгаа хийн, байгууллагын хяналтын камерын бичлэгт хяналт хийж, болзошгүй эрсдэлээс сэргийлж байна. Одоогийн байдлаар ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй, албан хаагчдаас ирсэн 15 ш өргөдөл, хүсэлтийг "Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэр"-т бүртгэн тухай бүр шийдвэрлэж байна.

12.2 Хүний нөөцийн бүрдүүлэлт, ТАХ-ын хувийн хэрэг, цахим системийн бүртгэлийг хангах: Хүний нөөцийг бэлтгэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдах зорилгоор 1 номын санчийг Номын санч мэргэжлээр эчнээгээр суралцуулж төгсгөлөө. Хүүхэд асрах чөлөөтэй байгаа номын санчийн түр орон тоо болон 1 номын санчийн сул орон тоонд ажиллуулах нээлттэй сонгон шалгаруулалтыг 4 удаа зарлан одоогийн байдлаар тус сонгон шалгаруулалтаас 1 номын санч, үйлчлэгчийн сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлан одоогийн байдлаар 1 үйлчлэгч тус бүр томилогдон ажиллаж байна. "Номын санч сонгож авах нээлттэй сонгон шалгаруулалт"-ыг зарлаж, сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд хүсэлт гаргасан боловч мэргэжлийн номын санч олдохгүй мөн цаашид номын санч мэргэжлээр суралцаж, тогтвор суурьшилтай ажиллах хүн олдохгүй байгаа тул байгууллагын үйлчлэгч цаашид номын санч мэргэжлээр суралцан ажиллах хүсэлт гаргасан тул тус номын санчийн ажилд томилон ажиллуулж байна.

АЛБАН ХААГЧИДТАЙ БАЙГУУЛАХ "НОМЫН САНЧИЙН МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИХ, МЭРГЭШИХЭЭР СУРАЛЦАХ ГЭРЭЭ"-Г БАЙГУУЛАХ:

Номын сангийн мэргэжлээр холбогдох сургуулийг төгссөн боловсон хүчин олдохгүй байгаа мөн номын санд ажилд орж буй номын санч нар анх ажилд орохдоо байгууллагын удирдлагатай тохиролцон, номын сангийн мэргэжлээр суралцан, тогтвор суурьшилтай ажиллах талаар өргөдөлдөө бичиж ажилд ордог боловч, тогтвор суурьшилтай ажиллах, суралцах тохиролцоогоо зөрчих тохиолдол удаа дараа гарч байгаа тул байгууллагын Захирлын 2022 оны 05 сарын 18-ны өдрийн А/49 тоот "Албан хаагчидтай байгуулах "Номын санчийн мэргэжил эзэмших, мэргэшихээр суралцах гэрээ"-г батлах тухай" тушаалыг гаргаж, номын санчийн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагын дагуу мэргэших, мэргэжил эзэмших сургалтад хамрагдах албан хаагчидтай байгуулах "Номын санчийн мэргэжил эзэмших, мэргэшихээр суралцах гэрээ"-г тус тушаалын нэгдүгээр хавсралтаар батлан холбогдох 2 номын санчтай гэрээг байгууллаа.

12.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хангах: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай 2020 онд, "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор, "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам" Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2018 онд тус тус шинэчлэгдэн батлагдсан тул байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах

зорилгоор байгууллагын хэвлэмэл хуудсыг хэвлүүлэх зөвшөөрөл авахаар Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтсийн Архивын тасагт хүсэлт хүргүүлэхэд эхийг өөрсдөө бэлтгүүлээд манайд ирүүлсний дагуу манайх баталж, зөвшөөрөл олгоно гэсэн тул манай байгууллагаас судалгаа хийж, доорх байдлаар асуудлыг шийдвэрлэлээ.

-Бэлгэ тэмдэг лого, Хэвлэмэл хуудас, тамга тэмдгийг сайжруулах: доорх ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Байгууллагын Удирдлагын бүртгэлийг Улсын бүртгэлийн гэрчилгээнд шинэчлэн бүртгүүллээ.
- Байгууллагын баталгаажуулалтын “Тамга” (албан ёсны нэршлээр “Тэмдэг”) нь хуучирч, агуулга мэдээлэл, стандарт хэмжээ зэрэг нь шинэчилсэн хууль журмын заалтаас хоцрогдсон тул Улсын бүртгэлийн газарт хүсэлт гарган зөвшөөрөл авч Улаанбаатар хотод “Тамга урлал” ХХК-аар загварыг гаргуулан шинэчлэн хэвлүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэллээ.
- Байгууллагын тушаал, албан бичгийг үйлдэх албан хэрэг хөтлөлтийн “Хэвлэмэл хуудас” нь шинэчилсэн хууль, журмын дагуу шинэчилж, мэдээлэл, агуулгыг өөрчлөх, нэмэх шаардлагатай болсон тул Аймгийн Хууль, эрхзүйн хэлтсийн Архивын тасгаас зөвшөөрөл авч, Улаанбаатар хотод Архивын ерөнхий газарт хэвлэмэл хуудасны эхийг бэлтгүүлж, мөн тэнд нийт 1500 хувь бланк хэвлүүлэн авч үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.
- Байгууллагын лого буюу “Бэлгэ тэмдэг”-ийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлогтой нийцүүлэн байгууллагын Захирал логоны загвар, санааг гарган Улаанбаатар хотод Logo design/ Лого дизайнаар 150,000 төгрөгөөр эхийг бэлтгүүлэн, хэвлүүлж авч, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

-Баримт бүрдүүлэх: Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны бичиг баримтыг “Түр хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”, “Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”, “70 жилээр хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”-ыг архивын 20 нэгж болгон бүрдүүлэв. Мөн “Архивын баримтын тооллого хийж, бүрдүүлэлтийг сайжруулах тухай” хугацаатай үүрэг даалгаврыг байгууллагын архивын ажилтанд өглөө.

-Засвар, тохижилт: Архивын өрөөг тохижуулж, цонхны тавцан, таазыг засварлаж, стандартын шаардлага хангах төмөр хаалгатай боллоо.

-Сургалт, мэдээлэлд хамрагдах: 2023 онд ирэх Архивын улсын үзлэгт бэлтгэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Хууль, эрхзүйн хэлтсийн Төрийн архивын тасгийн зөвлөн туслах шалгалтад хамрагдаж зөвлөгөө мэдээлэл авч, Архивын ажилтан нь “Архивын цахим систем нэвтрүүлэх” цахим сургалт болон Архивын байгууллага үүсэж хөгжсөний 95 жилийн ойд зориулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны “Бага чуулган”-д Сүхбаатар суманд тус бүр хамрагдлаа.

12.4 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг хангах: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажилд бэлдэх тухай” 09 дүгээр тогтоолын дагуу байгууллагын Захирлын 2022 оны 05 сарын 14-ний өдрийн А/47 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажилд бэлдэх тухай” тушаалыг гаргаж, бэлтгэл ажлыг хангаан 2022.05.16-ны өдөр тооллогод хамрагдлаа. Тооллогын ажлын дүнгээр байгууллагын эзэмшлийн автомашины ашиглалтын бүртгэлийн дэвтэр, барилгын ашиглалтын бүртгэлийн дэвтэр, хашааны зохион байгуулалтын палан зураг зэргийг даруй гаргаж, 2022.05.25-ны өдөрт багтаан тооллогын комисст ажлын үр дүнг мэдэгдэх даалгаврыг авч хэрэгжилтийг хангаж байна.

Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, аюулгүй ажиллагааг хангах, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, үндсэн үүргийн биелэлтийг ханган ажиллуулахын тулд байгууллагын Захирлын 2022 оны 05 сарын 14-ний өдрийн А/48 тоот тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон, байгууллагын Захирлын зүгээс тус зөвлөлийн ажиллах, журам болон жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан гаргаж, баталж өгч, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг 1 удаа хийж, байгууллагын гарааш, агуулахын өрөөг цэгцлэн, бүртгэлгүй бөгөөд ашиглагдахгүй байгаа эвдэрч муудсан эд

хөрөнгүүдийг хаяж устган, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг тоолж, цэгцлэх ажлыг 2022.05.16-17-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сумын ЗДТГ-ын Төрийн сангаас зохион байгуулсан “Цахим нэвтрэлтийн нэгдсэн систем” сургалтад байгууллагын Захирал, нягтлан бодогч нар хамрагдаж, албан хаагчдын цалинг цахим системээр, тоон гарын үсгээр бодох аргад суралцлаа. Мөн “Цахим нэвтрэлтийн систем”-д нэвтрэх байгууллагын Захирлын болон нягтлан бодогчийн мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагаар цахим системд бүртгүүлж, тус системд нэвтрэх цахим хэрэгслийг албан ёсоор хүлээн авч цалингийн гүйлгээг хийж байна.

2022 оны санхүүгийн 3 ш баримтыг Сэлэнгэ аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

Санхүүгийн ил тод байдлыг ханган байгууллагын “Санхүүгийн ил тод байдал”-ын самбарт тайлант оны төсөв, санхүүгийн мэдээллийг тухай бүр 18 мэдээлэл байрлуулж, иргэдийг мэдээллээр хангаж байна.

Төсвийн зарцуулалтыг зохих журмын дагуу явуулж, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, өр авлага үүсгэлгүй ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ авах тухай бүрд нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байна.

“Шилэн данс”-ны мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд бүртгэж 106ш мэдээллийг оруууллаа.

Байгууллагын 2023 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох дээд газарт хүргүүлсэн.

АРВАН ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

13.1 Байгууллагын орчны нөхцөлийг сайжруулан тохижилт, урсгал засварын ажлыг зохион байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх: “Ажлын байраа тохижуулья” бүтээлч ажлын хүрээнд байгууллагын урсгал засвар, тохижилтын ажлыг хамт олны өөрсдийн хүчээр хийж байна. Үүнд:

- "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн, Аймгийн Засаг даргын 2022 оны 01 тоот албан даалгавар, Сумын Засаг даргын 2022 оны 02 тоот албан даалгавар, "МИНИЙ ХОТ-ЦЭВЭР ОРЧИН" аяны хүрээнд байгууллагын хэмжээнд дараах тохижилт, хог цэвэрлэгээ, урсгал засварын ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:

- 2022.05.02-ны өдөр хамт олноороо байгууллагын хашаанд 31ш "Бөөрөлзгөнө" модыг шинээр тарилаа.
- 2022.05.11-ний өдөр хамт олноороо байгууллагын орчинд цэцэгжүүлэлтийн ажлыг хийж, тарьсан мод бутандаа ээлжит усалгаа арчилгааг хийж гүйцэтгэлээ
- 2022.05.12-ны өдөр хамт олноороо байгууллагын хогийн цэгт хуралдсан хог, тайрсан модны мөчир зэргийг ачуулан Төвлөрсөн хогийн цэгт хүргэж, хашааны сүүдрэвчийг засварлан 4 тулгуурыг бэхлэн бетон цутгах ажлыг хийлээ.
- Сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/74 тоот болон 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн А/407 тоот захирамжийн дагуу байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, эрүүл цэвэр орчин бүрдүүлэх зорилгоор “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-нд хамт олноороо 2 удаа оролцож, байгууллагынхаа ойр орчмын 50м хүртэлх газрыг цэвэрлэж, байгууллагын төлөвлөгөөт их цэвэрлэгээг байгууллагаас тогтоосон хугацаанд тогтмол хийж, орчны цэвэр, цэмцгэр байдлыг хангаж байна.
- Байгууллагын хашаанд ургаж буй бүх модонд хаврын тайралтыг хийж, засаж хэлбэржүүллээ.
- Байгууллагынхаа гаднах талбайн модон болон төмөр хашлага, сүүдрэвч, сандал, барилгын цонхны хамгаалалт төмөр зэргийг будаж, цэцгийн мандлыг шохойдож, өнгө үзэмжийг нэмэгдүүллээ.

- Ариун цэврийн өрөөний уян хоолой муудаж, цоорсныг шинээр сольж, Үндсэн

фондын өрөөний номын тавиурууд болон Архивын өрөөний тааз эвдэрч муудсан байсныг засаж янзаллаа.

- Төв үүдний хаалга хуучирч муудсан мөн архивын өрөөнд төмөр хаалга хийх шаардлагатай байсан тул 2ш төмөр хаалга шинээр суулгаж стандартын шаардлага хангасан аюулгүй байдлыг хангалаа.
- Барилгын хавтгай дээвэртэй хэсгийн хар цаасан хучилт хуучирч муудан дусаал ихээр гоожих болсон тул 5900,000 төгрөгийн зардлыг сумын Засаг даргаар шийдвэрлүүлэн хар цаасан хучилтыг төмөр хучилтаар солилоо.
- Мөн барилгын үндсэн хэсэг болох шувуун нуруутай дээврээс дусаал ихээр гоожиж эхэлсэн тул зай завсартай хэсгүүдийг гар аргаар бөглөж усыг түр аргацаан тогтоож байна.
- Ариун цэврийн өрөө болон архивын өрөөний хананы будаг хуурч өнгөө алдсан байсныг засварлан сэргээж будлаа.
- Номын санч бүр ажлын байраа тохижуулах, уншигчдад үйлчлэх орчин нөхцөлөө сайжруулах зорилгоор тус бүр төсөл бичиж, хэрэгцээт тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгааг гаргаж байна. "Хүүхдийн уншлагын танхим", "Нийтийн уншлагын танхим", "Хүлээлгийн танхим", "Шатны хэсэг" гэсэн чиглэлд нийт 4ш төсөл боловсруулагдаж дуусахаар төсөл хөтөлбөрийн байгууллагуудад дэмжлэг хүсэн хүргүүлнэ.
- Байгууллагын бохирын цооногийн хучилт борооны

усанд элэгдэж, хагаран цоорхойгоор нь цас, борооны ус орж, цооногийг дүүргэж байсныг засаж янзаллаа.

- Байгууллагын гадна байрлах сантехникийн төв шугам муудаж, ашиглалтын шаардлага хангахгүй болж, цаашид засаж сэлбэх боломжгүй болж, аюулгүй ажиллагаа маш ноцтой алдагдсан тул 2015 онд холбогдох мэргэжилтнээр хийлгэсэн "Сантехникийн шугамын засварын төсөв"-ийг шинэчилж гаргуулахаар холбогдох мэргэжилтэнд хандаад байна. Тус төсвийг бэлэн болохоор Аймаг, сумын Засаг даргад тус бүрд хүсэлт гаргаж, санхүүгийн дэмжлэг хүснэ.
- Байгууллагын хаяг, хаягжилтыг сайжруулж, "*Монгол* бичгийн үндэсний *хөтөлбөр* III"-ыг хэрэгжүүлэх үүднээс кирил, уйгуржин бичиг хосолсон загвараар хаяг, хаягжилтаа шинэчлэн өрөө, тасалгааны 7ш хаягийг хэвлүүлж, байрлуулан, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.
- Байгууллагын ариун цэврийн өрөөний ханыг бүхэлд нь буюу нийт 16,6м2 ханыг "эко" хавтангаар доторлож, өнгө үзэмжийг сайжруулан, албан хаагчид болон уншигч, үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангалаа.
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын 2022

оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 02/270 тоот албан бичгээр үүрэг болгон ирүүлсэн "Хүүхэд төвтэй гамшгийн эрсдэлийг бууруулах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж ажиллах" загвар төлөвлөгөөний хүрээнд байгууллагын өвөлжилтийн бэлтгэлийг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулж, уншигч үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор хуучирч муудсан хаалгыг шинэчлэн сольж, цонхны дулаалга хийж, халаалтын шугамд үзлэг хийж, ус шүүрч байсан хэсэгт боолт тавьж, хэвийн ажиллагааг хангаж байна. Мөн өвлийн улиралд орчны цэвэрлэгээг хийх хэрэгцээт багаж хэрэгслийг бэлтгэж, өвөлжилтийн бэлтгэлийг хангалаа.

- Коридорын цонхонд тус бүр нь 189,000 төгрөгийн үнэ бүхий 2 ш хөшгийг нийт 378,000 төгрөгийн хандиваар шинээр авч байрлуулан өнгө үзэмжийг сайжрууллаа.
- Нийт 177,500 төгрөгийн үнэ бүхий 26 ш тасалгааны цэцгийн савыг мөн хандиваар авлаа.

- Шатны хөндийн өрөөний гэрэлтүүлгийг сайжруулж, мэдрэгчтэй лед гэрэл 1ш, утас далдлагчийн хамт 39,500 төгрөгөөр авч суурилуулж, хүүхдийн уншлагын танхимын гэрэлтүүлгийг засварлалаа.
- "Хүүхдийн уншлагын танхимын тохижилт"-ыг хийж, уншигч хүүхдүүдийн таашаалд нийцсэн орчинг бүрдүүлэх зорилгоор 1ш нь 89,900 төгрөгийн үнэ бүхий хүүхдийн сэдэвт зурагтай шалны дэвсгэр нийт 2ш-ийг 179,800 төгрөгөөр, 1ш нь 89,000 төгрөгийн үнэ бүхий 4ш номын тавиурыг нийт 4ш-ийг 356,000 төгрөгөөр, 1ш нь 38,000 төгрөгийн үнэ бүхий жижиг модон ширээ 2ш-ийг 76,000 төгрөгөөр, 1ш нь 16,000 төгрөгийн үнэ бүхий газар тавьж суудаг зөөлөн дэр нийт 4ш-ийг 67,200 төгрөгөөр худалдан авч хүүхдүүдийг газар сууж, хэвтэж ном унших чөлөөт уншлагын булан гаргаж тохижууллаа. Мөн 1 боодол нь 30,000 төгрөгийн үнэ бүхий тавилгын зориулалттай өнгийн хуулга (5м х 60см хэмжээтэй) нийт 3ш-ийг 90,000 төгрөгөөр худалдан авч 18ш ширээний тавцанд нааж, 1ш нь 8000 төгрөгийн үнэ бүхий нийт 16ш сандлын углаа даавуур 128,000 төгрөгөөр тус бүр худалдан авч сандал, ширээний өнгө үзэмжийг сайжруулан, бусад жижиг тохижилтыг хийж, хүүхдийн сонирхол татахуйц, тав тухтай орчинг бүрдүүллээ.
- Нэг бүр нь 120,000 төгрөгийн үнэ бүхий ус буцалгагч 2ш-ийг нийт 240,000 төгрөгөөр, 1ш нь 38,000 төгрөгийн үнэ бүхий нийт 2ш ус шүүгч баллоныг 76,000 төгрөгөөр, цайны аяга 4ш-тэй 1 сетийг 9500 төгрөгөөр тус бүр хандиваар худалдан авч, Хүүхдийн болон Нийтийн уншлагын танхимд байрлуулан, уншигчдыг халуун, хүйтэн усаар хангах ажлыг зохион байгууллаа.

Нийт 1222,500 төгрөгийн зардлыг ХУТ-ын тохижилтод хандивын журмаар шийдвэрлэлээ.

13.2 "Номын сангийн шинэ барилгын зураг төсөв"-ийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, барилга баригдах хөрөнгийг шийдвэрлүүлэх асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилсан байна:

"Номын сан-музей-залуучууд хөгжлийн төв" бүхий соёлын байгууллагуудын цогцолбор барилга баригдах ажил Сумын Засаг дарга болон Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж доорх ажлуудыг 2020-2021 онд хийж гүйцэтгэсэн.

- Барилгын зураг, төсвийг боловсруулах 100 сая төгрөгийн төсөв нь Сумын засаг даргын дэмжлэгтэйгээр батлагдан шийдвэрлэгдлээ.
- Барилгын зураг, төсвийг Улаанбаатар хотын "Алтай газрын хүч" компанид боловсруулж байгаа бөгөөд тус компаний захирал, төлөөллүүд ирж барилга баригдах газартай танилцлаа.
- Мөн тус барилгыг барих газрын асуудал нь Сумын Засаг даргын дэмжлэгтэйгээр Ширхэнцэг хайрхан уулын бэлд баригдахаар шийдвэрлэгдлээ.
- Барилгын эскиз зургийн ажил дуусаж бэлэн болсон одоогийн байдлаар ажлын зураг хийгдэж байсан боловч "Алтай газрын хүч" ХХК нь ажил удаашруулж, холбоо харилцаа муу ажиллаж байгаа тул Сумын ЗДТГ-аас тус компанид ажлын гэрээг цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлээд хариуг хүлээж байна.
- Ширхэнцэг уулын бэл дэх газрын дэвсгэр зургийг Аймгийн барилга, хот байгуулалтын газраас авч Алтай газрын хүч ХХК-д явуулсан.
- Барилгын эскиз зургийг урьдчилсан байдлаар Аймгийн Барилга, хот байгуулалтын газрын Ерөнхий архитектороор батлуулсан боловч тус барилга баригдах газар нь сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ороогүй тул газар олголтын Үндэсний "Urban.gov.mn" цахим сайтад бүртгүүлэх боломжгүй байгаагаас газрын албан ёсны батлгаажуулалт 2022 оныг хүртэл хойшлоод байна.
- "Алтай газрын хүч" компани нь зураг, төсвийн ажлыг удааж, шалтгаан нь тодорхойгүй байгаа тул сумын зүгээс тухайн компаниас гэрээгээ цуцалж, ахин тендер зарлах тухай хариуг өгч байсан.

Гэвч дээрх ажил нь одоогийн байдлаар шийдвэрлэгдээгүй, дэмжлэг аваагүй байдалтайгаар зогссон байдалтай байна.

АРВАН ДӨРӨВ: ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

14.1 Дээд шатны байгууллага удирдлагаас өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг хангах, номын сангийн үйл ажиллагаанд холбогдох тайлан

мэдээг тухай бүр гаргах: Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөө, Үндэсний зорилтот хөтөлбөрүүд болон бусад холбогдох эрхзүйн баримтын хүрээнд зохион байгуулсан ажлын биелэлт, байгууллагын сар, улирал, жилийн ажлын мэдээ, тайлан, холбогдох судалгаа зэрэг мэдээ, тайлангуудыг тухай бүр, хуулийн хугацаанд гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж байна. Үүнд:

- Номын сангийн үйл ажиллагааны 2022 оны 1-4 дүгээр улирлын судалгаа- Аймгийн Соёл, урлагийн газарт
- 2021 оны хөрөнгө санхүүгийн мэдээ- Аймгийн Соёл, урлагийн газарт
- “Үндэсний соёлын байгууллагад тооцох шалгуур үзүүлэлт судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- “Номын сангийн тоног, төхөөрөмжийн судалгаа”-г- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Соёлын яамны 2022 оны календарчилсан төлөвлөгөөнд оруулах СОНА-ын саналыг- Соёлын яаманд
- Соёлын байгууллагын албан хаагчдад олгох 5 жилийн тэтгэмжид хамрагдах болзол хангасан 3 албан хаагчийн судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Сарын ажлын мэдээг- Сумын ЗДТГ-т
- Албан хаагчдын амьжиргааны тухай дэлгэрэнгүй судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- “Соёлын бүтээлч сар”-ын тайлан, мэдээг-Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын “7 хоногийн үйл ажиллагааны тойм”-ыг тухай бүр-Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын 2023 оны төсвийн хязгаарыг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын улирал, хагас жилийн болон бүтэн жилийн тайлан, мэдээнүүдийг холбогдох дээд газруудад гэх мэт тухай бүр, хугацаанд нь тус тус гарган хүргүүлж байна.
- Мөн номын сангийн үйл ажиллагаатай сумын Засаг дарга, нийгмийн бодлогын мэргэжилтэн нар ирж танилцаж, санал бодлоо солилцлоо.

14.2 Төв, орон нутгаас зохион байгуулж буй цаг үеийн шаардлагатай ажил, хурал зөвлөгөөн болон Бүх нийтээр мод тарих ажил, хог цэвэрлэгээний ажилд байгууллага хамт олноороо оролцох:

- **Сумын соёлын өвийг баримтжуулах ажил:** Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны Академийн түүх угсаатны зүйн хүрээлэнгээс соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, дүрсжүүлэх ажлын хэсгийн Мандал суманд ажиллах ажлыг хариуцан зохион байгуулж Сумын түүхийн архив болсон өргөн их мэдлэгтэй өв соёлоо өвлөн хадгалагч Цэнд-очир, уртын дууч ардын авьяастан Алтангэрэл нарын ярилцлага, дүрсжүүлэлтийг хийлгэлээ.
- **Нийтийн хог цэвэрлэгээнд оролцох тухай:** Аймгийн Засаг даргын 2022

оны 01 тоот албан даалгавар, Сумын Засаг даргын 2022 оны 02 тоот болон 01/355 тоот албан даалгавар, "Миний хот-цэвэр орчин" аяны хүрээнд Сумын Засаг даргын захирамжийн дагуу” Нийтийн хог цэвэрлэгээ”-ний ажилд 2022.05.06-ны өдөр 1 удаа, 2022.05.20-ны өдөр 1 удаа, нийт 2 удаа оролцож, Төвлөрсөн хогийн цэг-ийн зүүн талд давхардсан тоогоор 15 хүн хамт олноороо цэвэрлэгээ хийлээ.

“Илүүдэл жингүй- Эртэч Монгол” аян: “Илүүдэл жингүй эртэч Монгол” аян, “Эрүүл мэндийнхээ төлөө, Алхангаа ярилцъя, “Хариад амрая-Хамтраад шийдье”, “Цэх байя-Цэгцтэй хооллоё” арга хэмжээнүүдэд байгууллага хамт олноороо зохион байгуулалттай оролцож, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих ажлуудыг төлөвлөгөөтэй зохион байгуулж, “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аянд номын сангийн хамт олон нэгдэж, Мандал сумын “Ширхэнцэг хайрхан уул”, “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-рүү өглөөний алхалтыг хийлээ.

- **“Ном хож” нэвтрүүлэгт оролцох:** Соёлын яамнаас санаачлан зохион байгуулж буй, Үндэсний телевиз MNTV-н "Ном хож" нэвтрүүлэгт номын сангаас оролцож, тус нэвтрүүлгийн 1 асуултыг видео хэлбэрээр бэлтгэн явууллаа.
- Мөн Соёлын яам, Хүүхдийн төв номын сангийн урилгаар тус "Ном хож" нэвтрүүлэгт 1 уншигч хүүхдийг оролцуулан Улаанбаатар хот руу явах унаа, хоол, байрны 90,000 төгрөгийн зардлыг байгууллагаас гарган шийдвэрлэлээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай: Сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 09-ний өдрийн А/135 тоот захирамжийн дагуу байгууллагын Захирлын 2022 оны 05 сарын 18-ны өдрийн А/43 тоот “Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай” тушаалыг гаргаж, тухайн ажлыг хариуцуулан зохион байгуулахаар байгууллагын “Аж ахуйн алба”-ны ахлах, няравт үүрэг болгож, байгууллагын хашаанд 31 ширхэг бөөрөлзгөнө модны бут тарилаа. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны “Бүх нийтийн мод тарих арга хэмжээ зохион байгуулах тухай” А/380 дугаар захирамжийн дагуу 2022 оны 10-р сарын 8-ны өдөр “Хараа” голын эрэг орчимд 10 ширхэг бургасны суулгацыг суулгаж, усаллаа. Мод тарилтад 7 албан хаагч оролцлоо.

“Миний хот-Цэвэр орчин” сарын аяны хүрээнд ажил зохион байгуулах **тухай:** Сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 02-ны өдрийн 02 тоот албан даалгаврын хүрээнд байгууллагын Захирлын 2022 оны 05 сарын 13-ны өдрийн А/44 тоот “Миний хот-Цэвэр орчин” сарын аяны хүрээнд ажил зохион байгуулах тухай” тушаалыг гаргаж, байгууллагын хэмжээнд холбогдох ажлыг зохион байгуулахыг “Аж ахуйн алба”-ны ахлах, няравт үүрэг болгож, байгууллагын хашааны тохижилт, цэвэрлэгээ, мод, цэцэг тарих, урсгал засвар хийх, сумын нийтийн хог цэвэрлэгээнд оролцох зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Сумын түүх, соёлын холбогдолтой бүтээл, үзмэр, материал зэргийг гаргаж, Аймгийн ЗДТГ-т хүргүүлэх тухай: Сумын Засаг даргын Тамгын газраас 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Нийтийн номын санд цохон ирүүлсэн Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01/475 тоот албан бичгийн дагуу Сумын түүх, соёлын холбогдолтой бүтээл, үзмэр, материал зэргийг гаргаж, Аймгийн ЗДТГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулах ажилтай холбогдуулан байгууллагын Захирлын 2022 оны 05сарын 13-ны өдрийн А/45 тоот “Сумын түүх, соёлын холбогдолтой бүтээл, үзмэр, материал зэргийг гаргаж, Аймгийн ЗДТГ-т хүргүүлэх тухай” тушаалыг гаргаж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

- **Сумын “ДӨЛ” тэмцээний шүүгчээр ажилласан тухай:** 2022.05.06-ны өдөр Сумын ЗДТГ-ын даалгаврын дагуу сумын “ДӨЛ” тэмцээний шүүгчээр Нийтийн номын сангийн албан хаагч-3, Хүүхдийн ордны албан хаагч-3 нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, асуулт хариултын тэмцээн, цахим контент, эссэ бичлэгийн уралдаануудыг хариуцан зохион байгуулж, бэлтгэл ажлыг хантан, шүүж, оноо байрыг эзлүүлэх ажлыг хийлээ.
- **Соёлын салбарын залуучуудын хөгжлийн аймгийн салбар зөвлөлд**

оролцох: Соёлын яамнаас санаачлан зохион байгуулж буй “Соёлын салбарын залуучуудын хөгжлийн аймгийн салбар зөвлөл”-д 1 номын санчийг томилон гишүүнчлэлээр элсүүллээ.

- **Хурал, зөвлөгөөнд оролцох:** Сумын удирдах ажилтны зөвлөгөөнд 1 хүн,

аймгийн Соёл урлагийн газрын нээлтэд хамт олноороо, 2022 онд зохион байгуулагдаж буй “Төрийн өмчийн тооллогын ажлын хурал”-д Сүхбаатар суманд 1 хүн, Мандал суманд 2 хүн, Монгол улсад архивын байгууллага үүсэж хөгжсөний 95 жилийн ойд зориулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны “Бага чуулган”-д Сүхбаатар суманд 1 хүн тус бүр хамрагдлаа.

- **Сумын ИТХ-ын 30 жилийн ойн ном эмхэтгэх, хэвлүүлэх ажилд оролцох:**

Байгууллагын Захирал нь сумын ИТХ-ын 30 жилийн ойн ном эмхэтгэх, хэвлүүлэх ажлын комиссын даргаар томилогдон оролцож, ном бүтээх ажилд хувь нэмрээ орууллаа.

- **“Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулилалт”:** Сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/374 тоот албан даалгаврын дагуу зохион байгуулагдах “Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулилалт”-ын сумын ажлын хэсгийн “Сургалт, сурталчилгааны баг”-т Номын сангаас 2 албан хаагч ажиллаж, мэдээллийн хэрэгсэл, узелиэр зарлагдах сэрэмжлүүлэг, зарыг бичүүлэх, зарлуулах ажлыг хариуцаж, байгууллагын хамт олон болон иргэдийг сургалт, сургуулилалтад хамруулах ажилд оролцож байна. Мөн тус ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Гамшгаас сэргийлэх сургалт, мэдээлэл”-д байгууллагаас 5 хүн, 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан “Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлт”-ийн дадлага, сургуулилалтад 5 хүн тус бүр хамрагдлаа.
- **“Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” –ийн арга хэмжээнд оролцох:** Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах сумын ажлын хэсэгт оролцож, Нийтийн номын сангаас Соёмбот талбайд “Номын хотхон” зохион байгуулж, “Хүүхдийн ертөнц” гар зургийн уралдаан, “Асуулт, хариултын уралдаан”, “Уран бичлэгийн уралдаан”, “Хүүхдийн номын үзэсгэлэн”, “Номын худалдаа” гэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, идэвхтэй оролцсон 16 хүүхдийг гарын бэлгээр урамшууллаа.
- **Аймгийн баяр, наадмын нээлтэд оролцох:** Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяр, наадмын нээлтийн үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн соёл, урлагийн салбарын албан хаагчдын хамт нээлтийн жагсаал, урлагийн арга хэмжээнд хамт олноороо оролцож ажиллалаа.
- **Сумын баяр, наадмын нээлтэд оролцох:** Ардын

хувьсгалын 100, 101 жилийн ой, Сэлэнгэ аймгийн 91 жилийн ой, Мандал сум үүсэн байгуулагдсаны 98 жилийн ойн баяр, наадмын нээлтийн жагсаалд хамт олноороо оролцлоо.

- **“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд ажил зохион байгуулах:** 2022.11.01-

2022.11.30-ны өдрүүдэд Соёлын яамнаас зарласан “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд байгууллагын төлөвлөгөөнт соёл олон нийтийн ажлууд болон нэмэлтээр доорх ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

<u>Чингис хааны эш хөргийг залах:</u> “Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” Монгол улсын ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 159 дүгээр зарлигийн хүрээнд монгол туургатны бахархал болсон Эзэн Чингис хааны эш хөргийг байгууллагын хүндэтгэлийн хойморт хүндэтгэн заллаа.

<u>“Монголын нууц товчоог сурталчлах” ажил:</u> “Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай” Монгол улсын ерөнхийлөгчийн 2004 оны 02 дугаар сарын 18-ны өдөр 23 дугаар зарлигийн хүрээнд Монгол улсын түүхийн баримт, дурсгалыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, сурталчлах зорилгоор "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО" номын үзэсгэлэн, танилцуулга ярианд 35 хүүхдийг хамруулж, мэдээлэл өгсөн нь монгол үндэстний түүхийн талаарх хүүхдүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил боллоо.

<u>“Монгол бичиг минү”:</u> “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хүрээнд хүүхэд багачуудад зориулагдсан уйгуржин монгол бичгээр хэвлэгдсэн 21ш номоор “Монгол бичиг минү” сэдэвт номын үзэсгэлэнг цахимаар болон танхимаар зохион байгуулж, танилцуулга,

мэдээлэл хийж, 102 хүнийг хамруулсан үндэсний бичиг, соёлоо сурталчлах ач холбогдолтой ажил боллоо.

- "Соёлын орон зай" хөтөлбөрт оролцох: Сүхбаатар суманд 2022.09.22-2022.09.23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "СОЁЛЫН ОРОН ЗАЙ" зөвлөгөөний нээлтэд оролцож, “Ховор хуучин ном” болон “Ноён уул” фото зургийн үзэсгэлэн гаргалаа. Нийт 72 хүн үзэж сонирхлоо.

- “Номын баяр”-ын арга хэмжээнд оролцох: Хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх зорилгоор 1-р сургуулийн монгол хэлний багш нартай хамтран "Номын баяр"-ын арга хэмжээг зохион байгуулж, "Номын сангийн танилцуулга", "Шинэ ном"-ын болон "Ноён уул-Түүх соёлын дурсгал болох нь" номын үзэсгэлэн, "Номын санчийн мэргэжил сурталчлах" , “Шинэ уншигчийн карт нээх”, “Өвөрмөц нэгэн захидал" ажлуудад 227 хүнийг хамруулсан нь сурагчдад номын сангийн үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг ач холбогдлыг сурталчилж, шинэ номын мэдээллийг цаг алдалгүй хүргэсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

- Олон нийтийн лекцэд хамрагдах: 2022.10.03-ны өдөр Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын байранд явагдсан “Гэр бүлийн үнэ цэнэ- монгол хүний ёс жудаг” олон нийтийн лекцэд хамт олноороо 7 албан хаагч хамрагдлаа.

-“Зөв найруулж, бичиж сурцгаая” уралдаанд: Аймгийн Засаг даргын 2022.10.12-ны өдрийн 01/1371 тоот “Аян өрнүүлэх тухай” албан даалгаврын дагуу сумын төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, албан хаагчдын дунд “Бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан бичиг хэрэг хөтлөлтийг сайжруулах зорилгоор зохион байгуулж, удирдамжийн дагуу хийсэн ажлын тайланг ирүүлсэн 2 байгууллагыг нийт 350,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

-Улаан загалмайн нийгэмлэг”-ийн гишүүнчлэлд хамрагдсан тухай: Нийтийн номын сан нь сумын ИТХ-ын санаачилгаар Монголын Улаан Загалмайн нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулж, хамт олноороо МУЗН-ийн гишүүнээр элсэж, нийт 9 албан хаагчийн гишүүнчлэлийн жилийн татвар 54,000 төгрөгийг төлж, МУЗН-ийн талаарх мэдээллийг албан хаагчдад олгох зорилгоор “Улаан загалмайн нийгэмлэгийн тухай” ажлын байрны сургалт, мэдээлэл бэлтгэж 1 удаа, 8 албан хаагчийг бүрэн хамруулж, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зорилгоор МУЗН-ийн Facebook хуудсанд албан хаагч бүр лайк дарж нэгдэж мэдээлэл авах, Монголын улаан загалмай нийгэмлэг вэб хуудсаар мөн зочилж, уншиж танилцах талаар албан хаагч бүрд уриалан ажиллаж байна. Цаашид Улаан загалмайн нийгэмлэгийн зорилго, зорилтын хүрээнд нийгмийн хариуцлагаа үндэслэн нийгэмлэгийн ажилд идэвхтэй оролцох, иргэдэд мэдлэг түгээх, шаардлагатай хэсэгт тусламж хүргэх, гишүүн байгууллагын хувьд санаачилгатай ажиллаж, чадваржих ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

14.3 Ой хээрийн түймэр болон гамшгийн үед бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллах: Ой хээрийн түймэр, гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, болзошгүй аюулаас сэргийлэх албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэн мэдээлэл хүргэж, “Гамшгийн

зарлан мэдээллийн дохио"-оор 1 удаа байгууллагын хэмжээнд дадлага сургуулилалт хийж, 1 удаа Сумын дадлага сургуулилтад хамт олноороо оролцлоо. Сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил"-ыг зохион байгуулах тухай А/58 тоот захирамжийн дагуу сумын ЗДТГ-ын байранд жижүүрээр ажиллах албан хаагчдын хуваарийг Нийтийн номын сангийн Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/35 тоот тушаалаар батлан хуваарь ёсоор ажиллалаа.

Гамшгийн эрсдэлийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх үүрэг бүхий "Гамшгаас хамгаалах штаб"-ыг Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/31 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг үүрэг болголоо. Мөн Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/52 тоот тушаалаар тус штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруууллаа.

14.4 Хамт олны идэвх, санаачилгыг өрнүүлж, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтод бүлгийн 1 өрхийг дэмжиж ажиллах: Өрхийн амьжиргааг дээшлүүлэх бодлогын хүрээнд 1 хүнийг ажлын байраар хангаж дэмжлэг туслалцаа үзүүллээ. Цаашдаа номын сангийн мэргэжлийн дагуу сургаж, дэмжих зорилт тавин ажиллаж байна.

14.5 Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг сайжруулан, эрчимжүүлэх: Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-өөс "Хүүхдээ сонсъё-II" аяныг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж эхлэн, "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сургалтыг 1 удаа ажлын байранд зохион байгуулж, 8 албан хаагчийг хамрууллаа.

14.6 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлсэн хамт олон болох: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдыг ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлээс хамгаалах зорилгоор байгууллага дээр "Аж ахуйн алба", "Ёс зүйн зөвлөл", "Дотоод хяналтын комисс", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй"-г хариуцсан ажилтныг тус бүр томилон ажиллуулж байна. Үүнд:

-Бүх нийтээр амрах өдрүүдэд байгууллагын хариуцлагатай жижүүрийг тухай бүр томилж ажиллуулж байна. Уламжлалт цагаан сарын баяраар хариуцлагатай эргүүл жижүүрүүдийг хуваарийн дагуу ажиллуулж сумын тамгын газрын 70367010 утсанд өдөрт гурван удаа мэдээгээ өгч ажиллалаа.

-Хүчирхийлэл, гэмт хэргээс сэргийлэх сурталчилгааны хуудсыг байгууллагын мэдээллийн самбарт байрлуулан мэдээлэл түгээдэг.

-Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай заалтуудыг оруулж, мөрдөж, дотоод хяналтыг тогтмолжуулан ажиллаж байна.

Номын сангийн барилга нь сумын төвийн яг төв хэсэгт томоохон зах, худалдаа, үйлчилгээний байгууллага, Коллежийн орчимд байрладаг тул хүний хөл хөдөлгөөн их, архи ууж, гадуур тогтмол бөөгнөрөн цуглардаг иргэд номын сангийн хашаанд өдөр бүр тогтмол орж ирдэг тул гэмт хэрэг зөрчил гарч болзошгүй эрсдэлтэй бүсэд үйл ажиллагаа явуулдаг. Мөн уншигч, үйлчлүүлэгч нар олонтой байгууллага юм. Иймд:

-Байгууллагын харуул, хамгаалалтын үүргийг гүйцэтгэдэг жижүүрүүд анхаарал болгоомж, сонор сэрэмжтэй ажиллаж, байгууллагын орчинд гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх хяналтыг тогтмол тавьж, болзошгүй нөхцөл байдал үүсэхэд цагдаагийн байгууллагад шуурхай мэдэгдэж ажиллаж байна.

-Камерын хяналтыг тогтмол хийдэг бөгөөд 15 хоногийн бичлэгийг хадгалдаг 8ш камераар орчны бичлэгийг 24 цагийн хугацаанд хийж байна. Бичлэгт хяналт, үзлэг хийж, протокол хөтөлдөг.

АРВАН ТАВ: ХУУЛЬ ЭРХЗҮЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

15.1 Төрийн болон номын сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, албан хаагчдын ажлын хариуцлага, биелэлтийг сайжруулах:

Төрийн албаны хуулийг хэрэгжилтийг хангаж, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хамт олны эв нэгдлийг дээдлэн, иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээг бэхжүүлэх үүднээс Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон байгууллагын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Удирдлагын баг”, “Мэргэжил-аргазүйн алба”, “Аж ахуйн алба”, “Гамшгаас хамгаалах штаб”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус байнгын комисс” гэсэн ажлын хэсгүүдийг шинээр байгуулан томилж, “Дотоод хяналтын комисс”, “Баримт бичиг нягтлан шалгах комисс”, “Эцэг, эхийн зөвлөл”, “Ёс зүйн зөвлөл”, “Ариутгал халдваргүйтгэлийн баг”, “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл” гэсэн ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, жилийн ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаа явуулах журмаа баг, комисс, зөвлөл тус бүр гарган байгууллагын Захирлаар батлуулж ажиллахыг үүрэг болголоо.

Байгууллагын “Тайлангийн үр дүнгийн хурал”-ыг зохион байгуулж, ажлын үр дүнд дүгнэлт хийн, албан хаагчидтай мэдээлэл солилцон, засаж сайжруулах ажлын талаар ярилцан тус тусын чиглэлд үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хууль, Соёлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиуд 2022 онд шинэчилсэн найруулгаар хэрэгжиж эхэлсэн тул байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дараах эрхзүйн баримт бичиг, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдөж эхлээд байна. Үүнд:

- “ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ”- нийт 23 хуудас (Нийтийн номын сангийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/23 дугаар тоот тушаалаар баталсан)
- “ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ”- нийт 9 хуудас
- “НУУЦЛАЛЫН ГЭРЭЭ”-нийт 6 хуудас
- “НИЙТИЙН НОМЫН САНГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”- нийт 31 хуудас (Нийтийн номын сангийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/23 дугаар тоот тушаалаар баталсан)
- “УНШИГЧДАД ҮЙЛЧЛЭХ ЖУРАМ”- нийт 2 хуудас (Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/19 дугаар тоот тушаалаар баталсан) гэх мэт.

Байгууллагын албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэлд анхан шатанд нь хяналт тавих зорилготой Номын сангийн Мэргэжил -аргазүйн албаны номын санчдын болон аж ахуйн албаны албан хаагчдын "Эртэч уулзалт"-ыг зохион байгууллаа. Албан хаагчдын ажил үүргийн биелэлтийн үр дүнг тооцон “Эртэч уулзалт” арга хэмжээг 4 удаа зохион байгуулан ажлын явц, үр дүн, шинэ арга туршлагаа харилцан ярилцлаа.

Иргэдэд номын сангийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй хүргэх, уншигчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор “Ээлдэг харилцаа, ээлтэй үйлчилгээ” уриан дор номын сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Уншигчаа сонсъё” аян, “Хөтөч номын санч”-ийн үйлчилгээгээр дамжуулан уншигчдадаа хүрч үйлчилж, “Үйлчилгээний ажилтны авир төрхийн шаардлагууд”-ыг дагаж мөрдөн, төрийн албан хаагчийн мөрдөх зарчим, журам, ёс зүйн талаарх мэдээллүүдийг албан хаагчдын өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээнд нь хувилан тарааж, мэдээллийн самбарт байрлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022.03.03-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын “Төр төсвийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үр дүнг үнэлэх тухай” шалгалтад хамрагдаж, байгууллагын үйл ажиллагааг шалгуулж, байгууллагын Захирал хууль, эрхзүйн тестийн шалгалт өглөө.

15.2 “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг сайжруулах нь” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын хууль, эрхзүйн мэдлэгийг нэмэгдүүлэх: “Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга” цахим мэдээллийг байгууллагын албан хаагчдад 1 удаа хүргэж, 8 албан хаагчийг, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт ажлын байрны сургалтад 1 удаа, 8 албан хаагчийг тус тус хамрууллаа.

Байгууллагын “Хуулийн мэдээллийн сан”-г нэмэгдүүлэн баяжуулж, цэгцлэн эмхэтгэж, 5 хэсэг болгон төрөлжүүлэн, товьёг үйлдэн хавтаслаж, үдсэн нь гарын дор хэрэглэхэд хялбар үр дүнтэй ажил боллоо.

15.3 Төрийн албан хаагчийн ёс зүйг сахиж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх: Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын дагуу төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага, дэг журмыг чанд сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн, хүний эрх, жендерийн эрх тэгш байдлыг дээдлэн, алдаа дутагдал гаргахгүй ажиллах талаарх мэдээллийг албан хаагчдад тогтмол хүргэн сануулж, байгууллагын дотоод журамд тусган, боловсон хүчинтэй холбоотой тушаал шийдвэрт тогтмол оруулж, албан хаагчдыг албан томилолтоор ажиллах болон бусад шаардлагатай үед “Ёс зүйн зааварчилгаа”-г тогтмол бичгээр гарган өгч танилцуулан, уншуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулан, ээлжит болон ээлжит бусаар ёс зүйн зааварчилгааг тогтмол өгч гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Хичээлийн шинэ жилийг угтан “Соёлч, бүтээлч хамт олон болох” уриан дор “Бие биенээ хүндэтгэж, харилцаа хандлагаа дээшлүүлье” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг 1 удаа зохион байгуулж, 5 албан хаагчийг хамрууллаа.

Байгууллагын ёс зүйн зөвлөлийг Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 тоот тушаалаар шинэчлэн 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үйл ажиллагаа явуулж байна.

12 дугаар сард байгууллагын “Ёс зүйн сарын аян”-г зарлаж, ёс зүй, харилцаа хандлагаараа хамт олондоо үлгэр жишээ болсон албан хаагч С.Цэндсүрэнг байгууллагын Өргөмжлөл, 100,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Хувь хүний хөгжлийг дэмжих талаар “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалт, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалтад 2 удаа албан хаагчдыг хамруулж, мэдлэгийг нэмэгдүүллээ.

Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн ажлын тайлан мэдээг гаргаж, холбогдох дээд газарт хүргүүллээ.

15.4 Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд ил тод, шуурхай хүргэх: “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг хангаж, цахим орчинд, Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээлэл болон СОНА-ын талаарх мэдээллийг Сэлэнгэ Мандал номын сан цахим хуудсанд 40 удаа тус тус оруулж 625 хандалттай ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээлэл болон СОНА-ын талаарх мэдээлэл	40
Нийт 40 удаа 625 хандалт	

Мэдээллийн самбар-т, байгууллагын танилцуулга, уриа, номын сангийн үйлчилгээний журам, Номын сангийн холбогдолтой хууль дүрэм, байгууллагын захирлын тушаал, зөвлөгөө, зөвлөмж, шинэ номын мэдээлэл, сарын мэдээ тайлан зэрэг мэдээллийг 10 удаа шинэчлэн тавьсан.

15.5 Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд аливаа эрсдэлээс хамгаалах мэдлэг олгох мэдээллийг тогтмол хүргэх: Сэлэнгэ Мандал номын сан цахим хуудсанд

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, хүчирхийллийн эсрэг мэдээ мэдээллийг нийт 60 удаа иргэдэд хүргэж, 659 хандалттайгаар ажиллаж байна.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж	**46**
Нийт 46 удаа 409 хандалт	

Хүчирхийлэлд өртөх эрсдэлээс сэргийлэх зөвлөмж	**14**
Нийт 14 удаа 250 хандалт	

15.2.3 “Уншигчаа сонсъё” аяныг уламжлал болгон зохион байгуулах: Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй. Албан хаагчдаас ирүүлсэн 15ш өргөдөл, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж, хариуг шуурхай өгч ажиллаж байна.

Уншигчдын санал, хүсэлтийг сонсох, номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний түвшинд үнэлгээ хийх, ажил сайжруулах үүднээс жил бүр уламжлал болгон “Уншигчаа сонсъё” аяныг зохион байгуулж, уншигч, иргэдээс санал хүсэлт, судалгааг авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

- Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа: Түүврээр 31 хүнээс номын сангийн үйлчилгээ, номын санчдын харилцаа, хандлагын талаар судалгаа, санал хүсэлт ирсэн байна.

№	**Асуулт**	**Хариултын тоо буюу нийт 31 хүний сэтгэгдлээс эзлэх хувь**		
		Тийм	хааяа	үгүй
1	Та номын сангаар тогтмол үйлчлүүлдэг үү	9 буюу29%	14 буюу45 %	8буюу 26%
				-
2	Номын санчдын үйлчилгээний талаарх таны бодол	21 буюу 68 %	10 буюу 32 %	-
3	Номын санчдын харилцаа, хандлагын талаарх таны бодол	21 буюу 68 %	8 буюу 26%	2 буюу 6%
		Чаддаг	Заримдаа	Чаддагүй
4	Та уншихыг хүссэн номоо тухай бүртээ авч уншиж чаддаг уу	15 буюу 48 %	8 буюу 26 %	8 буюу26%
5	Гэрээр ном олгох үйлчилгээгээр ном зохиолоо авч уншиж чаддаг уу	9 буюу 29 %	13буюу 42 %	9 буюу29%
6	Номын сангийн удирдлагад хүргүүлэх таны санал	Хувцасны өлгүүртэй болмоор байна.Номын сангийн үйлчилгээнд баярласан талархсан сэтгэгдэл ихэнх хувийг эзэлж байна.СОНА-ыг сонирхолтой хэлбэрээр явуулж байгаад сэтгэл хангалуун байна.		

- Санал хүсэлтийн хайрцаг: Санал хүсэлтийн хайрцагаар 5 хүний санал ирсэн нь үйлчилгээний талаарх сэтгэгдэл байлаа.

Шийдвэрлэсэн байдал:

№	**Санал**	**Хийж гүйцэтгэсэн ажил**	**Хүрсэн үр дүн**

1	Хүүхдийн уншлагын танхимын тохижилтыг сайжруулах		Номын санч бүр ажлын байраа тохижуулах, уншигчдад үйлчлэх орчин нөхцөлөө сайжруулах зорилгоор тус бүр төсөл бичиж, хэрэгцээт тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгааг гаргаж байна. "Хүүхдийн уншлагын танхим", "Нийтийн уншлагын танхим", "Хүлээлгийн танхим", "Шатны хэсэг" гэсэн чиглэлд нийт 4ш төсөл боловсруулагдаж дуусахаар төсөл хөтөлбөрийн байгууллагуудад дэмжлэг хүсэн хүргүүлсэн. Хүүхдийн уншлагын танхимыг хүүхдийн сонирхол татахуйц хэлбэрээр тохижуулсан нь уншигч хүүхдүүдийн талархалыг хүлээгээд байна.
2	Компьютер ашиглаж цахим ном унших үйлчилгээтэй болох		Номын сангийн компьютер, техник хэрэгслийг сайжруулах зорилгоор 34 сая төгрөгийн өртөг бүхий "Цахим номын сан" төслийг бичиж, сумын Засаг даргаас дэмжлэг бүхий албан бичигтэйгээр Аймгийн Засаг даргад 2 удаа албан бичиг, Аймгийн СУГ-т 1 удаа албан бичиг, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст 1 удаа албан бичиг явуулж хүсэлт гарган, Аймгийн ИТХ-ын дарга, Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст тус тус танилцуулсан бөгөөд хариуг хүлээж байна. Мөн орон нутгаас төлөөлөл бүхий УИХ-ын гишүүдэд хүсэлт гаргасан.

- Сэлэнгэ Мандал Номын сан цахим хуудас: Мөн байгууллагын цахим хуудсанд уншигчдын сэтгэгдэл бичигдэж байна.
- "Бүх нийтийн соёлын боловсрол"-ын өнөөгийн түвшнийг судлах судлаачдын багийн эрдэм шинжилгээ, бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах зорилгоор хүн амын соёлын боловсролын талаарх нөхцөл байдлыг тандах судалгаанд түүврийн аргаар 40 хүнийг хамруулан судалгаа авч, тайлангийн хамт Аймгийн Соёл Урлагийн Газарт хүргүүллээ.

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН:

Үзүүлэлт		2020 он	2021 он	2022 он	Хувь
Суудлын тоо		**42**	**42**		
Уншигчдын тоо	Шинэ уншигч	1 105	439	1972	449 %
	Ирэгсэд	8 888	1235	8003	648 %
Олгосон номын тоо	Нийт	10 359	1685	11315	191 %
Номын фонд	тоогоор	28 270	28524	29137	2,1%
Шинээр авсан ном	тоогоор	168	254	613	

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго: Мэдлэг оюунд тулгуурласан мэдээллийн эрин зуунд дэвшилтэд техник технологийг ашиглан уншигч, үйлчлүүлэгчдэд хэрэгцээт мэдээллийг нээлттэй хүргэх, Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын санг "Хүний хөгжил-цахим мэдээллийн төв" болгоно.

1.2. Номын сангийн ерөнхий мэдээлэл: Төв аймгийн Нийтийн номын сан нь анх 1944 оны 4-р сарын 28-нд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 54 дүгээр тогтоолоор олон түмэнд ном хэвлэлээр үйлчлэх үйл ажиллагаагаа эхэлж 1989 оны 8-р сарын 1-нд нэг ээлжиндээ 120 хүн хүлээн авах, 100.000 ном байрлуулах хүчин чадалтай зориулалтын байранд шилжин орж үйл ажиллагаагаа явуулж байна. 2016 онд Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын сан болсон. Төв аймаг, БНСУ-ын Пёнтек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2020 онд Пёнтек хотоос 920 сая, ОНТ-өөс 276 сая нийт 1 тэрбум 196 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар шинэчлэл хийгдэн уншигч, үйлчлүүлэгчид мэдээллээ чөлөө олж чөлөөт сонголт бий болгож, тав тухтай орчин бүрлүүлж номын сангийн үйл ажиллагааг 1 дахин нэмэгдүүлж 238 хүний суудалтай болгон өргөжүүлсэн. Орон тооны нийт 13 ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан нь:

- Захирлын өрөө
- Сургалтын танхим
- Лавлагаа мэдээллийн танхим
- Тогтмол хэвлэл
- Насанд хүрэгчдийн уншлагын танхим
- Цахим мэдээллийн танхим
- Нягтлан бодогчийн өрөө
- Архивын өрөө
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр олгох танхим
- Цайны өрөө

Цахим хаяг: "Төв Нийтийн номын сан" – Фейсбүүк хаяг
Library.to.gov.mn – Вэб сайт

Цагийн хуваарь: Даваа - Баасан гаригт 9:00 - 13:00, 14:00-18:00 цаг, /13:00 – 14:00 цайны цаг/

Байгууллагын утас: 70272227

Номын сангийн захирал: Б.Зоригтбаатар

ХОЁР. САН ХӨМРӨГ

2.1. Сан хөмрөгийн баяжилт: Уншигчдын эрэлт хэрэгцээг үндэслэн татгалзлалын дэвтэр хөтөлж тухайн жилийн батлагдсан төсвөөс сан хөмрөгийн баяжилтаа хийж ирсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар төсвийн хөрөнгөөр 3,996,400 төгрөгийн 165ш ном, Хандив тусламжаар 2.801.800 төгрөгийн 265ш ном, Соёлын яамны санхүүжилтээр 4.750.000 төгрөгний 251ш ном нийт 11.548.200 төгрөгний 681ш номоор сан хөмрөгөө баяжуулан электрон каталогт оруулан уншигчдын хүртээл болголоо.

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт: Номын сангийн чухал зүйлийн нэг бол сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт байдаг. Ийм учраас 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Уншлагын танхимуудын сан хөмрөгийн урагдаж гэмтсэн, шаардлага хангахгүй болсон 132 ширхэг номыг өөрсдийн нөөц бололцоог ашиглан сэлбэн засаж, уншлага үйлчилгээнд гаргасан.

2. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт ном, хэвлэл болон тавиурын тоосыг арчиж цэвэрлэсэн.

3. Байууллагын өрөө тасалгаануудад жилд 2 удаа цэвэрлэгээ, ариутгал хийлгэсэн.

4. Шинээр ирсэн 681 ширхэг номыг бүртгэж, 3 танхимдаа хуваарилан танхим тус бүр техник ажиллагаагаа хийж ШУ–ны салбаруудаар тавиурт байрлуулсан.

5. Улирал бүр “Номын санч сэтгүүл” , ”Улирал ба зохниолч” , ”Төрийн мэдээлэл”, “Уламжлал” гэсэн 4 нэр төрлийн 192 ширхэг сэтгүүл захиалж уншигчдад хүргэж хаягжуулж, тогтмол хэвлэлийн фондод байршуулсан.

6. “Өдрийн сонин” , ”Зууны мэдээ” , ”Хүмүүн бичиг” , ”Утга зохиол урлаг” гэсэн 4 төрлийн сонинг захиалан уншигч үйлчлүүлэгчдэд хүргэсэн. “Өдрийн сонин” , ”Зууны мэдээ” сонины 480 дугаарыг сар сараар нь багцлан үдэж, ”Хүмүүн бичиг” сонины 48 дугаарыг багцлан үдэж тус бүр хаягжуулан архивласан.

7. Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй “Анхдугаар таван жил” сонины 1961 оноос 1990 он хүртэлх дугааруудыг хавтаслаж үдэн хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Мөн Байгууллагын www.library.to.gov.mn Вэб сайтад 1961, 1962 оны 72 дугаарыг цахимд оруулан уншигчийн хүртээл болгосон.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ

Нийтийн номын сан нь Насанд хүрэгчдийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр олгох танхим гэсэн 3 танхимаар иргэд, уншичдад үйлчилж 2742 байнгын уншигч, 13524 ирэгсэд, 35285ном, 190 сэтгүүл, 520 сонингоор танхимаар болон гэрээр олгож үйлчилгээ үзүүлсэн.

3.1. Уншлага, үйлчилгээ: Уншлага үйлчилгээг дараах байдлаар тус тус хүргэсэн байна.

1. Насанд хүрэгчдийн уншлагын танхим: 994 байнгын уншигч, 3997 ирэгсэд, 10341 ном танхимаар болон гэрээр олгосон.

2. Хүүхдийн уншлагын танхим: 1100 байнгын уншигч, 5749 ирэгсэд, 16180 ширхэг ном танхимаар олгосон.

3. Гэрээр олгох танхим: 648 байнгын уншигч, 3778 ирэгсэд, 8764 ширхэг ном танхимаар болон гэрээх олгосон.

3.2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: Аймгийн нийтийн номын сан нь Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн иргэд, уншигч, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, цар хүрээг өргөжүүлэх, мөн шинэ номын танилцуулга хийх зорилготойгоор Мөнгөнморьт, Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баянцогт, Баянхангай, Дэлгэрхаан, Бүрэн, Өндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант, Архуст, Сэргэлэн, Баянчандмань, Зуунмод сумын 6-н баг, МСҮТ, УБЦТС-Зуунмод ХҮГ, Нархан хүүхэд хөгжлийн төв, Ахмадын сувилал, ХЦА Сургуулийн Б дотуур байр, ХЦБ Сургуулийн 3б ангийн багш, 016-р цэргийн анги гэсэн байгууллагуудын сургуулийн номын санч нартай хамтран 1-3 сарын хугацаатайгаар “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээг хүргэсэн. Нийт 15 сум, 8 байгууллагын **1702** иргэнд **2257** номыг олгож уншуулсан.

3.3. Цахим номын үйлчилгээ: 1. Байгууллагын цахим хуудсанд электрон каталогоо байрлуулан иргэд, уншигчид орон зай харгалзахгүйгээр **13755** төрлийн **35455** номын мэдээллийг авах боломж бүрдсэн. Мөн байгууллагын Facebook цахим хуудсанд видео мэдээлэл 33, цахим ном 174, хүүхдийн уншлагын танхимаас 52 үлгэр, хөгжөөнт бодлого 37, танин мэдэхүй 184 нийт **480** мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулж **141300** иргэн хандалтаар орж мэдээлэл авсан. Цахим мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор цахим сайтад 39 удаагийн цахим номын үзэсгэлэнг гарган 5947 уншигч, үйлчлүүлэгч зочилж мэдээлэл авсан.



2. Гэртээ хүүхдээ харж байгаа ээжүүддээ зориулаад **“Оюунлаг Эмэгтэйчүүд”** групп чат нээж зөөврөөр болон цахим номын үйлчилгээг хүргэж байна. “Оюунлаг Эмэгтэйчүүд” групп нийт **640** байнгын уншигч гишүүдтэй болж нийт 80ш номоор зөөврийн номын үйлчилгээг хүргэсэн. Ээжүүд номын тэмдэглэл хөтөлж хэвшсэн.

3.4. Номын үзэсгэлэн: 1.2022 онд Нийтийн номын сангийн сан хөмрөгийн төрөл анги болон уран зохиолын номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 20 удаа зохион байгууллаа. “Үндсэн хууль тусгаар тогтнол”, “Бидний эх хэл”, “Монголын гуа хатад”, “Эх орны эзэд”, “Номтой нөхөрлөе”, “Дэлхийн шилдэг зохиолууд”, “Ханс Кристион Андерсений зохиол”, “Үндэсний бичиг соёл”, Монгол ёс заншил” “Хамгийн хамгийн” “Бидний ирээдүй гэрэлтэй сайхан”, “Монгол наадам”, “Эх хэл бидний бахархал”, “Сурагчдын заавал унших зохиол” “Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчдын номын үзэсгэлэн” “Монгол бичиг-ёс заншил, бийрэн бичлэг” зэрэг сэдэвчилсэн 16, шинэ номын 4 удаагийн үзэсгэлэнг 1207 номоор гаргаж 2282 уншигч иргэдэд хүргэсэн.

2.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтаж Нийтийн номын сангаас “Төв аймгийн түүхэн товчоо” номын хандивын аяныг эхлүүлж хувь хүн, албан байгууллагаас 33 ном хандиваар ирж Төв аймгийн холбогдолтой ном, хэвлэл, бүтээлээр сан хөмрөгөө баяжуулж иргэд, хүүхэд багачууддаа сурталчлан таниулах зорилгоор номын үзэсгэлэнг тогтмол хэвлэлийн танхимд нээлттэйгээр 2 сарын хугацаатай 70 номоор номын үзэсгэлэнг гаргасан. Нийт **350** иргэнийг хамруулсан.

3.Төв аймгийн **“Аялал жуулчлалын хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г** боловсруулсан эрдэмтдийн багийн хамт олноос өөрсдийн туурвисан **150** гаруй ном, тохимол, эрдэм шинжилгээний бүтээлээр аялал жуулчлал, ногоон хөгжил буланг “Гэрээр ном олгох танхим”-д тохижуулан уншигчдын хүртээл болгосон.

3.5. Зугаатай зуны хөгжилтэй уншлага: Нийтийн номын сан нь Зуунмод сумын 6 багтай хамтран "ЗУГААТАЙ ЗУНЫ ХӨГЖИЛТЭЙ УНШЛАГА" арга хэмжээг хүүхэд багачуудын дунд

амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд “Номын уншлага” хийж Үлгэрийн ном, Оюун ухаан, Танин мэдэхүй, Адал явдалт номуудыг уншиж, дүгнэлт хийн утга санааг хамтран ярилцлаа. Уншигч хүүхдүүддээ зориулан Шанага долоон одны домог, Үнэг Тогоруу хоёр, Ухаантай хүү, Алтан Шувуу, Нэг төө өвгөн, Нугасны муухай дэгдээхэй, Худалч гүнж зэрэг үлгэрүүдийг дэлгэцээр үзүүлж, үлгэрээс авах сургамж, зерэг ба эсрэг дүрүүдийн тухай харилцан ярилцсан. Мөн “АХА” тэмцээн, эвлүүлдэг “PUZZLE” зэрэг тоглоомуудыг хүүхдүүдийн дунд зохион байгуулахад мэдлэг оюунаа уралдуулан баг хамт олноороо идэвхтэй оролцож байлаа. Арга хэмжээнд оролцсон насанд хүрэгчид болон хүүхдүүдэд номын сангийн уншигчийн картыг үнэгүй нээсэн. Нийт 201 уншигч хүүхэд багачуудыг хамруулаад байна.

3.6. Номын хэлэлцүүлэг: 1.Аймгийн Нийтийн номын сан нь ADRF Mongolia Төв аймаг дахь салбарын багш Б.Түвдэндолгортой хамтран Шуурайн Солонгын “УЛААН СУДАР” номоор 8-12-р ангийн 12 сурагчийн дунд номын хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр Монголын түүхэнд эмгэнэлт улаан толбо болон үлдсэн их хэлмэгдүүлэлт, хэлмэгдсэн эмэгтэйчүүд, лам нарын талаар санал бодлоо солилцсон үр дүнтэй хэлэлцүүлэг боллоо. 2.Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн 12е ангийн сурагч Н.Мөнхзул алдарт зохиолч Ж.К.Роулинг-ийн "Харри Поттер ба Гүн ухаантны чулуу" номоор 8-12-р ангийн 17 сурагчийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан кино болон зохиолын ялгааг харилцан ярилцан өнгөрүүллээ. 3.Төв аймгийн Политехник коллежийн 1-р дамжааны Үсчин, Тогооч, Гагнуурчин, Цахилгаанчин, ЦТТ гэсэн 5 ангийн 47 сурагчдад "Ном уншихын 7-н ач холбогдол"-ын талаар үнэтэй зөвлөгөө өгч “Сохор сэтгэл" богино хэмжээний киног үзүүлж хэлэлцүүлгийг зохион байгууллаа.3 удаагийн хэлэлцүүлгийг 76 уншигч хүүхдүүдийн дунд зохион байгуулсан.

3.7. Зохиолч уншигчдын уулзалт: Төв аймгийн Соёл Урлагийн газар, Нийтийн номын сан, Зуунмод сумын 10 жилийн сургуулиудын 1992 оны төгсөгчид хамтран 2 удаагийн “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг зохион байгуулж **124** иргэд, уншигч хүүхдүүд хамрагдсан. Уулзалтын

зочидоор МЗЭ-ийн шагналт зохиолчид Б.Жамбалдорж,Н.Минжинсайхан, О.Цэнд-Аюуш, С.Баттулга, Э.Гантулга зэрэг залуу яруу найрагчид оролцож төрийн албан хаагчид, уншигч залуучуудын дунд, Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт зохиолчид Ш.Бадарч, О.Сундуй зэрэг хүүхдийн зохиолчид уншигч хүүхдүүдийн дунд уран бүтээлийг нь шимтэн сонсдог, залуус дүү нартаа зориулан сургамж, амьдралын сайн сайхан, зохиолч болох хүсэл сонирхлыг нь төрүүлсэн халуун дотно яриа өрнүүлэн, номын дээжээсээ хандив өргөсөн.

3.8. Лавлагаа мэдээлэл: Лавлагаа, номзүйн үйлчилгээг танхимаар 64, цахимаар 33 нийт 97 уншигч, үйлчлүүлэгч лавлагаа мэдээлэл авсан.

3.9.Мэргэжил арга зүйн зөвлөгөө: Аймгийн нийтийн номын сан нь 2022 онд Бүрэн, Өндөрширээт, Дэлгэрхаан, Баянцогт, Баянхангай, Эрдэнэсант, Алтанбулаг сумдын соёлын төв болон ЕБС-ийн номын санч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Сумдын номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын сангийн нэгдсэн бүртгэл, нэг бүрчилсэн бүртгэл болон өдөр тутмын бүртгэлийг хэрхэн хөтлөх, ном ангилах арга зүйн зөвлөгөөг 7 сумын 14 номын санчдад өгч ажилласан.

ДӨРӨВ. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

4.1. Яруу найраг сонирхогч өсвөр залуу үеийнхний уран зохиолын авьяас билгийг хөгжүүлж, уран сайхнаар сэтгэж бичих чадварыг сайжруулах, соён гэгээрүүлэх, шинээр төрж буй залуу авьяастнуудыг нээн илрүүлэх Төв аймгийн зохиолч, уран бүтээлчдийн залгамж халааг үргэлжлүүлэх зорилгоор **“Ухаарлаас ургасан бодол**” яруу найргийн уралдааныг 27 сумын ЕБС-ийн 8-12 ангийн сурагчдын дунд зохион байгуулан 1-р шатанд 7 сумын 75 яруу найрагч хүүхэд цахимаар оролцсоноос 2-р шатанд тэнцсэн 25 сурагч тэнцэж шагналт байранд 4 сурагч шалгарсан.

4.2.“Дэлхийн хүүхдийн номын өдөр”-ийг угтан Хүүхдийг уран зургаар дамжуулан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ном унших, номын утга агуулгыг ойлгон ухаарч өөрийнхөөрөө сэтгэх, номын сангийн хөгжилд хүүхдийн оролцоог нэмэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зорилгоор “**ҮЛГЭРЭЭР ХҮМҮҮЖҮҮЛЬЕ**” гар зураг болон бүтээлийн уралдааныг ЕБС-ийн 1-6 ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт **7** сумын **117** бүтээл ирүүлсэн бөгөөд 1-3, 4-6 гэсэн 2 насны ангиллаар шалгаруулалтаа явуулж 8 хүүхдийн бүтээл шалгарсан.

4.3. МУ-н Ерөнхийлөгчийн зарлигийг орон нутагт хэрэгжүүлж “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтаж Д.Нацагдоржийн нэрэмжит нийтийн номын сангаас Үндэсний оюуны соёлын их өв болсон Монгол бичгээ эрхэмлэн дээдлэх, эх хэл бичгээ зөв эзэмших, хэрэглэх, түүнд суралцах, хадгалан хамгаалах, хос бичигтэн болох, хойч үедээ өвлүүлэх, өөрийн мэдлэг чадвараа сорих, сурах хүсэл эрмэлзэл төрүүлэх зорилгоор **"МОНГОЛ БИЧИГТЭН-МОНГОЛ БАХАРХАЛ"** тэмцээнийг Төрийн байгууллага, ААН байгууллагуудын дунд 5 үе шаттайгаар зохион байгуулж нийт 8 байгууллагын 68 иргэн хамрагдаж эхний 3 байрыг шалгаруулсан. Мөн **“КАЛЛИГРАФ УРАН БИЧЛЭГ”-**ийн уралдааныг 27-н сумын насанд хүрэгчдийн дунд зохион байгуулан эхний 3 байрыг шалгаруулсан.

4.4. Бяцхан хүүхэд багачуудыг “Үлгэрээр хүмүүжүүлье” уриатайгаар номд дурлуулах, номтой нөхөрлөхийн үнэ цэнэ, ач холбогдлыг таниулах, хүүхдийн ном унших сонирхлыг төрүүлэх зорилгоор “Хүүхдийн уншлагын танхим”-с **“КИНО ӨДӨР”** арга хэмжээг зохион байгуулан нийт 16 удаагийн үлгэрээр **504** хүүхэд багачуудыг үлгэрийн ертөнцөөр аялуулж, кино зохиолын ялгааг таниулсан.

4.5. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2012 оны 158-р зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор **“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД” 31, 32** дахь удаагийн номын баярыг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриатайгаар зохион байгууллаа. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг угтан “Монгол бичигтэн-Монгол бахархал”, “Каллиграф-Уран бичлэг”, “Зохиолч уншигчдын уулзалт”, “Шидэт ном” бүтээлийн уралдаан, “Кино өдөр”, “Үлгэрийн баатрууд эргэж ирсэн нь маск парад”, “Үлгэрийн баатрууд амилсан нь” зэрэг арга хэмжээнд 567 уншигч хүүхэд залуучууд иргэдийг хамруулсан. Мөн “Шинэ ном”-ын үзэсгэлэн худалдаа, “Монгол ёс заншил”, “Хамгийн хамгийн”, “Хүүхдийн шилдэг зохиолууд”-иар сэдэвчилсэн номын үзэсгэлэн, “Хорин номын хожил” асуулт хариултын нэвтрүүлгийг 9 багийн 57 иргэний дунд, “Уншсан номын нэрээ нэрлээрэй” хөгжөөнт тэмцээнийг 40 хүүхэд нийт 11 арга хэмжээ зохион байгуулж 2380 хүн хамруулсан.

4.6. Зуунмод сумын 6 багийн албан хаагч, иргэдийн дунд Ардын уламжлалт тоглоом наадгай, Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор **“Монгол бахархал”** тэмцээнийг зохион байгуулж 98 иргэнийг хамруулсан.

4.7. Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 116 жилийн ойн баярын хүрээнд Нийтийн номын сангаас Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчдын номын үзэсгэлэн, “Яруу эгшиглэн-2022” богино өгүүллэгийн уран уншлагын уралдааныг зохион байгуулсан. "Яруу эгшиглэн-2022" богино өгүүллэгийн уралдааны 1-р шатыг 27 сумын хэмжээнд, 2-р шатанд 11 сумын яруу найраг сонирхогчид бүртгүүлснээс 6 сумын иргэд оролцон 4 байр шалгаруулсан. Нийт 175 иргэн уншигч хүүхдүүдийг хамруулсан.

4.8. Соёлын яамнаас 11 дүгээр сарыг “Соёлын бүтээлч сар” болгон зарласний дагуу нийт 7 чиглэлээр үйл ажиллагаа зохион явуулж 2112 иргэдийг хамруулсан. Мөн Төв аймгийн Соёл урлагийн газар, Монголын урчуудын эвлэлийн Төв аймаг дахь салбар хороотой хамтран

“Керамик”-ийн уран бүтээлчдын “Ваар-Урлал” бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж уг үзэсгэлэн нийт 5 хоног үргэлжилсэн.

4.9. Очир эрдэнийн гэрэл контент нэвтрүүлэг: Төв аймгийн нийтийн номын сангаас Их зохиолч Д.Нацагдоржийн амьдрал уран бүтээлийг иргэд, хүүхэд, залуучуудын мэдлэг, боловсролыг ахиулах зорилгоор “Очир-Эрдэнийн гэрэл” цуврал 2 удаагийн контент нэвтрүүлгийг Төв Телевиз, Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт зохиолч, судлаач Ш. Цэрэндоотой хамтран гаргасан.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийтийн номын сан нь 24 цагийн харуул хамгаалалт, галын дохиолол, гадна ба дотор хяналтын камер, гадна талбайн гэрэлтүүлэг зэргийг хийж аюулгүй байдлыг хангасан.Мөн үүдний хаалганд соронзон долгионоор мэдрэгч дохиолол бүхий хамгаалалтын төхөөрөмж байрлуулж ном алдагдахаас сэргийлсэн.

ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА

6.1.Япон улсын Тоттори мужийн номын сан болон Д. Нацагдоржийн нэрэмжит Төв аймгийн нийтийн номын сан хооронд адил тэгш байх зарчимд тулгуурлан 5 жилийн хугацаатай 20 ном солилцоо хийх үйл ажиллагааг эхлүүлж 2021 оны 11 сарын 09 нд эхний 20 номыг Тоттори мужийн номын санд илгээсэн. Энэ оны 06 сарын 16 нд 2 дахь 20 номоо илгээж, Тотори мужаас 7, 8 сард ном солилцооны 40 ном ирж уншигч, үйлчлүүлэгчдийн хүртээл болгосон.

6.2. Төв аймаг, БНСУ-ын Пёнтек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2020 онд Пёнтек хотоос 920 сая, ОНТ-өөс 276 сая нийт 1 тэрбум 196 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар шинэчлэл хийгдэн уншигч, үйлчлүүлэгчид мэдээллээ олж авах чөлөөт сонголт бий болгож, тав тухтай орчин бүрлүүлж, номын сангийн үйл ажиллагааг 1 дахин нэмэгдүүлж, 238 хүний суудалтай болгон өргөжүүлсэн. Энэ хүрээнд 2022 оны 09 сарын 16 нд БНСУ-ын Пёнтек хотын Дарга Жон Жансон тэргүүтэй зочид Нийтийн номын сангийн засвар шинэчлэл, БНСУ-ын Пёнтек хотын нэрэмжит цахим мэдээллийн танхимтай танилцаж ашиглалтад хүлээж авсан. Пёнтек хотын Бэдари номын сан болон Төв аймгийн нийтийн номын сангийн хамтын ажиллагааны “Санамж бичиг”-т гарын үсэг зуран хамтран ажиллахаар болсон.

6.3. 2022 оны 11 сарын 01-04 хооронд Солонгос улсын Пёнтек хотын номын сангийн урилгаар Төв аймгийн номын сангийн захирал Б.Зоригтбаатар, номын санч С.Бадамханд, Б.Буяннэмэх нар ажлын айлчлалыг хийж туршлага судлан, санал бодлоо солилцож цаашид хамтран хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргасан.

6.4. Япон улсын Тоттори мужтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсны 1 жилийн ойн арга хэмжээний хүрээнд :

1. 40ш Япон ном, 26ш Японы түүхийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж,
2. Сургуулийн Бага, Дунд насны сурагчдын дунд “Анимэ” гар зургийн уралдаанд 6 сумын 200-аад хүүхдийн бүтээл ирж 1-3, 4-6 гэсэн 2 насны ангиллаар 1-4-р байрыг шалгаруулж,
3. Сургуулийн Ахлах ангийн сурагчдын дунд “Миний мэдэх Япон орон” сэдэвт Эсээ бичлэгийн уралдаан зарлаж нийт 11 бүтээл ирж 1,2-р байр шалгаруулсан.
4. Шагнал гардуулах үеэр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Япон хэлний дугуйлангийн хүүхдүүд Япон дуугаар мэндчилгээ дэвшүүлсэн.

ДОЛОО. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

7.1. Аймгийн ЗДТГазрын Нийгмийн Бодлогын Хэлтэс, **“Ном түгээе”** төсөлтэй хамтран сумдын Соёлын төв, Зуунмод сумын МСҮТөв, ЕБС-ийн номын санч нарт чиглэл өгөх сургалт хэлэлцүүлэг зохион байгуулан “Ном түгээе" төслөөс 4,5 сая төгрөгийн номын хандив өргөсөн.

7.2. Хүүхэд багачуудыг соён гэгээрүүлж, оюун ухаан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, гар утас, дэлгэцийн хамааралтай болхоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюуны оньс” төсөл боловсруулан Дэлхийн Зөн Төв Орон Нутгийн хөгжлийн хөтөлбөрт уламжилсан. 2022 оны 11 сарын 18 нд уламжлалт оньсон тоглоом наадгай, сэтгэхүй хөгжүүлэх эвлүүлдэг, угсардаг, хөлөгт тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний 2,592,045 төгрөгийн хөрөнгө оруулалтыг авсан.

НАЙМ. СУРГАЛТ, СЕМИНАР

8.1. Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 удаагийн сургалтад албан хаагчдаа хамруулсан. Хамрагдсан сургалтуудыг жагсаавал: “Соёл ба хөгжил” сургалтад 8 албан хаагч, “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ”,“Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ”-ний цахим сургалтад номын сангийн мэргэжлийн 7 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. “Менежментийн чадавхыг бэхжүүлэх нь”, “Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт”, “Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо” цахим сургалтад 1 албан хаагч, “Залуучуудын чуулга” уулзалтад 3 албан хаагч, Төрийн архивын тасгаас зохион байгуулсан архив албан хэрэг хөтлөлтийн 2 удаагийн сургалтад 1 албан хаагч, Авлигатай тэмцэх газраас олон нийтийн авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, үйл ажиллагаагаа танилцуулах зорилгоор “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” сэдэвт сургалтад 1 албан хаагч, Зуунмод цэцэрлэгжүүлэлтийн газраас зохион байгуулсан “Мод ургуулах ашиг тус”, “Оффисын ногоон байгууламж” түргэвчилсэн сургалтад 2 албан хаагч, emongolia цахим систем сургалтад 2 албан хаагч, тоон гарын үсэг цахим шилжилт сургалтад 2 албан хаагч, Төрийн архивын тасаг, хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан “Цахим бичвэрийн сургалт”-д 1 албан хаагч, Онцгой байдлын газрын “Газар хөдлөлтийн аюул” сургалтад 6 албан хаагч, Цагдаагийн газрын “Гэр бүлийн харилцаа” сургалтад 7 албан хаагч, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд “Нандин бүхнээ хамгаалъя” сургалтад 7 албан хаагч, Архив албан хэрэг хөтлөлт сургалтад 7 албан хаагч, төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 цахим сургалтад албан хаагчид 7 хоног бүр тус тус хамрагдсан байна.

8.2. Номын санчдын мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлж номын сангийн цахим үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Аймаг, сум, сургуулийн номын санч нарын сургалтыг “НОМЫН САНГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА” сэдвээр Нийтийн номын сан, Соёлын төв, ЕБС, МСҮТ-ийн номын санч нарын дунд зохион байгуулж, сургалтад нийт 62 номын санч **93,3**% хамрагдсан.

.

ЕС. ДУГУЙЛАН, НОГООН БАЙГУУЛАМЖ

9.1 Хүүхэд багачуудыг соён гэгээрүүлж, оюун ухаан сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, гар утас дэлгэцийн хамаралтай болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюуны оньс” дугуйланг хичээллүүлсэн. Дугуйлангийн үйл ажиллагаагаар монгол өв соёл, тоглоом наадгайг танилцуулан сэтгэхүй хөгжүүлэх оньсон тоглоом зэрэг 2 төрлөөр хичээллүүлж нийт 45 хүүхэд хамрагддаг.

9.2. Цахим мэдээллийн танхимаас Солонгос хэлний анхан шатны сургалтыг 1 сарын хугацаатайгаар 2 удаа хичээллүүлж дунд ахлах ангийн 22 хүүхэд хамрагддаг.

9.3. Байгууллагын гадна талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн олон наст үрийг суулган, гадна тохижилтыг албан хаагч нар хийсэн. Мөн албан хаагч бүр тасалгаанд цэцэг тарьж ургасан цэцгийг гадна тохижилтод цэцгийн мандал болгон байршуулан ажилласан.

АРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨВ

2022 оны байдлаар Улсын төсвийн санхүүжилтаар 171,622.7 төгрөгийн санхүүжилт орсноос 157,790.8 төгрөгийн гүйцэтгэлтэй Нэмэлт санхүүжилтын дансанд 7,840.5 төгрөгийн санхүүжилт орж үндсэн үйл ажиллагаанаас 2,436.2 төгрөгийн орлого орж үндсэн үйл ажиллагаанаас 2,983.2 төгрөгийн орлого орсноос 1,728.2 төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна. Мөн Орон нутгийн санхүүжилтаар 93,747.8 төгрөг орсноос 91,783.8 төгрөгийн зардал гарч үүнээс дулааны мөнгө хүрэхгүйгээс 6,503.7 төгрөгийн өр үүссэн байна. Шилэн дансны ил тод байдлыг хангаж хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн гүйцэт байршуулан тухайн сарын 8-ны дотор тайлагнаж байна. Нийт 134 мэдээлэл байршуулахаас 123 мэдээлэл оруулсан.

АРВАН НЭГ. МОНГОЛ БИЧГИЙН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Төв аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Төв аймгийн төрийн архивын тасаг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний монгол бичгээр хөтлөх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлнэ” гэж тусгасны дагуу 1. Байгууллагын гадна болон дотор хаяг, албан хаагчдын хувийн хэрэг, байгууллагын үйл ажиллагааны хавтсыг кирилл монгол бичгээр хослуулан хаягжуулан албан хэрэгцээнд хэрэглэж байна. 2. Номын сангийн 8 албан хаагчид кирилл, монгол бичиг хосолсон энгэрийн тэмдэгтэй болсон.
2022 онд аймгийн хэмжээнд Монгол бичигтэн байгууллагаар шалгарсан.

АРВАН ХОЁР. БУСАД АЖИЛ:

1. Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэж, ажилтан, албан хаагч, уншигчдад тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлэн ажилладаг.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээг хамт олноороо хийж гүйцэтгэдэг

3. УБ хотод зохион байгуулагдсан “Монголын номын санчдын спортын 13 – р их наадам”-д 2022 оны 10 дугаар сарын 28 – 30 ны өдөр зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд баг хамт олноороо идэвхитэй оролцон шилжин явах цомын эзэн болсон.

4.Шагнал урамшуулал : 2022 оны ажлын үзүүлэлтээр аймгийн хэмжээнд 4 байгууллага шалгарч Нийтийн номын сан нь Шилдэг байгууллагын нэгээр шалгарсан.

5.Байгууллагын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд” сургалт хөгжлийн цагийн төлөвлөгөөг боловсруулан үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж байна.

.... oOo ....

УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.Ерөнхий мэдээлэл

Төв номын сан нь 16 орон тоотойгоор ажиллаж байна. /хавсралт зураг 1/

Үүнд: Захиргаа аж ахуй-8

Уншлага үйлчилгээний тасаг-5

Лавлагаа-мэдээлэл аргазүйн тасаг-2

Гэрээт ажилтан-1

Эрхэм зорилго:

Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц, хөгжлийн түвшинд хүрч, номын санг иргэдэд үйлчлэх “Нээлттэй мэдээллийн төв” болгох эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай байгууллага 1936 онд байгуулагдсан. Түүхэн хөгжлийн 86 жилийн ой тохиож байна. Төв номын сан нь одоогийн байдлаар 15 ажилтан, гэрээт 1 ажилтантай, уншлага үйлчилгээний 5 танхимтай, 20 гаруй шинжлэх ухааны 24090 нэр төрлийн 71542 ширхэг ном хэвлэлээр иргэдэд үйлчлэхээс гадна тэдний дунд

Зорилго нь бүх нийтийг ном хэвлэл уншуулах, номонд сонирхолтой болгох, ном унших үйл ажиллагааг нь дэмжих замаар соён гэгээрүүлэх явдал юм.

Манай байгууллагын уншигчдад мэдээлэл хүргэх, хэлбэр нь: **Вэб сайт хаяг: uvslibrary.blogspot.com**

Номын сангийн албан ёсны имэйл хаяг:libraryofuvs@gmail.com

Ажиллах цагийн хуваарь:

Даваа-Баасан гарагт Өглөө 8,30-аас орой 20,00 цаг

Бямба, Ням гарагуудад Өглөө 10,00-аас орой 17,00 цаг хүртэл ажилладаг.

Байгууллагын утасны дугаар: 70452477

2. Сан хөмрөг, каталог /хавсралт зураг2/

Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчидын эрэлт хэрэгцээн шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна.

Сан хөмрөгийн бүрдүүлэлт:

2022 онд Төв номын сан бэлэг хандивын журмаар **77** нэр төрлийн **102** ш **1 090 800** төгрөгийн ном, төсвийн хөрөнгөөр **849** ширхэг **10 748 849** төгрөгийн номоор фондоо баяжуулсан.

- Номын фондод тавигдах Монгол улсын стандарт MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Фондын стандартыг сайжруулахын тулд шинээр орж ирсэн номыг ангиллын дагуу байрлуулаж, дотоод зохион байгуулалт, эмх цэгц, ангилал, стандартыг сайжруулах зорилгоор ШУ-ны ангийн ялгагч тухай бүрд нь шинэчилж, уншигчдын гар дамжин гэмтсэн номоо сэлбэн засах ажлыг тогтмол хийж байна. 2022 онд номын санчид 3500 ширхэг номыг сэлбэн заслаа. Мөн фондын өрөөнд байнга нойтон цэвэрлэгээ хийж, чийгшүүлэх зорилгоор савтай ус, мэрэгч амьтадаас хамгаалах хор тавьж, хлорминтай усаар тавиур болон номоо арчиж, ариутгаж байна.
- Стандартанд заагдсанаар тавиур хоорондын зай, гэрэлтүүлэг, агааржуулалт, номын багтаамж зэргийг ханган зориулалтын номын тавиуруудтайгаас гадна фондын дулаан хэмжих багаж тавьж бүртгэл хөтлөн ажиллаж байна.
- Сан хөмрөгийн номын эргэлтийг сайжруулах зорилгоор шинэ болон сэдэвчилсэн 60 ш номын мэдээг “Увс нам бус” ТВ-гээр гаргах мөн canva программ дээр видео бэлдэх, шууд Live хийсэн зэргээр олон нийтэд суртчилж ажилласан.

Каталог зохион байгуулалт:

Номын сангийн бүх ном хэвлэлийг электрон каталогт 100 хувь оруулаа. 2022 онд шинээр ирсэн 951 номонд техник ажиллагаа хийж, тасаг танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд ашиглуулж байна.

Электрон каталогт 2022 оны байдлаар 23953 төрлийн 71304 ширхэг ном материал бүртгэгдсэн байна. Мөн төрөл ангийн цаасан каталог хэвлэн каталогийн шүүгээнд байрлуулаад байна.

3. Уншлага үйлчилгээ

Үйл ажиллагаа

- уламжлалт цаасан номын үйлчилгээ
- цахим номын үйлчилгээ
- интернет үйлчилгээ
- гэрээр ном олгох үйлчилгээ
- нүүдлийн болон зөөврийн номын үйлчилгээ
- соёл олон нийтийн ажил
- сургалт, мэдээлэл
- тэргүүний уншигч шалгаруулах, рекорд ном шалгаруулах, сурталчлах гэх мэт ажлуудыг зохион байгуулан ажилладаг.

Уншигч: /давхардсан тоогоор/

2022 онд нийт уншигчийн тоо - 8273

Шинэ уншигчийн тоо - 5013

Байнгын уншигчийн тоо -3395

Ирэгсэд - 20566

Үүнээс: Насанд хүрэгчид нь 3598, оюутан 483, сурагч хүүхэд багачууд 3195

Насны байдлаар авч үзвэл: 18 нас хүрлэх- 2959

18-24 насных- 891

25-35 насныхан- 1098

36-50 насныхан -1115

51-ээс дээш насных -494 уншигч байна.

Хүйсийн байдлаар нь авч үзвэл: эрэгтэй уншигч 3761,

эмэгтэй уншигч 2863 байна.

Боловсролын түвшингээр нь: бага боловсролтой- 1159,

суурь боловсролтой- 1923,

бүрэн дунд боловсролтой-832,

тусгай дунд боловсролтой- 909,

дээд боловсролтой- 1863

2022 онд нийт 39024 ширхэг ном хэвлэл олгож үйлчилсэн. Үүнээс:

Гэрээр- 29235, Зөөврийн номын үйлчилгээр- 4966 , Танхимаар- 12823

Нийт олгосон номыг шинжлэх ухааны ангилалаар нь авч үзвэл :

- Байгалийн шинжлэх ухааны 1580 ширхэг ном хэвлэл
- Техникийн шинжлэх ухааны 824 ширхэг ном хэвлэл
- Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны 577 ширхэг ном хэвлэл
- Ангаахын шинжлэх ухааны 691 ширхэг ном ном хэвлэл
- Социологи, статистикийн шинжлэх ухааны 296 ширхэг ном хэвлэл
- Түүхийн шинжлэх ухааны 1543 ширхэг ном хэвлэл
- Эдийн засгийн шинжлэх ухааны 780 ширхэг ном хэвлэл
- Улс төрийн шинжлэх ухааны 243 ширхэг ном
- Төр эрх ,хуулийн шинжлэх ухааны 531 ширхэг ном
- Цэргийн шинжлэх ухааны 83 ширхэг ном хэвлэл
- Соёл боловсролын шинжлэх ухааны 1501 ширхэг ном хэвлэл
- Хэл шинжлэлийн 1550 ширхэг ном хэвлэл
- Аман зохиол утга зохиолын 4663 ширхэг ном хэвлэл
- Уран зохиолын 18350 ширхэг ном хэвлэл
- Урлагийн 584 ширхэг ном хэвлэл
- Шашины ном 389 ширхэг ном хэвлэл
- Гүн ухааны ном 1841 ширхэг ном хэвлэл
- Сэтгэл судлалын ном 2565 ширхэг ном хэвлэл
- Лавлах хэвлэл 433 ширхэг ном хэвлэлээр үйлчилгээ үзүүлсэн байна.

Нийт 39024 ширхэг ном хэвлэл олгож үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Уншигчдад зориулан бэлдсэн гарын авлага: **/хавсралт зураг. 4/**

- Д.Мягмар “Тээрэмчин” тууж,
- Д. Батбаяр” Цахилж яваа гөрөөс” тууж,
- Б.Лхагвасүрэн”Тамгагүй төр” жүжиг,
- Д.Нацагдоржийн “Цагаан сар ба хар нулиис” өгүүллэг
- Д.Оюунчимэг “Буурлын эзэн” өгүүллэгээр гарын авлага бэлдэж flipsnack- сайтад номлож Page- д байрлуулсан, цаасаар хэвлэсэн.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл бэлдэж, зохиолч Б.Шүүдэрцэцэг “Архичны эхнэрийн хүүрнэл” өгүүллэгийг flipsnack- сайтад номлож Page-д байрлуулсан.цаасаар хэвлэсэн

  Байгууллагын facebook хаягт доорх материалыг цахим хэлбэрээр тавьж уншигчдын хүртээл болгосон
- Хүүхдээ хэрхэн номд дуртай болгох вэ?
- Ном унших зөвлөмж
- Ном уншихын ач тус
- Номын тэмдэглэл хөтлөх зөвлөмж
- Гар утасны зөв хэрэглээ

уншигчдын эрэлт хэрэгцээтэй материалуудаар **viplat, canva** програм ашиглан 11 ширхэг гарын авлага хийж уншигчдад үйлчиллээ.

Зөөврийн номын сангийн үйлчилгээ:

Алслагдсан баг, аж нэгж байгууллага, номын санд ирэх боломжгүй иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж үзэсгэлэн гаргаж танилцуулах үйлчилгээ үзүүлэх үйл ажилагаа үзүүлж ажиллалаа. Цаашид зөөврийн номын үйлчилгээгээ тогтмолжуулж уншигчдын бүтэц хамрагдалдалт өөрчллт оруулж чадлаа.

Үйлчилгээ үзүүлсэн Байгууллагууд: **/хавсралт зураг. 3/**

- Увс хүнс ХХК
- Шинэ улаангом зах
- Хүнсний зах
- Нэгдсэн эмнэлэг
- Улаангом политехник коллеж
- Хөдөлмөрийн дээд сургууль
- Номин худалдааны төв
- Прокурорын газар
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
- Хилийн цэргийн 0245-р анги
- УЦУОШГазар
- Улаангом сумын ЗДТГ
- Стандарт хэмжилзүйн газар

- Мал эмнэлэг
- ХАА-н газар
- БОАЖ-н газар
- Статистикийн хэлтэс
- Онцгой байдлын ерөнхий газар
- Цагдаагийн газар
- Наранбулаг сум
- ББЭХ

Улаангом сумын багууд:

- Улаангом сумын 1, 2, 4, 7, 11-р баг гэсэн 5 баг дээр зөөврийн номын үйлчилгээ үзүүлж 133 иргэнд номын сангийн уншигчийн карт шинээр нээж, 231 ширхэг номыг олгож үйлчилсэн.Үүнээс тусгай хэрэгцээт 17 иргэнд гэрээр очиж карт нээж 24 ширхэг ном олгож үйлчиллээ.

Сургууль, цэцэрлэг:

1. Улаангом сумын 4, 5, 9, 10, 11, 12, цэцэрлэг, мөн Ерөнхий боловсролын 2, 3, 4, 5. 6-р сургууль, Түргэн сумын сургуулийн дотуур байранд, Эрдмийн эхлэх сургууль дээр очиж зөөврийн номын үйлчилгээ үзүүллээ. Үүнд:
   - ЕБ-ын 3-р сургуулийн 8а, 9а ангийн сурагчдад Уншигч хамт олон болох зорилтын хүрээнд ангид нь очиж карт нээж зөөврийн 30 ном
   - ЕБ-ын 3-р сургуулийн Т.Энхбат багштай 2г ангийн хамт олонд Зөөврийн 25 ном
   - Эрдмийн Эхлэл ЕБС-ийн номын санч Б.Баттунгалагт 26 ном
   - Ахлах 3- р сургуулийн 1б ангид 23 ном,
   - Түргэн сумын ЕБС-ийн дотуур байрны сурагчдад 55 ном нийт 159 номоор зөөврийн номын үйлчилгээ үзүүллээ.

Соёлын төвийн номын сангууд:

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Соёлын төв, сургуулийн номын сантай байнга хамтран ажиллаж байна.

  Сан хөмрөгийн танхимаас зөөврийн ном авсан номын сангууд: нийт 310 ш ном олгож үйлчилсэн.

	Сургууль	**Тоо ширхэг**	**Соёлын төвийн номын сан**	**Тоо ширхэг**
1	Ахлах VI	49	Завхан сумын соёлын төвийн НС	46
2	Цогцолбор II	20	Наранбулаг СТНС	51
3	Ахлах V	19	Баруунтуруун СТНС	24
4	ХДС	35	Цагаанхайрхан СТНС	12
5	УГПКоллеж	4	Түргэн СТНС	26
6	Ахлах III	10	Зүүнговь СТНС	13
7			Өмнөговь СТНС	1

		137		**173**

2022 онд нийт зөөврийн номын үйлчилгээг 21 байгууллага, Улаангом сумын 5-н баг, ЕБ-ын 7 сургууль, 6-н цэцэрлэг, аймгийн 7-н Соёлын төвд хүрч ажилласан байна.

Соёл олон нийтийн ажил: **/хавсрат зураг 5/**

1. **“Эмэгтэйчүүддээ хэлэх чинь сэтгэлийн үг”** захидлын уралдааныг зохион байгуулж 21 захидал ирсэнийг шалгаруулан шагнаж урамшууллаа.
2. Молор-Эрдэнэ философийн академитай хамтран “**Зохиогчтой хийх уулзалт”** ярилцлага, шинэ номын танилцуулгыг зохион байгууллаж 60 гаруй уншигчид оролцлоо.
3. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Огторгуйн далай зохиолчдын нэгдэлтэй хамтран “**Зохиолч-уншигчийн”** уулзалт зохион багууллаа. Мөн уншигч хүүхдүүдийн дунд АХА тэмцээн, Сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүд гаргаж сурталчилан 1211 хүнд суртчиллаа.
4. Эх хэлний баярыг Наранбулаг сумын Хэлний зөвлөл,сумын соёлын төвийн номын сан,сургуулийн номын сантай хамтран эх хэлний баярыг сумын хэмжээнд өргөн тэмдэглэллээ.
5. **“Монгол бичгээр сайхан бичигтэн -2022”** уралдааныг зохион байгууллаа. Нийт 189 бүтээл ирснээс:

   Б.Ренчин:"Монгол хэл "шүлгээр хичээнгүй бичгийн төрөлд :
   - 1-р байр: Тариалан сум ЕБС -ийн сурагч Д. Будхүү
   - 2-р байр:5-р сургууль 9-а Э. Энхгэрэл
   - 3-р байр: 6-р сургуулт 9-в Б.Энхчимэг

   Д.Нацагдоржийн "Шувуун саарал" өгүүллэгээр хичээнгүй бичгийн төрөлд:
   - 1-р байр: 5-р сургуулийн 8-а Ц.Мөнхбат
   - 2-р байр:Наранбулаг сумын ЕБС 7-а Б.Заяа
   - 3-р байр: Зүүнговь сум ЕБС 8-а Г.Отгонцэцэг

   Бүтээлийн төрөлд:
   - 1-р байр: Улсын тэргүүний цогцолбор 1-р сургууль 11-б Ц.Баторших
   - 2-р байр:Наранбулаг сум ЕБС 10-а О. Тэмүүлэн
   - 3-р байр: Улсын тэргүүний цогцолбор 1-р сургууль 11-в Навчаа
   - Бүтээлийн оюутны төрөлд
   - 1-р байр: УПК Гутал-2 анги Ч.Гантигмаа нар шалгарлаа.
   - Хувийн номын сантай хувь хүн, байгууллага шалгаруулаа.
   - “Номтой нөхөрлөё”яруу найргийн үдэшлэгийг зохион байгууллаа.
   - Эх хэлний тунгаамал тэмцээнийг ЕБ-ын 6 сургуулийн 8 ангиудын дунд зохион явууллаа.
6. **“Эх хэл мину**”зохион бичлэгийн уралдааныг ЕБ-ын 5 сургуулийн 10-12-р ангиудын зохион явууллаа.

7. **“Эх түүх бидний бахархал**”дэвжээ тэмцээнийг ХДС-ийн 1-4-р ангийн оюутнуудын дунд зохион явууллаа.
8. Дэлхийн номын баярын өдөр Увсын одонтой ээжүүд ТББ-тай хамтран **"Номтой өдөр"** үйл ажиллагаа зохион явууллаа.
   - Тус арга хэмжээнд “Өглөөний гайхамшиг” номоор Б. Булганцэцэг Номын уншихын ач тус, Цахим орчны зохисгүй хэрэглээнээс хүүхдийг холдуулж номонд хэрхэн дурлуулах талаар ярилцлага хийлээ.

9. Дэлхийн бестселлер **"Икигай" номын хэлэлцүүлэг** зохион байгуулж
   ХДС оюутан Б.Батням илтгэл тавьж, Мөн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион явуулж шагнаж урамшууллаа.
10. "Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2022" арга хэмжээний хүрээнд УПК-ын сурагчдын дунд **“Хичээнгүй сайхан бичигтэн**” шалгаруулах уралдаан зохион байгууллаа. Нийт 120 гаруй сурагчид оролцож бичвэрийг шалгаруулլаа.
    1-р байр: Гутал-2 ангийн сурагч Ч.Ганигмаа
    2- р байр: Бэлэг дурсгалын зүйл урлаач-1 ангийн сурагч Б.Цоодол
    3-р байр: Оёдол-2 ангийн сурагч С.Туяа
11. "Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2022" арга хэмжээний хүрээнд УПК-ын сурагчдын дунд уран уншлага яруу найргийн “**Яруу эгшиглэн”** тэмцээнийг УПК-ын багш Б.Батхишигтэй хамтран зохион байгуулж шалгаруулլаа.
    1-р байрыг БЗЧ-2 ангийн сурагч Б. Алтанхүү “Би цагдаа” шүлгээр
    2-р байрыг АЖ-2 ангийн сурагч Б. Лянхуа “Нэгдмэл заяа” шүлгээр
    3-р байрыг БЗЧ-1 ангийн сурагч Б. Уянга “Саран нэг л уйтгартай” шүлгээр тус тус шалгарсан.
12. "Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2022" арга хэмжээний хүрээнд **“Гэрийн номын сан”-**тай айл өрхийг шалгаруулан шагнаж урамшууллаа. Үүнд:1-р байр: Д.Пүрэвжав 2-р байр: С.Уранбилэг нар шалгарлаа.
13. **“Номын сайн нөхөр”** уралдаан зохион явууллаа. Уралдаанд ЕБ-ын сургуулийн анги хамт олон, хувь уншигч сурагчид, насанд хүрэгчид, нийт 192 уншигчид оролцлоо.
    - ❖ Уралдааны 1-р төрөл: “Шилдэг уншигч- анги хамт олон”

      Нийт 6 ангийн 146 хүүхэд оролцлоо.Үүнээс: Ахлах ангийн төрөлд
      1- р байр: Цогцолбор 1-р сургуулийн Э.Энхцэцэг байгштай 11-г анги
      2- р байр: Цогцолбор 1-р сургуулийн Д.Одсүрэн байгштай 12-б анги
      3- р байр:3-р сургуулийн Булганчимэг багштай 12-а анги
      Бага ангийн төрөлд:
      1- р байр: 3-р сургуулийн Цэрэнпагам багштай 4-а анги
      2- р байр 2-р сургуулийн Кульчаря багштай 4-а анги
    - ❖ Уралдааны 2-р төрөл: “Шилдэг уншигч- сурагч”
      46 хүүхдийн уншсан номын тэмдэглэл, материал ирсэн. Үүнээс:
      1- р байр: 3-р сургуулийн 12-в ангийн сурагч Д.Амарзаяа
      2- р байр: 1-р сургуулийн 12-б анги Н.Наранцэцэг
      3- р байр: 3-р сургууль 10-а анги Б.Мөнхцэцэг
    - ❖ Уралдааны 3-р төрөл: “Шилдэг уншигч-насанд хүрэгч”-ийн төрөлд:
      Тэргүүний уншигч Нацагдарж тэмдэг-ээр:
      Д.Мандааж, Ц.Отгонцэцэг,Д.Нандинцэцэг
      “Номын нөхөр” тэмдэг-ээр:
      Д.Амарзаяа, О.Энхманлай нарыг тус бүр шагнаж урамшууллаа.
    - ❖ Уралдааны 4-р төрөл: “Шилдэг ном
      МУСГЗ Б.Норовын 2022 онд шинээр гарсан “Алтан зөгий” номыг шалгаруулլаа.

Номын баярын үйл ажиллагааны үеэр Бестселлер, Амьдрах ухаан, Номын тэмдэглэл, номын
хавчуургаар тус бүр үзэсгэлэн гаргалаа.

14. "**Зохиолч-Уншигч"-**ийн уулзалтыг Хилийн цэргийн 0245-р анги дээр зохион явууллаа. Энэхүү уулзалт ярилцлагад МЗЭ-ийн Увс салбар "Огторгуйн далай" УЗН-ийн тэргүүн Г.Оюун-Эрдэнэ, СГЗ-Зохиолч яруу найрагч Б.Норов, яруу найрагч Б.Цэрэн-Оол, Б. Болд нар халуун яриа өрнүүлэхийн зэрэгцээ уран бүтээлээсээ уншиж сонирхууллаа.

.

15. "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд оюутан, сурагчдын дунд **"Ном уншихын ач тус ба номтой нөхөрлөсөн нь"-Уншигчдын бага хурал** зохион явууллаа. Уг арга хэмжээнд:
    - -Аймгийн Төв номын сангийн дарга Б.Батхүү нээж үг хэллээ.
    - -ЕБ-ын 4-р сургуулийн 10-б ангийн сурагч Ж.Эрхэмбаяр морин хуурын "Үүлэн бор" аялгуу тогллоо.
    - -Монгол Улсын зөвлөх багш М.Мягмаржав "Ном уншихын ач тус ба номтой нөхөрлөсөн нь" сэдвээр яриа хийлээ.
    - -"Тэргүүний уншигч-Д.Нацагдорж " тэмдэгтэн Хөдөлмөрийн дээд сургуулийн оюутан Б.Батням "Икигай" номоор болон "Цахим хэрэглээ" сэдвээр яриа хийлээ.
    - -"Тэргүүний уншигч-Д.Нацагдорж " тэмдэгтэн ЕБ-ын 3-р сургуулийн 12-б ангийн сурагч Д.Амарзаяа " Цойлогсод" номоор яриа хийлээ.
16. “**Номтой нөхөрлөе”** аяны хүрээнд Цогцолбор 2-р сургуулийн дотуур байрны хүүхдүүдийн дунд ном унших аян зарлаж Монголын уран зохиол, Хүүхдийн уран зохиол,Гадаадын уран зохиолын 103 ном зөөврөөр хүргэж өгч тасаг бүрээр аялуулаж, номын сангийн уншигчийн карт 74 хүүхдэд нээж, танин мэдэхүйн тэмцээн зохион явууллаа.

    1-р байр: 11-в ангийн сурагч Б.Баттөмөр
    2-р байр:12-в ангийн сурагч Өнөрбаяр
    3-р байр: 12-б ангийн сурагч Түмэнхишиг нар шалгарлаа.

17. **“Өглөө бол гайхамшиг”** сэдвээр Б.Булганцэцэгтэй хамтран ЕБ-ын 3-р сургуулийн 8- 9 дүгээр ангийн 63 хүүхдийн хамруулан Өглөөний кофе-той яриа хийсэн.
18. ЕБ-ын 3-р сургуулийн 8а, 9а ангийн сурагчдын дунд хөгжөөнт, цэнгээнт, танин мэдэхүйн **“АХА”** тэмцээнийг зохион байгууллаа.

    1-р байр 8а ангийн сурагч Г.Эрхсаран
    2-р байр 9а ангийн сурагч Б.Мөнхзул,
    3-р байр 8а ангийн сурагч О.Нандинболор нар шалгарлаа.
19. Олон улсын Хүүхдийн номын өдрийг угтан **“Миний дуртай үлгэрийн баатар”** сэдэвт гар зургийн уралдаан зохион явууллаа.

    Уралдаанд 100 орчим зураг ирснээс Бага анги, дунд анги гэсэн ангиллаар нийт 15 бүтээл шалгаруулж ирсэн бүтээлээр танхимдаа үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.
20. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан уншигчдын дунд “**Гэр бүлийн уншлага”** challenge зарлан ажилласан.

    Challenge-ийн үр дүнд 15 гэр бүл оройд тогтмол ном уншдаг цагтай болсон.
21. Цогцолбор 1-р сургуулийн 4-р ангийн сурагчдын дунд **“Номтой нөхөрлөх”** аян зарлаж 350 хүүхдэд цаасан карт нээж 4б, 4г ангид гэрээр унших ном олгож үйлчиллээ. Энэ аяны хүрээнд сурагчид Номын тэмдэглэл хөтөлж суран,уншсан номынхоо дүрүүдийг баримлын шавраар урлаж ангидаа ном унших цагтай болж Бямба гарагт гэр бүлийн гишүүний хамт номын санд сууж ном уншиж хэвшлээ.

    Аянаа дүгнээд Д.Сэлэнгэ багштай 4б ангийг “Тэргүүний уншигч анги хамт олон”-оор шалгаруулж ажиллалаа.
22. ЕБС-ийн Ахлах 3-р сургуулийн 9а ангийн сурагчдын дунд **"Бүтээлч уншигч" уншсан номын тэмдэглэлийн уралдаан** зарлаж гурван байрыг шалгаруулж шагнаж урамшууллаа.

23. Б. Булганцэцэгтэй хамтран **“Үр бүтээлтэй хичээл давтах”** номоор 1-р сургуулийн 11в анги, 3-р сургуулийн 10а ангийн сурагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан.
24. Улаангом сумын 4-р цэцэрлэгийн бяцхан уншигчдад Гурван тоорой үлгэрээр **“Чанга уншлага”** хийлээ.
25. Улаангом сумын 11-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүд 15 хүүхдэд “Чанга уншлага хийж ажилласан.
26. **“Номын найз гэр бүлийн уншлага”**–г ЕБС-ын 4-р сургуулийн бага ангийн сурагчдын дунд зарласан. Энэ ажлын хүрээнд тус сургуулийн Хулан багштай 2а анги, Золзаяа багштай 4г анги, 3в ангиуд ирж номын сантай танилцаж карт нээлгэн, “Чанга уншлага” хийлээ.
27. ЕБс-ын 5-р сургуулийн сурагчдын дунд **“Бүтээлч уншигч”** уншсан номын тэмдэглэлийн уралдаан зарласан. Мөн номын санч М.Алтантуулын зарласан Дотуур байрны номын санд ном хандилах аянд нэгдэж өөрийн зүгээс 10 ном хандивлаж ажилласан.
28. “Үндэсний бичиг үсэг, номын өдрүүд-2022”-ийн хүрээнд **"Үлгэрийн баатрууд амилсан нь"** уралдаан зохион байгууллаа. Тэмцээнд 1-р цэцэрлэгийн Бэлтгэл 1,2 бүлэг, 4-р цэцэрлэгийн дунд бүлэг, 6-р цэцэрлэгийн дунд бүлэг нийт 40 хүүхэд оролцлоо. Үүнээс:
   1-р байр 4 цэцэрлэг
   2-р байр 6 цэцэрлэг,
   3-р байр 1 цэцэрлэг бэлтгэл1 бүлэг тус тус эзэллээ.
29. Уншигчдийн дунд **“Номын хавчуурга”** хийх уралдаан зарласан – 100 гаруй оролцогчийн 252 бүтээл ирсэн.
30. 2022 оны 09 сарын 01-ээс 14-н хүртэл хугацаанд **“Миний уншсан ном”** видео бичлэгийн уралдаан зарласан. Тус уралдаанд Улаангом сумын сургууль, Цэцэрлэг, Наранбулаг сум, Түргэн сум , Сагил сум, Хяргас сум, Зүүнхангай сум, Зүүнговь сум Мөн Ховд аймгийн Жаргалант сумын ЕБС-ийн хүүхдүүд, цэцэрлэгийн хүүхдийн нийт 50 гаруй хүүхдийн бүтээл ирсэн.
31. 2022 оны 09-р сарын 26- наас 27-ны өдрүүдэд **Увс аймгийн Завхан суманд Номын баярын** арга хэмжээнд оролцоод ирлээ. Уг арга хэмжээнд Номын сангийн үйл ажиллагааны талаар болон номын баярын тухай мэдээлэл хийж
   1- 5-р ангийн сурагчдад "Ном уншихын ач тус"
   6- 9-р ангийн сурагчдад "Ном унших зөвлөмж"
   Насан хүрэгчдэд "Хүүхдээ хэрхэн номод дуртай болгох арга" сэдвээр илтгэл тавьж идэвхтэн уншигчдад "Тэргүүний уншигч Д.Нацагдорж" тэмдэг гардууллаа. Тус арга хэмжээнд Завхан сумын сургуулийн сурагчид, Төрийн албан хаагчид, ахмадууд, иргэд хамрагдсан өргөн арга хэмжээ боллоо. Арга хэмжээнд нийт 350 гаруй хүн хамрагдсан. (1-9-р ангийн нийт 300 сурагч, 50-н Төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа)
32. Увс аймгийн хүүхдийн **“ОРОЛЦООД ХӨГЖЬЕ”** хүүхдийн чуулганыг өнөөдөр зохион байгуулагдсан Номын анд клубийн 26 хүүхэд 2 чиглүүлэгч багш нарыг хүлээн авч аргазүйн зөвлөгөө өгч ажиллаа.
33. Аймгийн сум, сургуулийн номын сангуудын дунд “Жишиг номын сан” шалгаруулах уралдаан зарлаж , дүгнэлээ.

“Америк соёл мэдээллийн төв”-с зохион байгуулсан СОНА

1. “Үндэсний бичиг үсэг, номын өдрүүд 2022” баярын хүрээнд зохиогдсон **“Миний мөрөөдлийн орон**” эсээ бичлэгийн уралдаан явуулж нийт 15 хүүхэд оролцсоноос эхний 3

байрыг шалгаруулж шагнаж урамшуулсан.Тус уралдаанд ЕБС-ийн 10-12-р ангийн сурагчид оролцсон. Мөн Түргэн, Тариалан, Ховд сумаас оролцлоо.

2. “Үндэсний бичиг үсэг, номын өдрүүд 2022” баярын өдөр “**Флашмоб бүжиг”** зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд “Насан туршийн боловсролын хүүхэд хөгжлийн төв-“ийн 40 сурагч оролцсон.
3. Насанд хүрэгчдэд зориулан өглөөний уулзалт зохион байгуулсан.Тус уулзалтанд Санхүү Төрийн Сангийн дарга Б.Эрдэнэсүрэн уригдан лекц тавьлаа.Уулзалтанд 25 хүн оролцлоо.
4. Англи хэл дээрх кино үзэх хөтөлбөрийг Баасан гараг бүр 17:00 цагаас тогтмол явуулсан.Сард нийтдээ 30-35 хүн хамрагддаг.
5. Охидын яриа клубийн уулзалтаар өсвөр насны охидод тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг хэрхэн даван туулах талаар ярилцлаа.
6. АНУ-ын Элчин сайдын яамнаас зохион байгуулсан "Embassy House Art" арга хэмжээний үйл ажиллагаатай холбогдуулан Насан туршийн сургалт, хүүхдийн урлан бүтээх төвийн урлаг, уран баримал багш дүрслэх урлагийн багш С.Баасанхүү, Х.Энхриймаа нар Солонгос-Америкийн орчин үеийн уран бүтээлч Нам Жоон Пикегийн талаар лекц уншлаа.
7. Дунд болон ахлах ангийн сурагчдад зориулсан англи хэлний сургалтыг 7 хоног бүр явуулж байна.
8. Game Time буюу тоглоомын хөтөлбөр Даваа гараг бүр тогтмол явагдаж байна.
9. “Америкт төгсөгчдийн яриа” подкаст хийж байна.
   анхны зочиноор Flex хөтөлбөрийн 2020 оны төгсөгч Д. Уянга оролцлоо. Уг подкастыг 983 гаруй хүн үзсэн.
10. Бага ангийн сурагчдын англи хэлний сургалт 7 хоног бүрийн Пүрэв, Баасан гарагуудад тогтмол явагдаж байна. тогтмол болон шинээр элсэж суусан хүүхдийн тоо 50 хүрсэн.
11. АНУ-аас Монгол улсад суух элчин сайд Жонн Браун Увс аймагт ажиллах үеэрээ Америкийн төвд зочилсон бөгөөд төвийн үйл ажиллагаатай танилцлаа.
12. Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн О.Саруул гадаадын тэтгэлэгт хөтөлбөрүүд болон IELTS, TOEFL-ийн шалгалтанд бэлтгэх лекцийг зохион байгууллаа. Хуралд 30 хүн оролцов.
13. Өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлээ зөв сонгох сургалтыг АСМТ-ийн англи хэлний багш орон нутаг дахь гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа.Энэхүү сургалтаар 12 анги төгсөж буй сурагчдад зөвлөгөө өгөх болон өсвөр насныханд тулгамдаж буй асуудлаар ярилцаж Мөн сургалтанд хамрагдсан өсвөрийн залуучуудтай хамтран ажиллахаар боллоо.Тус сургалтанд нийт 25 хүүхэд оролцлоо.
14. Ахлах ангид зохион байгуулагдсан танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээнийг "Увсын өнгө" болон Америкийн соёл мэдээллийн төв хамтран зохион байгууллаа. Тэмцээнд нийт 30 хүүхэд оролцсон бөгөөд үүнээс 10а ангийн сурагч Анхбаяр, Батгэрэл нар шалгарлаа
15. 7 сарын 1-2-ны хооронд FLEX хөтөлбөрийн 2020 оны төгсөгч Уянгатай хамтран “ Youth Synergy” сургалт зохион явуулсан.Тус сургалтанд 15 сурагч хамрагдсан.
16. 8 сарын 12нд FLEX хөтөлбөрийн 2020 оны төгсөгч Уянгатай хамтран “ Culture kids” сургалтыг зохион явуулсан.Тус хөтөлбөрт 21 хүүхэд хамрагдсан.
17. 9-р сарын 22-нд "Увс аймгийн соёл урлагийн залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн уулзалт зохион байгуулагдсан. Уулзалтанд соёлын салбарын залуус цугларч олон нийтийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар төлөвлөгөө гаргалаа.
18. 9-р сард кино хөтөлбөрийг 2 удаа зохион байгуулсан. "How to train your dragon 3 ? "Encanto", зэрэг киног 25 үзэгчдэд зориулан гаргасан.
19. 9-р сарын 23-ны өдөр "Сайн тус" НҮТББ-ын багш Дулмаа ирж хүүхдүүдэд зориулсан уулзалт зохион байгууллаа.
20. Төв номын сан дахь "Америкийн соёл мэдээллийн төв"-д 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны улс төрийн ажилтан хатагтай

Кристин, улс төрийн хэлтсийн ажилтан Б.Номин нар FLEX хөтөлбөр, тэтгэлэгт хөтөлбөр, АНУ-ын визийг сонгох зэрэг асуудлаар оюутнуудад мэдээлэл өглөө. Хурлын үеэр сурагчид маань хоёр цаг чөлөөтэй ярилцаж, асуулт асуулаа. Хуралд нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй оролцов.

21. 10-р сарын 26-нд англи хэлний дугуйлангийн сурагчидтай хамтран өрөөгөө өөрсдөө чимэж, 28-нд Halloween үдэшлэгийг тэмдэглэсэн.
22. Номын сангийн ажилтнуудад зориулсан мэргэжлийн англи хэлний сургалтуудыг Лхагва гариг бүр зохион байгуулж байна.
23. “American English for high school juniors and seniors” нэртэй төсөл хэрэгжиж байна. Төслийн үргэлжлэх хугацаа 2022 оны 10-р сарын 1-нээс 2023 оны 6-р сарын 1-ний хүртэл 9 сар үргэлжилнэ.Тус төслийн сургалтанд нийт 20 сурагч идэвхтэй хамрагдаж байна.
24. Увс аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөл, Америкийн соёл мэдээллийн төвтэй хамтран 16-34 насны залуучуудад зориулсан English course Англи хэлний анхан шатны Бямба гарагийн хөтөлбөр амжилттай эхэллээ. Хөтөлбөр маань удаан хугацаанд үргэлжлэх бөгөөд одоогоор 45 хүн бүртгүүлсэн байна.
25. ТЭГШ БОЛОМЖИЙН ТӨЛӨӨХ ЗАЛУУСЫН МАНЛАЙЛАЛ” сургалтын хүрээнд Увс аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд "Ажлын байрандаа эерэг соёл бүтээцгээе" сэдвээр сургалт зохион байгуулж ажиллалаа.Нийт 20 хүн хамрагдсан.

2022 онд нийт 131 Соёл олон нийтийн ажил зохион байгуулж 6200 гаруй хүнийг хамруулан ажиллаа.

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн: /хавсралт зураг.6/

- ❖ Монголын зохиолчдын эвлэл байгуулагдсан өдөрт /45 ширхэг /
- ❖ Үндсэн хууль батлагдсан өдөрт /49 ширхэг/
- ❖ Орон нутгийн зохиолчдын номоор /39 ширхэг/
- ❖ Монголын уламжлалт цагаан сар / 42 ширхэг/
- ❖ Монгол уран зохиол /46 ширхэг ном/
- ❖ Утга зохиолын шинжлэх ухааны номоор /45 ширхэг ном/
- ❖ Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт /40 ширхэг ном/
- ❖ Монгол цэргийн баярт /36 ширхэг ном/
- ❖ Инээдмийн баярт зориулсан үзэсгэлэн /45 ширхэг ном/
- ❖ Эрүүлийг хамгаалах,анагаахын шинжлэх ухаан / 37 ширхэг ном/
- ❖ Байгалийн шинжлэх ухааны /36 ширхэг ном/
- ❖ Дэлхийн номын өдөрт /144 ширхэг ном/
- ❖ Дэлхийн бүжгийн өдөрт /34 ширхэг ном/
- ❖ Үндэсний бичиг үсгийн баярт / 37 ширхэг ном/
- ❖ ХАА,Газар тариалан /36 ширхэг ном/
- ❖ Бестселлер 2 удаа /73 ширхэг ном/
- ❖ Амьдрах ухаан / 37 ширхэг ном/
- ❖ Ахмадын баярын өдөрт /34 ширхэг ном/
- ❖ Монголын хувьсгалчдын өдөрт /38 ширхэг ном/
- ❖ Олон Улсын эх үрсийн баярт /39 ширхэг ном/
- ❖ Түүх нийгмийн шинжлэх ухаан / 35 ширхэг ном/
- ❖ Монголын залуучуудын өдөрт / 28 ширхэг ном/
- ❖ Боловсролын шинжлэх ухаан / 36 ширхэг ном
- ❖ Соёл урлагийн ажилтны өдөрт / 37 ширхэг ном/
- ❖ Шилдэг шинэ ном 4 удаа / 128 ширхэг ном/
- ❖ Амьдрах ухаан / 49 ширхэг ном/
- ❖ Монголын оюутны холбоо байгуулагдсан өдөрт /35 ширхэг ном/
- ❖ “Зохиолч уншигчдын уулзалт”- д оролцож буй зохиолчдын номоор /88 ширхэг ном/

- ❖ Эдийн засгийн шинжлэх ухаан / 36 ширхэг ном/
- ❖ Хэвлэл мэдээллийн ажилтны өдөрт /25 ширхэг ном/
- ❖ Дэлхийн эмч нарын өдөрт /39 ширхэг ном/
- ❖ Эзэн Богд Чингис хааны мэлмий гийсний 860 жилийн ойд /102 ширхэг ном/
- ❖ Цагаан сар-27 ширхэг ном
- ❖ Багш нарын өдөрт-27 ширхэг ном
- ❖ Түүх түүхийн шинжлэх ухаан-28 ширхэг ном
- ❖ Эх хэлний өдөрт-24 ширхэг ном
- ❖ МАХН, эх орончдын өдөрт-24 ширхэг ном
- ❖ Охид бүсгүйчүүдэд зориулсан-24 ширхэг
- ❖ Гадаадын уран зохиол-27 ширхэг ном
- ❖ С. Удвалын зохиолоор цахим үзэсгэлэн
- ❖ Хүүхдийн уран зохиол-52 ширхэг
- ❖ Эрчүүдийн баярт-26 ширхэг
- ❖ Дэлхийн яруу найргийн өдөрт-26 ширхэг
- ❖ Шашин чөлөөт сэтгэлгээ-25 ширхэг
- ❖ Дэлхийн эмч нарын өдөрт-38 ширхэг
- ❖ Гадаадын уран зохиол-27 ширхэг
- ❖ Түх нийгмийн шинжлэх ухаан-21 ширхэг
- ❖ Дэлхийн дүрслэх урлагийн өдөрт-27 ширхэг
- ❖ Газар тариалан эрхлэгчдэд-26 ширхэг
- ❖ Урлагийн номоор-24 ширхэг
- ❖ Техникийн шинжлэх ухааны номоор 21
- ❖ Хэл шинжлэл болон гадаадын уран зохиолын нийт 150 ширхэг ном

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг цахим болон бусад хэлбэрээр 129 удаа гаргаж 3692 ном хэвлэлийг сурталчилж ажиллалаа.

- "Эмэгтэйчүүд ба хөгжил" баярын арга хэмжээнд: Шилдэг шинэ ном,Бестселлер /79/-номоор үзэсгэлэн гаргаж, номын сангийн уншигчийн карт нээж, ном олгох үйлчилгээ хийсэн.
- "Цэнхэр хязгаар-Увс"-2022 Цасны баярын арга хэмжээнд: Монгол уран зохиол,Амьдрах ухааны /82/- номоор үзэсгэлэн гаргаж,номын сангийн уншигчийн карт нээж,ном олгох үйлчиллээ.
- Дэлхийн номын өдөрт зориулсан номын үзэсгэлэн:
- 2 удаагийн Номын баярын арга хэмжээний үеэр Шилдэг шинэ ном,Бестселлер 111 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж, номын сангийн уншигчийн карт нээн ном олгох үйлчилгээ үзүүллээ.
- Бөхийн өргөөнд зохион байгуулагдсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т Монголын уран зохиол, Гадаадын уран зохиолын /77 ном/-оор үзэсгэлэн гаргаж, 16 хүнд карт нээж 48 ширхэг ном олгож үйлчиллээ.

Цахим үйлчилгээ: **/хавсралт зураг 7/**

- ❖ Номын сангийн Lib4U программын шинэчилсэн Вэб хувилбарыг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.
- ❖ Номын сангийн http://uvslibrary.blogspot.com вэб хаягаа тогтмол шинэчилж байна. Үүнд:
    - Шинээр ирсэн номыг урсдаг хэлбэрээр 3 удаа оруулж шинэчилсэн байна.
    - Цахим ном 3 удаа
    - Электрон каталогийн хаягыг 1 удаа
    - СОНА-ын тухай 10 удаа

- ❖ 10 ш үлгэрийн номыг цахим хэлбэрт оруулсан. Мөн E-san.mn сайтаас 50 ш, нийт 60 ш номыг цахим хэлбэрт орууллаа.
- ❖ Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд http://122.201.23.46 орон нутгийн анхны хэвлэл "Тэргүүний малчин" сонины 1976-1989 онд хүртэлх дугаарыг цахим санд орууллаа.
- ❖ 2022 оны "Увсын өнгө", "Өглөөний сонин"-ы материалыг Zotero програмд сонгон оруулж бааз үүсгэн ҮНС-ын тогтмол хэвлэлийн мэдээллийн сангийн баазад илгээлээ.
- ❖ "Номын сангийн хууль"-ийг постер хэлбэрээр бэлдэж page-д байршуулан иргэдэд сошиалаар сурталчилж байна
- ❖ "Цахим аймаг –Увс" нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээнд мэдээллийн ажилтан Д.Нямбилэг, Сан хөмрөгийн танхимын номын санч Д.Уранчимэг нар байгууллагын танилцуулга, цахимд шилжсэн ажлынхаа танилцуулга, мэдээллийг өгч ажиллаа.
- ❖ Сан хөмрөгт хадгалагдаж байсан 1207 сонин, 790 сэтгүүлийн номын сангийн Lib4U-программд бүртгэж, бар код нааж, нуруу хийж, хаягжуулсан.
- ❖ Социал медиа http://facebook.com/uvslib цахим хуудсаар Номын санд зохиогдсон СОТ-ний ажлын тухай, мөн шинэ номын мэдээ, цаг үеийн холбогдолтой, уншигчдийг соён гэгээрүүлэх мэдээллээр өдөр бүр тогтмол шинэчилэн ажиллаж байна. Үүнд:
  - Цахим хуудсаар E-nom 30 удаагийн мэдээлэл тавьж сурталчилан 683 хүнд хүргэлээ
  - "Би би-гээрээ амьдрахаар шийдсэн нь"," Бар ээж," Чихэр эмэгтэй 147 хоног "гэсэн 3 номоор шинэ номын видео танилцуулга хийж цахим хуудсанд байршуулан 485 хүнд суртачиллаа.

Мэдээлэл, ном зүй, арга зүйн ажлын хүрээнд: /хавсралт зураг.8/

- ❖ Сумдын Monbiblio програмыг эвдрэл гэмтэл гарсан үед нь шуурхай засаж хэвийн байдалд оруулан аргазүйн мэдээлэл өгч ажиллаж байна. Үүнд:
  - Өндөрхангай, Улаангом сумын номын сангийн програмыг засаж хэвийн ажиллагаанд орууллаа.
  - Хяргас сумын номын сангийн програмыг Үүлэн технологид суурилуулсны дараа номын санчид зааж сургах ажлыг цахимаар хийж гүйцэтгэлээ.
  - Өлгий сумын сургуулийн номын сангийн,
  - ЕБ-ын 4-р сургуулийн
  - Өлгийн сумын Соёлын төвийн номын сангийн,
  - Баруунтуруун сумын Соёлын төвийн номын сангийн Monbiblio програмуудыг засаж хэвийн байдалд оруулаа.

Сум, сургуулийн програмыг нийтдээ 15 удаа засаж, шинээр суулгасан байна.

- Аймгийн 10 сумын соёлын төвийн болон сургуулийн номын сангуудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Лавлагаа, Татгалзал: 213 удаа өгсөн. Үүнд:

- Цахимаар өгсөн лавлагаа-12, Сэдэвчилсэн лавлагаа-144, Номзүйн лавлагаа-7 нийт-163
- Татгалзал-50

Сургалт, Мэдээлэл: /хавсралт зураг. 9/

- Үндэсний номын сангийн Мэдээлэл-Аргазүйн хэлтсийн арга зүйч В.Түвшинтогтохыг урилгаар авч ирж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сум,сургуулийн номын

санчдыг хамруулан “**Шинэ эрин зууны номын сан**” сэдэвт 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

- Төв номын сангийн ажилчдад Авлигын эсрэг хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Нармандах, мэргэжилтэн Ц.Гэрэлцэцэг нараас сургалт авлаа.
- **“Түүхэн дурсгалт газар, өв соёл”**сургалтын ажилчдын дунд зохион байгууллаа. Тус сургалтыг Увс аймгийн музейн бүртгэл мэдээллийн санч Мянганбуу мэргэжилтэн явууллаа.
- Увс аймгийн Ураг удам уламжлал холбооны тэргүүн Ж.Дэлэг номын сангийн ажилчдад “**Угийн бичиг удмын түүх**” нэртэй сургалт хийлээ.
- “**Америкийн орон зайн 2022”** сургалт 3-р сарын 28-наас 4-р сарын 1-ний хооронд Улаанбаатар хотын Тэрэлж Ред Рок Резортод болсон сургалтанд АСМТ-ын номын санч, Англи хэлний багш, Аргазүйч нар хамрагдлаа.
- АСМТ-ын номын санч англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор **Wall street** онлайн сургалтанд 14 хоног тутам хамрагдаж байна.
- СУИС-ийн Соёлын сургуулиас зохион байгуулсан “**Номын сан-Цахим шилжилт**”сэдэвт вебинар сургалтанд Мэдээллийн ажилтан Д.Нямбилэг, Сан хөмрөгийн номын санч Д. Уранчимэг нар сууж сертификат авсан.
- Монголын үндэсний номын сан – МАЭШХэслтэсээс зохион байгуулж байгаа **“Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт”**- /нийт 28 цагийн/ онлайн сургалтад Мэдээллийн ажилтан Д.Нямбилэг, Сан хөмрөгийн номын санч Д. Уранчимэг нар хамрагдлаа.
- Мэдээллийн ажилтан Д.Нямбилэг мэргэжлийн ажилчдад “Ном цахимжуулах”- сургалт зохион байгууллаа.
- Номын сангийн нийт ажилчдад **“Хүний эрхийн үндсэн ойлголтууд**” сэдэвт лекц зохион байгуулсан бөгөөд зочиноор Хүний эрхийн үндэсний комиссын ажлын албаны ажилтан Я.Хонгорзул уригдан оролцлоо.Тус сургалтанд 14 хүн хамрагдлаа.

Мэдээлэл /Илтгэл/: ***/хавсралт зураг.10/***

Аймгийн төв номын сан уламжлалт үйлчилгээнээс гадна сургууль, албан байгууллагаар явж илтгэл, яриа хийдэг. Үүнд:

1. Хөдөлмөрийн дээд сургуулийн багш, ажилтан, оюутнуудад дэлхийн номын өдөр “**Номын тэмдэглэл бичих ач тус**” сэдэвт илтгэл тавьсан./60-гаруй оюутан оролцсон. /
2. Ахлах 4-р сургуулийн Дунд, ахлах ангийн сурагчдад “**Гар утасны хэрэглээ ба эрүүл мэнд**” сэдвээр илтгэл тавьж, чөлөөт ярилцлага хийсэн. / 40-н сурагч хамрагдсан/
3. ШШГГазрын түр саатуулах байранд байгаа хүмүүст “**Ном уншихын ашиг тус, номтой хэрхэн харьцах вэ?**” сэдэвт сургалт хийсэн. / 20-н хүн оролцсон /
4. Хилийн цэргийн 0245-р ангийн бие бүрэлдэхүүнд “**Ном унших соёл” илтгэл тавьж, сэдэвчилсэн номын тойм** яриа хийсэн. / 70-гаруй хүн хамрагдсан /
5. 7-р багийн хурал дээр Номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн. /80-гаруй хүн оролцсон /
6. Улаангом сумын ЕБ-ын VI-р сургуулийн 10-р ангийн сурагчид номын сангийн үйл ажиллаагаатай танилцаж уншигчийн карт нээлгэж, Их эзэн Чингис хааны төрсөн өдөрт зориулсан номын үзэсгэлэнтэй танилцлаа. Мөн **"Мэргэжил сонголт"** сэдвээр мэдээлэл

авч, мэргэжил сонголт сонжоо бөглөж мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойллоо. /25-сурагч оролцсон /

Нийт: 295 уншигчид мэдээлэл хүргэсэн.

Төсөв, Санхүү:

- Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд санхүүгийн мэдээллийг тогтмол хүргэж, "Шилэн халаас", "Шилэн данс" хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн самбар ажиллуулж, иргэд олон нийтэд мэдээллэж байна.
- Байгууллагын Вэб сайт болон www.shilendans.gov.mn шилэн дансны вэб сайтад жил, улирал, сар, тухай бүрд төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүссэн шийдвэрийг байршуулан ажиллаа. Батлагдсан төсвийг хуулийн хүрээнд зарцуулж ажиллаа.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль: 72-р зүйл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль: 12 -р зүйл 12.2 .2 дахь заалтын дагуу хөрөнгийн эд хариуцагч солигдсонтой холбоотой тооллого хийж 20 нэр төрлийн ширхэг 3940570 төгрөгний үнэ бүхий үндсэн хөрөнгийг төрийн өмчийн хорооны шийдвэрийн дагуу актлан данс бүртгэлээс хаслаа.

Байгууллагын дотоод ажил: /хавсралт зураг.11/

- Байгууллагын үүдний танхимд ажилчдын хүчээр засвар хийж, таазаа шинэчлэв.
- Америкийн соёл мэдээллийн төвийн шинэ анги үүсгэх засварын ажил хийсэн.
- 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгууллагын үүдний төв танхимд Чингис хааны эш хөрөгийг заллаа.
- Байгууллагын гадна хаягыг монгол бичгээр хийлгэж байрлуулав.
- Хог хаягдлаа ангилан ялгах цэгтэй боллоо.
- Байгууллагын гадна 2 сааданд мод тарьж цэцэгжүүлэлт хийв.
- Байгууллагын гадна гэрэлтүүлэг хийсэн.
- Байгууллагын хашаанд болон гадна талбайд хайрга буулгаж тэгшилж, хашааг будаж зосдов.

Шинээр санаачлан хийсэн шинэлэг ажил: / Хавсралт зураг.12/

1. Сурагчдын зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд туслах зорилгоор 7 сард Хархираа хүүхдийн зусланд "салбар номын сан" ажиллуулсан. 54 хүүхдэд цаасан карт нээж 500 гаруй номоор үйлчилж, амрагч багачуудын дунд СОНА- зохион байгуулаж ажиллаа. / зураг.1/
2. Сурагчдын зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд туслах зорилгоор 7 сарын 29-с 8 сарын 29 хүртэл Гашууны голын хөвөөнд **"Гэр номын сан"** ажиллуулж 44 хүүхдэд шинээр карт нээж 450 гаруй номоор үйлчилж ажилласан. / зураг.2/
3. Аймгийн Төв номын санг Заяа бандида Намхайжамцын нэрэмжит болгохыг хүссэн албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, энэ хүрээнд түүхийн ухааны доктор, профессор На.Сүхбаатартай холбогдон шаардлагатай ажлуудыг хийж эхлээд байна. / зураг.3/

4. “Хүргэлтийн ном” багцийн үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хүргэлтийн номын 10 багц гаргаж номын жагсаалт, байгууллагын хүрээнд Ном хүргэлтийн журам гаргаж ажиллаа.

   2022 онд хүргэлтийн үйлчилгээгээр 145 ном үйлчилгээнд гаргасан.   / зураг.4/

5. Иргэдэд автобус хүлээнгээ дуртай номоо унших орчин нөхцлийг бүрдүүлэхийн тулд “Та авч, өгч болно” уриатай Чөлөөт номын сан буюу “Гудамжны номын сан”-г Хөдөлмөрийн дээд сургуулийн автобусны зогсоол дээр байгууллаа.

   Уншигчид өөрсдийн дуртай номоо авч унших, өөрт байсан номоо өгөх зэргээр номын баяжилтыг хамтран хийж байгаа ба манай номын сангийн зүгээс 9 сарын 16-аас хойш 12 удаа шинэчилэн, 1500 ном сэтгүүлээр баяжуулсан.   / зураг.5/

6. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан уншигчдын дунд “**Гэр бүлийн уншлага”** challenge зарласан. Энэ ажлын хүрээнд 7 хоног бүрийн бямба гаригыг

   “**Гэр бүлийн уншлагын өдөр**” болгон ажиллаж байна .   / зураг.6/

7. “**Хуучин номын худалдаа**” зохион байгуулаж ажиллаа. Уншигчдийн хэрэгцээ шаардлага хангахгүй болсон 17025 ш ном хэвлэлийг актлах аймгийн ИХТ-ийн шийдвэрийн дагуу үнэ тогтоож зарсан. / зураг.7/

Хавсралт зураг:

Зураг.1

Зураг.2

Зураг. 3

Зураг. 4

Зураг.4

Зураг.5

АСМТ-ийн номын санч уншигчдад зориулан бэлтгэдэг подкаст:

Зураг.6

зураг.7

Ном сэлбэн засалт:



Ном сэлбэн засах ажил:

Зураг.8

Зураг.9

Зураг.10

Зураг.11

Шинээр санаачлан хийсэн шинэлэг ажил:

Зураг.1

Зураг.2

Зураг.3

Зураг.4

Зураг.5

Зураг.6

Зураг.7

ХОВД АЙМГИЙН МУСГЗ М.БАЯНЗУЛЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН

2022 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2022.12.05

Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтэнд анхааран Аймгийн Засаг Даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллав.

2022 оны эхнээс байгууллагын ажлын төлөвлөгөөг жилээр гаргаж зорилго зорилтууд, хийгдэх ажлын талаар ярилцан нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийтийн номын сан нь 2020-2024 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Оюунтүлхүүр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд 18 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 8 тасаг танхимаар уншлага үйлчилгээ үзүүлж байна.

Статистик үзүүлэлт:

2022 оны жилийн статистик тоон мэдээллийг төлөвлөгөөтэй харьцуулбал:





Байгууллагаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажил болон хийгдэж буй арга хэмжээ, мэдээлэл сурталчилгааг Фейсбүүк хуудсанд тогтмол байршуулан баяжуулан ажиллаж байна. Фейсбүүк хуудасны LIKE 10,982 - аас 11,049 болж, өссөн лайкны тоогоороо тэргүүлэн шинэ содон мэдээллээр хангаж байна.

Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь www.shilendans.gov.mn сайтад шивж оруулж тайланг улирлаар цаг тухайд нь илгээсэн.

Байгууллагын админаар захирал Т.Эрдэнэтуяа, хэрэглэгчээр Нягтлан бодогч О.Чанцалмаа, Мэдээллийн ажилтан Д.Нямгэрэл нарыг томилон цаг тухай бүр нь мэдээллийг тогтмол шивдэг.

Байгууллагын 2022 оны Ирсэн бичиг, Явуулсан бичиг, Захиралын /А,Б/ тушаал, ажилтнуудын тайлан, үр дүнгийн гэрээ, хурлын тэмдэглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг архивын баримт бичгийг хавтаслаж, товъёог үйлдэж, баталгааны хуудас хийж архивлав.

E-Mongolia-д Номын сангийн онлайн үйлчилгээг нэвтрүүлэн оруулж ажиллаа.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АЙМГИЙН ОЮУНТҮЛХҮҮР ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэх тухай 105 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр аймгийн “Монгол хэл, бичиг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үндэсний бичиг, өв соёл, түүхийг өвлөн эзэмших, олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх зорилготойгоор Хэлний бодлогын зөвлөл, СУГ-тай хамтарч “ҮНЭТ ӨВ, ҮНДЭСНИЙ ДАРХЛАА-ЭХ ХЭЛ МИНЬ” аяныг цахим болон танхимаар амжилттай зохион байгуулж явууллаа. Аяныг тусгай удирдамж, хөтөлбөр гарган олон үйл ажиллагааг зохион байгуулав.Үүнд: Уран бичлэгийн уралдааныг мэргэжлийн багш нар, иргэд, сурагчид гэсэн

ангиллаар явуулж нийт 30 оролцогч оролцож, Тэргүүн байранд Прогресс сургуулийн МХУЗ–ын багш Г.Бурмаа, Дэд байранд Манхан сумын –ын багш Т.Дунгармаа, Гутгаар байранд Жаргалант сумын ЕБ-ийн 3 дугаар сургуулийн МХУЗ–ын багш Ц.Насанхишиг, Иргэдийн ангилалд Тэргүүн байранд ГХХЗХГ-ын ажилтан Б.Ганцэцэг, Дэд байранд ХИС-ийн БАБ-ийн оюутан А.Аззаяа, Гутгаар байранд Манхан сумын иргэн Б.Сосорбурам, ЕБС-ийн сурагчид ангилалд Тэргүүн байранд ЦАЦ цогцолбор сургуулийн 10-а ангийн сурагч Б.Болортунгалаг, Дэд байранд Манхан сумын ЕБС-ийн 8-а ангийн сурагч Б.Хишигдэлгэр, Гутгаар байранд Прогресс сургуулийн 12-а ангийн сурагч Д.Нарангэрэл нар шалгарлаа. Монгол бичгийн сайхан бичигтэн уралдаанд нийт 135 оролцогч оролцож 6-7 дугаар ангийн насны ангилалд Тэргүүн байранд Прогресс сургуулийн 7-б ангийн сурагч О.Анхзаяа, Дэд байранд Прогресс сургуулийн 7-в ангийн сурагч Лу Хулан, Гутгаар байранд ЦАЦ сургуулийн 7-б ангийн сурагч Ц.Оюунсондор, 8-9 дүгээр ангийн насны ангилалд Тэргүүн байранд Манхан сумын 8-а ангийн сурагч Б.Хишигтөгөлдөр, Дэд байранд ЦАЦ сургуулийн 9-г ангийн сурагч П.Ану, Гутгаар байранд Прогресс сургуулийн 9-б ангийн сурагч Саруулмаа, 10-12 дугаар ангийн ангилалд Тэргүүн байранд 1 дүгээр сургуулийн 12-г ангийн сурагч Г.Ундрал, Дэд байр 6 дугаар сургуулийн 11-г ангийн сурагч Г.Ижилцэцэг, Гутгаар байранд 3 дугаар сургуулийн 12-а ангийн сурагч М.Мэндбаяр, Иргэдийн ангилалд Тэргүүн байранд Мөнххайрхан сумын иргэн Н.Эрдэнэхишиг, Дэд байранд Дөргөн сумын цэцэрлэгийн нярав Ё.Нямаа, Гутгаар байранд УЦУОШГ-ын ажилтан Ц.Нямбаяр нар шалгарлаа. “Босоо бичиг-Бидний бахархал” тэмцээнд 5 байгууллага оролцож, Тэргүүн байранд Хөгжил Политехник коллежийн “Өвийн хэлхээ” баг, Дэд байранд МХГ-ын Тэнгэрийн бичигтэн баг, Гутгаар байранд ХХААГ-ын Босоо бичигтэн баг, Гутгаар байранд 11 дүгээр цэцэрлэгийн Монгол бахархал баг, Тусгай байранд 15 дугаар цэцэрлэгийн багууд шалгарлаа. Монгол бичгийн Тэргүүний уншигч уралдаанд нийт 300 оролцогч оролцож 6-7 дугаар ангийн ангилалд Тэргүүн байранд Алтай сумын Б.Оюумаа, Дэд байранд ЦАЦ сургуулийн 7-а ангийн сурагч Г.Гантуяа, Гутгаар байранд Мөнххайрхан сумын ЕБС-ийн 7-б ангийн сурагч Б.Мягмарсүрэн, 8-9 дүгээр ангийн ангилалд Тэргүүн байранд Мөнххайрхан сумын 9-а ангийн сурагч Г.Алтандэлгэр, Дэд байранд 6 дугаар сургуулийн 9-г ангийн сурагч Б.Сугар, Гутгаар байранд Мөст сумын Энхжин, 10-12 дугаар ангийн ангилалд Тэргүүн байранд 6 дугаар сургуулийн 11-г ангийн сурагч Д.Мөнгөнхорол, Дэд байранд Дөргөн сумын 10-б ангийн сурагч С.Мөнгөнцэцэг, Гутгаар байранд 6 дугаар сургуулийн 11-г ангийн сурагч Б.Хонгорзул, Төрийн албан хаагчдын ангилалд Тэргүүн байранд Мөнххайрхан сумын ЕБС-ийн гадаад хэлний багш Э.Бурмаа, Дэд байранд Манхан сумын ЕБС-ийн дуу хөгжмийн багш Ц.Дэлгэрмаа, Гутгаар байранд Манхан сумын ЕБС-ийн физикийн багш Б.Энхцэцэг, Иргэдийн ангилалд Тэргүүн байранд Мөнххайрхан

сумын иргэн Д.Оюунчимэг, Дэд байранд Зэрэг сумын иргэн Э.Чулуунцэцэг, Гутгаар байранд Зэрэг сумын иргэн Э.Мөнх-Учрал нар шалгарлаа. “Монгол бичиг- Манай хамт олны бахархал” аяны хүрээнд Боловсрол, соёлын байгууллагуудын дунд “Үндэсний бичиг соёлоо дэлгэрүүлэгч байгууллага”-ыг тодруулан алдаршуулах зорилгоор монгол бичгийн орчин бүрдүүлэх, сурах хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлах чиглэлүүдээр хийсэн ажлын товч мэдээллийг видео хэлбэрээр цахим орчинд түгээх ажлууд хийгдэж 30 байгууллага оролцлоо. Тухайлбал: ЕБС-ийн ЦАЦ сургууль, 1, 2, 6 дугаар сургууль, 14 дүгээр цэцэрлэг, Хөгжил-Политехник коллеж, Нийтийн номын сан, МХГ, Манхан, Чандмань, Буянт, Мянгад, Дарви, Зэрэг, Дөргөн, Эрдэнэбүрэн, Алтай, Мөнххайрхан, Булган, Мөст сумын сургуулиуд зэрэг байгууллагууд оролцлоо. 2022 оны Үндэсний бичиг үсгийн баярын арга хэмжээ нь 2021 оныхоос нэг дахин илүү оролцогч оролцлоо. 2021 онд 155 оролцогч оролцож байсан бол 2022 онд 509 оролцогч оролцлоо. “ҮНЭТ ӨВ, ҮНДЭСНИЙ ДАРХЛАА-ЭХ ХЭЛ МИНЬ” аяны үйл ажиллагааг 2022 оны 04 сарын 01-ээс 05 сарын 11-ний хооронд зохион байгуулж явууллаа. Оролцогчдын унших, бичих ур чадвар нэмэгдэж, хийж хэрэгжүүлсэн ажлуудын тоо өссөн болон байгууллагууд маш их өрсөлдөөнтэй идэвхтэй, үр дүн өгч ажилласан, ач холбогдол үзүүлсэн арга хэмжээ боллоо.

Шалгарсан оролцогчид:

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд- 2022” номын баярын нээлтийн үйл ажиллагааг 05 сарын 20-21-ний өдөр Ард Аюушийн талбай дээр зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд Соёлын болон Боловсролын байгууллагууд албан байгууллагууд, сумдын соёлын төвийн ажилтнууд, ард иргэдийн дунд ховор болон хуучны ном судар, уйгаржин, тод бичгийн номын үзэсгэлэн, ном бэлэглэх, хандивлах, солилцох, орон нутгийн зохиолч уран

бүтээлчид онцлог бүхий гар бичмэл, гарын үсэгтэй номын худалдаа, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар бүтээсэн бүтээлийн үзэсгэлэн, уран бичвэрийн үзэсгэлэн худалдаа зэрэг арга хэмжээнүүдийг 2 өдрийн турш амжилттай зохион байгуулж явууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Номын баяр”-ыг тэмдэглэх тухай 158 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор бүх нийтэд соёл, мэдээлэл, боловсролыг олгоход чиглэсэн бүтээлч үйл ажиллагааны хүрээнд 24 ажлыг 3 чиглэлээр удирдамж, хөтөлбөр гаргаж, төлөвлөн ажиллаж байна. Үүнд 1. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд “Ураг удмаа судлъя” үндэсний бичиг, угийн бичгийн сургалтыг төрийн албан хаагчид, ард иргэдийн дунд 8 удаа зохион байгуулж нийт 300 гаруй хүн оролцлоо. Номын сангийн үйлчилгээг төрийн албан хаагчдад хүргэх,

байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, эерэг хандлагыг бий болгож номтой нөхөрлүүлэх зорилготой Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын албан хаагчид түүний гэр бүлийн гишүүдийн дунд “Номтой өглөө” аяныг зохион байгуулж нийт 18 байгууллагын 700 гаруй хүн хамрагдлаа. Аяны хүрээнд тусгай хөтөлбөр гарган номын сангийн үйлчилгээний танилцуулга хийх, харилцан туршлага солилцох, номын сан үүсгэн байгуулж буй байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Монголын нууц товчоог залах үйл ажиллагаа явуулах, шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчлах, хамтран ажиллах гэрээ байгуулан зөөврийн номын сангаар үйлчилгээ үзүүлэх, танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион явуулах, багийн ажиллагааны сургалт мэдээлэл өгөх зэрэг ажлуудыг амжилттай зохион байгуулан явууллаа. Аяны үр дүн нь хамтын ажиллагаа сайжирч, нийт ажилтан албан хаагчдын гэр бүл, хүүхдүүд номтой нөхөрлөх, мэдлэг боловсролоо нэмэгдүүлэх, ном унших дадал хэвшилд суралцах, мэдсэн мэдлэгээ хэрэгжүүлэх, бусдад үлгэр дууриалал үзүүлж, хандлагаа өөрчилсөн байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор **#Илүү_их_уншъя"** уриатайгаар улс орон даяар зохион байгуулагдаж байна.

Энэ арга хэмжээний хүрээнд **"Хамтдаа уншъя Гэр бүлийн уншлага"** –ыг төв талбайд зохион байгуулахад 6-р сургуулийн Х.Уранцэцэг багштай 6б ангийн хамт олон эцэг эхчүүд идэвх санаачлагатай оролцлоо.

Мөн уншсан зохиолоороо бүтээл ханын сонин хийлээ.

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд: 800 ширхэг шинэ, 2000 гаруй сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 21 удаа гаргаж иргэдэд сурталчиллаа. Монголын нууц товчоо зохиолыг уншигчдад таниулан сурталчлах, зохиолоор хийсэн ном болон номын тэмдэглэлийг

шалгаруулж сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа.

Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж буй 18 төрийн байгууллагын 700 гаруй, ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын төлөөлөл 2500, нийт 3200 гаруй уншигчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч боловсруулан дүгнэлт хийж ажиллав.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор #Илүү_их_уншъя” уриатайгаар улс орон даяар 09 сарын 16-18-ны өдрүүдэд 2 дахь удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд- 2022” номын баярын 2 дахь өдрийн үйл ажиллагаа нь МУСГЗ М.Баянзулын нэрэмжит нийтийн номын сангийн номын санчдын эмхэтгэн гаргасан “Орон нутгийн зохиолчдын ном зүйн бүртгэл” шинэ номын нээлтээр эхэлж, хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж явагдлаа.

Шинэ номын нээлтийн тууз хайчлах ёслолын үйл ажиллагаанд Соёл урлагийн газрын хэлтсийн дарга Д.Гантуяа, мэргэжилтэн Б.Бадамцэцэг, МЗЭ-ийн гишүүн зохиолч, яруу найрагч А.Жаргалсайхан, МЗЭ-ийн гишүүн зохиолч, яруу найрагч шүүхийн тамгын газрын дарга Д.Даваасүрэн, МЗЭ-ийн гишүүн зохиолч, яруу найрагч Ц.Жагирзүсэм, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Б.Оюунхүү, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Г.Бямбаа, Нийтийн номын сангийн ахмад ажилтан Ц.Мөнхжаргал нар урилгаар оролцож үнэтэй сайхан зөвлөгөө мэдээлэл өгч мэндчилгээ дэвшүүллээ.

Өнөөдрийн үйл ажиллагаанд:

• Шинэ номын нээлтийн үйл ажиллагаа

• Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ “АХА” тэмцээн

• Номын тэмдэглэл, бүтээлийн үзэсгэлэн

• Номын худалдаа
• Ховор хуучин номын худалдаа, солилцоо
• Номын хандив, бэлэг
• Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа
• Ховор хуучин номын үзэсгэлэн
• Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн
• Бичиг соёл- бидний бахархал үзэсгэлэн
• Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа

“ГАН ҮЗЭГ 2022” яруу найргий наадам

Жил бүр уламжлал болгон зохион байгуулж явуулдаг Ган үзэг яруу найргийн наадам нь 16 дахь жилдээ амжилттай явагдлаа. Уг наадамд дөрвөн насны ангилалд нийт 121 оролцогч оролцлоо. Үүнээс: 4-6-р ангийн насны ангилалд 34, 7-9-р ангийн насны ангилалд 35, 10-12-р ангийн насны ангилалд 41, насанд хүрэгсэд 11 оролцогч оролцож, 4-6-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд Мөнххайрхан сумын 5б ангийн сурагч М.Батзаяа, Дэд байранд 1-р сургуулийн 6г ангийн сурагч О.Халиунаа, Гутгаар байранд Манхан сумын 6а ангийн сурагч М.Дашчирав, Тусгай байранд Алтай сумын 6а анги Б.Отгонжаргал, Мөнххайрхан сумын 6б ангийн сурагч А.Энхбулган, 7-9-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд Алтай сумын 7а анги Б.Оюумаа, Дэд байранд 1-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Хулан, Гутгаар байранд 1-р сургуулийн 8д ангийн сурагч Х.Бат-Ундрал, Тусгай байранд ЦАЦ сургуулийн 9а анги Б.Бямбасүрэн, Дуут сум 9а анги М.Гэрэлчимэг, 10-12-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд Алтай сумын 11б анги Б.Хонгорзул, Дэд байранд 1-р сургуулийн 12б ангийн сурагч Г.Амгалан, Гутгаар байранд 3-р сургуулийн 11а ангийн сурагч Х.Атархүү, Тусгай байранд Үенч сумын 11б анги А.Хүслэн, Алтай сумын 10а анги Д.Туяацэцэг, насанд хүрэгсэд ХИС-ийн оюутан Б.Маралмаа, 1-р сургуулийн багш Б.Хөлөгбоорчи, Чандмань сумын багш Я.Сэлэнгэ, Үенч сумын багш П.Отгонзаяа, ХИС – ийн оюутан Э.Гантуул нар шалгарч, эхний 3 байр Ган үзэг тэмдэгтэн боллоо.

Шувуун саарал богино өгүүллэгийн уран уншлагын наадам нь 26 дахь жилдээ амжилттай явагдлаа. Уг наадамд дөрвөн насны ангилалд нийт 169 оролцогч оролцлоо. Үүнээс: 1-3-р ангийн насны ангилалд 49, 4-6-р ангийн насны ангилалд 58, 7-9-р ангийн насны ангилалд 33, 10-12-р ангийн насны ангилалд 25, насанд хүрэгсэд 4 оролцогч оролцож, 1-3-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд 3-р сургуулийн 2в ангийн сурагч А.Чанд-Үнэн, "Дэд байр" Мөст сумын 2а ангийн сурагч Э.Аялгуу, "Гутгаар байр" III сургуулийн 2в ангийн сурагч С.Ивээл "Тусгай байр" VII сургуулийн 2г ангийн сурагч Ж.Элбэгзаяа, 3а ангийн сурагч Д.Билэгжаргал, 4-6-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд III сургуулийн 5а ангийн сурагч Г.Анармаа, "Дэд байр" VII сургуулийн 6а ангийн сурагч Ч.Нандин-Эрдэнэ "Гутгаар байр" VII сургуулийн 4а ангийн сурагч Т.Сумъяа "Тусгай байр" III сургуулийн 6а ангийн

сурагч Ж.Энхгэрэл, Б.Хулан, 7-9-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд Ховд сумын 9б ангийн сурагч А.Нуршуах, "Дэд байр" Дөргөн сумын 9а ангийн сурагч Б.Сарангэрэл "Гутгаар байр" Прогресс сургуулийн 7б ангийн сурагч М.Номиндарь "Тусгай байр" I сургуулийн 7в ангийн сурагч Х.Бүдханд, Буянт сумын 9а ангийн сурагч Б.Хүслэн, 10-12-р ангийн насны ангилалд Тэргүүн байранд Дөргөн сумын 10а ангийн сурагч Э.Буянтогтох, "Дэд байр" Буянт сумын 11а ангийн сурагч Ц.Номин-Эрдэнэ "Гутгаар байр" I сургуулийн 11г ангийн сурагч Ө.Маралжингоо "Тусгай байр" VI сургуулийн 11а ангийн сурагч Б.Нямгэгээ, Үенч сумын 11б ангийн сурагч А.Хүслэн, насанд хүрэгсэд ХИС оюутан Т.Насантогтох, "Дэд байр" ХИС оюутан Т.Даариймаа "Гутгаар байр" Д.Саруулзаяа "Тусгай байр" Ү?нч сумын багш П.Отгонтуяа, нар шалгарлаа.

“Шувуун саарал” наадмын шилдэгийн шилдэг Гранпри шагналын эзнийг цахим орчинд хамгийн их лайк хандалт авсан оролцогчийг шалгаруулахад Буянт сумын 11а ангийн сурагч Ц.Номин-Эрдэнэ 3112 хүний хандалтыг авч "ГРАНПРИ" –аар шалгарлаа.

“УГИЙН БИЧИГ”-ийн сургалтыг хагас жилийн байдлаар 10 байгууллага дээр хийж нийт албан хаагчдыг, “угийн бичиг” хөтлөх анхан шатны мэдлэг, сэдэлжүүлэх, мэргэшүүлэх сургалтыг төлөвлөгөөт хуваарийн дагуу зохион байгуулж ажиллаа. Үүнд ГБХЗХГ, Онцгой байдлын газар, Байгаль орчин-ний газар, Цагдаагийн газар, Жаргалант сум, Биеийн тамир спортын газар, ШШГГ, Алтай сумын төрийн албан хаагч нарт /Мэргэшүүлэх/ сургалт зохион байгуулж ажиллаа.

Номын фонд баяжилтаар 549 ширхэг ном худалдаагаар, 292 ширхэг ном бэлэг хандиваар ирсэн номыг нэхэмжлэлийн дугаараар нэгдсэн болон нэг бүрчилсэн дансанд бүртгэж, дагалдахыг нь баталгаажуулж, санхүүгийн бүртгэлд оруулж ажиллаа.

Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудтай хамтарч “Номтой өглөө” аяныг амжилттай зохион байгуулан явууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийн дагуу Монголын нууц товчоог ХХҮГ-ийн номын санд залж, хамт олонд нь номын сангийн үйлчилгээ үзүүлж ажиллаа.

ЗДТГ-т төлөвлөгөөт хуваарийн дагуу очиж өглөөлөг зохион байгууллаа.

НОМТОЙ ӨГЛӨӨ” нээлттэй хаалга-ны өдөрлөг “Цагдаагийн газар ”

“НОМТОЙ ӨГЛӨӨ” нээлттэй хаалга-ны өдөрлөг “Жаргалант сум ”
“НОМТОЙ ӨГЛӨӨ” “Биеийн тамир спортын газар”
“НОМТОЙ ӨГЛӨӨ” нээлттэй хаалга-ны " “Эрүүл мэндийн газар ”
Хөгжил Политехник коллеж:

ЕБ-ийн 1 дүгээр ахлах сургууль дээр очиж “Нээлттэй хаалганы өдөр” өдөрлөгт, байгууллагын танилцуулга мэдээлэл хийж, сурагчдын дунд “Нууц товчооны нууцад нэвтрэхүй” сэдэвт танин мэдэхүйн АХА тэмцээн, номын үзэсгэлэн сурталчилах зэрэг ажлууд зохион байгуулж явууллаа.

ЕБ-ийн 2 дугаар сургууль дээр “Нээлттэй хаалга” өдөрлөг:
ЕБ-ийн 6 дугаар сургууль дээр “Нээлттэй хаалга” өдөрлөг:
Прогресс сургууль сургууль дээр “Нээлттэй хаалга” өдөрлөг:

3. Уншлагыг дэмжих арга хэмжээний хүрээнд: Зохиолч уншигчдын уулзалтыг онлайн болон танхимаар зохион байгуулж явууллаа. Уулзалтанд орон нутгийн зохиолч

уран бүтээлчидтэй ЕБС-ийн номын клубын гишүүд оролцож, номтой нөхөрлөхийн ач холбогдол, уншлагыг зөв удирдан явуулах, шүлэг зохиол бичих арга аргачлалын талаар чөлөөт ярилцлага зохион байгууллаа.

“Ном дотор зам бий” нээлттэй хэлэлцүүлгийг ЕБС-ийн ахлах дунд ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Оролцогчид хүний хөгжлийн номыг арай илүү уншиж, улмаар уншсан номоосоо сургамж авч өөрийгөө өөрчилсөн туршлагаасаа харилцан ярилцаж

дүгнэлт хийсэн хэлэлцүүлэг боллоо.

ЕБС-ийн сурагчдын дунд “Номын сангийн идэвхтэн – уншигч” уралдааныг шалгаруулж шагнаж урамшуулав.

6-р сургуулийн Цэрэнбадам багштай 4б анги хамт олон Нийтийн номын санд ангиараа карт нээлгэж уншигч боллоо

ЦАЦ сургуулийн Б.Цоггэрэл багштай 3в анги хамт олон, ЦАЦ сургуулийн Д.Цэрэндулам багштай 8в анги хамт олон

ЦАЦ сургуулийн Б.Хоролсүрэн багштай 8а анги, ЦАЦ сургуулийн Мөнхцэцэг багштай 5в анги

2-р сургуулийн О.Мандалхүү багштай 3а анги, 6-р сургуулийн Лхагвасүрэн багштай 9а ангийн сурагчид

2-р цэцэрлэгийн Ц.Оюунбилэг багштай "Ахлах А", О.Батчимэг багштай "Ахлах Б" бүлгийн бяцхан багачууд

"Уншихуйн гайхамшиг" илтгэлийн уралдааныг оюутан болон ахлах ангийн сурагчдын дунд 2 удаа зохион байгуулж, шагнаж урамшуулав.

"Үлгэрээс суралцъя" чанга уншлагыг сургуулийн өмнөх болон бага ангийн сурагчдын дунд зохион байгуулан явууллаа. Энэ арга хэмжээнд Жаргалант сумын 2, 3, 14 дүгээр цэцэрлэгийн бага дунд бүлгийн суралцагчид ЕБ-ийн 1, 2, ЦАЦ, Прогресс сургуулийн 3, 4 дүгээр ангийн сурагчид хамрагдлаа. "Номтой нөхөрлөе" урилгат уншлагыг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж, ЦАЦ сургуулийн 3,4,5,6, 8--р анги, 6 дугаар сургуулийн 4 ,5, 7, 9-р анги, 1, 2 дугаар сургуулийн 4,7-р ангийн нийт 1500 гаруй сурагчид хамрагдлаа.

Орон нутгийн соёлын байгууллагуудтай танилцах аяллыг Чандмань сумын ЕБС-ийн Оюун-Эрдэнэ багштай 4-б ангийн хамт олонтой хамтран зохион байгууллаа.

Энэ үеэр хүүхдүүд дэлхийн нэрт зохиолчдын зохиол бүтээлээс уншиж хоорондоо мэтгэлцэж, үр бүтээлтэй уншлага хийлээ.

Мөн их мэдэх танхимаас Дэлхийн хүүхдийн шилдэг бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

“МИНИЙ УНШСАН ХАМГИЙН ШИЛДЭГ ЗОХИОЛ” зохион бичлэгийн уралдаан





ЦАЦ Сургуулийн 6г ангийн сурагч Норжинсүрэн 1-р байр, 5б ангийн Тэнгис 2-р байр, 7 сургуулийн 6а ангийн сурагс Должин 3-р байр тус тус эзэллээ.

МИНИЙ МӨРӨӨДЛИЙН НОМЫН САН ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

ЕБС-ийн 5-р ангиудын дунд зохион байгуулсан гар зургийн уралдаанд 1-р сургуулийн 5а ангийн Учрал 1р байр, ЦАЦ сургуулийн 5в ангийн сурагч Мишээл 2-р байр, 2-р сургуулийн 5г ангийн сурагч Тэмүүлэн нар тэргүүллээ.

Цаст-Алтай цогцолбор сургуулийн Бямбасүрэн багштай 5а, Отгонцэцэг багштай 5-б, Нарандулам багштай 5-г ангийн сурагчид Нийтийн номын сангийн Их мэдэх танхимд 2 өдөр "Бүтээлч уншлага"-д хамрагдаж уншсан номоороо ном бүтээж, ярилцлаа.

Оюунтүлхүүр дэд хөтөлбөрийн хүрээнд нийтийн номын сангаас зохион байгуулж буй "Номтой нөхөрлөе" номын тухай нээлттэй хэлэлцүүлэгт ЕБС-ийн 6 дугаар сургуулийн 12-р ангийн сурагчид оролцлоо.

Хэлэлцүүлэгт :Цойлогсод, Өглөөний гайхамшиг, Харвардын сургуулий оюутнууд, Тренд бүсгүй, Ад үзэгдэх зориг, Эерэг харилцаа, Дэггүй нас зэрэг уншсан номынхоо тухай сонирхолтой илтгэл тавьсан сурагч Энх-Амгалан, Анударь, Чимэдцээеэ, Хэрлэн, Мөнхсүлд, Сувд-Эрдэнэ, Анужин болон багш М.Сарантуяа, О.Шийжав, Баярмаа нартаа талархал илэрхийлье. Дэлхийн яруу найргийн өдөртөө давхцсан энэ өдрийн хэлэлцүүлгийн уриа "Залхуурал бол маш чихэрлэг амттай зүйлтэй адил", "Эерэг хандлагатай байхад амьдрал сайхан ", Ном гэдэг дүүлэн нисэх аз жаргалыг хайрлана.

Ховд аймагт үйл ажиллагаагаа явуулж буй бага насны хүүхдүүдийн сувиллын “Ивээл” төвтэй хамтарч зуслангийн байранд нь очиж явуулын номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллаа. Тус арга хэмжээний хүрээнд тусгай зорилтот бүлгийн хүүхдүүдэд “Явуулын хүүхэлдэйн театр” ажиллуулж, үлгэр ярих, сонсдог ном, брайль ном, хүүхдийн зурагт ном, үлгэрийн номоор үзэсгэлэн гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулсан нь хүүхдүүдийн сонирхлыг татаж, талархал илэрхийлсэн сайхан ажил боллоо.

"Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны хөдөө орон нутгийн салбарыг чадавхижуулах сургалт семинарын үйл ажиллагааны үеэр сонсдог ном, брайль үсгийн номоор үзэсгэлэн гаргаж, холбогдох шийдвэр гаргах түвшний Сургалт нөлөөлөл хариуцсан ажилтан Б.Болдбаатартай уулзаж, брайль ном унших техник, дүрэм арга барилыг сургах сургалт зохион байгуулах талаар зөвлөгөө мэдээлэл солилцож ажиллаа.

"Цагаан уул" сувилалд амарч буй Булган, Мөст сумын амрагчдад зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ. Амрагчдад ном уншуулах, тоглоом тоглуулах, угийн бичгийг хөтлөх аргачлал мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээ үзүүлсэн нь ахмадуудын талархал илэрхийлсэн сайхан үйл ажиллагаа боллоо.

МУСГЗ М.Баянзулын нэрэмжит Нийтийн номын сангаас зуслангийн айлуудад "Зуны зугаатай уншлага" нүүдлийн гэр номын сангаар үйлчлэх нэг сарын аяны хүрээнд бяцхан уншигчиддаа үйлчилгээ үзүүллээ.

Улаанбаатар хотоос Гэрэлт номч ТББ-ын гэр бүл "Энэ номыг амандаа битгий хийгээрэй" уулзалт номын танилцуулгыг өнөөдөр лагерын "Шар гэр " дээр зохион байгуулж ажиллалаа. Бяцхан уншигчид маань аав, ээж, ах эгчтэйгээ ирж үлгэр сонсож, зураг зурж бүтээл хийсэн бол эцэг эхчүүд маань хүүхдээ хэрхэн номонд дуртай болгох талаар бяцхан яриа өрнүүлж нэг өдрийг үр бүтээлтэй өнгөрөөлөө.

Хүүхдүүдийн дунд тэмцээн зохион байгуулж Таслах, Охид хөвгүүн тэмцээн зохион хүүхдүүдийн дуу шүлэг “Талархалаа илэрхийлэе” өдөр бүр суралцаж тэмцээн явуулалаа. Цэцэн үгийн далай зүйр цэцэн үгсийг хэн олон унших вэ ? Уншигчдад шинэлэг, мэдээ , мэдээлэл тогтмол өгч ажилласан.

СОЁЛЫН бүтээлч сар аяны хүрээнд МУСГЗ М.Баянзулын нэрэмжит Нийтийн номын сангаас ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Хөөмий бидний бахархал” сэдэвт лекц танилцуулга хийж, УИТ-аас Алтан хонх тэмцээнийг амжилттай зохион байгуулж явууллаа. Тус арга арга хэмжээнд оролцсон 1 дүгээр сургуулийн 7г ангийн сурагч Ө.Жаргалбаяр, ЦАЦ сургуулийн 6б ангийн сурагч У.Цэлмэг, Дуут сумын ЕБС-ийн 10а ангийн сурагч А.Сэргэлэн, Прогресс сургууль, 6, 3 дугаар сургуулийн 6-8-р ангийн сурагчдын дундаас Тэргүүн байрын эзэн 8в ангийн сурагч Ө.Дэлгэрмаа нар тус тус шалгарлаа. Уг арга хэмжээнд нийт 1500 гаруй хүүхдүүд хамрагдлаа.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР: Бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэхэд Захирал Т.Эрдэнэтуяага монгол бичгийг бийрээр бичих сургалт мэдээллийг байгууллагын ажилтнуудад хийж сургалтанд хамрагдлаа.

МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Б Баяраагийн " Хадны ундаа" шинэ номын нээлтийг зохион байгуулж явууллаа. Нээлтэнд яруу найрагчийн "Наран хайрхан" шүлгэнд ая зохиосон хөгжмийн зохиолч МУУГЗ Цолмон, Соёл урлагийн газрын дарга М.Пүрэвхүү болон албаны төлөөлөгч, ах дүү, хамаатан садан найз нөхөд нь уран бүтээлийн мялаалга, сэтгэлийн мэндчилгээ хүргэсэн сайхан арга хэмжээ боллоо.

МЗЭ гишүүн, зохиолч, яруу найрагч хөнхөрийнхөн овогт говоон ДАШНЯМЫН ДАВААСҮРЭНГИЙН "Гурав дахь нүд" шинэ номын нээлт боллоо.

Аймгийн Соёлын төв, ЕБС-ийн номын санч нарын дунд "ИЛТГЭЛ"-ийн уралдаан зохион байгууллаа, "Номын сангийн ирээдүйн чиг хандлага". "Ном унших сэдэл тэмүүллийг хэрхэн бий болгох вэ?", "Номын санчийн мэргэжлийн ур чадвар үр нөлөө" гэсэн сэдвүүдийн хүрээнд сонголт хийж, асуудал, шийдэл дэвшүүлсэн энэхүү уралдаанд сум сургуулийн номын санч нар оролцлоо."

1-р байр Прогресс сургуулийн номын санч Д.Туяацэцэгийн "Номын сангийн ирээдүйн чиг хандлага" илтгэл

2-р байр Прогресс сургуулийн номын санч Д.Туяацэцэгийн "Номын сангийн өнөөгийн байдал" илтгэл

3-р байр Зэрэг сумын Соёлын төвийн номын санч Г.Оюунбилэгийн "Номын санчийн мэргэжлийн ур чадвар үр нөлөө" илтгэл тус тус шалгарлаа.

Амралтын өдөр Нийтийн номын санд ХХҮГ- ын хамт олон "Хамтдаа уншъя" гэр бүлийн уншлагад хамрагдлаа.

Уншигч хүүхдүүд номын санч нартайгаа хамтран өвөө, аав, ах, дүүдээ өөрийн гараар сарнай хийж, Нийтийн номын сангаас хүргэж буй талархалын үгтэй мэндчилгээ илгээлээ.

Урилгат уншлага

Жаргалант сумын ЕБС-ын бага дунд ахлах ангийн сурагчдыг Америкийн төвдөө урьж урилгын уншлага зохион байгуулж америкийн төвийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, бага ангийн сурагчдад англи дуу хөдөлгөөнт дасгал зааж сургаж байна.

Амралтын өдөр Нийтийн номын санд ХХҮГ- ын хамт олон "Хамтдаа уншъя" гэр бүлийн уншлагад хамрагдлаа. Хүүхдүүд уншсан номынхоо тухай аав, ээжтэйгээ ярилцаж, мөн тоглоом тоглох, оёдлын сургалтад хамрагдах, өөрийн сонголтоор манай үйлчилгээний танхимуудаар үйлчлүүлэх зэрэг чөлөөт цагаа зугаатай хөгжилтэй сайхан өнгөрүүллээ.

Монгол цэргийн баярыг угтаж уншигч хүүхдүүд номын санч нартайгаа хамтран өвөө, аав, ах, дүүдээ өөрийн гараар сарнай хийж, Нийтийн номын сангаас хүргэж буй талархалын үгтэй мэндчилгээний хамт бэлэглэхээр авч явлаа.

Монгол хэл бичиг" дэд хөтөлбөрийг үндэслэн ТӨРИЙН АЛБАНЫ МОНГОЛ БИЧГИЙН СУРГАЛТЫГ ажилтан албан хаагчдад олгох зорилгоор ахнан, дунд шатны Монгол бичгийн хичээлийг ЦАЦ сургуулийн МХУЗ-ын багш М.Бадамцэцэг багшаар заалгаллаа.

Уншлагын их танхимаас 12 жилийн 6-р сургуулийн Б.Баярмаа багштай 8а анги, Д.Баасанжав багштай 8в ангийн хамт олонд урилгын уншлага хийж, сурагчдын дунд "Хэн хамгийн олон ном нэрлэх вэ?" тэмцээнийг явуулж аваргаа шалгаруулллаа.

"НЭГ ХҮҮХЭД НЭГ ЗОХИОЛ"

"Нэг хүүхэд Нэг зохиол" уриан дор "Уншихуйн гайхамшиг" сэдэвтэй илтгэл 9-р ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулагдлаа. Сурагчид үе тэнгийн найз нөхдөдөө ном уншихын ач холбогдол, номтой нөхөрлөснөөр бидний амьдралд ямар ямар өөрчлөлт гарч болох талаар уран яруу илтгэсэн нь бахархууштай байлаа. 9в ангийн сурагч Нарангэрэл 1-р байр, 9г ангийн сурагч Энхтуяа 2-р байр, Ану 3-р байр, 9б ангийн сурагч Янжинлхам тусгай байрыг эзэллээ.

Сумдын соёлын төвийн болон ЕБС-ийн, Нийтийн номын сангийн номын санчдын дунд туршлага солилцох тайлант илтгэлийг зохион байгуулж, шинэ санаа, онцлог ажлыг санаачлан хэрэгжүүлж байгаа номын санчдыг шагнаж урамшуулав.

Ажилтан албан хаагчид харилцан биендээ хүндэтгэл үзүүлэх, аз жаргалтай ажиллах орчинг бүрдүүлэх, амьдралдаа хэрэгжүүлэх, бусдад эерэг хандлага түгээх зорилготойгоор “Эерэг орчин бүрдүүлцгээе” аяныг жилийн турш хэрэгжүүлэхээр байгууллагынхаа уриа болгон ажиллаж байна. Аяны хүрээнд тусгай удирдамж гарган хөтөлбөрийн дагуу “Талархлын захидал” байгууллагын албан хаагчид бие биендээ захидал бичиж өгөх, “Аз жаргалын мод” бүтээж нэгнийхээ сайн чанаруудыг бичиж байрлуулах, “Эерэг хандлага” өглөөний мэдээлэл хийж харилцан ярилцах, өглөө 7 цагт хөгжимт дасгал хийж ажиллах эрч хүчээ сэлбэх зэрэг олон ажлуудыг хийснээр ажлын бүтээмж сайжирсан үр дүн гарлаа.

Ховд аймгийн соёл,урлагийн салбарын удирдах ажилтан, номын санчдын сургалт зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулагдлаа.

Уншлагын их танхимаас 12 жилийн 6-р сургуулийн Б.Баярмаа багштай 8а анги, Д.Баасанжав багштай 8в ангийн хамт олонд урилгын уншлага хийж, сурагчдын дунд "Хэн хамгийн олон ном нэрлэх вэ?" тэмцээнийг явуулж аваргаа шалгарууллаа.

“Хамтдаа уншья” гэр бүлийн уншлагад 7б ангийн сурагчид маань эцэг эхтэйгээ ном унших, номын ертөнцөөр аялан, уншсан номныхоо тухай ярилцан, зуны амралтаар уншсан номныхоо тайлант уншлагыг амжилттай зохион байгууллаа.

Зуны турш үр хүүдүүддээ үлгэрлэн гэр бүлээрээ уншлага хийж идэвхи санаачлагатай оролцсон багш Х.Уранцэцэг мөн Батгэрэл, Батхүү, Тавьтай, нарын гэр бүлийг шагнаж урамшууллаа. Ховд телевизэд тайлант уншлагынхаа талаар мэдээлэл өгч ажиллаа.

Уншсан номын талаараа сурагчид болон эцэг эхчүүд хоорондоо ярилцаж санал бодолоо солилцож, мөн уншсан номын тэмдэглэл хөтлөж үр дүнтэй уншихаар санал гаргалаа.

“АХА” тэмцээн:

Мөн энэ үеэр зохиогдсон танин мэдэхүйн **“АХА”** тэмцээнд сурагч Б.Маргад анги хамт олноо манлайлан тэргүүллээ.

Нийтийн номын сангийн Монголын уран зохиолын фонд, Гадаадын уран зохиолын фондоор эцэг, эхчүүд, хүүхэд багачууд маань танилцаж талархсан сэтгэгдэлээ илэрхийллээ.

Баяр хөөртэй хүүхэд нас өртөөчилсөн аян ЕБС-ийн 7 сургуулийн ахлах ангийн сурагчид идэвхтэй сайн оролцлоо энэ үйл ажиллагааны хүрээнд сурагчидад тасаг танхимын танилцуулга болон багийн тоглоом болох хэлхээ, хулганы дэгээ тоглоом тоглууллаа.

МОНГОЛ БАХАРХАЛ –МОНГОЛ НААДГАЙ

Их мэдэх танхимаас "Монгол бахархлын өдөр"-ийг угтаж Монгол бахархал-Монгол наадгай сэдэвт шагайн наадмыг ЕБ-ын 6-р сургуулийн Нүрзэд багштай 5В ангийн сурагчдын дунд зохион явууллаа.

Уг арга хэмжээнд шагай няслах, морь уралдуулах, алаг мэлхий өрөх, шагай шүүрэх тоглоомыг таниулж мөн монголын хөлөгт тоглоомоор үзэсгэлэн гаргаж хүүхэд багачуудад сурталчлав. Монгол ёс уламжлалаа хойч үедээ таниулах түгээн дэлгэрүүллээ.

Үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон анги хамт олонд дурсгалын зүйл ном иштэй чихэр гардууллаа.

Ерөнхий боловсролын 2-р сургуулийн Ариунтунгалаг багштай 5б ангийн хамт олонд чанга уншлага зохион байгуулж явууллаа.

Чимээгүй уншлагыг Цаст Алтай цогцолбор сургуулийн 7б анги болон 6-р сургуулийн 5в ангийнхан зохион байгуулж явууллаа.

2022 оны Уншлагын их танхимын аварга номууд

1. Л.Түдэвийн Оройгүй сүм 268 удаа уншигдсан
2. Ш.Сарангэрэл Математик тест 154 уншигдсан
3. Д.Буян Нийгмийн тухай мэдлэг 208 удаа уншигдсан

УНШЛАГЫН ИХ ТАНХИМЫН 2022 ОНЫ ШИЛДЭГ УНШИГЧ, АНГИ ХАМТ ОЛОН

ШИЛДЭГ УНШИГЧ :

1. Прогресс сургуулийн 12б ангийн Б.Минжбадгар /99438796/

2. 1 дүгээр сургуулийн 10 ангийн сурагч Цагаанхүү

3. 7 дугаар сургуулийн 8а ангийн сурагч Б.Болорчимэг / 86051242 /

4. ЦАЦ сургуулийн 9 а ангийн сурагч Ж.Амина / **80015627**/

ШИЛДЭГ АНГИ ХАМТ ОЛОН:

1. О.Баасанжав багштай Прогресс сургуулийн 12б ангийн хамт олон / 99438796 /

2. Д. Алтангүль багштай 6 дугаар сургаалийн 9б анги хамт олон /99436892 /

3. П.Сарантунгалаг багштай ЦАЦ сургуулийн 8г ангийн хамт олон / 88024299/

4. Б.Гэгээнжаргал багштай ЦАЦ сургуулийн 10а ангийн хамт олон /**80015627/**

ШИЛДЭГ НОМЫН САН: ЦАЦ сургуулийн номын санч Б.Батзаяа /**80015627**/

ШИЛДЭГ БАГШ: 1 дүгээр сургууль н.Цэндаюуш / 99518615/

Ховд аймгийн Нийтийн номын сангийн Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхимаас шилдэг номоор Р.Киуозаки зохиол “Баян аав ядуу аав” зохиол шалгарлаа.

Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхимаас Математик-мэдээлэл зүйн 2-р курсийн оюутан А.Назым тэргүүний уншигчаар шалгарлаа.

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ИХ МЭДЭХ 2022 ОНЫ ТЭРГҮҮНИЙ ШИЛДЭГҮҮД

ТЭРГҮҮНИЙ ШИЛДЭГ УНШИГЧ АНГИ ХАМТ ОЛОН:

1. 6-р сургуулийн Нүрзэд багштай 5в ангийн хамт олон
2. 6-р сургуулийн Цэрэндулам багштай 6а ангийн хамт олон
3. Цаст алтай сургуулийн Цэцэгмаа багштай 7б ангийн хамт олон
4. 6-р сургуулийн Анхбаяр багштай 7а ангийн хамт олон

ТЭРГҮҮНИЙ ШИЛДЭГ УНШИГЧ :

1. 6-р сургуулийн 5В анги А.Аньс
2. 6-р сургуулийн 6б анги Г.Жавхлан
3. 6-р сургуулийн 7а анги Б.Өнөржаргал

АВАРГА НОМ:

Монголын хүүхдийн богино өгүүллэгийн дээжис 210 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

“Үл мэдэх” танхим 2022 оны шилдэг уншигч анги хамт олон, шилдэг уншигч

Оны шилдэг тэргүүний багш

3-р сургуулийн багш Б.Батсүх багш

Оны шилдэг уншигч анги хамт олон

3-р сургуулийн Б.Батсүх багштай 4б ангийн хамт олон

ЦАЦ сургуулийн Б.Цоггэрэл багштай 4в ангийн хамт олон

2-р сургуулийн Г. Рэгзэдмаа багштай 4б ангийн хамт олон

2-р сургуулийн М.Мөнгөнтуяа багштай 3г ангийн хамт олон

Оны шилдэг тэргүүний уншигч сурагч

ЦАЦ сургуулийн Э.Эрдэнэ-Оюун багш багштай 3в ангийн сурагч Л.Нандин-Эрдэнэ

3-р сургуулийн Б.Батсүх багштай 4б ангийн сурагч Б.Билгүүн

2-р сургуулийн Г. Рэгзэдмаа багштай 4б ангийн сурагч М.Янжинлхам

Аварга номоор- Динза цуврал жилийн турш 256 удаа уншлагд гарчээ.

АСМТ-ийн шилдэгүүд:

Аварга анги Прогресс 9 а, Цаст алтай 12б ангийн сурагчи Бандихүү Төгөлдөр

Тулгар төрийн 2230, 2231, Их монгол улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100,101 жилийн ой, Үндэсний их баяр наадмаар Нийтийн номын сангаас зохион байгуулж явуулсан ажлууд:

Ховор шинэ номын үзэсгэлэн:

Ховор болон шинэ номын үзэсгэлэнг наадмын талбай дээр гаргаж, сурталчилж, иргэдэд үйлчилж ажилласан. Нийт 4 тасгийн 168 номоор үзэсгэлэн гаргав.

Шүлгийн нээлттэй микрофон ажиллуулав.

Сээр цохих тэмцээнд:

Сээр цохих тэмцээнд нийт 25 хүн бүртгүүлж оролцсон байна.

“ЦАЙНЫ ЗАМ” ӨВ СОЁЛЫН НААДАМ-III наадамд ОУ-ын үзэсгэлэн хариуцаж ажиллав.

2022 оны 11 дүгээр сарын 26-30 хооронд Д.Нацандоржийн Нэрэмжит Улаанбаатахотын төв номын санд Ном каталогжуулах анхан шатны сургалт, Соёлын дархлаа сэдэвт лекц семниарт хамрагдлаа.

Д.Нацагдоржийн нэрэмжит Хотын төв номын сан, Үндэсний номын сан, Монгол Улсын Их Сургуулийн номын сангуудтай харилцан туршлага солилцож, арга зүйн зөвлөгөө авч номыг халдваргүйжүүлэх арга зүй, сонин сэтгүүл архивлах, Хараагүй хүмүүсийн

мэдээлэл харилцааны технологийн талаарх мэдээлэл мөн коха праграммд хэрхэн шилжиж байгаа ажлын явцаас ,фондын стандарт мөрдлөг болгох арга зүй анхаарах зүйлсүүд, зөвлөмжүүд, нас насанд үйлчилгээ үзүүлж байгаа тасаг танхимын номын санч нартай туршлага солилцож, олон олон мэдээ мэдээлэл цаашид яаж ажиллах талаарх зөвлөмж авлаа.

Дуут сумын соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж, соёлын төвийн номын сан болон сургуулийн номын сангийн номын санч нарт зөвлөн туслах ажлыг хамт олны хамт хийлээ.

“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Аймгийн соёлын газраас “Хөөмийн урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх сар болгон зарласны дагуу Нийтийн номын сангийн фондонд байгаа хөөмийн урлагийн тухай номуудыг цуварлаар хүргэж байна. Мөн хөөмий урлаг үүссэн домог, Алдарч хөөмийч МУГЖ Н.Сэнгэдорж, хөөмийч Цэрэндаваа гуайн намтар, уран бүтээлийг цахимаар тавьж сурталчиллаа.

Х.Алтангүль захиралтай Баян-Өлгий аймгийн номын сангийн хамт олон Ховд аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлан ажиллаа Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан урианхай, тува түмний баярт номын үзэсгэлэн гаргаж оролцсон ба Аймгийн Номын сангаар орж туршлага судаллаа.

Хувь хүний хөгжлийн талаарх лекц

Философич Молор-Эрдэнэ Ховд аймгийн иргэдэд өөрийн гаргасан номынхоо талаар мэдээлэл өгч, хувь хүний хөгжлийн талаар, хэл сурах арга зарим аргачлалын талаар сонирхолтой лекц яриа хийж оролцогчдын асуултад хариуллаа. Нийтдээ 86 хүн оролцов.

Аз жаргалтай ажиллахын нууц онлайн лекц

Батсүх Төгөлдөр энэ сэдвээр номын сангийн ажилчдад төлбөртэй лекцийг онлайнаар аажилттай зохион байгууллаа.

Эх дэлхийгээ авран хайрлая сэдэвт сургалт, мэдээлэл

4 дүгээр сарын 22 нд буюу “Эх дэлхийгээ авран хамгаалъя” Сэдэвт мэдээлэл хийж, байгальд ээлтэй хог хаягдалгүй орчинг бий болгох үүднээс номын санчид өөрсдөө хуучин зай хадгалах сав хийж тасагуудад байршуулав. МҮОНРТ-ээс санаачлан өрнүүлж буй “ҮНДЭСНИЙ_БИЧИГТЭН_МОНГОЛЧУУД” үндэсний хэл бичгээ сурталчлах аянд Олон угсаатны өлгий нутаг- Ховд аймгийн Нийтийн номын сангийн хамт олон нэгдлээ.

Хамтран ажиллаж буй албан газрууд, баруун бүсийн төв захын бизнес эрхлэгчид болон сумдын номын санч нарт зөөврийн номын сан үйлчилгээг хүргэж байна.

СУГ-аас зохион байгуулсан “Харилцан хүндэтгэе” аяныг байгууллагын албан хаагчдын дунд амжилттай зохион байгуулснаар маш их эерэг дүн гарч улмаар үйлчлүүлэгчдийн хүрээнд өргөжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Бүтээлч орон зайн төв /Redesign хуучин хувцсаа сэргээн засварлах хөтөлбөр/

Бүтээлч орон зайн төв нээгдсэнээр хувь хүний хөгжлийг дэмжих, бүтээлчээр хандах сэтгэлгээг бий болгож байгальд ээлтэй хөтөлбөрийг тогтмолжуулах зорилгоор хичээллэж байна. Мөн хөдөлмөр халамжийн газрын ажилчдад Улаанбаатар хотын Бүтээлч орон зайн төвөөс оёдлын сургалтыг шууд дамжуулж амжилттай зохион байгуулсан.

Кино үдэш

Долоо хоног бүрийн Баасан гаригийн 15.00 цагаас олон нийтэд зориулсан кино үдэш зохион байгуулж сурагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүллээ

Бага ангийн сурагчдын дунд бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх тоглоом тоглуулах өөрсдийн гараар бүтээл хийлгэх, угсруулах, багаар ажиллах чадварт сургах, тоглоомын аргаар англи хэл сурахад нь дэмжлэг үзүүлж байна.

Технологийн шинэчлэл ба өндөр хурдны интернеттэй болж бүрэн камерийн систем суурилууллаа.

Мод тарих аянд:

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан Нийтийн номын сангийн хамт олон , Залуус хорооллын зам дагуу мод тарилаа.

Энэ улиралд иргэдийн дунд 65 төрлөөр зохион байгуулсан соёл олон нийтийн ажилд нийт 15191 үйлчлүүлэгчид хамрагдлаа. Мөн аймаг орон нутгаас зохион байгуулсан олон нийтийн ажилд байгууллагын албан хаагчид идэвхтэй оролцож ажиллаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН Д.СҮРЭНЖАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ТАЙЛАН

2022-12-24

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ, үнэлгээний нийтлэг журам болон Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Аргачлал шинэчлэн батлах тухай” А/515 дугаар захирамжаар батлагдсан аргачлалын дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал гэсэн үндсэн зорилтын хүрээнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын ажил хэрэгч шийдвэр (Захирамж, албан даалгавар, хуралдааны тэмдэглэл)
- Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт
- Аймгийн Засаг даргаас агентлаг байгууллагын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний үүргийн биелэлт
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- “Нэрлэсэн жил”-ийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Байгууллагын ил тод байдал
- Авилгын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний үр дүнд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 6.2, 6.3-т заасан арга зүйгээр дээрх 3 зорилтын 10 үзүүлэлтийн үйл ажиллагааны үнэлгээний тайланг гаргалаа.

Аргачлалын 9 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Нэг. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100	0.6	
	2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.6		
	3. Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний биелэлт	-		
	4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт (Аймгийн Засаг даргын ажил хэрэгч шийдвэр)	100		
Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	92.5	0.2	
	2. Аймгийн Засаг даргаас агентлаг, байгууллагын даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	95.8		
	3. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	85.4		
	4. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100		
	5. Өмнөх оны дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ	-		
	6. “Нэрлэсэн жил”-ийн төлөвлөгөөний хэрэгжилт	90		
Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	-		
	3. Авилгын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ	100		
Ерөнхий үнэлгээ:		**95.5**	1.0	

1. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

1.6.2.1 "Цахим соёл"
1.6.2.2 "Бүх нийтийн соёлын боловсрол"
1.6.2.4 "Соёлын бүтээлч үйлдвэрлэл –II" арга хэмжээнүүдийг хяналтанд авч ажилласан. Хэрэгжилт 100%

Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II арга хэмжээний хүрээнд хүүхэд залуучуудыг ном уншихад уриалах, үлгэр дууриал болгох, алдаршуулах зорилгоор он оны Шилдэг уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэнүүдээр 2023 оны ширээний хуанли 15 ширхэг, номын сангийн логотой хэтэвчний хуанли 150 ширхэг, эко даавуун тор 50 ширхэг нийт 3 төрлийн бүтээгдхүүнийг өөрсдийн нөөц бололцоогоор гаргаж, үзэсгэлэн худалдаанд тавьж олны хүртээл болгосон.

2. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны "Соёл-Олон ястны өв" үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймгийн Нийтийн номын санд хэрэгжүүлэхээр тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6 арга хэмжээ тусгагдсан.

Хэрэгжилт -91.6%

Үүнд: 100% буюу үр дүнтэй,бүрэн хэрэгжсэн-5, 50% буюу шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй эрчимжүүлэх шаардлагатай-1 арга хэмжээ байна.

"Сумдын номын сангуудыг үүлэн технологид суурилсан Lib4u номын сангийн цогц программд үе шаттайгаар шилжүүлнэ" зорилт арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөгжлийн сангаас 10.0 сая төгрөгийн төсөв батлуулсан. 2021-2022 онд аймгийнхаа 23 сумын нийтийн номын санд Lib4U программыг бүрэн нэвтрүүлж дууссан. Аймгийн нийтийн номын сан болон сумдын нийтийн номын сангууд нэгдсэн цахим каталогитой болсоноор үйлчилгээний статистик мэдээ мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь өгөх, ном зүйн мэдээллийг орон зай, цаг хугацаа харгалзахгүй интернэттэй орчинд гар утас, компьютер болон дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглан авах боломж бүрдэж байгаагаас гадна номын сангийн үйл ажиллагааг автоматжуулах зорилтыг хангахад ач холбогдолтой ажил болсон.

Мөн сумдын нийтийн номын санд Lib4U программыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Волвес ХХК-ын программын мэргэжилтэн анхан шатны мэргэжил арга зүйн

сургалт зөвлөгөөг цахимаар болон биечлэн ирж өгсөн бөгөөд 6 удаагийн цахим сургалтанд давхардсан тоогоор 51 номын санч хамрагдсан.

“Нийтийн номын сангийн сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх” арга хэмжээний хүрээнд Засаг данснаас 3.0 сая төгрөгийн нэмэлт эх үүсвэрийг батлуулж, 97 төрлийн 128 ширхэг ном, хэвлэлийн бүтээгдхүүний баяжилт хийгдсэн.Үүнээс гадна төсвөөр 7,978,000 төгрөгийн 432 ширхэг, хандиваар 2,346,800 төгрөгийн 260 ширхэг , нийт 13,324,800 төгрөгийн 820 ширхэг ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр сан хөмрөгийн баяжилт хийгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлт юм.

Соён гэгээрүүлэх “Соёлын цаг” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээний хүрээнд “Дэлхийн номын өдөр”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээ, “Соёлын орон зай”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” намрын арга хэмжээ, “Соёлын бүтээлч сар” зэрэг соён гэгээрүүлэх 6 чиглэлийн хүрээнд хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан 52 арга хэмжээг аймгийн Төрийн болон Төрийн бус байгууллага, ЕБС, СӨБ, иргэд уншигчдын дунд амжилттай зохион байгууллаа.

Уг арга хэмжээг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 48900 уншигч иргэсдийг хамруулсан.

Тухайлбал:

- “Гэгээн цаг” уншигч зохиолчдын уулзалт
- “Оюунтүлхүүр сургаал”-ийг сурталчлах аян
- Соёлын өртөөчилсөн” аялал
- Номын клуб ном сонирхогчдын уулзалт (Номыг хэрхэн үр дүнтэй унших вэ?) Номын тухай подкаст
- Тэгш ойн нь тохиож буй зохиолчдын намтар уран бүтээлийн үзэсгэлэн
- Номын флашмоб (Номтой бүжиг)
- Урлагийн тоглолт /номын санч нар/
- Номын санд хандив өргөсөн алдартнуудыг алдаршуулах
- Номын өргөөний ид шид танилцуулга
- Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага
- “Хөвсгөлийн ган үсэгтнүүд” номын үзэсгэлэн
- Ховор хуучин номын үзэсгэлэн
- Шинэ номын үзэсгэлэн
- Тэргүүний уншигчдын бүтээлийн үзэсгэлэн

- Шинэ хуучин номын худалдаа
- Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа
- “Уншсанаа хуваалцъя” үлгэр уншсан 30 уншигчийг урамшуулах
- “Номын нөхөр-Шилдэг анги” уралдааны шагналыг гардуулах
- “Урнаар өгүүлэхүй” богино өгүүллэгийн уралдаан
- Үндэсний бичгээр номын хавчуурга хийж уншигчдад бэлэглэх
- Соёлын төвийн Нийтийн номын сангийн номын санчдын дунд “Бийрэн бичиг” уралдааны бүтээлийг шалгаруулж, үзэсгэлэн гарган, шагнал гардуулах
- “Ургаа судалъя, удмаа мэдье” ургийн бичгийн сургалт
- Номын санчдын сургалт МҮНС-аас сургалт
- МУСГЗ Д.Сүрэнжавын нэрэмжит “Шилдэг номын санч” шагнал гардуулах
- Тэгш ой тохиож буй зохиолчдын намтар, уран бүтээлийн үзэсгэлэн
- “Монголын сайхан бичигтэн” улсын уралдааны хамгийн залуу оролцогчийн уран бүтээлийн үзэсгэлэн
- “Босоо бичгээ дээдэлье” уриан дор танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээн
- “Хүүхдийн номын өргөө” номын дэлгүүрээс номын үзэсгэлэн- худалдаа
- “Хаан бичиг” номын төвийн үзэсгэлэн худалдаа
- Мөрөн сумын ЕБС-иудын дунд “ХҮМҮҮН БИЧИГ” монгол бичгийн уралдааныг дүгнэх зэрэг соёл олон нийтийн ажлыг зохион байгууллаа.

ЧАНГА УНШЛАГА

Хөвсгөл аймгийн Ахмад Настны Асрамж Үйлчилгээний Төв
2022 оны 'Шилдэг Номын Нөхөр ' байгууллага
Тэргүүн байр

Хөвсгөл аймгийн Онцгой байдлын алба
2022 оны 'Шилдэг Номын Нөхөр ' байгууллага
Дэд байр

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
2022 оны 'Шилдэг Номын Нөхөр ' байгуулга
Гутгаар байр

3. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ (Аймгийн Засаг даргын ажил хэрэгч шийдвэр)

Энэ онд гарсан аймгийн засаг даргын 5 ажил хэрэгч шийдвэр, албан даалгаврыг хяналтанд авч, 14 төрлийн төрлийн ажил төлөвлөн ажилласнаас 100%-тай буюу бүрэн хэрэгжсэн -14

Хэрэгжилт – 100%

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, мод тарьж ”Ногоон суварга босгоё” аяны ажлыг эрчимжүүлэх тухай. 03 тоот захирамжийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон суварга босгоё” аяны хавар, намар бүх нийтээр мод тарих аянд нэгдэж нээлтийн үйл ажиллагаанд байгууллагаараа оролцсон. Хувиарлагдсан төв зам дагуу 36,34 дугаар хайсанд болон байгууллагын хашаанд 40 ширхэг модыг суулгаж, өдөр бүр усалж арчилж байна.

Номын баярын өдөрт зориулж Шилдэг анги хамт олноор 70 ширхэг модыг 9-р багт тарьсан.

Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай 05 дугаар захирамжийн хүрээнд:

Нийтийн номын сангаас нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэхэд хувиарлагдсан Мөрөн сумын 4 дүгээр хорооны ар талаас уулын жалга хүртэл хогыг түүж шуудайлан бөөгнүүлж ажиллаа.

Байгууллагын орчны цэвэрлэгээг арын хашааны хатаж гандсан зэрлэг, хогыг түүж хадуулан ачуулсан. урд талын талбайн хайсны хог хаягдлыг авч, бут сөөгийг усалж бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцлоо.

4. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

8 үндсэн чиглэлийн хүрээнд 8 арга хэмжээ төлөвлөн ажилласан.

Хэрэгжилт – 92.5%

100% буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн -6

70% буюу тодорхой үр дүнд хүрсэн-2

Соёлын тухай хуулийн 24.1.2

Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх талаар холбогдох сургалтыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэн тогтвортой ажиллуулах энэ заалтын хүрээнд ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хувь хүний хөгжил, эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөн, хүний нөөцийн чиглэлээр 14 төрлийн тус бүр 4 цагаас дээш сургалтад хамрагдсан. Үүнд:

- “Хашаандаа сайхан амьдрая” 7 цаг
- “Үр дүнтэй удирдах нь” 6цаг
- “Төрийн сангийн цахим шилжилтийг нэвтэрүүлэх” 16 цаг
- “Үндэсний бичгийн цахим бичвэр” 10 цаг
- “Гэр бүлийн боловсрол” 8 цаг
- “Цахим сан хөмрөгийн зохион багуулалт” 8 цаг
- “Төсөл бичих арга зүй” (СУИС-иас 5 цаг цахимаар)
- “Ургаа судалъя-Удмаа мэдье” (угийн бичиг хөтлөх сургалт 4 цаг) ХАБЭА-ны сургалт 7 цаг

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1

Төрийн байгууллагуудын удирдлагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем erp.e Mongolia системд бүх албан хаагчдыг бүртгэлжүүлэн хамруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Ингэснээр үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн урсгалын зохион байгуулалтыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурай, ил тод хүргэхэд ач холбогдолтой байна.

ERP системийн ашиглалтыг сайжруулах зорилгоор гарын авлага бэлтгэн тарааж, холбогдох сургалтуудад хамрагдсан. Үүнд:

- ЗДТГ-аас зохион байгуулсан ERP системийг ашиглах сургалтад 2021 онд архив, бичиг хэргийн ажилтан Н.Цацрал хамрагдсан.

- 2022 онд Хууль зүйн хэлтэс, архивын тасгаас зохион байгуулсан сургалтад ERP -ын ашиглалт бүртгэлийн мэдээлэл олгох танхимын сургалтад хамрагдсан.
- Архивын ерөнхий газар, Хууль зүйн хэлтэс, архивын тасгаас зохион байгуулсан “Хууль тогтоомжийн хэрэглээ-зөрчилгүй цахим албан хэрэг хөтлөлт-архивын чанар, үйлчилгээ” сургалтад хамрагдсан.

E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд нэгдэж, ажилтан албан хаагчид гар утсандаа апп суулгаж, өөрт шаардлагатай үйлчилгээг цаг алдалгүй шуурхай, нэг дороос авч сурсан.

5. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Зургаан ястын соёл, зан заншил, эх хэл, өв уламжлалыг сурталчлах” ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын өгсөн үүргийн дагуу 45 ажил төлөвлөн ажилласан. Хэрэгжилт 95.8%

Үүнээс 100% тай буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн -39, 70%-тай буюу тодорхой үр дүнд хүрсэн-2, 40%-тай буюу эрчимжүүлэх шаардлагатай -2 арга хэмжээ байна. **Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах** ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон байгууллагын үйл ажиллагааг Хөвсгөл Нийтийн номын сан цахим хаягаар цаг тухай бүрд нь мэдээ мэдээлэл, зохион байгуулагдах гэж буй ажлуудыг контент, live, бичлэг хэлбэрээр сурталчилж бусад группт шейр хийж түгээдэг. Мөн Соёл, урлагийн газраас Хөвсгөлийн өнгө, Түмний телевизүүдтэй хамтран ажиллах гэрээ хийгдсэний дагуу зохион байгуулагдаж буй ойн баяр, тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээний бичлэгийг live, болон бичлэгээр хүргэж ажилладаг.

Тухайлбал МҮОНТелевизээр ном хандивлагчийг алдаршуулах арга хэмжээ, “Бичиг соёл номын өдрүүд-2022” хаврын үйл ажиллагаа, “Гэгээн цаг” уншигч зохиолчдын уулзалтын талаар мэдээ мэдээлэл нийт 3 удаа, аймгийн “Эрх чөлөө” сониноор “Бичиг соёл номын өдрүүд-2022” намрын арга хэмжээний талаар, “Хөвсгөлийн өнгө” сайт болон байгууллагын цахим хуудсаар видео бичлэг 92, зурган мэдээлэл, постер 74 ширхэг бэлтгэн байршуулсан нь 31933 уншигдад хүрсэн байна.

Цахим орчны ашиглалт:

- Facebook-ийн найзууд -5000
- Пейж хуудасны дагагч- 4269
- Нийтлэлтэй харьцаж буй хүний тоо- 31933

Мэдээллийн ил тод байдлыг хانган ажиллах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүд болох

- Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал
- Хүний нөөцийн бодлогын ил тод байдал
- Төсөв санхүүгийн ил тод байдал
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагаа
- Дотоод хяналт гэсэн чиглэлээр мэдээ мэдээллийг ил тод байлгах зорилгоор “Иргэн танд тусалъя” самбарыг гаргаж, мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь тогтмол шинэчлэн уншигч, үйлчлүүлэгчдэдээ сурталчлан ажиллаж байна.

Мөн Хөвсгөл Төв Номын сан пейж хуудсаар болон шилэн дансанд тухай бүрд байршуулдаг.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хانган ажиллахад байнгын хяналт тавьж, албан тушаалтнуудын ажил үүргийн хуваарьт тусган, хяналт тавин ажиллаж байна.

Хог хаягдлын менежментийн сайжруулах чиглэлээр байгууллага дээрээ ажил зохион байгуулах ажлын хүрээнд

- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэхэд Мөрөн сумын 4 дүгээр хорооны ар талаас уулын жалга хүртэл цэвэрлэгээг оролцсон.
- Байгууллагын орчны цэвэрлэгээг арын хашаан, урд талын талбайн хайсны хог хаягдлыг авч, бут сөөгийг усалж бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцсон.
- Хог хаягдлыг ангилах хогийн сав хийж байгууллагын үүдэнд байршуулсан.
- Байгууллага дээрээ дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялгаж ангилсан.
- Актлагдсан хэт хуучин болон, агуулга хуучирсан сэлбэн засах боломжгүй болсон номуудыг ангилж ялгаж дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэхээр бэлтгэл хангагдсан.
- Өрхийн амьжиргааг дээшлүүлэх, гялгар уутны хэрэглээг багасгах зорилгоор байгууллагын албан хаагчдадаа даавуун тор хийж тараан, хэрэглэж хэвшсэн.
- Хог хаягдлын тухай хууль, 10 дугаар зүйлийн 10.1 10.2 10.3 дугаар заалтууд, “Хог хаягдлын менежмент”, “Хог хаягдал гэж юу вэ”, “Аюултай хог хаягдал гэж юу вэ”, “Хог хаягдлын хэрхэн ангилан ялгах вэ” гэсэн сэвдүүдээр ажилтан албан хаагчиддаа мэдээлэл сургалт хийсэн. “Хог хаягдал ба миний амьдрах орчин сургалтанд” Жижүүр Эрдэнэмөнх, үйлчлэгч Ундармаа, Эрдэнэжаргал нар хамрагдлаа.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд:

- Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн захирлын А/11 дугаар тушаалаар 2022 оны 02 сарын 18 өдөр “Жендэрийн хороо”-г 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 2017 оны 129 тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” аймгийн ИТ-ын 37-р тогтоолоор батлагдсан Жендэрийн эрх тэгш

байдлыг хангах дэд хөтөлбөрийн холбогдох заалтыг хөдөлмөрийн дотоод журмандаа тусган хэрэгжүүлэн ажиллаж байна

- Монгол улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Харилцан хүндэтгэе” сарын аянд Хөвсгөл аймгийн нийтийн номын сан нэгдэж ажиллаа. Жендэр, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх, эрэгтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй жендэрийн асуудлын талаар мэдээлэх, холбогдох төрийн байгууллагуудад хүргэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” уриан доор үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй энэхүү аянд манай байгууллага нэгдсэн.

- Байгууллагын нийт ажилчид, албан хаагчдаас жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, тэдэнд тулгарч буй жендэрийн асуудлын талаарх 9 асуумж бүхий судалгаа авлаа. Судалаанд нийт 12 албан хаагч хамрагдсан нь нийт албан хаагчдын 85% эзэлж байна. Судалгааны үр дүнг харахад манай байгууллага жендэрийн сайн мэдрэмжтэй, ажлын байранд бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалт, жендэрийн тэгш бус байдал байхгүй, цалин урамшуулалд хүйсийн байдал нөлөөлж байгаагүй гэж гарсан байна. Мөн ажилчид, албан хаагчдад жендэрийн талаарх ойлголтыг зөв болгох, мэдлэг мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах талаар санал их ирсэн байна. ГБХЗХГ-аас “Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн асуудал” Ажлын байран дахь стресс” сэдвүүдээр сургалт мэдээлэл авсан

- Гэрээр ном олгох танхимд “Жендэрийн булан” байгуулж, жендэрийн тухай хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого чиглэл, гарын авлага үзүүлэн таниулах материал, постероор уншигчдад үйлчиллээ.

- Соёлын салбар дахь жендэрийн асуудал илтгэлийн уралдаанд оролцлоо.
- “Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө гэр бүлээ, орчин тойрноо” уриа постерийг байгууллагын фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан сурталчлан ажиллалаа.

- Аяны хүрээнд: Гэрээр ном олгох танхимд “Жендэрийн тухай А-Я" үзэсгэлэн гаргаж, тойм яриа, мэдээлэл хүргэлээ. Энэ үзэсгэлэнд жендэртэй холбоотой ерөнхий мэдээллүүд багтсан ба уг үзэсгэлэнг 262 уншигч ирэгсэд үзэж танилцлаа.

- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд Соёл Урлагийн газраас зохион байгуулсан “Жендэр ба хүний эрх, "Стрессгүй ажлын байр " сэдвүүдээр хийгдсэн сургалтанд Нийтийн номын сангийн хамт олон хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд:

Спорт-Эрүүл мэнд: Бид бүгд тогтмол суугаа ажил хийдэг учраас дасгал хөдөлгөөн зайлшгүй шаардалгатай байдаг. Тиймээс байгууллагын албан хаагчид хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор сагсан бөмбөг болон гар бөмбөг тоглож, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж, эрүүл мэнддээ анхаарч байна.

Бужгийн спортоор хичээллэх: Бужгийн 5 төрлийг сонгон авч заалгаж байна. Бужгийн сургалтад тогтмол явсанаар хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, гоо зүйн мэдрэмжтэй болох зэрэг олон ач холбогдолтой. Олон нийтийг хамарсан эдгээр ажлуудад байгууллагын албан хаагчдын 80-90 хувь нь тогтмол хамрагдаж байна.

Залуучуудад зориусан цахим контент:

Уран зохиолоор сурган хүмүүжүүлэх нь бидний зорилго юм. Тийм учраас бид бүхэн цахим орчинд эерэг хандлага түгээх залуусын эерэг хандлагатай болгох зорилгоор сургамж болох өгүүллэг, цэцэг үгс зэргийг цувралаар хүргэж ажиллаж байна.

- Монгол ухаан буланд 10 дугаар
- Богино өгүүллэг 5 дугаар
- Танин мэдэхүйн мэдээлэл
- Үлгэрийн баатрууд болцгооё

Үлгэрийн баатрууд болцгооё: Номын баяр-2022 арга хэмжээний хүрээнд залуучуудын зөвлөлийн гишүүд үлгэрийн баатрудын дүрд хувиран уншигчидтай хамт цагийг өнгөрүүллээ.

Уншигчдын явган аялал зохион байгуулах:

“Уншингаа алхъя-Алхангаа уншъя” явган аялалд Төрөлжсөн сургалттай Авьяас 8 дугаар сургуулийн 6в ангийн хамт олон оролцлоо. Аялал ННС, ОНСМ, 3 аваргын хөшөө, Чингүнжавын талбай, Хөвсгөл Нэг үе саад гэсэн дараалллаар зохион байгуулагдаж очсон газар бүрийнхээ талаар мэдээлэл солилцохоос гадна ном уншин тухайн номыхоо талаар ярилцах, ном уншихын ач холбогдолын талаар мэдээлэл солилцлоо.

Оюунаараа уралдах уу? Байгууллагын шатрын аварга шалгаруулах:

Байгууллагын албан хаагчид болон ахмад ажилтнуудаа хамруулан “Оюунаараа уралдах уу” байгууллагын шатрын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Энэ тэмцээнд нийт 16 хүн хамрагдаж оюунаараа уралдахаас гадна нэг өдөр байгууллага дээрээ ахмад ажилтнуудаасаа сайн туршлага судлах, санал бодлоо солилцох зэрэг хэд хэдэн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Гар урлал-Бидний бүтээл (Албан хаагчид бүтээл хийх)

Байгууллагын албан хаагчид өөрсдийн гараар дараах бүтээлүүдийг хийж олон нийтэд үйлчиллээ. Ингэхдээ байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлах зорилгоор

- Номын сангийн логотой даавуун тор
- Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэнгүүдтэй цаг тооны бичиг Түлхүүрийн оосор зэргийг хийлээ.

Манлайлагч гэр бүл шалгаруулах: Манлайлагч гэр бүлийг жилийн эцэст шалгаруулах бөгөөд залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан бүх ажилд идэвхтэй оролцсон, уралдаан тэмцээнд амжилт гаргасан гэр бүлийг шалгаруулах юм. Энэ хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.

- Танд 10 оноо байна: Байгууллагын дотоод журманд албан хаагч бүр олон нийтийг хамарсан ажилд идэвх санаачлагатай оролцоно гэж тусгаж өгсөн байдаг. Энэ журмыг дагаж мөрдүүлэх зорилгоор “Танд 10 оноо байна” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Энэ нь албан хаагчдыг тэр дундаа байгууллагын залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагатай байлгах зорилготой юм. Олон нийтийн ажилд нэг удаа оролцоогүй бол 1 оноо хасагдах байдлаар явах юм. Энэ аяныг зарласнаас хойш албан хаагчдын оролцоо нэмэгдсэн сайн үр дүн ажиглагдсан.
- Албан хаагчдын хүүхдүүдийн дунд бага, дунд, ахлах насны ангилалаар дуу бүжиг, эссэ, зохион бичлэгийн уралдаан
- Манай гэрийн номын сан
- Гэртээ болон хашаандаа хүүхдэд ээлтэй орчин байгуулах зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

EPR систем ашиглах тухай сургалт зохион байгуулах:
Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP системийг хэрхэн ашиглах тухай гарын авлага бэлтгэн ажилтан албан хаагчиддаа мэдээлэл хүргэлээ. Ирэх жил энэ чиглэлээр сургалт авахаар төлөвлөж байна.

- Байгууллагын залуу ажилтан албан хаагчдад Гэр бүл дэх жендерийн асуудал, Гэр бүл төлөвлөлт сэдвээр сургалтад хамруулсан. Энэхүү сургалтыг аймгийн ХЗГБХГазарт хүсэлт тавьсны дагуу зохион байгуулсан.
- ГБХЗХГазраас зохион байгуулсан “Сайн аав- Сайн ээж” номтой цахим сургалтанд байгууллагын 2 албан хаагчийн гэр бүл хамрагдсан.

Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтын дагуу "Ахмад настны сан" байгуулах ажлын хүрээнд:

- Аймгийн Нийтийн номын санд бүртгэлтэй, энэ байгууллагаас өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудынхаа мэдээллийн санг бүрдүүлж, байнга шинэчилж, баяжуулж байгаа. Энэ мэдээллийн санд тухайн ахмадын овог нэр, нас хүйс, ажилласан жил, ажилласан байдал, ам бүлийн тоо, гэр бүлийн байдал, өрхийн орлого, амьжиргааны түвшин, гэрийн хаяг, утасны дугаар гэх мэдээллүүдийг тусгасан байгаа.
- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтын дагуу "Ахмадын зөвлөл", "Ахмадын сан"-г тус тус байгуулж, "Ахмадын санг ажиллуулах журам"-ыг батлан мөрдөн ажиллаж байна.
  Банканд данс нээлгэн номын сангийн ажилтан, ажиллагсад сар бүр тодорхой хуримтлалыг үүсгэж, ахмадын санг тогтвортой, хэвийн үйл ажиллагаа явуулж байна.
- Ахмад залуу үеийн харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор "Ахмадын зөвлөл"-тэй хамтран "Олон улсын ахмадын өдөр"-ийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ жилийн ахмадын өдрийг "Ахмадуудаасаа суралцъя" уриан дор зохион байгуулсан бөгөөд тэдний арвин их туршлагаас сонсож, шинэ залуу номын санчдад ажлын байран дээр нь зөвлөх үйлчилгээ үзүүлсэний зэрэгцээ спортын тэмцээн уралдаан зохион байгууллаа. Жил бүр 1-2 ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ авч, зохих урамшууллыг "Ахмадын сан"-гаасаа санхүүжүүлж байхаар журамдаа тусгаад байна.
- Ахмад настнуудын нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд дэмжих, туслах зорилгоор байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан, зүйл заалтуудыг мөрдөн ажиллаж байна.
- 7, 13 дугаар багийн "Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төв"-д 150 гаруй ном, номын тавиурын хамт хандивлаж, номын булантай болгосон.

- Ахмадуудын чиглэлээр зохион байгуулсан ажлаа тухай бүрд пэйж хуудсаараа дамжуулан сурталчилж байна.



Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд:

- Номын санчдын монгол бичгийн Соёлын төвийн Нийтийн номын сангийн номын санчдын дунд “Бийрэн бичиг” уралдааныг зарлаж нийт 13 сумын номын санч аймгийн нийтийн номын сангийн албан хаагчдыг хамруулан бүтээлийн үзэсгэлэн гарган, шилдгүүдээ тодруулла.
- “Хос бичигтэн байгууллага” уриалгын хүрээнд нийт албан хаагчдад “Үндэсний бичгийн цахим бичвэр”, “Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт” зэрэг 10 цагийн сургалт зохион байгуулан компьютер болон гар утас ашиглан монгол бичгээр бичих, чадварт суралцлаа.
- Байгууллагын хаяг логог шинэчилж гадаа хаяг лого, болон байгууллагын өрөө, тасалгааны хаяг, танилцуулгыг кирилл, монгол бичгээр бичиж байршуулсан.

40%-тай буюу Эрчимжүүлэх шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 2 арга хэмжээ нь:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтын хэрэгжилтийг хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний орчны дэд бүтцийг стандартын дагуу бий болгох зорилт арга хэмжээний хүрээнд “Хараaны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах нь” Хөвсгөл аймгийн Нийтийн номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх уншлагын танхим нээх” төслийг бичсэн боловч санхүүжилтийн эх үүсвэрийг олж чадаагүй байна.
2. Залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа хандлагыг дэмжсэн зорилтот арга хэмжээ, залуу аав ээжүүдэд зориулсан явуулын сургалт үйлчилгээг хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд байгууллагын залуу ажилтан албан хаагчдад Гэр бүл дэх жендерийн асуудал, Гэр бүл төлөвлөлт сэдвээр сургалтад хамруулсан хэдий ч гадагшаа чиглэсэн зорилтот бүлэгт хандсан ажил хийгдээгүй байна.

6. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аймгийн нийтийн номын сан 2022 онд 5 үндсэн зорилтын хүрээнд 37 арга хэмжээ төлөвлөн ажилласан. Үүнээс:

90%-тай буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн – 34 арга хэмжээ
70%-тай буюу тодорхой үр дүнд хүрсэн -1 арга хэмжээ
30%-тай буюу үр дүнгүй -1 арга хэмжээ
0 %-тай буюу хэрэгжээгүй – 1 арга хэмжээ Хэрэгжилт 85.4%

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2022” ХАВРЫН АРГА ХЭМЖЭЭ

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээг 2022 оны 5 сарын 20-22 ний хооронд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Чингүнжавын талбайд зохион байгуулж 24 сумын ЕБС-ийн сургууль, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хувийн хэвшлийг өргөнөөр хамруулан нь уншигч иргэсдийн талархлыг хүлээлээ. Аймгийн хэмжээнд:

- 6 төрлийн тэмцээн уралдаан
- 1 ТВ нэвтрүүлэг
- 3 цахим арга хэмжээ
- Танхимаар 3 арга хэмжээ
- Нээлтэй өдөрлөгөөр 10 төрлийн соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж нийт 21000 гаруй уншигч иргэсэд үйлчилсэн байна.

Үүнд:

- “Соёлын өртөөчилсөн” аялал
- Номын клуб ном сонирхогчдын уулзалт (Номыг хэрхэн үр дүнтэй унших вэ?) Номын тухай подкаст
- Тэгш ойн нь тохиож буй зохиолчдын намтар уран бүтээлийн үзэсгэлэн
- Номын флашмоб (Номтой бүжиг)
- Урлагийн тоглолт /номын санч нар/
- Номын санд хандив өргөсөн алдартнуудыг алдаршуулах
- Номын өргөөний ид шид танилцуулга
- Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага
- “Хөвсгөлийн ган үсэгтнүүд” номын үзэсгэлэн Ховор хуучин номын үзэсгэлэн
- Шинэ номын үзэсгэлэн
- Тэргүүний уншигчдын бүтээлийн үзэсгэлэн
- Шинэ хуучин номын худалдаа
- Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа
- “Уншсанаа хуваалцъя” үлгэр уншсан 30 уншигчийг урамшуулах
- “Номын нөхөр-Шилдэг анги” уралдааны шагналыг гардуулах
- “Урнаар өгүүлэхүй” богино өгүүллэгийн уралдаан
- Үндэсний бичгээр номын хавчуурга хийж уншигчдад бэлэглэх
- Соёлын төвийн Нийтийн номын сангийн номын санчдын дунд “Бийрэн бичиг” уралдааны бүтээлийг шалгаруулж, үзэсгэлэн гарган, шагнал гардуулах үйл ажиллагаанууд болсон.



“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2022” НАМРЫН АРГА ХЭМЖЭЭ

32 дахь удаагийн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” намрын үйл ажиллагаа нь Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор “Илүү их уншъя” уриатай 9 сарын16-18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ арга хэмжээг “НомтойХөвсгөл” агуулгын хүрээнд 16 төрлийн үйл ажиллагаа болж, нийт давхардсан тоогоор 1192 уншигч, үйлчлүүлэгчид хамрагдсан.

Аймгийн Нийтийн номын сангаас шилдгүүдээ тодрууллаа. Үүнд:

- ✓ “Тэргүүний уншигч- Д.Нацагдорж тэмдэгтэн”
- ✓ “Номын нөхөр” байгууллага
- ✓ МУСГЗ Д.Сүрэнжавын нэрэмжит “Шилдэг номын санч”
- ✓ Шилдэг ном хандивлагч иргэн

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” намрын үйл ажиллагаанд аймгийн хэмжээнд 1200 мянга орчим хүн зорин ирж үзсэн нь иргэдийн оролцоо, идэвх өмнөх жилүүдээс ихэссэн байна.

Энэ удаагийн номын баярыг улс орон даяар “Илүү их уншъя” уриан дор нэгэн зэрэг зохион байгуулагдсан нь онцлог байлаа.

Манай аймгийн хувьд энэ жилийн номын баярын намрын үйл ажиллагааг “Илүү их уншъя” уриан дор “Номтой-Хөвсгөл” агуулгатайгаар зохион байгуулан ажилласан.

Зохион байгуулсан үйл ажиллагаа Хөвсгөл аймагт:

1. Номын баярын нээлт
2. “Ургаа судалъя, удмаа мэдье” ургийн бичгийн сургалт
3. “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага
4. “Номын өргөөний ид шид” лекц танилцуулга
5. Номын санчдын сургалт МҮНС-аас сургалт
6. МУСГЗ Д.Сүрэнжавын нэрэмжит “Шилдэг номын санч” шагнал гардуулах
7. Ном хандивлагчийг алдаршуулах
8. Шинэ номын үзэсгэлэн
9. Тэгш ой тохиож буй зохиолчдын намтар, уран бүтээлийн үзэсгэлэн
10. “Монголын сайхан бичигтэн” улсын уралдааны хамгийн залуу оролцогчийн уран бүтээлийн үзэсгэлэн
11. “Босоо бичгээ дээдэлье” уриан дор танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээн
12. “Тэргүүний уншигч- Д.Нацагдорж тэмдэгтэн” тэргүүний уншигчдад шагнал гардуулах
13. “Номын нөхөр” байгууллагын шагнал гардуулах
14. “Хүүхдийн номын өргөө” номын дэлгүүрээс номын үзэсгэлэн-худалдаа
15. “Хаан бичиг” номын төвийн үзэсгэлэн худалдаа
16. Хуучин номын худалдаа зэрэг соёл, урлагийн 16 нэрийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Мэдээлэл, сургалт сурталчилгааны ажил

<u>Номын сангийн тухай хуулийн сурталчилгаа, хэлэлцүүлэг</u>

Номын сангийн тухай хууль, номын сангийн үйл ажиллагааг уншигчдад сурталчлах зорилгоор соёл олон нийтийн олон талт үйл ажиллагаа явууллаа. Үүнд: Танин мэдэхүйн тэмцээн (Алтан хонх, АХА,), Номын сангийн пейж хуудсаар шторк, видео, (Хөвсгөл Нийтийн номын сан), Номын сангийн уншигч, аймгийн нийт номын санчид болон зохиолчдын дунд хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

<u>“Уншаад урагшлахуй” ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх</u>

“Уншаад урагшлахуй” бүтээлч уншлагад “Титэм” ЕБС-ийн Ж.Энхмаа багштай 9б ангийн 39 сурагчдад зохиолч Э.Амарзаяагийн “Сонгогдоогүй краш” номыг уншиж, зургаар илэрхийлсэн номын тэмдэглэлийг 21 уншигч хөтөллөө.

<u>“Номын өргөөний ид шид” лекц танилцуулга.</u>

Зохиолч яруу найрагч Ц.Гончиг “Номтой нөхөрлөсөн миний түүх” лекц-ярилцлагыг уншигчийн дунд зохион байгууллаа.

Зохиолч, ном унших ач тус, хамгийн анх уншсан ном, яагаад номын сан түүний 2 дахь гэр болсон тухай уншигчидтай ярилцлаа. Энэ арга хэмжээнд Мөрөн сумын Ерөнхий Боловсролын дөрвөн сургуулийн 45 хүүхэд хамрагдсан.

<u>“Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага.</u>

“Мянга нэгэн шөнийн үлгэр”, “Оршил”, “Мянга нэгэн шөнийн үлгэр-1”,

“Сариг цагаан ботго” зэрэг үлгэрээр Эрдмийн далай цогцолбор сургуулийн 3б,3в, Хөх сувд 1-р цэцэрлэгийн ахлах бүлэг, нийт 110 хүүхэд хамрагдсан. Эдгээр чанга уншлагыг бичлэг болгон цахим орчинд түгээсэн.

“Номын хандив өргөсөн, номын санд хөрөнгө оруулсан хувь хүн, албан байгууллагыг урамшуулах, алдаршуулах

Аймгийн Нийтийн номын сангаас ном хандивлагчийг алдаршуулах өдөрлөг зохион байгуулсан бөгөөд уншигчид ном хандивлагчтай чөлөөт ярилцлага, мөн сурсан англи, дуу шүлгээрээ мэндчилгээ дэвшүүлсэн

АНУ-д ажиллаж, амьдарч буй хүний их эмч Г.Цэнд-Аюуш нь Тосонцэнгэл сумын ЕБС-ийн болон аймгийн Нийтийн номын санд хүүхдийн уран зохиол, танин мэдэхүйн нэвтэрхий толь, англи хэлний толь бусад шинжлэх ухааны 1,050,000 төгрөгийн үнэ бүхий 150 ширхэг англи ном хандивласан.

Ховор хуучин номын үзэсгэлэн зохион байгуулах

МУСГЗ Д.Сүрэнжавын хэрэглэж байсан эд зүйл, гар бичмэлийн үзэсгэлэнг дэлгэн, уншигч үйлчлүүлэгчдэдээ танилцууллаа. Үзэсгэлэнд МУСГЗ Д.Сүрэнжавын өгүүллэг, тууж, нийтлэлийн 10 гаруй гар бичмэл тавигдсан.

“Бийрээ нийлье, ургаа уудалъя!” үндэсний бичиг, угийн бичгийн сургалт

Нийтийн номын сангийн албан хаагчдад МУГ багш Д.Сайнтогтох “Угийн бичиг хөтлөх арга зүй” 2 цаг, дадлага ажил 2 цаг нийт 4 цагийн сургалтыг зохион байгуулж, албан хаагчид өөрийн угийн бичгийг хөтөллөө.

Энэ үеэр “Ургаа судалъя Удмаа мэдье ” сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж, уншигчдад ургийн бичиг хөтлөхийн ач тусын тухай тойм яриа хийв. Уг сургалт, тойм ярианд нийт 45 уншигч албан хаагчид хамрагдсан.

Номын санч, уншигчдад зориулсан цахим сургалт

Аймгийн Соёл Урлагийн газар, Нийтийн номын сан МҮНС-тай хамтран Хөвсгөл аймгийн бүх номын санчдад чадавхжуулах сургалтыг МҮНС-ийн Мэдээлэл арга зүй-Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Т.Хайдав Цахим сан хөмрөгийн бүрдүүлэлт сэдвийн хүрээнд 65 номын санчдад 1 өдрийн дадлагад суурилсан сургалт, мэдээллийг хийлээ.

Үзүүлэн таниулах ажил Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн

2021-2022 онд сан хөмрөгт ирсэн 158 ширхэг номоор “Шинэ номын үзэсгэлэн”-г 3 өдөр гаргаж, шинэ номын мэдээг тодорхойломжийн аргаар хийсэн. Үзэсгэлэнг нийт 918 уншигч үзэж, шинэ номын мэдээлэлтэй танилцлаа. Энэ үеэр дөнгөж хэвлэлтээс гарсан, мөн номын худалдааны бестселлер болсон номууд цөөнгүй байлаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн, төрөл бүрийн материалаар хийсэн ном, баринтаг, хавчуурга болон бусад зүйлсийн үзэсгэлэн

Ширээний болон хэтэвчний хуанли, эко даавуун тор зэрэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Тэгш ой /80, 90, 100/ тохиож буй зохиолчдын бүтээлийн чуулган, үзэсгэлэн

80 дээш насны ой тохиож буй зургаан зохиолчийн намтар уран бүтээлээр үзэсгэлэн гаргалаа. Үзэсгэлэнд нийт 80 ширхэг ном дэлгэгдэн зохиолчдыг алдаршуулан уран бүтээлийг нь сурталчлан ажиллаа. Мөн онцлох дөрвөн зохиолчдын намтар уран бүтээлээр цахим контент хийн цахимд байршуулсныг 670 хүн үзсэн байна.

Уншлагыг дэмжих арга хэмжээ

Тэргүүний уншигч сурагч, гэр бүл, байгууллагыг шалгаруулах, сурталчлах, алдаршуулах арга хэмжээ

Монголын болон гадаадын утга зохиолын шилдэг бүтээлүүдээс хамгийн олон ном уншсан, номын тэмдэглэл хөтөлсөн, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцдог, хувийн номын сантай зэрэг олон үзүүлэлтийг ханган “Тэргүүний уншигчД.Нацагдорж

тэмдэгтэн”-ээр 3 сурагч шалгарлаа. *(“Гурван-Эрдэнэ” сургуулийн 11в ангийн сурагч Б.Нямсүрэн, Төрөлжсөн сургалттай “Авьяас” сургуулийн 12а ангийн сурагч Г.Гантогтох, ДМЦС-ийн 5в ангийн сурагч Б.Уянгацэцэг)*

Аймгийн төрийн байгууллагуудын дунд “Номын нөхөр-байгууллага” болзолт уралдаан зарлаж шилдгүүдийг тодруулсан. *(Тэргүүн байрыг аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төв, Дэд байранд аймгийн Онцгой байдлын алба, Гутгаар байранд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс)*

Энэ арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдыг номын сангийн уншигч болгож, байгууллагуудын дэргэд номын сан, булантай болж ном унших нөхцөл, боломжийг бүрдүүлэх ажил хийгдсэн.

2021 оны “Шилдэг номын санч”-ийг шалгарууллаа.

Аймгийн Нийтийн номын сан нь жил бүрийн номын баяраар МУСГЗ зохиолч, сэтгүүлч Д.Сүрэнжавын нэрэмжит шагнал “Шилдэг номын санч”-ийг шалгаруулдаг. Зохиолчийн ар гэр, үр хүүхдийн ивээн тэтгэлгээр бусдад оюуны талх түгээгч номын өргөөний эздээ урамшуулж, хичээл зүтгэлийг нь үнэлдэг уламжлалтай болоод 4 жилтэйгээ золгож байгаа бөгөөд 2021 оны шилдэг номын санчаар аймгийн нийтийн номын сангийн сан хөмрөгч Ч.Учралтбаясгалан тодорлоо.

<u>Номын тухай подкаст</u>

“Хамтдаа унших түүх-1” номын үзэгч 277, “Ад үзэгдэх зориг” номын үзэгч 457, “А-Я хүртлэх аялал” номын үзэгч 489, “Дэлхий” номын үзэгч 530 нийт 1753 хүнд хүрчээ.

Номын худалдаа

<u>Хэвлэх үйлдвэр, хэвлэлийн газар, зохиолчид, хувь ном цуглуулагчдын номын худалдаа</u>

Номын баяраар “Хүүхдийн номын өргөө” дэлгүүр 10-20% хямдралтай худалдааг 3 хоногийн турш зохион байгуулахад Мөрөн сумын иргэд болон ЕБСийн сурагчид идэвхтэй хамрагдаж, 2125000 төгрөгийн үнэ бүхий 85 ширхэг ном худалдан авсан байна.

Намрын арга хэмжээний шинэлэг тал

<u>Намрын “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээний шинэлэг тал, онцлог арга хэмжээ.</u>

“Номтой Хөвсгөл” агуулгын хүрээнд төрийн албан хаагчдын уншлагыг дэмжих зорилгоор Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд байгууллагын дэргэдэх номын сан, номын булантай боллоо. Үүнээс шилдэг 5 байгууллагыг шалгаруулан, цахим орчинд сурталчлан тус бүр 100000 төгрөгийн үнэ бүхий номын багцыг номын санд нь хандивлалаа.

31 дэх
НОМЫН БАЯР

НОМ ХАНДИВЛАГЧДАА БАЯРЛАЛАА

ХАНДИВЛАСАН ҮЗЭСГЭЛЭН

ШИНЭ НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

ЧАНГА УНШЛАГА

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” арга хэмжээний үр дүн, онцлог: 1.

Номын сангийн уншигчийн тоо нэмэгдсэн

2. Үйлчилгээний цар хүрээг тэлсэн.
3. Уншлагыг дэмжих ажил үр дүнтэй хийгдсэн.

Энэхүү хавар, намрын арга хэмжээ нь тусдаа 10.0 сая төгрөгийн төсөвтэй, монгол орон даяар нэг уриатай, нэг цаг хугацаанд нэгдмэл байдлаар зохион байгуулагдсан нь онцлогтой байсан бөгөөд соёл гэгээрлийн ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон.

7. “НЭРЛЭСЭН ЖИЛ”-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Манай аймаг 2022 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласан бөгөөд нийт 8 арга хэмжээ төлөвлөн ажилласан. Үүнээс:

100%-тай буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн – 8 арга хэмжээ

Хэрэгжилт – 100%

<u>Сурагчид мэргэжлээ зөв сонгох нь сургалт:</u>

- Ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох нь сургалт, төсөл хэрхэн бичиж өөрсдөө орлоготой болох талаар сургалтыг тус тус зохион байгууллаа. Энэ сургалтад 90 гаруй хүүхэд хамрагдлаа
- “Мэргэжил сонголт-Бидний ирээдүй” танилцуулга бэлтгэж, ахлах ангийн сурагчдад тараалаа. Энэ танилцуулгад Монгол улсад эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжил, мэргэжил сонголт хийхдээ гаргадаг алдаанууд, мэргэжил сонголтоос гарах алдаанууд зэрэг мэдээллүүдтйг багтаалаа.
- Нийтийн уншлагын танхим мэргэжил сонголт сэдвээр үзэсгэлэн гаргаж уншигч, үйлчлүүлэгчиддээ хүргэлээ.
- “Мэргэжил сонголт-Бидний ирээдүй” цахим контентийг цувралаар хүргэн танилцууллаа.
- Үүнд: Монгол улсад эрэлттэй 10 мэргэжил, илүүдэлтэй мэргэжлүүд, мэргэжил сонголтод эцэг эхчүүд хэрхэн нөлөөлдөг вэ? зэрэг хэд хэдэн мэдээллийг багтаажээ.

<u>Нээлттэй хаалганы өдөрлөг:</u>

- Ахлах ангийн сурагчдид, хөдөлмөрийн насны иргэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой   өөрт хэрэгтэй ном хэвлэлтэй танилцах, худалдаж авах боломжийг олгосон.

Албан хаагчид бүр- Нэг төсөл" аян зохион байгуулах:

- Энэ ажлын хүрээнд нийт 6 төслийг холбогдох газарт нь хүргүүллээ. Тухайлбал: Урц зөөврийн номын сан, Хүүхэд хөгжлийн төв, Гэр бүлийн уншлагын танхим болгох нь зэрэг төслүүд юм.

Ахмадаасаа суралцъя" аян:

- "Мэргэжил бүхэн сайхан" уулзалт зохион байгууллаа. Энэ хүрээнд номын санд ажиллаж байсан ахмадуудтайгаа уулзаж, туршлага солилцох арга хэмжээ зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд ахмад номын санч Ч.Дуламсүрэн П.Ваня, П.Нямжав, Х.Чимэдмаа нар оролцож залуу үеийнхэнтэйгээ хамтран ажиллаа.

8. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийт 7арга хэмжээ төлөвлөн ажилласан.

Үр дүнтэй бүрэн хэрэгжсэн арга хэмжээ -7

Хэрэгжилт-100%

(Тайланг хавсралтаар гаргав)

9. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллагад хамаарах 12 шалгуур үзүүлэлтүүдээс бүгд үр дүнтэй бүрэн хэрэгжсэн байна. Хэрэгжилт – 100%

Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон "Иргэн танд тусалъя" мэдээллийн самбарыг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолд тусгагдсан ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу гаргаж, холбогдох албан тушаалтанд

хариуцуулан цаг тухай бүрд нь мэдээ мэдээллийг шинэчлэн байршуулахад хяналт тавин, хариуцлагажуулан ажиллаж байна.

Байгууллагынхаа алсын хараа, эрхэм зорилго, зорилгоо шинэчлэн боловсруулж, олон нийтэд ил тод байршуулсан. Мөн ажил үйлчилгээ, зохион байгуулах арга хэмжээнийхээ талаарх мэдээ, мэдээллийг уншлагын танхим бүр мэдээллийн самбартаа болон Хөвсгөл Төв Номын сан пэйж хуудсанд байршуулан ажиллаж

байна.

Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;

Шинээр номын сангийн уншигч болоход болон гэрээр ном олгох үйлчилгээ үзүүлэх журмыг ил тодоор уншлагын танхимд хэвлүүлэн байрлуулсан. Энэ журамд гэрээр ном олгоход болон шинээр карт нээлгэхэд ямар бичиг баримт шаардлагатай болохыг тодорхой бичиж тавьсан. Мөн Хөвсгөл Төв номын сан цахим хуудсанд байрлуулдаг.

Мөн өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль дүрэм, тогтоол шийдвэрүүдийг ойлгомжтой байдлаар хэвлэн мэдээллийн самбарт байршуулан, тогтмол шинэчлэн ажилладаг.

10. АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөн ажилласан.

Хэрэгжилт -100%

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах шудраг, хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх ажлын хүрээнд:

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжуудыг номын сангийн веб хаяг болон Фейсбүүк хаягаар тогтмол түгээж албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, бусад мэдүүлэг, мэдэгдэлийг хэрхэн хөтлөх талаар ном хэвлэлийн үзэсгэлэн гаргаж уншигч ирэгсдэд сурталчилсан.

Аймгийн Засаг даргын тамгын газрын хууль, Эрхзүйн хэлтэстэй хамтран байгууллагын нийт албан хаагчдад төрийн албан хаагчдын авилгал ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны дэд хөтөлбөрийн талаар Аймгийн Засаг даргын тамгын газрын хууль, Эрхзүйн хэлтэсийн мэргэжилтэн М. Батчимэг сургалт мэдээлэл хүргэлээ.

Дүгнэлт:

Бодлогын баримт бичиг болон тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг гаргахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, аймгийн Засаг даргын 2021 оны А/515 дугаар "Аргачлал шинэчлэн батлах тухай" захирамжийг мөрдлөг болгосон.

Мөн тус байгууллагад хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудыг нэг бүрчлэн бүртгэл хяналтанд авч, тайлагнах хугацаа, хариуцах эзэн зэргийг тодорхой тусгасан "Мастер лист"-ийг боловсруулж, холбогдох дээд шатны мэргэжилтнээр хянуулан үйл ажиллагаандаа мөрдөж байгаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг төлөвлөлт, үйл ажиллагаатайгаа уялдуулан ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН.................. /Ч.ҮЧРАЛТБАЯСГАЛАН/

ХЯНАСАН:

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ .... /Э.ДАВААЧУЛУУН/

ХЭНТИЙ АЙМГИЙН Р.ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ТАЙЛАН

2022.12.25 Чингис хот

1. **<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:</u>**

1.1 Энэ хугацаанд байнгын Байнгын уншигч 2402, ирцээр уншигч 20658, тэдгээрт 20974 ном олгож үйлчиллээ.

-Үүнээс танхимаар 12767 ном, гэрээр 3772 ном Зөөврөөр 4435 олгосон байна.

Үүнийг танхим тус бүрээр харуулахад:

- Нийтийн уншлагын танхим байнгын уншигч 786, ирцээр уншигч 6500, олгосон ном 6217,
- Хүүхдийн уншлагын танхим байнгын уншигч 1286, ирцээр уншигч 6613, олгосон ном 4138,
- Гэрээр ном олгох танхим байнгын уншигч 184, ирцээр уншигч 6843, олгосон ном 4357,
- Сан хөмрөг байнгын уншигч 146, ирцээр уншигч 702, олгосон ном 3262,
- Танхим хооронд болон сумдын номын сангуудтай түр шилжүүлгийн бүртгэлээр 365 ном шилжүүлж үйлчилгээнд гаргасан байна.

1.2 **Үзэсгэлэн:** Тайлант жилийн тэмдэглэлт өдөр нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 72 удаа 4541 номоор үзэсгэлэн гаргаж иргэд олон нийтэд танилцуулсан байна..

1.3 **Сэлбэн засалт:** Сан хөмрөг, Хүүхдийн болон нийтийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхимын сан хөмрөгт буй 4323 ширхэг номонд сэлбэн засалт хийсэн.

1.4 **Ариутгал:** Номын санч бүр уншлаганд гарсан номын ариутгалын төхөөрөмжөөр ариутгаж энэ хугацаанд 1508 ширхэг ном ариутган уншлага үйлчилгээнд гаргаж байна.

1.5 **Зөөврийн номын сангийн үйлчилгээ:** Зөөврийн номын сангийн үйлчилгээг Дархан, Батширээт, Батноров, Дадал, Дадал сумын хилийн цэргийн 0287-р анги, Бэрх, Жаргалтхаан 6 сум, ШШГГазар, Цэцэрлэг, Авто тээврийн төв, ХБИргэдийн холбоо зэрэг ААНБ-д 15 удаагийн давтамжтайгаар 2230 хүнийг хамруулан 4435 ширхэг номоор үйлчилсэн. 1 сумын 4, ААНБ-д 115 ширхэг номоор 55 хүнийг хамруулан үйлчилсэн.

1.6 **Зөвлөн туслах ажиллагаа:** Хэрлэн, Дадал, Баянхутаг, Бэрх, Баян-Овоо, Батноров Соёлын төвийн номын санд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн

1.5 **Мэдээ, тайлан:** 7 хоногийн мэдээг Пүрэв гараг бүр, улирлын статистик мэдээг 3,6,9,12 сард тус тус дээд шатны байгууллагад үнэн зөв бодит тоон үзүүлэлт, бичмэл тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

<u>2.САН ХӨМРӨГ, КАТАЛОГ</u>

2.1 **Сан хөмрөгийн баяжилт:** Тайлант хугацаанд батлагдсан төсвийн хүрээнд болон хандив тусламжаар 15214.4 мян.төг-ийн үнэ бүхий 878 ширхэг номоор сан хөмрөгийн баяжилт хийсэн.

Үүнд: Төсвийн хөрөнгөөр 357 нэр төрлийн 521 ширхэг, 10755.7мян/төг, Хандиваар 263 нэр төрлийн 357 ширхэг 4458.7мян/төг-ийн номоор тус тус баяжууллаа. Эдгээрээс сан хөмрөгт 146, Нийтийн уншлагын танхимд

2.2 **Каталог зохион байгуулалт:**

- Үүлэн технологид суурилсан Khentii.Libu4.net цахим програмд сан хөмрөгт буй 24805 нэр төрлийн 53304 ширхэг номын каталогийг 100 хувь цахимжуулж, электрон каталогийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо 2855 хандалт байна. Энэ онд Номын сангийн электрон каталогт нийт уншлага үйлчилгээний танхимууд 878 ном шинээр цахим каталогт байршуулсан байна.
- Цахим сан үүсгэсэн нийт номоос 4.7 хувь буюу 2382 ширхэг номын стандарт бичилттэй тулгалт хийн хяналт хийлээ.
- Цахим сан үүсгэсэн нийт номоос 16% хувь буюу 7962 ширхэг номын стандарт бичилттэй тулгалт, хяналт, засварлалт хийж 597 номны цаасан каталогийг хэвлэж гаргаад байна.

3. ЦАХИМ

- **E-Mongolia болон Erp.e-mongolia систем**ийн үйл ажиллагааг албан хэрэгцээндээ 100 хувь ашиглаж байна. Энэ хугацаанд ирсэн бичиг 178 үүнээс хариутай бичиг 51, хугацаанд нь хариуг хүргүүлсэн 51, явсан бичиг 57, захирлын тушаал А-25, тушаал Б-7, хурлын тэмдэглэл 8 тус тус байна.
- Нийтийн номын сангийн “Хэнтий аймаг Номын сан” олон ниитийн сүлжээнд байгууллагынхаа үйл ажиллагааны 459 мэдээ, мэдээллийг байршуулж олон нийтэд ил тод нээлттэйгээр хүргэж ажиллалаа.

3.ТОГТМОЛ ХЭВЛЭЛ, СОНИН, СЭТГҮҮЛ

- Өдрийн сонин, Үндэсний шуудан болон Утга зохиол, урлаг, Дал, Open door, Хүмүүн бичиг, орон нутгийн Хэнтий мэдээ сонингууд, Цог, Улирал ба зохиолч, Төрийн мэдээлэл, Өрхийн үйлдвэрлэл зэрэг сонин сэтгүүлийг тус бүр 4 улирлын туршид нийтдээ 284.8мян.төг-ийн хэвлэлийг захиалан уншигчиддаа хүргэж байна.
- Үндэсний хэмжээний тогтмол хэвлэлийн мэдээллийн санд орон нутгийн “Урагшаа”, “Хэнтийн мэдээ” сонины 1990-1992 оны мэдээллийг оруулсан.
- МҮНС-ийн сонин сэтгүүлийн нэгдсэн сан Zotera програмд орон нутгийн “Урагшаа” сонины 1982-1988 онуудын мэдээллийг оруулж цахим нэгдсэн санд байршуулсан.
- Хан Хэнтий нутгийн бичгийн мэргэд, уран үгийн дархчууд, зохиолч, яруу найрагчдын бүтээлийн чуулган “Хэрлэн” цуврал сэтгүүлийн 9 дэх дугаарын редакцын зөвлөлд “Хэрлэн тооно” утга зохиолын нэгдэлтэй хамтран ажиллаж шинэ сэтгүүл хэвлэгдэн гаргалаа.

4.СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Соёл олон нийтийн ажлыг 44 удаа зохион байгуулан 21434 хүн хамрагдууллаа. Үүнээс Хүүхэд 11551, ХБИ 43 байна.

- “Уншсанаа хуваалцаж бусаддаа боломж олгоё”, “Үлгэрийн цаг”, “Номтой зочин”, “Яруу найрагчтай хийх уулзалт”, “Зуны зугаатай уншлага” 9-н цуврал, “Номын жим” хөтөлбөрт сургалт, “Та чадна, бид туслая” ХБИргэдэд зориулсан өдөрлөг, “Илүү их уншъя”, “Гэр бүлийн

уншлага”, Зохиолч уншигчдын уулзалт, сургалтыг МЗЭ-ийн шагналт яруу найрагч Б.Чулуунцэцэг, Хүүхдийн зохиолч Н.Мандал нар Хан Хэнтий цогцолбор сургуулийн суралцагч хүүхдүүдтэй, МЗЭ-ийн шагналт яруу найрагч М.Саруулдалай, МЗЭ-ийн шагналт дууны яруу найрагч М.Ган-Очир нар уншигчид, Хэрлэн 4-р сургуулийн багш, сурагчидыг хамруулан зохион байгууллаа.

- МЗЭ-ийн Хэнтий аймаг дах салбар Хэрлэн тооно утга зохиолын нэгдэлтэй хамтран “Сэцэн ханы найраг” сэдэвт зүүн бүсийн яруу найрагчдын уулзалт, үдэшлэгийг Б.Галсансүх, Б.Батсайхан тэргүүтэй 10 гаруй яруу найрагчидтай зохион байгуулж, Батноров суманд “Найраг хөгжөөх цаг” зохион байгууллаа.
- “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны хүрээнд “Бүтээлч уншлага”, “Буриад хэл аялга, түүний онцлог”, танилцуулга уулзалт, “Өвлийн яруусал” яруу уншлагын цахим уралдаан, Аймгийн нийт цэцэрлэгүүдийн дунд “Үлгэрийн баатар амилсан нь-2022” уралдаан, “Монгол хэл бичиг” хичээнгүй бичгийн аймгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгууллаа.
- “ӨВ СОЁЛ, ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ” сарын аяны хүрээнд Хэрлэн сумын ЕБ-ын I-IV сургуулиудад тус сургуулийн номын санч нартай хамтран үндэсний өв соёл уламжлалын сэдэвт болон Хан Хэнтийн зохиолч уран бүтээлчдийн ном бүтээлээр үзэсгэлэн гаргаж “Улс орны төрийн далбааг цээжилцгээе” дасгал ажил, “Монголын нууц товчоо” хөлөгт тоглоомоор наадах, “Монгол гэр”-ээ хэрхэн зөв барьж, зөв хураах, зөв буулгах нүүдэлчин ахуй соёлд сургах дадал хэвшүүлэх зорилгоор NAAD брэндийн “Нүүдэлчдийн угсардаг гэр”-ийн загвар дээр ажиллуулахын зэрэгцээ уншигчийн үнэмлэх нээх, гэрээр ном олгох, асуулт хариултын хөгжөөнт бяцхан тэмцээн зэрэг арга хэмжээ зохион байгуулсан байна.
- Соёл олон нийтийн үйлчилгээнд зориулан 3821 номоор үзэсгэлэн гаргаж үйлчиллээ.

- НОМЫН БАЯР “Дэлхийн ном болон зохиогчийн эрхийг хамгаалах өдөр”-г тохиолдуулан “Уншсанаа хуваалцаж, бусаддаа боломж олгоё” арга хэмжээг “KHENTII BOOKBRIDGE” сургалтын төв, Хэрлэн лаборатори I сургуулийн М.Ууганчимэг багштай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд асуулт хариултын цэнгээнт хөгжөөнт тоглоом, номын сангийн үйл ажиллагаатай танилцах аялал, номын үзэсгэлэн, номын танилцуулга, уулзалтыг Философич С.Молор-Эрдэнэ, МЗЭ-ийн гишүүн Хэрлэн тооно утга зохиолын нэгдлийн гишүүн, яруу найрагч Л.Баавай нартай зохион байгуулж уг арга хэмжээнд нийтдээ 85 хүн хамрагдлаа.
- “Гэрэлт цох” хүүхдийн оролцооны байгууллагатай хамтран “Номтой зочин”, “Хөтөч номын санч” номын сангийн үйлчилгээ төрийн болон төрийн бус байгууллагын 50 иргэнд 118 номтойгоор үйлчилгээ үзүүлсэн.
- Зохиолч уншигчдын уулзалт үдэшлэгийг 4 удаа уншигч олон нийтэд тэгш хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор: - Бэрх суманд Хэрлэн тооно утга зохиолын нэгдлийн гишүүд болон зүүн аймгуудын яруу найрагчидтай,
- Дадал суманд Болор цомын эзэн Яруу найрагч О.Цэнд-Аюуш, Хүүхдийн зохиолч О.Сундуй нар ЕБС-ийн хүүхдүүдтэй, Хилийн цэргийн ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзалт үдэшлэг зохион байгуулсан байна.

Номын баярт зориулан нийт 9 үйл ажиллагаа зохион байгуулж 8500 иргэд олон нийтийг хамруулсан ба үүнээс хүүхэд 5065, ХБИ-67 байна.

- ОЮУХАЙ-2022 ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ Р.Чойномын “Өд” сан, Дархан сумын Засаг даргын ивээл дор МЗЭ, Хэнтий аймаг дахь “Хэрлэн тооно” утга зохиолын нэгдэл хамтран “ОЮУХАЙ-2022” яруу найргийн наадмыг зохион байгуулсан. 11 дэх удаагийн наадамд 54 найрагчийн 162 бүтээл оролцож Хан Хэнтийн зохиолчид болон уригдан оролцож буй яруу

найрагчдын уран бүтээлийн үзэсгэлэн, 160 шинэ номын үзэсгэлэн худалдаа зэрэг арга арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа. Нийт хамрагдсан хүний тоо 310

- ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР “Эх хэлний өдөр”-өөр байгууллагынхаа хоймор хэсэгт уйгаржин монгол бичиг, дөрвөлжин, соёмбо үсгээр бичигдсэн Төрийн дуулал байрлуулж Чингис хааны хөргийн хамт залсан.
- Сан хөмрөгт 193 нэр төрлийн 339 ширхэг уйгаржин монгол бичгийн бичигдсэн ном хэвлэл бүртгэлтэй уншлага үйлчилгээнд гарч иргэд олон нийтэд хүрч байгаа ба улирал бүрийн эхэнд энэхүү номуудаараа лавлагаа мэдээллийн үйлчилгээ үзүүлэх үзүүлэнд байршуулж уншигчдад хүргэж байна.
- Хамт олноороо Аймгийн тамгын газраас зохион байгуулж буй цуврал “Монгол бичгийн хичээл” цахим сургалтанд хамрагдаж хос бичигтэн болохоор суралцаж байна.

- “Үндэсний бичиг үсгийн баяр”-аар Бичиг соёл, боловсролын төвийг үүсгэн байгуулагч Д. Ганбаатар, Зүүн хүрээ Дашчойлин хийдийн бурханч лам М.Эрдэмбилэг нар төрийн байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан нарт бүтээлийн үзэсгэлэнгээ толилуулж Соёмбо бичиг, Дөрвөлжин үсэг, Уйгаржин Монгол бичгийн тиг, Хулсан үзгийн тигийн тухай анхны мэдэгдэхүүн өгч, Монгол бичгийг хэрхэн хялбар сурах талаар зөвлөгөө өгч, Монгол хэл бичгийн багш нар, түүгээр хичээллэгч хүүхдүүдэд Соёмбо үсэг, Дөрвөлжин бичиг, Уйгаржин Монгол бичгийг тигийн тухай болон "ХУЛСАН ҮЗЭГ"-ийн тиг, хэрхэн бичих анхан шатны сургалтыг амжилттай зохион байгуулж 500 гаруй багш, сурагчдыг хамруулав.

- Хэрлэн сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Та чадна, бид тусалъя” өдөрлөгийг зохион байгууллаа. Нийт 130 хүн хамрагдлаа. Үүнээс 30 нь ХБИ байна.

- Номын санд хадгалагдаж буй ховор ном “Молон тойны эхийн ачийг хариулсан судар” нь уйгаржин монгол бичгээр бичигдсэн бөгөөд уншигч олондоо сурталчлах зорилгоор видео хэлбэрт оруулан номын сангийн цахим хаягт цуврал хэлбэрээр байршуулсан. /хэвлэгдсэн он тодорхойгүй/

4.СУРГАЛТ

4.1 Номын сангийн Lib4U програмын анхан болон дунд шатны сургалтуудын сумдын номын санч нарт, дотооддоо номын сангийн холбоод болон бусад мэргэжлийн байгууллагуудын зохион байгуулсан танхимын болон цахим сургалтуудад 8 удаа хамрагдсан.

- Мэргэжлийн бус 1 номын санч ажлын байрандаа Монголын боловсрол судлаачдын холбооны “Боловсрол” төвийн номын санчийн мэргэжил олгох сургалтанд суралцаж “Номын санч”-ийн мэргэжил эзэмшиж, 1 номын санч СУИС-ийн Номын сан судлалын эчнээ ангид суралцаж байна.
- Номын сангийн Консорциум, Соёлын яамнаас зохион байгуулсан “Номын санч-мэдээллийн ажилтан”-ы улсын IX зөвлөгөөнд 2 номын санч оролцлоо.
- Сан хөмрөгч танхимын сургалтаар “Номын эмч”, “Даавуун ном бүтээх арга зүй” сэдэвт номын санчийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан.
- Угийн бичгийн сургагч багштай хамтран “Угийн бичиг” хөтлөх сургалтыг Төрийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан нарт зохион байгууллаа. Хамрагдсан хүний тоо 50.
- 50 өрхөд угийн бичиг хөтлөх талаар гарын авлага тарааж мэдээлэл өгсөн.

Аймгийн хэмжээнд 2022 онд: Угийн бичгийн зөвлөмж, сургалт: 124 удаа 3019 иргэд хамрагдсан байна. Угийн бичгийн үзэсгэлэн- 3 удаа 240 хүнд

Угийн бичиг хөтөлсөн:

Нийт сумдын өрх- 24215 байгаагаас 2022 онд нэмж хөтөлсөн айл өрх - 850, нийт хөтөлсөн өрх -10917 Хувь-45.8%-тай байна

5. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТАЛААР

Тайлант хугацаанд гаднаас өргөдөл гомдол ирээгүй, дотооддоо хувийн чөлөө хүссэн өргөдөл 18, ёс зүйн зөрчил гаргасан ажилтны тайлбар 1 байна. Байгууллагын дэргэдэх орон тооны бус Ёс зүйн зөвлөл 3 удаа, ББНШКомисс 2 удаа хуралдсан.

Долоо хоногийн хийсэн ажлын тайланг 1 сард 4 удаа буюу СУГ-ын холбогдох мэргэжилтэнд Пүрэв гараг бүрийн 09:00 цагт хүргүүлж хэвшсэн.

Архивын 2021 оны 18 баримтыг стандартын дагуу үдэж хавтаслаж архивын баримт бичигт хяналт тавьж буруу бичигдсэн 8 хадгаламжийн нэгжийн хадгалах хугацааг тодорхойлон байрлуулсан. ХН-үүдийн хадгалах хугацааг тодорхойлон он цагийн дараалллаар байрлуулан байрлалын заагуур хийсэн.

6. САНХҮҮ

- Тайлант хугацаанд 138586.4 мян.төг-ийн санхүүжилт авч, 133148.5мян/төг-ийн бараа үйлчилгээний зардал гарсан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 170029.8мян/төг, ном хэвлэлд 4740.8мян/төг, Төрийн өмчийн барилгын тогтмол зардалд 14085.1мян/төг-ийн тус тус зарцуулсан. Нэмэлт дансанд 2738.5мян/төг төвлөрүүлэн үүнээс ном хэвлэлд 1550.0мян/төг, бусад зардалд 858.5мян/төг зарцуулсан. Санхүүгийн жилд өр авлагагүй санхүүгийн сахилга баттай хэмнэлтийн горимоор ажиллаж байна.
- Ахмадын сангаас төвлөрсөн төсвөөс зарцуулах журмыг мөрдлөг болгон жил бүрийн ахмад настны тэмдэглэлт өдрүүдэд 330.0мян/төг-ийн мөнгөн тусламж үзүүлсэн.
- Санхүүгийн жилд хэмнэлттэй, өр авлагагүй, зориулалтын дагуу зарцуулж санхүүгийн сахилга баттай ажилласан.

7.БУСАД

- Аймаг, орон нутгаас зохион байгуулж буй олон нийтийн ажилд хамт олноороо 8 удаа идэвхтэй оролцсон.
- Хэрлэн сумын Засаг даргын захирамж, албан тооны дагуу “Бүх нийтийн хог цэвэрлэгээг 14 хоног тутамд байгууллагын 50 метр хүртэлх ойр орчмын гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэж хэлшсэн. Мөн хуваарьт газар нийт 58 ширхэг мод тарьсан.
- Байгууллагын дэргэдэх орон тооны бус “Ёс зүйн зөвлөл” нь энэ онд 3 удаа хуралдаж 3 удаа дүгнэлт гаргасан байна. Хяналтын хуудсанд ёс зүйн зөрчилтэйгээр 1 ажилтны хяналтын хуудасны тэмдэглэлд тайлбар үйлдэгдсэн.
- “Шударга ёс, хөгжил дэвшил” нээлттэй самбарыг байршуулж 7 хоногийг үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, тухайн оны сар бүрийн санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг танилцуулж байна.

5.ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ

5.1 Тайлант хугацаанд 38022.3 мян.төг-ийн санхүүжилт хийгдэж нэмэлт дансандаа 406.0 мян.төг төвлөрүүлэн гүйцэтгэл 33571.3 мян.төг.тэйгээр өр авлагагүй санхүүгийн сахилга баттай хэмнэлтийн горимоор ажиллаж байна. Аудитын шалгалтаар “зөрчилгүй” дүгнэлт гарсан.

6.ДОТООД АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ:

6.1 Гэрээр ном олгох танхимын тооллогын ажлын данс тулгалт хийж гүйцэтгэсэн.

6.2 Хэрлэн сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/35 тоот захирамжийн дагуу Нийтийн номын сангийн ажилтан, албан хаагчид байгууллагынхаа ойр орчмын 50м хүртэлх талбайг 2 удаа, Чингис хотын хойд талаас хогийн цэг хүртэл 1 удаа цэвэрлэж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

6.3 Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилалт Улс орон даяар 16:00 цагт явагдаж Нийтийн номын сангийн ажилтан албан хаагчид, уншигч нарын хамт ажлын байрнаас "ЦУГЛАРАХ ЦЭГ"-т гарч ажиллалаа.

ХАВСРАЛТ

№01 Ном олголт

№	Номын сан	Стандарт хэмжээ	Үйлчилсэн тоо хэмжээ	Хувь	Оноо
1	Дорнод	55000	99121	180	26
2	Улаанбаатар ХоТНС	112500	141184	125	25
3	Орхон	112500	133910	119	24
4	Дархан ХНО	55000	61145	111	23
5	Архангай	55000	59997	109	22
6	Хөвсгөл	55000	57180	104	21
7	Баян-Өлгий	55000	56835	103	20
8	Ховд	55000	56468	103	19
9	ХүТНС	112500	91868	82	18
10	Дундговь	55000	41162	75	17
11	Увс	55000	39024	71	16
12	Төв	55000	37699	69	15
13	Дархан АТНС	112500	69812	62	14
14	Дорноговь	55000	25769	47	13
15	МҮНС	130000	58223	45	12
16	Өмнөговь	55000	23853	43	11
17	Хэнтий	55000	20974	38	10
18	Сүхбаатар	55000	17690	32	9
19	Баянхонгор	55000	15614	28	8
20	Өвөрхангай	55000	15170	28	7
21	Сэлэнгэ	55000	14568	26	6
22	Булган	55000	13691	25	5
23	Сэлэнгэ Мандал	55000	11315	21	4
24	Завхан	55000	10744	20	3
25	Говь-Алтай	55000	10200	19	2
26	Говь-Сүмбэр	55000	9670	18	1

№02 Ирц

№	Номын сан	Тоо хэмжээ	Оноо
1	Дорнод	72675	26
2	Улаанбаатар ХоТНС	69401	25
3	Орхон	66763	24
4	Дархан АТНС	55053	23
5	Өмнөговь	50032	22
6	Дархан ХНО	49359	21
7	Хөвсгөл	46747	20
8	Ховд	41497	19
9	Баян-Өлгий	30884	18
10	МҮНС	26027	17
11	Архангай	25000	16
12	Дундговь	22189	15
13	ХүТНС	21275	14
14	Хэнтий	20658	13
15	Увс	20566	12
16	Дорноговь	17394	11
17	Булган	15740	10
18	Өвөрхангай	14801	9
19	Төв	13524	8
20	Сэлэнгэ	12576	7
21	Сүхбаатар	9003	6
22	Говь-Алтай	8450	5
23	Сэлэнгэ Мандал	8003	4
24	Завхан	7744	3
25	Баянхонгор	6497	2
26	Говь-Сүмбэр	4309	1

№03 Байнгын уншигчид эзлэх ирцийн хувь хэмжээ

№	Номын сан	Стандарт хэмжээ	Байнгын уншигч	Ирц	Хувь	Оноо
1	Өвөрхангай	3800	334	14801	4431	26
2	Сэлэнгэ Мандал	3800	439	8003	1823	25
3	Дархан АТНС	7500	3062	55053	1798	24
4	Өмнөговь	3800	2834	50032	1765	23
5	Дархан ХНО	3800	3438	49359	1436	22
6	Дорнод	3800	5588	72675	1301	21
7	Ховд	3800	3372	41497	1231	20
8	Орхон	7500	7606	74369	978	19
9	Архангай	3800	2840	25000	880	18
10	Хэнтий	3800	2402	20658	860	17
11	Дундговь	3800	3000	22189	740	16
12	Дорноговь	3800	2430	17394	716	15
13	Говь-Алтай	3800	1300	8450	650	14
14	Булган	3800	2577	15740	611	13
15	Хөвсгөл	3800	8115	46747	576	12
16	ХүТНС	7500	3786	21275	562	11
17	МҮНС	8000	4768	26027	546	10
18	Баянхонгор	3800	1313	6497	495	9
19	Төв	3800	2742	13524	493	8
20	Сүхбаатар	3800	1877	9003	480	7
21	Говь-Сүмбэр	3800	1195	4309	361	6
22	Завхан	3800	2518	7744	308	5
23	Улаанбаатар ХоТНС	7500	25115	69401	276	4
24	Увс	3800	8273	20566	249	3
25	Баян-Өлгий	3800	14740	30884	210	2
26	Сэлэнгэ	3800	6058	12576	208	1

№04 Сан хөмрөгийн баяжилт

№	Номын сан	Тоо хэмжээ	Оноо
1	Завхан	5273	26
2	Улаанбаатар ХоТНС	4313	25
3	МҮНС	3675	24
4	Дархан АТНС	1774	23
5	Архангай	1625	22
6	Ховд	1475	21
7	Говь-Сүмбэр	1445	20
8	Өвөрхангай	1425	19
9	Дархан ХНО	1195	18
10	Баян-Өлгий	1154	17
11	Сэлэнгэ	1105	16
12	Өмнөговь	1089	15
13	ХүТНС	1018	14
14	Говь-Алтай	1015	13
15	Баянхонгор	992	12
16	Булган	958	11
17	Увс	951	10
18	Хэнтий	878	9
19	Сүхбаатар	855	8
20	Дорноговь	722	7
21	Хөвсгөл	704	6
22	Дундговь	668	5
23	Сэлэнгэ Мандал	655	4
24	Төв	654	3
25	Орхон	591	2
26	Дорнод	284	1

№05 Сан хөмрөгийн баяжилтад худалдаж авсан номын эзлэх хувь хэмжээ

№	Номын сан	Нийт баяжилт	Худалдаж авсан	Хувь	Оноо
1	Говь-Алтай	1015	958	94.4	26
2	Сэлэнгэ Мандал	655	598	91.3	25
3	Дархан ХНО	1195	1080	90.4	24
4	Увс	951	849	89.3	23
5	Баянхонгор	992	872	87.9	22
6	Орхон	591	490	82.9	21
7	Сүхбаатар	855	685	80.1	20
8	Өмнөговь	1089	865	79.4	19
9	Дорноговь	722	540	74.8	18
10	Булган	958	674	70.4	17
11	Төв	654	399	61.0	16
12	Хэнтий	878	532	60.6	15
13	Дундговь	668	402	60.2	14
14	Хөвсгөл	704	421	59.8	13
15	ХүТНС	1018	584	57.4	12
16	Ховд	1475	771	52.3	11
17	Баян-Өлгий	1154	496	43.0	10
18	МҮНС	3675	1555	42.3	9
19	Сэлэнгэ	1105	419	37.9	8
20	Архангай	1625	611	37.6	7
21	Дархан АТНС	1774	576	32.5	6
22	Говь-Сүмбэр	1445	208	14.4	5
23	Завхан	5273	677	12.8	4
24	Өвөрхангай	1425	169	11.9	3
25	Дорнод	284	33	11.6	2
26	Улаанбаатар ХоТНС	4313	228	5.3	1

№06 Сан хөмрөгийн эргэлт

№	Номын сан	Олголт	Сан хөмрөг тоо	Эргэлтийн хувь	Оноо
1	Дархан ХНО	61145	14879	411	26
2	Орхон	133910	35684	375	25
3	Дорнод	99121	74653	133	24
4	Дархан АТНС	69812	57968	120	23
5	Дундговь	41162	41412	99	22
6	Төв	37477	37965	99	21
7	Баян-Өлгий	56835	58768	97	20
8	Говь-Сүмбэр	9670	11613	83	19
9	Хөвсгөл	57180	68984	83	18
10	Ховд	56468	76707	74	17
11	Дорноговь	25769	40500	64	16
12	Өмнөговь	23853	42707	56	15
13	Увс	39024	71425	55	14
14	ХүТНС	48439	91868	53	13
15	Архангай	59997	124860	48	12
16	Хэнтий	20974	53325	39	11
17	Сэлэнгэ Мандал	11315	29437	38	10
18	Булган	13691	36284	38	9
19	Улаанбаатар ХоТНС	141184	388667	36	8
20	Сүхбаатар	17690	49786	36	7
21	Сэлэнгэ	14568	46299	31	6
22	Баянхонгор	15614	49784	31	5
23	Өвөрхангай	15170	51006	30	4
24	Говь-Алтай	10200	46515	22	3
25	Завхан	10744	56179	19	2
26	МҮНС	58223	2700133	2	1

№07 Олгосон ном

№	Номын сан	Үйлчлэх хүн ам	Нийт олголт	Хүн амд эзлэх хувь	Оноо
1	Архангай	21849	59997	275	26
2	Дундговь	16394	41162	251	25
3	Төв	17313	37477	216	24
4	Дорнод	47153	99121	210	23
5	Ховд	31980	56468	177	22
6	Баян-Өлгий	39711	56835	143	21
7	Хөвсгөл	42423	57180	135	20
8	Орхон	106145	133910	126	19
9	Увс	32912	39024	119	18
10	Булган	12810	13691	107	17
11	Дорноговь	27405	25769	94	16
12	Хэнтий	24115	20974	87	15
13	Өмнөговь	28854	23853	83	14
14	Дархан АТНС	87595	69812	80	13
15	Сүхбаатар	23103	17690	77	12
16	Говь-Сүмбэр	13152	9670	74	11
17	Дархан ХНО	87595	61145	70	10
18	Сэлэнгэ	22412	14568	65	9
19	Завхан	16580	10744	65	8
20	Говь-Алтай	18867	10200	54	7
21	Баянхонгор	32454	15614	48	6
22	Өвөрхангай	34605	15170	44	5
23	Сэлэнгэ Мандал	27017	11315	42	4
24	Улаанбаатар ХоТНС	1539252	141184	9	3
25	МҮНС	1539252	58223	4	2
26	ХүТНС	1539252	48439	3	1

№08 Өгөгдсөн лавлагааны тоо

№	**Номын сан**	**Лавлагааны тоо**	**Оноо**
1	Булган	5544	26
2	Сүхбаатар	4300	25
3	Улаанбаатар ХоТНС	3916	24
4	Хэнтий	2464	23
5	Дорнод	2328	22
6	Баянхонгор	1845	21
7	Өвөрхангай	1579	20
8	ХүТНС	1510	19
9	Дархан АТНС	1357	18
10	Дорноговь	1348	17
11	Говь-Сүмбэр	860	16
12	Архангай	517	15
13	Баян-Өлгий	473	14
14	Дархан ХНО	466	13
15	Дундговь	425	12
16	МҮНС	328	11
17	Хөвсгөл	291	10
18	Орхон	260	9
19	Сэлэнгэ	245	8
20	Өмнөговь	208	7
21	Завхан	188	6
22	Увс	181	5
23	Ховд	151	4
24	Говь-Алтай	134	3
25	Төв	97	2
26	Сэлэнгэ Мандал	73	1

№09 Хүн амын хэдэн хувьд үйлчилсэн (Байнгын Уншигч)

№	Номын сан	Хүн ам	Уншигч	Хэдэн хувь	Оноо
1	Булган	12810	2577	22.2	26
2	Говь-Сүмбэр	13152	1195	21.6	25
3	Дундговь	16394	3000	17.3	24
4	Завхан	16580	2518	17.1	23
5	Төв	17313	2742	16.4	22
6	Говь-Алтай	18867	1300	15.1	21
7	Архангай	21849	2840	13.0	20
8	Сэлэнгэ	22412	6058	12.7	19
9	Сүхбаатар	23103	1877	12.3	18
10	Хэнтий	24115	2402	11.8	17
11	Сэлэнгэ Мандал	27017	439	10.5	16
12	Дорноговь	27405	2430	10.4	15
13	Өмнөговь	28854	2834	9.8	14
14	Ховд	31980	3372	8.9	13
15	Баянхонгор	32454	1313	8.8	12
16	Увс	32912	8273	8.6	11
17	Өвөрхангай	34605	334	8.2	10
18	Баян-Өлгий	39711	14740	7.2	9
19	Хөвсгөл	42423	8115	6.7	8
20	Дорнод	47153	5588	6.0	7
21	Дархан АТНС	87595	3062	3.2	6
22	Дархан ХНО	87595	3438	3.2	5
23	Орхон	106145	74369	2.7	4
24	Улаанбаатар ХоТНС	1539252	25115	0.2	3
25	ХүТНС	1539252	3786	0.2	2
26	МҮНС	1539252	4768	0.2	1

№10 Соёл олон нийтийн төв

№	Номын сан	**Нийт**	Оноо
1	Улаанбаатар ХоТНС	1165	26
2	Дорноговь	364	25
3	Ховд	336	24
4	МҮНС	252	23
5	Дархан АТНС	245	22
6	Өмнөговь	188	21
7	Орхон	132	20
8	Увс	131	19
9	Дархан ХНО	131	18
10	Булган	112	17
11	Баян-Өлгий	102	16
12	Дорнод	84	15
13	Архангай	76	14
14	Баянхонгор	75	13
15	Сэлэнгэ Мандал	69	12
16	Сүхбаатар	67	11
17	Говь-Сүмбэр	63	10
18	Дундговь	62	9
19	Төв	60	8
20	Хэнтий	50	7
21	Завхан	40	6
22	Өвөрхангай	35	5
23	Сэлэнгэ	35	4
24	ХүТНС	32	3
25	Хөвсгөл	16	2
26	Говь-Алтай	15	1

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ 4
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 5
Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 46
Б.БААСТЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН 77
АРХАНГАЙ АЙМГИЙН С.ЖАМЬЯНГАРАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН........ 90
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН Б. АХТАНЫ НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 115
БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 168
БУЛГАН АЙМГИЙН С.УДВАЛЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 182
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН Д.СҮРЬЕЭГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 200
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН 215
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН........ 218
ДОРНОГОВЬ АЙМГИЙН А.ЭРДЭНЭ-ОЧИРЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 266
ДОРНОД АЙМГИЙН Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 291
ДУНДГОВЬ АЙМГИЙН С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 296
ЗАВХАН АЙМГИЙН Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 305
ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 315
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2021 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН326
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН........ 334
СҮХБААТАР АЙМГИЙН Г.МЭНД-ООЁОГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН........ 373
СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН 406
СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 427
ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 473
УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 488
ХОВД АЙМГИЙН МУСГЗ М.БАЯНЗУЛЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 511
ХӨВСГӨЛ АЙМГИЙН Д.СҮРЭНЖАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ТАЙЛАН 541

ХЭНТИЙ АЙМГИЙН Р.ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.. 573
ХАВСРАЛТ 579
ГАРЧИГ.. 589

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН
THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

9 789919 975142